

Зохион байгуулагчид:

Христмас Вайлли Цуглаан

Индогуан цуглаан

Үл Устах Үгс сайн дурын үйлчлэл

Зөвлөх хороо:

Марк Фийнер

Пак Сү Ён

Б. Пүрэвсүрэн

Ю. Гангаа-Эрдэнэ

Орчуулагчид:

Б. Пүрэвсүрэн

Б. Шинэбаяр

Хянан засварласан:

Б. Пүрэвсүрэн

Ю. Гангаа-Эрдэнэ

Эх бэлтгэсэн:

Зохиогчийн эрх © Виллиям МакДоналд 1989, 1990,  
1992, 1995

Америкийн Нэгдсэн Улс

Зохиогчийн албан ёсны зөвшөөрлөөр Монгол хэлнээ  
орчуулж, БНСУ-д 2018 онд хэвлэв.

Зохиогчийн бүх эрх хадгалагдана. Тус хэвлэлийн  
аль ч хэсгийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр  
цахилгаан, механик, фото хуулбар, хальсанд хуулах  
гэх мэт бусад ямар ч утга болон хэлбэрт шилжүүлэн,  
хуулж, хэвлэж үл болно.



# ШИНЭ ГЭРЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

*“Шинэ гэрээний бичвэрүүд тоо хэмжээний хувьд бага боловч үнэ цэнэ нь түүхийн талаас ч тэр, сүнслэг байдлын хувьд ч тэр маш их бөгөөд хүмүүний амьдрал, хүн төрөлхтний түүхэнд хэмжээлиггүй том нөлөө үзүүлсэн. Шинэ гэрээ болбоос Еденд эхэлсэн өдрийн үд дундын үе юм. Хуучин гэрээнд зөгнөгдсөн Христ бээр сайнмэдээний номуудад бодит түүх, захидлуудад практик амьдрал, Илчлэл номд алдар суу болов.”*

*-Виллиям Грэйм Скрожжи*

## I. “ШИНЭ ГЭРЭЭ” ХЭМЭЭХ НЭРИЙН ТУХАЙ

Шинэ гэрээг судлах их тэнгист гарахын урд, эсвэл тодорхой нэг номыг нь судлах арай бага талбар уруу орохоос өмнө, “Шинэ гэрээ” хэмээн нэрлэсэн ариун дагшин номын тухай ерөнхий мэдээллийг товчхон толилуулах нь зөв буй заа.

Гэрээ (англиар: “testament” (гэрээс) ба “covenant” (гэрээ) гэж орчуулагддаг ч нэг үг) гэдэг үг нь грекээр *διαθεκε*. Еврей номын ганц хоёр газар “testament” ба “covenant”-ын аль нь илүү зөв орчуулга болох вэ гэсэн маргаан байдаг ч христитгэлийн бичвэрүүдийг нэрлэхэд “гэрээ” (covenant) гэдэг үг илүү таарах мэт харагддаг.

Яагаад гэвэл уг ном нь Бурхан ба хүмүүсийн хооронд байгуулсан гэрээг агуулдаг.

Библийн хоёр дэх хэсгийг Шинэ гэрээ гэж нэрлэдэг нь өмнөх (хуучин) гэрээтэй нь эсрэгцүүлсэн хэрэг.

Шинэ, хуучин гэрээ хоёулаа Бурханы амьсгалаар бичигдсэн учраас христитгэгчдэд аль аль нь хэрэгтэй. Гэвч христитгэгч хүн Шинэ гэрээг илүүтэй авч үздэг. Учир нь Шинэ гэрээнд бидний Эзэн ба Түүний чуулганы тухай өгүүлэхээс гадна, Эзэн Есүс дагалдагч нараа хэрхэн амьдрахыг хүсдэг талаар дурдсан байдаг.

Августин хуучин ба шинэ гэрээний уялдаа холбоог тайлбарлахдаа “Шинэ гэрээ нь Хуучин гэрээнд нууцлагдсан. Хуучин гэрээ нь Шинэ гэрээнд илчлэгдсэн” хэмээсэн нь оновчтой сайхан тодорхойлолт болсон.

## **II. ШИНЭ ГЭРЭЭНИЙ КАНОН**

Канон (грекээр: *канон*) гэдэг нь аливаа юмыг хэмжих, үнэлэх “жишиг” гэсэн утгатай. Шинэ гэрээний канон гэвэл Бурханы амьсгалаар бичигдсэн номуудын эмхэтгэлийг хэлнэ. Тэгвэл одоогийн хорин долоон бичвэр нь канонд багтах ёстой ном мөн гэдгийг хэрхэн мэдэх вэ? Өөр ном байхгүй гэдгийг яаж мэдэх вэ? Шинэ гэрээний хорин долоон номоос гадна христитгэгчидтэй холбоотой янз бүрийн захидал, бичвэрүүд (гаж сургаалтай бичвэрүүд ч бас) эртнээс нааш олон

гарсан. Тэгвэл тэр олны дотроос аль нь канонд багтах ёстойг юугаар мэдсэн бэ?

МЭ 300-аад оны сүүлээр чуулганы зөвлөл каноны жагсаалтыг гаргасан гэж ярьдаг. Гэвч үнэндээ, Шинэ гэрээний номууд бичигдсэн даруйдаа л канон байсан. Сүсэгтэй, мэргэн дагалдагч нар уг бичвэрүүдийг Бурханы амьсгалаар бичигдсэн гэдгийг бүр анхнаасаа мэдэж байсан. Тухайлбал, Паулын захидлуудыг Петр канон гэж үзсэн (2Петр 3:15, 16). Гэхдээ зарим чуулганууд ганц нэг номыг (Иуда, 2Иохан, 3Иохан) хүлээн зөвшөөрөхгүй явдал байсан.

Ерөнхийдөө, элч нар (Матай, Петр, Иохан, Паул) юм уу элч нарын хүрээний хүмүүс (Марк, Лук) бичсэн бол тухайн номын канон эсэхэд эргэлзэх зүйл байгаагүй.

Чуулганы зөвлөлийн хийсэн ажил нь олон жилийн турш нэгэнт нийтээр баримталж ирсэн каноныг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн хэрэг болно. Уг зөвлөл Бурханы амьсгалаар бичигдсэн номын жагсаалт өөрсдөө бий болгосон бус, харин Бурханы амьсгалаар бичигдсэн номуудыг жагсаасан юм.

### **Ш. ЗОХИОГЧ**

Шинэ гэрээний тэнгэрлэг зохиогч нь Ариун Сүнс мөн. Матай, Марк, Лук, Иохан, Паул, Иаков, Петр, Иуда, мөн Еврей номыг бичсэн нэр нь үл мэдэгдэх хүн (Еврей номын оршлыг үз) бүгдээрээ Ариун Сүнсэнд хөтлөгджээ. Шинэ

гэрээний номууд “хоёр зохиогчтой” байсан гэвэл энэ асуудлыг хамгийн зөв ойлгох болов уу. Шинэ гэрээний зарим хэсгийг нь хүн, бусдыг нь Бурхан бичсэн юм биш. Харин бүгдийг нь хүн, бас бүгдийг нь Бурхан бичсэн. Бурханы тал нь хүний талыг алдаа гаргахаас хамгаалсан. Үүний үр дүнд эх бичвэртээ ямар ч алдаа мадаггүй ном бий болсон.

Бурханы амьд үг болох Эзэн Есүс Христийг харвал Бурханы бичмэл үгийн энэ чанарыг ойлгож болно. Грекийн үлгэр домогт гардаг шиг, Эзэн Есүсийн тал нь хүн, тал нь Бурхан байгаагүй. Тэрбээр бүрэн хүн, бас бүрэн Бурхан. Бурхан чанар нь хүн чанарыг нь ямар нэгэн алдаа гаргаж, нүгэлд унах боломжгүй болгосон.

#### **IV. БИЧИГДСЭН ОГНОО**

Хуучин гэрээ бүрдэхийн тулд нэг мянган (ойролцоогоор МЭӨ 1400-400 он) зарцуулагдсан бол Шинэ гэрээ бичигдэж дуусахад хагас зуун (ойролцоогоор МЭ 50-100 он) шаардагдсан.

Шинэ гэрээний номуудын өнөөгийн дэс дараа нь бүх цаг үеийн чуулганд хамгийн сайн тохирдог. Шинэ гэрээ Христийн амьдралаар эхэлж, чуулганы үүслийн талаар үргэлжилж, хойноос нь чуулганд заавар зөвлөмж өгч, эцэст нь чуулган ба энэ ертөнцийн ирээдүйг илчилдэг. Гэхдээ номуудын дэс дараа нь бичигдсэн хугацааныхаа дагуу байрлаагүй. Шинэ гэрээний

номууд нь бичигдэх хэрэгцээ шаардлага урган гарсан учраас бичигдсэн байдаг.

Хамгийн эхэнд бичигдсэн номууд гэвэл Филиппийн “шинэхэн чуулгануудад илгээсэн захидлууд” гэж нэрлэгдсэн захидлууд болно. Тухайн захидлуудын түрүүч нь Иаков, Галат, Тесалоник бөгөөд нэгдүгээр зууны дунд үед бичигдсэн гэж үздэг.

Харин араас нь сайнмэдээний номууд орно. Сайнмэдээний номуудаас хамгийн эхэнд Матай, Марк хоёрын аль нэг нь бичигдсэн. Дараа нь Лук, хамгийн сүүлд Иохан бичигдсэн. Шинэ гэрээний номуудаас хамгийн сүүлд бичигдсэн нь Илчлэл ном бөгөөд хугацаа нь нэгдүгээр зуун дуусгавар болохын өмнөхөн болно.

## V. АГУУЛГА

Шинэ гэрээний агуулгыг товчхон тоймловол:

*Түүх*

Сайнмэдээний номууд

Үйлс

*Захидал*

Паулын захидлууд

ерөнхий захидлууд

*Апокалиптик (Ертөнцийн төгсгөлийн тухай бичвэр)*

Илчлэл

Энэ номуудыг сайтар ойлгосон итгэгч хүн “алив сайн үйлд бүрэн бэлэн” болно.

Олон итгэгчдийг тийм болоход энэ ном маань хувь нэмэр оруулах болтугай хэмээн бид залбирч байна.

## VI. БИЧИГДСЭН ХЭЛ

Шинэ гэрээ нь эртний грек хэлний өдөр тутам хэрэглэгддэг хэлбэрээр (*койнэ* ‘нийтийн, ердийн’ грек хэл гэдэг) бичигдсэн. Өнөө цагт англи хэл дэлхий нийтэд ямархуу өргөн хэрэглэгдэж байгаа шиг, *койнэ* грек хэл бас нэгдүгээр зуунд даян дэлхийн улс үндэстний унаган хэлний дараа хоёрт ордог хэл болж байв. Христитгэл ч бас *койнэ* грек хэлээр нийтэд түгсэн.

Еврей хэлний халуун дулаан, өнгө чамин хэв маяг нь Хуучин гэрээний эш үзүүлэлэг, шүлэглэл, хүүрнэлд төгс нийцдэг шиг грек хэл ч бас Шинэ гэрээг бичихэд Бурханы мутарт гайхалтай зэмсэг болж ашиглагдсан байна. Агуу Александр хааны эзлэн түрэмгийлэл, түүний цэргүүдээр дамжин грек хэл олон улсад эгэл хэлбэрээр тархсан.

Грек хэлний цаг, тийн ялгал, үгийн сан гэх мэт хэлзүйн нарийн ширийн ялгарал захидлуудад өгүүлж буй онол сургаалын асуудлыг дамжуулахад, ялангуяа Ром номд маш чухал ач холбогдолтой байдаг.

*Койнэ* грек нь дээд зиндааныхны хэрэглэдэг утга зохиолын хэл биш боловч “гудамжны” хар



ярианы хэл бас биш юм. Еврей, Иаков, 2Петр гэх мэт Шинэ гэрээний зарим хэсэг бараг л утга зохиолын түвшинд бичигдсэн байх ба Лукийн бичвэрийн зарим хэсэг нь сонгодог хэлбэрийн мэт өнгө аястай. Паул ч гэсэн үе үе уран яруу бичдэг байсан (жишээ нь 1Коринт 13, 15 дугаар бүлэг).

## **VII. ОРЧУУЛГА**

Англи хэл олон орчуулгаар (дэндүү олон ч байж магад) ивээгджээ. Тэдгээр орчуулгыг дөрвөн төрөлд ангилж болно:

### **1. Ягштал үгчилсэн орчуулга**

Ж.Н.Дарбигийн шинэ орчуулга (1871), мөн English Revised Version (Хянан засварласан англи орчуулга-1881), үүний америк хувилбар болох American Standard Version (Америк Стандарт Орчуулга-1901) зэрэг нь үгийг ягштал баримталсан орчуулгууд юм. Энэ төрлийн орчуулга нь судалгаа хийхэд тустай боловч мөргөлд ашиглах, нийтээр унших, цээжлэхэд сул талтай. Хэдий ийм орчуулгууд байгаа ч христитгэгчдийн олонх нь KJV (Жэймс хааны орчуулга)-ын яруу тансаг хэллэгт татагдаад огтхон ч орхидоггүй.

### **2. Бүрэн дүйцүүлсэн орчуулга**

Англи хэл рүү үгчлэн буулгах боломжийн хэрээр еврей, грек хэлээ баримталсан хэдий ч

аргагүй тохиолдолд бүтэц найруулга, хэлц үгийн утгыг гаргахын тулд ягштал үгчлэхээс татгалздаг орчуулга. KJV (Жэймс хааны орчуулга), RSV (Хянан засварласан стандарт орчуулга), NASV (Шинэ америк стандарт орчуулга), NKJV (Жэймс хааны шинэ орчуулга) зэрэг орчуулга энэ ангилалд багтана. RSV нь ерөнхийдөө Шинэ гэрээнд тулгуурлаж, түүндээ Хуучин гэрээг уялдуулсны улмаас Мессиагийн олон эш үзүүлэгийг бүдгэрүүлсэн нь тун харамсалтай. Өмнө нь маш сайн байсан эрдэмтдийн дотор ч өнөөдөр энэ аюултай хандлага үзэгдэх болов. Манай номын хувьд гэвэл, KJV-ийн хуучны уран яруу хэлбэрийг хадгалахын сацуу өнөөгийн англи хэлний байдалд нийцүүлсэн (тухайлбал “thee”, “thou” байхгүй) NKJV-ийг баримталж тайлбар хийсэн болно. Мөн NKJV нь орчин цагийн ихэнх Библид гээгдсэн олон үгийг хадгалж үлдсэн байдаг (Манай номын доторх зүүлт тайлбаруудыг үзнэ үү).

### **3. Чөлөөтэй дүйцүүлсэн орчуулга**

Бүрэн дүйцүүлсэн орчуулгыг бодвол илүү чөлөөт орчуулга. Бичвэрийн эх хэл дээрх үгийг баримтлалгүй, уншигчид ойлгомжтой өөр үгээр орлуулж орчуулдаг. Моффатын орчуулга, NEB (Шинэ англи орчуулга), NIV (Шинэ олон улсын орчуулга), Иерусалимын Библи зэрэг орчуулга энэ ангилалд багтана. Иохан, Паул нар өнөө цагт англи хэлээр бичсэн бол яаж бичих байсан бол

гэх хандлагаар өгүүлбэрийн бүтцийг найруулдаг. Уламжлалаа барьдаг үзлээр ингэж орчуулбал энэ арга маш тустай.

#### **4. Утгачилсан орчуулга**

Утгачилсан орчуулга нь тухайн бичвэрийн утга санааг гаргаж ирэхийг чухалчилдаг. Ингэхдээ эх бичвэрт байхгүй үгийг чөлөөтэй нэмдэг. Ийм төрлийн орчуулгын үг нь эх бичвэрээсээ ихэд зөрүүтэй байх бөгөөд *хэт их тайлбар* нэмэх аюултай байдаг. Living Bible (Амьд Библи) орчуулга бол ийм орчуулгын нэг жишээ юм. Уг орчуулга эвангелийн үзэлд хамаарах ч орчуулгын нэлээд олон шийдвэр асуудалтай харагддаг.

Ж.Б.Филипсийн утгачилсан орчуулга нь утга зохиолын талаас нэлээн сайн бүтээл болсон. Тэрбээр, Петр, Паул нар ийм утгаар хэлсэн гэж үзсэнээ өөрийнхөө үгээр буулгасан байна.

Энэ ангиллуудаас наанадаж гурван өөр Библи авч харьцуулан судалбал Библийг ойлгоход маш тустай. Гэхдээ бидний хувьд, Библийг нарийн дэлгэрэнгүй судлахад бүрэн дүйцүүлсэн орчуулга хамгийн тохиромжтой гэж үзсэн.

# САЙНМЭДЭЭНИЙ НОМУУДЫН ТАНИЛЦУУЛГА

*“Сайнмэдээний номууд бол бүх бичвэрийн анхны үр жимс нь юм.” - Ориген*

## I. ЯРУУ АЛДАРТ САЙНМЭДЭЭ МИНУ

Утга зохиол судалж үзсэн хүмүүс өгүүллэг, роман, жүжиг, шүлэг, намтар гээд утга зохиолын янз бүрийн хэлбэрийг хэдийнээ мэдэх билээ. Гэвч бидний Эзэн Есүс Христ энэ дэлхийд ирэх үед утга зохиолын цоо шинэ хэлбэр хэрэгтэй болсон юм. Тэр бол сайнмэдээ. Сайнмэдээ нь намтар биш боловч намтрын шинжтэй агуулга тун их. Сайнмэдээ нь өгүүллэг биш боловч тэнэмэл хүү, сайн санаат самари хүн гэх мэт олон сургаалт зүйрлэл агуулдаг. Тэдгээр сургаалт зүйрлэл нь утга зохиолын өгүүллэгийн нэг адил хүний сонирхлыг татах юм ихтэй. Зарим нэг роман, өгүүллэгүүд сайнмэдээний сургаалт зүйрлэлээс санаа авсан нь ч бий. Сайнмэдээ нь баримтат мэдээ биш боловч Эзэний маань яриа, номлолыг тэмдэглэсэн тэмдэглэл дотор алдаа мадаггүй, баримттай мэдээллүүд ихээр агуулагдаж байдаг.

Сайнмэдээ нь утга зохиолын талаас онцгой хэлбэр болохоос гадна Матай, Марк, Лук, Иохан гэх дөрвөн сайнмэдээний ном бичигдсэнээр каноны хэв алдагдсан. Жинхэнэ Христийн дагалдагчид хоёр мянган жилийн хугацаанд энэ

дөрвөн сайнмэдээг л хүлээн зөвшөөрсөөр ирсэн. Мэдээж хэрэг сайнмэдээ хэмээх нэртэй янз бүрийн гаж ном зохиол гарч байсан боловч тэдгээр нь гностицизм мэтийн зарим гаж буруу сургаалыг хөхүүлэн дэмжих зорилготой хэрэггүй эд байв.

Тэгвэл яагаад дөрвөн сайнмэдээ гэж? Мосегийн таван номтой ижилсүүлэн, христитгэлийн Пентатухыг бий болгож, тав байж яагаад болоогүй гэж? Аль эсвэл давтагдсан хэсгүүдийг хасаад, илүү олон гайхамшиг, арай олон сургаалт зүйрлэл багтаасан ганц урт сайнмэдээ байж яагаад болоогүй гэж? Үнэндээ бол Татиан гэгч хүн хоёрдугаар зуунд сайнмэдээний дөрвөн номыг нэгтгэх оролдлого хийсэн байдаг. Тийнхүү тэрээр *Диатессарон* (грекээр “дөрвөөр дамжин” гэсэн үг) гэх нэртэй бүтээл туурвисан.

Иренаусын онолоор дөрвөн сайнмэдээ бол ертөнцийн дөрвөн зүг, дөрвөн салхитай дүйцэх бөгөөд дөрөв бол ертөнц дахиныг бэлгэдсэн тоо гэжээ.

## II. ДӨРВӨН БЭЛГЭДЭЛ

Олон хүн, тэр дундаа урлагийн талын хүмүүс дөрвөн сайнмэдээг Езекиел болон Илчлэлд гардаг дөрвөн амьд биеттэй (арслан, үхэр, хүн, бүргэд) адилтган харьцуулах дуртай байдаг. Гэхдээ итгэгчид тэднийг өөр өөрөөр жишиж харьцуулдаг. Тэр дөрвөн амьд биетийг урлагийн

талаас бэлгэдэл болгож үзвэл арслан нь Иудагийн арсланг харуулсан Матайн сайнмэдээтэй хамгийн их тохирно. Үхэр нь ачлага уналгын амьтан тул Христийг зарцын дүрээр илэрхийлсэн Маркийн сайнмэдээтэй тохирно. Лукийн сайнмэдээ нь Хүний Хүүгийн сайнмэдээ учраас хүний дүртэй амьд биеттэй тохирч байна. Тэгвэл “*Ижил утга, эсрэг утга, угтвар үгийн стандарт гарын авлага*” гэх номд “Бүргэд нь өндөр дээд сүнслэг харааг бэлгэддэгийн хувьд элч Иоханы шинж чанар юм” хэмээсэн байдаг<sup>1</sup>.

### III. ДӨРВӨН ТӨРЛИЙН УНШИГЧ

Ариун Сүнс өөр өөр бүлэг хүмүүст (эртний ертөнцөд байсан, одоо ч байдаг дөрвөн төрлийн хүнд) хүрэхийг хүсдэг гэж үзэх нь дөрвөн сайнмэдээ байгаагийн хамгийн сайн тайлбар болох болов уу.

Матай бол иудейчүүдэд зориулагдсан сайнмэдээ гэдгийг бүгд хүлээн зөвшөөрдөг. Хуучин гэрээнээс иш татсан байдал, харилцан ярианы хэлбэр, Эзэний маань угийн бичиг, өнгө аяс нь ерөнхийдөө семит байгаа нь шинэхэн уншигчид ч гэсэн илэрхий байдаг.

Маркийн сайнмэдээ магадгүй Ромын эзэнт гүрний нийслэлээс ромчуудад болон тэдний нэгэн адил хийсвэр бодлоос бодит үйлийг илүүд үздэг сая сая хүмүүст зориулж бичигджээ. Маркийн сайнмэдээ нь гайхамшигийг ихээхэн,

сургаалт зүйрлэлийг багахан дурдсан. Зарцын удам судрын тухай иудейн угийн бичгийг ромчууд ойшоон үзэхгүй учир Маркийн сайнмэдээнд угийн бичиг огтхон ч шаардлагагүй.

Лукийн сайнмэдээ грек урлаг, грек утга зохиолд дурлаж, даган дуурайгч грек, ром хүмүүст зориулагджээ. Тийм хүмүүс гоо үзэсгэлэн, хүмүүнлэг чанар, соёл урлаг, утга зохиолын сайханд дуртай. Эмч Лук сайнмэдээндээ энэ бүхнийг оруулж өгсөн. Ийм төрлийн хүмүүстэй ойролцоо гэвэл орчин цагийн грекүүдээс гадна франц хүмүүс юм. “Лукийн сайнмэдээ бол дэлхийн хамгийн сайхан ном” гэж нэгэн франц хүний хэлснийг тэгэхээр гайхах зүйл огт үгүй аж (Лукийн сайнмэдээний оршил хэсгийг үз).

Тэгвэл Иоханы сайнмэдээ хэнд зориулагдсан бэ? Иохан ном бол бүх хүнд зориулагдсан даян дэлхийн сайнмэдээ юм. Сайнмэдээ (20:30, 31) дамжуулахаас гадна Христэд итгэдэг гүн сэтгэгч нарт Иохан ном их таалагддаг. Тэгэхээр Иохан номыг “гуравдагч үндэстэнд” зориулжээ. “Гуравдагч үндэстэн” гэдэг нь эртний христитгэгчдэд үл итгэгчдээс өгсөн нэр юм. Энэ нь иудей ч биш, харь үндэстэн ч биш гэсэн утгатай аж.

#### IV. ДӨРВӨН ТАЛЫН ТУХАЙ БУСАД ДҮР ЗУРАГЛАЛ

Сайнмэдээний дөрвөн номын тус бүр онцолсон санааг илэрхийлэх дөрвөн талт гайхамшигтай дүр зураглал Хуучин гэрээнд бий. Үүнд:

“Мөчир” гэх үг Эзэний маань нэр байдлаар дараах хэсгүүдэд дурдагдсан:

“...Давидад...МӨЧИР...Хаан” (Иеремиа 23:5, 6)

“Өөрийн минь Зарц, МӨЧИР” (Зехариа 3:8)

“МӨЧИР хэмээх...Хүн” (Зехариа 6:12)

“Эзэний (Иехова) МӨЧИР” (Исаиа 4:2)

Сайнмэдээний дөрвөн номын гол санаатай яв цав нийцэж байгаа дөрвөн “Үзэгтүн” Хуучин гэрээнд гардаг. Үүнд:

“Үзэгтүн, Хаан чинь” (Зехариа 9:9)

“Үзэгтүн, миний Зарц” (Исаиа 42:1)

“Үзэгтүн, Хүн” (Зехариа 6:12)

“Үзэгтүн, та нарын Бурхан” (Исаиа 40:9)

Эцэст нь өгүүлэх зүйрлэл ач холбогдол багатай боловч олон хүнд ивээл болж чаддаг. Майхан сүмийг дөрвөн өөр өнгийн материалаар урласан бөгөөд тэдгээрийн бэлгэдлийн утга нь дөрвөн сайнмэдээнд илэрхийлсэн Эзэний маань шинж чанартай таарч байна:

*Нил ягаан:* Нил ягаан өнгө нь Христийн хаан шинжийг дүрсэлсэн Матайн сайнмэдээг илэрхийлдэг. Нил ягаан өнгө нь хааны эрх



мэдлийн бэлгэдэл байсныг Шүүгчид 8:26-аас үзэж болно.

*Час улаан:* Эрт цагт час улаан өнгөтэй нэг төрлийн хорхойноос час улаан өнгийн будаг гаргаж авдаг байв. Энэ нь “хүн биш, өт хорхой” мэт (Дуулал 22:6) зарцын тухай Маркийн сайнмэдээг илэрхийлж байна.

*Цагаан:* Цагаан өнгө нь ариун хүмүүсийн зөвт үйлсийг илэрхийлдэг (Илчлэл 19:8). Лукийн сайнмэдээ нь Христийн төгс хүмүүн мөн чанарыг цохон тэмдэглэсэн.

*Хөх:* Индранилаар зассан Бурханы орших газрыг бид тэнгэр гэж нэрлэдэг (Гэтлэл 24:10). Хөх өнгө нь Бурханы орших тэнгэрийн бэлгэдэл утгаараа Христийн бурхан чанарыг илэрхийлдэг тул Христ бол Бурхан болохыг цохон тэмдэглэсэн Иоханы сайнмэдээг илтгэдэг.

## **V. ҮЙЛ ЯВДЛЫН ДЭС ДАРАА БА ЦОХОН ТЭМДЭГЛЭСЭН САНАА**

Сайнмэдээний номуудад үйл явдлыг өрнөсөн дарааллынх нь дагуу тэмдэглээгүй. Бурханы Сүнс үйл явдлуудыг өгч буй сургамжийнх нь дагуу байрлуулсан гэдгийг ойлгох хэрэгтэй. Келли энэ талаар дараах үгийг хэлсэн:

Лукийн бичсэн сайнмэдээг унших үед нэг зүйл тодорхой харагдана. Лук болсон үйл явдал, харилцан яриа, асуулт хариулт, Эзэний маань номлолыг тэмдэглэхдээ болж

өнгөрсөн цагийн хэлхээсээр биш өгч буй сургамжаар нь, дотоод уялдаа холбооных нь дагуу эмхэтгэжээ. Үйл явдлыг болж өнгөрсөн дэс дарааллаар нь л бичих нь хамгийн бүдүүн тоймын түүхэн тэмдэглэл. Харин үйл явдлыг цаад шалтгаан, үр дагавар, түүнээс авах сургамжтай нь хамтатган бичнэ гэдэг бол түүхч хүний хувьд маш ярвигтай ажил бөгөөд зүгээр л болсон явдлыг тэмдэглэж авахаас огт өөр зүйл юм. Бурхан Лукийг ашиглаж энэ ажлыг төгс төгөлдөр гүйцэлдүүлжээ.<sup>2</sup>

Өөр өөр санааг цохон тэмдэглэж, өөр өөр зорилгоор бичигдсэн болохыг мэдвэл яагаад дөрвөн өөр сайнмэдээ байдгийг ойлгоход тус болох биз ээ. Гэхдээ сайнмэдээний эхний гурван номыг “синоптик” (“ижил өнцгөөс өгүүлдэг” гэсэн утгатай) гэж нэрлэдэг. Учир нь сайнмэдээний эхний гурван ном Христийн амьдралыг бичихдээ төстэй зүйл их агуулсан байдаг. Харин Иоханы сайнмэдээ бусад гурваасаа ондоо. Иохан номоо арай хожуу бичсэн учраас нэгэнт биччихсэн зүйлсийг давтахыг хүсээгүй байна. Тэрээр Эзэний маань амьдрал ба сургаалыг тунгаан бодрол, теологийн талаас илүүтэй харуулсан.

## VI. СИНОПТИКИЙН АСУУДАЛ

Сайнмэдээний эхний гурван номын олон хэсэг бараг үг бүрчлэн адилхан байхаас гадна олон ялгаатай зүйлс байдгийг “синоптикийн асуудал” гэж нэрлэдэг. Энэ нь консерватив үзэлт христитгэгчид нэг их асуудал биш боловч бичвэрийг Бурханы үг болохыг үгүйсгэгч хүмүүст бол бүдрэх чулуу болдог. Тэгээд тэд үүнтэй холбоотой олон нүсэр онол бий болгожээ. Тухайлбал, өнөөдөр гар бичмэлийн хэлбэрээр үлдэлгүй үрэгдсэн янз бүрийн бичвэрүүд байсан гэх онол. Зарим талаараа энэ санаа Лук 1:1 дүгээр эшлэлд дурдсантай таарч байгаа бөгөөд үнэхээр тийм байсан гэж үзэхэд буруу зүйл үгүй. Гэхдээ зарим онол нь “нэгдүгээр зууны чуулган Есүс Христийн талаар янз бүрийн үлгэр домог зохиосон” гэсэн үзэл санааг дэвшүүлэх хүртэл төөрөлдөж. Энэ бүх онол христитгэлийн бичвэрүүд хийгээд чуулганы түүхэнд үл итгэх хандлагыг илэрхийлэх бөгөөд ямар нэг баримт нотолгоо огт байхгүй гэдгийг цохон тэмдэглэх хэрэгтэй. Түүнээс гадна, синоптик сайнмэдээг ангилж, задалж байгаа арга барилаараа тэдгээр эрдэмтэн судлаачдаас ядаж хоёр хүн ч санал нийлэхгүй зөрөлддөг.

Энэ асуудлыг шийдэх сайхан аргыг Эзэн Есүс хэлж өгсөн: “Харин Туслагч буюу миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд та нарт хэлсэн бүгдийг минь сануулах болно” (Иохан 14:26).

Матай, Иохан нар өөрсдийн нүдээр үзэж харснаа дурсан санаж сайнмэдээний номоо бичсэн гэх баталгааг энэ үг өгч байна. Марк ч гэсэн Петрийн дурсамжийг тэмдэглэсэн гэж үздэг тул үүнд хамаарах юм. Ариун Сүнсний энэхүү шууд тусламжаас гадна Лук 1:1 дүгээр эшлэлд дурдсан бичмэл материалууд, бас семит хүмүүсийн алдаа мадаггүй ам дамжуулан уламжилдаг уламжлал гээд сайнмэдээг бичиж болох олон эх сурвалж байсныг үзвэл синоптикийн асуудал шийдэгдэх нь тэр. Мөн энд дурдсан эх сурвалжуудаас гадна, шаардлагатай мэдээлэл нь “Ариун Сүнсний сургасан үгсээр” шууд илчлэгдсэн байх боломжтой (1Коринт 2:13).

Үүнчлэн, нарийн ширийн зүйлс дээр зөрүү байгааг харвал “Тухайн сайнмэдээний ном уг үйл явдлыг, эсвэл уг үгийг яагаад хассан бэ, яагаад оруулсан бэ, яагаад онцолсон бэ?” гэж асуух нь зүйн хэрэг мөн. Жишээ нь, Матайн сайнмэдээнд хоёр хүнийг эдгээсэн тухай хоёр тохиолдол бий. Нэг тохиолдолд нь сохор хүнийг, нөгөө тохиолдолд нь чөтгөр шүглэсэн хүнийг эдгээсэн. Гэтэл Марк, Лукийн сайнмэдээнд энэ хоёр тохиолдолд нэг хүнийг эдгээсэн гэж өгүүлсэн. Зарим хүн иймэрхүү зүйлийг үзээд “сайнмэдээний номууд хоорондоо зөрж байна” гэдэг. Гэхдээ Матай ном бол иудейчүүдэд зориулагдсан сайнмэдээ болохыг ойлгох нь чухал. Хуульд заасанчлан “хоёр эсвэл гурван гэрчийн” үг хүчин төгөлдөр учраас Матайн

сайнмэдээнд хоёр хүнийг хоёуланг нь дурдсан байна. Гэтэл нөгөө хоёрт нь нэг хүний талаар дурдсан. Ингэхдээ тухайн хүнд ач холбогдол өгч нэрийг нь тусгасан (сохор Бартимай).

Сайнмэдээнд давтагдсан мэт харагдаж байвч үнэндээ ялгаатай зүйлсийг өгүүлж буй зарим жишээг сонгон дор иш татав:

Лук 6:20-23-г уулан дээрх номлолыг давтсан мэт харагдавч үнэндээ уулан дээр бус тал газар хэлсэн номлол болохыг Лук 6:17-оос харж болно. Матайд тэмдэглэсэн уулан дээрх номлол нь Бурханы хаанчлалын өвтэгш иргэний шинж чанарыг дүрсэлсэн бол Лукт тэмдэглэсэн номлол нь Христийн дагалдагч хүний амьдралын хэв маягийг өгүүлсэн.

Лук 6:40 ба Матай 10:24 хоорондоо ижил мэт харагддаг. Гэвч Матайд Эзэн Есүс өөрийгөө багш гээд, биднийг өөрийн шавь гэсэн. Харин Лукт бусдыг сургаж буй нэгэн багш ба багшаасаа сурч байгаа нэгэн шавийн тухай өгүүлж байна. Матай 7:22 дээр Хаанд зориулсан үйлчлэлийг тодотгосон бол Лук 13:25-27 дээр Эзэнтэй нөхөрлөх нөхөрлөлийг дүрсэлсэн.

Лук 15:4-7 дээр фарисайчуудыг егөөдөн зэмлэж байгаа бол Матай 18:12, 13 дээр хүүхдүүдийн тухай, тэднийг гэсэн Бурханы хайрын тухай ярьж байна.

Иохан баптист зөвхөн итгэгчдийг байх үед “Тэр та нарт Ариун Сүнсээр баптисм хүртээнэ” (Марк 1:8; Иохан 1:33) гэсэн бол, фарисайчууд тэргүүтэй янз бүрийн хүмүүс цугласан үед “Тэр

та нарт Ариун Сүнс болон галаар баптисм хүртээнэ (шүүлтийн баптисм)” (Матай 3:11; Лук 3:16) гэж хэлжээ.

“Өөрсдийнхөө хэмжсэн хэмжээсээр” гэдэг үг Матай 7:2 дээр бусдыг шүүмжлэх хандлагыг маань, Марк 4:24 дээр Бурханы үгэнд анхаарал хандуулах байдлыг маань, Лук 6:38 дээр өгөөмөр занг маань илэрхийлсэн.

Тэгэхээр сайнмэдээний номууд хоорондын ийм ялгаа нь зөрчилдөж байгаа хэрэг биш, харин тунгаан бодогч итгэгч хүний бодол санаанд сүнсний хоол болгох үүднээс өгөгдсөн ажээ.

## **VII. САЙНМЭДЭЭНИЙ НОМУУДЫН ЗОХИОГЧ**

Сайнмэдээний номуудын төдийгүй Библийн аль ч номын хувьд хэн бичсэн тухай асуудлыг авч үзэхдээ гадаад баримт, дотоод баримт гэсэн хоёр төрлийн нотолгоог судлах жишиг байдаг. Шинэ гэрээний хорин долоон номд бүгдэд нь бид энэ жишгийг баримтлах болно. Тухайн номын бичигдсэн цаг үетэй хамгийн ойр буюу хоёроос гуравдугаар зууны үед амьдарч байсан “чуулганы эцгүүд”, гаж урсгалын номлогчид, хуурамч багш нарын бичиг зохиол, бүтээл туурвилаас гадаад баримтыг авч үздэг. Тэр хүмүүс тухайн номоос иш татах, битүүхэн өгүүлэх, эсвэл бүр тухайн ном болон зохиогчийн талаар мэдээлэл болох зүйл дурдсан байх тохиолдол олон. Жишээ нь гэвэл, Ромын

Клемент гэгч хүн нэгдүгээр зууны сүүл үед бичсэн туурвилдаа IКоринт номоос иш татсан байвал үүнийг Паулын нэрээр хэн нэг хүн хоёрдугаар зуунд зохиож бичсэн гэж үзэх боломжгүй болно. Дотоод баримтын хувьд гэвэл, тухайн номын бичлэгийн хэв маяг, үгийн сонголт, өгүүлж буй түүх, агуулга нь гадаад баримт материал хийгээд зохиогчийн өөрийнх нь мэдэгдэлтэй таарч байгаа эсэхийг авч үздэг. Жишээлбэл, Лук ба Үйлс номуудын бичлэгийн хэв маягаас харахад энэ хоёр номыг хоёуланг нь эмч мэргэжилтэй иудей бус хүн бичсэн гэж үзэх үндэслэлтэй байдаг.

Хоёрдугаар зууны гаж урсгалын төлөөлөгч Маркион гэгч хүний “канон” буюу хүлээн зөвшөөрөгдсөн номуудын жагсаалтыг нэлээд олон номд дурдсан байгаа. Маркион гэгч тэр хүн Лукийн сайнмэдээний хураангуй хэлбэр ба Паулын арван захидлыг л хүлээн зөвшөөрсөн байдаг. Хэдийгээр Маркион гэгч нь гаж буруу сургаалтай хүн байсан боловч, түүний гаргасан жагсаалт нь тухайн цаг үед ямар ямар номууд жишиг байсныг харах чухал түүхийн баримт болдог. Мураторийн канон бол (уг бичгийг олсон итали кардинал Мураторийн нэрээр нэрлэгдсэн) бүгдийг хамраагүй ч христитгэлийн канон болсон номуудыг үнэн зөв жагсаасан нэн эртний жагсаалт юм.

## ***ЗҮҮЛТ ТАЙЛБАР***

<sup>1</sup>Жэймс Ч. Ферналд. Фанк энд Вагналс компаниас хэвлэн гаргасан *“Ижил утга, эсрэг утга, угтвар үгийн стандарт гарын авлага”* ном, хуудас 175, “Бэлгэ тэмдэг” хэсэг.

<sup>2</sup>Виллиям Келли, *Лукийн сайнмэдээний илэрхийлэл*, хуудас 16.



# МАТАЙН БИЧСЭН САЙНМЭДЭЭ

## ОРШИЛ

*“Шинэ ба хуучин гэрээний түүхэн сэдэвтэй бичвэрүүд дотроос, бодол төсөөллийн уудмаараа, агуу их санаанд хамаатай нэн их баримт дурдаж байгаагаараа Матайгаас илүү гарах ном нэг ч үгүй.”*

*-Теодер Цан*

## I. БИЧЭЭС ДЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Матайн сайнмэдээ нь Хуучин ба Шинэ гэрээний хоорондох төгс гүүр юм. Матай номын хамгийн эхний үгс нь Хуучин гэрээн дэх Бурханы ард түмний өвөг эцэг Абрахам ба Израилийн хамгийн агуу хаан Давидыг дурдана. Цохон тэмдэглэж буй санаа, иудей маягийн хүчтэй өнгө аяс, еврей бичвэрүүдээс олонтоо иш татсан байдал, Шинэ гэрээний номуудын тэргүүнд байрласан байрлал зэргийг харвал энэ дэлхийд Христийн мэдээг хамгийн түрүүнд хүргэх зүй ёсны байрыг Матай ном эзэлжээ.

Өнө эртнээс нааш Матай ном дөрвөн сайнмэдээний түрүүнд байрласаар ирсэн. Сайнмэдээний номууд дотроос Матай номыг хамгийн түрүүнд бичигдсэн гэж саяхныг хүртэл бүх нийтээрээ үздэг байсан учраас тэр юм. Матай ном эмх цэгцтэй бичигдсэн тул чуулганы үеэр олуулаа уншихад тохиромжтой байдаг.

Тиймээс Матай нь Иоханы сайнмэдээнээс дутахааргүй өндөр байр суурь эзэлж иржээ.

Матай ном хамгийн эхэнд бичигдсэн сайнмэдээ мөн эсэх нь бүрэн батлагдсан зүйл биш. Гэхдээ анхны итгэгчид бараг бүгдээрээ иудей хүмүүс байсан бөгөөд тухайн үед хэдэн мянган иудей итгэгч байсан. Тиймээс анхны итгэгчдийн хэрэгцээ шаардлагыг түрүүлж хангах нь нэлээн үндэслэлтэй санагдана.

## II. ЗОХИОГЧ

Леви гэгддэг татвар хураагч Матай анхны сайнмэдээг бичсэн гэдгийг эртний сурвалжуудад буй гадаад баримтууд нийтээрээ баталж байна. Матай элч нарын дотор тийм ч алдартай нь биш учраас Матай бичээгүй байхад Матайн нэрийг дурдах учиргүй.

*Дидахэ* (Арван хоёр элчийн сургаал) хэмээх эртний бичвэрээс гадна, Христийг амиараа гэрчилсэн Иустин, Коринтын Дионисиус, Антиохын Теофил, Афины Афенагорас нар Матайн сайнмэдээнээс иш татсан байдаг. Чуулганы түүхч Юсевиус бээр Папиасын үгийг иш татан “Матай нь еврей хэл дээр *Логиа* бичсэн бөгөөд хүн бүр чадах чинээгээрээ түүнийг нь тайлбарласан” гэж тэмдэглэсэн байдаг. Иренаус, Пантаенус, Ориген нар энэ үгтэй санал нийлж байсан. “Еврей хэл” гэдэг үгийн Шинэ гэрээнд дурдагдсан байдлыг харахад энэ нь Эзэн Есүсийн цаг үед еврейчүүдийн хэрэглэдэг

байсан арамей хэлний нэгэн аялгуу бололтой байдаг. Харин “*Логиа*” гэж юу вэ? Ерөнхийдөө энэхүү грек үг нь Хуучин гэрээнд гардаг Бурханы айлдварууд адил тэнгэрийн “бошго үг” гэсэн утгатай. Гэхдээ Папиасын хэлсэнд ийм утгаар байх боломжгүй байна. Папиасын хэлсэн үгийг гурван хувилбараар ойлгож болно. Үүнд: (1) *Логиа* гэдэг нь Матайн *сайнмэдээг* хэлсэн. Өөрөөр хэлбэл, Матай иудейчүүдийг Христ уруу авчирч, еврей итгэгчдийг барьж босгохын тулд *сайнмэдээг* арамей хэл дээр бичсэн. Грек хувилбар нь үүний дараа бичигдсэн. (2) *Логиа* гэдэг нь зөвхөн Есүсийн айлдсан *үгсийг* хэлсэн. Хожим нь Матай тэдгээр үгийг *сайнмэдээнийхээ* номд оруулсан. (3) *Логиа* гэдэг нь Есүсийн Мессиа болохыг батлахын тулд Хуучин гэрээнээс *иш татсан үгсийг* хэлсэн. Эндээс 1 ба 2 дахь хувилбар нь 3 дахиа бодвол магадлал илүү өндөртэй.

Матай номын грек хувилбар зүгээр нэг орчуулга шиг сонсогддоггүй. Эртнээс нааш баримталж ирсэн уламжлалт үзэлд зарим үндэслэл бий. Тэрхүү уламжлалт үзэлд, Матай Палестинд арван таван жил номлосны дараа харь хүмүүст *сайнмэдээг* хүргэхээр тэндээс явсан гэж өгүүлдэг. Хэрэв тийм бол, арамей хэл дээр анхны хувилбар болгон бичсэн *сайнмэдээг* нь (эсвэл зөвхөн Христийн айлдваруудыг нь) уншиж Есүсийг өөрсдийн Мессиа болгон хүлээн авсан иудейчүүдийг Матай МЭ 45 онд орхин явж, дараахан нь бүх дэлхийн хүмүүст зориулж

сайнмэдээнийхээ грек хувилбарыг бичсэн болов уу. Матайтай нэг цаг үед амьдарч асан Иосеф бас үүнтэй адил зүйл хийсэн байдаг. Иосеф гэх иудейн түүхч *Иудейчүүдийн Дайн* бүтээлээ эхлээд арамей хэлээр ноороглоод эцсийн хувилбарыг нь грек хэл дээр бичжээ.

Хуучин гэрээг хайрладаг, бичих найруулах чадвартай, сүсэгтэй иудей хүн Матайн сайнмэдээг бичсэн гэдэгтэй дотоод баримт ч бас сайтар таарч байна. Матай Ромын эзэнт гүрэнд төрийн алба хашиж байсан хүний хувьд ард түмнийхээ хэл (арамей) болоод эрх баригч хүмүүсийн хэлийг (ромчууд зүүн нутагтаа латин биш грек хэлийг ашигладаг байсан) аль алийг нь мэддэг байсан байх учиртай. Тоон мэдээлэл, мөнгөтэй холбоотой сургаалт зүйрлэлүүд, мөнгө санхүүгийн нэршил зэргийг харвал татвар хураагч хүн бичсэн гэж үзэх үндэслэл байна. Мөн товч тодорхой, эмх цэгцтэй байдлыг нь ч дурдаж болно. Консерватив бус үзэлт эрдэмтэн Гүүдспид хүртэл тодорхой хэмжээнд ийм дотоод баримтыг үзээд энэ сайнмэдээг Матай бичсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Гэвч гадаад баримт хангалттай их, дотоод баримт таарч байгааг үл харгалзан консерватив бус үзэлтэй ихэнх эрдэмтэн энэ сайнмэдээг татвар хураагч Матай бичсэн гэх уламжлалт үзлийг үгүйсгэдэг. Ингэхдээ тэд хоёр шалтгаан гаргаж тавьдаг.

Нэгдүгээрт, тэд Марк номыг хамгийн эхэнд бичигдсэн гэж таамаглаад (өнөө цагт олон газар

үүнийг “туйлын үнэн” мэтээр зааж байна), Матай бол элч хүн, бүхнийг нүдээр үзэж харсан, тиймээс Маркийн материалаас (Маркийн сайнмэдээний 93 хувь нь сайнмэдээний бусад номуудад дурдагддаг) яагаад ийм ихээр авч ашиглав гэдэг. Юуны өмнө, Маркийн сайнмэдээ хамгийн эхэнд бичигдсэн гэдэг нь батлагдсан зүйл биш гэдгийг мартаж болохгүй. Харин ч эртний сурвалжуудад Матайн сайнмэдээг хамгийн эхэнд бичигдсэн гэдэг. Түүнээс гадна, анхны итгэгчид бараг бүгдээрээ иудейчүүд байсан тул Матайн сайнмэдээ хамгийн эхэнд бичигдсэн гэвэл илүү үндэслэлтэй болно. Гэхдээ Маркийн сайнмэдээг эхэнд бичигдсэн гэж үзлээ ч гэсэн (тийн үздэг консерватив үзэлтэй эрдэмтэн олон бий) болохгүй зүйл үгүй. Эртний чуулганы түүхэнд тэмдэглэснээр Матайн хамтран зүтгэгч элч Симон Петрийн дурсамж дуртгалыг Марк тэмдэглэсэн нь Маркийн сайнмэдээ аж (Марк номын оршлыг үз).

Хоёрдугаарт, Матай (эсвэл нүдээр гэрчлэгч хүн) бичээгүй гэдгийг батлахын тулд Матай номд сэтгэлд хоногшсон дуртгал дутмаг гэх санааг дэвшүүлдэг. Христийн үйлчлэлийг нүдээр харсан эсэх нь тодорхойгүй Маркийн сайнмэдээнд хүртэл өөрөө тэнд байсан мэт нарийн чамин мэдээлэл орсон байхад нүдээрээ үзсэн хүний сайнмэдээ тийм биш байгаа нь ямар учиртай вэ гэдэг. Энэ нь магад татвар хураагч хүний зан чанартай холбоотой байх. Эзэний маань сургаалыг илүүтэй оруулах гээд

шаардлагагүй зарим мэдээллийг Леви хассан болов уу. Маркийн сайнмэдээ эхэнд бичигдсэн бол тийм байх магадлал илүү өндөр. Хэрэв тийм бол, Петрийн дурсамжийг тэмдэглэсэн номд нарийн ширийн зүйл хангалттай орсныг Матай үзсэн байж таарна.

### **III. БИЧИГДСЭН ОГНОО**

Матай сайнмэдээгээ (эсвэл Есүсийн айлдваруудыг) анхлан арамай хэл дээр бичсэн гэх нийтээр баримталдаг уламжлалт үзэл үнэн бол түүнийгээ Эзэн Есүс дээш өргөгдсөнөөс хойш арван таван жилийн дараа буюу МЭ 45 онд бичсэн гэж үзэх нь зөв. Тэгвэл тэрээр канонд орсон одоогийн бүрэн сайнмэдээг грек хэл дээр 50 юм уу 55 онд, эсвэл бага зэрэг хожуу бичсэн байх ёстой.

Христ ирээдүйг урьдчилан хэлж чадна гэдэгт итгэдэггүй болон Бурханы илчлэлийг үгүйсгэдэг рационалист онолыг баримтлагч хүмүүс Матайн сайнмэдээг Иерусалимын сүйрлээс хойш (МЭ 70 он) бичигдсэн гэж үздэг.

### **IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ӨГҮҮЛЖ БУЙ ГОЛ СЭДЭВ**

Есүсийг дуудах үед Матай залуухан байсан. Иудей гаралтай, татвар хураагч мэргэжилтэй тэрээр Христийг дагахын тулд бүхнээ орхижээ. Тэрбээр арван хоёр элчийн нэг болсон. Мөн

анхны сайнмэдээг бичихээр сонгогдсон. Ерөнхийдөө Матай, Леви хоёрыг нэг хүн гэж үздэг (Марк 2:14; Лук 5:27).

Есүс бол израильчуудын удаан хүлээсэн Мессиа, Давидын сэнтийд суух хууль ёсны Хаан мөн гэдгийг Матай сайнмэдээндээ харуулахыг зорьсон.

Матай ном нь Христийн амьдралыг бүхэлд нь өгүүлээгүй. Матай ном Христийн угийн бичгээр эхэлж, араас нь хүүхэд насных нь үеэс цухас дурдаад шуудхан гуч орчим насандаа эхэлсэн үйлчлэл уруу нь очдог. Матай Ариун Сүнсээр удирдуулан, Бурханы *Тослогдсон Нэгэн* (Мессиа буюу Христ) болохыг нь харуулах мөчүүдийг Аврагч Есүсийн амьдрал ба үйлчлэлээс сонгож сайнмэдээний номдоо оруулжээ. Номын үйл явдал нь Христэд тулгасан ял, Христийн үхэл, оршуулга, амилал, тэнгэр өөд одсоныг өгүүлснээр оргилдоо хүрнэ. Мэдээж хэрэг, яг тэр оргил хэсэгт хүмүүний авралын үндэс суурь оршдог. Энэ ном нүгэлт хүний аврагдах замыг заасан гэхээсээ илүү, авралыг боломжтой болгосон Христийн ажлыг, золиос болсон амьдралыг нь өгүүлдэг учраас Матай номыг сайнмэдээ гэж нэрлэдэг.

Манай номын хувьд мэргэжлийн үг хэллэгээр бүх тайлбарыг хүргэхээс илүүтэй харин Библийг бие даан судалж, тунгаан бодоход нь урамшуулахыг хүсэж байна. Тэр дундаа Хаан Есүсээ эргэн ирэхийг хүлээх халуун

сэтгэлийг нь улам бүр өрдөж өгөхийг зорьж  
байгаа билээ.

Би ихэд дүрэлзсэн зүрхээр  
Би илүү найдсан сэтгэлээр  
Буцаж ирэх Христ Таны цагийг  
Учиргүй ихээр харуулднам  
Улайссан хөлөө газар тавихыг тань  
Тэсэж ядан хүлээнэм (Ф.У.Х. Майрсын “Элч  
Паул” шүлгийн хэсэг)



## ***ТОЙМ***

I. МЕССИА ХААНЫ УГИЙН БИЧИГ БА МЭНДЭЛСЭН ТҮҮХ (1-р бүлэг)

II. МЕССИА ХААНЫ ХҮҮХЭД НАС (2-р бүлэг)

III. МЕССИАГИЙН ҮЙЛЧЛЭЛИЙН БЭЛТГЭЛ БА ТОМИЛГОО (3, 4-р бүлэг)

IV. ХААНЧЛАЛЫН ҮНДСЭН ХУУЛЬ (5-7-р бүлэг)

V. МЕССИАГИЙН ХҮЧ БОЛОН НИГҮҮЛСЭЛ БҮХИЙ ГАЙХАМШГУУД БА ХҮМҮҮСИЙН ХАНДЛАГА (8:1-9:34)

VI. МЕССИА ХААНЫ ИЗРАИЛЬ УРУУ ИЛГЭЭСЭН ЭЛЧ НАР (9:35-10:42)

VII. ЭСЭРГҮҮЦЭЛ, ДУРГҮЙЦЭЛ УЛАМ ИХ НЭМЭГДСЭН НЬ (11, 12-р бүлэг)

VIII. ИЗРАИЛЬ ТАТГАЛЗСАН ТУЛ ХААН НЬ ТҮР ХУГАЦААНД ШИНЭ ХААНЧЛАЛ БАЙГУУЛАХАА МЭДЭГДСЭН НЬ (13-р бүлэг)

IX. МЕССИАГИЙН АГУУ НИГҮҮЛСЭЛД ДАЙСАГНАЛААР ХАРИУ БАРИВ (14:1-16:12)

X. ДАГАЛДАГЧДАА БЭЛТГЭЖ БУЙ ХААН  
(16:13-17:27)

XI. ДАГАЛДАГЧДАДАА ЗААВАРЧИЛЖ БУЙ  
ХААН (18-20-р бүлэг)

XII. ӨӨРИЙГӨӨ ХААН БОЛОХЫГ  
ИЛЭРХИЙЛСЭН БОЛОВЧ АРД ТҮМЭН НЬ  
ХҮЛЭЭН АВСАНГҮЙ (21-23-р бүлэг)

XIII. ЧИДУН УУЛАН ДЭЭР АЙЛДСАН  
ХААНЫ СУРГААЛ (24, 25-р бүлэг)

XIV. МЕССИА ХААНЫ ЗОВЛОН БА ҮХЭЛ (26,  
27-р бүлэг)

XV. МЕССИА ХААНЫ ЯЛАЛТ (28-р бүлэг)

## **ТАЙЛБАР**

### **I. МЕССИА ХААНЫ УГИЙН БИЧИГ БА МЭНДЭЛСЭН ТҮҮХ (1-р бүлэг)**

#### **A. Есүс Христийн угийн бичиг (1:1-17)**

Шинэ гэрээг өнгөцхөн уншиж байгаа хүн яагаад ийм уйтгартай гэмээр угийн бичгээс эхэлж байгаа юм бол хэмээн гайхаж болох юм. Нуршсан олон хүний нэрийг тийм ч их ач холбогдолтой гэж үзэхгүй учраас шууд алгасан өнгөрөөж ч магад.

Гэвч энэ угийн бичиг үнэхээр чухал. Энэ угийн бичиг нь Матай номд өгүүлж буй бүхний үндэс суурь юм. Есүс бол Давид хааны алтан ургийн хууль ёсны угсаа залгамжлагч гэдгийг харуулахгүйгээр Израилийн Мессиа Хаан гэдгийг батлах боломж үгүй. Тиймээс Матай зөв газраасаа эхэлсэн байна. Хойд эцэг болох Иосефоор дамжуулан Давидын сэнтийд залрах хууль ёсны эрхийг Есүс өвлөж авсан гэдгийг үүгээр тэр нотолсон.

Есүс бол Израилийн Хааны байр суурийг өвлөн авсныг харуулсан хууль эрхзүйн удам угсааг энэ угийн бичиг харуулсан. Харин Есүс бол мах цусныхаа дагуу Давидын Хүү мөн болохыг Лукийн сайнмэдээнд буй угийн бичиг харуулдаг. Есүс Христ нь Давидын хаан сэнтийг залгамжилсан хүү Соломоны хаант угсаатай Иосефын хууль ёсны хүү болохыг Матайн угийн бичиг баталсан. Тэгвэл мах цусны талаасаа, Есүс

Христ нь Давидын нөгөө хүү болох Натаны удмаас төрснийг Лукийн угийн бичиг баталсан. Матайн угийн бичиг нь Есүсийг өргөж авсан Иосефын өвөг дээдсийг авч үзсэн бол, Лук номын 3 дугаар бүлэгт өгүүлж буй угийн бичиг нь Есүсийн биеийг төрүүлсэн Мариагийн өвөг дээдсийг өгүүлсэн болов уу.

Мянган жилийн тэртээ Бурхан Давидтай ямар ч болзолгүй гэрээ байгуулж, мөнхийн хаанчлал, үүрд захирах хаант угсааг амласан (Дуулал 89:4, 36, 37). Тэрхүү гэрээ эдүгээ Христийн дотор биелэлээ олов. Есүс Христ Иосефоор дамжуулан Давидын сэнтийг өвлөх хууль ёсны эрхтэй бөгөөд Мариагаар дамжуулан Давидын жинхэнэ үр удам болжээ. Тэрээр мөнх амьдардаг учраас хаанчлал нь ч мөнх байна. Тэрээр Давидын агуу Хүү болж үүрд хаанчлах болно. Израилийн хаан сэнтийг залгамжлахад хэрэгтэй үндсэн хоёр шаардлага (хууль ёсны дагуу, мах цусны дагуу) Есүсийн дотор нэгэн зэрэг хангагдсан. Тэрээр мөнх оршигч учраас өөр залгамжлагч гарч ирэхгүй.

**[1:1-15] Абрахамын удам, Давидын удам, Есүс Христийн угийн бичиг** гэдэг үг Эхлэл 5:1 дээрх “Адамын уг угсаа ийм билээ” гэдэг үгтэй төстэй байна. Эхлэл ном анхны Адамыг танилцуулсан бол Матай ном сүүлчийн Адамыг танилцуулав. Эхний Адам нь анхны биет бүтээлийн тэргүүн болсон бол сүүлчийн Адам нь шинэ сүнслэг бүтээлийн тэргүүн болжээ.

Энэхүү сайнмэдээний гол цөм нь **Есүс Христ** юм. **Есүс** гэдэг нэр нь “Иехова-Аврагч” болохыг нь, **Христ** (“Тослогдсон”) гэдэг хэргэм нь израильчуудын удаан хүлээсэн Мессиа болохыг нь илэрхийлдэг. **Давидын удам** гэдэг хэргэм болбоос Хуучин гэрээн дэх Мессиа ба Хааны үүрэгтэй холбоотой. Харин **Абрахамын удам** гэдэг хэргэм нь бидний Эзэн бол еврейчүүдийн өвөг эцэг Абрахамд амласан амлалтын төгс биелэл гэдгийг илтгэдэг.

Энэхүү угийн бичиг түүхэн гурван үеэр хуваагдаж байна. Үүнд: Абрахамаас Иесси хүртэл, Давидаас Иосиа хүртэл, Иекониагаас Иосеф хүртэл. Эхнийх нь Давидыг хүртэл үргэлжилнэ. Хоёр дахь нь хаадын үе дуусах хүртэл хугацааг хамарна. Гурав дахь нь цөллөгөөс (МЭӨ 586 он) хойших үеийг хамаарна.

Энэхүү тэмдэглэлд хэд хэдэн онцлог бий. Жишээ нь, дөрвөн эмэгтэйг дурдсан: **Тамар, Рахаб, Рут, Батшеба (Уриагийн эхнэр)**. Дорнынхны гэрийн цадигт эмэгтэйчүүдийн нэр бичигдэх нь тун ховор атал энэ эмэгтэйчүүдийн нэрийг оруулсан нь гайхалтай. Учир нь эдгээрийн хоёр нь (Тамар, Рахаб) биеэ үнэлэгч байсан, нэг нь (Батшеба) завхайрсан. Мөн хоёр нь (Рахаб, Рут) харь үндэстэн. Христийн ирэлт нь нүгэлтэнд аврал, харь үндэстнүүдэд нигүүлсэл авчрах бөгөөд үндэс угсаа, эр эмийн ялгаанаас улбаатай саад тотгор Христийн дотор үгүй болно гэдгийг илэрхийлэхийн тулд Матай энэ

эмэгтэйчүүдийн нэрийг зориуд оруулсан болов уу.

**Иекониа** хааны нэрийг дурдсан нь ч бас сонирхолтой. Иеремиа 22:30 дээр Бурхан энэ хүний дээр хараал тунхагласан: ЭЗЭН ингэж айлдаж байна: “Энэ хүнийг үр хүүхэдгүй, өөрийн өдрүүддээ бүтэлгүй хүн гэж бич. Учир нь удмынх нь ямар ч хүн Давидын сэнтийд залран, Иудаг цааш захирахгүй” хэмээв. Есүс Иосефын жинхэнэ хүү байсан бол энэ хараалын дор төрөх байв. Гэхдээ тэрээр Давидын сэнтийг өвлөн авах эрхтэй болохын тулд Иосефын хууль ёсны хүү нь байх ёстой. Бурханы гайхамшгаар Есүс онгон эмэгтэй Мариагаас төрснөөр энэ асуудал шийдэгдэв. Иосефоор дамжуулан Есүс Давидын сэнтийг залгамжлах хууль ёсны эрхтэй болсон. Харин Мариагаар дамжуулан Давидын жинхэнэ хүү болсон. Мариа нь Иекониагийн удам биш учир Иекониагийн дээрх хараал Мариа болон түүний хүүхдүүдэд хамаагүй.

[1:16] Англи хэл дээр Есүс Иосеф, Мариа хоёрын аль алинаас нь төрсөн мэт буудаг бол монгол хэлнээ **Есүсийг төрүүлсэн Мариагийн нөхөр Иосеф** гэсэн нь Есүсийг Иосеф биш Мариа төрүүлсэн нь тодорхой ойлгогддог бөгөөд грек эхтэйгээ дүйж байна. Грек дээр төрүүлсэн этгээд (**тэр**) ганц тооны эм хүйстэй үг байна. Энэ нь Есүс Иосефоос биш, харин Мариагаас төрсөн гэдгийг харуулдаг. Түүнчлэн, энд дурдсан онцлогуудаас гадна, тайлбарлахад амаргүй зүйлс

ч энэ угийн бичигт бий гэдгийг зөвшөөрөх хэрэгтэй.

**[1:17]** Матай угийн бичгийг **арван дөрвөн үеэр** гурван хэсэгт хуваасан. Гэвч Хуучин гэрээг уншвал энэ угийн бичигт зарим хүний нэр ороогүй байгааг мэдэж болно. Тухайлбал, Иорам, Уззиа нарын (8 дугаар эшлэл) хооронд Ахазиа, Иоаш, Амазиа нар төр барьсан байдаг (2Хаад 8-14; 2Шастир 21-25).

Түүнээс гадна, Матай болон Лукийн тэмдэглэсэн угийн бичиг Шеалтиел, Зеруббабел гэх хоёр хүний нэр дээр давхацдаг (Матай 1:12, 13; Лук 3:27). Иосеф, Мариа хоёрын өвөг дээдэс энэ хоёр хүн дээр давхацсанаа дахиад салж байгаа нь хачирхалтай. Гэтэл, Матай, Лук хоёулаа Езра 3:2 дээр Зеруббабелыг Шеалтиелын хүү гэж тэмдэглэснийг баримталсан байхад 1Шастир 3:19 дээр Зеруббабелыг Педаиагийн хүү гэсэн байдаг нь энэ асуудлыг тайлбарлахад улам амаргүй болгодог.

Тайлбарлахад хэцүү гурав дахь асуудал бол Матайн угийн бичигт Давидаас Есүсийг хүртэл хорин долоон үе өнгөрсөн бол Лукийн угийн бичигт дөчин хоёр үе өнгөрсөн байдаг. Энэ хоёр сайнмэдээ хэдийгээр өөр өөр хүний удам судрын түүхийг бичсэн ч гэлээ, тооны хувьд ийм хол зөрүү гарч байгаа нь бас л хачирхалтай.

Библи судалж байгаа хүмүүс ийм асуудалд ямар хандлагатай байх ёстой вэ? Юуны түрүүнд бид бүхэн, Библи бол Бурханы амьсгалаар

бичигдсэн Бурханы үг, тиймээс ямар нэг алдаа мадаггүй ном гэдэгт бүрэн итгэх ёстой. Энэ бол бидний суурь юм. Хоёрдугаарт, Библи нь бидний хязгаарлагдмал хүрээнээс хальсан ном гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Учир нь Бурхан Өөрөө хэмжээ хязгааргүй нэгэн юм. Бид Бурханы үгийн үндсэн үнэнүүдийг ойлгож чадах боловч түүн дотор агуулагдах бүхнийг бүрэн гүйцэд мэдэж огт чадахгүй.

Тиймээс, Библи алдаатай учраас биш, харин бидний мэдлэг дутуу учраас энэ бүхнийг бид бүрэн ойлгохгүй байна хэмээн дүгнэж болно. Библи доторх тайлбарлахад хэцүү зүйлс нь харин ч улам бүр судлах, хайх сэдлийг бидэнд төрүүлдэг. “Хэргийг нууцлах нь Бурханы алдар. Тэднийг эрж олох нь хаадын алдар” (Сургаалт үгс 25:2).

Түүхчдийн хичээнгүй судалгаа, археологичдын малтлага зэрэг нь Библийн үгсийг худал болохыг баталж чадсан удаагүй. Эдүгээ бид тайлбарлаж чадахгүй байж болох ч, хоорондоо зөрчилдөж буй мэт харагдавч, тэр бүхэнд тайлбар зайлшгүй бий. Тэдгээр тайлбар нь сүнслэг ач холбогдол, ашиг тусаар дүүрэн гэдэг нь дамжиггүй.

## **Б. Есүс Христ Мариагаас төрсөн**

[1:18] Есүс Христ мэндлэхдээ энэ угийн бичигт дурдагдсан бүх хүнээс өөр байв. Бусад хүний хувьд “А нь Б-г төрүүлэв” гэсэн үг давтагддаг. Харин одоо хүмүүн эцэг байхгүйгээр



төрсөн тухай үзэх болно. Гайхамшгаар үр тогтсон тухай энгийн бөгөөд хүндэтгэлтэй өгүүлж. **Мариа, Иосефтой** гэрлэхээр амлалт өгсөн байв. Гэхдээ тэд хараахан хуримлаагүй байлаа. Шинэ гэрээний цаг үеийн сүй тавилт өнөөгийнхөөс илүү хатуу байсан бөгөөд сүй цуцлахыг гэр бүл салах хэмжээнд үзнэ. Сүй тавьсан хосууд хуримын ёслол өнгөртөл нэг гэрт орохгүй ч сүй тавьсан хүнээсээ гадуур харилцаанд орохыг завхайралд тооцож, үхэх ял оноодог байв.

Сүй тавьсан хугацаандаа Мариа биеэ ариунаар сахиж явсан ч **Ариун Сүнсний** гайхамшгаар жирэмсэн болжээ. Тэнгэрэлч түүнд ийм явдал болохыг нь урьдчилан мэдэгдэж, “Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ” (Лук 1:35) гэсэн. Мариа үүнээс болж хүмүүст нүдний үзүүр, ичгүүр гутамшиг болох байв. Учир нь онгон эмэгтэй хүүхэд төрүүлсэн явдал хүн төрөлхтний түүхэнд үгүй. Нөхөрт гараагүй эмэгтэй жирэмсэн болсныг үзвэл бүгд ганц л дүгнэлт гаргана.

**[1:19]** Мариа яагаад ийм болсон үнэн шалтгааныг **Иосеф** ч мэдээгүй байв. Сүйт бүсгүйнхээ байдалд дургүйцэх хоёр шалтгаан Иосефт байсан. Нэгд, сүйт бүсгүй нь түүнд илэрхий үнэнч бус хандсан. Хоёрт, Иосеф өөрөө буруугүй боловч Мариатай хамт буруутгагдах магадлалтай. Иосеф Мариад хайртай байсан боловч шударга бусыг огоорч чадахгүй байсан учраас Мариагаас чимээгүйхэн салахаар

шийджээ. Ийн завхайрсан эмэгтэйг олны өмнө гутамшиг болгодог хэдий ч Иосеф үүнийг хүссэнгүй.

**[1:20]** Зөөлөн сэтгэлтэй, гүн боддог энэ эр Мариаг хэрхэн хамгаалахаа төлөвлөж байх зуур **Эзэний тэнгэрэлч зүүдэнд нь үзэгдэв.** Эзэний тэнгэрэлч түүнтэй **“Давидын хүү Иосеф оо!”** хэмээн мэндчилсэн нь хааны удам болохыг нь сануулж, Израилийн Мессиа Хааны ер бусын ирэлтэд бэлтгэхийг зорьжээ. **Мариатай** гэрлэх нь буруу биш бөгөөд Мариаг сэрдсэн бодлууд бүгд үндэслэлгүй гэдгийг тэнгэрэлч хэлэв. Учир нь Мариагийн жирэмсэн болсон нь **Ариун Сүнсний** ажил ажээ.

**[1:21]** Дараа нь өнөөх тэнгэрэлч Мариагаас төрөх хүүхдийн хүйс, нэр, амьдралын зорилгыг илчилж өгсөн. Мариа хүү төрүүлэх бөгөөд тэр хүү **ЕСҮС** (Утга нь: “Иехова бол аврал” эсвэл “Аврагч Иехова”) гэж нэрлэгдэх ёстой. Тэр хүү нэрийнхээ ёсоор **ард түмнээ нүглээс нь аварна.** Энэ хүүхэд болбоос нүглийн шийтгэлээс хүмүүсийг аварч, эцэст нь бүх нүглийг арилган зайлуулах гэж газар дэлхийд буун ирсэн Иехова билээ.

**[1:22]** Матай эдгээр үйл явдлыг тэмдэглэж байхдаа хүн төрөлхтөнтэй харилцах Бурханы арга замд цоо шинэ эрин үе ирж буйг мэдэж байв. Мессиагийн тухай эш үзүүллэгийн үгс, удаан хугацааны нам жим байдлыг эвдэн эдүгээ амь оров. Исаиагийн битүүлэг эш үзүүллэг одоо Мариагийн хүүгээр биеллээ олов: **Энэ бүхэн**

**тохиолдсон нь эш үзүүлэгчээр дамжуулан Эзэний айлдсан нь биелэгдэхийн тулд болой.** Христийг мэндлэхээс 700 гаруй жилийн тэртээ эш үзүүлэгч Исаиагаар дамжуулан Эзэний айлдсан үгнээс Матай Бурханы илчлэлийг гарган ирж байна.

**[1:23]** Исаиа 7:14-ийн эш үзүүлэлэг энэ онцгой төрөлтийн талаар (“Харагтун, нэгэн онгон эмэгтэй жирэмсэн болж”), тэрхүү хүүхдийн хүйсийн тухай (“Хүү төрүүлнэ”), хүүг хэн гэж нэрлэхийг (“түүнийг Иммануел гэж нэрлэх болно”) урьдаас зөгнөсөн. Матай үүн дээр **Иммануел нь Бурхан бидэнтэй хамт** гэсэн утгатай болохыг тайлбарласан. Газар дэлхий дээр амьдарч байхад нь Христийг “Иммануел” гэж дуудсан тохиолдол байхгүй. Түүнийг үргэлж “Есүс” гэж дуудсан. Гэхдээ Есүс нэрийн утга нь (21 дүгээр эшлэлийн тайлбарыг үз) **Бурхан бидэнтэй хамт** буйг илтгэдэг. Түүнээс гадна, Иммануел гэдэг нэр Христийн хоёр дахь ирэлтэд илүү хамаатай нэр байж болох юм.

**[1:24]** Тэнгэрэлчийн үгнээс болоод Иосеф Мариагаас салах бодлоо орхисон. Тэрээр Есүсийг төрөх хүртэл Мариатай тавьсан сүйгээ хүлээн зөвшөөрч, Хүүг төрсний дараа түүнтэй гэрлэсэн.

**[1:25]** Мариа бүх амьдралынхаа турш онгон хэвээр байсан гэх сургаал ямар ч үндэслэлгүй болох нь эхнэрээ болгон авсан гэдэг эшлэлээс тодорхой байна. Мариа, Иосеф нарын дундаас хэд хэдэн хүүхэд төрсөн болохыг харж болох

эшлэлүүд: Матай 12:46; 13:55, 56; Марк 6:3; Иохан 7:3, 5; Үйлс 1:14; 1Коринт 9:5; Галат 1:19.

Иосеф Мариаг эхнэрээ болгохдоо хүүхдийг нь ч бас хүүгээ болгож үрчилж авсан. Ийнхүү Есүс Давидын сэнтийг залгамжлах хууль ёсны эрхтэй болсон. Зүүдэнд нь айлчилсан тэнгэрэлчийн үгийг дагаж Иосеф хүүхдийг **Есүс гэж нэрлэсэн**.

Ингээд Мессиа Хаан төрлөө. Мөнх Бурхан цаг хугацааны хэмжээс дотор орж ирлээ. Бүхнийг чадагч бээр нярай хүүхэд болов. Цог жавхлант алдрын Эзэн тэрхүү алдраа хүний биеэр далдалсан. “Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршлоо” (Колоссай 2:9).

## **II. МЕССИА ХААНЫ ХҮҮХЭД НАС (2-р бүлэг)**

### **A. Хаанд мөргөхөөр ирсэн мэргэд (2:1-12)**

[2:1, 2] Христийг мэндлэх үед болсон үйл явдлуудын цаг хугацааг хүмүүс амархан хольж хутгадаг. Херод хаан Есүсийг хөнөөх гэсэн оролдлого нь Мариа, Иосеф нарыг Бэтлэхэмд байх үеэр болсон мэт нэгдүгээр эшлэлээс харагдаж байгаа боловч бусад баримтыг үзвэл энэ үйл явдал Есүсийг мэндэлснээс нэг хоёр жилийн дараа болжээ. Арван нэгдүгээр эшлэлд Матайн тэмдэглэсний дагуу, мэргэд Есүсийг малын саравчинд биш гэрт харсан. Түүнээс гадна, Херод хоёр ба түүнээс доош насны хүүхдүүдийг

хөнөөх зарлиг гаргасан (16-р эшлэл). Тэгэхээр Христийн төрсөн өдрөөс хойш тодорхой хугацаа өнгөрсөн аж.

Агуу хэмээх **Херод** хаан нь Есавын удам учраас иудейчүүдийн эртний дайсан байсан. Херод иудаизмд элссэн байсан ч улс төрийн зорилгоор л байсан болов уу. **Иудейчүүдийн Хааныг** сураглан **дорно зүгээс мэргэдийг ирэхэд** Херодын хаанчлал бараг шувтарч байв. Энэ мэргэд нь байгаль ертөнцийг шүтдэг ямар нэг шашны тахилч санваартан байсан байх магадлалтай. Мэдлэг чадвар, зөн билгээс нь болоод тийм хүмүүсийг хаадын зөвлөхөөр сонгодог байв. Тэд дорно зүгт хаана амьдарч байсан, хэдүүлээ ирсэн, хэр удаан аялсан талаар бид мэдэхгүй.

Энэ мэргэд **зүүнгээд од** хараад **Хаан** төрснийг мэдсэн бололтой. Тийнхүү тэр Хаанд **мөргөхөөр** аянд гарцгаажээ. Тэд Мессиа ирэх тухай Хуучин гэрээний эш үзүүллэгүүдийг мэддэг байсан байж болох юм. Магадгүй Иаковоос нэг Од гарна гэсэн Балаамын зөгнөлийг (Тооллого 24:17) мэддэг байсан бөгөөд Христийн эхний ирэлтийн хугацааг урьдчилан хэлсэн Даниелийн далан долоо хоногийн эш үзүүллэгтэй (Даниел 9:24, 25) түүнийг холбож үзсэн байх. Гэхдээ энэ мэдлэг нь тэдэнд ер бусын аргаар ирсэн ч байж мэднэ.

Энэ бүлэгт дурдсан одны талаар шинжлэх ухааны үндэслэлтэй хэд хэдэн тайлбар бий. Тухайлбал, зарим хүн үүнийг гараг эрхсийн

огтлолцол байсан гэж хэлдэг. Гэхдээ уг одны байдал нэлээн этгээд сонин. Од мэргэдийн өмнө явсаар тэднийг Иерусалимаас Бэтлэхэм хүртэл дагуулан Есүсийн амьдарч байсан байшин дээр авчирсан (9-р эшлэл). Тэгээд зогссон. Ийм явдал урьд өмнө хэзээ ч болж байгаагүй бөгөөд үүнийг гайхамшиг байсан гэхээс өөр аргагүй юм.

**[2:3]** Иудейчүүдийн хаан болох хүүхэд төрсөн гэдгийг **сонссон Херод хаан түгшсэн**. Учир нь тийм хүүхэд байвал хаанчлалд нь аюултай. Мөн **Иерусалим даяараа** түүнтэй хамт **түгшсэн**. Уг нь энэ мэдээг сонсоод баярлах ёстой Иерусалим хотынхон Ромын захирагч нарын дургүйг хүргэчих вий гэсэндээ энэ мэдээнд огтхон ч баярлаагүй, харин ч санаа нь зовцгоосон.

**[2:4-6]** Херод иудейн шашны удирдагчдыг цуглуулаад **Христ хаана төрөх ёстойг** лавласан. **Ахлах тахилчид** гэдэг нь тэргүүн тахилчид ба түүний хөвгүүд (магадгүй гэр бүлийнх нь өөр зарим гишүүд) юм. **Ард олны дундах хуулийн багш нар** гэдэг нь Мосегийн хуульд мэргэшсэн хүмүүс. Тэд Мосегийн хуулийг хадгалж хамгаалж, зааж сургаж, ахмадуудын зөвлөлд шүүгч хийдэг. Тэдгээр тахилч, хуулийн багш нар даруй Мика 5:2-ыг иш татаж, Хааны төрөх газар бол **Иудей нутгийн Бетлехем** гэж хэлж өгсөн. Микагийн эш үзүүллэгт уг хотыг “Ефратын Бетлехем” гэж тодотгосон. Палестины нутаг Бетлехем нэртэй хэд хэдэн хот байсан учраас Микагийн эш үзүүллэг Ефратын гэж тодотгож

өгснөөр Хааны төрөх хот нь Иуда овгийн нутаг дэвсгэрт байрлах Бетлехем гэдгийг илтгэж байна.

**[2:7-8] Херод мэргэдийг нууцаар дуудаж, од үзэгдсэн цагийг тэднээс лавлаж асуусан.** Тэрээр зөв Хүүхдийг олж чадахгүй бол мэргэдээс олж авсан мэдээллээ ашиглан харгис хөнөөлт үйл хийхээр тэднийг ийн нууцаар дуудсан. Гэхдээ өөрийн жинхэнэ санаагаа нуун далдлахын тулд мэргэдийг **Бетлехем уруу явуулж**, Хүүхдийг эрж олбол өөрт нь эргэж мэдэгдэхийг даалгасан.

**[2:9]** Ингээд мэргэдийг замдаа гарах үед зүүнтээд **харсан од нь** дахин үзэгдсэн. Тэгэхээр энэ од тэднийг дорноос ирэх бүх замынх нь турш замчлаагүй аж. Гэтэл одоо дахин үзэгдэж, **Хүүхдийн байгаа** газар уруу тэднийг замчилж байна.

**[2:10]** Мэргэд одыг хараад үлэмж баяр хөөр болж ихэд баярласан. Харь үндэстэн эдгээр хүмүүс Христийг үнэн сэтгэлээс эрж хайжээ. Херод Түүнийг алахыг санаархсан. Тахилчид ба хуулийн багш нар тоогоогүй. Иерусалимынхан Түүний талаар сонсоод түгшсэн. Тэдний энэ хандлага бол Мессиагаа хэрхэн хүлээн авахын урьдач шинж байв.

**[2:11]** Тэгээд гэрт орж, эх **Мариагийнхаа хамт буй хүүхдийг хараад, сөгдөн Түүнд мөргөж, алт, гүгэл, миррийг бэлэг болгон барив.** Есүс эхийнхээ хамт байгааг харсан гэснийг анзаараарай. Мэргэд **Мариа эсвэл Иосефт бус, харин Есүст мөргөсөн.** (Иосефын

тухай бол энд дурдаагүй. Түүний талаар Матайн сайнмэдээнд эндээс хойш гарахгүй.) Бидний магтаал, хүндлэлийг хүртэх зохистой нь Мариа эсвэл Иосеф бус, харин Есүс билээ.

Тэдний авчирсан бэлэг чухал зүйлийг өгүүлдэг. Алт бол Бурхан хийгээд алдар хүндийн бэлгэдэл бөгөөд Есүсийн бурхан чанарыг өгүүлдэг. Гүгэл бол анхилуун үнэртэн ба тос. Энэ нь төгс нүгэлгүй амьдралын тансаг үнэрийг илэрхийлдэг. Мирр бол гашуун ургамал бөгөөд ертөнцийн нүглүүдийг үүрэх зовлонг нь зөгнөдөг. Харь үндэстнүүд бэлэг авчирсан нь Исаиа 60:6 дээр хэлсэн үгийг сануулж байна. Үндэстнүүд Мессиа дээр бэлэгтэй ирнэ гэдгийг Исаиа зөгнөсөн. Гэхдээ энд алт хийгээд гүглийг л дурдсан: “Тэд алт хийгээд гүгэл авчран, Эзэний магтаалыг тунхаглана.” Миррийг яагаад дурдаагүй вэ? Яагаад гэвэл Исаиа Христийн хоёр дахь ирэлтийн тухай ярьсан. Хүч чадал, агуу сүр жавхлантай ирэх ирэлтийн тухай. Тэр үед Христ зовлон амсахгүй учраас мирр байхгүй. Харин Матайн сайнмэдээнд өгүүлсэнчлэн харийн мэргэд мирр бэлэглэсэн. Яагаад гэвэл Христийн эхний ирэлт нь зовлонгийн төлөө байсан учраас тэр юм. Матайн сайнмэдээнд бид Христийн зовлонг хардаг. Харин Исаиагаас иш татсан саяын хэсэгт Христийн цог жавхлангийн тухай өгүүлсэн байна.

**[2:12] Херод уруу буцаж бүү оч гэж зүүдэнд нь Бурхан анхааруулсанд тэд өөр замаар нутгийн зүг одлоо. Үнэн сэтгэлээр Христтэй**



уулзаад хуучин замаараа явсан нэг ч хүн үгүй. Христтэй учирсан хүний амьдрал бүхлээрээ өөрчлөгддөг.

## **Б. Иосеф, Мариа, Есүс Египет уруу зугтав (2:13-15)**

**[2:13, 14]** Уг нь эхийг түрүүлж, хүүг дараа нь дурддаг. Гэвч энэ бол онцгой хүүхэд бөгөөд эхэнд байх ёстой (20, 21-р эшлэлийг мөн үз). Эзэн маань нялх балчир наснаасаа үхлийн аюултай тулгарсаар иржээ. Тэрээр үхэхийн төлөө төрсөн боловч Бурханы тогтоосон цагт л үхэх болно. Бурханы хүсэл дотор алхаж буй хүн ажлаа дуусгах хүртэл үхэшгүй билээ. **Эзэний тэнгэр элч Иосефын зүүдэнд үзэгдэж** гэр бүлээ аван **Египет уруу зугтахыг** анхааруулав. Херод тун удахгүй “эрж хайж, алж устгах” ажлаа эхлүүлэх гэж байв. Тиймээс Иосефын гэр бүл Херодын уур хилэнгээс зугтаж, Египетэд хоргодов. Тэд Египетэд хэр удаан амьдарсныг бид мэдэхгүй. Гэхдээ Херод нас барснаар тэд эх орондоо буцах боломжтой болсон.

**[2:15]** Ингээд Хуучин гэрээний бас нэгэн зөгнөл шинэ утгатай болов. Бурхан эш үзүүлэгч Хосеагаар дамжуулан “**Хүүгээ би Египетээс дуудсан**” (Хосеа 11:1) гэж айлджээ. Анхны утгаараа бол энэ үг Египетийн боолчлолоос чөлөөлөгдсөн Израилийн авралтай холбоотой. Гэхдээ энэ үг хоёр утгатай байж болно. Учир нь Израилийн түүх нь Мессиагийн түүхийн

бэлгэдэл болдог. Христ Египетээс Израиль руу буцсанаар энэ зөгнөл биелсэн.

Эзэн зөвт байдал дотор хаанчлахаар эргэн ирэх үед Египет мянган жилийн ерөөлийг хуваалцах улс орны нэг болно (Исаиа 19:21-25; Зефаниа 3:9, 10; Дуулал 68:31). Израильд угаас дайсагнагч энэ улс яагаад ийм их тааллыг хүртэнэ гэж? Эзэн Есүст хоргодох газар болж өгсөнд нь Бурханаас ирэх талархал ч байж мэдэх юм.

## **В. Херод Бетлехемийн хүүхдүүдийг хөнөөв (2:16-18)**

**[2:16]** Мэргэд буцаж ирэлгүй явсныг мэдээд **Херод мэхлэгдсэнээ** ойлгож, шинэ Хааныг олох найдваргүй болсноо ухаарав. Асар ихээр хилэгнэн уурласан тэрээр **Бетлехем болон ойр орчимд нь хоёр ба түүнээс доош насны бүх эрэгтэй хүүхдийг хөнөөх** тушаал гаргав. Хэдэн хүүхэд алуулсан талаарх янз бүрийн тооцоо бий. Тухайлбал, нэг судлаач хорин зургаа гэсэн тоо гаргасан байдаг. Ямартай ч хэдэн зуун хүүхэд байх боломж тун бага.

**[2:17, 18]** Хүүхдүүдийг хөнөөсний араас болсон **гашуудал бол эш үзүүлэгч Иеремиагийн** хэлсэн үгсийн биелэл байв:

ЭЗЭН ингэж айлдаж байна.

“Ихэд гашуудан уйлах дуу Рамад сонсдов.

Рахел хүүхдүүдийнхээ төлөө уйлна.

Тэд үгүй болсон тул

Тэрээр тайтгарал авахыг үл хүснэ.” (Иеремиа 31:15)

Энэ зөгнөлд **Рахел** Израиль үндэстнийг төлөөлж байна. **Рамад** (Бетлехемийн ойролцоо хүүхдүүдийг хөнөөсөн газар) оршуулагдсан Рахелаар Израиль үндэстний гашуудлыг дүрсэлсэн. Хүүхдүүдээ алдсан эцэг эхчүүд түүний булшны дэргэдүүр өнгөрөхийг Рахел тэдэнтэй хамт уйлж гашуудаж буйгаар илэрхийлсэн. Өөрийнх нь орыг булааж магадгүй хүүхдийг үгүй хийх гэсэн Херодын оролдлого зорьсондоо хүрээгүй бөгөөд харин ч түүхэнд нэрээ гутамшигтайгаар бичиж үлдээжээ.

### **Г. Иосеф, Мариа, Есүс Назар хотод суурьшив (2:19-23)**

Херодыг үхсэний дараа **Эзэний тэнгэрэлч Иосеф** дээр ирж, нутагтаа буцахад аюулгүй болсон гэдгийг хэлсэн. Иосеф гэр бүлээ аваад **Израилийн нутагт** ирээд Херодын хүү **Архел эцгийнхээ** орыг залгамжилж **Иудейг** захирч байгааг сонссон тул буцаж очихоос болгоомжилсон. **Бурхан зүүдэнд нь** үүнийг зөв гэсэн тул тэрээр хойд зүгийн **Галил хавь уруу** аялж, **Назар хотод** суурьшсан.

Эш үзүүлэгийн үг **биелснийг** Матай энд дөрөв дэх удаагаа дурдаж байна. Тэрээр **эш үзүүлэгчдийн** хэн нэгний нэрийг дурдаагүй боловч Мессиа **Назарынх гэж дуудагдах болно** гэдгийг эш үзүүлэгчид урьдаас хэлж байсан хэмээжээ. Шууд ингэж хэлсэн эш үзүүлэг

Хуучин гэрээн дотор үгүй. Харин Мессиаг Хуучин гэрээнд Мөчир гэж зөгнөсөн байдагтай зарим судлаачид үүнийг холбон тайлбарладаг. Тухайлбал, Исаиа 11:1 дээр “Иессийн хожуулаас нахиа гарч, үндэснээс нь МӨЧИР ургаж, жимс гаргана” гэсэн байна. Еврей хэлээр мөчир гэдгийг “*нэцээр*” гэх бөгөөд энэ нь Назар гэдэг үгтэй холбоотой байж болох юм. Бас нэгэн боломжит тайлбар бол, хүмүүс Назар хотыг дорд үздэг байсантай холбогдоно. Натаниелын асуултад энэ хандлага тодорхой харагддаг: “Назараас ямар нэгэн сайн юм гарч чадна гэж үү?” (Иохан 1:46). Назар хот муу нэртэй байсан учраас оршин суугчдыг нь ч бас дорд үздэг байв. Тиймээс 23 дугаар эшлэл дэх **“Тэрээр Назарынх гэж дуудагдах болно”** гэдэг үг нь түүнийг хүмүүс дорд үзэх болно гэсэн утгатай байж болох юм. “Есүсийг Назарынх гэж дуудах болно” гэж шууд хэлсэн үг Хуучин гэрээн дотроос олддохгүй боловч “Хүмүүс түүнийг үзэн ядаж, үгүйсгэх болно” (Исаиа 53:3) гэсэн үг бий. Бас өөр нэг газар түүнийг “хүн биш өт, хүмүүсийн буруутгал бөгөөд ард олны жигшил” (Дуулал 22:6) байх болно гэж хэлсэн. Яг илэрхий үгээр хэлээгүй боловч ийм санаа цухуйлгасан эш үзүүлэгчид хэд хэд бий.

Хүчит Бурхан газар дэлхийд бууж ирээд доромж утгатай нэр авчээ. Юутай их агуу зан чанар вэ! Түүний дагалдагч нар энэхүү доромжлолыг нь хуваалцах аз завшааныг хүртжээ (Еврей 13:13).

### III. МЕССИАГИЙН ҮЙЛЧЛЭЛИЙН БЭЛТГЭЛ БА ТОМИЛГОО (3, 4-р бүлэг)

#### A. Баптисм хүртээгч Иохан Эзэний замыг бэлтгэсэн нь (3:1-12)

Хоёр ба гуравдугаар бүлгийн дунд хорин найм юм уу хорин есөн жилийн хугацаа өнгөрсөн. Матай тэр хооронд болсон үйл явдлаас дурдаагүй. Энэ хугацаанд Есүс хожим хийх ажилдаа бэлтгэгдэн Назар хотод амьдарч байсан. Энэ он жилүүдэд тэрээр ямар нэг гайхамшиг үйлдээгүй. Гэсэн ч Бурханы мэлмийд төгс тааллыг олсон. Эзэн Есүсийн олны өмнө үйлдсэн үйлчлэлийнх нь талаар энэ бүлэгт бид авч үзнэ.


**[3:1, 2]** Баптисм хүртээгч Иохан бол Есүсээс зургаан сарын өмнө төрсөн үеэл нь (Лук 1:26, 36-г үз) бөгөөд Израилийн хааны өмнөх замыг бэлтгэхээр түүхийн тавцан дээр гарч ирсэн. Тэрээр Иерусалимаас Иордан орох замд байдаг хуурай ангамал **Иудейн цөлд** орогнож, **“Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал айсуй”** гэх мэдээг тунхаглаж байв. Хаан удахгүй ирэх гэж байна. Гэхдээ тэр Хаан гэм нүглээсээ зуурсан хүмүүсийг захирч чадах ч үгүй, бас захирах ч үгүй. Тиймээс ард түмэн нь нүглээ хүлээн зөвшөөрч, гэмт амьдралаа орхиж, амьдралынхаа чиглэлийг өөрчлөх ёстой. Бурхан тэднийг харанхуйн хаанчлалаас **тэнгэрийн хаанчлал** уруу дуудаж байна.

## ТЭНГЭРИЙН ХААНЧЛАЛ

Матайн сайнмэдээнд тэнгэрийн хаанчлал гэх үг гучин хоёр удаа дурдагдах бөгөөд Матай номын гуравдугаар бүлгийн хоёр дахь эшлэлд хамгийн анх удаа гарч байна. Энэ ухагдахууныг зөв ойлгоогүй хүн Матайн сайнмэдээг зөв ойлгож чадахгүй тул тэнгэрийн хаанчлал гэдэг нь ямар утгатай болохыг энд дэлгэрэнгүй тайлбарлав.

Бурханы захиргаа хэрэгжиж буй газар бол тэнгэрийн хаанчлал юм. “Тэнгэр” гэдэг үг нь Бурханыг илтгэдэг. Даниел 4:25 дугаар эшлэлд Даниел “Хамгийн Дээд Нэгэн” хаанчилдаг гэж хэлсэн. Харин дараагийн эшлэлд нь тэрээр “тэнгэр захирдаг” гэсэн. Хүмүүс Бурханы захиргаанд орж байгаа газарт тэнгэрийн хаанчлал оршдог.

Тэнгэрийн хаанчлал харагдах хоёр өнцөгтэй. Гадна талаас нь харвал, Бурханыг хамгийн дээд эрх мэдэл хэмээн амаараа хүлээн зөвшөөрсөн бүх хүн тэнгэрийн хаанчлалд байдаг. Харин дотор талаас нь харвал, зөвхөн дахин төрсөн хүмүүс л тэнгэрийн хаанчлалд багтдаг. Дараах хоёр дугуйгаар тэнгэрийн хаанчлалыг дүрслэн харуулав.



Том тойрог бол амаараа хүлээн зөвшөөрсөн хүмүүсийг илэрхийлнэ. Энэ нь Хааны захиргааг амаараа хүлээн зөвшөөрдөг хүмүүс юм. Энэ байдал тариачны сургаалт зүйрлэл (Матай 13:3-9), гичний үрийн сургаалт зүйрлэл (Матай 13:31, 32), исгэгч хөрөнгөний сургаалт зүйрлэлд (Матай 13:33) гардаг. Жижиг тойрог бол Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан дахин төрсөн хүмүүсийг илэрхийлнэ. Тиймээс тэнгэрийн хаанчлалд зөвхөн дахин төрсөн хүмүүс орж чадна (Матай 18:3).

Хаанчлалын талаар Библид дурдсан бүхнийг нэгтгэн үзвэл тэнгэрийн хаанчлал нь түүхэнд таван үе шаттайгаар илэрч байна. Үүнд:

(1) Уг хаанчлалын тухай Хуучин гэрээнд эш үзүүлсэн. Хэзээ ч усташгүй, эрх мэдэл нь бусад ард түмний гарт орохгүй нэгэн хаанчлалыг Бурхан байгуулна гэж Даниел зөгнөсөн (Даниел 2:44). Христ бүх дэлхийг гартаа оруулж, мөнх ноёрхлыг тогтоохын тулд ирнэ гэдгийг Даниел өнө эрт харсан (Даниел 7:13, 14; мөн Иеремиа 23:5, 6-г үз).

(2) Баптисм хүртээгч Иохан, Есүс, мөн Есүсийн арван хоёр шавь тэнгэрийн хаанчлалыг “ойрхон байна, ирсэн байна” гэж дүрсэлсэн (Матай 3:2; 4:17; 10:7). Матай 12:28 дээр Есүс, “Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулдаг бол Бурханы хаанчлал та нарт ирчхээд байна” хэмээн хэлсэн. Лук 17:21 дээр Есүс, “Харагтун, Бурханы хаанчлал нь та нарын дунд байна” гэж айлдсан. Хаан биеэрээ оршин байгаа газар

хаанчлал оршиж байсан. Бурханы хаанчлал ба тэнгэрийн хаанчлал гэсэн хэллэгүүд нь бие биеэ орлож хэрэглэгддэг.

(3) Тэнгэрийн хаанчлалын түр зуурын хэлбэр. Израильчууд Хааныгаа үгүйсгэсний дараа Тэрээр тэнгэр уруу буцсан. Хэдий өнөөдөр Хаан биеэрээ байхгүй боловч Түүний хаан суурийг хүлээн зөвшөөрч, уулан дээрх сургаал зэрэг өнөөгийн бидэнд хамаатай ёс суртахууны зарчмуудыг нь баримталдаг хүмүүсийн зүрхэнд тэнгэрийн хаанчлал оршиж байна. Тэнгэрийн хаанчлалын түр зуурын ийм хэлбэрийг Матай 13-р бүлгийн сургаалт зүйрлэлд дүрсэлсэн.

(4) Тэнгэрийн хаанчлал биетээр газар дэлхийд орших үе. Энэ бол Христийн мянган жилийн хаанчлал юм. Христ хаанчлалынхаа алдраар үзэгдэж, дүр нь хувирах үед тэнгэрийн хаанчлалын биет хэлбэр тодорхой хэмжээгээр харагдсан (Матай 17:1-8). Есүс Матай 8:11 дээр, “Дорноос хийгээд өрнөөс олноороо ирцгээж, тэнгэрийн хаанчлалд Абрахам, Исаак, Иаковтай хамт ширээнд тухлах болно” гэсэн нь тэнгэрийн хаанчлалын энэ үе шатыг хэлжээ.

(5) Тэнгэрийн хаанчлалын эцсийн үе шат бол мөнхийн хаанчлал. Үүнийг 2Петр 1:11 дээр “бидний Эзэн ба Аврагч Есүс Христийн мөнх хаанчлал” гэж дүрсэлсэн.

“Тэнгэрийн хаанчлал” гэдэг үг зөвхөн Матайн сайнмэдээнд гарна. Харин “Бурханы хаанчлал” гэдэг үг дөрвөн сайнмэдээнд бүгдэд нь дурдагдана. Гэхдээ энэ хоёр хэллэг ижил



утгатай бөгөөд ямар ч ялгаагүй. Тухайлбал, Матай 19:23 дээр Есүс “Баян хүн тэнгэрийн хаанчлалд орох нь нэн бэрх” гэж айлдсаныг Марк (10:23), Лукийн (18:24) сайнмэдээнд “Хөрөнгөтэй хүн Бурханы хаанчлалд орох нь бэрх” хэмээн тэмдэглэжээ (“Бурханы хаанчлал” –ыг ерөнхийд нь ижил байдлаар хэрэглэсэн Матай 19:24-г үз).

Тэнгэрийн хаанчлалд гаднаас харагдах байдал ба доторх бодит байдал гэж хоёр тал байдгийг бид дээр дурдсан. Энэ зарчим Бурханы хаанчлалд ч адил. Тэнгэрийн хаанчлал ба Бурханы хаанчлал гэдэг хэллэг ижил зүйлийг өгүүлж байгааг үүнээс бас харж болно. Бурханы хаанчлалд ч бас жинхэнэ ба хуурамч хүмүүс бий. Энэ тухай тариачны сургаалт зүйрлэл (Лук 8:4-10), гичний үрийн сургаалт зүйрлэл (Лук 13:18, 19), исгэгч хөрөнгөний сургаалт зүйрлэлд (Лук 13: 20, 21) өгүүлнэ. Дотоод тал нь л жинхэнэ бодит байдал учраас, зөвхөн дахин төрсөн хүмүүс Бурханы хаанчлалд орох боломжтой (Иохан 3:3, 5).

Эцэст нь хэлэхэд хаанчлал ба чуулган нэг зүйл биш. Христ үйлчлэлд орсон цагаас хаанчлал эхэлсэн. Харин чуулган Пентэкостын өдөр эхэлсэн (Үйлс 2-р бүлэг). Хаанчлал дэлхийн төгсгөл хүртэл газар дэлхийд байна. Харин чуулган шүүрэлт хүртэл (Христ тэнгэрээс буун ирээд бүх итгэгчдийг өөртэйгөө хамт байлгахаар газар дэлхийгээс чуулганыг дээш татан авах үе-1Тесалоник 4:13-18) газар дэлхийд байна. Христ

хоёр дахиа ирэх үед чуулган Түүнтэй хамт байж, сүйт бүсгүйн хувьд Түүнтэй хамт захирна. Эдүгээ хаанчлалын дотор талд байгаа хүмүүс буюу дахин төрсөн жинхэнэ итгэгчид чуулганд ч бас ордог.

**[3:3]** Одоо Матай 3-р бүлэг уруу буцаж очъё. Эзэний замыг бэлдэх Иоханы үйлчлэлийг түүний амьдарч асан цаг үеэс долоон зууны тэртээ **Исаиа** зөгнөн эш үзүүлсэн:

Цөлд хашхирагч нэгний дуу:

“Эзэний замыг бэлтгэцгээ.

Зэлүүд газарт Бурханд маань зориулан

Их замыг шулуутгацгаа.” (Исаиа 40:3)

Иохан бол тэр дуу юм. Сүнслэг талаас нь яривал, Израиль үндэстэн бол шимгүй хуурай тэр цөл юм. Иохан **Эзэний замыг бэлтгэхийг** хүмүүст уриалсан. Тэгэхийн тулд гэмшиж, гэмт амьдралаа хаях ёстой. Мөн тэрээр Эзэний **замыг шулуутгахыг** хүмүүст тунхагласан. Тэгэхийн тулд, Эзэнд захирагдахад саад болж байгаа бүхнийг амьдралаасаа зайлуулах хэрэгтэй.

**[3:4]** Баптисм хүртээгч Иохан **тэмээний хялгасаар** хийсэн хувцас өмсөж, **суран бүс** бүсэлдэг байв. Гэхдээ тэр нь өнөө цагийнх шиг хөвөн зөөлөн биш, биед ширүүн хувцас байсан. Үүгээрээ тэр Елиатай төстэй харагддаг байжээ (2Хаад 1:8). Елиагийнхтай ижил үйлчлэл хийж буйгаа итгэсэн иудейчүүдэд харуулахыг зорьсон байж болох юм (Малахи 4:5; Лук 1:17; Матай 11:14; 17:10-12). Иохан **царцаа, зэрлэг зөгийн балаар** хооллодог байсан. Тэрээр үйлчлэлийнхээ

төлөө л шатаж байсан учраас амьдралын тав тух, дур таашаалыг ийн огоорчээ.

Амьдралаас хүмүүсийн авахыг хүсдэг зүйлсийг анхаарч үздэггүй Иохан шиг хүнтэй уулзвал гэм хийсэн мэт нүд уруу нь ч эгцэлж чаддаггүй байсан биз ээ. Зөвхөн сүнслэг зүйлсийг бодит байдлаа болгосон түүнийг харсан зарим нэгэн нь хэчнээн ядуу дорой болохоо ухаардаг байсан байх. Өөрийгөө үгүйсгэсэн амьдралаараа тэрээр тухайн цаг үеийнхээ дэлхийлэг байдалд хатуу зэмлэл болов.

**[3:5, 6]** Түүнийг сонсох гэсэн хүмүүс **Иерусалим, бүх Иудей, Иордан** хавийн нутгуудаас цугларав. Тунхагласан мэдээг нь зарим хүн хүлээн авч, ирж буй Хаанд захирагдахад бэлэн гэдгээ хэлэн **Иордан голд түүгээр баптисм хүртэцгээв.**

**[3:7]** Харин **фарисай ба садукайчуудын** хувьд байдал өөр байв. Тэд сонсохоор ирсэн ч үнэн сэтгэлээсээ биш гэдгийг Иохан мэдэж байлаа. Иохан тэдний үнэн чанарыг мэднэ: **Фарисайчууд** өөрсдийгөө хуульд чин сүсэгтэй гэж хэлэх мөртлөө дотор сэтгэл нь завхарч, хууран мэхлэл, хоёр нүүр, заль мэхээр дүүрсэн гэхдээ өөрсдийгөө зөвт гэж итгэдэг бардам хүмүүс юм. Харин **садукайчууд** бол биеийн амилал, тэнгэрэлч, сүнсний үхэшгүй байдал, мөнхийн шийтгэл гэх мэт суурь сургаалуудыг үгүйсгэдэг нийгмийн дээд зиндааны шашны бүлэглэл. **Ирэх уур хилэнгээс** зугтахыг хүсэх атлаа гэмших сонирхолгүй тэднийг хараад

Иохан аль алиныг нь **хорт могойн удам** гэж дуудав.

**[3:8]** Үнэхээр үнэн сэтгэлээсээ гэмшихийг хүсэж байгаа бол **гэмшилд зохистой үр жимс гаргахыг** Иохан тэдэнд уриалсан. Жинхэнэ гэмшил гэдгийг Ж.Р.Мюллер бээр “Хэрэв хэдхэн нулимс, багахан харамсал, жаахан айдсаас хэтрээгүй бол түүнийг огтхон ч гэмшил гэхгүй. Гэмшиж буй нүглээ хаяж, цоо шинэ ариун замаар алхаж эхлэх нь жинхэнэ гэмшил мөн” хэмээн тодорхойлсон.

**[3:9]** **Абрахамын** үр удам байснаараа диваажинд орох эрхтэй болохгүй. Иудейчүүд үүнийг ойлгох хэрэгтэй байв. Авралын нигүүлсэл нь удам дамжиж өвлөгдөхгүй. Хэрэв хүсэх л юм бол, Бурхан Иорданы **чулуунуудыг ч Абрахамын хүүхдүүд** болгож чадна. Энэ нь фарисай ба садукайчуудын аврагдахаас ч хялбар бүтэх ажил юм.

**[3:10]** **Моддын үндсэнд сүх хэдийнээ зоогджээ** гэсэн үгээрээ Бурханы шүүлтийн ажил эхлэх гэж байна шүү гэдгийг Иохан мэдэгдсэн. Христ ирээд газар дэлхийд амьдарсан нь бүх хүнийг шалгах сорилт болсон. Үр жимсгүй хүмүүс нь үр жимс гаргадаггүй мод адил **цавчигдан галд хаягдах болно.**

**[3:11, 12]** Иохан 7-10 дугаар эшлэлд зөвхөн фарисай ба садукайчуудад хандаж (7-р эшлэл) үг хэлсэн. Харин одоо өөрийг нь сонсож байгаа худал, үнэн бүгдэд хандан ярьж байна. Тэрбээр өөрийнх нь үйлчлэл хийгээд удахгүй ирэх

Мессиагийн үйлчлэл хоорондоо ямар их ялгаатайг тайлбарлаж байна. Иохан **гэмшлийн төлөө усаар баптисм хүртээдэг**. Усан баптисм нь жирийн нэг ёслол, бэлгэдэл бөгөөд ариусгах хүч агуулдаггүй. **Гэмшил** үнэн сэтгэлээсээ байсан ч хүнийг бүрэн аврал уруу авчраагүй. Иохан хийж буй үйлчлэлээ бэлтгэл ажил учраас бүрэн бүтэн биш гэж үзсэн. Мессиа хүрч ирэхэд Иохан сүүдэрт нь дарагдаж үзэгдэхээ болино. Мессиа илүү хүчирхэг, илүү чухал. Мессиагийн ажил Иоханыхоос ч агуу байх бөгөөд тэрээр **Ариун Сүнс ба галаар баптисм хүртээнэ**.

**Ариун Сүнсээр** хүртээх баптисм нь галаар хүртээх баптисмаас огт өөр. Ариун Сүнсний баптисм нь ерөөл авчирна. **Галаар** хүртээх баптисм нь шүүлт авчирна. Ариун Сүнсний баптисм нь Пентэкостын өдөр тохиосон бол галаар хүртээх баптисм нь ирээдүйд болно. Ариун Сүнсний баптисм нь Эзэн Есүст жинхэнээр итгэгч бүгдийг амсах сайхан ивээл. Галаар хүртээх баптисм нь үл итгэгч бүхний ирээдүйн хувь тавилан. Ариун Сүнсний баптисм нь дотроо гэмшсэн израильчуудын гаднах тэмдэг бол, галаар хүртээх баптисм нь фарисай ба садукайчууд хийгээд жинхэнэ гэмшилгүй хүн бүрд зориулагджээ.

Зарим хүн, Ариун Сүнсний баптисм ба галаар хүртээх баптисм нь нэг үйл явдал гэж заадаг. Өөрөөр хэлбэл, галаар хүртээх баптисм бол Пентэкостын өдөр Сүнс өгөгдөх үед үзэгдсэн гал мэт хэлүүдийг хэлж байна гэдэг. Харин 12-р

эшлэлд галыг шүүлттэй холбосон учраас ингэж үзэх үндэслэлгүй юм.

Иохан галаар хүртээх баптисм гэснийхээ араас залгаад шууд шүүлтийн тухай ярьсан. Эзэнийг тэрээр цайруулсан үр тариагаа **шигшүүрээр** шигшиж буй хүнээр зүйрлэсэн. Энэ явцад **буудай** нь (жинхэнэ итгэгчид) газарт шууд унах бөгөөд буудайг **саравчинд** хураана. Харин **хальс** (үл итгэгчид) нь салхинд хийсэн хол унахад дараа нь цуглуулж, **унтаршгүй галд** шатаана. Арван хоёрдугаар эшлэлд гарч буй гал гэдэг үг нь шүүлт шийтгэл гэсэн утгатай. Түүнээс гадна, арван хоёрдугаар эшлэл бол арван нэгдүгээр эшлэлийн үргэлжлэл. Тийм учраас галаар баптисм хүртээнэ гэдгийг шүүлт онооно гэсэн утгаар ойлгох нь хамгийн тохирч байна.

### **Б. Иохан Есүст баптисм хүртээсэн нь (3:13-17)**

**[3:13]** Есүс **Иоханаар баптисм хүртэхийн тулд Галилаас доод Иордан** хүртэл ойролцоогоор 96км газрыг явган туулжээ. Үүгээрээ Эзэн Есүс баптисм хэмээх ёслолд ямар их ач холбогдол өгч байгаагаа харуулсан. Тиймээс Эзэн Есүсийн дагалдагчид бид ч гэсэн баптисмыг чухалд тооцох ёстой.

**[3:14, 15]** Есүст гэмших нүгэл байхгүйг мэдэх Иохан Түүнд баптисм хүртээхээс татгалзав. Үнэндээ Иохан өөрөө Есүсээр баптисм хүртэх нь зүй ёсны зүйл гэдэг нь ч үнэн. Есүс үүнийг үгүйсгээгүй. Харин **бүхий л зөвт байдлыг**

**биелүүлэхэд нийцэж** буй арга зам учраас өөрт нь баптисм хүртээхийг Есүс дахин хүссэн. Гэмшиж баптисм хүртэхээр ирж буй бурханлаг израильчуудтай өөрийгөө адил болгохын тулд баптисм хийлгэхийг Есүс зөвд тооцсон.

Гэхдээ үүнд түүнээс ч гүн утга учир бий. Баптисм нь хүний нүглийн эсрэг Бурханы шаардаж байгаа бүх зөвт шаардлагыг Есүс биелүүлэх арга замыг бэлгэдэн харуулж буй ёслол. Ус уруу орсон нь Голгота толгой дээрх Бурханы шүүлтийн усанд хүртэх баптисмыг нь бэлгэдсэн. Уснаас гарч ирсэн нь үхлээс амилахыг нь бэлгэдсэн. Үхэл, оршуулга, амиллаараа Есүс Бурханы шударга ёсны бүх шаардлага нэхэмжлэлийг хангаж, нүгэлт хүн зөвтгөгдөж болох зөвт суурийг бэлтгэн өгсөн.

**[3:16, 17] Уснаас гарсан даруйд нь Бурханы Сүнс тэнгэрээс тагтаа мэт бууж, түүн дээр ирэхийг Есүс харлаа.** Хуучин гэрээний үед хүн болон эд юмсыг ариун зорилгод тусгаарлахын тулд “ариун тосоор” тосолдог (Гэтлэл 30:25-30) байсны адил Есүс Ариун Сүнсний томилон тосолсон Мессиа байв.

Гурвалын гишүүд гурвуулаа оролцсон маш онцгой ариун үйл явдал энд тохиож байна. **Хайрт Хүү** байна. Ариун **Сүнс** ч бас **тагтаа** хэлбэрээр байна. Эцэг Бурханы дуун **тэнгэрээс** сонстож, Есүсийн дээр ерөөлөө тунхагласан. Энэ бол гарцаагүй мартагдашгүй явдал билээ. Учир нь Бурханы дуу хоолой хуучин гэрээний бичвэрээс иш татсан: **“Хайрт Хүү минь энэ**

**билээ** (Дуулал 2:7). **Таалал минь Түүнд оршдог** (Исаиа 42:1)” Онцгой Хүүгээ машид таалж буйгаа илэрхийлэн Эцэг Бурхан тэнгэрээс ярьсан гурван тохиолдлын нэг нь энэ юм. Нөгөө хоёр тохиолдол нь Матай 17:5, Иохан 12:28 дээр гарна.

### **Г. Есүс Сатанд соригдсон нь (4:1-11)**

**[4:1]** Есүс соригдохын тулд **Сүнсээр хөтлөгдөн** явсан нь хачирхалтай санагдаж болох юм. Ариун Сүнс яагаад Түүнийг ийм зүйл уруу дагуулсан юм бол оо? Яагаад гэвэл, энэ дэлхийд биелүүлэхээр ирсэн ажлаа гүйцэтгэхэд Тэр зан чанарын хувьд зохистой гэдгийг харуулахын тулд ийм сорилт хэрэгтэй байсан. Анхны Адам Еден цэцэрлэгт дайсантай учрах үедээ дэлхийг захирах шалгуурт тэнцэхгүй хүн болохоо харуулсан. Харин сүүлчийн Адам диаволтой нүүр тулаад ямар ч сэвгүй гарч ирж байна.

“Сорих” гэж орчуулагдсан грек үг хоёр утгатай: (1) шалгах, туршиж батлах (Иохан 6:6; 2Коринт 13:5; Еврей 11:17); (2) бузар мууд уруу татагдах. Ариун Сүнс Христийг шалган туршиж батлан харуулсан. Диавол түүнийг бузар мууг хийлгэхээр уруу татахыг хичээсэн.

Эзэн Есүсийн сорилттой холбоотой маш гүнзгий нууц бий. “Тэр нүгэлд унах боломжтой байсан гэж үү?” гэх асуулт гарцаагүй урган гардаг. Хэрэв “үгүй” гэвэл “Хэрэв Тэр нүгэлд унах боломжгүй байсан юм бол түүний сорилт нь хэрхэн жинхэнэ сорилт болох юм бэ?” гэсэн асуулт араас нь урган гарна. Хэрэв “тийм” гэж



хариулбал хүн болсон Бурхан хэрхэн нүгэл хийх боломжтой байх билээ гэдэг асуулттай тулгарна.

Юуны түрүүнд, Есүс Христ бол Бурхан гэдгийг санах нь чухал. Бурхан нүгэл үйлддэггүй. Түүнээс гадна Тэр бас хүн юм. Гэхдээ, Тэр хүнийхээ хувьд нүгэл хийх боломжтой, Бурханыхаа хувьд боломжгүй байсан гэвэл бичвэрийн үндэслэлгүй үг болно. Христийн дотор ямар ч нүгэл байгаагүй болохыг Шинэ гэрээний бичээч нар хэд хэдэн газар дурдсан байдаг. “Тэр бол нүглийг үл мэдэгч” (2Коринт 5:21) гэж Паул бичсэн. “Тэр нүгэл үйлдээгүй” (1Петр 2:22) гэж Петр хэлсэн. “Түүний дотор ямар ч нүгэл үгүй” (1Иохан 3:5) гэж Иохан тэмдэглэсэн.

Бидэнтэй адил нь гэвэл, Есүсийг гаднаас нь сорих боломжтой аж. Сатан хүрч ирээд Бурханы хүслийн эсрэг зүйл санал болгосон. Харин биднээс ялгаатай нь гэвэл, Түүний дотор нүгэлт хүсэл, дур тачаал төрөх боломжгүй. Түүнээс гадна, Сатаны өгөөшийг үмхэх ямар нэгэн өдөөлт Түүний дотор байгаагүй (Иохан 14:30).

Есүс нүгэл үйлдээгүй ч Түүнд ирсэн сорилт бодит байсан. Сатаны уруу татлага Түүнд тулгарах боломжтой байсан, гэхдээ Тэрээр ёс суртахууны хувьд нүгэлд унах боломжгүй байв. Тэрээр зөвхөн Эцэгийнхээ юу хийдгийг харснаа л хийх боломжтой байсан (Иохан 5:19). Тэгэхээр Эцэг нь хэзээ нэгэн цагт нүгэл үйлдэхийг Тэр харна гэх нь огт боломжгүй. Тэрээр Өөрийн

эрхээр юуг ч хийж чадахгүй (Иохан 5:30). Эцэг нь хэзээ ч уруу татлагад унах эрх Түүнд өгөхгүй.

Энэхүү сорилт нь нүгэл хийх эсэхийг нь үзэн гэж биш, харин туйлын хүнд дарамт дор ч гэсэн Бурханы үгийг дагахаас өөр юу ч хийхгүй гэдгийг нь батлах зорилготой байсан.

Хэрэв Есүс бусад хүн шиг нүгэл хийж чадах байсан гэвэл, Тэр одоо ч гэсэн тэнгэрт хүн хэвээр байгаа гэдгийг тайлбарлахад асуудал үүснэ. Тэр одоо ч гэсэн нүгэл хийж чадна гэж үү? Огтхон ч үгүй.

**[4:2, 3] Дөчин өдөр, дөчин шөнө мацаг барьсны** дараа Есүс **өлсжээ**. (**Дөчийн** тоо бичвэрт сорилт, шалгууртай холбоотой хэрэглэгдэх нь элбэг.) Бие махбодын энэ хэрэгцээ нь дайсанд давуу тал олгодог. Тэрээр үүнийгээ олон хүн дээр ашиглаж иржээ. Тэрээр Есүсийг гайхамшигт хүчээ ашиглан цөлийн **чулуунуудыг талх** болгож хувиргахыг ятгасан. Тийн ятгахдаа **“Чи Бурханы Хүү мөн аваас”** гэж хэлсэн нь итгэхгүй эргэлзэж байгаа санаа биш юм. Харин **“Чи Бурханы Хүү мөн юм чинь”** гэсэн утга илэрхийлдэг. Есүсийг баптисм хийлгэх үед Эцэг Бурханаас айлдсан үгийг диавол энд иш татаж байна. Сатаны энэ үгийг грек эх хэл дээр нь үзвэл, хэлж буй нь үнэн болохыг баталсан утга илэрхийлдэг өгүүлбэрзүйн бүтэц ашигласан байдаг. Тиймээс тэрээр Есүсийг хүч чадлаа ашиглаад өлсгөлөнгөө дарахыг ятгасан гэсэн үг.

Эзэн Есүс Сатаны ятгалгад автаж, бурханлаг хүчээ ашиглан биеийн хэрэгцээгээ хангавал Бурханд шууд дуулгаваргүй хандсан хэрэг болно. Сатаны саналын цаана Эхлэл 3:6 (хүнс болоход шимтэй) цуурайтаж байна. Иохан энэ сорилтыг “махбодын хүсэл тачаал” (ИИохан 2:16) гэж тодорхойлсон. Бидний хувьд, биеийн хүслээ өөгшүүлж, Бурханы хаанчлал ба зөвт байдлыг эрмэлзэхийн оронд тав тухыг эрэлхийлэх нь энэ сорилтын хэлбэр юм. “Чи амьдрах хэрэгтэй биз дээ” гэж диавол хэлдэг.

**[4:4]** Есүс энэхүү уруу татлагад Бурханы үгээс иш татан **хариулсан**. Бид амьдрах ёстой биш, харин Бурханд дуулгавартай байх ёстойг Эзэний маань жишээ зааж байна. **Талхтай** болох нь бус, харин **Бурханы үг бүрийг** дуулгавартай дагах нь амьдралд хамгийн чухал зүйл аж. Есүс чулууг талх болгох заавар Эцэгээс аваагүй учир, хэчнээн их өлссөн ч, Сатаны үгэнд орж, дураараа үйлдэл хийхгүй.

**[4:5, 6]** Хоёр дахь сорилт **сүмийн орой дээр** Иерусалимд болсон. **Доош үсэрч** Бурханы Хүү болохоо ер бусын аргаар үзүүлээч хэмээн диавол Есүсийг ятгасан. Дуулал 91:11, 12-т Бурханаас Мессиад амласан үгийг Сатан иш татахдаа хэрэв гэсэн үг хэрэглэсэн нь энд ч бас эргэлзэж тээнэгэлзсэн утга илэрхийлээгүй.

Олны анхаарлыг өөр дээрээ хандуулах үйлдэл хийж Мессиа гэдгээ харуулах сорилт Есүст ирсэн. Тэрээр зовлон амсахгүйгээр алдарт хүрэх боломжтой байв. Тэрээр загалмайг

алгасаад сэнтийд хүрэх боломжтой байв. Гэвч тийм үйлдэл Бурханы хүсэлд нийцэхгүй. Ийм хандлагыг Иохан “амьдралын бардамнал” (1Иохан 2:16) гэж тодорхойлсон байдаг. Энэ нь Еден цэцэрлэгт байсан “мэргэн болгочихмоор хүсүүштэй модноос” (Эхлэл 3:6) идэх хүсэлтэй адил бөгөөд Бурханы хүслийг харгалзан үзэхгүйгээр өөрийнхөө замаар алдарт хүрэх гэсэн оролдлого болно. Христийн зовлонг хуваалцалгүй шашинлаг байр суурьтай болох гэсэн хүслээр дамжин энэ сорилт бидэнд ирдэг. Бид өөрсдөдөө агуу зүйлсийг хайж, хүнд хэцүү зүйл тулгарах үед зугтаж, нуугддаг. Бид Бурханы хүслийг үл тоомсорлоод, өөрсдийгөө өргөмжилбөл Бурханыг сорьж буй хэрэг.

[4:7] Сатаны дайралтад **Есүс** дахин бичвэрээс иш татан хариулж байна: **“Чи Бурхан Эзэнэ бүү сорь’ гэж бичигдсэн байдаг.”** (Дэд хууль 6:16-г үз.) Бурхан Мессиаг хамгаална гэдгээ амласан. Гэхдээ эхлээд Бурханы хүслийг дагаж амьдрах ёстой. Дуулгаваргүй мөртлөө Бурханы амлалтыг барих нь Бурханыг сорьж буй хэрэг юм. Есүс бол Мессиа гэдгийг илчлэх цаг гарцаагүй ирнэ. Гэхдээ эхлээд загалмайг дайрах ёстой. Сэнтийд залрахын өмнө тахилын ширээг давах ёстой байв. Алдрын титмээс урд өргөст титэм өмсөх учиртай байлаа. Есүс Бурханы цагийг хүлээх бөгөөд Бурханы хүслийг гүйцэлдүүлэх болно.

[4:8, 9] Гурав дахь сорилтод **диавол** Есүсийг **асар өндөр ууланд аваачаад, ертөнцийн бүх**

**хаанчлалыг үзүүлсэн.** Өөрт нь мөргөвөл хариуд нь тэдгээр хаанчлалыг өгөхөө амласан. Энэ сорилт нь **мөргөл** буюу сүнсний зан үйлтэй холбоотой ч дэлхий дахиныг захирах эрх мэдлийг авахын тулд Сатанд мөргөхийг бидний Эзэнд санал болгосон уруу татах оролдлого байв. **Дэлхийн бүх хаанчлал, сүр хүчийг** санал болгосон шагнал “нүдний шунал хүслийг” (1Иохан 2:16) хөдөлгөдөг.

Тэгэхээр одоогоор энэ дэлхийн хаанчлалууд диаволын мэдэлд байдаг гэсэн үг юм. Тэр бол “энэ үеийн бурхан” (2Коринт 4:4) бөгөөд “бүх ертөнц муу нэгний доор байдаг” (1Иохан 5:19). Есүс хоёр дахь ирэлтээрээ хаадын Хаан (Илчлэл 19:16) болон үзэгдэх үед “энэ ертөнцийн хаанчлалууд” Түүнийх болно (Илчлэл 11:15). Есүс Бурханы тогтоосон цагийг зөрчихгүй бөгөөд Сатанд хэзээ ч мөргөхгүй.

Бидний хувьд хоёр янзын сорилт бий: (1) Бурханы хүүхэд болж Сүнсээр төрсөн эрхээ энэ ертөнцийн өнгөрөн одож буй алдраар солих. (2) Бүтээгчид бус, бүтээлд мөргөж, үйлчлэх.

**[4:10]** Есүс сорилтыг эсэргүүцэхдээ гурав дахь удаагаа Хуучин гэрээнээс иш татаж байна: **“Чи Эзэн Бурхандаа мөргөж, зөвхөн Түүнд үйлчлэх ёстой.”** Мөргөл хийгээд мөргөлөөс гарч байгаа үйлчлэл нь зөвхөн Бурханд зориулагдах ёстой. Сатанд мөргөнө гэдэг нь түүнийг Бурхан хэмээн үзэж байгаа хэрэг юм.

Есүсийн сорилтыг тэмдэглэсэн Матайн тэмдэглэл нь дарааллын хувьд Лукийнхаас (4:1-

13) ондоо байна. Матайн тэмдэглэсэн дараалал нь цөлд израильчуудад тулгарсан сорилттой (Гэтлэл 16:17; 32) адилтгах зорилготой байсан гэж зарим хүн үздэг. Есүс хүнд хэцүүтэй нүүр тулахдаа израильчуудаас огт өөр хариу үзүүлсэн.

**[4:11]** Есүс Сатаны сорилтыг амжилттай няцаах үед **диавол түүнийг орхиж** явсан. Сорилтууд ер нь усны тогтуун урсгал мэт биш далайн хүчит давлагаа мэт ирдэг. “Урсгал мэт дайсан ирвэл ЭЗЭНий салхи түүнийг хөөн явуулна” (Исаиа 59:19). Бурханы зарц нарыг сорилтод орвол юутай их урам зориг өгөх үг вэ!

**Тэнгэрэлч нар хүрч ирээд Түүнд үйлчилсэн** гэж энд өгүүлж байгаа боловч ер бусын энэ тусламж нь юу байсан талаар тодорхой тайлбарлаагүй байна. Магадгүй тэнгэрэлч нар Түүнд идэх хоол, уух унд өгч, биеийг нь тэнхрэхэд тусалсан байх боломжтой.

Диавол Ариун Сүнсээр удирдуулж буй хүн уруу дайрч болох боловч өөрийг нь Бурханы үгээр эсэргүүцвэл ямар ч хүчгүй гэдгийг бид Есүсийн туулсан сорилтоос ойлгож авдаг.

### **Г. Есүс Галилын үйлчлэлээ эхлүүлэв (4:12-17)**

Иудейд бараг жил шахам хийсэн Есүсийн үйлчлэлийн талаар Матай ямар нэг юм өгүүлээгүй. Энэ нэг жилийг Иохан 1-4 дүгээр бүлэгт өгүүлсэн ба Матай 4:11 болон Матай 4:12-ын хооронд болж өнгөрсөн гэж үзвэл таардаг. Матай биднийг Есүсийн сорилтоос шууд Галилд хийсэн үйлчлэл уруу нь авчирч байна.

**[4:12]** Баптисм хүртээгч **Иохан шоронд хоригдсон гэдгийг Есүс сонсов.** Энэ нь Өөрийг нь үгүйсгэх ёр байсныг Есүс мэдэж байв. Хааны элчийг үгүйсгэж байгаа хүмүүс Хааныг үгүйсгэж байгаагаас ялгаагүй юм. Гэхдээ Тэр айсандаа хойд зүгийн **Галил** уруу яваагүй. Харин ч Иоханыг шоронд хорьсон Херодын хаанчлалын яг төвд нь очжээ. Иудейчүүд Өөрөөс нь татгалзах үед сайнмэдээг харь үндэстнүүд уруу хүргэх болно гэдгийг Есүс харь үндэстнүүдийн Галил уруу очсоноороо харуулсан.

**[4:13]** Есүс эхлээд Назарт ирсэн. Хүмүүс Өөрийг нь алах гэж оролдох хүртэл тэндээ байж байгаад харь үндэстнүүдэд авралыг тунхаглахаар тэндээс явсан. Тэндээсээ тэр Галил нуурын эрэг дээрх **Капернаум** хотод иржээ. Тэр хавийн нутагт анх **Зебулун, Нафтали** овог суурьшсан бөгөөд тэр цагаас хойш Капернаум хот уг нутгийн төв болж байв.

**[4:14-16]** Есүс Галилд ирсэн нь **Исаиа 9:1, 2-**ын биелэл болсон. **Галилд амьдарч байсан харанхуй бүдүүлэг мухар сүсэгт харь үндэстнүүд их гэрлийг** буюу ертөнцийн **Гэрэл Христийг** үзэцгээсэн.

**[4:17]** **Тэр цагаас эхлэн Есүс, Иоханы тунхаглаж байсан мэдээг үргэлжлүүлэн, “Гэмшигтүн, учир нь тэнгэрийн хаанчлал ойрхон байна”** хэмээн тунхаглаж эхлэв. Тэрээр Өөрийн хаанчлалд хүмүүсийг бэлтгэхийн тулд тэднийг уриалж байна. Хаан нь ирчихсэн учир хаанчлал ойрхон байсан.

#### **Д. Есүс дөрвөн загасчныг дуудсан нь (4:18-22)**

**[4:18, 19]** Үнэндээ энд **Петр, Андрей хоёрыг** Есүс хоёр дахь удаагаа дуудаж байна. Иохан 1:35-42-т тэднийг авралд дуудсан бол энд тэднийг үйлчлэлд дуудаж байна. Эхний үйл явдал нь Иудейд болсон бол энэ нь Галилд болж байна. Петр, Андрей хоёр загасчид байсан ч Есүс тэднийг **хүмүүсийн загасчин** болгохоор дуудсан. Тэдний үүрэг бол Христийг **дагах**. Есүсийн үүрэг бол тэднийг амжилттай загасчид **болгох**. Христийг дагах нь биеэрээ ойр байхаас илүү зүйл юм. Тэд Христийн зан чанарыг дуурайх ёстой. Учир нь тэдний үйлчлэл бол зан чанарын үйлчлэл юм. Тэдний дотор юу байгаа нь юу ярьсан, юу хийсэн гэдгээс нь илүү чухал. Тийм учраас, жинхэнэ сүнслэг байдлыг бид уран цэцэн үг, хувийн зан араншин, ухаантай нотолгоогоор орлуулж болохгүй. Христийн дагалдагч хүн загас буй газарт очиж, тохирох өгөөшийг ашиглан, тухгүй таагүй нөхцөл байдалд ч дасан зохицож, тэвчээртэй байж, хараанд өртөлгүй хүлээн суухыг сурдаг.

**[4:20]** Петр, Андрей хоёр Эзэний дуудлагыг сонсоод **тэр даруй** түүнийг нь хүлээн авсан. Тэд жинхэнэ итгэлээр **тороо орхисон**. Жинхэнэ зориулалт, үнэн сэтгэлээр тэд Есүсийг **дагасан**.

**[4:21, 22]** Дараа нь Есүс **Иаков, Иохан нарыг** дуудсан. Тэд ч бас тэр даруй түүнийг дагасан. Тэд амьжиргааныхаа хэрэгслийг төдийгүй **эцгийгээ** ч орхисон. Тэд Есүсийг дэлхийн бүх холбоо хамаарлаас дээгүүр тавьсан.



Христийн дуудлагыг хүлээн авсан энэ загасчид дэлхий дахинд сайнмэдээ түгээх ажилд томоохон үүрэг гүйцэтгэсэн билээ. Хэрэв тэд торныхоо дэргэд үлдсэн бол тэдний тухай бид сонсохгүй байх байв. Христийг Эзэн гэж захирагдахад орчлон ертөнцөд өөрчлөлт авчирч чадна.

### **Е. Есүс олон түмнийг эдгээсэн нь (4:23-25)**

Эзэн Есүс гурван талбарт үйлчлэлээ явуулсан: Тэрээр **синагогуудад** Бурханы үгийг зааж, **хаанчлалын сайнмэдээг** тунхаглаж, өвчтэй хүмүүсийг эдгээсэн. Өвчтэй хүмүүсийг эдгээх гайхамшиг нь Есүс гэж хэн болохыг, хийж буй үйлчлэлийг нь гэрчлэх (Еврей 2:3, 4) зорилготой байсан. Матай 5-7 дугаар бүлэг бол заах номлох үйлчлэлийнх нь жишээ юм. Харин 8-9 дүгээр бүлэгт Түүний гайхамшгуудыг дүрсэлдэг.

**[4:23] Сайнмэдээ** гэдэг үг Шинэ гэрээнд хамгийн анх энэ эшлэлд ашиглагдаж байна. Энэ нь “авралын мэдээ” юм. Дэлхийн түүхийн бүх цаг үед цорын ганц сайнмэдээ, аврагдах ганцхан зам байсан.

## САЙНМЭДЭЭ

Сайнмэдээ нь Бурханы нигүүлслээс урган гарсан (Ефес 2:8). Мөнх амийг хүртэх зохисгүй нүгэлт хүмүүст Бурхан мөнх амийг бэлэг болгон өгдөг гэдэг нь сайнмэдээний утга юм.

Сайнмэдээний үндэс бол загалмай дээрх Христийн ажил юм (1Коринт 15:1-4). Бурханы шударга ёсны нэхэмжлэл шаардлагыг бүгдийг нь Аврагч маань биелүүлж, итгэсэн нүгэлтнийг зөвтгөх боломжийг Бурханд олгосон. Хуучин гэрээний итгэгчдийн хувьд Христийн ажил нь ирээдүйн үйл явдал байсан боловч тэд ч гэсэн Христийн ажлаар аврагдаж байсан. Тэд Мессиагийн талаар тийм ихийг мэдэхгүй байсан байж болох ч хожим хэрэгжих Христийн ажлыг Бурхан тэдэнд хамааруулан тооцжээ. Нэг ёсондоо тэд зээлээр аврагдаж байсан юм. Бид ч гэсэн Христийн ажлаар дамжуулан аврагддаг. Гэхдээ тэднээс ялгаатай нь, бидний хувьд Христийн ажил бол нэгэнт хийгдсэн зүйл юм.

Сайнмэдээг зөвхөн итгэлээр хүлээн авдаг (Ефес 2:8). Хуучин гэрээний үед хүмүүс Бурханы айлдсан үгэнд итгэж аврагддаг байсан. Харин энэ үед бол цорын ганц авралын зам болох Хүүгийнх нь талаарх гэрчлэлд итгэн аврагддаг (1Иохан 5:11, 12). Сайнмэдээний туйлын зорилго нь хүмүүсийг тэнгэрт диваажинд хүргэх. Хуучин гэрээний ариун хүмүүсийн нэгэн адил (Еврей 11:10, 14-16) бидэнд ч бас тэнгэрт мөнх орших найдвар бий (2Коринт 5:6-10).

Хэдийгээр сайнмэдээ ганц боловч цаг хугацааны янз бүрийн үеүдэд сайнмэдээ нь өөр өөр шинж чанартай байв. Тухайлбал, хаанчлалын сайнмэдээ ба Бурханы нигүүлслийн сайнмэдээ нь хоорондоо ялгарах онцлогтой. Хаанчлалын сайнмэдээ нь “Гэмшиж, Мессиаг хүлээн ав. Тэгвэл Түүний хаанчлал газар дэлхий дээр байгуулагдах үед та нар тэрхүү хаанчлалд орох болно” гэдэг. Нигүүлслийн сайнмэдээ нь “Гэмшиж, Христийг хүлээн ав. Тэгвэл та нар Түүнтэй уулзахаар, мөнхөд Түүнтэй байхаар дээш авагдах болно” гэдэг. Үндсэндээ бол энэ хоёр хоёулаа нэг сайнмэдээ юм. Аль аль нь итгэлээр дамжуулан нигүүлслийн улмаас аврагдах авралыг тунхагладаг. Гэхдээ Бурханы хэрэгжүүлж буй хөтөлбөрийн тухайн үеийн (диспенсаци) зорилгоос болж өөр өөр хэлбэрээр илэрдэг.

Есүс хаанчлалын сайнмэдээг тунхаглах үедээ Өөрийгөө еврейчүүдийн Хаан болохыг мэдэгдэж, өөрийнх нь хаанчлалд хэрхэн орохыг тайлбарлав. Түүний хийсэн гайхамшгууд нь тэрхүү хаанчлалын сайн сайхан шинж чанарыг харуулсан.<sup>3</sup>

**[4:24, 25] Түүний тухай зар бүх Сири (Израилийн хойд болон зүүн хойд нутаг) даяар тархав. Зовж шаналсан, чөтгөр шүглэсэн, тахир дутуу бүхнийг Есүс эдгээжээ. Хүмүүс түүнийг Галил, Декаполь (Палестины зүүн хойд зүгт байрлах харь үндэстнүүдийн арван холбоотон хот), Иерусалим, Иудей, Иордан**

голын зүүнтэйгээс эрж хайн ирцгээж байв. “Тэр нутгаас түр хугацаанд ч болов үхэл ба өвчин алга болжээ” хэмээн Б.Б.Ворфилд бичсэн байдаг. Олон түмэн Галилд болж буй мэдээг дуулаад гайхаж алмайрсан нь дамжиггүй.

#### **IV. ХААНЧЛАЛЫН ҮНДСЭН ХУУЛЬ (5-7-р бүлэг)**

Уулан дээрх сургаалыг Шинэ гэрээний эхэн хэсэгт байрлуулсан нь санаандгүй хэрэг биш. Энэ сургаал хэчнээн чухал болохыг байрлалаас нь харж болох юм. Эзэн Хаан өөрийн албатуудаас ямар зан чанар, хандлага үйл хүсдэг болохоо энэ сургаалдаа тусгасан.

Энэ сургаал аврагдах замыг заагаагүйгээс гадна аврагдаагүй хүмүүст зориулагдаагүй болно. Үүнийг Эзэн Есүс дагалдагч нартаа хандаж (5:1, 2) айлдсан бөгөөд өөрийнх нь хаанчлалд албатууд нь ямар байх ёстойг харуулахыг зорьсон. Нэг ёсондоо энэ сургаал бол хаанчлалын үндсэн хууль юм. Христийг Хаан гэж үздэг, өнгөрсөн, одоо, ирээдүйн бүх хүнд энэ сургаал зориулагдсан. Христийг энэ дэлхий дээр амьдарч байхад энэ сургаал дагалдагч нарт нь шууд хамаатай байсан. Эдүгээ Эзэн маань тэнгэрт хаанчилж буй энэ үед Түүнийг зүрх сэтгэлдээ Хаан болгон өргөмжилдөг бүгдэд хамаатай юм. Эцэст нь, зовлонгийн үе болон мянган жилийн хаанчлалын

үеэр Христийн дагалдагч нарын зан үйлийн зарчим болно.

Зөвлөл (өөрөөр хэлбэл, Иудейчүүдийн ахлагч нарын зөвлөл, 5:22), тахилын ширээ (5:23, 24), Иерусалим (5:35) гэх мэт ухагдахууныг харахад уг сургаалд иудей хэв шинж агуулагдаж байдаг. Гэхдээ үүнийг өнгөрсөн ба ирээдүйн еврей итгэгчдэд л хамаатай гэж хэлбэл буруу болно. Есүс Христийг Хаан гэж үздэг бүх үеийн хүмүүст энэ сургаал зориулагджээ.

#### **А. Жинхэнэ ивээл (5:1-12)**

**[5:1, 2]** Энэхүү сургаал нь ерөөл гэж юу болох тухай өгүүлснээр эхэлдэг. Христийн хаанчлалын төгс төгөлдөр иргэнийг энд тодорхойлсон. Христийн хаанчлалын жишиг, үнэлэмж энэ ертөнцийнхөөс тэс өөр болохыг эндээс харж болно. А.У.Тозер энэ сургаалын тухай: “Хүн төрөлхтөн гэж хэн бэ гэдгийг үнэн зөв тодорхойлж гэвэл Есүс Христийн уулан дээр заасан сургаалыг яг эсрэгээр нь хэлэхэд болно” гэсэн байдаг.

**[5:3]** Эхний ерөөлийг **сүнсэн дотроо ядуу** хүмүүст хандан хэлсэн. Энэ нь төрөлх зан араншныг хэлээгүй, харин сайн дурын сонголт ба сахилга батыг хэлсэн. **Сүнсэн дотроо ядуу** хүмүүс гэдэг нь өөрсдийн сул доройг ухаарч, Бурханы төгс хүчинд түшиглэгчид юм. Тэд сүнслэг хэрэгцээгээ мэдэрдэг бөгөөд Эзэнээс хангамжийг нь олдог. Өөртөө бардаж, өөрийгөө

өргөмжилдөг хүмүүст багтах зайгүй **тэнгэрийн хаанчлал** тийм хүмүүсийнх билээ.

**[5:4] Гашуудаж буй хүмүүс ерөөлтэй еэ!**

Тэд тайвшрах өдөр ирнэ. Энд дурдагдсан гашуудагсад бол амьдралын элдэв зовлонгоос болж гашуудаж буй хүмүүс биш. Харин Эзэн Есүстэй нөхөрлөсөн учраас гашуудлыг мэдэрч буй хүмүүс юм. Эзэн Есүс энэ ертөнцийн нүгэл хийгээд нүглээс улбаатай өвдөлтөд гашууддаг. Тэр хүмүүс Эзэн Есүсийн энэ гашуудлыг хуваалцдаг. Тэд өөрсдийнхөө нүгэлд гашууддаг. Түүнээс гадна, энэ ертөнцийн муу муухайг хараад сэтгэл нь өвдөж, Аврагчийг хүлээн авахаас татгалзаж байгаад нь гуниглаж, Түүний өршөөлийг үл ойшоогчдыг хүлээж буй аймшигт сүйрлийг бодохдоо гашууддаг. Ирээдүйд Бурхан “тэдний нүднээс нулимс бүрийг нь арчих” (Илчлэл 21:4) үед энэ хүмүүс **тайвшрал авах болно**. Итгэгчид зөвхөн энэ амьдралдаа л гашуудна. Харин үл итгэгчдийн өнөөгийн гашуудал бол мөнх зовлонгийнх нь амталгаа төдий юм.

**[5:5] Гурав дахь ерөөл дөлгөөн хүмүүст хандсан. Тэд дэлхийг өвлөх болно.** Энэ хүмүүсийн угийн зан нь догшин омог, огцом уур, ширүүн байдал байж болох юм. Харин Христийн үлгэр жишээг сайн дураар даган дуурайхдаа дөлгөөн, даруу (Матай 11:29-ийг үз) болдог. Дөлгөөн зан гэдэг нь өөрийнхөө дорд байр суурийг хүлээн зөвшөөрсөн байдал юм. Дөлгөөн хүн өөрийнхөө төлөө хүлцэнгүй ханддаг бол

Бурханы төлөө дуугарахдаа, бусдыг өмгөөлөн хамгаалахдаа арслан мэт байдаг.

Дөлгөөн хүмүүс одоо дэлхийг өвлөхгүй. Харин ч доромжлол, шударга бусыг хүртэнэ. Гэхдээ Христ мянган жилийн хугацаанд амар амгалан, амжилт цэцэглэлт дотор хаанчлах үеэр **дэлхийг** бодитоор **өвлөх** болно.

**[5:6]** Дараагийн ерөөлийг **зөвт байдлын төлөө өлсөж, цангагч хүмүүст** айлдсан. Бурхан тэднийг хангалуун болгохоо амлаж байна. Тэд бол **зөвт байдлын төлөө** зүрх нь асаж байдаг хүмүүс юм. Тэд нийгэмдээ шударга ёс, зөвт байдал, ёс зүйг хүсдэг. Мөн чуулгандаа ариун амьдралыг хүсдэг. Гамалиел Брэдфорд тэдэн шиг хүмүүсийг дараах байдлаар тодорхойлсон: “Тэдний цангааг дэлхийн ямар ч булаг шанд тайлж чадахгүй. Тэдний өлсгөлөнг Христээс өөр юу ч цагтаж дийлэхгүй. Тиймээс тэд үүнийхээ төлөө үхэхэд ч бэлэн байдаг.” Христийн хаанчлал ирэх үед энэ хүмүүс ханатлаа цадах болно. Учир нь тэр цагт зөвт байдал ноёрхож, шударга бус явдал үгүй болж, хүмүүсийн ёс суртахуун дээд цэгтээ хүрнэ.

**[5:7]** Эзэний хаанчлалд **энэрэнгүй хүмүүс ерөөлтэй. Учир нь тэд өршөөл энэрэл хүртэнэ.** Энэрэнгүй байх гэдэг нь сайхан сэтгэлтэй байхыг хэлнэ. Нэг утгаараа бол энэрэнгүй байх гэдэг нь шийтгэл хүртэх ёстой хүнд шийтгэл үзүүлэхгүй өнгөрөхийг хэлнэ. Өргөн утгаараа бол тусламж дэмжлэг хэрэгтэй хүмүүст туслах юм. Нүглийнхээ улмаас хүртэх ёстой байсан

шийтгэлийг маань хэлтрүүлж, Христийн ажлаар дамжуулан бидэнд сайхан сэтгэл гаргасан нь Бурханаас бидэнд үзүүлсэн энэрэл өршөөл мөн. Бусдад энэрэнгүй хандах нь Бурханы зан чанарыг харуулж байгаа хэрэг юм.

**Энэрэнгүй хүн энэрэл өршөөл хүртэнэ.** Эзэн Есүс энд итгэгч нүгэлтнүүдэд Бурханаас хүртээдэг авралын энэрэл өршөөлийн тухай яриагүй. Хүнийг аврахын тулд Бурханы үзүүлдэг өршөөл энэрэл нь болзолгүй, үнэ төлбөргүй бэлэг бөгөөд тухайн хүний энэрэнгүй эсэхээс хамаарахгүй. Энд Эзэн Есүс, христитгэгчийн амьдралд хэрэгтэй энэрэл өршөөл ба хожмын өдөр ажил үйлсээ шалгуулах үед (1Коринт 3:12-15) хэрэгтэй энэрэл өршөөлийн тухай ярьж байна. Энэрэнгүй бус хүн энэрэл өршөөл хүртэхгүй. Авах шагнал нь ч гэсэн түүнийгээ дагаад багасна.

**[5:8] Зүрхэндээ цэвэр ариун байгсад Бурханыг харна** гэдгийг энд амлаж байна. Зүрхэндээ цэвэр ариун байгсад гэдэг нь чигч сэтгэлтэй, ариун бодолтой, цэвэр мөс чанартай хүмүүсийг хэлнэ. **Тэд Бурханыг харна** гэдгийг хэд хэдэн утгаар ойлгож болох юм. Нэгт, **зүрхэндээ цэвэр ариун байгсад** Үг ба Сүнс доторх нөхөрлөлөөр дамжуулан **Бурханыг харна**. Хоёрт, тэд Эзэнээс өгсөн ер бусын үзэгдэл, илчлэлтийг үзэж болох юм. Гуравт, Есүсийг ирэх үед Түүний дотор **Бурханыг харна**. Дөрөвт, тэд мөнх эринд **Бурханыг харна**.



**[5:9]** Амар тайвныг тогтоогч нарт өгөгдөх ивээл: Тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно. Эзэн энд амар амгалан зантай хүмүүсийн тухай болон энх тайвныг хүсэгч нарын талаар яриагүй байна. Харин амар тайвныг тогтоохын төлөө гар бие оролцогчдын тухай ярьжээ. Хүний төрөлх чанар бол зөрчил тэмцлийг хөндлөнгөөс хараад суудаг. Харин Бурханы зан чанар нь **амар тайван** бий болгохын төлөө тодорхой үйлдэл хийдэг. Хэчнээн их доромжлол зовлон амссан ч тийм үйлдэл хийхээс буцдаггүй.

Амар тайван тогтоогчид **Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэнэ**. Тэд хэрхэн Бурханы хөвгүүд болох тухай энд яриагүй. Тэд Есүс Христийг Аврагч болгон хүлээн авахдаа аль хэдийнээ Бурханы хүүхэд болсон (Иохан 1:12). Амар тайвныг тогтоосноороо итгэгчид өөрсдийгөө **Бурханы хөвгүүд** болохоо харуулахыг энд хэлж байна. Түүнээс гадна, Бурханы гэр бүлийн шинж чанарыг харуулж амьдарсан гэдгийг нь хожмын өдөр Бурхан шагнах болно.

**[5:10]** Дараагийн ивээл нь, өөрсдийн буруугаас бус, **зөвт байдлын төлөө хавчигдагч** нарт хандаж байна. Зөвийг хийснийхээ төлөө зовлон амсаж байгаа итгэгчдэд **тэнгэрийн хаанчлалыг** амлажээ. Тэдний шударга зөв амьдрал нь бурханлаг бус ертөнцийг яллаж, хорсол дургүйцлийг нь төрүүлдэг. Өөрсдийнх нь зөвт бус байдлыг илчлэн харуулдаг учраас хүмүүс зөв шударга амьдралыг үзэн яддаг.

[5:11] Хамгийн сүүлчийн ивээл нь өмнөхийгөө давтан хэлж байгаа мэт харагддаг. Гэхдээ нэг ялгаа бий. Өмнөх эшлэлд зөвт байдлын улмаас хавчигдах тухай гарсан. Харин энэ эшлэлд Христээс **болж** хавчигдах тухай ярьж байна. Өөртэй нь холбоотой болж, Өөрт нь үнэнч байсныхаа төлөө дагалдагчид нь элдвийн зовлон амсана гэдгийг Эзэн Есүс мэдэж байсан. Энэ үнэн болохыг түүх гэрчилнэ. Бүр эхнээсээ л энэ ертөнц Есүсийн дагалдагчдыг хавчин гадуурхаж, шоронд хорьж, амь насыг нь хөнөөж байсан.

[5:12] Христийн төлөө зовлон эдлэх нь баярлан хөөрөх шалтгаан мөн. Зовлон амсаж, **эш үзүүлэгчдийн** хамтрагч болсон хүмүүсийг **агуу шагнал** хүлээж байна. Хуучин гэрээний цаг үед Бурханы төлөө ам нээсэн тэд хавчлага зовлон дунд ч бат зогсжээ. Тэдний үнэнч сэтгэл, зориг тэвчээрийг даган дуурайгчид энэ цагт баяр хөөрийг, ирээдүйд өргөмжлөл алдрыг хүртэх болно.

Христийн хаанчлалын иргэнийг энд дүрсэлжээ. Зөвт байдал (6-р эшлэл), амар тайван (9-р эшлэл), баяр хөөр (12-р эшлэл) гэсэн үгнүүд энэ сургаалаас тодорч буйг анхаарна уу! “Бурханы хаанчлал бол идэж, уух нь биш, харин Ариун Сүнс доторх зөвт байдал, амар тайван, баяр хөөр билээ” (Ром 14:17) хэмээн бичихдээ Паул энэ хэсгийг дотроо бодож байсан болов уу.

## **Б. Итгэгчид бол давс ба гэрэл (5:13-16)**

**[5:13]** Есүс дагалдагчдаа **давстай** адилтгасан. Давсыг бид өдөр тутмын амьдралдаа хэрхэн ашигладаг шиг Христийн дагалдагчид ч бас энэ ертөнцөд тийм нөлөө үзүүлдэг. Давсаар хоол амтална. Хүнсийг муутгахгүйн тулд давс цацна. Давс цангааг бий болгоно. Үүний нэгэн адилаар, Христийн дагалдагчид хүний нийгэмд амт нэмж, хүн төрөлхтнийг ялзарч муудахаас хамгаалж, бусдад зөвт байдлын цангааг өгдөг.

**Давс амтаа алдвал** давслаг чанарыг нь дахин бий болгож болох уу? Анхны жинхэнэ амтыг нь дахин бий болгох боломж байхгүй. Амтаа алдвал давс **юунд ч хэрэг болохгүй**. Түүнийг хүний хөлд, зам дээр цацна. Алберт Барнес энэ хэсгийг дараах байдлаар тайлбарласан:

Бидний хэрэглэдэг давс нь нэг төрлийн химийн нэгдэл бөгөөд амт чанараа алдвал юу ч үлдэхгүй. Харин дорнын улс орнуудад давс дангаараа бус буюу хүнсний ногоо, хөрсний бодисуудтай холимог байдалтай байв. Тиймээс энэ бодис нь давслаг чанараа алдахад цаана нь их хэмжээний хатуу бүхэллэг зүйл үлдэнэ. Өнөө цагт бид хайрга хэрэглэдэг шиг, амт чанараа алдсан тийм давсыг замын дэвсгэр болгон ашигладаг байв.

Дагалдагч хүн Эзэн Есүсийн уулан дээрх сургаалын зарчмаар амьдарч **энэ дэлхийд давс**

болох том үүрэгтэй. Тэрээр үүнийгээ биелүүлж чадахгүй бол хүмүүс түүний гэрчлэлийг хөл доороо гишгэлэх болно. Зориулалтгүй итгэгчид энэ ертөнцөд жигшлийг төрүүлдэг.

**[5:14]** Христитгэгчдийг Есүс **ертөнцийн гэрэл** гэж нэрлэж байна. Тэр өөрийгөө бас “ертөнцийн гэрэл” гэж хэлсэн (Иохан 8:12; 12:35, 36, 46). Ялгаа нь гэвэл, Есүс бол гэрлийн эх үүсвэр. Харин итгэгчид бол тэр гэрлийг өөрсөд дээрээ ойлгож аваад тусгагчид юм. Сар өөрөөсөө гэрэл гаргадаггүй боловч нарны гэрлийг өөртөө ойлгож аваад тусган харуулдагтай адил.

Христитгэгчид **уулан дээрх хоттой адил**. Тэд эргэн тойрноосоо өндөр газар байрлаж, харанхуйд гэрэлтэгчид мөн. Амьдрал нь Христийн сургаалыг тусган харуулж буй хүмүүс **нуугдаж үл чадна**.

**[5:15, 16]** Хүмүүс **дэнлүү асаагаад савны доор тавьдаггүй**. Харин **дэнлүүний суурин дээр тавьж, гэрт байгаа бүгдэд гэрэл тусгадаг**. Сургаалаас нь цацрах гэрлийг хүн зөвхөн өөртөө хадгалаад байгаасай гэж Христ хүсдэггүй. Харин бусдад хуваалцаасай гэж хүсдэг. Хүмүүс **сайн үйлсийг** маань **хараад тэнгэр дэх Эцэгийг** маань **алдаршуулахын тулд** бид **гэрлээ** цацруулах ёстой. Тэгэхээр Христитгэгч хүний зан чанар тун чухал юм. Христийн зан чанарыг харуулж байгаа амьдрал нь үгээрээ ятгахаас ч илүү хүч нөлөөтэй.

## **В. Христ хуулийг биелүүлсэн (5:17-20)**

[5:17, 18] Хувьсгал гаргасан удирдагчид ихэнхдээ өнгөрсөнтэй холбоотой бүхнийг устгаж, уламжлал, тогтож дадсан зүйлсийг өөрчилдөг. Харин Эзэн Есүс тэгсэнгүй. Тэрээр Мосегийн хуулийг баримталж, бүх үг нь биелэх ёстой гэж хэлсэн. Есүс **хууль ба эш үзүүлэгчдийг** хүчингүй болгох гэж бус, харин **биелүүлэх** гэж иржээ. Бүрэн биелэгдэх хүртлээ **хуулиас нэг ч үсэг (иод), нэг ч зураас** алга болохгүй гэдгийг Есүс тодорхой хэлсэн. Иод бол еврей цагаан толгойн хамгийн жижиг үсэг. Зураас (грекээр: кэраиа) гэдэг нь нэг үсгийг нөгөөгөөс ялгахад хэрэглэдэг жижиг тэмдэг, зартиг. Тухайлбал **ө** үсгийн дундах зураас нь түүнийг **о** үсгээс ялгаатай болгодог. Библийн үг бүр, хамгийн өчүүхэн хэсэг нь ч гэсэн Бурханы амьсгалаар бичигдсэнд Есүс итгэдэг байв. Тиймээс ач холбогдолгүй хэсэг гэж бичвэрт үгүй.

Есүс хуулийг хэзээ ч өнгөрөн одохгүй гэж хэлээгүйг харах нь чухал. **Бүгд биелэгдэх хүртэл** өнгөрөн одохгүй гэж Есүс хэлсэн байна. Энэ ялгааг өнөөгийн итгэгчид олон янзаар авч үздэг бөгөөд итгэгч хүн хуульд ямар хамаатай вэ гэдэг нь нэлээн нарийн асуудал учраас хуулийн талаарх Библийн сургаалыг дор тоймлон дүгнэж байна.

## **ХРИСТИТГЭГЧ ХҮНД ХУУЛЬ ЯМАР ХАМААТАЙ ВЭ?**

Хууль гэдэг нь Мосегоор дамжуулан Израиль үндэстэнд Бурханаас өгсөн зарлиг тушаалын эмхэтгэл юм. Хуулийг Гэтлэл 20-31 дүгээр бүлэг, Леви, Дэд хууль номуудад тэмдэглэсэн. Гэхдээ үндсэн утга нь арван тушаалд шингэсэн байдаг.

Хүнийг аврах хэрэгсэл болгох гэж хуулийг өгөөгүй (Үйлс 13:39; Ром 3:20а; Галат 2:16, 21; 3:11) Хууль нь хүмүүсийн нүгэлт байдлыг харуулж (Ром 3:20б; 5:20; 7:7; 1Коринт 15:56; Галат 3:19), Бурхан уруу хөтлөн дагуулаад, Бурханы нигүүлсэнгүй авралыг хүртээх зорилготой. Хуулийг Израиль үндэстэнд өгсөн боловч бүх үеийн хүмүүст хүчин төгөлдөр зарчмууд түүн дотор бий (Ром 2:14, 15). Бурхан Израилийг бүх хүн төрөлхтний дээж болгон авч, хуулийн дор шинжилсэн бөгөөд Израилийн буруу нь бүх хүн төрөлхтний бурууг нотолсон (Ром 3:19).

Хууль нь үхлийн ял тулгадаг (Галат 3:10) бөгөөд хуулиас нэг л тушаалыг зөрчвөл бүх тушаалыг зөрчсөнөөс өөрцгүй болно (Иаков 2:10). Хүмүүс хуулийг зөрчсөн учраас үхлийн хараалын дор байдаг. Бурханы зөвт ба ариун байдал нь тэрхүү ялыг нэхэн шаарддаг. Тийм учраас л Есүс энэ дэлхийд ирсэн юм. Тэрээр өөрийнхөө үхлээр тэр ялыг эдэлжээ. Есүс өөрөө нүгэлгүй байсан боловч хууль зөрчсөн нүгэлтнүүдийн өмнөөс золиос болж үхсэн. Есүс

хуулийг хүчингүй болгоогүй. Харин хуулийн нэхэн шаардаж байгаа шаардлагыг өөрийнхөө амьдрал ба үхлээр нэг бүрчлэн биелүүлсэн байна. Тийм учраас сайнмэдээ нь хуулийг үгүйсгэдэггүй бөгөөд харин ч хуулийг баримталж, Христийн авралын ажлаар дамжуулан хуулийн шаарддаг зүйлс хэрхэн хангагдсаныг харуулдаг.

Тиймээс Есүст найддаг хүн одоо хуулийн дор биш нигүүлслийн дор байдаг (Ром 6:14). Итгэгч хүн нь Христийн ажлаар дамжуулан хуулийн хувьд үхжээ. Хуулиас ирдэг ялыг нэг л удаа эдлэх ёстой бөгөөд Христ тэр ялыг нэгэнт эдэлсэн тул итгэгч хүнд одоо ямар ч ял байхгүй. Энэ утгаар бодвол Христигтгэгч хүний хувьд хуулийн алдар сүр арилан алга болсон байна (2Коринт 3:7-11). Хууль нь Христийг ирэх хүртэл зааварлаж байсан. Эдүгээ аврал ирсэн тул энэ зааварлагч цаашид хэрэггүй болжээ (Галат 3:24, 25).

Христигтгэгч хүн хэдийгээр хуулийн дор байдаггүй боловч хуульгүй гэсэн үг биш юм. Тэрээр Христийн хууль дор байдаг (1Коринт 9:21). Христийн хууль нь Мосегийн хуулиас хүчтэй нөлөөг түүнд үзүүлдэг. Шийтгэлээс айсан айдсын улмаас бус, Аврагчийнхаа таалалд нийцэх гэсэн хайр ба хүслийн улмаас түүний зан чанар төлөвшдөг. Христ түүнд амьдралын хөтөч болжээ (Иохан 13:15; 15:12; Ефес 5:1, 2; 1Иохан 2:6; 3:16).

Христитгэгч хүн хуульд ямар хамаатай вэ гэдэг асуудлыг хэлэлцэх үед “Арван тушаалыг сахих ёстой юу?” гэсэн асуултыг нийтлэг асуудаг. Хариулт: Хуульд дурдагдсан зарчим нь одоо ч гэсэн ач холбогдолтой хэвээр байна. Хулгайлах нь, шунахайрах нь, хүний амь хөнөөх нь хэзээ ч буруу байдаг. Шинэ гэрээнд арван хуулийн есийг нь давтан өгүүлсэн байдаг. Гэхдээ тэднийг хууль болгож, ял шийтгэл оноох зорилгоор өгүүлээгүй нь хуучин гэрээнийхээс ялгарах том ялгаа юм. Харин Бурханы хүмүүст зөвт байдлыг зааж сургах зорилгоор өгсөн байна (2Тимот 3:16б). Шинэ гэрээнд давтан өгүүлээгүй нэг тушаал бол шаббатын буюу Амралтын өдрийн тухай хууль юм. Христитгэгчид шаббатыг (долоо дахь өдөр буюу бямба гараг) сахих ёстой гэж заасан нэг ч сургаал үгүй.

Аврагдаагүй хүмүүст хандсан хуулийн үйлчлэл хараахан дуусаагүй байгаа: “Хуулийг ёсоор нь ашиглавал сайн гэдгийг бид мэднэ” (1Тимот 1:8). Хүнд нүглийн мэдлэгийг өгч, хүнийг гэмшил уруу хөтлөхийн тулд хуулийг ашиглах нь зүй ёсны хэрэг юм. Гэхдээ хууль нь хэдийнээ аврагдсан хүмүүст зориулагдаагүй юм: “Хууль нь зөвт хүнд зориулагдаагүй юм” (1Тимот 1:9).

Хуулийн шаарддаг зөвт байдал нь “махбодоор алхагчдад бус, Сүнсээр алхагчдад” (Ром 8:4) биелжээ. Үнэндээ Эзэн Есүсийн уулан дээр заасан номлол нь хуульд зааснаас өндөр жишгийг тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, “хүн



бүү ал” гэж хуульд заасан байдаг бол “бүү үзэн яд” гэж Есүс сургасан байна. Тийм учраас уулан дээрх номлол нь хууль ба эш үзүүлэгчдийг баримтлаад зогсохгүй, тэдгээрийг улам гүнзгийрүүлж, цаад утгыг нь илүү тодруулсан.

**[5:19]** Одоо эргээд уулан дээрх сургаал уруугаа орцгооё. Эзэн Есүсийн үгийг үзвэл Бурханы тушаалуудыг хүн ер нь сулруулдаг хандлагатай болохыг Тэр мэдэж байжээ. Хүн Бурханы тушаалуудыг нэг бол баахан тайлбарлаж байгаад мултрах гэж оролддог, эс бол утгыг нь мушгин гуйвуулах гэж оролддог. Хуулийн аль нэг хэсгийг **үл тоомсорлож**, түүнийг бусдад үлгэрлэн **заасан хүн тэнгэрийн хаанчлалд хамгийн өчүүхэн гэгдэх болно**. Хачирхалтай нь тийм хүн тэнгэрийн хаанчлалд орсон байх юм. Тэгэхээр тэнгэрийн хаанчлалд орох эрх нь зөвхөн Христэд итгэх итгэлээр л ирдэг ажээ. Харин тэрхүү хаанчлалд ямар байр суурьтай байх вэ гэдэг нь газар дэлхий дээрх дуулгавартай байдал, итгэмжээс хамаарна. Хаанчлалын хуулийг дуулгавартай дагадаг хүн **тэнгэрийн хаанчлалд агуу гэгдэх болно**.

**[5:20]** Хаанчлалд орох эрхийг авахын тул **зөвт байдал** маань **хуулийн багш нар болон фарисайчуудынхаас** (гадна талдаа ариун шударга мэт харагдах шашны ёслолуудад анхаарал хандуулах боловч зүрх сэтгэлээ өөрчилдөггүй хүмүүс) илүү гарах ёстой. Хаанчлалд орох эрхийг авахын тулд гаднаа бус дотроо зөвт болох хэрэгтэй гэдгийг ойлгуулахын

тулд Есүс энд хүч нэмэгдүүлсэн яриа ашиглажээ. Хүүг нь Аврагч болгон хүлээн авсан хүнийг Бурхан гэмгүйд тооцож, төгс гэж үздэг бөгөөд зөвхөн энэ зарчмаар ирсэн зөвт байдлыг л (2Коринт 5:21) Бурхан хүлээн зөвшөөрдөг. Мэдээж хэрэг, Христэд үнэн итгэлтэй хүн бодит амьдрал дээр ч гэсэн, уулан дээрх номлолын үлдсэн хэсэгт өгүүлж буй зөв шударга зан чанарыг хэрэгжүүлдэг.

### **Г. Есүс уур хилэнгийн эсрэг анхааруулга өгч байна (5:21-26)**

**[5:21]** Хүний аминд хүрэхийг Бурхан хориглосон бөгөөд алуурчныг шийтгэх ёстой гэдгийг Эзэн Есүсийн үеийн иудейчүүд мэдэж байсан. Хууль өгөгдөхийн өмнө ч тийм байсан (Эхлэл 9:6) бөгөөд хожим үүнийг хуульд оруулж өгчээ (Гэтлэл 20:13; Дэд хууль 5:17). **“Гэхдээ Бита нарт хэлье”** гэдэг үгээр Есүс хүн алах тухай сургаалд нэмэлт өөрчлөлт оруулж байна. Үүнээс хойш, хүний аминд хүрээгүй хүн өөрөөрөө сайрхах боломжгүй болсон. **“Миний хаанчлалд та нар аллагын сэдэлтэй бодол ч тээж болохгүй”** хэмээн Есүс хэлж байна. Тэрээр хүний аминд хүргэдэг шалтгааныг хөндөж, зөвт бус уур хилэнгийн гурван хэлбэрийн эсрэг сануулга өгч байна.

**[5:22]** Эхнийх нь **шалтгаангүйгээр ах дүүдээ уурлан хилэгнэх.**<sup>5</sup> Ийм хүн **шүүхийн өмнө буруутай.** Өөрсдийнх нь бодож байгаа зүйл уурлах шалтгаан мөн гэж боддог хүн олон

бий. Гэвч Бурханыг үл хүндлэх, хүнд буруу зүйл үйлдэхээс бусад тохиолдолд уурлахыг зөвтгөх аргагүй. Харин хувийн өш хонзонгоор уурлах нь хэзээ ч зөв байдаггүй.

Харин түүнээс ноцтой уур бол ах дүүгээ доромжлох. Есүсийн цаг үед “**хоосон толгой**” (арамей хэлээр “**Рака**”) гэдэг үгийг хүмүүс гутаан доромжлох зорилгоор хэрэглэдэг байв. Энэ үгийг хэрэглэсэн хүн **зөвлөлийн өмнө буруутай**. Зөвлөлийн (еврей хэлээр “Санхедрин”; иудейчүүдийн ахлагчдын хуралдай) өмнө гэдэг нь тэр нутгийн дээд шүүхээр хэргээ шүүлгэнэ гэсэн утгатай.

Эцэст нь, Есүсийн буруутгасан зөвт бус уур хилэнгийн гурав дахь хэлбэр бол бусдыг “**мунхаг**” гэж дуудах. Энд гарч буй “**мунхаг**” гэдэг үг “тэнэг мулгуу” гэдгээс ч илүү муухай утга илэрхийлдэг. Энэ нь үхвэл таарах ёс суртахууны доройтол бүхий мунхаглалыг хэлэх бөгөөд хэн нэгнийг үүгээр хараах нь түүнийг тийн үхээсэй гэж байгаатай адилхан утгатай ажээ. Өнөө үед бол англи хэл дээр хүмүүс бие биеэ “**God damn you!**” (Тэнгэр ниргээсэй! Бурхан тамд унагаасай!) гэж хараах нь их түгээмэл. Тийн хараагч нь хүнийг тамд унагахын тулд Бурханыг дуудаж буй хэрэг юм. Тийм хүмүүс **галтай тамд орох буруутай** гэдгийг Есүс хэлсэн. Тухайн үед цаазаар авхуулсан хүмүүсийн цогцсыг Иерусалимын гадна, Хинномын хөндий (Гехенна) нэртэй газар галд шатаадаг байжээ. Тэнд хог шатаадаг байсан тул гал нь огт

унтардаггүй байв. Тиймээс Гехеннагаар галт тамыг дүрсэлдэг.

Аврагч Эзэний энэ хатуу үгст ямар ч алдаа мадаг үгүй. Уур хилэн нь аллагын үр тээж, доромж үг нь аллагын сэтгэл агуулж, хараалын үг нь алах хүслийн илрэл мөн болохыг тэр бидэнд сургаж байна. Хөнгөнөөс нь хүнд уруу дараалсан энэ гурван төрлийн гэмт хэрэгт оногдох шийтгэл нь гурван түвшинтэй байна. Тодруулбал: шүүх, зөвлөл, галт там. Өөрийнхөө хаанчлалд Есүс нүглийн хэр ноцтойг харгалзан үзэж шийтгэл оноох болно.

**[5:23, 24]** Хүн уураар юм уу өөр бусад шалтгаанаар бусдад бурууг үйлдсэн бол Бурханд өргөл авчраад нэмэргүй. Эзэн түүний өргөлийг таалахгүй. Буруутай этгээд юуны өмнө буруугаа залруулах ёстой. Тэгсний дараа л Бурхан өргөлийг нь хүлээн авах болно.

Эдгээр үгсийг иудейн ёс уламжлалтай холбон бичсэн боловч өнөөгийн бидэнд хамаагүй гэсэн үг огт биш. Паул энэ зарчмыг Эзэний Зоогтой холбогдуулан тайлбарласан байдаг (1Коринт 11-р бүлгийг үз). Бусадтай эв найртай байж чаддаггүй итгэгч хүнээс Бурхан ямар ч мөргөл хүлээн авдаггүй.

**[5:25, 26]** Бусадтай арцалдаж, буруугаа хүлээхгүй гөжүүд зан бүү гарга хэмээн Есүс энд сануулж байна. Өөрийг чинь буруутгаж байгаа хүнтэй даруй асуудлаа шийдэх нь шүүхэд очсоноос дээр гэдгийг энд хэлж байна. Хэрэв шүүхэд очвол бидэнд хохиролтой. Энэ сургаалд

хэнийг ярьж байгаа вэ гэдэг дээр эрдэмтдийн дунд зарим санал зөрөлдөөн байдаг боловч энд хэлж байгаа санаа нь тодорхой байна: Хэрэв чиний буруу бол буруугаа хурдан хүлээгээд асуудлыг зөвөөр эргүүл. Буруугаа хүлээхгүй зөрүүдлээд байвал буруу чинь чамайг барьж, эцэст нь чи нөхөн төлөөд зогсохгүй, нэмж шийтгэл амсаж мэднэ. Шүүх уруу явах гэж яарах хэрэггүй. Эс бөгөөс хууль чиний бурууг олж, чи эцсийн зоосыг барагдтал төлөх болно.

#### **Д. Есүс завхайрлыг буруутгасан нь (5:27-30)**

**[5:27, 28]** Мосегийн хуульд завхайрлыг тов тодорхой хориглосон байдаг (Гэтлэл 20:14; Дэд хууль 5:18). “Бүү завхайр” гэсэн хуулийг огт зөрчиж байгаагүй хэмээн сайрхан бардавч “нүд нь завхайрлаар дүүрэн” (2Петр 2:14) байх нь бий. Гадна талдаа ариун шударга мэт боловч бодол санаа нь бузар хүсэл тачаалд эзлэгдсэн байх нь ч бий. Завхайралд бие махбодоороо оролцохгүй байх нь хангалтгүй, дотоод сэтгэл ч бас цэвэр байх ёстой гэдгийг Есүс дагалдагчдадаа сануулж байна. Хууль завхай үйлсийг хориглосон бол Есүс завхай хүслийг хоригложээ: **Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм.** Е.Станли Жонс энэ эшлэлтэй уялдуулан дараах үгийг бичсэн байдаг: “Бодлоороо эсвэл үйлдлээрээ завхайрал үйлдсэн ч та бэлгийн дур хүсэлд төгсгөл тавьж чадахгүй. Галыг унтраахын тулд дээр нь тос асгавал ямар үр дүн гарах нь

тодорхой. Үүнтэй л ижил.” Нүгэл нь оюун бодол дотор эхэлдэг бөгөөд хэрэв бид түүнийгээ өөгшүүлбэл эцэст нь үйлдэл болдог.

**[5:29, 30]** Бодол сэтгэлээ цэвэр ариун хадгалж явахын тулд маш их сахилга бат шаардагдана. Тийм учраас, биеийн маань нэг эрхтэн биднийг нүгэл уруу хөтлөөд байвал, мөнхөд тамд хаягдсанаас энэ амьдралдаа тухайн эрхтнийг тастаж хаясан нь дээр хэмээн Есүс сургажээ. Есүсийн үгийг бид шууд утгаар нь хүлээн авах ёстой юу? Өөрийгөө гэмтээхийг Есүс шаардаж байна гэж үү? Тамд хаягдахгүйн тулд нэг эрхтнээсээ салах *шаардлагатай бол* бодож санах зүйлгүй бид тухайн эрхтнээсээ салах хэрэгтэй. Энэ утгаараа бол Есүсийн үгэнд ямар ч хоёрдмол санаа байхгүй. Гэхдээ Ариун Сүнс итгэгчдийг ариун амьдралаар амьдрах хүчийг өгдөг тул ингэх *шаардлага байхгүй*. Гэвч итгэгчийн талаас Ариун Сүнстэй хамтран ажиллаж, хатуу сахилга баттай байх ёстой.

### **Е. Есүс гэр бүл салалтыг шүүмжлэв (5:31, 32)**

**[5:31]** Хуучин гэрээний хуульд, Дэд хууль 24:1-4-т тэмдэглэснээр Бурхан салалтыг зөвшөөрсөн байна. Энэ хэсэгт завхайрсан эхнэрээс болж салах тухай дурдаагүй (Завхайрлын шийтгэл нь үхэл байсан. Дэд хууль 22:22-ыг үз). Харин, таалахаа больсон, юм уу нийцэхгүй байгаагаас болоод салж буй салалтын тухай дурдсан.

**[5:32] Харин Христийн хаанчлалд бол садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салсан хүн эхнэрээ завхайруулж буй хэрэг юм. Энэ эхнэр хүн салмагц завхай эм болж байгаа гэсэн үг биш. Түүнийг эр хүний дэмжлэггүй үлдээж, өөр эртэй амьдрахаас өөр аргагүй болгож байгаагаараа түүнийг завхайрал уруу түлхсэн хэрэг гэдгийг хэлж байна. Түүнээс гадна тийм салсан эмэгтэйтэй гэрлэсэн хэн боловч завхайрсан хэрэг юм.**

Гэр бүл салалт хийгээд удаах гэрлэлт бол Библи дэх хамгийн адармаатай сэдвүүдийн нэг мөн. Энэ сэдэвтэй холбоотой бүх асуултад Библиэс хариу өгөх боломжгүй боловч бичвэрт энэ талаар юу гэж сургасныг судлаад, тоймлон харвал тустай байх болов уу.

## **ГЭР БҮЛ САЛАЛТ БА ДАХИН ГЭРЛЭЛТ**

Хүнд зориулсан Бурханы зорилгод салалт хэзээ ч байгаагүй. Нэг эрэгтэй, нэг эмэгтэйтэй гэрлэж, үхэн үхтлээ салахгүй хамт байх нь (Ром 7:2, 3) Бурханы туйлын хүсэл юм. Есүс фарисайчуудад хандан анх Бурхан орчлон ертөнцийг бүтээсэн байдлын талаар ярихдаа үүнийг тодорхой сургасан (Матай 19:4-6).

Бурхан салалтыг үзэн яддаг (Малахи 2:16). Гэхдээ зөвхөн Библид хориглосон салалтыг үзэн яддаг болохоос бүх салалтыг үзэн яддаггүй. Яагаад гэвэл тэр Өөрөө ч бас Израилаас салсан тухайгаа ярьдаг (Иеремиа 3:8). Израиль үндэстэн

шүтээнүүдэд мөргөхийн тулд Бурханыг хаяж, Түүнд үнэнч бус хандсан учраас Бурхан түүнээс салжээ.

Аль нэг тал нь садар самуунд орооцолдоогүй л бол салж болохгүй гэж Матай 5:31, 32 болон 19:9 дээр Есүс сургасан. Марк 10:11, 12 болон Лук 16:18 дээр салж болох энэхүү үндэслэлийг хассан байдаг.

Марк, Лук хоёр Есүсийн үгийг бүтэн тэмдэглээгүй гэж үзэх нь үүнд хамгийн оновчтой тайлбар болно. Тиймээс, салалт гэдэг нь Бурханы төгс хүсэл биш ч гэлээ, эхнэр нөхрийн аль нэг нь итгэмжгүй хандсан тохиолдолд зөвшөөрөгдсөн зүйл ажээ. Энэ тохиолдолд Есүс салалтыг зөвшөөрсөн боловч салах ёстой гэж тушаагаагүй.

Үл итгэгч эхнэр юм уу нөхөр нь өөрийг нь орхиж явбал итгэгч хүн түүнээс салж болно хэмээн зарим эрдэмтэд үздэг. Үүнийг тэд 1Коринт 7:12-16-д үндэслэн ярьдаг. Энд Паул, үлдэж байгаа итгэгч хүн нь “боолчлол дор байхгүй” гэж хэлсэн байгаагаас үзэхэд итгэгч бус нөхөр юм уу эхнэртээ хаягдсан итгэгч хүн салж болно гэсэн үг юм. Гэхдээ миний хувьд гэвэл, энд өгүүлж буй тохиолдол нь Матай 5 болон 19 дүгээр бүлэгт өгүүлж буйтай ижил зүйлийг ярьж байна гэж үздэг. Тодруулбал, итгэгч бус эхнэр юм уу нөхөр нь өөр хүнтэй амьдрахаар орхиж явахыг хэлсэн болов уу. Тэгэхээр, эхнэр юм уу нөхөр нь завхайрсан



тохиолдолд л тухайн итгэгч хүн Бурханы үгэнд үндэслэн салж болно гэсэн үг юм.

Шинэ гэрээнд салалтыг зөвшөөрсөн ч гэлээ дахин гэрлэхийг дэмждэггүй гэж зарим хүн маргадаг. Гэхдээ энэ бол ташаа ойлголт. Гэрлэлтдээ үнэнч байсан тал нь дахин гэрлэхийг Шинэ гэрээнд буруутгасан зүйл үгүй. Харин завхайрсан тал нь дахин гэрлэхийг буруутгадаг. Түүнээс гадна, бичвэрт зөвшөөрсөн үндэслэлээр салахын нэг том шалтгаан бол дахин гэрлэх явдал юм. Тийм биш байсан бол, заавал гэрлэлтээ цуцлахгүйгээр тусдаа амьдарсан ч үр дүн нь адилхан болно.

Энэ сэдвээр ярилцах үед, “Христэд итгэхээсээ өмнө салсан хүмүүс яах вэ?” гэсэн асуулт байнга хөндөгддөг. Хүн Христэд итгэхээс өмнө хууль бусаар салсан эсвэл дахин гэрлэсэн явдал нь бүрэн уучлагдсан нүгэлд тооцогдох ёстой (Жишээлбэл 1Коринт 6:11-ийг үзэж болно. Коринтын итгэгчдийн итгэхээсээ өмнө хийж байсан нүглүүдийн дотор Паул завхайрлыг оруулсан байна.). Үүнд ямар ч эргэлзээ байхгүй. Итгэхээсээ өмнө ямар ч гэм нүгэлтэй байсан, тэр нь итгэгчдийг нутгийн чуулганд хамрагдахад саад болж болохгүй.

Харин үүнээс ярвигтай асуудал бол, бичвэрт зөвшөөрөөгүй үндэслэлээр гэр бүлээсээ салаад өөр хүнтэй гэрлэсэн итгэгчдийн асуудал юм. Тэднийг нутгийн чуулганы нөхөрлөлд дахин хүлээн авч болох уу? Тухайн завхайрал нь нэг удаагийн бэлгийн харьцаа юу, аль эсвэл удаан

үргэлжилсэн харилцаа юу гэдгийг харгалзан үзэж байж ямар хариулт өгөх нь хамаарна. Хэрэв тэр хүмүүс завхайрал үйлдсээр байгаа бол нүглээ улайгаад зогсохгүй, одоогийн амрагаа орхих ёстой ч байж мэднэ. Гэхдээ Бурхан ямар нэг асуудалд улам дордуулсан шийдэл өгдөггүй. Гэр бүлийн харилцааны орооцолдсон утас мэт асуудлын орооцолдоог тайлахдаа хүмүүсээр дахин нүгэл үйлдүүлж, эмэгтэйчүүд хүүхдүүдийг орох орон, оочих аягагүй үлдээвэл нуухыг нь авах гээд нүдийг нь сохолсноос ялгаагүй.

Бичвэрт зөвшөөрснөөс өөр үндэслэлээр салаад дахин гэрлэсэн итгэгч хүн нүглээсээ үнэхээр гэмшсэн бол Эзэнээс сэргээлтийг авч, чуулганы нөхөрлөлд оролцож болно гэж би хувьдаа үздэг. Салалтын асуудал бүгдээрээ өөр өөр байдаг. Тийм учраас нутгийн чуулганы удирдагчид тухайн асуудлыг хувьчлан нягталж, Бурханы үгээр шүүн тунгаах нь зөв. Хэрэв сахилгажуулах арга хэмжээ хэрэгтэй бол ахлагч нар үүн дээр шийдвэр гаргах хэрэгтэй.

### **Ё. Есүс ам тангараг өгөхийг буруутгасан нь (5:33-37)**

**[5:33-37]** Бурханы нэрээр хуурамчаар тангараглахыг Мосегийн хууль хэд хэдэн удаа хориглосон (Леви 19:12; Тооллого 30:2; Дэд хууль 23:21). Бурханы нэрээр тангараглах гэдэг нь хэлж байгаа үг минь үнэн гэдгийг Бурхан батална гэсэн утгатай. Бурханы нэрээр

хуурамчаар тангараглахгүйн тулд иудейчүүд түүний оронд **тэнгэр, газар, Иерусалим**, эсвэл өөрсдийн **толгойгоор** тангараглах заншилтай болжээ.

Хуульд тийнхүү хоёр нүүртэй зальжин аргаар хандаж буйг нь Есүс зэмлээд, ямар нэг байдлаар ам тангараг өгөхгүй байхыг сургажээ. Үнэндээ энэ нь хоёр нүүртэй явдлаас гадна, Түүний нэрийг зүгээр л өөр нэр үгээр орлуулан хэлж байгаа учраас ямар ч ашиггүй арга байжээ. **Тэнгэрээр** тангараглана гэдэг нь **Бурханы сэнтийгээр** тангараглаж байгаа хэрэг. **Газраар** тангараглана гэдэг нь **Түүний хөлийн гишгүүрээр** тангараглана гэсэн үг. **Иерусалимаар** тангараглана гэдэг нь хааны хотоор тангараглана гэсэн үг. **Толгойгоороо** тангараглах нь ч гэсэн Бурханыг оруулж байдаг. Яагаад гэвэл Бурхан бол бүхнийг Бүтээгч билээ.

[5:37] Христитгэгч хүнд ам тангараг хэрэггүй. Харин тэрээр **за** гэсэн бол **за, үгүй** гэсэн бол **үгүйгээрээ** л байх ёстой. Түүнээс илүүг хэлэх нь **муу нэгэн** буюу Сатанаар амьдралаа удирдуулахын цондон болно. Христитгэгч зайлшгүй худлаа ярих ёстой нөхцөл байдал гэж байдаггүй.

Энэ хэсэгт бас үнэнийг харлуулах, хуурч мэхлэхийг хориглож байна. Гэхдээ энд хууль шүүхийн өмнө тангараг тавихыг хориглоогүй. Есүс тэргүүн тахилчийн өмнө тангараг дор Өөрийнхөө тухай гэрчилсэн (Матай 26:63). Паул ч гэсэн бичиж буй зүйлээ үнэн гэдгийг батлахын

тулд Бурханыг өөрийн гэрч болгон тангарагласан байдаг (2Коринт 1:23; Галат 1:20).

### **Ж. Хоёр бээр газар явахуй (5:38-42)**

**[5:38]** Хуульд, “**нүдийг нүдээр, шүдийг шүдээр**” гэж хэлсэн (Гэтлэл 21:24; Леви 24:20; Дэд хууль 19:21). Энэ нь, нэг талдаа шийтгэл оноох ёстой гэсэн тушаал. Харин нөгөө талдаа шийтгэлийн хэм хэмжээг заасан үг. Шийтгэл нь хийсэн гэмт үйлдэлд нь таарсан байх ёстой бөгөөд хэтрүүлж болохгүй гэсэн утгатай. Гэхдээ Хуучин гэрээний дагуу шийтгэх эрх мэдэл нь хувь хүнд биш, харин засаг захиргаанд өгөгдсөн байсан.

**[5:39-41]** Энд Есүс хуулиас давсан зөвт байдлаар амьдрахыг уриалж байна. Буруутанд шанг нь хүртээлгүй өнгөрөх. Хэдийгээр хуулийн дагуу тохирох шийтгэлийг оноох ёстой боловч нигүүлслээр ямар ч эсэргүүцэл үзүүлэхгүй байх боломжтойг Есүс дагалдагчдадаа харуулж байна. **Муу хүнийг эсэргүүцэх хэрэггүй хэмээн Есүс дагалдагчдадаа зааж байна.** Христийн дагалдагчдын **хацрыг хэн нэг алгадвал нөгөө хацраа** бас тавьж өгөх ёстой. Христийн дагалдагчдаас хэн нэгэн хүн цамцыг нь авах гэж оролдвол гаднах дээлээ ч бас тайлж өгөх хэрэгтэй. Албаны хүн хүрч ирээд ачаагаа **нэг бээр** газар үүрүүлэх гэвэл түүнийг нь **хоёр бээр** газар сайн дураараа хүргэж өгөх хэрэгтэй.

**[5:42]** Энэ хэсгийн эцэст хэлсэн Есүсийн тушаал нь өнөөгийн бидний хувьд хамгийн

биелүүлэх боломжгүй үг мэт харагддаг. **Гуйсан хүнд өг, чамаас зээлэхийг хүссэн хүнээс бүү зайлсхий.** Бид материаллаг зүйлс ба эд хөрөнгөд дэндүү их ач холбогдол өгдөг учраас олж авсан юмаа хүнд зүгээр өгнө гэдгийг хүлээн зөвшөөрч чаддаггүй. Хэрэв бид тэнгэрийн баялагт анхаарлаа хандуулж, шаардлагатай хувцас хунар, хоол хүнс байхад л сэтгэл хангалуун байж чаддаг бол энэ үгсийг байгаа чигээр нь, баяр хөөртэй хүлээн авах болно. Есүсийн үгэнд дурдагдсан “гуйсан хүн” гэдэг нь зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хүнийг хэлсэн. Гэхдээ гуйж байгаа хүн бүрийн хэрэгцээ зайлшгүй гэдгийг мэдэх боломжгүй. Хэн нэгэн хүн үүн дээр дараах үгийг хэлжээ: “Луйвардах санаатай ч байсан хүн бүрд тусалсан нь дээр. Туслахгүй өнгөрөөснөөс болоод зайлшгүй хэрэгцээтэй байгаа нэг хүнээс нүүр буруулчхаж мэдэх юм.”

Гэвч Эзэний уриалж буй энэ үгийг биелүүлэх хүч чадал хүмүүст байхгүй. Гагцхүү, Ариун Сүнсээр удирдуулж, өөрийгөө золиослоход бэлэн байгаа хүн л үүнийг биелүүлж чадна. Эзэн Есүсийг өөрөөр нь дамжин амьдрахыг зөвшөөрсөн хүн л ийм доромжлол (39-р эшлэл), шударга бус хандлага (40-р эшлэл), тав тухгүй нөхцөл байдалд (41-р эшлэл) хайраар хариу барьж чадна. Ийнхүү хоёр бээр илүү газар явснаараа тэр сайнмэдээг тунхаглана.

### 3. Дайснуудаа хайрла (5:43-48)

[5:43] Өөрийнх нь хаанчлалд шаарддаг хуулиас илүү зөвт байдлын талаар Эзэний маань өгсөн хамгийн сүүлийн жишээ нь дайснууддаа хэрхэн хандах тухай байна. Энэ нь өмнөх сэдвийн үргэлжлэл юм. Хууль израильчуудад **хөршөө хайрлахыг** (Леви 19:18) заасан. Бурхан **дайснаа үзэн яд** гэж илэрхий тушаасан үг байдаггүй боловч израильчууд ийм үзэл баримтлалтай байжээ. Бурханы ард түмнийг хавчин зовоогсдын талаарх Хуучин гэрээний хандлага ийм байв (Дуулал 139:21, 22-ыг үз). Энэ нь Бурханы дайснуудын эсрэг хандсан зөв шударга уур хилэн юм.

[5:44-47] Тэгвэл одоо **дайснуудаа хайрлаж**, өөрсдийг нь **хавчигчдын төлөө залбирах ёстой** гэж Есүс хэлж байна. **Хайрлахыг** Эзэн Есүс бидэнд тушаасан. Тэгэхээр хайр бол сэтгэл хөдлөл гэхээсээ шийдвэр хүслийн асуудал ажээ. Энэ нь хүний дотор төрөлхөөс байдаг сайхан сэтгэл биш юм. Яагаад гэвэл өөрсдийг маань гэмтээж, хохироож, үзэн яддаг хүмүүсийг хайрлаж, тэдэнд сайхан сэтгэлээр хандах төрөлхийн зан араншин бидний дотор байдаггүй. Тэгэхээр дайснуудаа хайрлах гэдэг нь ер бусын нигүүлсэл бөгөөд зөвхөн тэнгэрлэг амьдралтай хүмүүс л харуулж чадна.

Өөрсдийг маань **хайрладаг хүмүүсийг хайрлалаа** гээд ямар ч шагнал байхгүй. Дээрээс төрөөгүй **татвар хураагч нар**<sup>6</sup> хүртэл түүнийг хийж чадна гэдгийг Есүс хэлж байна. Ийм

төрлийн хайранд Бурханы хүч чадал хэрэггүй. Түүнчлэн **зөвхөн ах дүүтэйгээ**<sup>7</sup> (хамаатан садан, найз нөхөд) мэндэллээ гээд онцгой зүйл юу ч байхгүй. Дахин төрөөгүй хүмүүс ч түүнийг хийж чадна. Үүнд бусдаас ялгарах зүйл огт алга. Хэрэв бидний стандарт энэ ертөнцийнхөөс илүү гарахгүй л бол бид энэ ертөнцөд хэзээ ч нөлөөлж чадахгүй.

Өөрийнх нь дагалдагчид мууг сайнаар хариулбал **тэнгэр дэх Эцэгийнхээ хөвгүүд** болохоо харуулна гэж Есүс хэлжээ. Гэхдээ тэр Бурханы хөвгүүд болохын тулд ингэх ёстой гэж хэлээгүй. Харин энэ замаар бид Бурханы хүүхдүүд гэдгээ энэ ертөнцөд харуулах юм. Бурхан хүмүүсийг **сайн, муу** гэж алагчилдаггүйтэй (аль аль нь нар ба борооны ашиг тусыг хүртдэг) адил бид ч бас бүх хүнд адилхан сайнаар хандах хэрэгтэй.

**[5:48]** Есүс энэ хэсгийг уриалгаар төгсгөж байна: **Тиймд тэнгэрлэг Эцэг чинь төгс байдаг шиг та нар мөн төгс бай. Төгс** гэдэг үгийг хам сэдэвтэй нь уялдуулж ойлгох хэрэгтэй. Энэ нь ямар ч нүгэлгүй, алдаагүй гэсэн утгатай биш. Төгс байх гэдгийг өмнөх эшлэлүүдэд нь тайлбарласан. Энэ нь өөрсдийг маань үзэн ядаж хавчигсдыг хайрлаж, тэдний төлөө залбирч, анд найз, өстөн дайсан ялгаагүй сайхан сэтгэлээр хандахыг хэлнэ. Хэнийг ч ялгавар үзэхгүйгээр бүх хүнд ивээлээ хайрлагч Бурханы адил болж, сүнслэг төлөвшилд хүрэхийг бас хэлнэ.

## **И. Үнэн сэтгэлийн өглөг (6:1-4)**

**[6:1]** Энэ бүлгийн эхний хагаст Эзэн Есүс зөв шударга амьдралын гурван талбарыг тусгайлан авч үзсэн: (1) Бусдад өгөөмөр хандах (1-4-р эшлэл) (2) залбирал (5-15-р эшлэл) (3) мацаг барилт (16-18-р эшлэл). Энэхүү арван найман эшлэлд **Эцэг** гэх үг арван удаа гарах бөгөөд энэ арван найман эшлэлийг ойлгох түлхүүр үг болно. Зөв шударга амьдралын үйлс нь хүмүүст биш, **Эцэгт** хүлээн зөвшөөрөгдөх ёстой.

Хүмүүст **харуулах гэж зөвийг үйлдэн** өөрсдийн сайхан сэтгэлийг зарлан тунхагладаг сорилт байдгийг Эзэн Есүс сэрэмжлүүлснээр номлолынхоо энэ хэсгийг эхэлсэн. Бурхан үйлсийг нь буруутгаагүй, харин тэрхүү үйлсийг үйлдэж байгаа сэдлийг нь буруутгасан. Гэхдээ тэрхүү үйлсийг хийхдээ юунд хөтлөгдөж байгаагаа бодох хэрэгтэй. Хүмүүсийн анхааралд өртөх гэсэн хүсэлд хөтлөгдөн хийж байгаа бол хүмүүсийн анхаарлыг л **шагналд** авна. Учир нь Бурхан хоёр нүүрт байдлыг шагнахгүй.

**[6:2]** Бусдын анхаарлыг татах гэж сүр дуулиантайгаар **синагогт** өргөл өргөж, **гудамжинд** гуйлга гуйж буй хүмүүст өглөг өгөх нь **хоёр нүүртний** хийдэг зүйл ажээ. Эзэн тэдний үйлсийг хүлээн авахгүй гэдгээ товчхон бөгөөд тодорхой илэрхийлсэн: **“Тэд шагналаа авчихсан юм.”** (Өөрөөр хэлбэл, тэд газар дэлхий дээр бусдаар магтан сайшаалгаж байгаа нь тэдний шагнал юм.)



**[6:3,4]** Христийн дагалдагч хүн **өглөг өгөхөөр** бол түүнийгээ **нууцаар** хийх хэрэгтэй. Хэр зэрэг нууц байх вэ гэдгийг Эзэн Есүс дагалдагчдадаа дараах үгээр тодорхой хэлсэн: **“Баруун гарын чинь юу хийж байгааг зүүн гар чинь бүү мэдэг.”** Бидний **өглөг** нь өөрсдийн маань нэр хүндийн төлөө биш, харин **Эцэгт** зориулагдсан байх ёстой гэдгийг Эзэн Есүс харуулж байна.

Гэхдээ бусдын өмнө юм өгч болохгүй хэмээн энэ эшлэлийг ашиглан хориглох хэрэггүй. Өгч байгаа зүйлсээ бүгдийг нь нууцаар өгөх боломж угаас байхгүй. Энэ эшлэлийн гол санаа бол өгч байгаагаа сүр дуулиантай харуулах, гайхуулахыг буруутгасан байна.

### **К. Чин сэтгэлийн залбирал (6:5-8)**

**[6:5]** Дараа нь Эзэн Есүс **залбирахдаа** хоёр нүүргүй байхыг дагалдагчдадаа сануулсан. Христийн дагалдагчид залбирч буйгаа бусдад харуулж, сайхан сэтгэлээ хүмүүсээр магтуулахын тулд зориудаар олны өмнө очих хэрэггүй. Залбирч байгаагийн цаад шалтгаан нь зөвхөн бусдаар хүндлүүлэх гэсэн хүсэл бол бусдаар хүндлүүлж байгаа нь өөрөө **шагнал** юм гэдгийг Есүс мэдэгджээ.

**[6:6]** Тав ба долоодугаар эшлэлд та нар гэсэн олон тооны төлөөний үг ашигласан боловч Бурхантай харилцах хувьчилсан харилцааг онцлохын тулд 6 дугаар эшлэлд төлөөний үг өөрчлөгдөж **чи** гэсэн ганц тоо болсон байна.

Залбиралдаа хариу авах түлхүүр нь **нууцаар** залбирах юм. (Өөрөөр хэлбэл, **өрөөндөө орж, хаалгаа хаах** хэрэгтэй.) Өөр ямар нэг шалтгаангүйгээр зөвхөн Бурханд л хандан залбирвал Бурхан сонсож, тэрхүү залбиралд хариулах болно.

Энэ эшлэлийг ашиглаад нийтээрээ залбирч болохгүй гэж хэлбэл хилсэднэ. Учир нь анхны чуулган хамт цуглаад залбирдаг байсан (Үйлс 2:42; 12:12; 13:3; 14:23; 20:36). Хамгийн чухал нь *хаана* залбирч байгаа вэ гэдгийг бус, *яагаад* залбирч байгаа вэ гэдгийг харах нь чухал. Хүмүүст харуулахын тулд залбирч байна уу, аль эсвэл Бурханд сонсох гэж залбирч байна уу? Энд өгүүлж буй гол санаа энэ юм.

**[6:7]** Залбиралд **утгагүй хоосон үг давтах** хэрэггүй. Аврагдаагүй хүмүүс тийнхүү залбирдаг. Гэхдээ **олон үг** хэллээ гээд Бурхан тоохгүй. Бурхан зүрх сэтгэлийн илэрхийлэл болсон үнэн үгсийг сонсохыг хүсдэг.

**[6:8]** Бидэнд **юу хэрэгтэйг Эцэг гуйхаас** маань **өмнө мэддэг** юм бол “Залбирах ямар хэрэг байгаа юм бэ?” гэж асуух нь зүйн хэрэг. Шалтгаан нь юу гэвэл, бидэнд Бурхан хэрэгтэй байгааг, бид Бурханд найдаж байгааг залбирлаар илэрхийлдэг. Залбирал бол Бурхантай харилцах харилцааны маань үндэс суурь юм. Түүнээс гадна, зарим зүйлсийг Бурхан зөвхөн залбирлын хариуд үйлддэг (Иаков 4:2).

**Л. Эзэн Есүс хэрхэн залбирахыг заасан нь  
(6:9-15)**

**[6:9]** Эзэн Есүс хэрхэн залбирахыг заасан жишээ 9-13 дугаар эшлэлд бий. Үүнийг хүмүүс “Эзэний залбирал” гэж нэрлэдэг. Гэхдээ “Эзэний залбирал” гэдэг нь Эзэн Есүс ийн залбирсан үг гэсэн утгаар биш, харин Эзэн Есүсээс үлгэр загвар болгож дагалдагчдадаа хэлж өгсөн залбирал гэсэн утгатай. Энэ залбирлыг давтаж уншуулах гэж өгөөгүй гэдгийг бас мартаж болохгүй. Долоодугаар эшлэлд энэ тухай тодорхой хэлсэн. Хэрэв эдгээрийг зүгээр л давтаж уншвал ямар ч утгагүй хоосон хэллэг болж хувирна.

**Тэнгэрт буй бидний Эцэг минь!** Залбирал нь Эцэг Бурханд хандах ёстой. Ингэхдээ бүх орчлон ертөнцийг захирагч бүрэн дээд эрх мэдлийг нь хүлээн зөвшөөрөх ёстой.

**Таны нэр ариунаар дуurstугай.** Залбирлаа бид мөргөл, хүндлэл, магтаалаар эхлэх нь зүйтэй. Бурхан тэр бүхнийг авах зохистой билээ.

**[6:10] Хаанчлал тань ирэх болтугай!** Тийнхүү мөргөсний дараа Бурханы хүсэл сонирхлыг нэгдүгээрт тавьж, Түүний зорилго хурдан биеллээ олохын төлөө залбирах хэрэгтэй. Тэр тусмаа, Эзэн Есүс Христ, Аврагч Бурхан маань газар дэлхий дээр хаанчлалаа байгуулж, зөвт байдалдаа ноёрхох тэрхүү агуу өдрийг хурдан ирүүлэхийн төлөө залбирах хэрэгтэй.

**Хүсэл тань биелэх болтугай!** Бурхан хамгийн сайныг мэддэг тул өөрсдийгөө бид

Түүний хүсэлд захируулах болно гэдгийг энэ гуйлт илэрхийлдэг. Түүнээс гадна, Бурханы хүсэл бүх дэлхий даяар биелэхийг хүсэмжилж буйн илэрхийлэл болдог.

**Тэнгэрт шигээ газар дээр.** Энэ үг нь өмнөх гурван гуйлтаа тодотгосон. Бурханд мөргөх, Бурханы бүрэн эрхт захиргаа, Түүний **хүслийн** биелэл нь бүгдээрээ **тэнгэрт** бодитоор оршдог. Энэ байдал **тэнгэрт шигээ газар дээр ч** бас орших болтугай хэмээн энд залбирч байна.

**[6:11] Өнөөдөр бидэнд өдөр тутмын маань талхыг өгөөч.** Бурханы хүсэл сонирхлыг нэн тэргүүнд тавьсны дараа бид өөрсдийн хэрэгцээний төлөө залбирч болно. Энэ гуйлт нь өдөр тутмын сүнсний болон биеийн хоол хүнснийхээ төлөө Бурханд түшиглэх ёстойг маань илтгэдэг.

**[6:12] Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийг уучлаач.** Энд нүглийн шийтгэлээс хэлтрүүлэхийн төлөөх уучлалыг яриагүй. (Бурханы Хүүд итгэх итгэлээр тэр уучлалыг итгэгчид нэгэнт авчихсан.) Харин Эцэгтэй нөхөрлөх нөхөрлөлд хэрэгтэй эцэг үрийн харилцааны уучлалыг энд ярьж байна. Итгэгч хүн өөрт нь бурууг хийсэн хүнийг уучлах хүсэлгүй бол өөрийнх нь олон бурууг өгөөмрөөр уучилсан Эцэгтэй хэрхэн нөхөрлөж чадах билээ?

**[6:13] Биднийг бүү сорилтод оруулаач.** Иаков 1:13 дээр Бурхан хэнийг ч сорьдоггүй гэж хэлсэнтэй энэ гуйлт зөрчилдөж байгаа мэт харагдаж болох юм. Гэхдээ Бурхан Өөрөө хэн

нэгнийг сорьдоггүй ч хүмүүсээ сорилт ба уруу татлагад орохыг зөвшөөрдөг. Сорилтыг эсэргүүцэж, уруу татлагыг тэсвэрлэж чадна гэдэгтээ найдахгүй байгааг энэ үг илэрхийлдэг. Энэ тал дээр өөртөө эрдэхгүй байх нь эрүүл зөв хандлага бөгөөд тийм хүн хамгаалалтын төлөө Эзэнд бүрэн түшдэг.

**Биднийг муу нэгнээс гэтэлгээч.** Энэ бол Бурханы хүчээр нүглээс хамгаалагдахыг хүсэгч хүн бүрийн залбирал мөн. Өөрийн амьдралыг өдөр бүр нүгэл ба Сатаны хүчнээс аврахын төлөө Бурханд хандсан сэтгэлийн гуйлт бас мөн.

**Учир нь хаанчлал, хүч, алдар суу үүрд Таных билээ. Амен.** Эзэний залбирлын хамгийн сүүлийн энэ үг эртний олон гар бичмэлд байдаггүй учраас Ромын Католик чуулган болон Протестант чуулганы орчин цагийн ихэнх Библид энэ өгүүлбэрийг хассан байдаг. Гэхдээ энэ үг зонхилох гар бичмэлд бий<sup>8</sup>. Түүнээс гадна, Эзэний залбирал нь ийм доксологиор (грекээр: докса-алдар, логиа-үг; төгсгөлд хэлдэг магтаалын үг) төгсөх нь зүйтэй мэт харагддаг. Жон Калвин энэ тухайд: “Энэ нь зүрхийг маань бүлээсгэн, Бурханы алдар өөд хандуулаад зогсохгүй, залбирал маань бүхэлдээ Бурханаас өөр юунд ч суурилах ёсгүйг бидэнд хэлж өгдөг хэмээжээ.

**[6:14, 15]** Арван хоёрдугаар эшлэлд дурдсан үгийг энд тайлбарлаж байна. Энэ бол залбирлын нэг хэсэг биш. 12-р эшлэлд дурдсан эцгийн уучлал болзолтой гэдгийг энд хэлжээ.

## **М. Есүс хэрхэн мацаг барихыг заасан нь (6:16-18)**

[6:16] Есүсийн буруутгасан шашинлаг хоёр нүүрт байдлын гурав дахь нь **мацаг барьж буйгаа** бусдад зориудаар харуулах нь. **Хоёр нүүртнүүд** мацаг барьж байхдаа царайгаа барайлгаж, цонхигор ядруу харагдахыг хичээдэг аж. Ариун **харагдах** гэж хичээх нь үнэндээ инээдтэй зүйл болохыг Есүс хэлж байна.

Жинхэнэ итгэгчид нууцаар **мацаг барьж**, гаднаа түүнийгээ харуулдаггүй. **Толгойгоо тосоор тосолж, нүүрээ угаах** гэдэг нь гаднаа хэвийн харагдах гэсэн утгатай. **Эцэг** мэдэж байгаа нь л жинхэнэ итгэгчдэд хангалттай. Хүмүүст таалагдсанаас **Эцэгийн шагналыг** авах нь илүү дээр.

### **МАЦАГ БАРИХ**

Мацаг барих гэдэг нь биеийн алив тааламж, дур хүслийг хангахаас татгалзахыг хэлнэ. Энэ хэсэгт дурдсан шиг сайн дураараа мацаг барьж болно. Эсвэл сайн дурынх биш ч байж болно (Үйлс 27:33; 2Коринт 11:27). Шинэ гэрээнд мацаг барилтыг гашуудал (Матай 9:14, 15) ба залбиралтай (Лук 2:37; Үйлс 14:23) холбож дурдсан. Эдгээр хэсэгт Бурханы хүслийг ойлгож мэдэхэд нухацтай хандахын тулд залбирлын хажуугаар мацаг барьж байна.

Мацаг барилт нь авралыг олж авахад ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй. Итгэгч хүн мацаг

барьснаараа Бурханы өмнө онцгой болохгүй. Фарисай хүн долоо хоногт хоёр удаа мацаг барьдгаараа сайрхсан ч эрж хайсан зөвтгөлөө олж аваагүй (Лук 18:12, 14). Гэхдээ итгэгч хүн сүнслэг дасгал байдлаар нууцаар мацаг баривал Бурхан түүнийг нь хараад шагнах болно. Мацаг барь гэсэн тушаал Шинэ гэрээнд байхгүй боловч шагнал бий хэмээн урамшуулсан. Мацаг барилт нь дөжирсөн үлбэгэр сэтгэлд гал өгч, залбирлын амьдралыг сэргээдэг сайн талтай. Бас нухацтай асуудал гарахад Бурханы хүслийг мэдэхийн тулд мацаг барих нь сайн. Мөн өөрийгөө сахилгажуулахын тулд мацаг баривал ашиг тустай. Мацаг барилт бол тухайн хүн ба Бурханы хоорондох хувийн асуудал учраас зөвхөн Бурханд таалагдахын тулд хийгдэх ёстой. Хэрэв хүмүүст харуулах зорилготой бол мацаг барихын утга учир, үнэ цэнэ үгүй болно.

## **Н. Тэнгэрт эд хөрөнгө хураахуй (6:19-21)**

Энэ хэсэгт Эзэн Есүсийн заасан хамгийн эргэлт авчирсан сургаалууд гардаг. Даанч эдгээрийг төдийлөн хайхардаггүй. Зургаадугаар бүлгийн үлдсэн хэсэг нь хэрхэн ирээдүйгээ баталгаатай болгох вэ гэсэн сэдвийн тухай өгүүлнэ.

**[6:19, 20]** Санхүүгийн хувьд баталгаатай ирээдүйг хэрхэн бий болгох вэ гэсэн хүмүүний бүх зөвлөгөөг Есүс 19-21 дүгээр эшлэлд үгүйсгэсэн. Тэрээр “Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа” гэж хэлэхдээ материаллаг

юмс ямар ч найдваргүй, баталгаагүй болохыг хэлсэн. **Газар дээрх** алив материаллаг эд хөрөнгө нь байгалийн хүчин зүйлээр (**хивэн хорхой ба зэв**) сүйдэх юм уу **хулгайчийн** гарт алдагдах эрсдэлтэй. Хэзээ ч алдагдахгүй цорын ганц найдвартай хөрөнгө оруулалт бол **тэнгэрт эд баялаг хураах** юм шүү гэдгийг Есүс сануулж байна.

**[6:21]** Энэхүү эрс хатуу санхүүгийн бодлого нь “**та нарын эд хөрөнгө хаана байна зүрх сэтгэл чинь бас тэнд оршдог**” гэсэн үндсэн зарчимтай. Хэрэв та мөнгөө банкны хадгаламжийн хайрцагт хийвэл зүрх сэтгэл, бодол санаа чинь тэр хайрцаг руу л хандана. Хэрэв таны эрдэнэс тэнгэрт байвал таны бодол санаа тэнгэрт төвлөрнө. Тэгэхээр Есүсийн хэлсэн энэ үгийг шууд утгаар нь авах эсэхээ шийдэх хэрэгтэй. Хэрэв шууд утгаар хэлсэн бол бидэнд нэг асуудал тулгарна. “Бид газар дээрх эд хөрөнгөө яах вэ?” Хэрэв Есүсийн хэлснийг шууд утгаар нь ойлгохгүй гэвэл “Бид Библиэ яах вэ?” гэдэг асуудалтай тулгарна.

### **О. Биений дэнлүү (6:22, 23)**

Ирээдүйн баталгааны тухай сургаал нь бодит амьдрал дээр хэрхэн биелэхийг төсөөлөхөд шавь нарт нь амаргүй байна гэдгийг Есүс мэдэж байжээ. Тиймээс тэр сүнслэг харааны тухай ойлгуулахын тулд хүний нүдийг жишээ болгосон. **Нүд бол биений дэнлүү** гэж Есүс хэлсэн. **Хэрэв нүд сайн бол бүх бие гэрлээр**



дүүрнэ. **Нүд муу бол** хараа булингартана. Нүд муутай хүний дотор гэрэл бус, **харанхуй** байх болно.

Үүний утга нь: Сайн нүд бол цэвэр ариун сэдэлтэй, зөвхөн Бурханы хүсэл сонирхлыг эрхэмлэдэг, Христийн сургаалыг шууд утгаар хүлээн авдаг хүнийх. Тэр хүний амьдрал бүхэлдээ гэрлээр дүүрэн байх болно. Тэрээр Есүсийн үгэнд итгэж, дэлхийн баялгийг огоорч, тэнгэрт эд хөрөнгө хураах ба үүнд л баталгаа байгааг мэддэг. Тэгвэл муу нүд бол хоёр төрлийн амьдралаар амьдрах гэж хичээж буй хүний хандлага юм. Тэрээр газар дээрх баялгаасаа салахыг эс хүснэ. Тэгсэн мөртлөө бас тэнгэрт баялагтай болохыг хүснэ. Есүсийн сургаал түүний хувьд амьдралд нийцэшгүй, биелүүлэх боломжгүй санагдана. Тэрээр харанхуйгаар дүүрэн учраас тодорхой чиглүүлгээр дутдаг.

Дараа нь Есүс, **хэрэв та нарын дотор гэрэл бус харанхуй байх аваас тэр нь юутай их харанхуй байх бол доо** гэжээ. Өөрөөр хэлбэл, энэ дэлхийн эд баялагт бүү найд гэсэн Христийн үгийг мэддэг атлаа, тэр үгийн дагуу үйлддэггүй бол, дагахаас татгалзсан тэр сургаал нь харанхуй болж хувирдаг. Тэр нь сүнсний хувьд маш гүнзгий харалган байдал юм. Тийм хүн эд баялгийн жинхэнэ мөн чанарыг харж чадахгүй болно.

## **Ө. Бурхан ба эд баялагт зэрэг үйлчилж чадахгүй (6:24)**

Бурхан ба эд мөнгө хоёрыг нэг зэрэг хайрлан амьдрах боломжгүй гэдгийг энд эзэн зарцын харилцаагаар дүрсэлжээ. **Хэн ч хоёр эзэнд зэрэг үйлчилж чадахгүй.** Хүн аль нэгийг нь заавал илүү хайрлаж, түүндээ илүү үнэнч дуулгавартай болдог. Энэ зарчим **Бурхан ба эд баялгийн** хувьд ч адилхан үйлчилнэ. Тэдний шаардлага нь бие биеэсээ эсрэг учраас хүн аль нэгийг л сонгохоос өөр аргагүй болдог. Нэг бол Бурханыг эхэнд тавиад материализмаас татгалзана, эс бол хорвоогийн зуурдын юмсын төлөө амьдарч, амьдралаас маань шаардаж буй Бурханы шаардлагуудыг огоорно.

## **П. Бүү санаа зов (6:25-34)**

[6:25] Гол хараа маань зөвхөн идэх хоол, өмсөх хувцсан дээр төвлөрөөд амьдралын жинхэнэ утга учрыг орхигдуулчих вий гэсэн сэрэмжлүүлгийг Есүс энэ хэсэгт хэлсэн. *Өнөөдөр* юу идэж, юу өмсөх вэ гэхээс арав, хорь, гучин жилийн дараа юу идэж, юу өмсөх вэ гэдэгт санаа зовж байгааг зэмлэсэн. Ирээдүйн талаар ийнхүү санаа зовох нь Бурханы хайр, мэргэн ухаан, хүч чадлыг үгүйсгэж буй нүгэл билээ. Тийнхүү санаа зовох нь, Бурхан биднийг анхаардаггүй гэсэнтэй адил тул Бурханы хайрыг үгүйсгэсэн хэрэг мөн. Бурхан юу хийж байгаагаа мэддэггүй гэсэнтэй адил тул Бурханы мэргэн ухааныг үгүйсгэсэн хэрэг юм. Түүнээс гадна, Бурхан хэрэгцээг маань

хангаж өгч чадахгүй гэж хэлсэнтэй адил тул Бурханы хүчийг үгүйсгэж байгаа болно.

Ингэж санаа зовсноосоо болоод бид амьдралаа тэтгэх зүйлийг бий болгохын тулд хамаг эрч хүчээ тэдгээрийн төлөө зориулахад хүрдэг. Тэгээд эцэст нь бүтээгдсэн зорилгоо ухааравч хамаг юм ард хоцорсон байдаг. Бурхан биднийг зөвхөн хоол идүүлэхийн тулд өөрийн дүр төрхөөр бүтээгээгүй нь мэдээж. Түүнээс ч илүү агуу хувь тавилан бидэнд бий. Бурханыг хайрлаж, Түүнд мөргөж, Түүнд үйлчлэн, Түүнийг газар дэлхий дээр харуулахын тулд бид оршдог билээ. Бие махбод маань бидний эзэн бус, харин зарц байхаар бүтээгдсэн.

**[6:26]** Бурхан өөрийн бүтээлүүдээ анхаардаг. Үүнийг Есүс **тэнгэрийн шувуудаар** илэрхийлсэн. Санаа зовох ямар ч шаардлагагүй гэдгийг тэдгээр шувууд бидэнд номлодог. Тэд **тариа тарьж, хураадаггүй**. Харин Бурхан **тэднийг тэжээдэг**. Гэтэл Бурханы бүтээл дотор хүн шувуудаас ч **илүү үнэ цэнэтэй**. Тиймээс Бурхан бидний хэрэгцээг гарцаагүй анхаарах болно.

Гэхдээ одоогийн хэрэгцээгээ хангахын төлөө ажил бүү хий гэсэн үг биш юм. “Ажил хийдэггүй хүн хоол идэх хэрэггүй” (2Тесалоник 3:10) гэж Паул бидэнд сануулсан шүү дээ. Түүнээс гадна, тариа тарьж, хурааж, нөөцөлж болохгүй гэж дүгнэх нь ч буруу. Одоогийн хэрэгцээгээ хангахад энэ зүйлс чухал ач холбогдолтой. Харин Бурханд түшиглэхгүйгээр ирээдүйн

баталгаатай болох гэж агуулах саваа нэмэгдүүлэхийг Есүс энд зэмлэж байгаа юм. Лук 12:16-21 дээр нэгэн баяны тухай ярихдаа Есүс ийм хандлагыг буруутгасан. *Бичвэрийн Холбооноос* гаргадаг *Өдөр Бүрийн Сургамж* дээр 26 дугаар эшлэлийг дараах байдлаар товчхон дүгнэсэн байдаг:

Ан амьтан, араатан жигүүртэн юу ч бодохгүй амьдарч байхад хүртэл Бурхан тэднийг анхаарч тэтгэдэг юм бол дэлхий ертөнц орших гол шалтгаан болсон хүнийг тэдний ухамсарласан оролцоотойгоор Тэрээр бүр ч илүү анхаарч тэтгэх нь дамжиггүй.

[6:27] Ирээдүйдээ санаа зовох нь Бурханыг үл хүндэлсэн хэрэг төдийгүй ямар ч үр ашиггүй зүйл юм. Эзэн Есүс үүнийг харуулахын тулд дараах асуултыг асуусан: **“Санаа зовсноороо өөрийгөө арай өндөр болгож чадах хүн та нарын дотор байна уу?”** Намхан хүн өөрийнхөө намханд санаа зовлоо гээд өндөр болчихгүй. Гэхдээ ирээдүйн хэрэгцээндээ санаа зовж сууснаас хүнийг өндөр болгох нь илүү амархан байж ч мэдэх юм.

[6:28-30] Ирээдүйд **хувцас** хунараар дутагдаж гачигдах вий гэж санаа зовох нь ч гэсэн утга учиргүй зүйл гэдгийг Эзэн Есүс энд ярьж байна. **Талын сараана** цэцэг зүдэж зүтгэдэггүй, **ээрч оёдоггүй** атлаа Соломон хааны хувцаснуудаас ч илүү гоо үзэмжтэй харагддаг. Хэсэгхэн зуур үзэгдээд **зууханд** түлш болох зэрлэг цэцэгсийг хүртэл Бурхан ингэж үзэмж

төгс болгоход анхаардаг юм бол өөрт нь мөргөж, үйлчилдэг хүмүүсээ бүр ч илүү анхаарах нь дамжиггүй.

**[6:31, 32]** Дүгнэж хэлэхэд, бид ирээдүйдээ сэтгэл зовнин, идэх хоол, уух унд, өмсөх хувцасны араас гүйх хэрэггүй. Христэд үл итгэгч **харь үндэстнүүд** идэх хоол, өмсөх хувцас л амьдралын хамаг утга учир мэт материаллаг юмсыг улайран цуглуулдаг. Харин итгэгч хүмүүс ийм байж болохгүй. Учир нь **тэнгэрлэг Эцэг** итгэгчдийн хэрэгцээг мэдэж байгаа.

Хэрэв христитгэгчид ирээдүйн хэрэгцээгээ урьдаас хангахыг зорилгоо болговол санхүүгийн нөөц бий болгоход цаг хугацаа, эрч хүчээ зарцуулахаас өөр аргагүй болно. Гэвч хангалттай хэмжээний мөнгө цуглуулж чадсан гэж хэлэх боломж хэзээ ч гарахгүй. Яагаад гэвэл эдийн засгийн хямрал, инфляцын тогтворгүй байдал, золгүй явдал, удаан хугацааны өвчин, осол гэмтэл гээд олон янзын асуудал амьдралд үргэлж гарч ирнэ. Тиймээс тэд Бурханы үйлчлэлд өөрсдийгөө зориулж чадахгүй. Мөн Бурханаар бүтээгдсэн жинхэнэ утга учрыг, христитгэгчийн гол зорилгыг орхигдуулах болно. Бурханы дүр төрхийг тээж яваа хүмүүс мөнхийн утга учрыг харан амьдарвал энэ дэлхий дээрх ирээдүй нь тодорхойгүй ч гэсэн зоригтой амьдарч чадна.

**[6:33]** Тиймээс Эзэн Есүс өөрийн дагалдагч нартайгаа гэрээ байгуулж байна. Тэрээр бидэнд, “Та нар Бурханы хүслийг нэгт тавивал би ирээдүйн хэрэгцээг чинь батлан даая. **Эхлээд**

**Бурханы хаанчлал ба Түүний зөвт байдлыг хай.** Тэгвэл амьдралдаа хэрэгцээт зүйлсээр дутагдаж гачигдахыг та нар хэзээ ч үзэхгүй” гэжээ.

**[6:34]** Энэ бол “Бурханы нийгмийн хамгааллын” хөтөлбөр юм. Итгэгч хүний хийх ёстой зүйл бол Эзэний төлөө амьдарч, Бурхан хангана гэдэгт гуйвалгүй итгэн найдах. Түүний ажил мэргэжил нь ердөө одоогийнхоо хэрэгцээг хангах хэрэгсэл байх ёстой. Тэрхүү ажил нь Эзэний ажлыг хийхэд нэмэр болж байх нь хамгийн чухал. Бид тухайн цагтаа л амьдарч байхаар дуудагджээ. **Маргааш нь өөрийнхөө зүйлсэд санаа тавих болно.**

### **Р. Бүү шүү (7:1-6)**

Эзэн Есүс дэлхийн баялгийн талаарх сургаалынхаа яг араас бусдыг шүүх тухай ярьсан байна. Тэгэхээр энэ хоёр сэдвийн уялдаа холбоо чухал. Бүхнээ орхисон итгэгч хүн баян ах дүүгээ шүүж шүүмжлэх хандлагатай болж мэдэх юм. Нөгөө талаас, гэр бүлийнхээ ирээдүйн хэрэгцээг хангах үүргээ нухацтай авч үздэг итгэгч хүн б дугаар бүлэгт дурдсан Есүсийн үгсийг шууд утгаар нь хүлээн авч буй ах дүүгээ шүүж болох юм. Тэдний хэн нь ч итгэлийн дагуу бүрэн амьдрахгүй байгаа тул хэн хэнийх нь шүүмжлэл зохисгүй ажээ.

Бусдыг бүү шүү гэсэн энэ тушаал дараах зүйлсэд хамаатай: хүмүүсийн сэдлийг шүүж болохгүй. Түүнийг зөвхөн Бурхан л мэднэ.

Гаднах төрхөөр шүүж болохгүй (Иохан 7:24; Иаков 2:1-4). Зөв ч биш, буруу ч биш асуудал дээр өөрөөсөө өөр бодолтой хүмүүсийг шүүх хэрэггүй (Ром 14:1-5). Бусад итгэгчдийн үйлчлэлийг шүүж болохгүй (1Коринт 4:1-5). Бусад итгэгчдээ муугаар ярьж, шүүж болохгүй (Иаков 4:11, 12).

[7:1] Зарим хүн Эзэний маань энэ үгсийг буруугаар ашиглаж, юуг ч шүүж болохгүй гэдэг. Ямар ч асуудал дээр **“Шүүгдэхгүйн тулд бүү шүү”** гэж хэлдэг. Гэвч Эзэн Есүс биднийг ялган таних чадваргүй итгэгчид байгаасай гэж хүсдэггүй. Тэр хэзээ ч биднийг шүүн тунгаах, наад цаадхыг бодох чадвараа алдаасай гэж хүсдэггүй. Шинэ гэрээг үзвэл бусдын нөхцөл байдал, зан хандлага, номлож буй сургаалыг зохих ёсоор шүүж байсан олон тохиолдол бий. Түүнээс гадна сайн мууг ялгах, сайн дотроос шилдэг сайныг олохын тулд шүүж байхыг итгэгчдэд тушаасан үгс хэд хэд бий. Үүнд:

1. Итгэгчдийн дунд маргаан гарвал чуулганы гишүүдийн дотроос асуудлыг шийдэх чадвартай хүмүүс тухайн асуудлыг шүүн тунгааж чуулган дотор шийдэх ёстой (1Коринт 6:1-8).

2. Нутгийн чуулган нь гишүүдийнхээ ноцтой нүглийг шүүж, зохих арга хэмжээг авах ёстой (Матай 18:17; 1Коринт 5:9-13).

3. Багш, номлогч нарын зааж буй сургаалыг итгэгчид Бурханы үгээр шүүж байх ёстой (Матай 7:15-20; 1Коринт 14:29; 1Иохан 4:1).

4. Паулын 2Коринт 6:14 дээр өгсөн тушаалыг дагахын тулд хүнийг итгэгч үү, итгэгч биш үү гэдгийг таних ёстой.

5. Ямар хүн ахлагч, ямар хүн үйлчлэгч болох шаардлага хангасан байгааг шүүх ёстой (1Тимот 3:1-13).

6. Хүмүүсийн дотор аль нь дуулгаваргүй, аль нь аймхай, аль нь сул дорой байгааг ялгаж салган, тус бүрд нь Библид өгсөн зааврын дагуу хандах ёстой (1Тесалоник 5:14).

[7:2] Зөв бус шүүлт нь эргээд өөрт нь ирнэ гэдгийг Эзэн Есүс анхааруулж **“Та нар хэрхэн шүүнэ, өөрсдөө түүнчлэн шүүгдэнэ”** гэж хэлжээ. Юу тарина, түүнийгээ хураана гэдэг энэ зарчим хүний амьдралын бүх асуудал дээр харагддаг. Марк энэ зарчмыг Бурханы үгэнд хандах хандлагатай холбож (Марк 4:24), Лук өгөх хэмжээтэй холбон тайлбарласан (Лук 6:38).

[7:3-5] Бусдын өчүүхэн алдааг хардаг мөртлөө өөрсдөө яг адилхан алдаа гаргаж байгаагаа ухаардаггүй хандлагыг маань Эзэн Есүс энд илчилж байна. Тэрээр санаагаа ойлгомжтой илэрхийлэхийн тулд уран дүрслэл ашиглажээ. Хүмүүс бид ихэвчлэн өөрийн маань **нүдэнд дүнз** байгааг анзаардаггүй мөртлөө бусдын нүдэн дэх **үртсийг** сайн хардаг. Энэ бол



өөрсдөө асар их алдаатай мөртлөө бусдын өчүүхэн алдааг засах гэсэн хоёр нүүртэй хандлага мөн. Бид бусдыг шүүмжлэхээсээ өмнө өөрсдийнхөө алдааг засах хэрэгтэй.

[7:6] Есүс үүгээр *бүх* төрлийн шүүлтийг хориглоогүй гэдгийг 6 дугаар эшлэл баталдаг. Тэрээр дагалдагчдадаа **ариун юмсыг ноходод бүү өг, сувдыг гахайн өмнө бүү хая** хэмээн анхааруулсан. Мосегийн хуулийн дагуу нохой, гахай хоёр нь цэвэр бус амьтан бөгөөд энд хорон муу хүмүүсийг дүрсэлжээ. Бурханы үнэнийг доромжилж, Христийн шаардлагуудыг тунхаглахад маань хүчирхийлэл ба зүй бусаар харьцагч хүмүүст сайнмэдээг үргэлжлүүлэн хуваалцах хэрэггүй. Тэдэнтэй дахин дахин зууралдах нь тэднийг улам буруутан болгохоос хэтрэхгүй.

Ийм хүмүүсийг бид ялган салгаж, таних хэрэгтэй. Тийм учраас дараагийн эшлэлд мэргэн ухааныг гуйх залбирлын тухай өгүүлжээ.

### **С. Гуй, хай, тогш (7:7-12)**

[7:7, 8] Хэрэв бид уулан дээрх сургаалыг өөрсдийнхөө хүчээр хэрэгжүүлж чадна гэж бодож байвал Аврагч Эзэний зааж байгаа амьдралыг зөвхөн ер бусын хүчээр л амьдрах боломжтойг ухаараагүй хэрэг юм. Тийм амьдралаар амьдрах мэргэн ухаан, хүч чадал дээрээс ирдэг. Тиймээс Эзэн биднийг **гуй**, гуйсаар бай, **хай**, хайсаар бай, **тогш**, тогшсоор бай хэмээн уриалж байна. Христэч амьдралаар

амьдрах мэргэн ухаан, хүч чадал нь чин сэтгэлээсээ шаргуу гуйсан бүгдэд өгөгдөх болно.

Бид 7 ба 8 дугаар эшлэлийг хам сэдвээс нь салгавал итгэгч хүн юу ч гуйсан биелнэ хэмээн ойлгож болох юм. Гэвч тийм утгаар энд хэлээгүй. Эдгээр эшлэлийг хам сэдвийнх нь хүрээнд залбирлын тухай Библийн хэлсэн бүх сургаалын гэрэл дор шүүн үзэх хэрэгтэй. Гуйсан л бол Бурхан өгдөг гэж хэлсэн мэт харагдаж байгаа энэ этгээд амлалтыг Библийн бусад хэсэгтэй хамт харвал гуйлтын хариугаа авахад шаардагдах зарим түлхүүрүүд гарч ирнэ. Тухайлбал Дуулал 66:18 дээр хэлсэнчлэн, залбирч буй хүний амьдралд гэмшиж улайгаагүй нүгэл байх ёсгүй. Түүнээс гадна, итгэлээр (Иаков 1:6-8), Бурханы хүслийн дагуу (1Иохан 5:14) залбирах ёстой. Мөн, уйгагүй шаргуу (Лук 18:1-8), үнэн сэтгэлээс (Еврей 10:22а) залбирах ёстой.

**[7:9, 10]** Хэрэв залбиралд шаардагддаг эдгээр нөхцөлийг биелүүлсэн бол Бурхан түүнийг нь сонсож хариу өгнө гэдэгт баттай итгэж болно. Залбиралд хариу ирнэ гэдэг баталгаа нь бидний аав болсон Бурханы зан чанарт үндэслэдэг. Хүмүүсийн хувьд ч ялгаагүй, **талх гуйсан хүүдээ чулуу өгдөг** аав гэж үгүй. Эцэг хүн хүүхдээ **загас** гуйхад нь **могой өгдөггүй**. Хүмүүн эцгүүд ч байсан өлссөн хүүгээ хуурдаггүй. Бас хүүгээ өвтгөх зүйлийг өгдөггүй.

**[7:11]** Эзэн Есүс багыг томтой, хүнийг Бурхантай жишин санаагаа илэрхийлжээ. Хүмүүн эцгүүд хүртэл юм гуйсан хүүхдэдээ

хамгийн сайныг өгдөг юм бол **тэнгэр дэх Эцэг маань тэр тусмаа сайныг өгөх нь лавтай юм.**

**[7:12]** Энэхүү 12 дугаар эшлэл өмнөх эшлэлтэйгээ холбогдож байна. Бурхан Эцэг маань бидэнд сайныг өгөгч учраас бид ч бас Түүнийг дуурайн бусдад сайхан сэтгэлээр хандах хэрэгтэй. Бидний хийж буй үйлдэл бусдад сайн сайхан мөн үү үгүй юу гэдгийг шалгахын тулд тэрхүү үйлдлээ бид өөрсөд дээрээ хүсэж байна уу үгүй юу гэж бодох хэрэгтэй. Иудейн алдарт багш Рабби Хиллел энэхүү “алтан дүрмийг” Есүсийн цаг үеэс зуу орчим жилийн өмнө бага зэрэг өөрөөр “өөрт чинь муу муухай бол түүнийгээ бусдад ч бүү хий” хэмээн хэлж байжээ. Есүс энэхүү алтан дүрмийн муу муухайг тэвчих ёстой гэсэн идэвхгүй хоригийн санааг өөрчилж идэвхтэй сайн сайхны үйлчлэл рүү хандуулсан. Христитгэл бол зүгээр л мууг цээрлэх тухай биш, харин сайн сайхныг хийх тухай юм.

Есүсийн хэлсэн энэ үгэнд **хууль ба эш үзүүлэгчид буй. Мосегийн хууль** ба Израилийн **эш үзүүлэгчдийн** бичвэрүүдийн гол сургаал энэ үгэнд багтдаг. Тэгэхээр Сүнсээр тийнхүү алхдаг дахин төрсөн итгэгч хүн Хуучин гэрээний шаарддаг зөвт байдлыг биелүүлдэг (Ром 8:4). Хэрэв энэ эшлэлийг бүх дэлхий даяар даган мөрдвөл олон улсын харилцаа, улс орны төр засаг, гэр бүлийн амьдрал, сүм чуулганы амьдрал гээд бүх талбар хувьсан өөрчлөгдөнө.

## **Т. Нарийн зам (7:13, 14)**

Харин одоо Эзэн Есүс энд Христийн дагалдагч болоход ордог **хаалга нь хавчиг** бөгөөд замнадаг **зам** нь хэцүү<sup>9</sup> гэдгийг анхааруулж байна. Гэхдээ Түүний сургаалыг итгэмжтэй дагадаг хүмүүс бялхсан амийг олдог. Гэтэл нөгөө талд **өргөн хаалга** бий. Энэ бол биеийн тааламжийг өөгшүүлэх амьдрал юм. Ийм амьдралын төгсгөлд **сүйрэл бий**. Гэхдээ энд сүнсний аврал алдах тухай яриагүй гэдгийг мартаж болохгүй. Энд ярьж байгаа зүйл бол утга учир, жинхэнэ зорилгоосоо төөрсөн амьдрал юм.

Энэ эшлэлийг сайнмэдээний утгаар ашиглаж, хүн төрөлхтний өмнө байдаг хоёр өөр зам, хоёр өөр хувь тавилангийн дүрслэл болгож болно. Уужуу хаалга, өргөн зам нь сүйрэл уруу хөтөлж (Сургаалт үгс 16:25), давчуу хаалга, нарийн зам нь аминд хүргэдэг бөгөөд Есүс бол тэрхүү давчуу хаалга (Иохан 10:9), нарийн зам (Иохан 14:6) мөн гэж хэлж болно. Гэхдээ энэ эшлэлийг итгэгч хүнтэй холбон яривал хамгийн зөв утга, хамгийн оновчтой тайлбар болно. Христийг дагах нь итгэл, сахилга бат, тэсвэр тэвчээр шаардана гэдгийг Есүс хэлжээ. Гэхдээ хэцүү ч гэсэн энэ л замаар амьдрах хэрэгтэй. Хялбар замыг сонговол олон найз нөхөдтэй болох ч гэлээ танд зориулсан Бурханы хамгийн сайныг та хүртэж чадахгүй өнгөрнө.

## У. Тэднийг үр жимсээр нь тань (7:15-20)

[7:15] Жинхэнэ дагалдагч хүний хатуу чанга шаардлагыг ярьж буй газарт уужуу хаалга, амар хялбар замыг өмгөөлдөг **хуурамч эш үзүүлэгчид** ч бас байдаг. Тэд үнэнийг Ч.Х.Спержоны хэлсэн шиг “өвчтэй царцаанд ч шөл хийж хүрэхээргүй” өчүүхэн болгодог. Бурханы төлөө ярьж байгаа мэт тэр хүмүүс **хонины арьс** нөмөрдөг тул жинхэнэ итгэгчидтэй адил харагддаг. Гэвч тэд **дотроо хомхой чононууд** юм. Өөрөөр хэлбэл, тэд бол төлөвшөөгүй, тогтворгүй, гэнэн хүмүүсээр ашиг хонжоо олдог сувдаг сэтгэлт үл итгэгчид юм.

[7:16-18] Тэдгээр хуурамч эш үзүүлэгчийг хэрхэн таних аргыг 16-18 дугаар эшлэлд дурдсан байна: **Та нар тэднийг үр жимсээр нь танина.** Тэр хүмүүсийн ёс суртахуунгүй амьдрал, хор хөнөөлтэй сургаал өөрсдийг нь барьж өгнө. Аливаа ургамал мод өөрийнхөө шинж чанарын дагуу **жимс** ургуулдаг. **Өргөст бут** өөрөөсөө **усан үзэм** ургуулж чадахгүй. **Халгай** өөрөөсөө **инжир** ургуулж чадахгүй. **Сайн мод сайн жимс** ургуулдаг. **Муу мод муу жимс** ургуулдаг. Байгаль ертөнцийн энэ хууль сүнслэг ертөнцөд бас хэрэгждэг. Бурханы төлөө ярьж байгаа гэх тэр хүмүүсийн амьдрал ба сургаал Бурханы үгээр шаллагдах ёстой: “Хэрэв тэд энэ үгийн дагуу ярьдаггүй бол тэдэнд гэрэл үгүй учраас тэр юм” (Исаиа 8:20).

[7:19, 20] Хуурамч эш үзүүлэгчид эцсийн эцэст **галд хаягдах** болно. Хуурамч багш нар ба

эш үзүүлэгчдийн дээр “түргэн сүйрэл” ирнэ (2Петр 2:1). Тэднийг үр жимсээр нь таньж болно.

### **Ү. Би чамайг танихгүй (7:21-23)**

**[7:21]** Өөрийг нь Аврагч гэж амаараа хүлээн зөвшөөрдөг ч дахин төрөөгүй хүмүүсийн талаар Эзэн Есүс энд анхааруулж байна. Есүсийг “**Эзэн минь, Эзэн минь**” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Бурханы хүслийг үйлддэг хүмүүс л тэр хаанчлалд орно. Бурханы хүслийг үйлдэхэд хамгийн эхний алхам бол Эзэн Есүст итгэх билээ (Иохан 6:29).

**[7:22, 23]** Үл итгэгчид Христийн өмнө зогсох шүүлтийн өдөр (Илчлэл 20:11-15) олон хүн түүнд, өөрийнх нь нэрээр эш үзүүлж, **чөтгөрүүдийг хөөж, олон гайхамшигийг үйлдэж** байсан тухайгаа сануулах болно. Гэхдээ тэдний өмгөөллийг Есүс тоож үзэхгүй. Тэр хүмүүсийг **огт танихгүй** бөгөөд тэд хэзээ ч Өөрийнх нь байгаагүй гэдгийг Есүс хэлэх болно.

Тэгэхээр гайхамшиг бүхэн Бурханаас ирдэггүй, гайхамшиг үйлдэгч бүр Бурханы томилгоотой байдаггүйг энэ эшлэлүүдээс ойлгож болно. Гайхамшиг гэдэг бол ердөө ер бусын хүч ажиллахыг хэлнэ. Тэр нь нэг бол Бурханаас, эс бол Сатанаас байна. Сатан тухайн гайхамшигийг Бурханых гэж харагдуулахын тулд өөрийн ажилчдадаа чөтгөрүүдийг түрхэн зуур холдуулах хүч өгч болно. Энэ тохиолдолд түүний хаанчлал дотроо хуваагдсан гэсэн үг биш.

Ирээдүйд Сатан бүр ч долоон дор чөтгөрийн дайралт, эзэгнэлийг төлөвлөж байгаа.

### **Ф. Байшингаа хадан дээр барь (7:24-29)**

[7:24, 25] Есүс энэ бүх сургаалынхаа эцэст айлдсан сургаалт зүйрлэл нь дуулгавартай байдлыг бидэнд чухалчилжээ. **Эдгээр үгсийг зүгээр сонсоод өнгөрөх нь хангалтгүй. Тэдгээрийг амьдрал болгох ёстой. Есүсийн тушаасныг сонсоод, сонссоноо үйлдэгч дагалдагч бол хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй адил. Түүний байшин (амьдрал) нь бат тогтвортой суурин дээр байх бөгөөд бороо, салхинд нүдүүлсэн ч нурахгүй.**

[7:26, 27] Есүсийн хэлсэн үгсийг сонсоод, сонссоноо үйлддэггүй хүн бол элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй адил. Тийм хүн бэрхшээл зовлонгийн шуургыг сөрөн зогсож чадахгүй. **Бороо асгаж, салхи салхилахад тогтвортой суурь байхгүй учраас байшин нурж унана.**

Уулан дээр номлосон Есүсийн сургаалаар амьдрагч хүнийг энэ ертөнц мунхаг гэж дуудах боловч Есүс харин **мэргэн** гэж хэлнэ. Зөвхөн харсандаа итгэж, одоогийнхоо төлөө л амьдарч, хувиа бодох хүнийг энэ ертөнц мэргэн гэж тооцох боловч Есүс харин мунхаг гэнэ. Мэргэн ба мунхаг барилгачдыг сайнмэдээний зураглал болгон ашиглах бүрэн боломжтой. Хад болох Христ Есүст бүх найдвараа тавьж, түүнийг Эзэн ба Аврагч болгосон хүн бол мэргэн барилгачин

юм. Харин гэмшихийг эс хүсэж, Есүсийг авралын цорын ганц найдвар болгохоос татгалзсан хүн бол мунхаг барилгачин юм. Гэхдээ энэ сургаалт зүйрлэл бидэнд авралаас ч цаадхыг ярьсан бөгөөд христитгэгчийн амьдралд хамгийн түрүүнд хамаатай.

**[7:28, 29]** Эзэн маань номлолоо **гүйцээмэгц ард олон гайхаж** хоцорсон. Уулан дээрх номлолыг уншаад, шинэлэг эрс өөр шинж чанар нь биднийг алмайруулахгүй бол тэнд өгүүлсэн зүйлсийн утгыг ойлгоогүй өнгөрсний шинж билээ.

Тэнд байсан хүмүүс хүртэл Есүсийн сургаалыг хуулийн багш нарынхаас хэчнээн өөр болохыг анзаарчээ. Есүс эрх мэдэлтэй ярьдаг байсан бол хуулийн багш нарын үг хүчгүй байв. Есүс жинхэнэ дуу хоолой, нөгөөдүүл нь цуурай аж. Жэмисон, Фаузет, Браун нар үүнд дараах тайлбарыг хийсэн:

Эзэн Есүсийн сургаалаар дамжин Бурханы Хууль тогтоох, Тайлбарлах, Шүүх эрх мэдэл туяаран гэрэлтсэн агаад хуулийн багш нарын үгс тэрхүү гэрэлд ямар ч утгагүй мунхаг харагдсан.<sup>10</sup>

## **V. МЕССИАГИЙН ХҮЧ БОЛОН НИГҮҮЛСЭЛ БҮХИЙ ГАЙХАМШГУУД БА ХҮМҮҮСИЙН ХАНДЛАГА (8:1-9:34)**

Эзэн Есүс өөрийгөө эш үзүүлэгчдийн бичиж байсан Мессиа гэдгийг Израиль үндэстэнд



маргашгүй олон нотолгоогоор харуулж байсныг 8-12 дугаар бүлэгт өгүүлнэ. Жишээ нь, Мессиа сохрын нүдийг нээж, дүлийгийн чихэнд сонсгол өгч, доголонт эдгээж, хэлгүйг дуулуулна гэдгийг Исаиа зөгнөсөн (Исаиа 35:5, 6). Есүс тэр бүх эш үзүүлэгийг биелүүлснээрээ өөрийгөө Мессиа болохыг баталсан. Израильчууд бичвэрийг үзээд Түүнийг төвөггүй таньж болох байв. Гэвч тэд хараагүй сохор хүмүүс шиг маш харалган хандсан.

Энэ бүлгүүдэд тэмдэглэсэн үйл явдлуудыг цаг хугацааны дарааллаар бус сэдэвчилсэн байдлаар эмхэтгэсэн. Эдгээр нь Эзэний үйлчлэлийг бүгдийг нь хамраагүй боловч Аврагчийн амьдралын тодорхой шинж чанаруудыг харуулахаар Ариун Сүнсний тусгайлан сонгосон үйл явдлууд болно. Үүнд:

1. Христ нь өвчин, чөтгөр, үхэл, байгалийн үзэгдлээс ч дээд эрх мэдэлтэй гэдгийг харуулсан.

2. Өөрийг нь дагах хүмүүсийн амьдралд дээд эрх мэдэлт Эзэн гэдгээ хэлсэн мэдэгдлүүд.

3. Израиль үндэстэн, ялангуяа шашны удирдагчид Есүсээс татгалзаж буйгаа харуулсан.

4. Харь үндэстэн хүмүүс Аврагчийг хүлээн авахад бэлэн байгааг харуулсан.

## **А. Мессиа уяман өвчнийг эдгээх хүч чадалтай (8:1-4)**

**[8:1]** Есүсийн сургаал эрс шулуун, хурц хэдий ч Түүнд бусдыг татах хүч байсан учир **хүмүүс олноороо Түүнийг дагаж байв**. Үнэн өөрийгөө баталдаг. Хүмүүс дургүй байсан ч хэзээ ч мартаж чаддаггүй.

**[8:2]** **Нэгэн уяман өвчтөн** Есүс дээр ирээд өмнө нь сөхөрч, эдгээж өгөхийг гуйсан. Эзэн өөрийг нь эдгээж чадна гэсэн итгэл тэр хүнд байв. Жинхэнэ итгэл хэзээ ч гар хоосон буцдаггүй билээ. Уяман бол муухай харагддаг, маш хөнөөлтэй, бусдад халдварладаг өвчин бөгөөд зарим хэлбэрийг нь хүн огт эдгээж чаддаггүй тул нүглийн бэлгэдэл болдог.

**[8:3]** Уяман өвчтөнд хүрч болохгүй. Тийм хүмүүст хүрвэл өвчин нь халдварлах аюултай. Иудейчүүдийн хувьд уяман өвчтөнд хүрсэн хүн бузарт тооцогддог тул Израилийн чуулгантай хамт мөргөлд оролцох боломжгүй болдог байв. Харин Эзэн Есүс тэрхүү уяман өвчтөнд **хүрч**, эдгээх үгийг айлдахад **уяман өвчин нь тэр даруй** алга болсон. Бидний Аврагч хүнийг нүглээс нь цэвэрлэж, цэвэршсэн хүнийг Бурханд мөргөгч болгох хүч чадалтай.

**[8:4]** Өөрсдөд нь хийж өгсөн гайхамшгийг болон харсан зүйлээ **хэнд ч бүү хэлээрэй** хэмээх Эзэн Есүсийн айлдварыг тэмдэглэсэн тохиолдлуудын эхнийх нь Матайн сайнмэдээнд энд гарч байна (Мөн 9:30; 12:16; 17:9; Марк 5:43; 7:36; 8:26-г үз). Олон хүн зөвхөн Ромын

дарлалаас чөлөөлөгдөх талаар л бодож, өөрийг нь хаан болгохоор санаархаж буйг Эзэн Есүс мэдэж байсан болохоор ингэж хэлсэн болов уу гэж харагддаг. Гэвч Израиль гэмшээгүй, Түүний сүнслэг удирдлагаас татгалзах тул Тэрээр эхлээд загалмайд хадагдах ёстой гэдгийг тэр мэдэж байсан.

Мосегийн хуулийн дагуу **тахилч** хүн эмчийн үүргийг ч гүйцэтгэж байсан. Мөн тус хуулийн дагуу эдгэрсэн уяман өвчтөн тахилч дээр өргөлтэй очиж, өөрийгөө үзүүлэн цэвэршсэн болохоо нийтэд зарлуулах ёстой байв (Леви 14:4-6). Энэ нь маш ховор үзэгдэл тул уяман өвчин ийнхүү эдгэрснийг харсан тахилч хүн Мессиа ирсэн байж болзошгүй хэмээн түүнийг нягтлан үзэх ёстой байсан. Гэхдээ тийм зүйл болсон талаар бичээгүй байна. Есүс уяман өвчтэй байсан хүнд уг хуулийг биелүүл гэж хэлсэн.

Энэ гайхамшгийн сүнслэг учир холбогдол маш тодорхой. Мессиа Израиль үндэстнийг өвчнөөс нь эдгээх хүч чадалтайгаар иржээ. Тэрээр өөрийгөө батлан харуулах тэмдэг болгож энэ гайхамшгийг үйлджээ. Гэтэл израильчууд өөрсдийн Аврагчийг хүлээж авахад бэлэн биш байв.

## **Б. Мессиа саа өвчнийг эдгээх хүч чадалтай (8:5-13)**

**[8:5, 6]** Иудейчүүд өөрсдийн Мессиагаа хүлээн аваагүй байхад харь үндэстэн **зуутын даргын** итгэлийг үүнээс тэс өөр дүр зургийг

танилцуулж байна. Хэрэв Израиль өөрийн Хааныг эс хүлээн авбал дорд харийнхан хүлээн авах болно. Зуутын дарга гэдэг нь Ромын армийн зуун цэргийг захирагч бөгөөд түүний анги Капернаумд юм уу түүний ойр хавьд байрлаж байв. Тэрээр саа өвчнөөр шаналж байгаа **зарцаа** эдгээлгэхийн төлөө Есүс дээр **ирсэн**. Энэ зуутын дарга ер бусын сайхан сэтгэлтэй хүн ажээ. Учир нь ихэнх дарга нар зарцынхаа төлөө ингэж санаа тавихгүй байсан болов уу.

**[8:7-9]** Эзэн **Есүс** өвчтэй зарц дээр нь очъё гэхэд өнөөх **зуутын дарга** ямар их итгэлтэй болохоо харуулж, “**Таныг** гэртээ **оруулах зохистой хүн би биш ээ**. Тэгээд ч та заавал манайд очих шаардлагагүй. Яагаад гэвэл та тэндээс **үг** хэлээд зарцыг минь хялбархан эдгээж чадна. **Эрх мэдэл** гэж юу болохыг би мэднэ. Би удирдлагаасаа тушаал авч, удирдлага дор байгаа хүндээ тушаал буулгадаг. Тэд ч тушаалыг минь биелүүлдэг. Тийм учраас таны хэлэх эрх мэдэлт **үг зарцын** минь өвчнийг эдгээх нь дамжиггүй” хэмээн хэлжээ.

**[8:10-12]** Энэ харь хүний итгэлийг Есүс **гайхсан**. Есүсийн гайхсан хоёр тохиолдлыг тэмдэглэсэн байдгийн нэг нь энэ юм. Нөгөө нь гэвэл тэрээр иудейчүүдийн итгэлгүй байдалд гайхаж байсан (Марк 6:6). Тэрээр Бурханы сонгосон ард түмэн болох **Израилийн** дотроос ч **ийм агуу итгэлийг олоогүй**. Үүнээс улбаалаад Есүс, хожмын хаанчлалд нь дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн харь үндэстнүүд иудейчүүдийн

өвөг дээдэстэй хамт орох боловч **хаанчлалын хөвгүүд гаднах харанхуйд** хаягдаж, уйлан **шүдээ хавирах** болно гэдгийг хэлжээ. **Хаанчлалын хөвгүүд** гэдэг нь Бурханыг Хаан хэмээн амаараа тунхагладаг ч бодит байдал дээр Бурханд итгээгүй төрөлх иудейчүүд юм. Энэ зарчим өнөөдөр ч хэвээр байна. Христитгэгч гэр бүл дотор төрж өссөн олон хүн Христээс татгалзан тамд шийтгүүлэх боловч сайнмэдээний үнэнд итгэсэн ширэнгийн зэрлэг хүмүүс олноороо тэнгэр дэх мөнх алдрыг хүртэх болно.

**[8:13] Есүс зуутын даргад, “Яв, чиний итгэсэнчлэн болог” гэв.** Энэ хүний итгэл нь Бурханы зан чанарт хэр их найдсан тэр хэмжээгээр шагналаа авав. Есүс хэдийгээр зарцаас нь хол байсан ч **зарц нь тэр даруй эдгэрсэн байв.** Үүнээс бид Есүсийн одоогийн үйлчлэлийг харж чадна. Тэрээр яг одоо өөрийн биеэр байхгүй боловч зохисгүй харь үндэстнүүдийг нүглийн саа өвчнөөс эдгээж байгаа билээ.

## **В. Мессиа халуурлыг эдгээх хүч чадалтай (8:14, 15)**

Есүсийг **Петрийн гэрт** ороход Петрийн хадам эх халуунтай байв. Есүс түүний **гарт хүрэхэд халуун нь алга** болов. Жирийн үед халуурсан хүн их ядарсан байдаг боловч энэ нь эгшин зуурын бүрэн эдгэрэл байсан тул Петрийн хадам эх орноосоо босоод Түүнд **үйлчилжээ.**

Өөрөөр хэлбэл Аврагч Эзэний хийж өгсөн зүйлд ийнхүү зохих ёсоор талархлаа илэрхийлсэн байна. Бид ч бас түүнээс үлгэр авч, эдгэрсэн даруйдаа цоо шинэ зориулалт, эрч хүчээр Түүнд үйлчлэх хэрэгтэй.

**Г. Мессиа чөтгөрүүдээс илүү хүчтэй бөгөөд төрөл бүрийн өвчнийг эдгээх чадалтай (8:16, 17)**

Амралтын өдөр өнгөрч **өглөө** болоход (Марк 1:21-34) хүмүүс чөтгөрт эзэмдүүлсэн **олон** хүнийг Түүн дээр авчрав. Хөөрхий энэ хүмүүсийн дотор муу ёрын сүнс орж, тэднийг удирддаг аж. Ихэнх тохиолдолд тэд хүмүүний хэрээс хэтэрсэн мэдлэг, хүчийг харуулах боловч бас тарчлан зовох нь бий. Тэдний зан үйл яг л галзуу солиотой хүн шиг болдог. Гэхдээ түүний шалтгаан нь бие ба оюуны доголдол бус, чөтгөрийн үйл ажиллагаа байдаг. Есүс тэр **сүнснүүдийг үгээр хөөн зайлуулав.**

Бас тэрээр **өвдсөн бүгдийг эдгээж**, Исаиа 53:4-ийн эш үзүүлэгийг биелүүлсэн: **“Тэр бидний сул дорой байдлыг авч, өвчин зовлонг маань үүрсэн.”** Христийн золилтоор эдгэрэл ирсэн хэмээж, итгэлтэй байвал ямар ч өвчин эдгэнэ гэж нотлохын тулд 17 дугаар эшлэлийг ашигладаг хүмүүс бий. Гэтэл Бурханы Сүнс энэ эш үзүүлэгийг Аврагчийн маань дэлхий дээр байхдаа хийж байсан эдгэрлийн үйлчлэлтэй холбосон болохоос загалмайн ажилд нь хамааруулж яриагүй болохыг харах хэрэгтэй.

Тэгэхээр энэ бүлгээс сая бид дөрвөн гайхамшгийг харлаа. Үүнд:

1. Христ уяман өвчтэй иудей хүнийг эдгээсэн. Ингэхдээ биеэрээ хажууд нь байсан.

2. Христ зуутын даргын зарцыг эдгээсэн. Ингэхдээ биеэрээ хамт байгаагүй.

3. Христ гэрт Петрийн хадам эхийг эдгээсэн.

4. Христ чөтгөрт эзэмдүүлсэн, өвчтэй бүх хүнийг эдгээсэн. Ингэхдээ биеэрээ хамт байсан.

Энэ нь Эзэний маань үйлчлэлийн дөрвөн үе шатыг бэлгэдэж байна гэсэн санааг Гаебелейн дэвшүүлжээ. Үүнд:

1. Өөрийн ард түмэн Израильд үйлчилсэн Христийн нэг дэх ирэлт.

2. Есүс биеэр байхгүй боловч харь үндэстнүүд Түүн уруу эргэх цаг үе.

3. Гэрт орж, Израильтай холбоотой харилцаагаа сэргээж, Сионы охины өвчнийг эдгээх Христийн хоёр дахь ирэлт.

4. Чөтгөрт эзэмдүүлсэн, өвчтэй бүгдийг эдгээх мянган жилийн хаанчлал.

Гайхамшгуудын тухай өгүүлсэн энэ хэсгийн дэс дараанд ийм дүгнэлт хийсэн нь тун сонирхолтой бөгөөд ариун бичвэрийн утгад хэчнээн гүн нууцууд байдгийг бидэнд сануулж

байна. Гэхдээ ямар ч уялдаагүй зүйлсийг хооронд нь хүчээр холбож өөрсдийн санасан утгыг гаргаж ирэхээс сэрэмжлэх нь зүйтэй.

#### **Д. Христээс татгалзагч хүмүүс (8:18-22)**

Христ өвчнийг ч тэр, чөтгөрүүдийг ч тэр захирах эрх мэдэлтэйг бид харсан. Харин хүн гэгч Түүнд захирагддаггүй ажээ. Хүн Бурханыг эсэргүүцдэг нь гайхалтай яа.

**[8:18-20]** Есүс Капернаумаас Галил нуурыг гатлан зүүн эрэг уруу нь очихоор зэхэж байхад өөртөө итгэлтэй нэгэн хуулийн багш Түүн дээр ирээд “хаа ч явсан” дагана гэдгээ хэлэв. Өөрийгөө үгүйсгэгч амьдрал ямар их золиос шаарддагийг Эзэн хэлсэн үгээрээ түүнд сануулжээ: **“Үнэгэнд нүх, тэнгэрийн шувуудад үүр байдаг ч Хүний Хүүд толгой хоргодох газар үгүй.”** Нийтийн өмнө гаран үйлчилж байхдаа Тэр өөрийн гэсэн орох орон байсангүй. Гэхдээ Түүнийг гэртээ дуртайяа хонуулж үйлчлэх айлууд байжээ. Түүний хэлсэн дээрх үгэнд жинхэнэ сүнслэг хүч бий. Энэ ертөнц Түүнд жинхэнэ амрах газрыг хангаж өгч чадахгүй. Хийх ёстой ажил байгаа тул Тэрээр ажлаа гүйцээх хүртлээ амарч чадахгүй. Христийн дагалдагчдад ч бас энэ зарчим адилхан. Энэ ертөнц тэдний амрах газар биш бөгөөд тэд ч энэ ертөнцийг амрах газраа хэмээн үзэх ёсгүй.

**[8:21]** Сэтгэл нь хөдөлсөн **өөр нэгэн** дагалдагч Түүн дээр ирээд дагах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв. Гэхдээ тэрээр өөрийнхөө



зүйлийг нэн тэргүүнд тавьсан байв: “**Эзэн, эхлээд явж, эцгээ оршуулахыг минь надад зөвшөөрөөч.**” Эцэг нь нас барчихсан байсан уу, үгүй юу гэдэг нь энд ямар ч ялгаагүй юм. Гол асуудал “**Эзэн, эхлээд...**” гэдэг үгнээс тодорхой харагддаг. Тэр хүн өөрийгөө Христээс түрүүнд тавьжээ. Мэдээж хэрэг эцгээ оршуулах нь зүй ёсны хэрэг мөн. Харин үүнийгээ Аврагч Эзэний дуудлагаас дээгүүр тавивал буруу болно.

[8:22] Есүс түүнд нэг ёсондоо ийм хариу өгсөн: “Чиний нэн тэргүүний үүрэг бол **Намайг дагах**. Сүнсний хувьд **үхмэл** хүмүүс нь биеийн хувьд **үхсэн** хүнийг **оршуулаг**. Аврагдаагүй хүн тийм зүйлсийг хийж чадна. Гэвч зөвхөн чиний л хийж чадах ажил гэж бий. Мөнхөд үлдэх юманд амьдралынхаа хамгийн сайныг өргө. Амьдралаа дэмий зүйлд бүү үрэн таран хий.” Энэ хоёр дагалдагч ямар хариу өгснийг дурдаагүй. Гэхдээ тэд энэ ертөнцөд өөрсдөдөө тав тухтай газар бий болгож, зуурдын юмсаас зуурч амьдрахын тулд Христийг орхисон гэж үзэж болохоор байна. Харин бид энэ хүмүүсийг яллахаасаа өмнө Эзэн Есүсийн хэлсэн үгээр өөрсдийгөө нягтлах хэрэгтэй.

## **Е. Мессиа байгалийн үзэгдлүүдийг ч захирах хүчтэй (8:23-27)**

Галил нуур нь гэнэтийн аймшигт шуургаараа алдартай. Шуурга дэгдэхэд хуйлран хөөсрөх нь нэн сүртэй. Иорданы хөндийгөөр хойд зүгээс үлээх салхи нарийн хавцлаар дайрахдаа эрч аван

Галил нуурыг цохиход нуураар аялахад нэн аюултай болгодог байжээ.

Яг ийм үзэгдэл тохиох үеэр Есүс нуурын баруун эргээс зүүн уруу нь гаталж таарав. Шуурга дэгдэх үед Тэрээр завин дээр **унтаж байлаа**. Айж тэвдсэн дагалдагчид нь Түүнийг сэрээгээд тусламж гуйцгаав. Тэд зөв Хүн дээрээ очсон нь сайшаалтай. Эзэн Есүс тэдний өчүүхэн итгэлийг зэмлээд дараа нь **салхи болоод** давлагааг **зандрав**. Тэгэхэд **нам гүм боллоо**. Харахад эгэл жирийн энэ Хүнийг байгалийн үзэгдлүүд хүртэл дуулгавартай дагаж байгааг нь тэнд байсан хүмүүс хараад бүр **гайхаж** орхив. Тэр өдөр завинд нь орчлон ертөнцийн Бүтээгч ба Тэтгэгч хамт явсныг тэд хараахан ойлгоогүй ажээ.

Дагалдагч бүхэн эрт орой хэзээ нэгэн цагт шуургатай учирдаг. Тэр үед хүчит давлагаанууд биднийг хөмөрч хаях гэж буй мэт санагддаг. Харин Есүс бидэнтэй хамт завин дээр явж байгааг мэдвэл юутай их амар амгалан байх бол доо! “Тэнгис далай, газар дэлхий, тэнгэр огторгуйн Эзэний зорчиж байгаа завийг ямар ч ус залгиж чадахгүй.” Амьдралын шуургыг Эзэн Есүс шиг номхотгож чадах хэн ч үгүй.

**Ё. Эзэн Есүс чөтгөрт эзэмдүүлсэн хоёр эрийг эдгээв (8:28-34)**

**[8:28]** Галил нуурын зүүн талд гадарчуудийн нутаг байв. Есүс тэр нутагт хүрэхэд чөтгөрт хэрцгийгээр эзэмдүүлсэн **хоёр**

хүнтэй учирчээ. Энэ хоёр хүн хад ухаж хийсэн агуй мэт булшнуудад амьдрах бөгөөд маш хэрцгий догшин тул тэр хавиар явах хүмүүст аюултай байжээ.

**[8:29-31]** Есүсийг ойртох үед чөтгөрүүд хашхиран **“Бурханы Хүү Есүс Та бидэнд ямар хамаатай билээ? Цагаас маань өмнө биднийг тарчилгахаар Та энд ирэв үү?”** гэв. Есүс гэж хэн болохыг тэд мэдэж байсан. Есүс эцсийн өдөр өөрсдийг нь мөнх галд хаяна гэдгийг ч мэдэж байсан. Тэгэхээр тэдний теологийн ойлголт мэдлэг орчин үеийн олон либерал үзэлтнүүдээс илүү зөв байгаа юм. Есүс өөрсдийг нь тэр хоёр хүнээс хөөж гаргах гэж буйг мэдэрсэн чөтгөрүүд **зайдуухан идшилж буй сүрэг гахай** уруу оруулж өгөхийг гуйсан.

**[8:32]** Хачирхалтай нь Есүс тэдний хүсэлтийг зөвшөөрсөн. Бүхнийг захирагч Эзэн яагаад чөтгөрүүдийн хүсэлтийг зөвшөөрсөн юм бол? Есүс яагаад ийн хандсаныг ойлгохын тулд хоёр зүйлийг санах хэрэгтэй. Нэгт, чөтгөрүүд биегүй орших дургүй. Тийм учраас тэд хүн юм уу амьтан, бусад бүтээлүүдийн дотор орогнодог. Хоёрт, чөтгөрүүдийн зорилго нь ердөө алж устгах. Хэрэв Есүс чөтгөрүүдийг зүгээр л хөөгөөд гаргачихсан бол тэд тухайн нутаг оронд өөр хүмүүсийн дотор орогноно. Тэднийг гахайнууд уруу орохыг зөвшөөрснөөрөө хүмүүс уруу орохоос хамгаалж, хорлон сүйтгэгч хүчийг нь хүмүүс дээр биш амьтад дээр гаргуулжээ. Чөтгөрүүдийг бүр мөсөн шийтгэх эцсийн цаг

хараахан болоогүй байсан юм. Чөтгөрүүд гахайнууд уруу ормогц **гахайн сүрэг бултаараа нуурын эгц ганга дээрээс давхилдан усанд орж, живцгээлээ.**

Чөтгөрүүдийн туйлын зорилго бол алж устгах явдал бөгөөд хоёр мянган гахайг (Марк 5:13) хөнөөж чадах хэмжээний үй олон чөтгөрүүд хоёрхон хүний дотор орогнох аймшигт боломжийг энэ түүх харуулж байна.

**[8:33, 34]** Гахайчид хот уруугаа буцаж гүйгээд юу болсон талаар бүгдэд ярив. Тэгтэл хотынхон Есүс дээр хүрч ирээд нутгаас нь явахыг **Түүнээс гуйжээ.** Есүс хүний амийг амьтныхаас илүүд үзсэнийхээ төлөө гахай алсанд буруутгагдан, тэр газраас явах шаардлага хүлээж авсан. Хэрэв гадарчууд иудей хүмүүс байсан бол хуулийн дагуу гахай тэжээж болохгүй. Гэхдээ тэд иудейчүүд мөн ч бай, биш ч бай, сүрэг гахайг чөтгөрт эзэмдүүлсэн хоёр хүний эдгэрлээс үнэтэйд тооцжээ.

### **Ж. Мессиа нүглийг уучлах эрхтэй (9:1-8)**

**[9:1]** Герасчууд Түүнийг хүлээн аваагүй учраас Аврагч Эзэн маань Галил нуурыг дахин гаталж Капернаумд ирэв. Назар хотынхон Түүнийг хөнөөх гэж оролдсоноос хойш Эзэн Есүс Капернаумыг **өөрийн хот** болгосон байна (Лук 4:29-31). Энэ хотод тэрээр хамгийн агуу гайхамшгуудаасаа үйлджээ.

**[9:2]** Дэвсгэр дээр нэгэн **саа өвчтөнийг** дөрвөн хүн дамжлан Түүн дээр ирэв. Маркийн

тэмдэглэлийг үзвэл тэд үүдэнд шавсан олныг нэвтэрч эс чадсан тул байшингийн дээврийг ярж, нүхээр нь өвчтөнийг буулгаж, Есүсийн хөлд тавьсан гэжээ (Марк 2:1-12). **Есүс тэдний итгэлийг хараад, саа өвчтөнд хандан “Хүү минь, зоригтой бай. Нүгэл чинь уучлагдсан”** гэж хэлэв. Есүс тэдний итгэлийг харсан гэдэг үгийг анхаараарай. Итгэсэн учраас тэр дөрвөн хүн өвчтөнийг Есүс дээр авчирсан. Өвчтөн итгэсэн учраас Есүс өвчнийг нь эдгээж өгсөн. Бидний Эзэн энэ итгэлийг эхлээд нүглийн уучлалаар шагнасан. Агуу эмч тэрээр шинж тэмдгийг эмчлэхээсээ өмнө үүсгэгчийг нь авч хаяжээ. Тэрээр эхлээд илүү агуу ерөөлийг өгчээ. Христ авралыг өгөхгүйгээр хүнийг эдгээж байсан уу гэдэг асуулт энэ түүхээс урган гардаг.

**[9:3-5]** Есүс хүний нүглийг уучиллаа гэдгийг тэнд байсан **зарим хуулийн багш нар** сонсоод энэ бол Бурханыг доромжилсон хэрэг хэмээн **дотроо** Түүнийг буруутгаж байв. Зөвхөн Бурхан нүглийг уучлах эрхтэй. Тэгэхээр тэд Есүсийг Бурхан гэж хүлээн аваагүй байсныг харуулж байна. Бүхнийг мэдэгч Эзэн Есүс тэдний бодлыг уншаад үл итгэгч зүрхнийх нь ёр муугийн төлөө тэднийг зэмлэв. Тэгээд ингэж асуув: **“Нүгэл чинь уучлагдсан” гэж хэлэх эсвэл “Босоод алх” гэж хэлэхийн аль нь амархан бэ?** Үнэндээ аль алиныг хэлэхэд амархан. Харин хийхэд аль нь илүү амархан бэ? Аль аль нь хүнд боломжгүй зүйлс юм. Гэхдээ эхний тушаалын үр дүн

харагдахгүй. Харин хоёр дахь тушаалын үр нөлөөг тэр даруй харж болно.

**[9:6, 7]** **Есүс газар дээр нүглийг уучлах эрх мэдэлтэй** (бөгөөд Бурхан адил хүндлэгдэх ёстой) гэж хуулийн багш нарт харуулахын тулд нүдэнд *харагдах* боломжтой гайхамшиг үйлджээ. Тэрээр **саа өвчтөн** уруу эргэж хараад **“Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь”** гэж хэлэв.

**[9:8]** Саа өвчтөн гэр уруугаа алхаж яваг харсан олон түмэнд айх гайхах нь зэрэгцэв. Ийм агуу их хүч өөрсдийнх нь дунд байгаад айн сүрдэхийн сацуу **хүнд ийм эрх мэдэл өгсөн Бурханыг алдаршуулсан**. Харамсалтай нь тэрхүү гайхамшигийн утга учрыг тэд харалгүй өнгөрчээ. Саа өвчтэй хүнийг эдгээж, нүдэнд харагдах гайхамшиг үйлдсэн нь нүдэнд үл харагдах гайхамшиг болох нүглийн уучлалыг батлан харуулах зорилготой байсан. Бурхан хүнд эрх мэдэл өгсөн бус, Бурхан өөрөө Эзэн Есүс Христ гэдэг Хүн болоод дунд нь зогсож байгааг үүгээр тэд ойлгох ёстой байсан. Даанч тэд ойлгосонгүй.

Өнөөх хуулийн багш нарыг дараа дараачийн үйл явдлуудаас үзэхэд зүрхээ улам хатууруулж, итгэлгүй байдал ба хорсол зэвүүцэлдээ улам шигджээ.

### **3. Татвар хураагч Матайг Есүс дуудав (9:9-13)**

**[9:9]** Өөрийг нь дуудсан түүхийг Матай даруухнаар өгүүлж, Аврагч Эзэний эргэн тойронд ширүүссэн уур амьсгалаас бид түр

амсхийж байна. Татвар хураагч, гаалийн ажилтнуудыг иудейчүүд ихэд үзэн яддаг байв. Тэдний хууль бус явдал, нэхэн шаардах өндөр татвараас нь болоод иудейчүүд тэдэнд дургүй байжээ. Гэхдээ хамгийн гол нь израильчуудыг ноёрхогч Ромын Эзэнт гүрэнд үйлчилдгээс нь болоод иудейчүүд татвар хураагч нарт дургүй байсан. **Есүс** татварын газрын хажуугаар **өнгөрч яваад** Матайд хандан **“Намайг дага”** гэж хэлэв. Матай бодож цөхөлгүй Түүний араас **дагалаа**. Үүний тухай хэн нэгэн нь хэлэхдээ: “Матай тав тухтай ажлаа алдсан ч хувь тавилангаа олж, өндөр цалингаа алдсан ч хүндлэлийг олж, амьдралын баталгаагаа алдсан ч зүүдэлж ч яваагүй адал явдлыг олсон билээ” гэжээ. Матай арван хоёрын нэг болж, өөрийнхөө нэрээр нэрлэгдсэн сайнмэдээг бичих хүндлэлийг олсон нь түүний хүртсэн шагналуудын нэгээхэн хэсэг мөн.

**[9:10]** Энд өгүүлж буй зоогийг Матай Есүсийг хүндэтгэн барьжээ (Лук 5:29). Үүгээрээ тэр Христийг нийтийн өмнө хүлээн зөвшөөрч, анд нөхдөө Аврагчид танилцуулжээ. Тийм учраас уригдсан зочид нь мэдээж **татвар хураагч нар** болоод **нүгэлтнүүд** гэж тооцогдсон хүмүүс байсан.

**[9:11]** Тухайн үед хүмүүс буйдан налж, ширээнд нүүрээ ойртуулан зоог барих нь ердийн үзэгдэл байв. Есүс ийнхүү нийгмийн шаар шавхруунуудтай хамт байгааг **харсан фарисайчууд** шавь нар дээр нь очоод үүнийг нь

буруутгав. Бурханы жинхэнэ эш үзүүлэгч хүн хэзээ ч **нүгэлтнүүдтэй** хамт хоол идэхгүй гэж тэд үзжээ.

**[9:12]** Есүсийн үүнийг нь сонсоод тэдэнд, **“Эмч эрүүл хүнд бус, өвчтөнд хэрэгтэй”** гэж хариу өгчээ. Фарисайчууд өөрсдийгөө эрүүл гэж үзсэн учраас Есүсийг өөрсдөд нь хэрэгтэй гэж хүлээн зөвшөөрөхийг хүсээгүй. (Үнэндээ тэд сүнсний хувьд туйлын хүнд өвчтэй бөгөөд эдгэрэх нэн хэрэгцээтэй хүмүүс байв.) Харин татвар хураагчид болоод нүгэлтнүүд тэднийг бодвол өөрсдийн үнэн байдлыг хүлээн зөвшөөрч, Христийн авралт нигүүлслийг хайх хүсэлтэй байжээ. Фарисайчуудын хэлсэн үг үнэн байсан. Есүс нүгэлтнүүдтэй хамт хооллосон. Гэхдээ фарисайчуудтай хамт хооллосон ч ялгаагүй нүгэлтнүүдтэй хамт хооллосон хэрэг мөн. Хэрэв Есүс биднийх шиг ертөнцөд нүгэлтнүүдтэй хамт хооллохгүй гэвэл үргэлж ганцаараа хооллохоос өөр аргагүй болно. Тэр хэдийгээр нүгэлтнүүдтэй хамт хооллосон ч тэдний бузар муу замаар нь явж, гэрчлэлээ үгүй хийгээгүй гэдгийг санах нь чухал. Тэрээр хүмүүсийг үнэн ба ариун байдал уруу дуудахын тулд тэдэнтэй нийлдэг байсан юм.

**[9:13]** Фарисайчууд иудаизмын ёс жаягийг хатуу чанд баримталдаг ч зүрх сэтгэл нь хатуу, хүйтэн, өршөөлгүй байсан нь тэдний гол асуудал юм. Тийм учраас Есүс тэдэнд **“Би тахилыг бус энэрлийг хүсдэг”** (Хосеа 6:6-аас иш татсан) гэсэн Иеховагийн үг ямар утгатайг мэдэхийг ятгасан. Бурхан тахил өргөх ёс журмыг



тогтоосон ч гэлээ дотоод сэтгэлийн зөвт байдлыг ёс жаягаар орлуулахыг огт хүсээгүй. Бурхан ёслолыг өргөмжилдөггүй. Ёслолыг зүрхний зөвт байдлаас салангид байлгавал Тэр хэзээ ч таалахгүй. Харин фарисайчууд яг ийм байдалтай байв. Тэд хуулийн үсгийг баримталдаг боловч сүнслэг хэрэгцээтэй хүмүүст энэрлээр хандаагүй. Тэд өөрийгөө зөвд тооцдог өөрсөд шигээ хүмүүстэй л нийлдэг ажээ.

Эзэн Есүс үүний эсрэг байв. Тиймээс тэр тэдэнд **“Би зөвт хүнийг бус, харин нүгэлтнүүдийг дуудахаар ирсэн”** гэж тов тодорхой хэлжээ. Эзэн Есүс энэрэл өршөөл хийгээд тахил хүссэн Бурханы хүслийг төгс биелүүлсэн билээ. Энэ ертөнцөд зөвт хүн гэж нэг ч байхгүй учраас тэр бүх хүнийг гэмшилд дуудахаар ирсэн гэж нэг талаараа хэлж болно. Гэхдээ энд хэлсэн дуудлага бол өөрийгөө нүгэлтэн гэж хүлээн зөвшөөрдөг хүмүүст л хамаатай байна. Фарисайчууд шиг өөрийгөө зөвд тооцсон, бардам, гэмшдэггүй хүмүүст Эзэн Есүс эдгэрэл өгч чадахгүй.

## **И. Мацаг барилтын тухай Есүсээс асуусан нь (9:14-17)**

**[9:14]** Энэ үед **Иохан** Баптист шоронд байв. Иоханы шавь нар юм асуухаар Есүс дээр ирэв. Тэд **байнга мацаг барьдаг** ажээ. **Харин** Есүсийн шавь нар мацаг барьдаггүй байв. Энэ ямар учиртай юм бэ?

**[9:15]** Эзэн үүнд дүрслэлээр хариулсан. Эзэн Өөрөө хүргэн бөгөөд шавь нар нь хуримын зочид аж. **Хүргэн** нь зочидтойгоо **хамт байхад** гашуудлын тэмдэг болгож мацаг барих ямар нэг шалтгаан байхгүй. Гэхдээ хүргэн тэдний дундаас **авагдах өдрүүд ирнэ**. Тэр үед шавь нар **мацаг барьж** болно. Эзэн Есүс үхээд, булшлагдахдаа тэдний дундаас авагдсан. Түүнээс гадна тэр тэнгэр өөд одоод шавь нартайгаа биеэр хамт байхгүй байна. Есүс мацаг барихыг тушаагаагүй боловч Хүргэний эргэн ирэхийг хүлээгч нар мацаг барих нь зүй ёсны үйлдэл гэж үздэгээ хэлжээ.

**[9:16]** Иоханы шавь нарын тавьсан асуултаас ургуулан Эзэн Есүс бас нэг чухал үнэнийг илчилсэн. Иохан бол нэг диспенсацийн (Бурханы хөтөлбөрийн нэг үе) төгсгөлийг зааж, нигүүлслийн шинэ үе эхэлж буйг тунхагласан тэмдэг юм. Энэ хоёрын зарчим нь ондоо. Хуулийг нигүүлсэлтэй хольж хутгах нь хуучин хувцас дээр агчаагүй шинэ нөхөөс тавьж буйтай адил болно. Тэрхүү хувцсыг угаавал нөхөөс агшиж хуучин хувцсыг бүр ихээр урна. Тэгээд хуучнаасаа ч дор болно. Гаебелейн энэ тухай дараах үгийг хэлсэн:

Нигүүлсэл ба сайнмэдээг тунхаглахынхаа хажуугаар хуулийг сахиж, хуулиас ирдэг зөвт байдлыг хөхүүлэн дэмждэг иудей сэтгэхүйт христитгэл нь Бурханы нүдэнд жигшүүрт зүйл бөгөөд эрт цагт шүтээн

шүтэгч байсан израильчуудын нүглээс ч жигшим харагддаг.<sup>14</sup>

**[9:17]** Нигүүлсэл ба хуулийг хольж хутгах нь **шинэ дарсыг хуучин туламд** хийхтэй адил. Хуучин тулам нь уян хатан чанараа алдсан байдаг тул шинэ дарсны исэлтээс үүдэх даралтад задарна. Сайнмэдээний өгдөг амь ба эрх чөлөө нь ёс горим барьсан хуучин тулмыг сүйтгэдэг.

Христитгэлийн эрин үе орж ирэх үед маш их тэлэлт бий болсон. Христийн авчирсан баяр хөөрийг Хуучин гэрээний ёслолууд багтааж чадахгүй. Тиймээс шинэ үйл явдалд шинэ зарчим хэрэгтэй. Петтингил үүнийг маш тодорхой тайлбарласан:

Хуучныг шинэтэй нь хольж болохгүй гэдгийг Хаан Эзэн маань шавь нартаа анхааруулж байсан. Гэтэл үүнийг нь хэрэгжүүлсэнгүй. Христэд итгэх итгэлийг иудаизмын нөхөөс болгож, иудейн шашныг чуулганд авчраад, хуучин хувцсыг “христитгэл” гэх болов. Тэгээд одоо иудаизм ч биш, христитгэл ч биш

холион бантан болжээ. Амьд Бурханд найдахын оронд ёслол хэмээх үхмэл үйлсийг тавьжээ. Үнэгүй авралын шинэ дарсыг хуулийн хуучин туламд хийжээ. Үр дүнд нь тэгээд юу болов? Тулам задарч, дарс асгарав. Амь өгөх үнэ цэнтэй ундаа зүгээр л газар хаягдав. Хуулийг нигүүлсэлтэй хольсноос болоод хуулиас айх нь үгүй болов. Нигүүлслийг хуулийн үйлстэй

хольсноос болоод нигүүлслийн сайхан нь ч үгүй болов.<sup>15</sup>

### **К. Мессиа эдгэшгүйг эдгээж, үхсэнийг босгох хүч чадалтай (9:18-26)**

**[9:18, 19]** Шинэ эрин үеийн талаар өгүүлж байсан Есүсийн үгийг **охиноо алдсандаа** сэтгэл нь шаналсан синагогийн **ахлагч** тасалдуулав. Тэрээр Эзэний өмнө сөхөрч, охиныг нь амилуулж өгөхийг гуйв. Энэ ахлагч Есүсээс ийн тусламж гуйсан нь онцгой хэрэг юм. Есүстэй холбоо тогтоовол доромжлуулж, буруутгагдана гэхээс иудейчүүдийн ихэнх удирдагч айж байсан. **Есүс** түүний итгэлийг хүндэлж шавь нарынхаа хамтаар гэр уруу нь хөдөллөө.

**[9:20]** Энэ үеэр бас нэг хүн түүнийг саатуулав. **Арван хоёр жилийн турш цус алддаг өвчнөөр** шаналсан **нэгэн эмэгтэй** Түүнд хүрчээ. Өөрт нь ингэж хүрэхэд Есүс огтхон ч уурлаж байгаагүй юм. Өөрт нь хүрч, ойртож, хамт байхад Тэр үргэлж нээлттэй байсан.

**[9:21, 22]** Энэ эмэгтэйд анагаах ухаан тусалж чадаагүй аж. Харин ч биеийн байдал нь улам дордож байв (Марк 5:26). Тэрээр туйлдаа хүрсэн үедээ Есүстэй уулзсан, уулзах ч юу байх вэ олны дунд явахыг нь харсан. Есүс өөрийг нь эдгээх чадалтай бөгөөд эдгээхийг хүсэж байгаа гэдэгт итгэсэн тэрээр олны дундуур зүсэн гарч **дээлийнх нь** хормойд **хүрэв**. Эзэн жинхэнэ итгэлийг хэзээ ч анзааралгүй өнгөрдөггүй. Есүс эргэж хараад эдгэрснийг нь хэлэхэд өнөөх

эмэгтэй даруй эдгэрчээ. Ийнхүү тэрээр арван хоёр жил шаналсан өвчнөөсөө салжээ.

**[9:23, 24]** Үйл явдлын хүүрнэл эргээд охиноо алдсан ахлагч уруу хандаж байна. **Есүс ахлагчийн гэрт очиход** хөлсөөр гашуудагчид уйлалдан байлаа. Тэд үнэн сэтгэлээсээ биш “хуурамчаар уйлж гашууддаг” ажээ. Есүс ирсэн хүмүүсийг өрөөнөөс гарахыг тушаав. Түүгээр ч зогсохгүй, **охин үхээгүй, харин унтаж байна** гэж тунхаглалаа. Эзэн Есүс энд унтах гэдэг үгээр үхлийг зүйрлэсэн гэж Библийн ихэнх судлаачид үздэг. Охиныг зүгээр комд орсон гэж үздэг хүмүүс ч бий. Гэхдээ ийнхүү үзэх нь охин үхсэн байсан ч Эзэн Есүс амилуулж чадна гэдгийг үгүйсгэхийн тулд биш харин Эзэн Есүс охиныг үхээгүй байхад үхсэн хүнийг амилуулж байгаа мэт ойлголт өгөхгүй, дэндүү шударга учраас үнэнийг хэлсэн гэж ойлгодог. Ноён Роберт Андерсон энэ үзлийг баримталдаг байв. Охины аав болон бусад хүн охиныг нас барсан гэж хэлж байхад Есүс үхээгүй гэсэн хэмээн Ноён Роберт Андерсон тайлбарладаг.

**[9:25, 26]** Ямартай ч Эзэн Есүс **охины гараас барихад** гайхамшиг болж, охин бослоо. Энэ гайхамшгийн тухай мэдээ тэр нутаг даяар тун хурдан тархав.

#### **Л. Мессиа сохрыг хараатай болгох хүчтэй (9:27-31)**

**[9:27, 28]** Есүс ахлагчийн гэрээс гараад **явж байтал** Түүнийг **хоёр сохор хүн дагаж хараатай**

болгож өгөхийг гуйлаа. Тэр хүмүүсийн махбод нь хараагүй ч гэлээ сүнс нь маш тод хараатай байжээ. Тэд Есүсийг **Давидын Хүү** гэж дуудсан. Өөрөөр хэлбэл, Есүс бол удаан хүлээгдсэн Мессиа, Израилийн хууль ёсны Хаан гэдгийг тэд таньжээ. Мессиа ирээд сохрыг хараатай болгоно гэдгийг тэд мэдэж байв (Исаиа 61:1). Есүс тэднээс хараатай болгож өгч чадна гэдэгт нь итгэж байна уу хэмээн асууж итгэлийг нь шалгахад тэд шуудхан **“Тийм ээ, Эзэн”** гэж хариулав.

**[9:29, 30]** Тэгэхэд Агуу Эмч тэдний нүдэнд **хүрч**, итгэсэн учраас хараатай боллоо гэж тэдэнд хэлэв. Тэдний нүд тэр даруй бүрэн эдгэрчээ.

Хүн “харвал итгэе” гэж хэлдэг. Бурхан харин “итгэвэл харна” гэдэг. Есүс Мартад “Хэрэв чи итгэвэл...харна гэж би чамд хэлсэн бус уу?” (Иохан 11:40) гэсэн. Еврей номыг бичигч бас “Итгэлээр бид...ойлгодог” (11:3) гэсэн. Элч Иохан ч гэсэн “Та нар...мэдээсэй гэсэндээ би..итгэдэг та нарт үүнийг бичлээ” (1Иохан 5:13) гэж бичсэн. Эхлээд гайхамшиг нэхдэг итгэлийг Бурхан таашаадаггүй. Тэр бол Бурхан. Тиймээс өөрт нь зүгээр л итгэхийг хүсдэг.

Өөрсдийг нь эдгээсэн явдлыг хэнд ч хэлж болохгүй гэж Эзэн **Есүс** тэр хоёр хүнд яагаад **хатуу сануулсан** юм бол? Өөрийг нь Хаан болгох гэсэн үймээн самууныг тэр хүсээгүй гэсэн санааг бид 8:4 дүгээр эшлэлийн тайлбарт дэвшүүлсэн. Израильчууд гэмшээгүй байсан. Тэднийг дахин төрөхөөс нааш Эзэн Есүс

хаанчилж чадахгүй. Мөн Есүсээс болж дэгдсэн хувьсгалт хөдөлгөөний улмаас Ромын засгийн газар иудейчүүдийг цээрлүүлж мэднэ. Гэхдээ хамгийн гол шалтгаан нь, Хаан байр сууринаас захирахын өмнө Эзэн Есүс загалмайн үхлийг амсах ёстой байсан. Голгота уруу явах замыг нь хаагч бүхэн Бурханы урьдаас тогтоосон төлөвлөгөөний эсрэг юм.

**[9:31]** Хараатай болоод дэндүү их баярласан хоёр эр гайхамшигт эдгэрлийн тухай **зарыг тэр нутаг даяар тараалаа**. Магад бид тэднийг өмөөрч, сэтгэл хөдлөн ярьсан гэрчлэлийг нь биширч болох юм. Гэвч тэд дуулгаваргүй хандсан гэдэг нь хатуу үнэн юм. Тэдний үйлдэл сайн гэхээсээ муу үр дагавар авчирсан. Юу гэвэл, тэдний ярианаас болоод хүмүүст Сүнсээр хөтлүүлсэн сонирхол бус, зүгээр нэг гүехэн сониуч зангаар сонирхсон. Талархсан сэтгэл байсан ч дуулгаваргүй байдлыг хаацайлж чадахгүй.

### **М. Мессиа хэлгүйг яриулах хүчтэй (9:32-34)**

**[9:32]** Есүс эхлээд үхсэн хүнд амь өгч, дараа нь сохорт хараа оруулсан бол одоо хэлгүй хүнийг ярьдаг болгож байна. Энд гарч байгаа гайхамшгуудад эхлээд амь, дараа нь ойлголт, тэгээд гэрчлэл гэсэн сүнслэг дараалал буй мэт харагддаг.

Муу ёрын сүнс энэ хүнийг хэлгүй болгожээ. Гэтэл хэн нэгэн түүний төлөө санаа тавьж Есүс дээр авчирсан байна. Бусдыг Есүс уруу авчрахад

Бурханы зэмсэг бологч нэр нь үл мэдэгдэх тэр сайхан сэтгэлт хүмүүсийг Бурхан ерөөх болтугай!

**[9:33] Чөтгөр нь зайлуулагдсан даруй мөнөөх хэлгүй ярьж эхэлжээ.** Тэр хүн эдгэрсэн хэл яриагаа ашиглаж, өөрийг нь эдгээсэн Нигүүлсэлт Нэгэнийг магтан алдаршуулж, гэрчилсэн буй заа. Урьд хожид болж байгаагүй олон гайхамшгийг Израиль нүдээрээ харж буйг жирийн хүмүүс ойлгож байв.

**[9:34] Харин фарисайчууд** үүнд дараах тайлбарыг өгсөн: “Есүс **чөтгөрүүдийн захирагчаар чөтгөрүүдийг хөөдөг юм байна.**” Есүс хожим нь үүнийг үл уучлагдах нүгэл гэж хэлсэн байдаг (12:32). Ариун Сүнсээр үйлдэж байсан гайхамшгуудыг нь Сатаны хүч гэж нэрлэсэн нь Ариун Сүнсийг доромжилж буй хэрэг юм. Христийн эдгэрлийн гараар олон хүн ерөөгдөж байхад фарисайчууд харин сүнсний хувьд үхмэл, сохор, дүлий хэвээр үлдэцгээв.

## **VI. МЕССИА ХААНЫ ИЗРАИЛЬ УРУУ ИЛГЭЭСЭН ЭЛЧ НАР (9:35-10:42)**

### **А. Ургацын ажилчид хэрэгтэй байна (9:35-38)**

**[9:35]** Галилд хийсэн гурав дахь тойрон аялал гэж нэрлэдэг үйл явдлыг энэ эшлэлд гарна. **Есүс хот тосгодоор явж, хаанчлалын сайнмэдээг тунхаглаж байв.** Тодруулж хэлбэл, Өөрийгөө Израилийн Хаан гэдгийг тунхаглаж байв. Хэрэв Израиль үндэстэн гэмшиж, Хааныгаа хүлээн



авсан бол Есүс тэднийг хаанчилж, Бурханы амласан хаанчлал тэр үед Израильд байгуулагдах байсан. Израильд үнэхээр хаанчлал байгуулах боломжийг олгосон. Израиль итгэсэн бол юу болох байсан бол? Библи энэ асуултад хариу өгөөгүй. Бурхан бүх үеийн нүгэлтнүүдийг зөвтгөх үндэслэлийг хангахын тулд Христийг үхүүлэх нь гарцаагүй гэдгийг бид мэднэ.

Христ зааж, номлож байхдаа бүх төрлийн өвчнүүдийг эдгээсэн. Даруу нигүүлслээр үйлдсэн гайхамшгууд нь Христийн эхний ирэлтийн шинж тэмдэг болж байсан шиг хожим хүч ба агуу алдар дотор үйлдэх гайхамшгууд нь (Еврей 6:5-ыг үз: “ирэх үеийн хүч”) Христийн хоёр дахь ирэлтэд дагалдах болно.

**[9:36]** Есүс Израилийн хүн ардын эцэж туйлдсан, **хоньчингүй хонь** мэт байдлыг хараад ихэд **өрөвдөв**. Төөрч алдагдсан, үхэж мөхөж буй хүмүүсийн төлөө гэсэн Эзэн Есүсийн энэ сэтгэлийг бид бүр илүү мэддэг болоосой доо!

Зовсон олныг Аврагч минь

Зүрх шимшрэн харсан шиг

Би ч тэднийг нулимстай харъя

Төөрсөн хонь мэт байдлыг нь

Сэтгэл чилээн энэрэн харъя

Эзэний хайраар хайрлаж харъя хэмээн тасралтгүй залбирах хүмүүс хэчнээн их хэрэгтэй байна вэ!

**[9:37]** Сүнслэг ургацыг хураах ажил асар их боловч **ажилчид цөөн байв**. Энэ асуудал өнөөдөр ч хэвээр үлджээ. Хэрэгцээ шаардлага хэзээд байдаг. Гэвч ажиллах хүч байнга дутагддаг.

**[9:38]** Ургацдаа **ажилчид явуулахыг ургацын Эзэнээс гуй** хэмээн Эзэн Есүс шавь нартаа айлджээ. Энэ үгийг үзвэл хэрэгцээ шаардлага нь дуудлагыг бий болгодоггүй бөгөөд ажилчид нь илгээгдэхээс нааш явж болохгүй гэдэг нь тодорхой байна.

Бурханы Хүү Христ намайг  
Шөнийн нутагт илгээсэн билээ  
Хадаасанд хатгуулсан мутраас нь би  
Агуу тушаал авсан билээ

-Герхард Терстиген

**Ургацын Эзэн** гэж хэн бэ гэдгийг Есүс тодорхой хэлээгүй. Зарим хүний бодлоор ургацын Эзэн бол Ариун Сүнс. Харин 10:5 дугаар эшлэлд Есүс Өөрөө шавь нараа илгээсэн. Тэгэхээр ургацын Эзэн бол Есүс Өөрөө гэдэг нь тодорхой юм. Энэ дэлхийд сайнмэдээг хүргэх ажилд зүтгэх ажилчдыг бид Эзэн Есүсээс гуйх ёстой.

## **Б. Арван хоёр элчийг дуудсан нь (10:1-4)**

**[10:1]** Есдүгээр бүлгийн сүүлийн эшлэлд Эзэн Есүс шавь нартаа хандан, илүү олон ажилчдын төлөө залбирахыг зааварласан. Үүнийг үнэн сэтгэлээс хүсэхийн тулд итгэгчид өөрсдөө ажилчин болохыг хүсэх ёстой. Тиймээс энд Эзэн Есүс **өөрийн арван хоёр шавиа** дуудаж байна. Эзэн тэднийг өмнө нь сонгосон байсан бол одоо харин Израиль үндэстэн уруу сайнмэдээний тусгай ажилд дуудан томилж байна. Энэ дуудлагатай хамт бузар сүнснүүдийг зайлуулах хүч, бүх төрлийн өвчнийг эдгээх эрх мэдэл өгөгдсөн. Есүс бусдаас онцгой болох нь энд харагдана. Хүмүүс гайхамшиг үйлдэх нь байдаг ч тэрхүү хүчээ бусдад дамжуулдаггүй.

### **[10:2-4] Арван хоёр элч нь:**

1. **Петр гэгддэг Симон.** Түргэн зантай, өгөөмөр, сайхан сэтгэлтэй хүн. Тэрээр төрөлхийн удирдагч байв.

2. **Симоны дүү Андрей.** Иохан Баптист түүнийг Есүст танилцуулсан (Иохан 1:36, 40). Дараа нь тэр ах Петрийгээ Есүс дээр авчирсан. Түүнээс хойш байнга л хүмүүсийг Есүс дээр авчрах болсон.

3. **Зебедеен хүү Иаков.** Хожим Херод хаанд алуулсан (Үйлс 12:2). Арван хоёрын дотроос итгэлийнхээ төлөө амиа өгсөн анхны хүн.

4. **Иаковын дүү Иохан.** Тэр ч бас Зебедеен хүү. Тэрээр Есүсийн хайртай шавь нь байв. Дөрөв дэх сайнмэдээг, гурван захидлыг болон Илчлэл номын хамт бичсэн ачтан.

5. **Филип.** Бетсайдын оршин суугч тэрээр Натанаелыг Есүс дээр авчирсан хүн. Үйлс номд дурдагдсан сайнмэдээ түгээгч Филиптэй андуурч болохгүй.

6. **Бартоломай.** Заль мэхгүй жинхэнэ Израиль хүн хэмээн Есүсийн тодорхойлсон Натанаелтай нэг хүн гэж үздэг (Иохан 1:47).

7. **Томас.** Өөр нэр нь Дидимус (орчуулбал “ихэр” гэсэн утгатай). “Эргэлзэгч Томас” гэдгээр хүмүүс таньдаг болсон. Тэрээр Христийг дахин амилсан гэдэгт эргэлзсэн боловч дараа нь Христийг Эзэн ба Бурхан гэдгийг дуу алдан хүлээн зөвшөөрсөн (Иохан 20:28).

8. **Матай.** Өмнө нь татвар хураагч байсан ба энэхүү сайнмэдээг бичсэн хүн.

9. **Алфайн хүү Иаков.** Түүний талаар тодорхой мэдэх зүйл бидэнд нэрээс нь өөр байхгүй.

10. **Таддай овогт Леббай.** Түүнийг бас Иаковын хүү Иудас гэж нэрлэдэг (Лук 6:16). Түүний нэг л үг тэмдэглэгдэн үлдсэн нь Иохан 14:22 дээр бий.

11. **Канаан хүн Симон.** Лук түүнийг Зеалот гэж нэрлэсэн (Лук 6:15).

12. **Искаротын Иудас.** Эзэнээс урвасан хүн.

Шавь нар тухайн үедээ хорь гаруй настай байсан бололтой. Нийгмийн янз бүрийн давхаргаас сонгогдсон тэдгээр залуучууд мэдлэг чадварын хувьд дундаж хүмүүс байсан. Тэдний агуу байдлын жинхэнэ шалтгаан бол Есүстэй холбогдсон явдал юм.

### **В. Израиль уруу илгээгдсэн нь (10:5-33)**

[10:5, 6] Үүнээс хойш энэ бүлэгт **Израилийн гэрт** тунхаглал хийхээр явж буй тусгай аялалд нь хандсан Есүсийн зааварчилгаа гарна. Хожим далан хүнийг илгээсэн илгээлт (Лук 10:1) болон Агуу захирамжтай (Матай 28:19, 20) үүнийг андуурч болохгүй. Энэ нь тэнгэрийн хаанчлал ойрхон буйг тунхаглах тусгай зорилготой түр хугацааны илгээлт юм. Энд өгүүлсэн зүйлсийн зарим нь бүх цаг үед хэрэгжүүлэх үнэ цэнтэй зарчим боловч хожим Эзэн Өөрөө заримыг нь цуцалснаас (Лук 22:35, 36) харахад байнга хэрэглэх зарчим болгон өгөөгүй гэдэг нь илэрхий байдаг.

Нэгдүгээрт, Эзэн тэдэнд очих газрыг нь тодорхой хэлж өгсөн. **Харь үндэстнүүдэд** бүү оч гэсэн. Иудейчүүдийн үзэн яддаг, цус холилдсон **самаричууд** дээр ч очих хэрэггүй гэсэн. Энэ удаа тэдний үйлчлэл нь **Израилийн гэрийн төөрсөн хонинуудаар** хязгаарлагдсан.

**[10:7]** Мэдээ нь гэвэл **тэнгэрийн хаанчлал ойрхон буйг** тунхаглах. Хэрэв Израиль тэр мэдээг хүлээн авахаас татгалзвал тэдэнд ямар ч шалтаг үлдэхгүй. Яагаад гэвэл тэдэнд зориулан албан ёсны мэдэгдэл хийгдсэн юм. Хаан нь ирчихсэн тул хаанчлал нь тун ойрхон байсан. Харин Хааныгаа хүлээж авах эсэхээ израильчууд шийдэх ёстой болсон.

**[10:8]** Тунхагласан мэдээг нь батлахын тулд шавь нарт **өвчтөнийг эдгээх, уяманг цэвэрлэх, үхсэнийг босгох<sup>16</sup>, чөтгөрүүдийг зайлуулах** эрх мэдэл өгөгдсөн. Иудейчүүд тэмдэг шаарддаг (1Коринт 1:22) учраас Бурхан нигүүлсэнгүйгээр тэдэнд тэмдэг өгсөн.

Тэд бол Эзэний төлөөлөгч учраас үйлчлэлийнхээ хариуд ямар ч хөлс авах ёсгүй. Тэдэнд өгсөн ивээлийг тэд үнэгүй авсан. Тиймээс тэрхүү ивээлээ бусдад үнэгүй өгөх ёстой.

**[10:9, 10]** Тэд аяллынхаа өмнө юм бэлдэх шаардлагагүй. Яагаад гэвэл тэд израильчуудад тунхаглаж байгаа израиль хүмүүс. Ажилчин хүн хоол хүнсээр хангагдах зохистой гэдэг зарчмыг иудейчүүд сайн мэдэж байсан. Тиймээс **алт, мөнгө, зэс, хүнсний богц, хос дээл, гутал, таяг** авч явах хэрэг байгаагүй. Гэхдээ хэдийнээ таягтай бол түүнийгээ авч явахыг зөвшөөрсөн (Марк 6:8). Тэгэхээр илүү гутал, илүү таяг авч явах хэрэггүй гэсэн санаагаар энд хэлсэн болов уу. Өөрөөр хэлбэл, хэрэгцээ нь тухайн өдөртөө

хангагдана гэсэн зарчим баримтлахыг энд хэлж байна.

[10:11] Хоноглох газрын хувьд тэдэнд ямар заавар өгсөн бэ? Тэд ямар нэг **хот тосгонд** очоод **зохистой** хүнийг хайх ёстой. Өөрөөр хэлбэл, тэднийг Эзэний шавь нар хэмээн хүлээн авч, тунхаглах мэдээнд нь нээлттэй хандах хүн. Нэгэнт тийм хүнийг олбол тухайн хот тосгоноос явах хүртлээ тэр айлдаа байх хэрэгтэй. Илүү тухтай газар олмогцоо тэндээс явж болохгүй. Нэг газраа л тогтвортой байх хэрэгтэй.

[10:12-14] Хэрэв тухайн нэг **айл** шавь нарыг хүлээн авбал тэдэнтэй **мэнд мэдэж**, зочломтгой сэтгэлийг нь хүлээн авч, талархсанаа илэрхийлнэ. Харин Эзэний элч нарыг зочлохоос татгалзвал шавь нар тэр айлд Бурханы **амар амгалангийн** төлөө залбирч өгөх үүрэггүй болно. Өөрөөр хэлбэл, тухайн айлд сайн сайхныг ерөөхгүй гэсэн үг. Түүгээр ч зогсохгүй Бурханы дургүйцлийг илэрхийлэн **хөлийнхөө шороог** сэгсэрч унагах ёстой. Христийн шавь нарыг хүлээн авахаас татгалзсан айл нь Христийг хүлээн аваагүйтэй адил билээ.

[10:15] Шавь нарыг хүлээн авахаас татгалзагсад хожим **шүүлтийн өдөр Содом ба Гоморрагаас** хүнд шийтгэл амсах болно гэдгийг Эзэн Есүс анхааруулсан. Тэгэхээр тамд ч гэсэн шийтгэлийн зэрэглэл байдаг ажээ. Эс бөгөөс нэгнийх нь шийтгэл нөгөөгийнхөөс **илүү хүлцэхүйц** байх боломжгүй болно.

**[10:16]** Энэ хэсэгт хавчлагатай нүүр тулбал ямар зан хандлагатай байх ёстой талаар Эзэн Есүс арван хоёр шавьдаа зөвлөж байна. Тэд **сүрэг чонон дундах хонь мэт** байдалтай байх болно. Өөрсдийг нь хөнөөх гэсэн хорон санаат хүмүүс тэднийг тойрон хүрээлнэ. Тиймээс тэд хэрэггүй юманд буруутаж, элдэв заль мэхэнд унахгүйн тулд **могой мэт ухаалаг байх** ёстой. Мөн **тагтаа мэт гэмгүй** байж, зөв шударга зан, үнэн итгэлийн хуяг дуулгаар өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй.

**[10:17]** Итгэлгүй иудейчүүд шавь нарыг шүүхийн өмнө авчирч, **синагогууддаа ташуурдахаас** буцахгүй тул болгоомжтой байх хэрэгтэй. Тэдний эсрэг шашныхан төдийгүй жирийн иргэд ч дайрах болно.

**[10:18]** Тэд Христийн төлөө **захирагчид ба хаадын** өмнө хүргэгдэх болно. Гэвч Бурханы зорилго хүний бузар мууг ялна. “Хүн бузар муудаа хөтлүүлдэг бол Бурханд Өөрийн зам буй.” Ялагдаж буй мэт харагдах тэр цагт захирагчид болоод **харийнхны** өмнө гэрчлэх онцгой боломж шавь нарт гарч ирнэ. Бурхан бүх зүйлсийг хамтад нь сайны төлөө ажиллуулах болно. Христитгэл төрийн удирдагчдаас маш их зовлон амсаж байсан ч гэлээ “төрийн эрхэнд байгаа хүмүүст үүн шиг ач тустай сургаал байхгүй ажээ.”

**[10:19, 20]** Хэцүү бэрх цагт юу хэлэх билээ хэмээн сэтгэл зовних хэрэггүй. Цаг нь ирэхэд Бурханы **Сүнс** тэнгэрлэг мэргэн ухаан өгч,



Христийг алдаршуулах хариултыг зааж, буруутгагчдыг нь хэлэх үггүй болгоно. Арван есдүгээр эшлэлийг тайлбарлахдаа зайлсхийх ёстой хоёр туйлшрал бий. Нэгт, итгэгч хүн сургаал номлолоо урьдчилан бэлтгэх хэрэггүй гэж үзэх. Хоёрт гэвэл, энэ эшлэл өнөөгийн бидэнд ямар ч хамаагүй гэж үзэх. Номлогч хүн Бурханы өмнө залбиран байж, тухайн нөхцөл байдалд тохирсон үгийг асуун, номлолоо бэлтгэх нь зүй ёсны зүйл бөгөөд тийм ч байх хэрэгтэй. Гэхдээ хүнд бэрх цагт Бурханы өмнөөс ярих тэнгэрлэг мэргэн ухаан өгөгдөнө гэдэг Бурханы амлалт ч үнэн билээ. Тэд Эцэгийн Сүнсийг төлөөлж ярих ам болох болно.

**[10:21]** Өөрсдөөс нь урваж, өөрсдийг нь барьж өгөх явдал гарна гэдгийг Есүс шавь нартаа урьдчилан сануулсан. **Ах нь дүүгээ** буруутгана. **Эцэг нь хүүхдээ** барьж өгнө. **Хүүхдүүд нь эцэг эхийнхээ** талаар мэдээлэл өгч эцэг эхээ цазаар авхуулна.

Ж.К.Макавлэй үүнийг маш сайхан хэлсэн:  
Энэ дэлхийн хорсол зэвүүцлийг тээхээр бид дуудагджээ. Эзэнд маань хэрхэн хандсаныг мэдсээр байж түүнээс дээр хандлагыг бид дайсны гараас хүлээх хэрэггүй. Энэ дэлхий Эзэн Есүст загалмай өгсөн юм бол дагалдагчдад нь сүйх тэрэг өгнө гэж бодох хэрэггүй. Түүнд өргөст титэм өмсүүлсэн юм бол бидэнд цэцгийн хэлхээ зүүнэ гэж санах хэрэггүй. Хорслыг нь төрүүлэх ямар нэг муу

юм бидэнд байгаа учраас юм уу нигүүлсэлт  
Эзэн маань зохисгүй нэгэн учраас бус, зүгээр  
л тэд Христэд хорсдог учраас бидэнд дургүй  
байгааг санацгаая.<sup>17</sup>

**[10:22, 23] Шавь нарыг бүгд үзэн ядах болно.**  
Зарим нь биш бүгд. Бүх үндэстэн ястан, бүх соёл  
иргэншил, бүх анги давхарга тэднийг үзэн ядна.  
**“Харин эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах  
болно.”** Энэ үгийг дангаар нь авч үзвэл авралыг  
тууштай тэвчээрээр олно гэж буй мэт харагддаг.  
Гэвч ийм утгаар хэлсэн байх боломжгүй гэдгийг  
бид мэднэ. Яагаад гэвэл аврал бол итгэлээр  
дамжуулж авдаг Бурханы нигүүлслийн үнэгүй  
бэлэг (Ефес 2:8, 9) гэдгийг бичвэрт олон газар  
тодорхой хэлсэн. Түүнээс гадна, Христэд үнэнч  
хүн үхлээс аврагдана гэсэн утгатай байх  
боломжгүй. Яагаад гэвэл итгэмжит үнэнч  
дагалдагчид ч үхэлд тушаагдана гэдгийг өмнөх  
эшлэлд өгүүлсэн. Тэгэхээр, хамгийн энгийн  
тайлбар бол тэвчээр нь жинхэнээсээ аврагдсаны  
нэг шинж тэмдэг. Үүнтэй адилхан үгийг Матай  
24:13 дээр их зовлонгийн үед Эзэн Есүст үнэнч  
байдлаа алдалгүй итгэмжит үлдэх иудейчүүдийн  
тухай бас хэлсэн. Тэдний тэвчээр нь жинхэнэ  
дагалдагч болохыг нь харуулна.

Ирээдүйн тухай ярьж буй Библийн хэсгүүдэд  
Бурханы Сүнс заримдаа ойрын ирээдүйтэй  
холбоотой үгийг алс ирээдүйд холбох нь байдаг.  
Ойрын ирээдүйд зарим талаараа холбогдох  
боловч алс ирээдүйд бүрэн дүүрэн биеллээ олох

эш үзүүллэг Библид олон бий. Тухайлбал Христийн хоёр ирэлтийг ямар ч тайлбаргүйгээр хамтатган өгүүлдэг (Исаиа 52:14, 15; Мика 5:2-4). Эзэн Есүс 22, 23 дугаар эшлэлд ийм маягийн утга шилждэг эш үзүүллэг өгч байна. Нэг талаараа Эзэн Есүс өөрийнх төлөө зовлон эдлэхийг нь шавь нартаа сануулж байгаа ч гэсэн нөгөө талаараа энэ нь их зовлонгийн үеийн иудей дагалдагчдынх нь үлгэр жишээ болох ажээ. Анхны итгэгчдийн туулах зовлон бэрхшээлийг тэрээр хоёр дахь ирэлтийнх нь өмнө амьдарч байх итгэгчдэд хамаатуулан ярьж байна.

Хорин гуравдугаар эшлэлийн эхний хэсэг нь арван хоёр шавь нарт хамаатай байж болно: **“Харин тэд та нарыг энэ хотод хавчвал өөр хот уруу зугтацгаа.”** Хэрэв зугтах боломж байвал дайснаас ирэх дарамт шахалт дор заавал үлдэх албагүй. “Аюулаас зугтах нь буруу биш, харин үүрэг хариуцлагаас зугтаж болохгүй.”

Хорин гуравдугаар эшлэлийн хоёр дахь хэсэг нь Христ хаанчлахаар ирэх өдрүүд рүү биднийг аваачдаг: **“Хүний Хүүг ирэхээс нааш та нар Израилийн хотуудаар явж дуусахгүй.”** Арван хоёр шавийн үед Хүний Хүү аль хэдийнээ ирчихсэн байсан учраас энэ үг тэдний илгээлтийн тухай байх боломжгүй. Библийн зарим багш нар үүнийг МЭ 70 онд болсон Иерусалимын сүйрлийн тухай гэж үздэг. Гэвч тэр үйл явдлыг “Хүний Хүүгийн ирэлт” гэж үзэх үндэслэл байхгүй. Тиймээс энэ үг нь Христийн хоёр дахь ирэлтийг хэлсэн гэвэл илүү таарна. Их

зовлонгийн үеэр Христэд үнэнч иудей ах дүү нар хаанчлалын сайнмэдээг тунхаглаж Израилийн хотуудаар явах болно. Хүмүүс тэднийг хавчиж, мөшгөх учраас тэд Израилийн бүх хотуудад хүрч амжихгүй. Түүнээс нь өмнө Эзэн Есүс хүрч ирээд дайснуудыг нь шийтгэж, хаанчлалаа байгуулна.

Хорин гуравдугаар эшлэл ба Матай 24:14 хоорондоо зөрчилдөж байгаа мэт харягддаг. Энд болохоор **Хүний Хүүг ирэхээс нааш Израилийн бүх хотуудаар явж дуусахгүй** гэсэн байна. Харин 24:14 дээр хаанчлалын сайнмэдээ нь Христийн хоёр дахь ирэлтээс өмнө бүх дэлхий даяар тунхаглагдана гэжээ. Үнэндээ энд ямар нэг зөрчилдөх зүйл байхгүй. Хаанчлалын сайнмэдээ нь хүн бүрд биш юмаа гэхэд бүх үндэстэнд тунхаглагдах болно. Харин Израильд энэ мэдээг хатуу эсэргүүцэж, элч нарыг нь ширүүн хавчиж хяхна. Түүнээс болоод Израилийн бүх хотуудад хүрч амжихгүй.

**[10:24, 25]** Бид яагаад заавал хүмүүсээс хавчлага зовлон амсах ёстой юм бэ гэж асуух үе Христийн дагалдагчдад бишгүй гардаг. Хэрэв Есүс Мессиа юм бол дагалдагчид нь зовох биш хаанчлах ёстой биш үү? Эзэн Есүс ийн асуухыг нь мэдээд 24, 25 дугаар эшлэлд хариу өгчээ. Ингэхдээ өөртэй нь ямар холбоотой болохыг нь шавь нартаа сануулсан. Тэд бол шавь нар. Тэр бол Багш. Тэд бол зарц. Тэр бол Эзэн. Багшийгаа дагаж буй шавь багшаасаа илүү байдаггүй. Зарц хүнд Эзэнээс нь илүү ханддаггүй. Хэрэв хүмүүс

Эзэнийг нь **“Беелзэбүл”** (“Ялааны эзэн” гэсэн утгатай үг, екрончуудын бурхны нэр. Хожим иудейчүүд Сатаныг үүгээр нэрлэжээ) гэсэн юм бол зарц нарыг нь түүнээс муухайгаар доромжлох нь дамжиггүй. Шавь хүн Багшид нь ирж буй доромжлолыг ч бас хуваалцдаг.

**[10:26, 27]** Эзэн Есүс дагалдагч нартаа гурван удаа (26, 28, 31-р эшлэл) бүү ай гэж хэлжээ. Нэгт, дайснууд нь ялж байгаа мэт харагдаж байсан ч айх хэрэггүй. Хожмын өдөр түүний зорилго яруу алдартайгаар биелэх болно. Өдий болтол сайнмэдээ нь харьцангуй **далдлагдсан**, Түүний сургаал **нууцлагдсан** байсан. Гэхдээ тун удахгүй Христийн нууцаар хувьчлан хэлж байсан мэдээг шавь нар нь зоригтойгоор ил тунхаглах болно.

**[10:28]** Хоёрт, хүмүүс амь насанд нь аюул занал учруулсан ч **айх хэрэггүй**. Хүний хийж чадах хамгийн муу зүйл бол **биеийг хөнөөх**. Гэтэл үнэндээ үхэл бол христитгэгч хүнд тохиож болох хамгийн аймшигтай зүйл биш юм. Үхэх нь Христтэй хамт байх гэсэн үг тул амьдрахаас ч дээр зүйл мөн. Үхэл биднийг нүгэл, шаналал, өвчин, зовлон, үхлээс бүрмөсөн чөлөөлдөг. Үхэл биднийг мөнх алдар уруу оруулдаг. Тиймээс хүмүүсийн хийж чадах хамгийн муу зүйл нь Бурханы хүүхдүүдэд учирч болох хамгийн сайхан зүйл юм.

Дагалдагчид хүмүүсээс бус, харин **сүнс ба биеийг хоёуланг нь тамд устгаж чадах** Бурханаас **айн** эмээх хэрэгтэй. Бурхан ба Христээс мөнхөд салж, ямар ч найдваргүй үлдэх

нь хамгийн том хохирол мөн. Сүнсний үхэл бол юугаар ч хэмжих аргагүй гарз хохирол юм. Тиймээс тэр хохирлыг амсахгүйн төлөө бүхнээ өгсөн ч болно.

Хорин наймдугаар эшлэлд Есүсийн хэлсэн үг нь Бурханы үнэнч дагалдагч Жон Ноксыг санагдуулж байна. Түүний булшны чулуун дээр дараах үгийг бичиж үлдээжээ: “Хүнээс айдаггүй, зөвхөн Бурханаас эмээгч нэгэн энд нойрсож байна.”

[10:29] Гал мэт ширүүн зовлон дунд ч гэсэн Бурхан анхааран халамжилна гэдэгт шавь нар бүрэн итгэлтэй байж болно. Эзэн Есүс үүнийг ойлгуулахын тулд хаа сайгүй тааралдах бор шувууг жишээ болгосон. **Хоёр бор шувууг задгай зоосоор худалддаг.** Гэсэн ч **Эцэгийн зөвшөөрөлгүйгээр тэдний нэг нь ч үхдэггүй.** Эцэг бүгдийг мэдэж байгаа. “Бурхан бор шувуу бүхний оршуулгад оролцдог” гэж нэг хүний хэлсэн үг юутай үнэн бэ.

[10:30, 31] Өчүүхэн бор шувууг хүртэл тус бүр анхаардаг тэр Бурхан өөрийн бүх хүүхдүүдийн **толгойн үсийг** ч ширхэгчлэн тоолжээ. Үсний ганц ширхэг нь бор шувуунаас хямдхан шүү дээ. Тэгэхээр Бурхан өөрийнхөө хүмүүсийг **олон бор шувуунаас ч үнэтгйд** тооцдог гэсэн үг юм. Тиймээс Христийн дагалдагчдад айх шалтгаан үгүй.

[10:32] Сая дурдсан бүхнийг бодож үзвэл, Христийг **хүмүүсийн өмнө** зоригтой хүлээн **зөвшөөрөхөөс** илүү зөв зүйл гэж Христийн

дагалдагч хүнд үгүй. Түүнээсээ болоод доромжлол, буруутгал үүрснийх нь хариуд Эзэн Есүс түүнийг **Эцэгийнхээ өмнө хүлээн зөвшөөрч**, тэнгэрт элбэг баян шагнал өгөх болно. Христийг хүлээн зөвшөөрөх гэдэг нь Эзэн ба Аврагчийн хувиар Түүнд өөрийгөө зориулж, амьдралаараа болон амаараа түүнийгээ батлан харуулахыг хэлнэ. Есүс Христийн арван хоёр шавь нь бараг бүгдээрээ ийнхүү хүлээн зөвшөөрч байгаагаа харуулахын тулд шаардлагатай үед амиа ч гэсэн өгсөн билээ.

**[10:33]** Христийг газар дэлхий дээр үгүйсгэгч хүн эргээд **тэнгэрт** Бурханы **өмнө** үгүйсгэгдэн хариугаа авах болно. Энд хэлж байгаачлан Христийг үгүйсгэх гэдэг нь өөрийнх нь амьдралаас шаардаж буй Христийн шаардлагуудыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах явдал юм. “Би Таныг огт мэдэхгүй” гэж буй амьдралтай хүмүүс эцсийн өдөр Христээс “Би чамайг огт танихгүй” гэдэг үг сонсох болно. Гэхдээ Эзэн энд, дарамт шахалтаас болж үгүйсгэсэн Петрийнх шиг түр зуурын үгүйсгэлийг яриагүй. Харин байнга үгүйсгэх, бүрмөсөн үгүйсгэх тухай ярьж байна.

### **Г. Энхийг бус илдийг (10:34-39)**

**[10:34]** Эзэн Есүс үнэн хэрэгтээ энх тайван, амар амгаланг авчрахаар ирсэн (Ефес 2:14-17). Тэр Өөрөөрөө дамжуулан ертөнцийг аврахаар ирсэн (Иохан 3:17). Гэтэл Түүнийг ирснээс болоод гарах үр дагавар нь ирсэн зорилго нь юм

шиг харагдахыг Есүс “**Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм**” гэж ёгтлон хэлжээ.

[10:35-37] Нэг ёсондоо, хэн нэг хүн Христийн дагалдагч болох үед гэр бүлийнхэн нь түүний эсрэг болно гэдгийг энд ярьж байна. Үл итгэгч хүү нь итгэгч аавыгаа эсэргүүцнэ. Аврагдаагүй охин нь аврагдсан ээждээ дургүйцнэ. Сүнсээр дахин төрөөгүй бэр нь сүнсээр дахин төрсөн хадам эхийгээ үзэн ядна. Тийм учраас Христ үү эсвэл гэр бүл үү гэсэн сонголт хийх үе ирж болох юм. Дагалдагч хүн Эзэнд үнэнч сэтгэлээ гэр бүлийн холбооноос болж хаяж болохгүй. Эзэн Есүс дагалдагч хүний хувьд аав, ээж, хүү, охиноос нь ч илүү байх ёстой. Дагалдагч хүний төлөх ёстой төлөөснүүдийн нэг нь гэр бүлээсээ салах явдал байж болох юм. Энэхүү дайсагнал нь амьдралд тохиолдох хамгийн гашуун явдал ч байж магад.

[10:38] Христийн зүй ёсны байрыг дагалдагч хүний сэтгэлээс хулгайлж чадах, гэр бүлээс ч хүчтэй өөр нэг зүйл бий. Тэр бол өөрийнхөө амийг хайрлах хайр. Тиймээс Есүс араас нь дараах үгийг нэмжээ: **“Загалмайгаа авалгүйгээр Миний хойноос дагагч нь Миний хувьд зохистой нэгэн биш.”** Загалмай гэдэг нь мэдээж үхэл гэсэн утгатай. Тэгэхээр загалмайгаа аваад Христийг дагана гэдэг нь өөрийгөө бүрэн үгүйсгээд Христэд бүхнээ зориулан амьдрахыг хэлнэ. Үхлээ ч гэсэн харамсахгүй гэсэн үг. Эзэний төлөө амиа өгөх шаардлага бүх



дагалдагчдад гарахгүй. Гэхдээ бүх дагалдагч Түүнийг дээдийн дээдээр хайрлаж, аминаасаа ч үнэтэйд тооцон амьдрахаар дуудагдсан билээ.

**[10:39]** Аминдаа хайртай төрөлх занг Христийг хайрласан хайраар дийлж чадна. **Амиа ологч нь түүнийгээ алдах болно.** Христийн төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно. Христэд өөрийгөө зориулснаас болоод амиа алдахгүйн тулд амьдралаас зуурч, түүнийгээ хувийнхаа ашиг сонирхолд зарцуулах нь үнэндээ амь амьдралыг ямар ч ашиггүй зүйлд үрж буй хэрэг мөн. Харин Христийн төлөө үйлчлэн амьдарвал амь амьдралыг хамгийн үр дүнтэй ашиглаж байгаа хэрэг юм. Христэд бүхнээ зориулаад **амиа алдсан хүн** түүнийгээ жинхэнэ утгаар нь бүрэн дүүрэн **олж авах болно.**

#### **Д. Аяга хүйтэн ус (10:40-42)**

**[10:40]** Шавь нарын тунхаглах мэдээг хүн бүр эсэргүүцэхгүй. Зарим хүн тэднийг Мессиагийн төлөөлөгчид байна гэж таниад найрсгаар хүлээн авна. Тэрхүү сайхан сэтгэлд хариу барих зүйл шавь нарт хомс байх боловч түүнд санаа зовох хэрэггүй. Шавь нарт нь хийж өгсөн зүйлсийг бүгдийг нь Эзэн өөртөө хийж өгснөөр тооцож хожим тэдгээр сайхан сэтгэлт хүмүүсийг шагнах болно.

Христийн дагалдагчийг хүлээн авах нь Христийг хүлээн авсантай адил. Христийг хүлээн авах нь Түүнийг **илгээсэн** Эцэгийг хүлээн авсантай адил. Яагаад гэвэл илгээгдсэн

хүн нь илгээсэн хүнээ төлөөлж байдаг учраас тэр юм. Өөрийг нь томилсон засгийн газрыг төлөөлж суугаа элчин сайдыг хүлээн авах нь тухайн улстай дипломат харилцаа тогтоосон гэсэн үг мөн.

**[10:41] Эш үзүүлэгч болохоор нь эш үзүүлэгчийг хүлээн авсан хүн эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна.** А.Т.Пиерсон үүнд дараах тайлбарыг хийсэн:

Иудейчүүд эш үзүүлэгчийн шагналыг хамгийн агуу шагнал гэж үздэг. Учир нь, хаан хүн Эзэний нэрээр захирч, тахилч хүн Эзэний нэрээр үйлчилдэг байхад Эзэнээс ирсэн эш үзүүлэгч хүн хаан болоод тахилчид аль алинд нь заавар өгдөг. Хэрэв та эш үзүүлэгчийг хүлээн авч түүнд тусалбал өөр юу ч хийгээгүй байсан ч эш үзүүлэгчид өгөх шагналыг хүлээн авна гэдгийг Христ хэлж байна. Хэрэв та хэн нэг номлогчийг шүүмжилж суугаа бол үүнийг нэг бодоод үз. Бурханы өмнөөс ярихад нь та тэр хүнд тусалж, түүнийг урамшуулах аваас түүнд өгөгдөх шагналаас нь ч бас авах болно. Харин үүргээ биелүүлэхэд нь нэрмээс болж байвал та шагналаа алдана. Сайныг үйлдэхээр эрмэлзэж байгаа хүнд туслах нь агуу зүйл мөн. Түүний хувцас, зан хандлага, биеэ авч яваа байдал, дууны өнгийг нь бодох хэрэггүй. Харин түүнээс цаадхыг бод. “Ярьж байгаа үг нь надад зориулсан Бурханы үг мөн

үү? Энэ хүн сүнсэнд минь үг хэлэхээр илгээгдсэн Бурханы эш үзүүлэгч юм биш биз?” хэмээн бод. Хэрэв мөн бол тэр хүнийг хүлээн авч, үг ба үйлсийг дэмж, тэгвэл та шагналаас нь авах болно.<sup>18</sup>

**Зөвт хүн болохоор нь зөвт хүнийг хүлээн авсан хүн зөвт хүний шагналыг хүлээн авна.** Өнгө үзэмж, хөрөнгө чинээгээр нь бусдыг дүгнэдэг хүн даруухан дорд харагдах нэгэнд жинхэнэ зөв зан чанар байдгийг тэр бүр мэддэггүй. Эзэний хамгийн өчүүхэн шавьд үзүүлсэн хандлагыг хүртэл Эзэн Өөрт нь хандсанаар хүлээн авдаг.

**[10:42]** Есүсийн дагалдагч хүнд үзүүлсэн сайхан сэтгэлийг Эзэн мартахгүй. Есүсийн дагалдагч гэдгийг нь бодоод Эзэний **шавьд** өгсөн **аяга хүйтэн ус** хүртэл заавал шагнал хүртэнэ.

Эзэн Есүс арван хоёр шавийнхаа хэр өндөр байр суурьтай хүмүүс болохыг нь сануулаад зааварчилгаагаа өндөрлөж байна. Хүмүүс тэднийг эсэргүүцэж, үгүйсгэж, барьж цагдаж, шоронд хорьж, бүр алж ч мэднэ. Гэвч тэд Хааны төлөөлөгчид гэдгээ огтхон ч мартаж болохгүй. Тэд бол Хааны нэрийн өмнөөс ярьж, үйлдэх онцгой эрхтэй хүмүүс билээ.

## VII. ЭСЭРГҮҮЦЭЛ, ДУРГУЙЦЭЛ УЛАМ ИХ НЭМЭГДСЭН НЬ (11, 12-р бүлэг)

### А. Иохан Баптист шоронд (11:1-19)

[11:1] **Есүс** арван хоёртоо түр хугацааны тусгай даалгавар өгч Израилийн гэр уруу илгээгээд Өөрөө дагалдагч нарынхаа амьдарч байсан Галилын хотуудаар зааж, тунхаглахаар тэндээс явав.

[11:2, 3] Тэр үед **Иоханыг** Херод хаан шоронд хорьсон байв. Урам хугарч, ганцаардсан Иохан яагаад ийм байгааг гайхаж эхэлжээ. Хэрэв Есүс үнэхээр Мессиа мөн юм бол замыг нь бэлдсэн хүнийг ингэж шоронд хатахыг яагаад зөвшөөрч байгаа юм бол? Бурханы олон агуу хүмүүсийн адил Иохан хэсэг зуур итгэлээр унажээ. Тэгээд **тэр хоёр шавиараа үг дайж** асуулгав: Та эш үзүүлэгчдийн амласан хүн үнэхээр мөн үү, аль эсвэл бид одоо ч гэсэн Тослогдсон Нэгэнийг (Мессиа буюу Христ) хүлээсээр л байна уу?

[11:4, 5] **Есүс хариуд нь** Мессиагийн тухай зөгнөсөн гайхамшгуудыг үйлдэж буйгаа Иоханд сануулсан: **Сохор нь хараа орж** (Исаиа 35:5), **суунги нь алхаж** (Исаиа 35:6), **уямантай нь цэвэршиж** (Исаиа 53:4, Матай 8:16, 17-г харьцуулж үз), **дүлий нь сонсож** (Исаиа 35:5), **үхэгсэд нь амилж** (Мессиагийн талаар ийм зөгнөл байхгүй. Тэгэхээр урьдаас хэлэгдсэн гайхамшгуудаас ч илүүг Есүс хийжээ) байна. Есүс мөн ядууст сайнмэдээ тунхаглагдаж буйг

Иоханд сануулсан. Энэ бол Исаиа 61:1-г зөгнөсөн Мессиагийн тухай эш үзүүлэгийн биелэл юм. Дийлэнх шашны удирдагчид баян чинээлэг, нэр төртэй хүмүүст гол анхаарлаа хандуулсан бол Мессиа **ядууст** сайнмэдээг авчирсан.

**[11:6]** Аврагч Эзэн маань дээр нь нэмээд **“Надаас болж үл бүдрэгч нь ерөөлтэй еэ”** гэжээ. Энэ үг өөр хүний амнаас гарсан бол өөрийгөө дээд зэргээр өргөмжилсөн хийрхэл болох байв. Харин Есүсийн амнаас гарахдаа төгс мөн чанарыг нь илэрхийлсэн зүй ёсны үгс байлаа. Мессиа ирэхдээ сүр жавхлантай цэргийн жанжин бололгүй төлөв даруу Мужаан болжээ. Түүний дөлгөөн, даруу чанар тухайн үед Мессиаг цэргийн жанжин гэж төсөөлж байсан олны үзэлтэй нийцэхгүй байв. Махбодын хүсэлд хөтлөгдөгч хүн Есүсийг хараад хаан гэдэгт нь эргэлзэж болох юм. Харин Назарын Есүсийг амлагдсан Мессиа гэж сүнсний нүдээр таньсан хүмүүст Бурхан ерөөлөө хайрлах болно.

Зургаадугаар эшлэлийг Иохан Баптистад хэлсэн зэмлэл хэмээн тайлбарлаж болохгүй. Итгэл нь батжин босгогдох хэрэгтэй үе хүн бүхэнд ирдэг. Түр зуур итгэлээр унах нэг хэрэг, харин Эзэн Есүсийн хэн болохыг танихгүйгээр бүр мөсөн бүдрэх гэдэг өөр хэрэг юм. Амьдралаас нэг л бүлгийг аваад бүхэлд нь төлөөлүүлж болохгүй. Харин Иоханы амьдралыг бүхэлд нь авч үзвэл түүний итгэмжит байдал ба мятаршгүй сэтгэлийг харж болно.

**[11:7, 8]** Иоханы шавь нар Есүсийн баттай үгийг аваад тэндээс **явмагц** Эзэн хурсан олонд хандан Иохан Баптистыг өндрөөр үнэлэн ярив. Тэр хүмүүс Иоханыг цөлд номлож байхад цөл уруу хуйларч байсан юм. Яагаад цөл уруу явж байсан гэж? Хүний үзэл бодлын **салхинд найгаж** байдаг нарийн туяхан зэгс шиг дорой хүнийг **харах** гэж үү? Мэдээж үгүй. Иохан бол чимээгүй байснаас зовсон нь дээр гэж үздэг, худал хэлэхийн оронд үхэхийг сонгодог хатан зоригтой, бат тууштай тунхаглагч байсан юм. Тэд тансаглан суудаг сайхан хувцастай ихэс дээдсийг харах гэж цөл уруу явсан гэж үү? Бас л үгүй. Иохан бол хүмүүсийн дэндүү их дэлхийлэг байдлыг эгэл хатуужсан амьдралаараа зэмлэдэг Бурханы жирийн хүн байсан.

**[11:9]** Тэд **эш үзүүлэгчийг** харах гэж цөл уруу очсон гэж үү? Тийм ээ. Иохан бол эш үзүүлэгч байсан. Хамгийн агуу эш үзүүлэгч байсан. Гэхдээ зан чанар, тэвчээр хатуужил, номлох чадвараараа бусдаасаа агуу гэсэн үг биш юм. Эзэн Есүс энд ийм утгаар хэлээгүй. Тэрээр Мессиа Хааны замыг бэлдсэн учраас бусад эш үзүүлэгчээс агууд тооцогдсон.

**[11:10]** Үүнийг 10 дугаар эшлэлээс тодорхой харж болно. Иохан бол Малахигийн эш үзүүллэгийн (3:1) биелэл байв. Тэрээр Эзэний өмнөх **зарлага элч** бөгөөд Христийн ирэлтэд хүмүүсийг **бэлтгэсэн**. Бусад нь Христийн ирэлтийг эш үзүүлсэн бол Иохан ирснийг нь тунхагласан. “Иохан Христэд зориулж *зам*

*гаргаж өгчхөөд дараа нь Христийн төлөө замаа тавьж өгсөн билээ” гэх үг үнэхээр оновчтой тодорхойлолт болсон.*

**[11:11] “Тэнгэрийн хаанчлалын хамгийн бага нь ч гэсэн түүнээс агуу”** гэсэн үгнээс харахад Есүс Иоханы зан чанарыг бус, хүртсэн хувь завшааныг ярьсан болох нь баттай байна. **Тэнгэрийн хаанчлалд хамгийн бага** хүн Иоханаас илүү сайн зан чанартай байх боломжгүй. Харин илүү **агуу** хувь завшаантай байх нь дамжиггүй. Тэнгэрийн хаанчлалын иргэн байх нь тэнгэрийн хаанчлал ирснийг тунхаглахаас ч агуу зүйл мөн. Иохан Эзэнд зам бэлдсэн агуу хувь завшаантай хүн боловч тэрхүү хаанчлалын ивээлийг амсаагүй билээ.

**[11:12]** Иоханы үйлчлэлийн эхнээс аваад түүний шоронд орсон үеийг хүртэл **тэнгэрийн хаанчлал хүчирхийлэлд** автаад байна. Фарисайчууд болон хуулийн багш нар тэнгэрийн хаанчлалыг хүчтэй эсэргүүцсэн. Херод хаан бас тэнгэрийн хаанчлалыг тунхагласан элчийг барьж хорьсноороо үүнд хувь нэмрээ оруулсан.

**“Хүчирхийлэгч хүмүүс түүнийг хүчээр авдаг.”** Энэ үгийг тайлбарлаж болох хоёр хувилбар бий. (1) Тэнгэрийн хаанчлалыг устгахын тулд дайснууд нь хамаг хүчээрээ эсэргүүцэж байна. Тухайлбал, тэд Иоханыг эсэргүүцсэн нь Хааныг болоод хаанчлалыг эсэргүүцсэнтэй адил хэрэг мөн. (2) Хаан ирэхийг хүлээн байсан хүмүүс хаанчлалын мэдээг маш идэвхтэй хүлээн авсан бөгөөд тийш орох гэж

байдаг чадлаараа хичээн байна. Лук 16:16 дээр энэ утгаар хэлсэн: “Хууль ба эш үзүүлэгчид Иоханыг хүртэл байсан. Харин Бурханы хаанчлал тунхаглагдсан цагаас хойш хүн бүхэн тийш орохоор хүчлэн байна.” Энд тэнгэрийн хаанчлалыг бүслэгдсэн хотоор дүрсэлсэн. Бүх анги давхаргын хүмүүс гадна талаас хот уруу орох гэж хамаг хүчээрээ оролдон байна. Тэгэхийн тулд тодорхой хэмжээний сүнслэг хүч хэрэглэх хэрэгтэй.

Энэ хоёрын аль ч утгаар нь ойлгосон бай, нэг зүйл тодорхой. Юу гэвэл, Иоханы тунхаглал нь эргээд өргөн хүрээтэй, гүн нөлөөтэй хүчирхийллийг өдөөсөн.

**[11:13] “Хууль болон эш үзүүлэгчид Иоханыг хүртэл эш үзүүлж байлаа.”** Эхлэлээс Малахи хүртэлх бүх ном Мессиагийн ирэлтийн тухай зөгнөсөн. Тэгээд Иохан түүхийн тавцан дээр гарч ирсэн. Тэрээр зөвхөн эш үзүүлээд зогсохгүй Христийн эхний ирэлттэй холбоотой бүх эш үзүүлэлэг биелснийг тунхагласан.

**[11:14]** Мессиаг үзэгдэхээс өмнө Елиа ирэх болно гэж Малахи зөгнөсөн (Малахи 4:5, 6). Хэрэв хүмүүс Есүсийг Мессиа хэмээн **хүлээн авах** бол Иохан **Елиагийн** үүргийг гүйцэтгэхсэн. Гэхдээ Иохан бол дахин амилж ирсэн Елиа биш. Иохан өөрөө ч үүнийгээ Иохан 1:21 дээр хэлсэн. Харин тэрээр Елиагийн сүнс ба хүч дотор (Лук 1:17) Христийн өмнөх замыг бэлдэгч байжээ.

**[11:15]** Хүн бүр Иоханыг таашаан хүлээн аваагүй юм. Түүний үйлчлэлийн ач холбогдлыг



ч ойлгоогүй. Тиймээс Эзэн Есүс **“Сонсох чихтэй нь сонсогтун”** гэж хэлжээ. Өөрөөр хэлбэл, үүнийг сайн бод гэсэн утгатай. “Сонсож байгаа үг чинь маш чухал юм шүү! Ойлгохгүй өнгөрч болохгүй” гэсэн үг. Хэрэв Елиатай холбоотой эш үзүүллэгийг Иохан биелүүлсэн юм бол Есүс амлагдсан Мессиа байж таарна. Тэрээр Иохан Баптистыг баталж хэлснээр өөрийгөө Бурханы Христ болохыг харуулахыг зорьсон. Иохан Баптистыг хүлээн авсан хүн Христийг хүлээн авна. Христийг хүлээн авсан хүн Иохан Баптистыг хүлээн авна.

**[11:16, 17]** Гэвч Есүсийн үгийг сонсож байсан **үеийнхэн** хэнийг ч хүлээн авахыг хүссэнгүй. Мессиа Хаан ирэхийг үзэх хувь завшаан оногдсон иудейчүүд Хааныг ч тэр, элчийг нь ч тэр хүлээн авах хүсэлгүй байжээ. Тэд яг юу хүсээд байгаа нь ойлгомжгүй. Есүс тэдний энэ байдлыг **гудамж зээл дээр суугаа** ааш нь олдохгүй **хүүхдүүдтэй** зүйрлэсэн. Бүжиглэ гээд лимбэ тоглож өгөхөд дургүйцнэ. Оршуулга болж тоглоё гэхээр гашуудахаас татгалзана.

**[11:18, 19]** Иохан ирээд хатуу сахилга баттай байж, элдэв зүйлээс цээрлэн амьдрахад иудейчүүд түүнийг чөтгөр шүглэсэн хүн гэж доромжилсон. Гэтэл **Хүний Хүү** ердийн байдлаар идэж, ууж амьдарсан. Иоханы хатуу дэгтэй амьдрал тэднийг тавгүйтүүлсэн юм бол Есүс ердийн хүмүүсийн адил идэж уух нь тэдэнд таалагдах ёстой. Гэтэл тэгсэнгүй. Тэд түүнийг **ховдог, архичин бас татвар хураагчид ба**

**нүгэлтнүүдийн анд** гэж дуудав. Мэдээж хэрэг Есүс хэзээ ч хэтрүүлэн ууж идэж байгаагүй. Тэд энэ тал дээр дэвэргэн ярьсан. Харин **татвар хураагчид ба нүгэлтнүүдийн анд** байсан нь үнэн. Гэхдээ тэдний ярьж байгаагаас ондоо анд юм. Есүс тэднийг нүглүүдээс нь аврахын тулд нөхөрлөж байсан болохоос тэдний нүгэлд оролцох юм уу хүлээн зөвшөөрсөн удаа байгаагүй.

**“Гэсэн хэдий ч мэргэн ухаан үйлсээрээ зөвтгөгддөг.”** Эзэн Есүс бол хүн болсон Мэргэн ухаан мөн (1Коринт 1:30). Үл итгэгч хүмүүс түүнийг гүтгэн гүжирдэж магад. Гэхдээ Түүний үйлс хийгээд дагалдагч нарынх нь амьдрал Түүний зөвийг батална. Иудейчүүдийн ихэнх нь түүнийг Мессиа Хаан хэмээн хүлээн зөвшөөрөөгүй байж болно. Гэвч Түүний мэдэгдлүүд үнэн байсныг үйлдсэн гайхамшгууд болоод үнэнч дагалдагч нарынх нь сүнслэг өөрчлөлт бүрэн баталсан.

## **Б. Галилын гэмшээгүй хотууд золгүй еэ**

**[11:20]** Хүн хэр ихийг хүлээн авна тэр хэрээр хариуцлага хүлээнэ. Хоразин, Бетсайд, Капернаум шиг ихийг үзсэн хот байхгүй. Бурханы Хүү хүн болж ирээд тэр хотуудаар явж, зааж номлож, **ихэнх гайхамшгаа** тэнд **үйлдсэн** билээ. Ийм их баталгаа нотолгоо үзсэн атлаа тэд хөшүүн хүзүүлж, **гэмшихээс** татгалзав. Тиймээс, Эзэн Есүс тэдний дээр мөхлийн хувь тавиланг тунхагласанд гайхах зүйлгүй.

**[11:21]** Эзэн Есүс **Хоразин** ба **Бетсайд** хотуудаас эхэлсэн. Аврагч Бурхан нигүүлсэнгүйгээр тэднээс гуйж байхыг энэ хотууд сонссон мөртлөө түүнээс зориудаар нүүр буруулсан. Хуурамч шүтээн, бузар муугаасаа болоод Бурханы шийтгэлийг амссан **Тир, Сидон** хотод Есүсийн хийсэн энэ олон гайхамшгийг харах боломж олдсон бол тэд өөрсдийгөө даруу болгож, маш ихээр гэмших байсан. Тийм учраас, **шүүлтийн өдөр Тир, Сидон** хотынхныг Бурхан Хоразин, Бетсайд хотынхноос хөнгөн шийтгэх болно.

**[11:22]** “**Шүүлтийн өдөр...та нараас илүү хүлцэхүйц байх болно**” гэдэг үгийг үзвэл, тэнгэрт хүртэх шагналд зэрэглэл байдаг шиг (1Коринт 3:12-15) тамд ч гэсэн шийтгэлийн зэрэглэл байдаг ажээ. Хүнийг тамд унагах цорын ганц нүгэл бол Есүс Христэд захирагдахаас татгалзах (Иохан 3:36б). Харин тамд хэр их зовох вэ гэдэг нь хэр их нотолгоог үзэж, хэр муухай нүгэлд холбогдсон бэ гэдгээс шалтгаална.

**[11:23, 24]** **Капернаум** шиг агуу ивээл хүртсэн хот тун цөөн. Назар хотынхон өөрийг нь үгүйсгэсний дараа (9:1, Марк 2:1-12-ыг харьцуулж харь) Есүс Капернаумд суурьшсан. Тэгээд өөрийгөө Мессиа болохыг баттай нотлон харуулж, хамгийн агуу гайхамшгуудаа үйлдсэн. Ижил хүйстний харилцаагаараа зартай Содом хотынхон ч ийм агуу гайхамшгуудыг үзсэн бол гэмшиж, устгагдахгүй үлдэх байсан. Тэд гэмшээд зогсохгүй Эзэнийг баяр хөөртэйгөөр

хүлээн авах байсан. Харамсалтай нь Капернаум хот энэ боломжийг алджээ. Содомын нүгэл маш хүнд байсан нь үнэн. Гэхдээ Бурханы ариун Хүүг хүлээн аваагүй Капернаумын нүгэл түүнээс ч илүү хүнд юм. Тийм учраас шүүлтийн өдөр ирэхэд Содомын шийтгэл Капернаумынхаас хөнгөн байх болно. Өгөгдсөн боломжоороо **тэнгэрт тулгал өргөмжлөгдсөн Капернаум шүүлт ирэхэд үхэгсдийн оронд хаягдах болно.** Бурханаас ийм их нотолгоо үзсэн Капернаумыг хүлээж буй хувь тавилан энэ юм бол, Библиэр хахаж цэцэн, сайнмэдээг үргэлж сонсдог, хэлэх шалтаг цөөтэй газрууд гэмшиж Бурханы үнэн уруу эргэхгүй аваас тэднийг ч бас ийм хувь тавилан хүлээж байгаа нь дамжиггүй.

Эзэн Есүсийн үед Галилд Хоразин, Бетсайд, Капернаум, Тибер гэсэн дөрвөн голлох хот байсан. Эзэн Есүс Тиберээс бусад гурван хотод золгүй хувь тавилан тунхагласан. Үр дүн нь юу байв? Бетсайд, Хоразин хот бүрэн сүйрсэн учраас тэдний хаана байсныг өнөөдөр баттай мэдэж чадахгүй байна. Капернаумын байршил ч баттай тогтоогдоогүй. Харин Тибер хот одоо ч бий. Эш үзүүлэгийн ийм гайхалтай биелэл бол Аврагч Эзэний маань бүхнийг мэдэх мэдлэг ба Библийн илчлэлийн бас нэгэн нотолгоо билээ.

### **В. Аврагч Эзэний хариу хандлага (11:25-30)**

[11:25, 26] Дээр дурдсан Галилын гурван хот Бурханы Христийг хайрлах зүрх, харах нүдгүй байжээ. Тэдний энэ байдал бол нийт Израилийн

хүлээж авахгүй эсэргүүцэхийн зах зух нь гэдгийг Эзэн Есүс мэдэж байсан. Эзэн Есүс үүнд ямар хариу барьсан бэ? Эзэн Есүс гомдож хорсоогүй, итгэл алдраагүй, өс санаагүй. Харин ч Бурхан уруу дуугаа өргөн, бүхнээс дээд зорилгуудад нь юу ч саад болж чадахгүй хэмээн талархсан. **“Тэнгэр газрын Эзэн, Аав аа тандаа би талархъя. Цэцэд мэргэд хийгээд ухаантнуудаас нууцалсан зүйлээ та балчир хүүхдүүдэд илчилжээ.”**

Энэ үгийн талаарх хоёр буруу ойлголтоос зайлсхийх хэрэгтэй. Нэгт, Галилын хотууд дээр гарцаагүй шүүлт ирж байгаад Есүс баярласандаа ингэж хэлээгүй. Хоёрт, мэргэн цэцэн ухаантнуудаас Бурхан ихэмсгээр гэрлээ хааж, ухаарах боломж олгодоггүй гэсэн үг биш.

Галилын хотуудад Эзэн Есүсийг хүлээн авах бүх боломж байсан. Тэд зориудаар Түүнээс татгалзсан. Тэд гэрлээс татгалзсан учраас Бурхан гэрлээ татан авсан. Гэсэн ч Бурханы төлөвлөгөө бүтэлгүйтэхгүй. Хэрэв ухаантан сэхээтнүүд итгэхгүй бол Бурхан даруу зүрхтнүүдэд Христийг илчлэх болно. Тэрээр өлссөн хүмүүсийг сайнаар бялхуулж, баячуудыг гар хоосон буцаана (Лук 1:53).

Өөрсдийгөө мэргэн цэцэнд тооцсоноосоо болоод Христийг хэрэггүй гэж үздэг хүмүүс шүүн тунгаах чадваргүй харалган байдаг. Харин мэргэн ухаанаар дутмаг гэдгээ хүлээн зөвшөөрөгч хүмүүст “мэргэн ухаан ба мэдлэгийн бүх баялгийг өөртөө нууж байдаг” (Колоссай 2:3)

Христийг илчилж өгдөг. Зарим хүн Өөрөөс нь татгалзсан ч Өөрийг нь хүлээн авах өөр хүмүүсийг байлгаж байгаад Эзэн Есүс Эцэгтээ талархсан. Хатуу хөшүүн үл итгэлтэй тулгарсан ч гэлээ Бурханы төлөвлөгөө ба зорилго дотроос Эзэн Есүс тайтгарлыг олсон.

**[11:27] Эцэг бүх зүйлийг Христэд өгсөн.** Эзэн Есүсээс өөр хүн ийм тунхаглал хийвэл ойворгон сагсуурал болно. Харин Эзэн Есүсийн хувьд бол энэ үнэн мэдэгдэл мөн. Тухайн үед эсэргүүцэл уул овоо шиг болж, Түүний хяналтад нэг ч зүйл үгүй мэт харагдаж байсан ч энэ мэдэгдэл үнэн байсан. Эзэн Есүсийн амьдрал эцсийн эцэст алдарт ялалтад гарцаагүй хүрнэ. **“Эцэгээс өөр хэн ч Хүүг мэдэхгүй.”** Христийн бодгаль мөн чанарын тухай нууц нь дэндүү гүн билээ. Хүн ба бурхан чанар нэг бодгальд буйг хүмүүний ухаан ойлгож чаддаггүй. Тухайлбал, Христийн үхлийг ойлгох аргагүй. Бурхан үхэх боломжгүй. Есүс бол Бурхан. Гэвч Тэр үхсэн. Гэтэл Есүсийн бурхан мөн чанар ба хүмүүн мөн чанар нь салшгүй зүйлс. Тэгэхээр, Есүсийг бид таньж, хайрлаж, Түүнд итгэж чадах боловч Эцэгээс өөр хэн ч бүрэн ойлгож чадахгүй зүйл Түүнд бий.

Таны нэрийн гүнзгий нууцуудыг  
Тайлж ойлгохгүй хүний ухаанаар  
Бурхан Эцэг л гагц  
Бурхан Хүүг мэднэ  
Бурханы Хурга минь ээ!

Өвдөг бүхнийг өмнөө сөхрүүлэх

Хүндэтгэл танд зохист билээ

-Жосиа Кондер

**“Хүү болон Хүүгийн Эцэгээ илчлэхээр хүссэн хүнээс өөр хэн ч Эцэгийг мэдэхгүй.”** Эцэг ч гэсэн ухаарч ойлгошгүй агуу билээ. Зөвхөн Бурхан л Бурханыг ойлгож чадна. Хүн өөрийн хүч чадал, оюун ухаанаар Бурханыг мэдэж чадахгүй. Харин Эзэн Есүс өөрийн хүссэн хүнд Эцэгийг илчилж чадах бөгөөд илчилдэг. Хүүг мэдсэн хүн Эцэгийг ч бас мэддэг (Иохан 14:7).

Энэ олон зүйлийг хэлснийхээ дараа ч гэсэн 27 дугаар эшлэлийг тайлбарлах гэж оролдох нь дэндүү ухааршгүй зүйлийг авч үзэж буйгаа хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Бид толинд бүдэг бадаг харж байна. Мөнх эрин үеийг үзлээ ч гэсэн хязгаарлагдмал оюун ухаан маань Бурханы агууг бүрэн таньж мэдэж, хүн болсон Бурханы нууцуудыг төгс ойлгож чадахгүй л болов уу. Эцэг зөвхөн Хүүгийн сонгосон хүмүүст илчлэгддэг гэдгийг уншаад Бурханы таалсан цөөн хэдэн хүн л автоматаар сонгогдоно гэж бодож болохгүй. Дараагийн эшлэл нь тийм үзлийг эрс няцааж байна. Ядарч туйлдсан, хүнд дарамт үүрсэн хэн ч бай өөрт нь ирж амралтыг авах урилгыг Эзэн Есүс даян дэлхийн бүх хүнд өгч байна. Өөрөөр хэлбэл, Хүүгийн Эцэгээ илчлэхээр хүссэн хүмүүс гэдэг нь Хүүг Эзэн ба Аврагч болгон итгэж найдах хүмүүс юм.

Хэмжээлшгүй агуу дөлгөөн зантай Эзэн Есүсийн энэ урилга Галилын хотууд Эзэн Есүсээс илэрхий татгалзсаны дараа өгөгдсөн гэдгийг бүү мартаарай. Хүний үзэн ядалт ба гэжүүд муйхарлал нь Бурханы хайр ба нигүүлслийг үгүй хийж чадахгүй. А.Ж.Маклайн:

Израиль үндэстэн хэдийгээр Бурханы шийтгэлийг туулах цаг ойртож байгаа ч Хаан Эзэн эцсийн үгэндээ хүний авралд өргөн хаалга нээж өгчээ. Шүүлтийн босгон дээр ч гэсэн Тэр нигүүлслээр ханддаг Бурхан гэдгээ ийнхүү батлан харуулсан.<sup>19</sup>

**[11:28] Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн бүгд ээ.** Есүс дээр жинхэнэ утгаараа ирэхийн тулд хүн нүглийн хүнд дарамт дор эцэж туйлдсанаа хүлээн зөвшөөрөх ёстой. Төөрч алдагдсан гэдгээ ойлгосон хүмүүс л аврагдах боломжтой. Эзэн Есүс Христэд итгэхийн өмнө Бурханд хандан заавал гэмших учиртай.

**Над уруу.** Хэнд итгэх вэ гэхээр чуулган биш, итгэлийн тунхаг биш, ямар нэгэн санваартан биш, зөвхөн амьд Христэд итгэх. Аврал нь Есүс Христ хэмээх хүний дотор байдаг. Есүсийг хүлээн авсан хүмүүст Бурханы батламжилсан аврал бий.

**Ир.** Ирэх гэдэг нь дараах утгуудыг илэрхийлнэ: итгэх (Үйлс 16:31); хүлээж авах (Иохан 1:12); идэх (Иохан 6:35); уух (Иохан 7:37); харах (Исаиа 45:22); хүлээн зөвшөөрөх (1Иохан 4:2); сонсох (Иохан 5:24, 25); хаалгаар орох



(Иохан 10:9); хаалгаа нээх (Илчлэл 3:20); дээлийнх нь хормойд хүрэх (Матай 9:20, 21); бидний Эзэн Христээр дамжуулж мөнх амийг хүлээж авах (Ром 6:23).

**Би та нарт амралтыг өгнө.** Эзэн Есүсийн өгөх амралт нь бэлэг гэдгийг эндээс харах хэрэгтэй. Түүнийг авахын тулд ямар нэг гавьяа байгуулах хэрэггүй. Христ авралын ажлыг Голготын загалмай дээр бүрэн дуусгасныг ойлгосноос энэ амралт авралтай хамт ирдэг. Хүний нүглийн шийтгэлийг Христ нэг удаа бүр мөсөн үүрсэн бөгөөд Бурхан тийм шийтгэлийг хоёр дахиа шаардахгүй гэдгийг мэдсэнээр энэ амралт ухаан бодолд маань ирдэг.

**[11:29]** Өмнөх эшлэлд Эзэн Есүс хүмүүсийг авралд урьсан. Харин 29, 30 дугаар эшлэлд үйлчлэлд урьж байна.

**Буулгыг минь өөрсөд дээрээ ав.** Энэ нь Түүний хүсэлд өөрсдийгөө захируулж, амьдралын жолоогоо Түүнд өгөх гэсэн утгатай (Ром 12:1, 2).

**Надаас суралц.** Түүнийг бид амьдралынхаа бүх талбарт Эзэн гэдгийг хүлээн зөвшөөрвөл тэр биднийг өөрийнхөө замуудаар сургах болно.

**Учир нь би дөлгөөн, зүрхэндээ даруу.** Хахир хатуу, бардам зантай фарисайчуудаас маш их ялгаатай. Жинхэнэ Багш тэрээр дөлгөөн даруу зантай. Түүний буулгыг авсан хүмүүс даруу байхыг сурна.

**Та нар сэтгэлдээ амралтыг олох болно.** Энэ бол мөс чанарт ирдэг амралт биш, харин Бурхан

ба хүмүүсийн өмнө даруу болох үед зүрхэнд ирдэг амралт юм. Агуу болох гэсэн хандлагаа хаяж Христэд үйлчлэх үедээ хүн энэ амралтыг амсдаг.

**[11:30] “Учир нь буулга минь аятай, ачаа минь хөнгөн.”** Энд ч гэсэн фарисайчуудаас дэндүү их ялгаатай байна. Есүс тэдний тухай дараах үгийг хэлсэн: “Тэд хүнд ачаанууд баглаж хүмүүсийн мөрөн дээр тавьдаг атлаа өөрсдөө тэр ачаанд хуруугаа ч хүргэхийг хүсдэггүй” (Матай 23:4). Есүсийн буулга аятай учраас холгож нухахгүй. Хэрэв Есүс мужааны газрынхаа гадна хаяг тавивал “Таарсан буулга хийнэ” гэсэн бичигтэй байх байсан гэж нэг хүн хэлжээ.

Түүний **ачаа хөнгөн**. Гэхдээ Христэд итгэн амьдарвал асуудалгүй, зовлонгүй, бэрхшээлгүй, ажил хийхгүй байна гэсэн үг биш. Харин тэрхүү ачааг та ганцаараа үүрэхгүй гэсэн үг. Хэрэгтэй үед минь хангалттай нигүүлслийг өгдөг Нэгэн бидэнтэй хамт нэг буулгад бий. Түүнд үйлчлэх нь боолчлол биш ээ. Харин төгс эрх чөлөө мөн. Ж.Х.Жоветт:

Итгэгч хүн амьдралын ачаагаа ганцаараа үүрэх гэж зүтгэх нь түүний гаргадаг маш том алдаа юм. Хүн ачаагаа ганцаараа үүрэх нь Бурханы хүсэл биш. Тиймээс Христ хос буулга дор ажилладаг. Хос буулгаар хоёр малыг хамтад нь хөллөдөг. Тэрхүү буулгын нэг талд Эзэн Өөрөө ордог. Учир нь Эзэн хүнд хэцүүг бидэнтэй хамт үүрэхийг хүсдэг.

Хэрэв та “өөрөө” зүтгэдэг ганц оруулгатай буулгаа авч хаяад Эзэний “хос буулгад” хүзүүгээ хийвэл үүрэх ачаа чинь илүү хөнгөн болно. Христитгэгч хүний амар тайван, ялалттай амьдрах нууц энд оршдог.<sup>20</sup>

### **Г. Есүс бол амралтын өдрийн Эзэн (12:1-8)**

**[12:1]** Есүс Христийг үгүйсгэж, түүнээс татгалзсан хүмүүсийн эсэргүүцэл улам нэмэгдэж байгаа тухай энэ бүлэгт тэмдэглэсэн байдаг. Фарисайчуудын уур хилэн, хорсол занал нэмэгдсээр зад тавихад нэгэнт бэлэн болжээ. Тэрхүү үерийн даланг сэтэлсэн зүйл нь Амралтын өдрийн тухай асуудал байв.

Тэрхүү амралтын өдөр **Есүс** шавь нарынхаа хамтаар **тариан талбай дундуур явж байлаа. Шавь нар нь тариан түрүүг шувтран идэж эхлэв.** Хөршийнхөө тариан талбайд хадуур хүргээгүй л бол тарианаас нь идэхийг хуульд зөвшөөрсөн байдаг (Дэд хууль 23:25).

**[12:2]** Гэтэл **фарисайчууд** үүнийг хараад **Амралтын өдрийг** зөрчлөө хэмээн тэднийг буруутгав. Фарисайчууд тэднийг ямар ажил хийлээ гэж буруутгасныг тодорхой дурдаагүй. Гэхдээ магад дараах шалтгаанаар буруутгасан байж болох юм: (1) ургац хураасан (тариан түрүү тасалсан); (2) тариа цайруулсан (гараараа шувтарсан); (3) тариа шигшсэн (тарианы үрийг хальсалсан).

**[12:3, 4]** Энэ хөгийн буруутгалд Есүс хариу барихдаа **Давидын** амьдралд тохиолдсон нэг

явдлыг тэдэнд сануулсан. Давид зугтаж явахдаа цөлд очоод хүмүүсийнхээ хамтаар **тавиг талхыг идсэн**. Энэ нь тахилчдаас өөр хэн ч идэж болдоггүй арван хоёр талх байжээ. Гэсэн ч Бурхан Давидыг ч тэр, хамт явсан хүмүүсийг ч тахилч биш атлаа талх идлээ гэж буруутгаагүй. Яагаад буруутгаагүй юм бол?

Яагаад гэвэл, Бурхан хэзээ ч өөрийнхөө итгэмжит хүмүүсийг зовоох гэж хууль тогтоодоггүй. Давид тийнхүү зугтаж явсан нь Давидын буруугаас болоогүй. Нүгэлт Израиль түүнийг хүлээж аваагүйгээс болсон. Хэрэв тэд Давидад зүй ёсны байр суурийг нь өгсөн байсан бол тэрээр дагалдагч нарынхаа хамтаар тавиг талхыг идэхгүй байх байсан. Израильд нүгэл байсан учраас Бурхан хориглосон зүйлээ Давидад зөвшөөрчээ.

Есүсийн зүйрлэлийн цаад санаа маш тодорхой байна. Эзэн Есүс бол Израилийн хууль ёсны Хаан мөн. Гэтэл израильчууд Түүний эрх мэдлийг хүлээн зөвшөөрөөгүй. Хэрэв Есүст зохих байр суурийг нь өгсөн байсан бол дагалдагчид нь Амралтын өдрөөр ч тэр, ер нь долоо хоногийн аль ч өдөр ингэж дорд байдлаар юм идэхгүй байх байсан. Энд түүх давтагджээ. Эзэн дагалдагч нараа зэмлээгүй. Учир нь хийсэн буруу зүйл тэдэнд байхгүй.

**[12:5] Тахилчид** мал нядалж, өргөж, янз бүрийн үйлчлэл хийж **Амралтын өдрийг зөрчсөн ч** (Тооллого 28:9, 10), Бурханы

үйлчлэлийг хийж байгаа учраас **гэм зэмгүй** гэсэн хуулийг Есүс фарисайчуудад сануулсан.

[12:6] Тахилчид амралтын өдөр болгон ажилладаг ч амралтын өдрийг сэвтээдэггүйг фарисайчууд мэдэж байсан. Тэгвэл **сүмээс илүү агуу** нэгэний өмнө үйлдэж байгаа хүмүүсийг яагаад буруутгах ёстой гэж? Энд өгүүлж буй “нэгэн” гэдэг үгээр хүнийг биш “зүйл юмыг” хэлсэн гэж үзвэл илүү таарна. Тэгэхээр “Энд сүмээс илүү агуу зүйл байна” гэж уншигдана. Тэр зүйл нь Хаан дотор оршиж байгаа Бурханы хаанчлал юм.

[12:7] Фарисайчууд Бурханы сэтгэлийг огтхон ч ойлгосонгүй. Хосеа 6:6 дээр Бурхан, **“Би тахилыг бус энэрлийг хүсдэг”** гэж хэлсэн. Бурхан ёслолоос урд энэрэл хайрыг чухалчилдаг. Өөрийнх нь хүмүүс амралтын өдрийг хатуу сахиснаасаа болоод өлсөж зовж байхыг харснаас амралтын өдөр хэдэн тариан түүрүү тасалж идэхийг харах нь Түүнд илүү дээр. Фарисайчууд гагц үүнийг л ойлгож байсан бол Есүсийн шавь нарыг буруутгахгүй байсан. Гэвч тэд хүний сайн сайхан байдлаас илүү гадаад хэлбэрийг чухалчилж байжээ.

[12:8] Дараа нь Аврагч Эзэн **“Учир нь Хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн”** гэж нэмж хэлэв. Тэрээр хууль тогтоосон Нэгэн бөгөөд хуулийн жинхэнэ утгыг тайлбарлах бүрэн эрхтэй, зүй ёсны Нэгэн мөн. Е.В.Рожерс:

Энэ бүлэгт Матай Ариун Сүнсээр дамжуулан Эзэн Есүсийн нэр ба албыг олон талаас нь дурджээ. Үүнд: Хүний Хүү, Амралтын өдрийн Эзэн, Миний сонгосон Зарц, Миний Хайрт, Давидын Хүү, сүмээс агуу Нэгэн, Ионагаас агуу Нэгэн, Соломоноос агуу Нэгэн. Израильчууд Эзэн Есүсийг хүлээн авахаас татгалзаж, зүй ёсны эрхийнх нь дагуу хандахгүй байгаа нь хэчнээн том нүгэл болохыг Матай үүгээр харуулахыг зорьжээ.<sup>21</sup>

Есүс хатангир гартай хүнийг Амралтын өдөр эдгээсэн дараагийн үйл явдлыг авч үзэхээс өмнө түр зогсож, бичвэрт Амралтын өдрийн талаар ямар сургаал байдаг талаар товчхон харцгаая.

## АМРАЛТЫН ӨДӨР БУЮУ ШАББАТ

Шаббат бол долоо хоногийн долоо дахь өдрийг л хэлж байгаа (Бямба гараг). Энэ өдөр өөрчлөгдөхгүй.

Бурхан орчлон ертөнцийг зургаан өдөрт бүтээгээд долоо дахь өдөртөө амарсан (Эхлэл 2:2). Тухайн үедээ Бурхан амралтын өдрийг сахихыг хүнд тушаагаагүй. Гэхдээ долоо хоногийн нэг өдрийг амралт болгох зарчим анхнаасаа байсан бололтой.

Арван хуулийг өгөхдөө Бурхан Амралтын өдрийг сахих тушаалыг израильчуудад өгсөн (Гэтлэл 20:8-11). Амралтын өдрийн хууль нь бусад есөөсөө ялгаатай. Амралтын өдрийн хууль нь ёслолын шинж чанартай бол бусад ес нь ёс суртахуунтай холбоотой байв. Шаббат өдөр ажиллах нь буруу байгаагийн цорын ганц шалтгаан бол Бурхан тийн хэлсэн учраас тэр юм. Бусад тушаал угаасаа буруу зүйлстэй холбоотой.

Амралтын өдрөөр ажиллахыг хориглосон ч Бурханд үйлчлэх (Матай 12:5), хэрэгцээ тулгарсан үед ямар нэг зүйл хийх (Матай 12:3, 4), энэрэл өршөөл үзүүлэх (Матай 12:11, 12) зэрэгт энэ хориг хамаарахгүй. Арван хуулийн есийг нь Шинэ гэрээнд дахин дурдсан. Гэхдээ хууль болгож биш, харин нигүүлсэл дор амьдарч буй христитгэгчдэд зааварчилгаа болгож өгсөн. Тэдгээр арван тушаалаас христитгэгчдийг дагахыг заагаагүй ганц тушаал нь Амралтыг өдрийг сахих юм. Харин ч Амралтын өдрийг

сахихгүй байлаа гээд христитгэгчид буруутгагдахгүй гэж Паул заасан байдаг (Колоссай 2:16).

Христитгэгчдийн онцгой өдөр бол долоо хоногийн эхний өдөр юм. Энэ өдөр Эзэн Есүс үхлээс амилж (Иохан 20:1), авралын ажил гүйцсэнийг болоод тэр ажил Бурханд хүлээн зөвшөөрөгдсөнийг баталсан. Амиллын дараагийн хоёр Эзэний өдрөөр Есүс дагалдагч нартайгаа уулзсан (Иохан 20:19, 26). Ариун Сүнс долоо хоногийн эхний өдөр өгөгдсөн (Үйлс 2:1; Леви 23:15, 16). Анхны итгэгчид тэр өдөр цуглаж, талх хувааж, Эзэний үхлийг тунхагладаг байсан (Үйлс 20:7). Христитгэгчид Эзэний ажилд зориулж хуримтлал бий болгохоор Бурхан энэ өдрийг зааж өгсөн (1Коринт 16:1, 2).

Шаббат буюу Бямба гараг нь тухайн долоо хоногийн эцэст ажил хөдөлмөрөө зогсоож амардаг өдөр юм. Харин Эзэний өдөр буюу Ням гараг нь авралын ажил гүйцсэн тухай мэдлэгээр амралтыг авч тухайн долоо хоногийг эхлүүлдэг өдөр юм. Шаббат өдөр нь анхны бүтээлийг дурсан тэмдэглэдэг. Эзэний өдөр нь шинэ бүтээлтэй холбоотой. Шаббат бол үүрэг хариуцлагын өдөр. Эзэний өдөр бол христитгэгчдэд өгөгдсөн хувь завшааны өдөр.

Христитгэгчид авралыг олж авах гэж, эсвэл ариун болох гэж, эсвэл шийтгэлээс айсандаа Эзэний өдрийг сахидаггүй. Бидний төлөө Өөрийгөө өгсөн Нэгэнд хайраар зориулалт гарган энэ өдрийг бид онцгойлдог. Энэ өдөр бид



өдөр тутмын амьдралын хэмнэлээ түр азнаж, тусгайлан Христэд мөргөж, Түүнд үйлчилдэг.

Амралтын өдөр өөрчлөгдөж Эзэний өдөр болоогүй. Шаббат бол Бямба гараг, Эзэний өдөр бол Ням гараг. Амралтын өдөр бол сүүдэр, яг жинхэнэ мөн чанар нь Христ (Колоссай 2:16, 17). Христийн дахин амилал шинэ эхлэлийг тавьсан бөгөөд Эзэний өдөр нь тэрхүү эхлэлийг сануулж байдаг.

Хэдийгээр фарисайчууд Эзэн Есүсийг гүтгэн гүжирдсэн ч гэлээ, хуулийн дор амьдрагч итгэмжит иудей хүн байсныхаа хувьд Эзэн Есүс амралтын өдрийг сахидаг байсан. Амралтын өдрийн Эзэн болохынхоо хувьд Тэрээр Амралтын өдрийг сахихдаа хэрэглэдэг байсан хуурамч дүрэм журмаас нь ангижруулсан.

#### **Д. Есүс амралтын өдөр хүн эдгээсэн нь (12:9-14)**

**[12:9]** Есүс тариан талбайгаас **синагог уруу орлоо**. Лукийн сайнмэдээнд тэмдэглэснээр, хуулийн багш нар ба фарисайчууд Есүсийг буруутгах өө хайн тэнд сууцгааж байв (Лук 6:6, 7).

**[12:10]** Тэр үед синагогт **хатангир гартай нэгэн хүн байжээ**. Фарисайчууд түүнд туслах ямар ч хүчгүй гэдгийг үтгүйгээр гэрчлээд сууж байсан. Өнөөдрийг хүртэл фарисайчууд түүнийг ерөөсөө тоодоггүй байснаа гэнэтхэн тэр хүний хэрэг гарсан. Учир нь тэд Есүсийг буруутгахад түүнийг ашиглахаар санаархжээ. Аврагч Эзэн

маань зовж шаналсан хүнээс нүүр буруулдаггүйг нь мэддэг тул хатангир гартай хүнийг амралтын өдөр эдгээхийг нь андаад сууж байв. Тэгээд Түүнийг буруутган шийтгэх бодолтой байжээ. Тиймээс тэд **“Амралтын өдөр эдгээх нь хуульд нийцэх үү?”** хэмээн Эзэн Есүсийг сорьж асуусан.

[12:11] Аврагч Эзэн маань асуултынх нь хариуд **хонь нь Амралтын өдөр нүхэнд уначихвал тэндээс гаргахгүй гэж үү** гэж асуусан. Мэдээж тэд татаж гаргана. Гэхдээ яагаад татаж гаргана гэж? Магадгүй тэд **“Амьтны амийг сүйдэхээс аварч байгаа учраас”** гэж хариулах байх. Гэхдээ гол шалтгаан нь хонь бол мөнгө. Тиймээс тэд амралтын өдөр байсан ч гэсэн санхүүгийн алдагдалд орохыг хүсэхгүй.

[12:12] Хүн бол **хониноос илүү** үнэтэй гэдгийг Эзэн маань тэдэнд сануулжээ. Хэрэв **амралтын өдөр** амьтанд сайн зүйл хийх нь зөв юм бол хүнд **сайныг үйлдэх** нь бүр ч зөв зүйл байх нь дамжиггүй.

[12:13, 14] Иудейн удирдагчид өөрсдийн ухсан нүхэнд унаж, Есүс харин хатангир гартай хүнийг эдгээв. Эзэн Есүс хатангир гартай хүнийг эдгээхдээ **гараа сунга** гэж хэлснээр шийдвэр гарган итгэлийн үйлдэл хийхийг урьсан. Нөгөө хүн ч дуулгавартай хандсанд эдгэрлээр шагнуулав. Гайхамшигт Бүтээгч гарыг нь нөгөө гартай нь яг адил эрүүл болгож өгөв. Фарисайчууд тэр хүнд туслах ямар ч чадалгүй, хүсэлгүй байхад харин ч эдгэрснийх нь төлөө баярлах болов уу гэж та бодох байх. Гэтэл тэд

тэндээ гарч яваад Есүсийн эсрэг хуйвалдан, **Түүнийг хэрхэн хөнөөх талаар зөвлөлдөв.** Хэрэв тэд хатангир гартай байсан бол амралтын өдөр ч гэсэн эдгэрсэндээ хэчнээн их баярлах байсан бол доо.

**Е. Эзэн Есүс бүх хүнийг эдгээсэн нь (12:15-21)**

[12:15, 16] Өөрт нь дайсагнаж байгаа хүмүүсийн бодлыг **мэдэнгүүтээ Эзэн Есүс тэндээс холдов.** Гэтэл Түүнийг хаашаа л явна олон түмэн цугларч байв. Өвчтэй хүмүүс цуглахад **Тэрээр бүгдийг нь эдгээж** өгч байлаа. Харин ингэж гайхамшгаар эдгэрсэн явдлаа хэнд ч бүү хэл хэмээн Эзэн Есүс тэдэнд хэлж байв. Эзэн Есүс Өөрийгөө аюулаас хамгаалах гэсэндээ биш харин Өөрийг нь ардын баатар болгож, хувьсгалт хөдөлгөөн гарахаас сэргийлэхийн тулд ингэжээ. Бүх зүйл Бурханы төлөвлөгөөний дагуу болох ёстой. Эзэн Есүсийн хувьсгал гарцаагүй ирнэ. Гэхдээ Тэрээр ромчуудын цусыг урсгаж хувьсгал хийхгүй. Харин Өөрийнхөө цусыг урсах болно.

[12:17, 18] Эзэн Есүсийн үйлчлэл бол **Исаиа** 41:9, 42:1-4-д өгүүлсэн эш үзүүллэгийн биелэл байв. Мессиа зорьсондоо хүрэхдээ дөлгөөн даруу хандана гэдгийг **эш үзүүлэгч Исаиа** урьдаас зөгнөжээ. Түүнийг Иеховагийн **сонгосон Зарц**, Бурханы сэтгэлд **нийцсэн Хайрт** хэмээн дүрсэлжээ. Бурхан Мессиагийн дээр **Сүнсээ тавина** гэдэг эш үзүүллэг нь Есүсийг баптисм хүртэх үед биелсэн.

Мессиагийн үйлчлэл зөвхөн Израилаар тогтохгүй. **Тэрээр харийнханд шударга ёсыг тунхаглана.** Израильчууд Мессиагийнхаа эсрэг “ҮГҮЙ” гэж хэлэх нь чангарах тусам шударга ёсыг харийнханд тунхаглах энэ үйлчлэл улам тодорсон.

**[12:19]** Мессиа маргаж хэрэлдэхгүй, хашхирахгүй, гудамжнуудад хэн ч түүний дуу хоолойг сонсохгүй гэдгийг бас Исаиа зөгнөсөн. Өөрөөр хэлбэл, тэрээр улс төрийн зорилготой үймээн самуун дэгдээж, хүн ардыг өдөөн турхирахгүй гэсэн үг юм. Маклайн энэ талаар дараах үгийг хэлсэн:

Бурханы “зарц” болох ХААН тэрээр зүй ёсныхоо өндөр дээд байр суурийг авахдаа махбодын чадал, улс төрийн эрх мэдэл, эсвэл Өөрт байгаа ер бусын хүчийг ашиглахгүй.<sup>22</sup>

**[12:20]** Тэрээр бяцарсан зэгсийг хугалахгүй, бүдгэрсэн дэнг бөхөөхгүй. Тэрээр зорилгодоо хүрэхийн тулд ядуу доройг дарлахгүй. Харин ч эмтэрсэн зүрхтэй, дарлагдсан хүмүүсийг тэнхрүүлж, зоригжуулна. Тэрээр итгэлийн очийг гал болтол нь үлээнэ. Түүний үйлчлэл нь **шударга ёсыг ялалтад хүргэтэл үргэлжилнэ.** Хүмүүсийн үзэн ядалт, талархалгүй сэтгэлээс болоод бусдыг гэсэн дөлгөөн даруу хайр халамжаа Тэр гээхгүй.

**[12:21]** Түүний нэрд харийнхан найдах болно. Исаиад энэ үгийг “эргийн нутгууд түүний хуулийг найдан хүлээнэ” гэж хэлсэн байдаг.

Гэхдээ утга нь үндсэндээ адилхан юм. Эргийн нутгууд гэж харь үндэстнүүдийг хэлдэг. Харь үндэстнүүд түүний үнэнч харьяат болохын тулд засаглалыг нь хүлээж буйгаар Исаиа дүрсэлжээ. Клэйст, Лилли нар Исаиагаас иш татсан энэ үгийг машид үнэлж дараах үгийг хэлсэн:

Матайн сайнмэдээнд буй нэгэн эрдэнэ, Христийн гоо үзэсгэлэнгийн сайхан зураглал...Христ Эцэг Бурхантай нэгдмэл бөгөөд тэрээр үндэстнүүдэд заавар өгч, зовсон хүмүүст дөлгөөн сэтгэлээр хандаж, эцэст нь ялалт байгуулна гэдгийг Исаиа дүрслэн харуулжээ. Түүний нэрээс өөр найдвар энэ ертөнцөд үгүй. Хүн төрөлхтний Аврагч болох Христийг мэргэжлийн хуурай нэр томъёогоор бус, харин дорно дахины баялаг дүрслэлээр илэрхийлжээ.<sup>23</sup>

## **Ё. Уучлагдашгүй нүгэл (12:22-32)**

**[12:22-24] Чөтгөр шүглэж сохор, хэлгүй болсон хүнийг** Эзэн Есүс эдгээсний дараа жирийн ард иргэд түүнийг **Давидын Хүү**, Израилийн Мессиа мөн юм биш үү гэж нухацтай бодож эхэлсэн. Үүнээс болоод **фарисайчууд** маш ихээр хилэгнэцгээсэн. Эзэн Есүсийн хэлж байгааг хүмүүс хүлээн зөвшөөрч буйг тэвчиж чадахгүй болсон учраас Эзэн Есүсийн гайхамшгууд нь **чөтгөрүүдийн захирагч Беелзебүлийн** хүчээр хийгддэг гэсэн буруутгалыг тэд гаргаж ирсэн. Эзэн Есүсийг

чөтгөрийн хүчээр ажилладаг гэж ил тод буруутгасан хамгийн анхны буруутгал энэ юм.

**[12:25, 26]** Эзэн Есүс тэдний бодлыг мэдээд, ярьж хэлж байгаа зүйл нь ямар ч утга авцалдаагүй болохыг тайлбарласан. **Аливаа хаанчлал, хот, айл дотроо хуваагдвал** цаашид оршин тогтнохгүй. Тиймээс Эзэн Есүс Сатаны чөтгөрүүдийг Сатаны хүчээр зайлуулдаг юм бол Сатан **өөрийнхөө эсрэг** ажиллаж буй хэрэг болно. Ийм байх боломжгүй.

**[12:27]** Эзэн Есүс бас нэг ярвигтай асуултыг фарисайчуудад тавьсан. Тухайн үед өөрсдийгөө чөтгөр зайлуулах хүч чадалтай гэж ярьдаг хүмүүс иудейчүүдийн дунд байжээ. Эзэн Есүс тэднийг үнэн ч гээгүй, худлаа ч гээгүй. Харин Эзэн Есүсийг **Беелзевүлээр чөтгөрүүдийг зайлуулдаг** гэвэл фарисайчуудын **хөвгүүд** (тухайлбал өөрсдийгөө чөтгөр зайлуулдаг гэх хүмүүс) ч гэсэн ялгаагүй болно. Фарисайчууд үүнийг яасан ч хүлээн зөвшөөрч чадахгүй. Гэхдээ бас Эзэн Есүсийн сөргүүлж тавьсан үгийн логикийг ч үгүйсгэж чадахгүй. Хэрэв чөтгөр зайлуулдаг гэх иудейчүүдийг Сатаны гар хөл гэж хэлбэл тэр хүмүүс фарисайчуудыг буруутгана. Скофилд энэ талаар дараах үгийг хэлжээ:

Өөрсдийг нь болон өөрсдийнх нь талын хүмүүсийг Сатаны хүчээр чөтгөрүүдийг зайлуулдаг гэж хэлэхийг фарисайчууд хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй. Гэтэл Христ

чөтгөрүүдийг Беелзевүлээр зайлуулдаг гэж хэлбэл үзэл баримтлалтай нь уялдахгүй учраас өөрсдийнх нь хүмүүс тэднийг буруутгана. Яагаад гэвэл Христ Сатаны хүчээр чөтгөр зайлуулдаг гэж хэлэх нь үнэндээ тийм хүч бүхнийг Сатаных гэж байгаагаас ялгаагүй болно.<sup>24</sup>

Фарисайчууд нэг ижил зүйлийг хоёр өөр талаас тайлбарласнаараа логик учирзүйн алдаа гаргасан.

**[12:28]** Мэдээж хэрэг Эзэн Есүс **чөтгөрүүдийг Бурханы Сүнсээр зайлуулсан.** Тэрээр энэ газар дэлхий дээр амьдарч ахуйдаа үргэлж Ариун Сүнсний хүчээр амьдарсан билээ. Тэр бол Исаиагийн урьдаас зөгнөсөн (Исаиа 11:2, 42:1, 61:1-3) Сүнсээр дүүрэн Мессиа юм. Тиймээс тэрээр фарисайчуудад хандан **“Хэрэв би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулдаг бол Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна”** гэж хэлжээ. Энэ үг тэдэнд маш хүчтэй нөлөө үзүүлсэн байх ёстой. Фарисайчууд теологийн мэдлэгээрээ бардан байхад **Бурханы хаанчлал** аль хэдийнээ тэдэн дээр **ирчихээд байлаа.** Яагаад гэвэл Хаан нь тэдний дунд амьдарч байжээ. Харамсалтай тэд Хааныгаа огтхон ч таньсангүй.

**[12:29]** Эзэн Есүс хэзээ ч Сатантай хамтрахгүй. Харин эсрэгээрээ Сатаныг эзлэн түрэмгийлэх болно. Үүнийгээ тэрээр **бяртай эрийн** түүхээр дүрсэлж илэрхийлсэн. **Бяртай эр**

бол Сатан юм. **Түүний гэр** гэдэг нь Сатаны атганад байгаа хүрээ юм. **Эд хөрөнгө** гэдэг нь түүний чөтгөрүүд. Харин **бяргай эрийг хүлж, гэрт** ороод эд **хөрөнгийг нь булааж байгаа** хүн бол Эзэн Есүс. Сатаныг хүлэх үйл явдалд хэд хэдэн үе шат бий. Энэ нь Эзэн Есүсийн газар дэлхий дээрх үйлчлэлээр эхэлсэн. Тэгээд Христийн үхэл ба амиллаар эргэлт буцалтгүй баталгаажсан. Хожим Эзэн Есүсийн мянган жилийн хаанчлалаар тодорхой түвшинд хэрэгжих (Илчлэл 20:2) бөгөөд Сатаныг галт нуурт хаях үед үүрд мөнхийн үнэн болно (Илчлэл 20:10). Одоогоор диавол хараахан хүлэгдээгүй байна. Тэрээр одоо ч гэсэн нэлээд их хүч чадалтай байгаа. Гэхдээ түүний сүйрэл нэгэнт тогтоогдсон бөгөөд түүнд ахархан хугацаа үлджээ.

**[12:30]** Тэгээд Эзэн Есүс **“Надтай хамт байдаггүй хүн миний эсрэг байна. Надтай хамт хураалцдаггүй хүн бол тараагч нэгэн мөн”** гэв. Фарисайчууд Эзэн Есүсийг доромжлох хандлагатай байсан нь Эзэн Есүстэй хамт биш байгааг харуулсан. Тиймээс учраас тэд түүнийг эсэргүүцсэн. Тэд Эзэн Есүстэй хамт хураахгүй байсан нь үр тариаг цацаж тараасантай адил. Чөтгөрүүдийг зайлуулж байгаа Эзэн Есүсийн ажлыг буруутгасан тэд үнэндээ өөрсдөө Сатанд боолчлогдож байсан бөгөөд Бурханы ажилд саад болж байв.

Марк 9:40 дээр Есүс “Хэн биднийг үл эсэргүүцнэ тэр бидний талд байна” гэж хэлсэн.



Энэ үг нь Матай 12:30 дугаар эшлэлтэй зөрчилдөж байгаа мэт харагддаг. Гэхдээ Матай *авралын* талаар ярьж байгааг мэдвэл үүнийг ойлгоход төвөггүй болно. Хүн нэг бол Христийн талд, эс бол Христийн эсрэг байдаг. Дундыг баримтална гэж огт байхгүй. Харин Марк үйлчлэлийн тухай ярьж байна. Есүсийн дагалдагчид хоорондоо олон талаар ялгаатай байдаг. Орон нутгийн чуулганы нөхөрлөлөөрөө, ашиглаж буй арга замаараа, онол сургаалаараа ялгардаг. Энд гарч байгаа зарчмын дагуу тухайн хүн Эзэний эсрэг биш бол Эзэний талд байгаа учир бид хүндэтгэлтэй хандах ёстой.

**[12:31,32]** Христ Израилийн удирдагчдыг маш хатуу үгээр зэмлэснийг энэ эшлэлүүдэд тэмдэглэсэн байна. Израилийн удирдагчид Ариун Сүнсний хүч чадлаар үйлдэгдэж байгаа Эзэн Есүсийн гайхамшгуудыг Сатаны хүч чадлаар үйлдэгдэж байна гэснээрээ Ариун Сүнсийг доромжилж, уучлагдашгүй нүгэл үйлдлээ хэмээн Эзэн Есүс тэднийг буруутгасан. Үүгээрээ тэд Ариун Сүнсийг чөтгөрүүдийн удирдагч Беелзебүл гэж буй хэрэг юм.

Үүнээс бусад **нүгэл ба доромжлол** уучлагдах боломжтой. **Хүний Хүүг доромжилсон** хүн ч гэсэн уучлагдах боломжтой. Харин Ариун Сүнсийг доромжилсон хүнд **энэ үед ч, ирэх** мянган жилийн хаанчлалын **үед ч** уучлагдахгүй. Эзэн Есүсийн хэлсэн **энэ үе** гэдэг нь Эзэн Есүсийн үйлчилсэн хугацаа юм. Өнөөдөр ийм уучлагдашгүй нүгэл байгаа

эсэхийг баттай хэлэх аргагүй юм. Яагаад гэвэл өнөөдөр Эзэн Есүс өөрөө газар дэлхий дээр биеэрээ амьдарч, гайхамшиг үйлддэггүй.

Сайнмэдээг үгүйсгэх нь уучлагдашгүй нүгэл биш. Олон жилийн турш Аврагч Есүсээс татгалзаж байсан хүн гэмшиж, итгэвэл аврагдах болно. Мэдээж хэрэг итгэлгүй байдал дотроо нас барсан хүнд уучлал байхгүй. Итгэгч хүн итгэлээр унах нь уучлагдашгүй нүгэл биш. Итгэгч хүн Эзэнээс холдон тэнүүчилж болох юм. Гэвч тийм хүн ч гэсэн Бурханы гэр бүлд байсан нөхөрлөлөө сэргээх боломжтой.

Уучлагдашгүй нүглийг үйлдсэн байх вий гэж санаа зовдог олон хүн байдаг. Хүн ийм нүглийг өнөөдөр үйлдэх боломжтой байсан ч тийнхүү санаа зовж байгаа нь тухайн хүн уучлагдашгүй нүгэл үйлдээгүй гэдгийн баталгаа юм. Уучлагдашгүй нүглийг үйлдсэн хүний шинж тэмдэг бол Христийг эсэргүүцсэн байдалдаа хэзээ ч гэмшихгүй хатуу сэтгэл юм. Фарисайчууд Ариун Сүнсийг доромжилж байгаагаа ч ухаараагүй, Бурханы Хүүг алахаар хуйвалдаж байхдаа ч шаналаагүй. Тэдэнд харуусал, гэмшил өчүүхэн төдий ч байгаагүй.

### **Ж. Модыг үр жимсээр нь танина (12:33-37)**

[12:33] Эзэн Есүс чөтгөрүүдийг зайлуулж байгаа нь сайныг үйлдэж буй хэрэг гэдгийг фарисайчууд ч хүртэл хүлээн зөвшөөрч байсан. Тэгсэн мөртлөө тэд Эзэн Есүсийг хорон муу гэж буруутгасан. Тийм учраас Эзэн Есүс тэдний

уялдаа холбоогүй буруутгалын эсрэг, “Эргэцүүлэн бод. **Мод нь сайн бол үр жимс нь сайн байна. Мод нь муу бол үр жимс нь муу байна** шүү дээ!” гэж хэлжээ. Үр жимс нь ургаж байгаа модныхоо чанарыг харуулна. Эзэн Есүсийн үйлчлэлийн үр жимс сайн байсан. Тэрээр өвчтэй, сохор, доголон, хэлгүй, дүлийг эдгээж, чөтгөрүүдийг зайлуулж, үхсэнийг амилуулж байсан. Өмхөрсөн муу модноос ийм сайн үр жимс гарч чадна гэж үү? Тэгэх ямар ч боломж байхгүй. Тэгвэл тэд яагаад Эзэн Есүсийг хүлээн зөвшөөрөхгүй ийм их хөшүүн хүзүү гаргана вэ?

**[12:34, 35]** Яагаад гэвэл тэд **хорт могойн удам** байсан. Тэдний хорон муу зүрхнээс<sup>24</sup> урссан хорт үгс нь Хүний Хүүгийн эсрэг ямар их хорсол тээж байсныг нь нотолдог. Зүрхэнд сайн сайхан дүүрэн бол амнаас нигүүлсэл ба зөвт байдлын үгс гардаг. Харин хорон муу зүрхнээс доромжлол, хорсол, хараал гардаг.

**[12:36]** Хүн амнаасаа унагасан **үг бүрийнхээ төлөө тайлагнах болно** гэдгийг Эзэн Есүс тэдэнд (болон бидэнд) анхааруулж байна. Яагаад гэвэл хүмүүсийн үг бол амьдралынх нь үнэн дүр төрх юм. Хүмүүсийг буруутгах, эсвэл зөвтгөхөд хэлсэн үгийг нь үндэслэл болгох зүй ёсны шалтгаан бий. Бурханы ариун Хүүг гутаан доромжилсон үгсийнхээ төлөө фарисайчууд хожим ямар их буруутгагдах бол доо!

**[12:37]** “**Учир нь чи үгсээрээ зөвтгөгдөж, бас үгсээрээ яллагдана.**” Итгэгчдийн хувьд

гэвэл, тэдний бодлогогүй хэлсэн үгсийн шийтгэлийг Христ үхлээрээ дамжуулж эдэлсэн. Бидний хувьд бодлогогүй үг хэлээд гэмшин улайж уучлал аваагүй бол Христийн шүүх суудлын өмнө авах байсан шагналаа алдах болно.

### **3. Эш үзүүлэгч Ионагийн тэмдэг (12:38-42)**

[12:38] Есүс өчнөөн гайхамшиг үйлдээд байхад **хуулийн багш нар ба фарисайчууд** түүнээс тэмдэг шаардаж, Мессиа болохоо батлан харуулаач гэв. Тэр Өөрийгөө Мессиа болохыг батлан харуулж болох ч тэдний хоёр нүүр илэрхий байлаа. Эзэн Есүс хэчнээн олон гайхамшиг үйлдсэн ч итгээгүй хүмүүс дахин нэг гайхамшиг үзлээ гээд итгэнэ гэж үү? Итгэхийн тулд гайхамшиг тэмдэг шаарддаг хандлагыг Бурхан таалдаггүй. Үүний илэрхийлэл болсон үгийг Эзэн Есүс Томаст хэлсэн байдаг: “Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй ээ!” (Иохан 20:29). Бурханы зарчим ёсоор бол харах нь итгэхийн араас дагадаг зүйл юм.

[12:39] Эзэн тэднийг **хорон муу болоод завхай үеийнхэн** гэж дуудсан. Тэд өөрсдийн Мессиад зориудаар харалган хандсан учраас **хорон муу үеийнхэн** юм. Тэд өөрсдийн Бурхандаа сүнсний хувьд үнэнч бус учраас **завхай үеийнхэн** юм. Бүтээгч Бурхан нь хүн ба бурхан чанарыг бүрэн хослуулаад дунд нь зогсоод үгээ айлдаж байхад тэд түүнээс тэмдэг нэхэхээс эмээсэнгүй.

**[12:40]** Тэрээр тэдэнд эш үзүүлэгч **Ионагийн тэмдгээс өөр тэмдэг өгөхгүй** гэдгээ товч бөгөөд тодорхой хэлэв. Эш үзүүлэгч Ионагийн тэмдэг гэдгээр тэр өөрийн үхэл, оршуулга, амиллын тухай ярьсан. Аварга загас Ионаг залгиад, буцааж бөөлжин гаргасан үйл явдал нь (Иона 1:17; 2:10) Эзэн Есүсийн загалмайн үхэл ба амиллын бэлгэдэл болсон. Үхэгсдийн дундаас амилах нь Израиль үндэстэнд зориулсан үйлчлэлийнх нь эцсийн бөгөөд оргил тэмдэг нь болох ажээ.

**Иона аварга загасны гэдсэнд гурван өдөр, гурван шөнө байсан.** Үүн шиг бидний Эзэн ч бас газрын зүрхэнд гурван өдөр, гурван шөнө байна гэдгээ урьдчилан хэлжээ. Эндээс нэг асуудал гарч ирдэг. Хэрэв Эзэн Есүс баасан гарагийн үдээс хойш оршуулагдаж, Ням гарагийн өглөө үхлээс амилсан юм бол тэр яаж гурван өдөр, гурван шөнө булшинд байсан байж таарах вэ? Хариулт нь иудейчүүдийн уламжлалд аливаа өдрийн хэсгийг бүтэн нэг өдрөөр тооцдог байжээ. “Өдөр шөнө нь хамтдаа нэг өдрийг бүрдүүлдэг. Гэхдээ өдрийн аль ч хэсэг нэг өдөрт тооцогдох ёстой” (Иудей үг).

**[12:41]** Иудейчүүдийн удирдагчдын гэм бурууг Есүс хоёр жишээтэй харьцуулан буруутгасан. Эхнийх нь **Ниневе** хотын харь үндэстнүүд. Иудейчүүд тэднийг бодвол хамаагүй их давуу талыг хүртсэн. Ниневечүүдэд оногдсон хувь завшаан нь иудейчүүдийнхээс тун бага. Гэтэл тэд эш үзүүлэгч **Ионагийн**

**тунхаглалыг** сонсмогцоо асар ихээр гашуудаж, гэмт амьдралдаа **гэмшжээ**. Тиймээс тэд **шүүлт дээр босож, Ионагаас агуу** нэгэн болох Бурханы Хүүг хүлээн аваагүй үеийнхнийг яллах болно.

[12:42] Хоёр дахь нь Шебагийн **хатан хаан**. Тэрээр иудейчүүдэд олгогдсон давуу эрхийг хүртээгүй боловч Соломон хаантай уулзахын тулд асар их зардал, хичээл зүтгэл гарган байж **өмнө** зүгээс иржээ. Есүсийн үеийн иудейчүүд Түүнийг харахын тулд тэгж аялах хэрэг байгаагүй. Яагаад гэвэл Эзэн Есүс тэдний Мессиа-Хаан нь болохоор тэнгэрээс бууж, жижигхэн хот сууринуудад нь Өөрөө аялан иржээ. Даанч иудейчүүд **Соломоноос агуу нэгнийг** амьдралдаа оруулах зайгүй байжээ. Ийм харалган байдлынх нь төлөө хожим шүүлтийн өдөр тэрхүү харийн хатан хаан тэднийг яллах болно.

Энэ бүлэгт Эзэнийг маань сүмээс агуу нэгэн (6 дугаар эшлэл), Ионагаас агуу нэгэн (41 дүгээр эшлэл), Соломоноос агуу нэгэн (42 дугаар эшлэл) гэж дүрсэлжээ. Бидний Эзэн бол “хамгийн агуугаас илүү агуу, хамгийн сайнаас ч илүү сайн” нэгэн мөн.

## **И. Бузар сүнс эргэн ирдэг (12:43-45)**

[12:43, 44] Эзэн Есүс үл итгэгч Израилийн өнгөрсөн, одоо, ирээдүйг зүйрлэлийн аргаар тоймлон ярьж байна. **Хүн** гэдэг нь Израиль үндэстнийг, **бузар сүнс** гэдэг нь шүтээн шүтэх явдлыг хэлсэн. Израильчууд Египетэд

боолчлогдож байх үеэсээ аваад Вавилоны цөллөг хүртэл үргэлжид шүтээн шүтэх зуршилтай байсан. Харин Вавилоны цөллөг нь Израиль үндэстний шүтээн шүтэх эмгэгийг түр хугацаанд эмчилсэн. **Бузар сүнс хүнээс гарсан** гэдэг нь үүний зүйрлэл юм. Цөллөгийн үеэс өнөөг хүртэл иудей хүмүүс шүтээн шүтэх явдлаас ангид байсан. Тэд яг л **хоосон, шүүрдсэн, цэгцтэй болсон** байшин шиг байна.

Аврагч Эзэн маань өнгөрсөн хоёр мянган жилийн туршид тэрхүү хоосон байшин уруу нэвтрэхийг эрмэлзсээр иржээ. Тэр бол гэрийн Эзэн бөгөөд гэрт орох эрх бүхий Хүн мөн. Гэвч израиль түмэн түүнийг дотогш оруулахыг хатуу эсэргүүцсээр иржээ. Тэд хэдийгээр хуурамч шүтээнд мөргөхөө больсон боловч үнэн Бурханд ч бас мөргөхөө больжээ.

**Хоосон** байшин гэдэг нь сүнслэг хоосролыг хэлсэн. Хоосон гэрт юу ч орох эрсдэлтэй тул Израиль үндэстэн одоо маш аюултай нөхцөлд байна. Шинэчлэл хийлээ гээд хангалттай биш. Тэд Аврагч Эзэнийг дотогш оруулах хэрэгтэй.

**[12:45]** Хожмын нэг өдөр шүтээний өнөөх сүнс буцаад байшин уруу орохоор шийдэх болно. Ингэхдээ **өөрөөсөө дор өөр долоон сүнсний хамт** ирнэ. Библид долоогийн тоо нь төгс байдал, бүрэн дүүрнийг илтгэдэг учраас долоон сүнс гэдэг нь дээд зэргийн боловсронгуй хэлбэрийн шүтлэгийг илэрхийлсэн болов уу. Итгэлээ гээсэн Израиль үндэстэн Антихристэд мөргөх их зовлонгийн үеийн тухай энд өгүүлж байна. Ёс

бусын хүний өмнө бөхийж, түүнийг Бурхан адил шүтэх нь Израиль үндэстнийг урьд урьдынхаас илүү гэм нүгэлтэй болгоно. Тиймээс **өнөөх хүний хувьд сүүлчийнх нь байдал анхныхаасаа бүр дорддог.** Үл итгэсэн Израиль үндэстэн их зовлонгийн аймшигт шүүлтийг амсаж, Вавилоны цөллөгийн үеийнхээс ч хүнд үеийг туулна. Харин израильчуудын хуурамч шүтээнийг Христийн хоёр дахь ирэлт бүрэн устгана.

**“Энэ муу үеийнхэн ч мөн тийм байх болно.”**

Бурханы Хүүг анх ирэхэд нь гутаан доромжилж, хүлээн авахаас татгалзсан ард түмэн Христийн хоёр дахь ирэлтээр аймшигт шийтгэл амсах болно.

### **К. Есүсийн ээж ба дүү нар (12:46-50)**

Эдгээр эшлэлийг цухасхан харвал ээж дүү нар нь Есүстэй уулзах гэж ирсэн жирийн мэт нэгэн үйл явдал гарна. Тэд яагаад ирсэн юм бол? Маркийн сайнмэдээнд үүний шалтгааныг бичсэн байна. Есүсийн зарим нөхөд нь Түүнийг ухаан мэдрэлээ алдсан гэж бодох болжээ (Марк 3:21, 31-35). Тиймээс гэр бүлийнх нь Түүнийг чимээгүйхэн авч явахыг бодсон бололтой (Иохан 7:5-ыг бас үз). **Ээж дүү нар нь гадаа ирчхээд Түүнтэй ярилцахаар хүлээн зогсож байгааг хэлэхэд Эзэн Есүс “Хэн миний эх, хэн миний дүү нар юм бэ?”** гэж асуув. Тэгээд **шавь нар уруугаа заагаад “Тэнгэр дэх Эцэгийн минь**



**хүслийг биелүүлэгч хэн боловч миний эх, ах эгч дүүс мөн” гэж айлдав.**

Энэхүү мэдэгдэл нь сүнслэг ач холбогдлоор дүүрэн. Эзэн Есүсийн Израильд хандах хандлага одоо өөр зүгт эргэж буйг энэ үг харуулдаг. Мариа болон түүний хүүхдүүд Эзэн Есүсийн цусан төрөл болохын хувьд Израиль үндэстнийг төлөөлдөг. Энэ үеийг хүртэл тэрээр зөвхөн Израилийн гэрийн алдагдсан хонинуудад үйлчлэлээ хийж байсан. Гэвч өөрийнх нь цусан төрлийн хүмүүс түүнийг хүлээн авахгүй нь тодорхой болжээ. Мессиагийнхаа өмнө сөгдөх нь битгий хэл, фарисайчууд түүнийг Сатанаар удирдуулдаг гэж буруутгаж байв.

Тиймээс Эзэн Есүс энд шинэ зүй зарчмыг мэдэгдэж байна. Үүнээс хойш Эзэн Есүсийн гар сунгах хүмүүс нь зөвхөн Израилиар хязгаарлагдахгүй. Махбодын дагуу ах дүүс болсон Израиль үндэстнийг гэсэн сэтгэлээ Эзэн Есүс хадгалсаар байх боловч Түүний Израильтай харилцах харилцаанд нь ан цав гарсан болохыг 12 дугаар бүлэг илтгэдэг. Тэгэхээр одоо цаашид яах вэ гэдэг нь тодорхой. Израиль үндэстэн түүнийг хүлээн авахыг хүсэхгүй байгаа юм бол Өөрийг нь хүлээн авахыг хүссэн хүмүүс уруу Тэр эргэх болно. Эзэн Есүс цусан төрлийн холбооноос илүү сүнслэг холбоог чухалд тавихаар болжээ. Хүмүүс Бурханд л дуулгавартай байвал иудей ба харь үндэстэн байх нь хамаагүй Эзэн Есүстэй харилцаа холбоотой болох боломжтой болж байна.

Энэ хэсгийг орхиж цааш явахын өмнө бид Есүсийн эх Мариагийн тухай хоёр зүйлийг зайлшгүй дурдах хэрэгтэй. Нэгт, Эзэн Есүсийн өмнө Есүсийн эх давуу эрх эдэлж байгаагүй нь тодорхой байна.

Хоёрт, Мариа насан туршдаа онгон явсан гэдэг сургаал үндсээрээ буруу юм. Учир нь Эзэн Есүс дүү нартай байсан тухай энд дурджээ. Тэд Мариагийн жинхэнэ хүүхдүүд байсан. Энэ үзлийг бататгах эшлэлүүд гэвэл: Дуулал 69:8; Матай 13:55; Марк 3:31, 32; 6:3; Иохан 7:3, 5; Үйлс 1:14; 1Коринт 9:5; Галат 1:19.

## **VIII. ИЗРАИЛЬ ТАТГАЛЗСАН ТУЛ ХААН НЬ ТҮР ХУГАЦААНД ШИНЭ ХААНЧЛАЛ БАЙГУУЛАХАА МЭДЭГДСЭН НЬ (13-р бүлэг)**

### **Хаанчлалын тухай сургаалт зүйрлэлүүд**

Бид Матайн бичсэн сайнмэдээний маш чухал хэсэг дээр ирээд байна. Махбодын холбооноос илүү сүнсний холбоог чухалчлах болно гэдгээ Эзэн Есүс энд харуулжээ. Асуудлын гол нь төрөхдөө иудей байсан эсэхэд биш, харин Бурхан Эцэгт дуулгавартай эсэхэд оршино. Хуулийн багш нар ба фарисайчууд Хааныгаа хүлээн авахаас татгалзсан нь үнэндээ хаанчлалыг ч бас хүлээн авахаас татгалзсан хэрэг юм. Тиймээс өөрөөс нь татгалзсан энэ үе болоод хаадын Хаан, эздийн Эзэн болж ирэх эцсийн ирэлтийнх нь хооронд хаанчлал нь шинэ хэлбэрээр орших тухай Эзэн Есүс сургаалт

зүйрлэлүүдээр тайлбарлаж байна. Эдгээр сургаалт зүйрлэлийн зургаа нь “тэнгэрийн хаанчлал нь юутай адил вэ гэвэл...” гэж эхэлдэг.

Эдгээр сургаалт зүйрлэлийг зөвөөр ойлгохын тулд “тэнгэрийн хаанчлал” (3 дугаар бүлгийн тайлбар дотор бий) гэсэн хэсгийг эргэн харах хэрэгтэй. Тэнгэрийн хаанчлал бол Бурханы захиргаа хэрэгжиж буй газар юм. Тэнгэрийн хаанчлал харагдах хоёр өнцөгтэй. (1) Гадна тал. Гадна талаас нь харвал, Бурханыг хамгийн дээд эрх мэдэл хэмээн амаараа хүлээн зөвшөөрсөн бүх хүн тэнгэрийн хаанчлалд байдаг. (2) Дотор тал. Дотор талаас нь харвал, зөвхөн дахин төрсөн хүмүүс л тэнгэрийн хаанчлалд багтдаг. Хаанчлал нь таван үе шаттай: (1) Урьдчилан зөгнөгдсөн Хуучин гэрээний үе; (2) Хаан нь газар дэлхий дээр ирсэн үе. Энэ үед “тэнгэрийн хаанчлал ойрхон байна”, “тэнгэрийн хаанчлал ирчихсэн байна” гэж тунхаглаж байсан; (3) Түр хугацааны үе. Израильчууд Хаанаасаа татгалзаж, Хаан нь тэнгэр уруу буцсаны дараах үе. Энэ үед түүний албат харьяат болохыг хүлээн зөвшөөрсөн хүмүүсээс хаанчлал бүрдэнэ; (4) Мянган жилийн хаанчлалын үе; (5) Хамгийн сүүлчийн мөнх хаанчлал. Библид хаанчлалын тухай өгүүлж буй хэсгүүд эдгээр үеүдийн аль нэгтэй тохирч байдаг. Харин одоо үзэх 13 дүгээр бүлэгт түр хугацааны гурав дахь үеийг өгүүлж байна. Энэ үе маань Пентэктоос шүүрэлт хүртэл үргэлжилнэ. Энэ үед хаанчлалыг чуулганы жинхэнэ итгэгчид бүрдүүлэх бөгөөд хаанчлал гадна талаасаа

харагдахгүй. Зөвхөн энд л хаанчлал ба чуулган хоёр адил шинж чанартай байдаг. Харин үнэндээ хаанчлал ба чуулган бол хоёр ондоо зүйлс юм. Хаанчлалын талаарх эдгээр ойлголтод тулгуурлан Эзэн Есүсийн ярьсан сургаалт зүйрлэлүүдийг харцгаая.

### **А. Тариачны тухай сургаалт зүйрлэл (13:1-9)**

**[13:1]** Эзэн Есүс чөтгөр шүглэсэн хүнийг эдгээсэн гэрээс гарч, Галил нуурын эрэг дээр сууж байлаа. Библийн олон эрдэмтэн гэрийг Израиль, далайг харь үндэстнүүд гэж үздэг. Тиймээс гэрээс гарч нуур уруу очсон Эзэн Есүсийн энэ үйлдэл Израилиас хөндийрснийг нь бэлгэддэг. Түр хугацаанд хаанчлалыг харь үндэстнүүдэд тунхаглана.

**[13:2]** Асар олон хүн эрэг дээр хуран цугласан тул тэрээр завин дээр гарч суугаад сургаалт зүйрлэлээр ярьж эхлэв. Сургаалт зүйрлэл бол сүнсний болон ёс суртахууны үнэнийг өгүүлсэн жижиг хэмжээний өгүүлэмж юм. Гэхдээ утга нь шууд ойлгогддоггүй. Эзэн Есүсийн нэг ба хоёр дахь ирэлтийн дунд хаанчлал нь ямар байх вэ гэдгийг 13 дугаар бүлэгт доорх долоон сургаалт зүйрлэлээр өгүүлдэг.

Эхний дөрвийг нь тэнд байсан олон түмэнд хандаж хэлсэн. Харин сүүлийн гурвыг нь дагалдагч нартаа зориулжээ. Эзэн Есүс эхний хоёроос гадна долоо дахь сургаалт зүйрлэлийг дагалдагч нартаа тайлбарлаж өгсөн. Тэгээд

тэрхүү тайллуудаар үлдсэн сургаалт зүйрлэлүүдийг нь бусдад тайлбарлахыг дагалдагчдадаа (арван хоёр шавьдаа болон бидэнд) даатган үлдээжээ.

**[13:3]** Дөрвөн төрлийн хөрсөнд үр тарьсан тариачны талаар нэг дэх сургаалт зүйрлэлд өгүүлнэ. Гэхдээ хөрс бүрээс өөр өөр үр дүн гарсан.

**[13:4-8]**

*Хөрс*

*Үр дүн*

- |   |  |
|---|--|
| 1. Хатуу хучилттай зам.                   | 1. Шувууд үрийг идсэн.   |
| 2. Чулуулаг давхарга дээр буй нимгэн хөрс | 2. Үр нь хурдан соёоловч гүн үндэслээгүй. Тиймээс нар гарахад хорчийн хатсан.  |
| 3. Хогийн ургамалд баригдсан хөрс         | 3. Үр нь соёолох боловч хогийн ургамлуудаас болоод ургаж чадаагүй.   |
| 4. Сайн хөрс                              | 4. Үр нь соёолж, ургана. Тэгээд ургацаа өгөхөд зарим нь зуу дахин, зарим нь жар дахин, зарим нь гуч дахин их болсон. |

**[13:9]** Эзэн Есүс сургаалт зүйрлэлээ **“Сонсох чихтэй нь сонсогтун!”** гэсэн битүү анхааруулгаар дуусгасан. Эзэн Есүс сургаалт зүйрлэлээрээ тэнд байсан олон түмэнд хандан маш чухал санааг хэлсэн ч дагалдагчдадаа харин өөр санааг илэрхийлжээ. Гэхдээ хэн хэн нь марталгүй тусгаж авах ёстой чухал асуудлыг энд хөндсөн.

Эзэн Есүс энэхүү сургаалт зүйрлэлээ 18-23 дугаар эшлэлд өөрөө тайлбарласан учраас тэрхүү хэсэг хүртэл тариачны тухай сургаалт зүйрлэлийг авч үзэхээ түр азная.

## **Б. Сургаалт зүйрлэлүүдийн зорилго (13:10-17)**

**[13:10]** **Шавь нар нь** Эзэн Есүсийг яагаад битүү утгатай **сургаалт зүйрлэлүүдээр** хүмүүст **ярьдгийг** гайхацгааж байв. Тиймээс тэд учрыг нь лавласан.

**[13:11]** Эзэн Есүс хариултдаа үл итгэгч олон түмэн ба итгэгч шавь нарынхаа хооронд буй ялгааг хэлж өгсөн. Израиль үндэстний ерөнхий төлөөлөл болсон тэдгээр цугласан олон Эзэн Есүсээс татгалзаж, Түүнийг үгүйсгэж байгаа нь тодорхой байв. Гэхдээ тэдний татгалзсан нь загалмай дээр бүрэн утгаараа ил болно. Тиймээс **тэнгэрийн хаанчлалын нууцуудыг** мэдэх нь тэдэнд **өгөгдөөгүй**. Харин Христийн жинхэнэ дагалдагчид энэ нууцуудыг ойлгоход сургаалт зүйрлэл тус болдог.

Шинэ гэрээн дэх нууц бол түүнээс өмнөх үеийнхэнд мэдэгдээгүй далд байсан хэрэг явдал

юм. Түүнийг Бурханы илчлэлтгүйгээр мэдэх боломжгүй байсан ч эдүгээ тэр нь илчлэгджээ. **Хаанчлалын нууцууд** гэдэг нь хаанчлалын түр хугацааны хэлбэрийн тухай мэдлэг юм. Бурханы хаанчлалд түр хугацааны хэлбэр байх болно гэсэн мэдлэг ч өдийг хүртэл мэдэгдээгүй явж ирсэн. Хааныг эзгүй хойгуур хаанчлал ямар шинж чанартай байх талаар зарим ойлголтыг эдгээр сургаалт зүйрлэлд тайлбарладаг. Тийм учраас зарим хүн үүнийг “хаанчлалын нууц хэлбэр” гэж нэрлэдэг. Гэхдээ түүнд нь ямар нэг нууц зүйлс агуулагдаж байгаа учраас бус, харин урьд өмнө нь нууц буюу далд байсан гэдэг утгаар нь ингэж нэрлэдэг.

[13:12] Арван нэгдүгээр эшлэлийг уншвал энэ нууцууд нь олон түмнээс нууцлагдаад шавь нарт илчлэгдсэн мэт ойлгогдож болох юм. Гэхдээ Эзэн Есүс үүнийг дараах байдлаар тайлбарласан: **“Учир нь хэнд байна, түүнд ихээр өгөгдөж, элбэг дэлбэг байх болно. Харин хэнд байхгүй байна, байгаа нь хүртэл түүнээс авагдана.”** Шавь нар Эзэн Есүст итгэж байсан учраас илүү ихийг хүлээн авах чадамжтай болно. Тэд гэрлийг хүлээн авсан учраас илүү их гэрлийг үзнэ. Гэтэл иудейчүүд ертөнцийн гэрлийг хүлээн авахаас татгалзсан тул нэмж гэрэл хүлээн авах боломжгүй болоод зогсохгүй өөрсдөд нь байсан багахан гэрлээ ч хүртэл алджээ. Тэд гэрлийг үгүйсгэснээрээ тэр гэрлийг хүлээн авахаас татгалзсан билээ.

**[13:13]** Матью Хэнри сургаалт зүйрлэлүүдийг үүл ба галан баганатай адилтгасан. Үүл ба галан багана израильчуудад гэрэл тусгасан ч египетчүүдийг самгардуулсан. Үүн шиг, үнэн сэтгэлээс итгэж байгаа хүмүүст сургаалт зүйрлэлийн утга илчлэгдэх боловч Эзэн Есүст хорсдог хүмүүст бол зөвхөн цухалдах шалтгаан болохоос хэтрэхгүй.

Тэгэхээр тэр хүмүүсийг Эзэн харалган болгоод байгаа бус, харин үнэнээс зориуд татгалзсан хүмүүст харалган байдал угаас шүүлт болж ирдэг гэх бүгдэд хүчинтэй зарчим хэрэгжиж байгаагаас ийм зүйл болдог байна. Тийм учраас л Эзэн Есүс иудейчүүдэд сургаалт зүйрлэлээр ярьжээ. Х.Ч.Вүүдрин: “Тэд үнэнийг хайрлаагүй учраас үнэний гэрэл ч тэдэн дээр тусаагүй.”<sup>26</sup> Тэд Бурханы үнэнийг таньж мэддэг, ойлгодог гэж хэлж байсан ч тэрхүү Үнэн нь махбодыг өмсөөд өмнө нь зогсож байхад Үнэн уруу харахаас татгалзсан. Тэд Бурханы үгийг сонсдог гэж хэлж байсан ч Бурханы амьд Үг дунд нь зогсож байхад Түүнийг дагахыг хүсээгүй. Бурхан махбодоор буун ирсэн гайхамшигт үнэнийг тэд ойлгох хүсэлгүй байсан учраас ойлгох чадвараа ч бас алджээ.

**[13:14, 15]** Тиймээс тэд Исаиа 6:9,10 дугаар эшлэлд хэлсэн эш үзүүллэгийн амьд биелэл болов. Израилийн зүрх **хатуурч, чих** нь Бурханы дуу хоолойд мэдрэмжгүй болсон байв. Тэд **нүдээрээ харахаас** зориуд татгалзжээ. Хэрэв харж, сонсож, ойлгож, гэмшвэл Бурхан эдгэрлээ



өгөхийг тэд мэдэж байсан. Гэсэн ч өвчтэй дорой мөртлөө тэд Бурханы тусламжаас татгалзжээ. Тиймээс **сонссон ч үл ойлгож, харсан ч үл ухаарах** нь тэдэнд оногдсон шийтгэл болов.

[13:16, 17] Харин Эзэн Есүсийн дагалдагчид дэндүү их хувь завшааныг хүртсэн хүмүүс болжээ. Яагаад гэвэл өмнө нь хэний ч хараагүй зүйлийг тэд харсан юм. Хуучин гэрээний үеийн эш үзүүлэгчид хийгээд зөвт хүмүүс Мессиаг ирэхэд амьд байхыг туйлаас хүсэж байсан ч тэдний энэ хүсэл биелээгүй. Харин Эзэн Есүсийн дагалдагчид түүхийн тэр торгон агшинд амьдарч, Мессиаг нүдээрээ үзэж, хийсэн гайхамшгуудынх нь гэрч болж, амнаас нь гарсан зүйрлэшгүй агуу сургаалыг сонсжээ.

## **В. Тариачны тухай сургаалт зүйрлэлийн тайлбар (13:18-23)**

[13:18] Эзэн Есүс яагаад сургаалт зүйрлэл ашигладгаа тайлбарласныхаа араас дөрвөн өөр хөрсний тухай сургаалт зүйрлэлийнхээ утгыг хэлж өгсөн. **Тариачин** нь хэн гэдгийг тэр хэлж өгөөгүй. Гэхдээ тариачныг Эзэн Есүс (37 дугаар эшлэл) болон хаанчлалын мэдээг тунхаглаж байгаа хүмүүс гэж үзэж болно. Харин үр бол хаанчлалын тухай үгийг (19 дүгээр эшлэл), хөрс бол уг мэдээг сонсож байгаа хүмүүсийг төлөөлж байна.

[13:19] Хатуу хучилттай зам гэж үгийг хүлээн авахаас татгалзсан хүмүүсийг хэлж байна. Тэд сайнмэдээг сонсовч ойлгодоггүй. Тэд

ойлгож чадахгүй учраас бус, хүсэхгүй учраас сайнмэдээг **ойлгодоггүй**. Шувуудаар Сатаныг илэрхийлсэн. Сатан сонсогчийн зүрхнээс үрийг булаан авдаг. Сайнмэдээг хүлээн авахаас татгалзсан тэр сэтгэлийг нь Сатан далимдуулдаг. Фарисайчууд бол зам мэт хатуу хөрстэй сонсогчид байжээ.

[13:20, 21] Эзэн Есүс чулуурхаг хөрс гэж хэлэхдээ чулуун давхаргыг хучсан нимгэн хөрсийг бодож байсан бололтой. **Үгийг сонсоод баяртайгаар хүлээн авдаг** хүмүүсийг үүгээр илэрхийлсэн. Тариачин эхэндээ энэ үр дүнг хараад номлол нь ихэд үр дүнгээ өгчээ хэмээн эндүүрч болох юм. Гэвч инээмсэглэл ба алга ташилтаар үгийг хүлээн авах нь тийм ч сайн зүйл биш юм байна гэсэн томхон сургамжийг тун удахгүй тэр мэдэх болно. Юуны түрүүнд хүн гэм нүгэлтэйгээ ойлгож, түүндээ халаглан харамсаж, түүнээсээ гэмшин гэдрэг эргэх ёстой. Гүехэн бодлоор баяр хөөртэй яваа хүнээс Голгота уруу гашуудан яваа хүнд бид илүү найдаж болно. Гүехэн хөрстэй зүрхэнд гүн үндэс байхгүй учраас түүнээс бат шийдвэр гарахгүй. **Хавчлага зовлонгийн** халуун нар төөнөхөд л түүний шийдвэр ганхаж, Христэд захирагдах гэдгийг тийм үнэ цэнтэй зүйл биш хэмээн үзэж, шийдвэрээсээ эргэж няцна.

[13:22] Хогийн ургамалд баригдсан хөрс нь үгийг өнгөцхөн сонсдог өөр төрлийн хэсэг хүмүүсийг илэрхийлж байна. Тэднийг гадна талаас нь харахад хаанчлалын жинхэнэ харьяат

мэт байдаг. Гэвч сэтгэл нь **дэлхийн зовнил**, эд **баялагт** татагдан сонирхол нь байхгүй болдог. Тэгээд амьдралаас нь Бурханы төлөөх үр жимс ургаж гардаггүй. Ланг үүнийг тайлбарлахдаа том бизнестэй, мөнгөнд дуртай хүний хүүг жишээ болгосон байдаг. Тэр хүн бага залуудаа Бурханы Үгийг сонссон ч эцэстээ бизнестээ гол анхаарлаа хандуулжээ.

Тэрээр Эзэний хүслийг сонгох уу, эцгийнхээ зааснаар явах уу гэдэг сонголтын өмнө ирсэн байна. Үр суулгагдаж, соёолох үед хөрсөнд нь хогийн ургамал байсан аж. Тэрээр энэ ертөнцийн зовнил болоод эд баялгийн хуурамч байдалд нэгэнт олзлуулсан байжээ. Тиймээс тэр эцгийнхээ хүссэнээр явж, бизнестээ хамаг анхаарлаа тавин, түүнийг амьдралынхаа тэргүүн зорилго болгов. Ийнхүү тэнгэрлэг зүйлсийг үл ойшоов. Тийн явсаар эцэст нь тэтгэвэрт гарах цаг нь иржээ. Тэрээр тэтгэвэртээ гараад сүнслэг зүйлсэд илүү их анхаарах болно гэж байв. Гэвч Бурхан тэнэг биш билээ. Тэрээр тэтгэвэрт гарсныхаа дараа удаа ч үгүй гэнэт нас барав. Тэрээр 90,000 фунт стерлингээ орхин оджээ. Эцэст нь харахад тэр хүн амьдралаа сүнсний хувьд үрэн таран хийсэн байв. Түүний зүрхэнд байсан хогийн ургамал үгийг шахан зайлуулж, ямар ч үр жимс ургуулсангүй.<sup>27</sup>

**[13:23] Сайн хөрс** нь жинхэнэ итгэгчдийг илэрхийлж байна. Тэд **үгийг** хүлээн авч **сонсдог**

бөгөөд сонссондоо дуулгавартай байсны үр дүнд **ойлгодог**. Энэ хүмүүс бүгд ижилхэн хэмжээтэй үр жимс гаргахгүй ч гэсэн Бурханы амийг харуулах үр жимсийг ямар ч байсан ургуулах болно. Энд хэлсэн **үр жимс** гэдэг нь Христ уруу авчирсан хүмүүсийг биш, харин амьдралаас харагдах Христийн зан чанарыг хэлж байна. Шинэ гэрээнд үр жимс гэдэг үг нь ерөнхийдөө Сүнсний үр жимс (Галат 5:22, 23) гэсэн утгаар хэрэглэгддэг.

Тэгвэл энэ сургаалт зүйрлэл тэнд байсан олон түмэнд юуг ойлгуулсан бэ? Юуны түрүүнд, дагахгүйгээр сонсох нь хэчнээн аюултай болохыг анхааруулсан. Бас Үгийг анхааралтай сонсож, хүлээн авахыг уриалсан. Үнэхээр хүлээн авсан бол Бурханы төлөөх үр жимс заавал гарна гэдгийг хэлсэн. Харин Есүсийн шавь нар болоод хожим гарч ирэх дагалдагчдын хувьд гэвэл, сургаалыг нь сонсогчдоос цөөхөн хүн л аврагдах болно гэх гашуун үнэнд зүрх сэтгэлийг нь бэлтгэн өгч байна. Түүнчлэн Христийн үнэнч дагалдагч хүнийг сайнмэдээг тараавал бүх дэлхий аврагдана гэсэн төөрөгдлөөс хамгаална. Мөн сайнмэдээний гурван том дайсныг анхааруулсан байна: (1) диавол (шувууд, муу нэгэн); (2) махбод (нар, хавчлага зовлон); (3) энэ ертөнц (хогийн ургамал, энэ ертөнцийн зовнил ба эд баялгийн хуурамч байдал).

Эцэст нь, хувь хүний төлөвшилд хөрөнгө оруулалт хийвэл эргэж ирэх ашиг нь маш их гэдгийг Эзэн Есүс шавь нартаа сануулж өгчээ.

Гуч дахин гэдэг нь 3,000 хувь, жар дахин гэдэг нь 6,000 хувь, зуу дахин гэдэг нь 10,000 хувь юм. Тэгэхээр энэхүү хөрөнгө оруулалтаас ийм их ашиг эргэж ирнэ гэсэн үг. Үнэн сэтгэлээсээ итгэж дахин төрсөн ганцхан хүн л байхад үр дүн нь ямар их болохыг тооцохын арга үгүй. Хүүхдийн цуглааны жирийн нэгэн багш Двайт Л. Мүүдийгийн итгэлд хөрөнгө оруулалт хийсэн байдаг. Харин Мүүдий олон хүнийг Христ уруу авчирсан. Тэд ч бас бусдыг Христ уруу авчирсан. Энэ цуваа үргэлжилсээр байна. Хүүхдийн цуглааны тэр нэгэн багшийн эхлүүлсэн ажил ийнхүү үргэлжилсээр байна.

### **Г. Буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэл (13:24-30)**

Тэнгэрийн хаанчлалд хоёр төрлийн хүн байдаг гэдгийг өмнөх сургаалт зүйрлэлд дүрсэлсэн. Нэг дэх нь Хаанд зөвхөн амаараа үйлчилдэг хүмүүс. Хоёр дахь нь бол жинхэнэ дагалдагчид. Эхний гурван хөрсөөр тэнгэрийн хаанчлалын гадна талаас харагдах хэлбэрийг илэрхийлсэн. Энэ нь арай өргөн хүрээг хамарна. Харин дөрөв дэх хөрс бол жинхэнээсээ дахин төрсөн хүмүүсийг хэлсэн. Энэ нь гадна талаас харагдах хэлбэрээсээ бага хүрээг хамарна.

[13:24-26] Буудай ба зэрлэг өвсний тухай хоёр дахь сургаалт зүйрлэл ч бас тэнгэрийн хаанчлалыг энэ хоёр өнцгөөс дүрсэлж байна. Буудай нь жинхэнэ итгэгчдийг, зэрлэг өвс нь хоосон хүлээн зөвшөөрөгчдийг илэрхийлдэг.

Эзэн Есүс хаанчлалыг талбайдаа сайн үр тарьсан хүнтэй адилтгасан. Хүмүүсийг унтаж байхад түүний дайсан ирж, буудайн дунд зэрлэг өвс тарьчхаад яваад өгчээ. “Палестины тариан талбайд хамгийн түгээмэл таардаг зэрлэг өвс (bearded darnel) нь маш хортой бөгөөд дөнгөж цухуйж байхдаа буудайнаас бараг ялгардаггүй. Харин боловсорч гүйцэх үед нь тэднийг хялбархан ялгах боломжтой байдаг.”<sup>28</sup>

**[13:27, 28]** Буудайн дунд зэрлэг өвс ургаж буйг үзсэн зарц нар яагаад ийм болсныг гэрийн эзнээс асуув. Гэрийн эзэн үүнийг дайсны ажил гэдгийг даруй ойлгов. Тэгэхэд нь зарц нар зэрлэг өвсийг зулгаах гэв.

**[13:29, 30]** Тэгэхэд нь эзэн ургац хураатал хүлээе гэж зарц нартаа хэлжээ. Цаг нь ирэхэд ургац хураагчид буудай ба зэрлэг өвсийг тус тусад нь хураагаад буудайг амбаарт хийж, зэрлэг өвсийг шатаах болно.

Тариачин буудай ба зэрлэг өвсийг тусгаарлах ажлыг яагаад ингэж хойшлуулсан юм бол? Байгаль дээр буудай ба зэрлэг өвсний үндсийг ялгах амаргүй байдаг тул дөнгөж ургаж байгаа зэрлэг өвсийг зулгаах гэвэл андуурч буудайг нь зулгаах аюултай байдаг.

Эзэн Есүс энэ сургаалт зүйрлэлийг 37-43 дугаар эшлэлд тайлбарласан учраас тэнд хүртэл энэ сургаалт зүйрлэлийг тайлбарлахаа түр зогсооё.

#### **Д. Гичний үрийн тухай сургаалт зүйрлэл (13:31, 32)**

Дараа нь Аврагч Эзэн маань **хаанчлалыг гичний үртэй** адилтгасан. Эзэн Есүс гичний үрийг хамгийн **жижиг** үр гэсэн нь түүнийг сонсож байсан хүмүүсийн мэдэх үрүүдийн дотор хамгийн жижиг нь гэдэг утгаар хэлсэн бололтой. Гичний үр хэдий жижиг ч **мод** болтлоо ургадаг нь гайхалтай. Гэхдээ ердийн гичний ургамал мод гэхээсээ буттай адил. Гэхдээ **шувууд мөчрүүд дээр нь үүрээ засах** хэмжээний хангалттай том болдог.

Гичний үр нь хаанчлалын өчүүхэн эхлэлийг илэрхийлж байна. Хаанчлал эхэндээ маш жижиг бөгөөд хавчлагын үр дүнд цэвэр тунгалаг байна. Гэвч улсын хангамж ба хамгаалалтыг хүртэх болсноор асар ихээр өсөх болно. Тэгээд шувууд ирж тэнд үүрээ засна. Энэ эшлэлд гарч байгаа шувууд гэдэг үг эх грек дээрээ 4 дүгээр эшлэлийнхтэй ижил байдаг. Эзэн Есүс шувуудыг муу нэгэн хэмээн тайлбарласан (19 дүгээр эшлэл). Тэгэхээр хаанчлалын дотор Сатан болон түүний гар хөл үүрээ засах болно гэдгийг илэрхийлж байна. Өнөөдөр Христийнх гэсэн нэрийн доор Христийг эсэргүүцэгч тогтолцоо, үзэл суртал, шашин шүтлэгийг хүртэл ойлгох болжээ. Тухайлбал Юнитарианизм, Христийн шинжлэх ухаан, Мормонизм, Иеховагийн гэрчүүд, Эв нэгдлийн сүм (Мүүнизм) зэргийг дурдаж болно.

Тэгэхээр Хааны эзгүй хойгуур хаанчлал хэтэрхий томорч өсвөл анхаарах ёстой зүйл байгааг Эзэн Есүс энд урьдаас анхааруулжээ. Христийн дагалдагч нар өсөлтөөр мэхлэгдэж болохгүй. Бас өсөлтийг хараад амжилттай байна гэж андуурч болохгүй. Учир нь эрүүл бус өсөлт байхыг ч үгүйсгэхгүй. Гичний өчүүхэн үр том мод болсон ч гэлээ томорсноосоо болоод “чөтгөрүүдийн нутагладаг газар, бузар сүнс бүрийн орогнох газар, бүх төрлийн бузар, жигшүүрт шувуудын үүр” болсон (Илчлэл 18:2).

### **Е. Исгэх хөрөнгөний тухай сургаалт зүйрлэл (13:33)**

Дараа нь Эзэн Есүс хаанчлалыг гурван хэмжүүр гурилыг исгэхээр нэгэн эмэгтэйн хийсэн хөрөнгөтэй адилтгасан. Эцэст нь гурил бүхэлдээ иссэн. Энэ сургаалт зүйрлэлээс хөрөнгийг сайнмэдээ, гурилыг энэ ертөнц гэж тайлбарлаад сайнмэдээг дэлхий даяар тунхаглавал бүх хүн аврагдана хэмээн номлодог. Гэвч ингэж үзэх нь Бичвэрийн агуулгатай зөрчилддөг. Түүнээс гадна түүхэн болон өнөө үеийн үйл явдлуудаас зөрж байна.

Библид хөрөнгө нь үргэлж бузар муугийн бэлгэдэл болдог. Бурхан өөрийн ард түмнийг гэртээ ямар ч хөрөнгө байлгаж болохгүй (Гэтлэл 12:15) хэмээн тушаахад тэд үүнийг ойлгож байсан. Исгээгүй талхны баярын долоон өдрийн хугацаанд исгэсэн юм идсэн хүн Израилиас таслагддаг байв. Эзэн Есүс фарисайчууд болон



садукайчуудын хөрөнгө (Матай 16:6, 12), бас Херодын хөрөнгөнөөс (Марк 8:15) болгоомжлохыг анхааруулж байсан. 1Коринт 5:6-8 дээр хөрөнгийг хорсол ба бузар муутай холбон ярьсан. Галат номын хам сэдэв нь гаж буруу сургаалын тухай тул Галат 5:9 дээр хөрөнгө нь ийм утгаар орсон. Ерөнхийдөө хөрөнгө гэдэг нь гаж буруу онол сургаал юм уу бузар муу зан хандлагыг хэлдэг.

Тиймээс энэ сургаалт зүйрлэлд Эзэн Есүс **тэнгэрийн хаанчлалын** дотор ажиллагч тархах нөлөө ихтэй бузар муугийн хүчний талаар анхааруулга өгч байна. Гичний үрийн тухай сургаалт зүйрлэлд бузар мууд эзлэгдсэн хаанчлалын гаднах шинжийг харуулсан бол, энэ сургаалт зүйрлэлд болзошгүй дотоод ялзралыг харуулж байна.

Тэгэхээр энэ сургаалт зүйрлэлд гарч байгаа **гурил** бол Бурханы хүмүүсийн хүнс буюу Библийн сургаал, **хөрөнгө** бол гаж буруу онол сургаал, **эмэгтэй** бол тэрхүү сургаалыг зааж, сургах хуурамч эш үзүүлэгч юм (Илчлэл 2:20). Гаж буруу урсгалыг үндэслэсэн хүмүүсийн дотор эмэгтэй хүн олон байгаа нь бодууштай зүйл юм шүү! Эмэгтэй хүн чуулган дотор номлохыг Библи хориглосон байхад (1Коринт 14:34; 1Тимот 2:12) зарим нэг эмэгтэйчүүд үүнийг эсэргүүцэж, номлох, заах байр суурийг авч, Бурханы хүмүүсийн хүнсийг хөнөөлт буруу номлолтой хольж хутган завхруулж байжээ. Ж.Х.Брукс:

Христ тэнгэрийн хаанчлалыг бузар муутай адилтгаагүй гэсэн сөргүүлэл гарч ирвэл үүнд хариу өгөх тун амархан. Эзэн Есүс хаанчлалыг буудай ба зэрлэг өвс, сайн ба муу загасаар зүйрлэсэн. Бас бузар муу зарцын (Матай 18:23-32) тухай сургаалт зүйрлэл ч үүнтэй холбоотой. Түүнээс гадна, хуримын хувцасгүй хүн авралаа алдаж байгааг ч харж болно (Матай 22:1-13).<sup>29</sup>

**Ё. Эзэн Есүс сургаалт зүйрлэлээр ярьсан нь эш үзүүлэгийн биелэл болох нь (13:34, 35)**

Эзэн Есүс эхний дөрвөн сургаалт зүйрлэлийг тэнд цугласан **олонд** хандаж ярьсан. Сургаалаа заахдаа ийм арга ашигладаг байсан нь Дуулал 78:2-т хэлсэн Асафын эш үзүүлэгийн биелэл байв. Мессиа **сургаалт зүйрлэлээр** ярьж, **дэлхийн сууриас эхлэн нууцлагдсан зүйлсийг хэлэх болно** гэдгийг тэнд зөгнөсөн байна. Тэнгэрийн хаанчлал түр хугацааны хэлбэртэй байх нь дэлхий сууриас эхлэн нууцлагдсан байсан боловч Христийн үед ил болжээ.

**Ж. Зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийн тайлбар (13:36-43)**

[13:36] Үүнээс цааш гарах Эзэн Есүсийн яриа нь дагалдагчдадаа хандсан. Үүнийгээ тэр **гэрт ороод** ярьсан байна. Энд **шавь нар** бол Израилийн итгэгч үлдэгсдийг төлөөлнө. Эзэн Есүс эргээд гэрт орсон гэдэг нь Бурхан өөрийн

урьдаас мэдсэн ард түмнээ үүрд орхиогүй гэдгийг бидэнд сануулж байна (Ром 11:2).

**[13:37]** Эзэн Есүс буудай болон зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийг тайлбарлахдаа өөрийгөө тариачнаар илэрхийлсэн болохоо хэлсэн. Тэрээр газар дэлхий дээр амьдарч ахуйдаа шууд тарьж байсан бол эдүгээ үе үеийн зарц нараараа дамжуулан тарьж байна.

**[13:38]** Талбай бол энэ дэлхий. Талбай бол чуулган биш, харин энэ дэлхий гэдгийг анзаарах нь чухал. **Сайн үр нь хаанчлалын хөвгүүд.** Амьд хүнийг газарт тариалах тухай ярьж байгааг бодохоор нэлээн хачирхалтай санагдаж болох юм. Гэхдээ энэ нь хаанчлалын хөвгүүдийг энэ дэлхийд тарьж суулгах гэсэн утгатай. Эзэн Есүс үйлчлэлийнхээ он жилүүдэд хаанчлалынх нь үнэнч албатууд болсон шавь нараа энэ дэлхийд тарьж суулгасан билээ. **Зэрлэг өвсний үр бол муу нэгний хөвгүүд.** Бурханы гэсэн юм бүхнийг Сатан дуурайлгаж, хуурамчийг нь гаргаж ирдэг. Тэрээр Христийн дагалдагчидтай адил харагддаг, адил зүйл ярьдаг, зарим талаараа адил амьдралын хэв маягтай хүмүүсийг энэ дэлхийд тарьж ургуулдаг. Гэвч тэд Хааны жинхэнэ дагалдагч биш юм.

**[13:39]** Дайсан бол Сатан. Тэрээр Бурхан болоод Бурханы хүмүүсийн дайсан билээ. **Ургац хураах цаг нь үеийн төгсгөл.** Өөрөөр хэлбэл, хаанчлал түр хэлбэрээр байх үеийн төгсгөл бөгөөд тэр үед Есүс Христ хүч ба яруу алдраар

эргэн ирж Хааны байр сууринаас захирах болно. Эзэн энд чуулганы үеийн төгсгөлийг яриагүй. Хэрэв энд чуулганыг оруулж ирвэл ойлгоход төвөгтэй болно.

**[13:40-42]** Ургац хураагчид бол тэнгэрэлч нар (Илчлэл 14:14-20-ыг үз). Хаанчлалын одоогийн үе шатанд буудай ба зэрлэг өвсийг хүчээр салгаж тусгаарлахгүй. Хамтдаа ургахыг нь Бурхан одоохондоо зөвшөөрсөн. Харин Христийн хоёр дахь ирэлт болоход тэнгэрэлч нар нүглийн бүх шалтгааныг хамаг нүгэлтнүүдтэй нийлүүлээд **галтай зууханд хаяна. Тэнд тэд уйлж, шүдээ хавирна.**

**[13:43]** Их зовлонгийн үед газар дэлхий дээр байсан зөв шударга албат харьяатууд нь **Эцэгийнхээ хаанчлалд орж Христийн мянган жилийн захиргааг хүлээн авна. Тэд мэт гийх болно.** Тэд яруу алдартай, сүр жавхлантай болно.

Эзэн Есүс энд бас дахин **“Сонсох чихтэй нь сонсогтун”** хэмээх битүүлэг анхааруулгыг хэлсэн байна.

Бурханлаг бус хүмүүсийг нутгийн чуулган дотор хүлцэн байлгах ёстой гэдгийг энэ эшлэлээр зөвтгөж болохгүй. Талбай бол чуулган биш, энэ дэлхий гэдгийг бүү мартаарай. Бузар муугийн зарим нэг хэлбэрээс салахгүй байгаа хүмүүсийг чуулганы нөхөрлөлөөс гаргахыг нутгийн чуулгануудад тодорхой хэлсэн (1Коринт 5:9-13) учраас ингэж ойлгож болохгүй. Хаанчлалын нууц хэлбэр нь үеийн төгсгөл хүртэл жинхэнэ ба хуурамч дагалдагчдыг дотроо

агуулж байх болно гэдэг санааг энэ сургаалт зүйрлэл дэлгэн тавьсан. Тэгээд эцэст нь Бурханы тэнгэрэлч нар хуурамчийг нь жинхэнээс нь салгаж, хуурамчийг нь шийтгэл уруу, жинхэнийг нь газар дэлхий дээрх Христийн яруу жавхлант хаанчлал уруу авчирна.

### **3. Нууцлагдсан эрдэнэсийн тухай сургаалт зүйрлэл (13:44)**

Хаанчлалын дотор сайн ба муу, зөвт ба зөвт бус дагалдагчид байх болно гэдгийг өмнөх сургаалт зүйрлэлүүд бидэнд зааж өгсөн. Тэгвэл одоо үзэх хоёр сургаалт зүйрлэлд хаанчлалын доторх зөвт хүмүүс нь хоёр янз болохыг харуулдаг: (1) Чуулганы үеийн өмнө ба дараа байх итгэгч иудейчүүд; (2) Энэ үед иудейчүүд болон харь үндэстнүүдээс бүрдэх итгэгчид.

**Эрдэнэсийн тухай сургаалт зүйрлэлд Эзэн Есүс хаанчлалыг талбайд нуусан эрдэнэстэй адилтгасан. Түүнийг хүн олоод нууж, өөрт байгаа бүхнээ зараад тэрхүү талбайг баяртайгаар худалдан авна.**

**Хүн бол Эзэн Есүс өөрөө юм. Учир нь буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлд гарч байгаа хүн бол Эзэн Есүс өөрөө болохыг тэр бидэнд 37 дугаар эшлэлд тайлж өгсөн. Харин эрдэнэс бол Есүсийн үйлчлэлийн үед болон чуулганы шүүрэлтийн дараа байх итгэгч иудейчүүд юм (Дуулал 135:4-ийг үз. Тэнд Израилийг Бурханы онцгой эрдэнэс гэсэн байна). Тэд талбайд нууцлагдсан ажээ. Өөрөөр хэлбэл,**

тэд энэ дэлхийгээр тарсан учраас тэдний байгаа эсэхийг Бурханаас өөр хэн ч мэдэхгүй. Гэтэл Эзэн Есүс тэрхүү эрдэнэсийг олоод загалмай уруу явж, эрдэнэсийг нуусан энэ дэлхийг худалдаж (2Коринт 5:19; 1Иохан 2:2) авахын тулд бүхнээ өгөх болно. Чөлөөлөгч Сионоос гарч, удаан хүлээгдсэн Мессиагийн хаанчлал байгуулагдах цагт золигдсон Израиль ил гарах болно.

Энэ сургаалт зүйрлэлийг заримдаа дараах байдлаар тайлбарладаг: Нүгэлт хүн хамгийн агуу эрдэнэс болох Христийг олохын тулд бүхнээ өгөх ёстой. Гэвч ингэж тайлбарлавал авралыг үнэгүй өгнө (Исаиа 55:1; Ефес 2:8, 9) гэсэн нигүүлслийн тухай сургаалыг үгүйсгэнэ.

## **И. Асар үнэтэй сувдын тухай сургаалт зүйрлэл (13:45, 46)**

**Хаанчлалыг энд сайн сувд хайгч худалдаачинтай** зүйрлэсэн. Тэр худалдаачин хайж явсан **үнэт** сувдаа олбол байгаа бүхнээ зараад түүнийг худалдаж авна.

“Хамгийн үнэт Сувдаа би олсон” гэх магтан дууг үзвэл Сувд бол Аврагч, худалдаачин бол нүгэлт хүн болж байна. Тэгвэл би дахиад л хэлье. Нүгэлт хүн бүхнээ зараад, Христийг худалдан авдаггүй.

Харин энд гарч байгаа **худалдаачин** бол Эзэн Есүс, **үнэт сувд** бол чуулган юм. Эзэн Есүс үнэт сувд болсон чуулганыг худалдан авахын тулд Голгота толгод дээр бүхнээ зарсан билээ. Сувд

нь хясааны өвдөлт зовлонгоос болж дотор нь бий болдог шиг чуулган бас Аврагч Эзэний биеийн шарх сорвиор дамжуулан бий болсон.

Нууцлагдсан эрдэнэсийн тухай сургаалт зүйрлэлд хаанчлалыг эрдэнэстэй зүйрлэсэн бол энэ сургаалт зүйрлэлд хаанчлалыг сувдтай биш худалдаачинтай зүйрлэсэн байгаа нь сонирхолтой. Яагаад ийм ялгаа байна вэ?

Эхний сургаалт зүйрлэл дээр эрдэнэс буюу золигдсон Израилийг онцолсон. Хаанчлалыг Израиль үндэстэнтэй холбосон. Хаанчлалыг хамгийн түрүүнд энэ үндэстэнд санал болгосон бөгөөд ирээдүйд хаанчлалын үндсэн харьяатууд нь Израиль хүмүүс байх болно.

Өмнө дурдсанчлан чуулган ба хаанчлал хоёр хоорондоо ялгаатай. Чуулганы дотор байгаа бүхэн хаанчлалын түр хугацааны хэлбэрт багтдаг боловч хаанчлалд байгаа бүхэн чуулганд багтахгүй. *Чуулган нь хаанчлалын ирээдүйн хэлбэрийн дотор багтахгүй, харин Христтэй хамт шинэчлэгдсэн дэлхийг захирах болно.* Хоёр дахь сургаалт зүйрлэл Хааныг өөрийг нь болон сүйт бүсгүйгээ олж авахын тулд төлж буй асар их үнийг нь онцолсон. Хожим Хаан үзэгдэх үед сүйт бүсгүй нь түүний алдар жавхланг хуваалцах болно.

Сувд далайгаас (далай бол харь үндэстнүүдийн бэлгэдэл) гардаг. Чуулган ч бас үүнтэй адил. Чуулганы зонхилогч хэсэг нь иудей бус үндэстнүүдээс бүрдэх тул чуулганыг Христийн харийн сүйт бүсгүй гэж нэрлэдэг.

Гэхдээ чуулганы дотор иудей хүн орохгүй гэсэн үг биш юм. Харин түүний нэрийн төлөө үндэстнүүдээс дуудагдсан хүмүүс чуулганы дийлэнх олонхыг бүрдүүлдэг гэсэн утгатай. Энэ бол эдүгээ үед зориулсан Бурханы төлөвлөгөө гэдгийг Үйлс 15:14 дээр Иаков батлан хэлж байна.

### **К. Загасны торны тухай сургаалт зүйрлэл (13:47-50)**

[13:47, 48] Хамгийн сүүлийн сургаалт зүйрлэлд **тэнгэрийн хаанчлалыг төрөл бүрийн загас барихаар тэнгист хаясан загасны тортой зүйрлэсэн**. Загасчид тороо татаад загаснуудаа ангилж, **сайныг нь саванд хийн, мууг нь хаяна**.

[13:49, 50] Бидний Эзэн энэхүү сургаалт зүйрлэлийг тайлбарлаж байна. Энэ нь **үеийн төгсгөлийн** тухай ярьжээ. Өөрөөр хэлбэл, их зовлонгийн үеийн төгсгөл, Христийн хоёр дахь ирэлтийн үе. Загасчид бол **тэнгэрэлч нар**. Сайн загас бол зөвт хүмүүс. Иудейчүүд хийгээд харь үндэстнүүдийн дотроос аврагдагсад. Муу загас бол зөвт бус хүмүүс. Тодруулбал, бүх үндэстний үл итгэгчид. Буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлтэй (30, 39-43 дугаар эшлэл) адил нь, хожим сайныг муугаас ялгана гэдгийг энд хэлж байна. Зөвт хүмүүс Эцэгийнхээ хаанчлалд орно. Харин зөвт бус хүмүүс галтай газарт хаягдана. **Тэнд тэд уйлж, шүдээ хавирна**. Гэхдээ энэ бол эцсийн шүүлт биш. Энэ шүүлт мянган жил эхлэхийн өмнө болно. Харин эцсийн



шүүлт нь мянган жил дууссаны дараа болно (Илчлэл 20:7-15).

Гаебелейн энэ сургаалт зүйрлэлд дараах тайлбарыг хийсэн:

Далай бол үндэстнүүдийн бэлгэдэл. Загасны торыг далайд хаясан. Их зовлонгийн үед мөнхийн сайнмэдээг тунхаглагдах явдлыг (Илчлэл 14:6, 7) энэ сургаалт зүйрлэлд ярьж байна. Сайныг муугаас ялгах ажлыг тэнгэрэлч нар хийнэ. Тэгэхээр энэ үйл явдал одоо үеийн тухай юм уу чуулганы талаар байх боломжгүй. Харин хаанчлал байгуулагдахын өмнөхөн болох үйл явдалд хамаатай байна. Энэ сургаалт зүйрлэлд гарч байгаа тэнгэрэлч нарын ажил хэрхэн явагдах нь Илчлэл номд тодорхой дүрслэгдсэн. Хорон муу хүмүүс галт зууханд хаягдаж, зөвт хүмүүс газар дэлхий дээр үлдэн мянган жилийн хаанчлалд орно.<sup>30</sup>

#### **Л. Үнэний сан хөмрөг (13:51, 52)**

**[13:51]** Эзэн ба Багш болох Есүс сургаалт зүйрлэлүүдээ айлдаж дуусаад **ойлгосон** эсэхийг нь шавь нараасаа асуув. Шавь нар нь түүнд **“Тийм ээ”** гэж хариуллаа. Тэд үнэхээр ойлгосон эсэх нь биднийг эргэлзүүлдэг. Яагаад гэвэл бид **“тийм”** гэж ийм итгэлтэй хариулж чадахгүй шүү дээ.

**[13:52]** Тэд ойлгосон учраас энэ сургаалт зүйрлэлүүдийг бусдад хуваалцах үүрэгтэй болов. Шавь нар ерөөлийг өөртөө шингээгээд дуусдаг

битүү сав байж болохгүй. Харин түүнийгээ бусдад дамжуулдаг суваг байх ёстой. Арван хоёр шавь одоо **тэнгэрийн хаанчлалын** талаар сургагдсан хуулийн багш нар болж байна. Өөрөөр хэлбэл, үнэнийг заах багш, тайлбарлагч нар болсон гэсэн үг. Тэд **эрдэнэсийн сангаасаа хуучныг болон шинийг гаргах өрхийн тэргүүлэгчтэй адил юм.** Хуучин гэрээ нь зааж сургах зүйлсийн уурхай агаад тэдгээрийг бид **хуучин** үнэн гэж нэрлэж болох юм. Харин Христийн сургаалт зүйрлэлээр дөнгөж сая хүлээж авсан сургаал бол цоо **шинэ** зүйл юм. Тэгэхээр тэд мэдлэгийн ийм өргөн сан хөмрөгийг уудлан цог жавхлантад үнэнийг бусдад дамжуулах ёстой.

### **М. Есүсийг Назар хотынхон хүлээн авахаас татгалзсан нь (13:53-58)**

[13:53-56] Эзэн Есүс энэ сургаалт зүйрлэлүүдээ айлдаж дуусаад Галил нуурын эргийг орхин өссөн хот Назартаа ирэв. Энэ нь түүний сүүлийн айлчлал болжээ. Тэрээр **синагогт нь орж, тэднийг сургахад хүмүүс мэргэн ухааныг нь хийгээд өөрсдийн дуулсан гайхамшгуудыг гайхширцгаав.** Есүс бол тэдний хувьд ердөө л нэг **мужааны хүү** байлаа. Тэд **эх Мариаг нь, Иаков, Иосеф, Симон, Иуда** нэртэй эрэгтэй дүү нарыг нь, бас **охин дүү нарыг** нь мэднэ. Есүсийн гэрийнхэн Назартаа амьдарч байжээ. Төрөлх хотынх нь жирийн нэг хүү бусдыг сургаж, гайхамшиг үйлдэн, олны танил

болсон гэдэг нь тэдэнд жигтэй хэрэг байв. Үүнийг тэд ойлгохгүй байлаа. Тиймээс үнэнийг таньж мэдсэнээс мэдэхгүй өнгөрөх нь тэдэнд дээр санагджээ.

**[13:57, 58]** Тэд түүнд гомдов. Үүнээс болоод Эзэн Есүс “жинхэнэ эш үзүүлэгчийг гэрээс нь өөр газарт л илүүтэй талархан хүлээн авдаг” гэсэн дүгнэлтийг хэлсэн. Өссөн хотынх нь хүмүүс, хамаатан саднууд нь Есүсийг таньж мэддэгээсээ болоод түүнийг дорд үзсэн. Тийнхүү тэдний итгэлгүй байдлаас болоод Аврагч Эзэн маань Назарт далайцтай ажиллаагүй. Зөвхөн цөөн хэдэн өвчтэй хүнийг л эдгээжээ (Марк 6:5-ийг харьцуулан хар). Тэрээр ажиллаж чадваргүй байсан гэсэн үг биш юм. Хүний хорон муу байдал Бурханы хүч чадлыг хязгаарлаж чадахгүй. Хамгийн гол нь ерөөлийг хүсэхгүй хүмүүсийг ерөөж, хэрэгцээ байгаа гэж бодохгүй хүмүүсийн хэрэгцээг хангаж, өөрсдийгөө өвчтэй гэж үзэхгүй хүмүүсийг эдгээхийг тэр хүсээгүй юм.

## **IX. МЕССИАГИЙН АГУУ НИГҮҮЛСЭЛД ДАЙСАГНАЛААР ХАРИУ БАРИВ (14:1- 16:12)**

### **A. Иохан Баптистын толгойг авсан нь (14:1- 12)**

**[14:1, 2]** Эзэн Есүсийн хийж буй үйлчлэлийн тухай зар захирагч Херодын чихэнд хүрэв. Их Херодын нэр муутай энэ хүүг Херод Антип гэж бас нэрлэдэг. Иохан Баптистын толгойг авах

зарлиг гаргасан нь Херод Антип юм. Христийн гайхамшгуудын тухай сонссон түүний мөс чанар нь түүнийг зовоож эхлэв. Толгойг нь авсан эш үзүүлэгч байн байн эргэн санагдах болжээ. Херод зарц нартаа “Энэ хүн бол **Иохан мөн**. Тэр **үхлээс амилжээ**. Эдгээр гайхамшгийн учир энэ” гэж хэлжээ.

[14:3] Энэ бүлгийн 3-12 дугаар эшлэлд Матай хүүрнэж байсан үйл явдлаа ухрааж Иоханы үхлийн шалтгааныг дэлгэн тавьсан.

[14:4,5] Херод Антип эхнэрээ үл тоож, **дүү Филиппийнхээ эхнэр Херодиатай** эр эмийн харьцаатай болж завхайран амьдарч байв. Иохан Бурханы эш үзүүлэгч тул үүнийг нүдээ анин өнгөрөөсөнгүй. Тэрээр Херодоос айж эмээлгүйгээр ёс бус явдлыг нь буруушаажээ.

Херод хаан үүнд нь машид уурлан хилэгнэж, Иоханыг алахыг хүссэн боловч Иоханы аминд хүрэх нь улс төрийн хувьд сөрөг үр дагавартай байв. Ард түмэн Иоханыг **эш үзүүлэгч** хэмээн үздэг тул Иоханыг хөнөөвөл үймээн самуун дэгдээж болзошгүй байлаа. Тиймээс Херод Иохан Баптистыг шоронд хориод уур хилэнгээ түр намжаав. “Үхсэн арслан эсвэл торны цаана байгаа арсланд хүн ойртож чаддаг. Үнэн шударга байдлыг хорон муу хүн ийм байлгах дуртай. Харин торноосоо алдуурч, мөс чанарыг нь хөндөх үед тэд үнэн ба шударгаас айдаг.”<sup>31</sup>

[14:6-11] **Херодын төрсөн өдрөөр Херодиагийн охин олны өмнө бүжиглэж Херодод ихэд таашаагджээ. Сэтгэл хөдөлсөн**

Херод охины хүссэн бүхнийг нь өгнө гээд бодлогогүй үг унагачхав. Охин муу санаат эхийнхээ зөвлөснөөр **Иохан Баптистын толгойг царан дээр** авчрахыг ичиж зовохгүй гуйв. Тухайн үед Херод Иоханд хилэгнэх нь намжсан байсан ч, Иоханы эр зориг ба шударга занг нь биширдэг байсан ч, хэдийгээр харууссан ч, амласнаа биелүүлэхээс аргагүй хэмээн үзэж, Иоханы толгойг авахыг тушаажээ. Ингээд **Иоханы толгойг авч**, бүжигч охины аймшигт хүсэлтийг биелүүлэв.

**[14:12]** Иоханы шавь нар багшийнхаа цогцсыг хүндэтгэлтэй оршуулаад **явж Есүст мэдэгдлээ**. Уй гашуу, гомдол харууслаа илэрхийлэх хүн Есүсээс өөр байсангүй. Тэд бидэнд үнэхээр сайн үлгэр дуурайл үзүүлжээ. Хавчлага, дарамт, зовлон, шаналлын үед бид ч бас Эзэн Есүс уруу очиж, тэр бүхнээ хэлэх хэрэгтэй.

Херодын гэмт үйлдэл Иоханыг хөнөөснөөр намжсан боловч ой дурсамжаас нь арилаагүй юм. Тэрээр Эзэн Есүсийн үйл хэргийг сонсох болгонд хийсэн үйлдсэн нь бодол санаанаас нь салахгүй дагаж байв.

## **Б. Таван мянган хүнийг хооллосон нь (14:13-21)**

**[14:13, 14]** Үйлдэж буй гайхамшгуудыг нь дуулсан Херодын сэтгэл зовуурь зовнилтой болсныг Эзэн **Есүс сонсоод завинд** суун Галил нуурын орчмоос холдохоор **явлаа**. Гэхдээ тэр

Херодоос айсандаа холдоогүй гэдэг нь тодорхой. Цаг нь болоогүй байхад түүнд юу ч тохиолдохгүй гэдгийг тэр мэдэж байсан. Яагаад тэндээс явсан шалтгааныг бид мэдэхгүй. Шавь нар нь илгээлтийн үйлчлэлээсээ эргэж ирж байсан учраас тэднийг угтахаар явсан байх гэж таамагладаг (Марк 6:30; Лук 9:10). Түүнээс гадна нам гүм газарт амрах цаг хэрэгтэй байсан бололтой.

Гэвч хүмүүс түүний араас ирж, **түүнийг явганаар дагалаа**. Түүнийг эрэг дээр буухад хурсан олон түүнийг амдан хүлээж байв. Өрнинжин Эзэн маань үүнд уурлан цухалдалгүй **өвчтөнүүдийг нь эдгээв**.

**[14:15] Орой** (15:00 цагаас хойш) **болох үед шавь нарт нь** нөхцөл байдал хэцүүдэж эхлэх нь гэсэн бодол төрж эхлэв. Тэнд маш олон хүн байсан ч идэх юм юу ч байсангүй. Тиймээс хүмүүсийг **гацаанууд уруу** явуулаач хэмээн Есүсийг ятгав. Тэгвэл хүмүүс тэндээсээ хоол хүнс олж авна гэж тэд боджээ. Тэр үед шавь нар нь Христийн сэтгэлийг хараахан сайн таниагүй байжээ. Хүч чадлыг нь ч дутуу үнэлжээ.

**[14:16-18] Харин Есүс тэдэнд “гэд явах хэрэггүй” гэв**. Мутраа дэлгээд амьд бүхний хүслийг хангагч нэгнийг хүмүүс яагаад орхиж явна гэж? Тэгээд тэр шавь нартаа хандан **“Та нар тэдэнд идэх юм өг”** гэв. Шавь нар нь бүр гайхаж хоцорлоо. “Тэдэнд идэх юм өгнө гэнэ ээ? Бидэнд **таван талх, хоёр загаснаас өөр юу ч алга.**” Өөрсдөд нь Эзэн Есүс байгааг тэд мартжээ.

Аврагч маань уужуу зангаар тэдэнд **“Нааш нь аваад ир”** гэв. Тэднээс гарах ёстой юм нь тэр байжээ.

**[14:19-21]** Эзэн Есүс хурсан олонд зүлгэн дээр суухыг тушаагаад таван талх, хоёр загасыг авч, талархал илэрхийлэн, талх, загасаа хувааж, хүмүүст хуваарилан тараа гээд шавь нартаа өгөв. Талх, загас бүгдэд хангалттай хүрчээ. Бүгд цадсаны дараа шавь нар нь үлдэгдэл өвдөл цөвдлийг нь цуглуулахад арван хоёр сагс дүүрэв. Анх байснаас хамгаагүй олон талх, загас үлдсэн байлаа. Эцэст нь арван хоёр шавь бүгдээрээ нэг нэг сагс хүнстэй үлджээ. Тэнд 5,000 орчим эрчүүд байсан. Тэгвэл эмэгтэйчүүд, хүүхдүүдийг оролцуулаад барагцаагаар 10-15 мянган хүн хооллосон гэж үзэж болохоор байна.

Энэхүү гайхамшиг нь бүх үеийн дагалдагчдад сүнслэг чухал сургамжийг өгдөг. Өлсгөлөн хүмүүс хэзээд олон байдаг. Харин дагалдагчид цөөхүүлээ бөгөөд өгөх юмаар ч хомсхон байдаг. Гэвч өр нинжин Аврагч Эзэн маань үргэлж бидэнтэй хамт байдаг билээ. Хэрэв дагалдагчид өөрсдөдөө байгаа өчүүхэн жаахныгаа бүгдийг Эзэндээ өгвөл тэр түүнийг нь арвижуулаад олон мянган хүнийг хооллож чадна. Галилд хооллосон таван мянган эрчүүд түрхэн хугацаанд цадсан бол өнөөдөр амьд Христээр хооллосон хүмүүс үүрд мөнхөд цадах болно (Иохан 6:35-ыг үз).

## **В. Эзэн Есүс усан дээгүүр алхсан нь (14:22-33)**

Олон түмнийг хооллосон гайхамшгаас шавь нар хэрэгцээт бүхнийг нь хангаж чаддаг нэгнийг дагаж буйгаа ойлгож авсан. Харин энд гарах гайхамшгаас тэд Эзэн Есүс бол өөрсдийг нь хамгаалж, хүчирхэгжүүлж чадах нэгэн юм байна гэдгийг мэдэх болно.

**[14:22-23] Эзэн Есүс хурсан олныг явуулах зуураа шавь нараа завинд нь суулгаж, нуурын нөгөө эрэг уруу явуулав. Тэгээд өөрөө ууланд гарч залбирахаар явлаа. Орой болоход (RSV орчуулгаас Гэтлэл 12:6-ын хажуугийн тайлбарыг үз. Иудейчүүдэд хоёр орой байжээ. Эхнийх нь 15 дугаар эшлэлд дурдагдсан орой бөгөөд үдээс хойш эхэлдэг. Хоёр дахь энд гарч байгаа орой бөгөөд нар жаргасны дараа эхэлдэг.) тэр тэнд ганцаараа байв.**

**[14:24-27] Энэ зуур завь салхинд туугдсаар хэдийн эргээс холдсон байв. Давлагаа ширүүсэж байсан тул Эзэн Есүс шавь нараа хэцүүдэж байгааг ойлгоод шөнийн дөрөвдүгээр манааны үед (үүрийн 3:00-6:00 цагийн хооронд) нуурын дээгүүр алхан тэднийг зүглэн явав. Үүнийг харсан шавь нар нь хий үзэгдэл байна гээд айж сандралдав. Тэгтэл Эзэн ба Андынх нь зоригжуулсан дуу хоолой сонстох нь тэр: “Зоригтой бай. Би байна. Бүү ай.”**

Энэ явдал бидний нөхцөл байдалтай ч бас адил. Хүнд хэцүү үед бид юу юугүй л айн сандарч, яахаа мэдэхээ больдог. Аврагчийгаа алс хол байгаа мэт санадаг. Гэтэл тэр бидний төлөө



цаг ямагт залбирч байдаг. Шөнийн хамгийн гүн харанхуйд ч тэр бидэнд ойр байдаг. Тэгэхэд нь хүртэл бид Түүнийг танилгүй түгшин сандрах товчлуураа дарчихдаг. Тэгэхэд Түүний дуу хоолой сонстож, зүрх сэтгэлийг маань тайтгаруулж, бидний айн сүрдэж буй давлагаа нь хөлийнх нь дор буйг санадаг.

[14:28] Танил дотно тэрхүү дуу хоолойг сонссон **Петрийн** сэтгэл хөдөлж, сониуч зан нь хөндөгдөв. **“Эзэн, хэрэв та мөн юм бол, усан дээгүүр алхаж өөр уруу тань ирэхийг надад тушаагаач.”** “Хэрэв” гэдэг үг Петрийн эргэлзээ тээнэгэлзлийг харуулж байгаа ч ийм зоригтой хүсэлт тавьсан нь ямар их итгэж найдаж буйн илрэл юм. Эзэн Есүс тушаах л юм бол чадна гэдгээ Петр мэдэж байв. Эзэн Есүсийн тушаал юунд ч хүч өгч чадна.

[14:29-33] Эзэн Есүсийг **“ир”** гэж хэлмэгц **Петр** завинаасаа үсрэн гараад Эзэн Есүсийн өөдөөс алхаж эхэллээ. Петр хараагаа Эзэн Есүс дээр байлгаж байхдаа боломжгүйг үйлдэж байв. Харин хүчит **салхинд** анхаарлаа хандуулмагц живж эхлэв. Мэгдэж сандарсан Петр **“Эзэн, намайг авраач”** хэмээн хашхирч эхлэв. Эзэн Есүс түүний гараас татаад, **өчүүхэн итгэлийг** нь намуухнаар зэмлээд, завинд суулгав. Эзэн Есүсийг завинд суумагц **салхи зогсжээ. Завин дээр байсан хүмүүс түүнд мөргөж, “Та бол үнэхээр Бурханы Хүү мөн”** гэгцгээв.

Христэд итгэн амьдрах гэдэг нь усан дээр алхахтай адил хүмүүний хувьд боломжгүй зүйл

билээ. Хүн зөвхөн Ариун Сүнсний хүчээр л Христэд итгэн амьдрах боломжтой. Бид хараагаа зөвхөн Эзэн Есүс дээр хандуулбал (Еврей 12:2) ер бусын амьдралаар амьдрах болно. Харин өөрсөд дээрээ болон нөхцөл байдалдаа төвлөрөх мөчөөс эхлээд живж эхэлдэг. Хэрэв бид тийн живбэл сэргэлтийг гуйн, Бурханы хүч чадлыг хүсэн Христ уруу хашхирах хэрэгтэй.

### **Г. Эзэн Есүс Геннесаретэд өвчтэй хүмүүсийг эдгээсэн нь (Матай 14:34-36)**

Ингээд сууж явсан завь нь Галил нуурын баруун хойд эргийн **Геннесаретэд** газардлаа. Хүмүүс Есүсийг танимагцаа тэр нутгийн **өвчтэй хүн бүрийг** цуглуулан **Түүн дээр авчирлаа**. **Өвчтэй хүмүүс зөвхөн дээлийнх нь хормойд гар хүрэхэд л эдгэж байлаа**. Ингээд тэр нутаг нэг хэсэгтээ л ямар ч өвчтөнгүй болсон учраас эмч нар нь амралтаа авахаас өөр аргагүй болов. Агуу их эмч айлчлан ирснээр тэр нутаг эрүүл энх ба эдгэрлийг амсжээ.

### **Д. Бузар муу нь хүний дотроос гардаг (15:1-20)**

Матай эхний хэдэн бүлгүүддээ үйл явдлыг цаг хугацааны дарааллаар хүүрнээгүй байснаа 14 дүгээр бүлгийн эхнээс аваад номын төгсгөл хүртэл ер нь болсон дарааллын дагуу бичсэн харагддаг.

Арван тавдугаар бүлэгт тэмдэглэсэн үйл явдал нь диспенсацийг (Бурханы хөтөлбөрийг) харуулахуйц дараалалтай өрнөсөн байна. Эхлээд

фарисайчууд болон хуулийн багш нар Эзэн Есүстэй маргасан (1-20 дугаар эшлэл). Үүн шиг эхлээд Израиль Мессиагаас татгалзана. Дараа нь канаан эмэгтэйн итгэл гарсан (21-28 дугаар эшлэл). Израиль Мессиагаас татгалзсаны дараа сайнмэдээ харь үндэстнүүдэд хүрнэ. Эцэст нь Эзэн Есүс олон түмнийг эдгээж (29-31 дүгээр эшлэл), 4000 хүнийг хооллосон нь энэ ертөнцөд эдгэрэл ба сайн сайхан дүүрэх ирээдүйн мянган жилийн үеийг зааж байна.

**[15:1, 2] Хуулийн багш нар ба фарисайчууд** Аврагч Эзэнийг үгэнд нь унагах гэж цөхрөлтгүй оролдсоор байв. Тэднийг төлөөлсөн хэсэг хүмүүс **Иерусалимаас** ирээд, гараа угаахгүйгээр хоол иддэг **шавь нарыг нь** шүүмжилж, **ахмадын ёс заншлыг зөрчсөн** хэрэгт буруутгав.

Энд гарч байгаа үйл явдлыг ойлгохын тулд цэвэр ба бузрын тухай ойлголтыг бид мэдэх ёстой. Гараа угаах гэдгээр фарисайчууд юу хэлж байсныг ойлгох хэрэгтэй. Цэвэр ба бузрын тухай ухагдахуун нь Хуучин гэрээнээс улбаатай. Эзэн Есүсийн шавь нарыг буруутгасан бузар байдлын тухай яриа бол шашны зан үйлтэй холбоотой сэдэв юм. Жишээ нь хүн үхсэн хүний цогцост хүрвэл бузарт тооцогдож, шашны зан үйлд орох эрхгүй болдог байжээ. Тиймээс тэр хүн Бурханд мөргөх ёслолыг үйлдэж болохгүй гэсэн үг. Тэр хүн Бурханы өмнө ирэхийн тулд эхлээд цэвэрших, ариусах зан үйлийг үйлдэх ёстой хэмээн Бурханы хууль шаарддаг.

Гэтэл ахмадууд ариусах зан үйлд өөрсдийн уламжлалыг нэмж оруулжээ. Тухайлбал, иудей хүн хоол идэхийнхээ өмнө гарыг тохойноос урагш бүхэлд нь угаадаг нарийн зан үйлийг үйлдэх ёстой гэсэн уламжлал байв. Хэрэв иудей хүн зах явсан бол ирээд биеэ бүхэлд нь угаадаг зан заншил ч байжээ. Тэгэхээр фарисайчуудын ярьж байгаа ахмадын ёс заншил гэдэг нь Бурханы хууль бус, иудейчүүдийн өөрсдийнх нь уламжлал ажээ.

[15:3-6] Өөрийг нь шүүмжилсэн хүмүүс ахмадын зан заншлыг ч биш, бүр **Бурханы тушаалуудыг** зөрчдөгийг нь Эзэн Есүс сануулсан. Хуульд эцэг, эхээ **хүндлэхийг** заасан. Ингэхийн тулд шаардлагатай тохиолдолд эцэг эхдээ санхүүгийн тусламж үзүүлэх хэрэгтэй. Гэтэл хуулийн багш нар болоод фарисайчууд (өөр олон хүн) нас өндөр болсон эцэг эхээ асарч халамжлахын тулд мөнгөө зарцуулахыг хүсээгүй учраас энэ үүрэг хариуцлагаасаа мултрах уламжлал, ёс заншлыг бий болгожээ. Юу гэвэл, **эцэг, эх** нь тэднээс тусламж гуйвал тэд “Та нарт өгөх байсан мөнгөө би **Бурханд** зориулчихсан учраас өгч чадахгүй нь” гэж хэлдэг байжээ. Энэ үгийг хэлэхэд л эцэг, эхээ санхүүгийн хувьд тэтгэх үүрэг хариуцлагаас мултардаг байв. Уламжлал, ёс заншлаа дагахын тулд тэд эцэг эхээ асарч хүндлэх ёстой гэсэн **Бурханы** Үгийг үгүйсгэжээ.

[15:7-9] Тэд үгсийг ийнхүү зальжин мушгин гуйвуулснаараа **Исаиа** 29:13 дээр хэлэгдсэн эш

үзүүлэгийг биелүүлэв. Тэд **амаараа** Бурханыг хүндэлдэг **боловч тэдний зүрх сэтгэл** Бурханаас **алс хол байдаг**. Тэд хүний уламжлалыг Бурханы үгээс дээгүүр тавьсан учраас Бурханд мөргөж байгаа нь ямар ч ашиггүй, үнэ цэнэгүй зүйл болсон байна.

**[15:10, 11]** Эзэн Есүс **хурсан олныг** өөртөө хандуулаад туйлын чухал үгийг хэлсэн юм. Тэрээр **“Аманд орсон юм хүнийг бузарладаггүй, харин амнаас гарч буй нь хүнийг бузарладаг”** гэв. Оюун санаанд хувьсгал хийсэн энэ үгэнд бид талархах учиртай. Левийн хуульд ам уруу орсон зүйл хүнийг бузарладаг гэж заасан. Сэвсээ хивдэггүй, ац туурайтай амьтны махыг идэх нь иудей хүнд хориглогдсон зүйл байсан. Бас сэрвээгүй, хайрсгүй загасны махыг идэж болохгүй байсан. Ямар хүнс нь цэвэр, ямар хүнс нь бузар вэ гэдэг талаар Бурхан маш олон заавар өгсөн байдаг.

Харин эдүгээ Хууль Тогтоогч нь бузар байдлын тухай заасан хуулийн тогтолцоог үгүй хийх замыг тавьж өгч байна. Гараа угаахгүй идсэн хоол хүнс шавь нарыг нь бузартуулахгүй гэдгийг тэр хэлсэн. Харин хоёр нүүрт хуулийн багш нар ба фарисайчуудад бол тэр нь үнэхээрийн бузар зүйл байв.

**[15:12-14]** Хэлсэн үгнээс нь болоод **фарисайчууд гомдсон** болохыг шавь нараасаа сонсоод Эзэн Есүс шавь нартаа хариулахдаа фарисайчуудыг Бурханы тарьсан ургамалтай жишсэн. Фарисайчууд бол буудай биш зэрлэг

өвс юм. Тэд өөрсдийн сургаалтайгаа хамт үндсээрээ сугалагдах болно. Тэгээд Эзэн Есүс шавь нартаа **“Тэднийг орхи. Тэд бол сохруудыг удирддаг сохрууд юм”** гэв. Тэд сүнслэг зүйлсийн эрх мэдлийг атгасан гэдэг ч сүнсний үнэнийг харж чаддаггүй **сохор** байв. Тэднийг дагаж байгаа хүмүүс ч тэдэнтэй адил сохор аж. Тиймээс дагаж байгаа нь ч тэр, дагуулж байгаа нь ч тэр **хоёул нүхэнд унах болно.**

**[15:15]** Цэвэр ба бузар хоолны тухай насаараа заалгасан үзэл баримтлалыг нь үгүйсгэсэн зүйлийг ярьсан учраас шавь нар гайхаж хоцорчээ. Эзэн Есүсийн үг тэдэнд яг л **сургаалт зүйрлэл** мэт байв. Өөрөөр хэлбэл тэд Эзэн Есүсийн үгийн утгыг ойлгоогүй байна. Тэд ойлгоогүй учраас **Петр** ам нээж, тайлбарлаж өгөхийг гуйсан.

**[15:16-17]** Шавь нар нь үүнийг ойлгож цөхсөнд Эзэн Есүс гайхсан. Тэгээд жинхэнэ бузарталт нь биеийн хувьд биш, сэтгэлийн хувьд байдгийг тайлбарлаж өгсөн. Байгалиасаа цэвэр эсвэл бузар гэсэн зүйл хоол хүнсэнд байдаггүй. Ер нь аливаа зүйл өөртөө бузар муу юм агуулдаггүй. Харин буруугаар ашиглагдах үедээ бузар муу болж хувирдаг. Хүний идсэн хоол **ам уруу ороод гэдсэнд очиж**, дараа нь ялгадас болон гадагшилж, эцэстээ газарт шингэн **арилдаг**. Үүнээс болж сэтгэл нь сэвтэхгүй, ёс суртахуун нь доройтохгүй. Идсэн хоол зөвхөн биед нөлөөлнө. “Бурханаар бүтээгдсэн юм бүхэн сайхан. Хэрэв тэдгээрийг талархалтайгаар хүлээн авсан бол гологдох ямар ч зүйл байхгүй.

Учир нь энэ нь Бурханы үгээр ба залбирлаар ариусгагддаг” (1Тимот 4:4, 5) гэдгийг эдүгээ бид мэдэх болсон. Гэхдээ энэ хэсэгт хортой хоол хүнс, ургамал ногооны тухай яриагүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Харин Бурханы тогтоосон, хүний идэж болох хоол хүнсийг ярьж байна. Тэр бүхэн бүгд сайхан учраас талархалтайгаар идэх хэрэгтэй. Гэхдээ тухайн хүн харшилдаг зүйлээ идэх хэрэггүй. Бас дургүй зүйлээ ч идэх хэрэггүй. Бурхан бидний биеийг тэжээн тэтгэхийн тулд хүнс болгон ашиглаж байгаа гэсэн зүйлээ л идэх нь зүйтэй.

**[15:18]** Хэрэв хоол хүнс хүнийг бузарладаггүй юм бол юу бузарладаг гэж? Эзэн Есүс дараах хариуг өгч байна: **“Амнаас гарах зүйл зүрхнээс гарч, тэдгээр нь хүнийг бузарладаг.”** Энд ярьж байгаа зүрх гэж цус шахдаг эрхтнийг яриагүй. Харин хүмүүний хүсэл бодлын ялзарсан эх сурвалж болох сэтгэлийг хэлж байна. Хүмүүний энэ ялзарсан сэтгэлээс бузар бодол ургаж, тэр нь амнаас үг болон гарч, үйлдэл болон илэрдэг.

**[15:19, 20]** Хүнийг бузарладаг зарим зүйлийг дурдвал, **хорон муу бодол, аллага, завхайрал, садар самуун, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг зэрэг нь юм.**

Фарисайчууд ба хуулийн багш нар гар угаах мэтийн гадна талын цэвэр ариун байдлыг чухалчлан сахиж, хүмүүсийн өмнө зөв сайхан мэт харагдавч дотор талдаа бохир заваанаар дүүрэн байв. Тэд ач холбогдол багатай зүйлд

мэргэжилтэн болсон боловч үнэхээрийн чухлыг нь орхигдуулжээ. Ахмадын ёс заншлыг сахисангүй хэмээн Есүсийн шавь нарыг буруутгаж байсан атлаа тэд Бурханы Хүүг алахаар хуйвалдаж, 19 дүгээр эшлэлд жагсаасан нүглүүдийг бүгдийг нь үйлдэхдээ юу ч бодсонгүй.

### **Е. Итгэлийнхээ улмаас ерөөгдсөн харь хүн (15:21-28)**

[15:21, 22] Есүс тэндээс явж, **Тир, Сидоны нутагт**, Газар дундын тэнгисийн эрэг орчимд **ирэв**. Бидэнд мэдэгдэж байгаагаар, Эзэн Есүс иудейчүүдийн нутгаас гарч үйлчлэлээ явуулсан ганц тохиолдол энэ юм. Гэтэл нэгэн канаан эмэгтэй түүн дээр ирээд **чөтгөрт эзэмдүүлсэн охиныг** нь эдгээж өгөхийг гуйв.

Энэ эмэгтэй иудей биш, харь хүн байсныг мэдэх нь тун чухал. Тэрээр канаанчуудын удам угсаа байжээ. Канаанчууд ёс суртахууны хувьд маш муу хүмүүс байсан тул Бурхан тэднийг газрын хөрснөөс арчин хаяхыг тушаасан байдаг. Гэвч израильчуудын дуулгаваргүй байдлаас болоод Иошуагийн эзлэн түрэмгийллийн үед канаанчуудын зарим нь үлдэж хоцорчээ. Энэ эмэгтэй эсэн мэнд үлдсэн канаанчуудын үр хойч байв. Харь үндэстэн учраас Бурханы сонгосон ард түмний эдэлдэг онцгой эрхүүд түүнд байсангүй. Тэрээр ямар ч найдваргүй харь хүн байлаа. Бурханаас болон Мессиагаас ямар нэг юм нэхэх эрх бүхий байр суурь түүнд байсангүй.



Тэрээр Есүст ойртохдоо түүнийг “**Давидын Хүү Эзэн**” гэж дуудсан. Иудейчүүд Мессиагийн тухай ярихдаа энэ нэрийг ашигладаг байв. Есүс **Давидын Хүү** мөн боловч үүнд суурилан түүнд ойртох эрх харь үндэстэнд байгаагүй. Тийм учраас Эзэн Есүс эхлээд түүнд хариу өгөөгүй.

**[15:23] Тэгтэл шавь нар нь ирээд “түүнийг явуулаач”** гэж Эзэн Есүсээс гуйв. Шавь нарынх нь хувьд тэр эмэгтэй яршиг төвөг байлаа. Харин Эзэн Есүсийн хувьд бол итгэлийн үлгэр жишээ, нигүүлслийг харуулах хэрэгсэл байлаа. Гэхдээ эхлээд түүний итгэлийг тэр батлан харуулахыг хүссэн.

**[15:24, 25]** Эзэн Есүс харь үндэстэн, тэр дундаа канаанчууд уруу биш, харин **Израилийн гэрийн алдагдсан хонинууд уруу** илгээгдсэн гэдгээ түүнд сануулсан. Эзэн Есүс өөрийг нь илэрхий тээршээсэн ч тэр үүнд гутарсангүй. Харин *Давидын Хүү* гэдэг нэрийг хэлэхээ болиод түүнд мөргөн, “**Эзэн, надад туслаач**” гэв. Хэрэв Эзэн Есүс дээр Мессиагийнх нь үүднээс иудей хүний байр сууринаас очиж болохгүй юм бол Бүтээгчийнх нь үүднээс бүтээлийн байр сууринаас очих гэж хичээсэн.

**[15:26]** Иудей хүүхдүүдийн хоолыг авч, харийн **нохдод** өгөх нь **сайн** зүйл биш гэж хэлснээрээ Эзэн Есүс тэр эмэгтэйн итгэлийг жинхэнэ болохыг батлан харуулахыг зорьсон. Эзэн Есүс ийм хатуу хурц үг хэлсэн нь тэр эмэгтэйд эдгээхийн тулд байсныг мартаж болохгүй. Зүйрлэвэл, мэс заслын эмч өвчтөнийг

шархдуулах гэж биш, харин илаарьшуулах гэж хутгаар зүсдэгтэй адил юм. Эзэн Есүс энд тэжээмэл хав **нохойг** хэлдэг үгийг ашигласан. Тэр эмэгтэй “Бурханы өршөөл энэрлээс өчүүхэн төдийг ч болов хүртэх эрхгүй гэдгээ ойлгож байна уу?” гэдэг нь асуудлын гол нь байсан.

[15:27] Тэр эмэгтэй гайхалтай хариу өгсөн. Тэрээр Эзэн Есүсийн тодорхойлолтыг бүгдийг нь хүлээн зөвшөөрч, ямар ч үнэ цэнгүй харь үндэстэн гэдэг байр суурин дээр очоод, Эзэн Есүсийн өршөөл, хайр, нигүүлсэлд өөрийгөө даатгасан. Түүний үгийг багахан өөрчлөөд сийрүүлбэл дараах байдлаар хэлж болно: “Таны хэлж байгаа үнэн. Би бол ширээний доор байдаг **нохдын** нэг мөн. Гэхдээ заримдаа **ширээнээс** хоол хүнсний хаягдал **үйрмэг** шалан дээр **унадгийг** би мэднэ. Тэрхүү үйрмэгээс идэхийг маань та зөвшөөрөхгүй гэж үү? Охиноо эдгээлгэх зохистой хүн би биш. Гэхдээ зохисгүй бүтээлдээ та үүнийг хийж өгөөч хэмээн би танаас гуйж байна.”

[15:28] Эзэн Есүс түүний **агуу итгэлийн** дагуу үйлдэв. Үл итгэгч хүүхдүүд талхандаа цатгалдан байхад өөрийгөө “нохой” болохыг хүлээн зөвшөөрсөн зарим нь тэр талхны төлөө хашхирч байх нь энэ. Тэр эмэгтэйн итгэл шагнагдаж, охин нь тэр даруй **эдгэрэв**. Эзэн маань харь үндэстэн эмэгтэйн охиныг алс зайнаас эдгээсэн нь энэ үед хийж байгаа үйлчлэлтэй нь адил байна. Тэрээр Бурханы баруун гарт залран байгаа бөгөөд өнө эртнээс

сонгосон ард түмнээ түр хажуу тийш тавин, харь үндэстнүүдэд сүнслэг эдгэрлийг өгч байна.

**Ё. Эзэн Есүс олон хүнийг эдгээсэн нь (15:29-31)**

Марк 7:31-ийг үзвэл Эзэн Есүс Тирээс хойш гараад Сидон уруу явж, дараа нь өмнө зүгт, Иорданы зүүнтэйд байрлах Декапольд очсон байна. Тэнд Галил нуурын ойролцоо **догolon, тахир дутуу, сохор, дүлий** болон өөр янз бүрийн өвчтэй хүмүүсийг тэр эдгээв. Гайхан шагширсан олон түмэн **Израилийн Бурханыг алдаршууллаа**. Хүмүүс ийм нааштай хүлээн авсан энэ явдал харь үндэстнүүдийн суудаг нутагт болсон билээ. Тэр хүмүүс Эзэн Есүс ба түүний шавь нарыг израильчууд гэдгийг мэдэж байсан учраас өөрсдийнх нь дунд **Израилийн Бурхан** ажиллаж байна хэмээн зөв дүгнэсэн юм.

**Ж. Дөрвөн мянган хүнийг хооллосон нь (15:32-39)**

[15:32] Библийг уншихдаа өнгөц (эсвэл шүүмжлэлтэй) ханддаг хүмүүс энд гарч байгаа үйл явдлыг 5,000 хүн хооллосон явдалтай хольж хутган, Библи нэг зүйлээ хоёр давтсан, хоорондоо зөрчилдөх зүйл бичсэн, тооцоолол алдсан зэргээр Библийг буруутгадаг. Гэвч энэ хоёр нь өөр өөр үйл явдал юм. Тиймээс энэ хоёр үйл явдлыг тэмдэглэсэн нь бие биетэйгээ зөрчилдөөгүйн дээр нэгээр нь нөгөөг нь ойлгоход дэм болдог.

**Хурсан олон** Эзэн Есүстэй хамт гурван өдөр байсны эцэст хүнс хоолоо барав. Эзэн Есүс тэднийг өлсгөлөн байдалтай явуулж, **замдаа** сульдахыг нь хүссэнгүй.

[15:33, 34] Ийм олон хүнийг хооллох боломжгүй энэ даалгаврыг хэрхэн биелүүлэх вэ гэдэг дээр **шавь нар** нь дахиад л арга мухардав. Энэ удаа тэдэнд **долоон** талх, **хэдэн жижиг загас** байлаа.

[15:35, 36] Эзэн Есүс 5,000 хүнийг хооллосон шигээ хүмүүсийг газар суулгаад, Бурханд **талархлаа өргөн, талх, загасыг хувааж**, хүмүүст тараа гээд **шавь нартаа өгөв**. Эзэн Есүс шавь нараа чадах зүйлсээ хийгээсэй гэж хүсдэг. Шавь нар нь чадахыгаа хийсний дараа Тэр өөрөө үйлдсэнийг нь гартаа авч, шавь нарынхаа чадахгүйг хийж өгдөг.

[15:37-39] Хүмүүсийг **цадсаны** дараа илүү гарсан хүнсийг **цуглуулахад долоон том сагс дүүрэв**. Хооллосон хүмүүс нь **эмэгтэйчүүд, хүүхдүүдээс гадна дөрвөн мянган эрчүүд** байв.

Хүмүүсийг хооллосон энэ хоёр үйл явдалд дурдагдсан тоон үзүүлэлт дараагийн бүлэгт (16:8-12) нэлээн чухал ач холбогдолтой байдаг. Библид утга учиргүйгээр дурдагдсан зүйл гэж нэг ч үгүй. Хүмүүсийг явсны дараа Эзэн Есүс **завинд** суугаад Галил нуурын баруун эрэг дээрх **Магадан** уруу явав.

### 3. Фарисайчууд ба садукайчуудын исгэх хөрөнгө (16:1-12)

[16:1] Фарисайчууд ба садукайчууд нь баримталдаг онол сургаалынхаа хувьд хоёр өөр туйл байсан учир теологийн асуудал дээр үргэлж зөрчилддөг байв. Гэвч Аврагч Эзэний эсрэг өвөрлөсөн хорсол нь тэднийг хамтран ажиллахад хүргэжээ. Түүнийг туршихын тулд тэд **тэнгэрээс тэмдэг үзүүлэхийг гуйв**. Тэд түүнийг буулт хийхүйц байдалд оруулахыг зорьж байсан. **Тэнгэрээс тэмдэг үзүүлэхийг гуйснаараа** хийж байгаа гайхамшгууд нь тэнгэрийнх биш гэдгийг харуулахыг зорьсон ч байж болох юм. Эсвэл тэнгэрт ямар нэг гайхамшиг үзүүлэхийг гуйсан ч байж болно. Эзэн Есүсийн хийсэн гайхамшгууд бүгдээрээ газар дээр болж байсан. Тэрээр тэнгэрийн эрхсүүд дээр ч гэсэн гайхамшиг үйлдэж чадах уу хэмээн тэд сорьсон бололтой.

[16:2, 3] Эзэн Есүс тэдэнд хариулахдаа тэнгэрт үзэгддэг шинж тэмдгийг авч үзсэн. **Орой нь тэнгэр улаан** байвал маргааш өдөр **цэлмэг болно** гэж хүмүүс хэлж чаддаг. Эсвэл **өглөө нь тэнгэр улаан, бүрхэг** байвал тэр өдөр **шуургатай** байх нь гэж ярьдаг.<sup>32</sup> Тэд тэнгэрийн шинж тэмдгийг тайлбарлаж чаддаг мөртлөө **цаг үеийн тэмдгүүдийг ялгаж** чаддаггүй.

Тэдэнд ямар тэмдгүүд өгөгдсөн байсан бэ? Мессиагийн ирэлтийг зарлан тунхагласан эш үзүүлэгч Иохан Баптист бол нэг тэмдэг. Мессиагийн талаарх эш үзүүлэлт дурдагдсан гайхамшгууд нүднийх нь өмнө үйлдэгдэж

байсан нь бас нэг тэмдэг. Тийм гайхамшгуудыг өөр ямар ч хүн үйлдээгүй юм. Цаг үеийн өөр нэг тэмдэг бол иудейчүүд Мессиагаас илэрхий татгалзаж, сайнмэдээ харь үндэстнүүд уруу эргэсэн явдал. Энэ бүгд эш үзүүллэгийн биелэл байсан. Хэн ч харсан ойлгож болохоор илэрхий баталгаа нотолгоо байсаар байхад тэд түүхийн явцыг ч ойлгосонгүй, эш үзүүллэгийн биеллийг ч харсангүй.

**[16:4]** Өгөгдсөн тэмдэг дунд нь зогсож байхад тэмдэг гуйснаараа фарисайчууд ба садукайчууд бузар муу, сүнсний хувьд **завхай үеийнхэн** гэдгээ харуулав. Тиймээс тэдэнд одоо **эш үзүүлэгч Ионагийн тэмдгээс өөр тэмдэг өгөхгүй**. Энэ нь гурав дахь өдрөө дахин амилах амиллыг нь хэлсэн. Үүнийг 12:39 дээр тайлбарласан. **Бузар болон завхай үеийнхэн** Мессиагаа цовдлох боловч Бурхан Түүнийг үхлээс амилуулна. Түүнд мөргөхөөс татгалзсан бүгдийн сүйрлийн тэмдэг энэ болой.

**“Тэр тэднийг орхин явлаа”** гэсэн үгээр энэ хэсэг төгссөн нь тун чухал байгаа юм. Энэ үг чухал сүнслэг утга санааг агуулж байдаг.

**[16:5, 6]** **Шавь нар нь** нуурын зүүн талд Эзэн Есүстэй уулзахдаа хүнс авахаа мартсан байжээ. Тэр үед Эзэн Есүс тэдэнтэй мэндлэхдээ **“фарисай болон садукайчуудын хөрөнгөнөөс сэрэмжил”** гэж хэлснийг тэд буруугаар ойлгон, **“Иудейчүүдийн удирдагчид дээр очиж хүнс гуйх хэрэггүй”** хэмээн хэлж байна гэж боджээ. Тэд Есүстэй уулзахдаа хүнсний талаар бодож байсан

учраас хэлсэн үгийг нь шууд утгаар нь хүлээн авав. Харин Эзэн тэдэнд сүнслэг сургамжийг өгч байв.

**[16:7-10]** Эзэн Есүс 5000 болон 4000 хүнийг хооллож байсныг мэдсээр байж шавь нар нь хоол хүнсний тухайд санаа зовсоор байв. Тиймээс Эзэн Есүс энэ хоёр үйл явдлыг тэдэнд дахин сануулсан. Тэрхүү үйл явдлууд бидэнд тэнгэрийн арифметик ба Бурханы арга ухааныг зааж өгдөг. Юу гэвэл, *Эзэн Есүс багыг ашиглах тусмаа олныг хооллож, цаана нь илүү их хүнс үлдсэн.* Таван талх, хоёр загас байхад тэр 5000 гаруй хүнийг хооллож, дараа нь 12 сагс хүнс илүү гарсан. Гэтэл талх, загас нь олон болоход 4000 гаруй хүнийг хооллож, 7 сагс хүнс үлдсэн. Хэрвээ бид өөрсдийн хязгаарлагдмал нөөцөө Түүний мэдэлд тавих юм бол өгсөн зүйлсийн маань тоо хэмжээг тэр урвуу пропорционалиар арвижуулж өгдөг. “Бурханыг агуулсан бага юм нь үнэндээ их юм мөн.”

Таван мянган хүнийг хооллосон тухай хэсэг эх грек дээрээ энд гардгаас өөр үгийг **сагс**<sup>33</sup> гэхэд ашигласан. Энэ тохиолдолд гарч буй долоон сагсыг өмнөх тохиолдлын 12 сагснаас том байсан гэж үздэг. Гэсэн ч энэ хоёр түүхийн хэлж байгаа сургамж хэвээр үлдэнэ: “Хэрэв бид хязгааргүй хүч чадал ба дуусашгүй нөөц баялагтай нэгэнд холбогдсон юм бол юунд идэх юманд санаа зовниж, хоол хүнсийг эрмэлзэн амьдарна вэ?”

**[16:11, 12]**Фарисай болон садикайчуудын хөрөнгө гэж хэлэхдээ Эзэн Есүс талхны тухай бус, гаж буруу сургаал, бузар муу зан хандлагын тухай ярьжээ. Лук 12:1-д фарисайчуудын хөрөнгө нь хоёр нүүртэй байдлыг хэлсэн. Тэд хамгийн жижиг зүйл дээр хүртэл Бурханы үгийг баримтлагтун гэж номлодог байсан атлаа өөрсдөө Бурханд дуулгаваргүй байж, зөвхөн гадна талын өнгөн зүйлсэд анхаарал хандуулж байв. Гэтэл тэдний дотор тал нь бузар муу хийгээд ялзралаар дүүрэн ажээ.

Харин садикайчуудын хөрөнгө гэдэг нь рационализм. Садикайчууд бол тухайн үеийнхээ чөлөөт сэтгэгчид, өнөөгийнхөөр бол либералистууд юм. Тэд логикоор бодох, эргэлзэж тээнэгэлзэх, үгүйсгэн шүүмжлэх тухай бүхэл бүтэн цогц онол сургаалыг бий болгожээ. Тэд тэнгэрэлч хийгээд сүнс оршин байдгийг үгүйсгэж, биеийн амилал, сүнсний үхэшгүй байдал, мөнх шийтгэл байхгүй гэж үзсэн. Тэдний энэ хөнөөлт үзэл санааг хүлээн авбал гурилд хийсэн хөрөнгө адил тархаж, гурилыг бүхэлд нь исгэх болно.

## **Х. ДАГАЛДАГЧДАА БЭЛТГЭЖ БУЙ ХААН (16:13-17:27)**

### **А. Петрийн мэдэгдэл (16:13-20)**

**[16:13, 14]**Цезарь Филлиппийн нутаг нь Галил нуурын хойд зүгт ойролцоогоор дөчин километр, Иорданаас найман километр



оршино. Эзэн Есүс ойр орчмынх нь тосгодоор явав (Марк 8:27). Энэ үед болсон үйл явдлыг Түүний заах үйлчлэлийн оргил гэж үздэг. Энэ мөчийг хүртэл Тэрээр дагалдагчдадаа өөрийн мөн чанарыг үнэн зөв ойлгуулахад гол анхаарлаа хандуулж байсан. Харин энэ зорилгоо биелүүлсэн учраас одоо Тэр эргэлт буцалтгүй загалмайг зорихоор тийш нүүрээ хандуулжээ.

**Шавь нараасаа** Тэр, хүмүүс Хүний Хүүг юу гэж ярьж байна гэж асуухад тэд **“Иохан Баптист, Елиа, Иеремиа, эш үзүүлэгчдийн нэг”** гэх мэт янз бүрийн хариу өгөв. Эзэн Есүс хүмүүсийн хувьд олны дундах ердийн л нэгэн байжээ. Хамгийн сайн түүнийг хүмүүс зүгээр л нэг сайн хүн гэж бодож байв. Хамгийн агуу түүнийг хүмүүс нэг агуу хүн гэж бодож байв. Хуучин гэрээнд зөгнөгдсөн *өнөөх* Эш үзүүлэгч түүнийг хүмүүс эш үзүүлэгчдийн нэг гэж бодож байв. Энэ бүхэн бүгдээр буруу бодол байсан. Тэд дулимагхан магтаалаар Түүний үнэ цэнийг уландаа гишгэжээ. Хэрэв Тэр ердийн нэг хүн байсан бол өөрийгөө Эцэг Бурхантай энэ тэнцүү гэж тунхагласнаараа хуурамч нэгэн болно.

[16:15, 16]Тиймээс Тэр шавь нараасаа өөрийнхөө хэн болохыг асуусан. Үүнд нь **Симон Петр** хариулахдаа, **“Та бол Христ, Амьд Бурханы Хүү мөн”** гэсэн түүхэн тунхаглалаа хэлжээ. Өөрөөр хэлбэл, Тэр бол Израилийн Мессиа, Хүү Бурхан байжээ.

[16:17, 18]Тэгэхэд Эзэн маань **Ионагийн** хүү **Симон** дээр ивээлээ тунхагласан. Эзэн Есүсийн

тухай энэхүү илчлэлийг Симон Петр өөрийн оюун ухаанаас эсвэл төрөлх мэргэн ухаанаараа олж аваагүй юм. Үүнийг түүнд **Эцэг** Бурхан ер бусын байдлаар илчилжээ. Харин Петрт хандан хэлэх бас нэгэн чухал зүйл Хүүд байв. Юу гэвэл, Эзэн Есүс түүн дээр нэмж, **“Би мөн чамд хэлье. Чи Петр. Энэ хадан дээр би чуулганаа босгох бөгөөд түүнийг үхэгсдийн орны хаалга дийлэхгүй”** гэлээ. Матайн сайнмэдээнээс хамгийн их санал зөрдөг эшлэл бол энэ гэдгийг бид мэднэ. **“Хад** гэж хэнийг эсвэл юуг хэлсэн бэ?” гэдэгт гол асуудал байдаг. Грек хэлэнд Петр, хад хоёрыг илэрхийлдэг үг төстэй учраас хүмүүс төөрч будилаад байдаг. Гэхдээ энэ хоёр үг өөр өөр утгатай. *Петрос* гэдэг нь чулуу гэсэн утгатай. Харин *петра* гэдэг нь хад гэсэн утгатай. Тэгэхээр Есүс юу гэж хэлсэн бэ гэвэл: **“... чи бол Петр (чулуу). Энэ хадан дээр Би чуулганаа босгоно.”** Тэр чуулганаа чулуун дээр бус, хадан дээр барина гэсэн юм.

Хэрэв Петр хад биш юм бол хад гэж юуг хэлсэн бэ? Хэрвээ бид хам сэдвээ харвал “Христийг амьд Бурханы Хүү мөн” гэсэн Петрийн мэдэгдэл бол өнөөх хад гэдэг нь тодорхой байна. Эзэн Есүс энэ хадан дээр чуулганаа барина. Чуулган нь булангийн чулуу болох Есүс Христ дээр чуулган баригдаж байгааг Ефес 2:20 дээр хэлсэн. Энд биднийг “бид элч нар, эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байна” гэж хэлэхдээ элч нар ба эш үзүүлэгчдийг суурь гээгүй, харин элч нар ба эш үзүүлэгчдийн зааж

байсан Эзэн Есүс Христийн тухай сургаалыг суурь гэсэн болно.

1Коринт 10:4 дээр Есүсийг Хад гэж нэрлэсэн. Үүнтэй холбогдуулан Морган тун тустай зүйл хэлсэн. Тэр нь:

Тэрээр иудейчуудад хандан ярьж байсныг сана. Хэрэв бид еврей бичвэрүүдийг нягтлан үзээд хад гэдэг үгийг шилжсэн утгаар ашигласан хэсгүүдийг ажиглавал хүнийг бэлгэдэхэд ашигласан тохиолдол нэгийг ч олж харахгүй. Хад гэдэг үг зөвхөн Бурханыг төлөөлдөг. Тиймээс Цезарь Филиппийн нутагт Эзэн Есүс, чуулганаа Петр дээр барина гэж хэлээгүй юм. Есүс үгийг хамаа намаагүй утгаар ашиглахгүй. Тэрээр еврей бичвэрт танил болсон дүрслэл буюу үргэлж Бурхантай холбон ярьдаг Хад хэмээх үгийг авч, “Амьд Бурханы Хүү болох Христ би чуулганаа Бурхан дээр барина” гэж хэлжээ.<sup>34</sup>

Петр өөрийгөө чуулганы суурь гэж хэзээ ч ярьж байгаагүй. Тэр Эзэн Есүсийг хоёр удаа чулуутай адилтгасан (Үйлс 4:11, 12; 1Петр 2:4-8). Гэхдээ дүрслэл нь ондоо. Энэ хоёр хэсэгт чулуу нь суурийг бус, булангийн чулууг хэлсэн байна.

**“Би чуулганаа босгоно.” Чуулган** гэх үг Библид хамгийн анх энд гардаг. Хуучин гэрээнд энэ үг байхгүй. Чуулганыг Есүс ирээдүй цаг дээр ярьсан. Чуулган нь Пентэкостын өдөр байгуулагдсан бөгөөд иудей болон харь үндэстний доторх бүх жинхэнэ итгэгчдээс

бүрдэнэ. Чуулган бол Христийн сүйт бүсгүй ба бие юм. Түүнд маш онцгой тэнгэрлэг дуудлага, хувь тавилан бий.

Матайн сайнмэдээнд чуулганы тухай өгүүлсэн зүйл бараг үгүй. Харин Израиль болон хаанчлалын талаар голлон өгүүлдэг. Гэхдээ Израиль Христийг хүлээн авахаас татгалзсаны улмаас чуулганы үе хэмээх тодорхой нэг хугацаа гарч ирсэн бөгөөд энэ нь итгэгчдийн шүүрэлт хүртэл үргэлжилнэ. Дараа нь Бурхан Израильд хандсан төлөвлөгөөгөө дахин хэрэгжүүлж эхэлнэ. Тиймээс Израиль Христээс татгалзахад Бурхан диспенсаци хөтөлбөрийнхөө дараагийн алхам болгож чуулганыг танилцуулжээ. Ингэж үзвэл Библийг ойлгоход хамгийн тохиромжтой байна.

**“Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй”** гэдгийг хоёр янзаар ойлгож болно. Нэг: **үхэгсдийн орны хаалга** гэдэг нь чуулганы эсрэг хийсэн амжилтгүй довтолгоонуудын дүрслэл. Эдгээр дайралтуудаас болж чуулган мөхөхгүй. Хоёр: Чуулган өөрөө дайрагч этгээд болж, ялалтад хүрнэ гэсэн дүрслэл. Аль ч талаас нь үзсэн, амьд итгэгчдийн хувиралт ба Христийн дотор үхэгсдийн амиллаар дамжуулж үхлийн хүч устгагдах болно.

**[16:19] “Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө”** гэсэн нь хүмүүсийг тэнгэрт нэвтрүүлэх эрх мэдлийг Петр авсан гэдэг утга агуулдаггүй. Энэ нь *газар дээр буй тэнгэрийн хаанчлалд* хамаатай. Өөрөөр хэлбэл, Хаанд

үнэнч гэсэн хүмүүст, Христэд итгэнэ гэсэн хүмүүст хамаатай. Орох, нэвтрэх зүйлд **түлхүүр** хэрэгтэй. Христийн харьяанд орохоо хүлээн зөвшөөрөгсдийн хүрээлэлд орох үүдийг нээгч түлхүүрүүдийг агуу захирамжид (Матай 28:19) дурджээ. Тэдгээр түлхүүр нь шавь болгох, баптисм хүртээх, зааж сургах юм (Баптисмыг аврагдахын тулд хийдэггүй. Харин Хааны харьяат болж байгаагаа олон нийтэд батлан харуулж байгаа удиртгал маягийн ёслол юм). Петр эдгээр түлхүүрийг анх Пентэкостын өдөр ашигласан. Гэхдээ эдгээр түлхүүрийг түүнд зөвхөн өгөөгүй. Харин дагалдагчдад бүгдэд нь өгчээ (Матай 18:18-г харвал бүх дагалдагчдад адил амлалт өгөгдсөн байна.)

**“Чи газар дээр юуг холбоно тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна тэр нь тэнгэрт тайлагдана.”** Үүнийг Иохан 20:23 дугаар эшлэлтэй хамт ашиглаж, Петр болон түүний залгамжлагч нарт нүглийг уучлах эрх мэдэл өгөгдсөн гэж заадаг байна. Ийм байх боломжгүйг бид мэднэ. Нүглийг зөвхөн Бурхан уучилдаг.

Энэ эшлэлийг хоёр янзаар ойлгож болно. Нэг: Өнөөгийн бидэнд байхгүй ч, элч нарт байсан тайлах, холбох эрх мэдлийг энд ярьсан байж болно. Энд Петрийн жишээг дурдаж болно. Тэрээр Ананиа, Сапфир хоёрт нүглийг холбосон тул тэд шийтгэл авч, тэр дороо нас барсан (Үйлс 5:1-10). Бас Паул Коринтын чуулганы сахилгажуулагдсан эрийг нүглийнх нь үр

дагавраас тайлсан. Яагаад гэвэл тэр хүн гэмшсэн (2 Коринт 2:10).

Хоёр: Элч нарын газар дээр холбосон, тайлсан аливаа зүйл угаасаа тэнгэрт холбогдчихсон, тайлагдчихсан байсан зүйлс гэсэн утгатай байж болно (NKJV орчуулгын хажуугийн тайлбарыг үз). Райри энэ тухай: “Холбох, тайлах бүхэн нь элч нараас бус, тэнгэрээс эхтэй. Харин элч нар тэдгээрийг зарладаг” гэж хэлжээ.

Өнөөдөр энэ эшлэлийг сайнмэдээг *тунхаглахад* бодит утгаар нь ашиглаж болно. Нүгэлт хүн үнэн сэтгэлээс нүглээ гэмшээд, Есүс Христийг Эзэн ба Аврагчаа болгон хүлээн авбал гэм нүгэл нь уучлагдана хэмээн итгэгч хүн *тунхаглаж болно*. Харин Аврагчийг хүлээн авахаас татгалзвал нүглийн уучлал байхгүй хэмээн Христийн үйлчлэгч хүн *тунхаглах эрхтэй*. Уилльям Келли: “Чуулган үнэхээр Эзэний нэрээр ажиллаж, Түүний хүслийг үйлдэх юм бол үйлсийнх нь дээр Бурхан тамгаа дарах болно” гэж бичжээ.

**[16:20]** Эзэн Есүс өөрийг нь Христ гэдгийг **хэнд ч бүү хэл** гэж **шавь нартаа** тушааж байна. Израиль итгэлгүй байгаа тул ингэж хэлснээр сайн үр дүн гарахгүй байсан. Түүнийг хаан болгох гэсэн ард түмний бослого хөдөлгөөнөөс болж хор хохиролтой үр дагавар гарч мэднэ. Цагаа олоогүй ийм хөдөлгөөн ромчуудын гарт нухчин дарагдах болно.

Энэ бүлгийг Есүсийн үйлчлэлийн эргэлтийн цэг гэж нэрлэсэн Стюард дараах зүйлийг бичсэн:

Цезарь Филиппийн нутагт ирсэн тэр өдрөөс хойш сайнмэдээний номуудад өөр өнгө аяс орж ирдэг. Эндээс эхлээд урсгал өөр чиглэлд урсаж эхэлдэг. Үйлчлэлийнхээ эхэн үед хаан ширээнд ч суусан болохоор байсан олны тэр дэмжлэг нэгэнт ард хоцорчээ. Давлагаа одоо загалмай уруу чиглэж байна. Цезарь Филиппийн нутагт Есүс хоёр мөчлөгийн зааг дээр зогсож байв. Туулсан бүх замаа эргэн харахын сацуу өмнөө дурайх хар бараан замыг ч харж болох өндөр уулын орой гэлтэй. Хойшоо нэг харахад баяр хөөртэй өдрүүд нь гэрэлтэн зурайна. Гэсэн ч тэр харцаа урагш чиглүүлж, өмнөө харагдах сүүдэр уруу алхан оров. Одоо тэр Голготыг зорин явж байна.<sup>36</sup>

## **Б. Эзэн Есүс шавь нараа өөрийн үхэл ба амилалд бэлтгэсэн нь (16:21-23)**

**[16:21]** Есүс бол Мессиа, амьд Бурханы Хүү гэдгийг шавь нар нь ойлгожээ. Тиймээс үхэл ба амиллынхаа талаар шууд ярихыг нь сонсоход тэд бэлэн болжээ. Тэд Бурханы зорилго гарцаагүй биелнэ гэдгийг мэдэх болсон. Ялагч талд орсноо, юу ч болсон ялалт ирнэ гэдгийг ч мэдэх болсон. Тиймээс бэлэн болсон сэтгэлд нь Эзэн Есүс одоо өөр нэгэн мэдээг задалж байна. Тэрээр **Иерусалим уруу явж**, шашны удирдагчдын гараас **их зовлон амсан, алуулж**,

**гурав дахь хоног дээрээ амилах ёстойгоо** шавь нартаа хэлэв. Хэрэв хамгийн сүүлд **гурав дахь хоног дээрээ амилах ёстой** гэж хэлээгүй байсан бол Эзэн Есүсийн үг бүхэлдээ ямар ч найдваргүй мөхлийн мэдээ болох байв. Харин амилах ёстой гэсэн нь бүхнийг өөрчилж байна.

**[16:22]** Багш нь зовлон амсаж, үхнэ гэдэг үг Петрт таалагдсангүй. Тиймээс тэр Эзэн Есүсийг татаж авчраад, замд нь хөндөлсөж, **“Эзэн минь, Таныг Бурхан өршөөг. Ийм юм танд хэзээ ч тохиолдохгүй”** гэв.

**[16:23]** Харин Эзэн Есүс үүнийг нь зэмлэв. Тэрээр нүгэлтнүүдийн төлөө үхэхээр энэ ертөнцөд ирсэн. Энэ зорилгод саад бологч хэн ч бай, юу ч бай Бурханы хүсэлд харшлагч болно. Тиймээс Петрт Тэр **“Миний араас зайл, Сатан аа! Чи надад бүдрэх чулуу болж байна. Учир нь чи Бурханы юмыг бус, харин хүнийхийг л боддог”** гэлээ. Эзэн Есүс элч Петрийг **Сатан** гэж дуудахдаа түүнийг чөтгөрт эзэмдүүлсэн юм уу Сатанаар удирдуулдаг гэсэн утгаар хэлээгүй. Харин Сатанаас (энэ нь дайсан гэсэн утгатай нэр) гармаар үг ба үйлдэл Петрээс гарсан гэдгийг илэрхийлсэн. Петр Голгота уруу явахыг нь эсэргүүцсэнээрээ Аврагч Эзэний урд хөндөлсөж байв.

Итгэгч хүн бүр загалмайгаа аваад Эзэн Есүсийг дагахаар дуудагдсан билээ. Харин урдаа байгаа загалмайн зүг явах гэхэд маань **“Тийш бүү оч, тэгвэл аюулгүй”** гэсэн дуу хоолой дотроос гарах юм уу хайртай дотнын хүмүүс



маань дуулгавартай байдлын замаас биднийг холдуулах гэвэл бид ч бас “Миний араас зайл, Сатан аа! Чи надад бүдрэх чулуу болж байна” гэж хэлэх ёстой.

**В. Жинхэнэ дагалдагч байхад бэлтгэсэн нь (16:24-28)**

[16:24] Энд Эзэн Есүс өөрийнх нь дагалдагчдад юу шаардлагатайг тодорхой мэдэгдсэн. Христийн жинхэнэ дагалдагч хүн өөрийгөө үгүйсгэж, загалмайгаа үүрээд Эзэн Есүсийг дагах ёстой. Өөрийгөө **үгүйсгэх** гэж өөрийгөө үзэн ядах юм уу өөрийгөө гаргуунд нь хаяхыг хэлээгүй. Харин өөртөө ямар ч эрх үлдээлгүйгээр бүх удирдлагыг Эзэн Есүсийн гарт өгөхийг хэлнэ. **Загалмайгаа үүрэх** гэдэг нь ичгүүр, зовлонг амсахаас халшрахгүй байх, бүр цаашилбал Эзэний төлөө үхэхэд бэлэн байхыг хэлнэ. Бас нүглийн хувьд, махбодын хувьд, энэ ертөнцийн хувьд үхэхийг хэлнэ. Түүнийг **дагах** гэдэг нь Эзэн Есүсийн адил амьдрахыг хэлнэ. Тэрээр даруу төлөв, ядуу хоосон, сайхан сэтгэлтэй байж, хайр энэрэл, өршөөл нигүүлслийг үзүүлж, бурханлаг чанар бүхнээр дүүрэн амьдарсан.

[16:25] Дагалдагч байхад саад болох зүйлийг Эзэн урьдаас хэлжээ. Тухгүйдтэл, өвдөлт, ганцаардал, алдагдал зэргээс өөрийгөө **аврах** гэсэн уруу татлага бол нэг дэх саад. Хоёрт гэвэл, баян болох гэсэн хүсэл. Хувиа хичээсэн зорилгоор амиасаа зуурсан хүн үнэндээ амиа

олохгүй гэдгийг Эзэн Есүс анхааруулж байна. Харин Эзэн Есүст амиа даатгасан хүн түүнийгээ хэзээ ч үрэн таран хийхгүй.

**[16:26]** Хоёр дахь уруу татлага буюу баян болох гэсэн хүсэл нь үнэндээ мунхаглал юм. “Ажил бизнес нь амжилт олж **бүх дэлхийг** өөрийн болгосон **хүн** байлаа гэж бодъё. Гэвч үүндээ хүрэхийн тулд асар их цаг хугацаа, эрч хүчийг зарцуулах тул амьдралын гол утга учрыг орхигдуулна. Тэгээд эцэст нь зорилгодоо хүрлээ ч нэгэнт нас барвал бүхнийг орхиж, хорвоогоос юу ч авч явж чадахгүй. Тэгвэл тэр их зүйлийг олж авахын ашиг юу байсан юм бэ?” хэмээн Эзэн Есүс асууж байна. Дагалдагч хүн энэ дэлхий дээр мөнгө олохоос ч илүү чухал зүйлийн төлөө амьдарч байна. Тэрээр Хааныхаа хүсэл сонирхлыг тусган харуулахаар дуудагджээ. Энэ дуудлагыг алдвал тэр бүхнээ алдаж байгаа нь тэр билээ.

Эзэн Есүс 24 дүгээр эшлэлд хамгийн мууг нь ярьсан. Энэ бол христитгэлийн шинж чанар. Та эхлэхдээ хамгийн мууг нь мэднэ. Харин түүгээр явж эхэлмэгц үнэт эрдэнэс хийгээд ивээл ерөөлтэй учирсаар байх болно. Барнхаус энэ тухай маш сайхан илэрхийлжээ:

Итгэлийн амьдралаар амьдрахад тулгарах таагүй бүхнийг бичвэрийн дотроос ойлгон хүлээн зөвшөөрсөн хүн тэдгээртэй тулгарахдаа огт гайхахгүй сэтгэлийн бэлтгэлтэй байдаг. Нэгэнт хамгийн мууг нь

хүлээн зөвшөөрсөн бол энэ амьдрал болоод ирэх амьдралаас сурах шинэ юм бүхэн нь баяр хөөр болдог.<sup>37</sup>

**[16:27]** Эзэн Есүс зовлон амссаныхаа дараа **алдар**, сүр жавхланд орох тухайгаа энд мэдэгдэж байна. **Эцэгийнхээ алдрын дотор** ер бусын байдлаар **тэнгэрэлч нарын хамт** ирэх хоёр дахь ирэлтийнхээ талаар өгүүлж байна. Тэр үедээ Эзэн Есүс өөрийнх нь төлөө амьдарсан хүмүүст **хариуг нь өгөх болно**. Яруу алдарт тэр өдөр дээр хамаг анхаарлаа хандуулан явж, тийн явахын тулд юуг чухалчлах ёстойгоо шийдэх нь итгэлийн амьдралаар амжилттай амьдрах ганц зам юм. Тэр нь итгэгч хүний амьдралын хүч болдог.

**[16:28]** Дараа нь Эзэн Есүс тун хачирхалтай мэдэгдэл хийсэн. Юу гэхээр, тэнд Эзэн Есүстэй хамт **зогсож байсан хүмүүсийн зарим нь Хүний Хүүг хаанчлалынхаа дотор ирэхийг харах хүртэл үхлийг үл амсана** гэжээ. Гэтэл тэнд байсан шавь нар одоо бүгд нас барчихсан бөгөөд Христ хаанчлалаа байгуулахаар хүч ба алдар дотор ирээгүй л байна. Хэрэв бүлгээр хуваасныг эс харгалзаад, дараагийн бүлгийн эхний найман эшлэлийг энэ мэдэгдлийн тайлбар гэж үзвэл Эзэн Есүсийн хэлсэн үгэнд ойлгомжгүй зүйл огт үгүй. Эзэн Есүс гурван шавьтайгаа уулан дээр байхад дүр нь хувирсан тухай тэр найман эшлэлд өгүүлдэг. Христийн дүр хувирсан явдлыг Петр, Иаков, Иохан нар

харжээ. Христ хаанчлалынхаа алдар дотор ямар байхыг урьдчилан харах завшаан тэдэнд олдсон нь энэ байв.

Тэгэхээр өөрийг нь хаанчлалынхаа дотор ирэхийг харах хүртэл шавь нарын зарим нь үхлийг үл амсана гэж үүнийг хэлжээ. Петр энэ үйл явдлыг дүрслэхдээ “Эзэн Есүс Христийн хүч чадал болоод Түүний ирэх тухай...” (2Петр 1:16) гэсэн үг хэрэглэжээ. Эзэн Есүсийн хүч чадал ба ирэлт гэж түүний хоёр дахь удаагийн залралыг хэлдэг. Харин Иохан “...бид түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар...” (Иохан 1:14) гэж хэлэхдээ уулан дээр үзсэн зүйлээ ярьсан бололтой. Христ эхний ирэлтдээ алдар жавхлантай бус, дорд байсан. Харин Түүний хоёр дахь ирэлт яруу алдартай байх болно. Тэгэхээр Петр, Иаков, Иохан нар уулан дээр байхдаа Хүний Хүүг дорд нэгэн Назар хүнээр бус, алдар жавхлантай Хаан байдлаар харсныг 28 дугаар эшлэлийн үгийн биелэл гэж үзэх нь зөв.

### **Г. Шавь нараа өөрийн алдарт бэлтгэсэн нь: Эзэн Есүсийн дүр хувирав (17:1-8)**

[17:1, 2] Цезарь Филиппийн нутагт болсон үйл явдлаас хойш зургаан өдрийн дараа **Есүс Петр, Иаков, Иохан нарыг дагуулан Галилын аль нэг өндөр ууланд гарав.** Библийн олон тайлбарлагчид зургаан өдөр гэдэг дээр маш их ач холбогдол өгдөг. Тухайлбал Гаебелейн дараах үгийг хэлсэн: “Зургаа бол хүний тоо. Ажлын

өдрүүдийг илэрхийлдэг. Зургаан өдрийн дараа, өөрөөр хэлбэл, ажиллах өдөр буюу хүний өдөр дууссаны дараа Эзэний өдөр болох хаанчлал эхэлдэг.”

Лук Цезарь Филипт байсан өдөр болон уулан дээр гарсан өдрийг оруулж ярьсан учраас Есүсийн дүр хувирсан явдлыг “найман өдрийн дараа” (Лук ) болсон гэж хэлсэн. Найм нь амилал ба шинэ эхлэлийн тоо учраас Лук хаанчлалыг шинэ эхлэлтэй адилтгасан бололтой.

Петр, Иаков, Иохан нар Аврагч Эзэнтэй маш ойр дотно байсан учраас түүний дүр хувирахыг харах завшаан тэдэнд олджээ. Энэ мөчийг хүртэл Түүний цог жавхлан махан биеэр халхлагдсан байв. Харин эдүгээ **Түүний нүүр ба хувцас нь нар мэт** хурц гэрэлтэж байв. Алдрын үүл буюу *шэкина* нь Хуучин гэрээний дотор Бурханы оршихуйг бэлгэдэж байсны адил Тэрээр бурхан чанараа илтгэн туяаран гялбаж байв. Эзэн Есүс өөрийн хаанчлалаа байгуулахаар ирэхдээ ямар дүртэй байхыг тэр үед шавь нартаа урьдаас харуулжээ. Хоёр дахь удаадаа тэрээр тахилын хурга мэт биш, харин Иуда овгийн арслан мэт ирнэ. Түүнийг харсан бүхэн шууд л Хүү Бурхан, хаадын Хаан, эздийн Эзэн хэмээн төвөггүй таних болно.

**[17:3]** Тэрхүү уулан дээр Мосе, Елиа нар үзэгдэж, удахгүй Иерусалимд үхэх тухай нь ярилцаж байв (Лук 9:30, 31). Мосе, Елиа хоёр Хуучин гэрээний ариун хүмүүсийг төлөөлж буй болов уу. Эсвэл, Мосе нь хуулийг, Елиа нь эш

үзүүлэгчдийг төлөөлж байсан гэж үзвэл, Хуучин гэрээний хоёр хэсэг энд Христийн амсах зовлон, түүний араас дагалдах яруу алдарт цог жавхлан уруу зааж буйг бид харж байна. Эсвэл, Мосе нас барж тэнгэр уруу явсан учраас мянган жилийн хаанчлалд орохоор үхлээс амилах хүмүүсийг илэрхийлж, Елиа нь тэнгэр уруу авагдсан учраас хувиран өөрчлөгдөх замаар хаанчлал уруу орох хүмүүсийг илэрхийлж байж болох юм.

Петр, Иаков, Иохан нар харин Шинэ гэрээний ариун хүмүүсийг төлөөлсөн. Мөн хоёр дахь ирэлтийн үеэр амьд байж, Христтэй хамт хаанчлалд орох итгэмжит иудейчүүдийн үлдэгсдийн сүүдэр болсон байж болно.

Уулын бэлд байсан хурсан олныг (14 дүгээр эшлэл; Лук 9:37-г бас үз) Христийн мянган жилийн хаанчлалын ерөөлийг хуваалцах харь үндэстнүүдтэй зүйрлэж болно.

**[17:4, 5]** Үүнийг үзсэн **Петрийн** сэтгэл машид хөдөлжээ. Тэрээр түүхийн торгон агшинд туйлын мэдрэг байв. Тэрхүү сүр жавхланг хадгалж үлдэхийг хүсэн, **гурван** дурсгалын **цацар** барьж, **нэгийг нь** Есүст, **нэгийг нь** Мосед, **нэгийг нь** Елиад зориулья гэв. Тэрээр Есүсийг эхэнд тавьсан нь зөв ч, тэр хоёроос ангид тавиагүй нь буруу байсан. Есүсийг юутай ч адилтгаж, нэг зиндаанд тавьж болохгүй. Учир нь Есүс бол бүгдийн Эзэн билээ. Бурхан тэдэнд үүнийг ойлгуулахын тулд тэднийг хурц гялбаат үүлээр бүрхэж, “Энэ бол миний хайрт Хүү мөн. Түүнд миний таалал оршдог. Түүнийг

**сонсогтун!”** хэмээн тунхаглалаа. Бурханы хаанчлалд Христ хэнтэй ч эгнэшгүй дээд байна. Тэрээр эцсийн шийдвэрлэх эрх мэдэл бүхий дээдийн дээд Эзэн Хаан байна. Тэр цаг хараахан ирээгүй байгаа ч гэлээ шавь нар нь зүрхэндээ үүнийг ойлгож байх хэрэгтэй.

**[17:6-8]** Цог жавхлант үүл ба Бурханы дуу хоолойд айн сандарсан **шавь нар нь нүүрээрээ унав.** Харин **Есүс тэдэнд бос, бүү ай гэлээ.** Тэд өндийгөөд **Есүсээс өөр хэнийг ч олж харсангүй.** Бурханы хаанчлалд ийм байх болно. Иммануелын нутгийн бүх алдар жавхлан нь Эзэн Есүс байх болно.

#### **Д. Эзэний замыг бэлдэгчийн тухай (17:9-13)**

**[17:9]** Үзсэн харснаа **үхэгсдээс амилтал нь** хэнд ч хэлж болохгүйг **Есүс тэдэнд уулнаас бууж явахдаа** тушаав. Учир нь иудейчүүд Ромын дарлалаас чөлөөлж өгөх хэнийг ч бай хамаагүй хошууран дагаж байсан учраас өөрсдийг нь ромчуудаас аварна гэвэл тэд Эзэн Есүсийг хүлээн авах байв. Харин нүглээс нь аврах Аврагчийг тэд хүлээн авахыг хүсэхгүй байжээ. Израиль өөрийн Мессиагаас бүх талаар татгалзсан учраас Мессиагийн цог жавхланг үзсэнээ иудейчүүдэд ярилаа гээд ашиг тус болох зүйл байсангүй. Христийг үхлээс амилсны дараа бол энэ мэдээ бүх дэлхий даяар тунхаглагдана.

**[17:10-13]** Христ хүч ба алдар дотор ирэхийн урьдач илэрхийллийг шавь нар үзлээ. Гэвч түүний өмнө ирэх ёстой хүн харагдсангүй.

Малахигийн зөгнөл ёсоор Мессиагийн ирэлтийн өмнө **Елиа ирэх ёстой** (Малахи 4:5, 6). Үүнийг ойлгож ядсан **шавь нар нь** энэ тухай Есүсээс **асуув**. Мессиагийн өмнө **эхлээд Елиа ирэх ёстойг** Эзэн Есүс үнэн гээд, **Елиа хэдийнээ ирсэн** болохыг тайлбарлав. Эзэн Есүс энд **Иохан Баптистын** (13 дугаар эшлэлийг үз) тухай ярьсан нь тодорхой байна. Иохан Елиа биш (Иохан 1:21) боловч “Елиагийн сүнс ба хүчээр” ирсэн нэгэн ажээ (Лук 1:17). Хэрэв Израиль Иоханыг болон түүний мэдээг хүлээн авсан бол Елиагийн талаарх эш үзүүллэгтэй холбоотой үүргийг тэр биелүүлэх байв (Матай 11:14). Гэвч Израиль үндэстэн Иоханы үйлчлэлийн ач холбогдлыг ойлгоогүйн дээр түүнд хүссэнээрээ ханджээ. Иоханы үхэл нь Хүний Хүүд хэрхэн хандахын урьдач дохио болсон. Тэд замыг нь бэлдэгч элчийг хүлээн аваагүй учраас Хааныг ч бас хүлээн авахгүй гэсэн үг юм. Есүс үүнийг тайлбарлах үед **Иохан Баптистын** тухай ярьж байгааг шавь нар нь ойлгожээ.

Тэгэхээр Христийн хоёр дахь ирэлтийн өмнө Хааны ирэлтэд Израилийг бэлтгэх нэг эш үзүүлэгч гарч ирнэ гэж үзэх үндэслэл байна. Тэр нь Елиа өөрийн биеэр байх уу эсвэл Елиа шиг үйлчлэл хийх өөр хэн нэгэн байх уу гэдгийг хэлэх боломж бол байхгүй.



## **Е. Залбирал ба мацаг барилтаар дамжуулан үйлчлэлд бэлтгэх нь (17:14-21)**

Амьдрал үргэлж уулын орой дээрх ер бусын үйл явдал байдаггүй. Сүнслэг сэргэлтийн дараа ажиллаж хөдөлмөрлөн, эрч хүчээ шавхах үе гэж бий. Уулын оргилыг орхиод хүмүүний хэрэгцээний хөндий уруу буух цаг ирдэг.

**[17:14, 15]** Уулын бэлд шаналж зовсон нэгэн аав хүн Аврагч Эзэнийг хүлээж байв. Тэрээр Эзэн Есүсийн **өмнө сөхрөн** унаад чөтгөрт эзэмдүүлсэн хүүг нь эдгээж өгөхийг хамаг сэтгэлийнхээ угаас хүсэмжлэн гуйв. Чөтгөрт эзэмдүүлснээсээ болоод хүүгийнх нь ухаан санаа солиорч, **гал усанд байнга унаж** ойчин, өөрийгөө шатаах юм уу живүүлэх аюулд ороод байв. Хамгийн харгис бурангуй эзэн болох Сатан хүнийг хэрхэн тарчлаан зовоодгийн сонгодог жишээ энэ билээ.

**[17:16]** Тэр хүүгийн аав Эзэн Есүсийн **шавь нар** дээр ирээд тусламж гуйсан боловч “хүний тусламжид найдах нь хоосон” гэдгийг ойлгохоос хэтэрсэнгүй. Түүнийг эдгээх хүч шавь нарт байсангүй.

**[17:17]** “Итгэлгүй, гөжүүд үеийнхэн. Хэдий болтол би та нартай байх юм бэ? Хэдий болтол та нарыг тэсвэрлэх юм бэ?” гэдэг үгийг тэр шавь нартаа хэлсэн. Солиорсон хүүг эдгээх итгэл тэдэнд байсангүй. Тэгэхээр тухайн үеийн иудейчүүд ер нь итгэлгүй, тэрслүү байсныг эндээс харж болно.

**[17:18]** Ухаан солиорсон хүүг авчирмагц **Есүс** доторх **чөтгөрийг** нь зэмлэхэд хүү тэр даруй эдгэрэв.

**[17:19, 20]** Яагаад ийм хүч чадалгүй байснаа гайхсан **шавь нар нь** тайлбарлаж өгөхийг Эзэн **Есүсээс** гуйв. Эзэн тэдэнд товч бөгөөд тодорхой шулуухан хариулт өгсөн. Шалтгаан нь итгэлгүй байдал. Хэрэв тэдэнд **гичний үрийн** (хамгийн жижиг үр) төдий **итгэл байвал ууланд** хандан далай уруу нүү гэж тушаасан ч уул далай уруу нүүх болно. Гэхдээ жинхэнэ итгэл нь Бурханы тушаал ба амлалтад суурилах ёстойг мартаж болохгүй. Энэ эшлэлийг бариад, ямар нэг содон жигтэй зүйл хийн, хувийн хүсэл ашиг сонирхлоо хангах гэж оролдох нь үнэндээ итгэл биш, харин мухар сүсэг, хоосон үнэмшил мөн. Харин Бурхан тодорхой зүгт чиглүүлэх юм уу тодорхой тушаал өгвөл, уул мэт хэцүү бэрхшээл ч гайхамшигтайгаар холдох болно гэдэгт итгэгч хүн эргэлзэхгүй итгэх ёстой. Итгэсэн хүмүүст боломжгүй зүйл гэж юу ч үгүй.

**[17:21]** “Гэвч энэ төрлийн чөтгөр нь мацаг барилт ба залбирлаар л гардаг” гэдэг үг хамгийн хуучны олон гар бичмэлд байдаггүй учраас RSV болон орчин үеийн Библийн ихэнх орчуулгад оруулдаггүй. Гэхдээ эртнийх биш ч гэлээ бидэнд байгаа зонхилох гар бичмэлд энэ үг бий. Мөн онцгой хүнд асуудлын тухай ярьсан хам сэдэвт нь энэ үг таарч байна.

**Ё. Өөрөөс нь урвах тухайд шавь нараа бэлтгэсэн нь (17:22, 23)**

Эзэн Есүс дахиад л өөрийн үхлийн талаар шавь нартаа урьдаас анхааруулав. Гэхдээ найдвар ба ялалтын үгийг орхигдуулалгүй **гурав дахь өдрөө амилна** гэдгээ ч хэлэв. Хэрэв Эзэн Есүс үхлийнхээ тухай урьдаас хэлээгүй бол тийм явдал болох үед шавь нар нь хамаг найдвараа алдах байв. Мессиаг тэд ичгүүртэйгээр зовлон эдэлж, үхнэ гэж огтхон ч бодоогүй ажээ.

Тиймээс Эзэн Есүс өөрсдийг нь орхиж, алагдах болно гэдгийг сонсмогцоо машид сэтгэлээр унав. Зовлон эдэлж, үхнэ гэдэг дээр тэд хэт анхаараад, дахин амилна гэснийг нь анхааралтай сонсоогүй бололтой.

**Ж. Петр багшийнхаа хамт татвараа төлсөн нь (17:24-27)**

[17:24, 25] Тэднийг Капернаумд байхад сүмд төлөх ёстой **хоёр драхмын татварыг хураагч хүмүүс Петр дээр ирээд “Танай багш чинь сүмийн үйлчлэлийг явуулахад хэрэглэдэг хоёр драхмын татвараа төлдөггүй юм уу?”** гэсэнд тэр **“Төлдөг”** гэв. Үнэндээ Петр Христийг ичгэвтэр байдалд оруулахыг хүсээгүй болохоор ингэж хэлсэн бололтой.

Харин дараа нь болсон үйл явдал Эзэн Есүс бүхнийг мэдэгч болохыг харуулдаг. **Петрийг гэрт ороход Есүс түрүүлэн түүнд “Симон оо, чи юу гэж боддог вэ? Газрын хаад хэнээс алба гувчуур, албан татварыг авдаг вэ? Өөрсдийн**

**хөвгүүдээс үү, эсвэл гаднын хүмүүсээс үү?”** гэж асуув. Энэ асуултыг тухайн үеийн байдалтай нь холбон ойлгох хэрэгтэй. Тухайн үед хаан, захирагч, удирдагчид албат харьяатуудаасаа татвар авч, өөрийн хаант улс болоод гэр бүлийнхээ хэрэгцээг хангадаг байв. Гэхдээ тэд гэр бүлээсээ татвар авахгүй. Харин өнөөгийн төр засгийн тогтолцооны дагуу бол бүх хүн улсад татвар төлөх ёстой. Үүнд удирдагч хүн ба түүний гэр бүлийнхэн ч багтана.

**[17:26]** Захирагч удирдагчид гаднын хүмүүсээс татвар авдаг гэж Петр зөв хариулсан. Тэгэхэд нь Есүс “Тэгвэл **хөвгүүд нь чөлөөлөгдсөн байх нь**” гэдэг дүгнэлтийг хэлсэн. Юу гэвэл, сүм бол Бурханы өргөө. Харин Есүс бол Бурханы Хүү. Тэгэхээр Есүс сүмийн дэмжлэгт зориулж татвар төлнө гэвэл өөртөө татвар төлснөөс ялгаагүй болно.

**[17:27]** Гэхдээ ямар ч ашиггүй бүдрүүлэл болохгүйн тулд Эзэн Есүс татвар төлөхийг зөвшөөрчээ. Харин мөнгөө яаж олох вэ? Есүс өөртөө мөнгө авч явсан талаар тэмдэглэсэн зүйл нэг ч байдаггүй. Эзэн Есүс Петрийг Галил **нуур уруу явуулаад** хамгийн эхэнд барьсан загасны амнаас **дөрвөн драхмын нэг зоос олж**, түүгээрээ өөрийнхөө болон Эзэн Есүсийн татварыг төл гэв.

Энэ онцгой гайхамшиг нь Христ бүхнийг мэдэгч гэдгийг харуулж байна. Галил нуурын түмэн загасны дунд амандаа зоостой загас нь аль вэ гэдгийг Тэр мэдэж байсан. Бас тэрхүү загасны тодорхой байршлыг ч мэдэж байв. Бас тэр нь

Петрийн барих эхний загас байна гэдгийг ч мэдэж байжээ.

Эзэн Есүс тэр татварыг төлөхгүй байж болох л байсан. Тэглээ гээд Түүний буруу болохгүй. Харин бусдад бүдрэх шалтгаан болохгүй байх гэсэн Бурханы зарчмын улмаас Эзэн Есүс тэр татварыг төлөхийг хүсжээ. Итгэгч бид хуулиас чөлөөтэй нь үнэн. Гэхдээ бид хүмүүсийн мөс чанарыг хүндэлж, тэднийг бүдрүүлэх зүйлийг үйлдэхгүй байхыг хичээх хэрэгтэй.

## **XI. ДАГАЛДАГЧДАДАА ЗААВАРЧИЛЖ БУЙ ХААН (18-20-р бүлэг)**

### **A. Даруу байдал (18:1-6)**

Арван наймдугаар бүлэгт агуу байдал ба уучлалын тухай яриа гарна. Өөрийгөө Хаан Христийн харьяат гэх хүмүүст ямар зан хандлага тохиромжтой болохыг Эзэн Есүс сургаж байна.

**[18:1]** Тэнгэрийн хаанчлал байгуулагдахад энх тайван, хөгжил цэцэглэлийн алтан үе ирнэ гэсэн ойлголт Эзэн Есүсийн шавь нарт байв. Тиймээс тэд тэнгэрийн хаанчлалын байр сууринд шунаж эхлэв. **“Тэнгэрийн хаанчлалд хэн хамгийн агуу нь байх вэ?”** гэсэн асуултаас өөрсдийгөө тэргүүнд тавьсан сэтгэл нь харагддаг.

**[18:2, 3]** Есүс нэгэн хүүхдийг тэдний дунд зогсоогоод, түүнийг амьд жишээ болгож, шавь нартаа сургамжлан, **“Та нар өөрчлөгдөж, хүүхдүүдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй”** гэж хэлэв. Тэрээр

тэнгэрийн хаанчлалын дотоод талыг өгүүлж байна. Хүн жинхэнэ итгэгч болохын тулд өөрийгөө өргөмжлөх бодлуудаа орхиж, хүүхэд адил дорд байр сууринд өөрийгөө аваачих ёстой. Тэгэхийн тулд хүн нүгэлтэй болохоо ойлгож, өөдгүй муу гэдгээ ухаарч, Есүс Христийг цорын ганц найдвар болгон хүлээн авах хэрэгтэй. Христэд итгэсэн амьдралынхаа турш тэрээр энэ хандлагаа гэж болохгүй. Есүс үүгээрээ өөрийн шавь нарыг аврагдаагүй гэж хэлээгүй. Иудасаас бусад нь Эзэн Есүст үнэнээр итгэсэн тул зөвтгөгдсөн байсан. Гэхдээ тэдний дотор Ариун Сүнс оршин суухаар ирээгүй байсан тул өнөөгийн бидэнд байгаа шиг (гэхдээ бид хэрэглэдэггүй) жинхэнэ даруу хандлагатай байх хүч чадал тэдэнд дутсан. Түүнээс гадна, тэд буруу бодлуудаа орхиж, хаанчлалын зарчимд нийцэх үзэл санааг авах ёстой байсан.

**[18:4] Өөрийгөө хүүхэд адил даруу болгосон хүн л тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно.** Тэнгэрийн хаанчлалын жишиг стандарт хийгээд үнэлдэг зүйлс нь энэ ертөнцийнхөөс эсрэг байдаг тул юмыг бодох байдал маань эсрэг зүгт эргэх ёстой. Бид Христтэй адил бодол санаатай байх ёстой (Филиппой 2:5-8-г үз).

**[18:5]** Эзэн Есүсийн ярианы сэдэв бодит хүүхдийн тухай байснаа бараг анзаарагдахгүйгээр сүнслэг хүүхдийн тухай болж хувирав. Даруу дорд дагалдагчийг нь Түүний нэрээр хүлээн авсан хүн Эзэн Есүсийг

өөрийг нь хүлээн авсантай адил юм. Тэрхүү шавьд нь хийж өгсөн зүйлийг багшид нь хийснээр тооцох болно.

**[18:6]** Харин нөгөө талд, итгэгч хүнийг нүгэлд уруу татагч хүн ноцтой яллагдах болно. Итгэгч хүнийг уруу татсанаас хүзүүндээ **тээрмийн хүнд чулуу зүүгээд тэнгисийн гүнд живсэн нь түүнд дээр.** (Хүнд тээрмийн чулуу гэж амьтны хүчээр эргүүлдэг том чулууг хэлсэн. Харин жижиг тээрмийн чулууг гараар эргүүлж болдог.) Өөрийгөө буруутан болгох нүгэл үйлдэх нь маш муу хэрэг мөн. Харин итгэгч хүнийг нүгэлд унагах гэдэг нь итгэгч хүний гэм зэмгүй байдлыг үгүй хийж, оюун санааг ялзруулж, нэр төрийг гутаах юм. Бусдын цэвэр ариун байдлаар тоглосноос үхэж далдарсан нь хамаагүй дээр.

### **Б. Бүдрүүлэх саадуудын тухай (18:7-14)**

**[18:7]** **Бүдрүүлэх саадууд** гарч ирэх нь зайлшгүй гэж Эзэн Есүс цааш нь тайлбарлаж байна. Энэ **ертөнц**, махан бие, диавол нь хамтдаа уруу татлага ба бузар явдлын үндэс мөн. Гэхдээ бузар муугийн энэ хүчнүүдийн зэмсэг болсон хүний ял зэм асар их байх болно. Тиймээс Бурханы хүүхдийг уруу татахгүйн тулд өөрсдийгөө сахилгажуулахыг Эзэн Есүс анхааруулж байна.

**[18:8, 9]** Нүгэлд унагаж буй эрхтэн нь **гар, хөл, нүдний** аль нь ч бай, бусад хүний амьдрал дахь Бурханы ажлыг сүйтгэж байснаас тэдгээр

эрхтнээ мэс засалчийн хутган дор тавих нь илүү өлзийтэй болно. Бүх эрхтэнтэйгээ тамд унаснаас сохор, доголон, тахир дутуу болоод ч болов **аминд орох нь** хавьгүй дээр. Гэхдээ тэнгэрт зарим хүн тахир дутуу байна гэж ойлгож болохгүй. Эзэн Есүс тийм утгаар хэлээгүй. Харин итгэгч хүн дараагийн амьдрал уруу явахаас өмнөх үе буюу энэ амьдралын байдлыг ярьж байна. Амилсан бие бүрэн бүтэн, төгс төгөлдөр байх нь ямар ч маргаангүй баттай зүйл билээ.

**[18:10]** Дараа нь эдгээр **багачуудыг** басамжилж болохгүйг Бурханы Хүү анхааруулж байна. Жирийн хүүхдүүд ч бай, хаанчлалын харьяат ч бай ялгаагүй тэднийг басамжлах хэрэггүй. **Тэдний тэнгэрэлч нар** нь Бурханы царайг харан Бурханы оршихуйд зогсож байдгийг Эзэн Есүс хэлснээрээ эдгээр багачуудын хэчнээн чухлыг онцолсон. **Тэнгэрэлч нар** гэж хамгаалагч тэнгэрэлч нарыг хэлсэн бололтой (Еврей 1:14-г бас үз).

**[18:11]** RSV болон орчин үеийн Библийн ихэнх орчуулгад ороогүй боловч Аврагчийн маань зорилгыг хэлсэн энэ эшлэл уг хэсгийн оргил үг бөгөөд энэ үгийг агуулсан олон гар бичмэл бий.<sup>38</sup>

**[18:12, 13]** Дөлгөөн даруу Хоньчины аврах үйлчлэл тэдгээр багачууд уруу ч бас ханджээ. **Зуун хониных** нь нэг нь төөрч алдагдсан ч, тэрээр **ерэн есийгөө** орхиод тэр нэгийг хайж, олон олтлоо явах л болно. Төөрсөн ганц хонио



олоод баярлан хөөрөх Хоньчины сэтгэлээс бид багачуудыг үнэ цэнэтэйд тооцож, хүндлэхийг сурч ойлгох ёстой.

**[18:14]** Тэд тэнгэрэлч нарын хувьд чухал. Гэхдээ Хоньчин Эзэнд маань болоод Бурхан **Эцэгт** бүр ч илүү чухал билээ. Тэднээс **хэн нэг нь эрсдэх нь** Эцэгийн хүсэл биш ээ. Тэнгэрэлч нар, Эзэн Есүс, Эцэг Бурханы хувьд тэд тийм чухал юм бол, хэчнээн дорд, хэчнээн таагүй харагдаж байсан ч тэднийг хэзээ ч басамжлах хэрэггүй.

### **В. Буруудсаныг сахилгажуулах нь (18:15-20)**

Энэ бүлгийн үлдсэн хэсэгт чуулганы гишүүдийн доторх зөрчилдөөнийг хэрхэн шийдэх талаар болон хязгааргүйгээр уучлал үзүүлэх тухай сэдвийг өгүүлнэ.

**[18:15]** Итгэгч ах дүүсийн хэн нэг нь шударга бус хандвал, итгэгч хүн хэрхэн хандах ёстойг энд маш тодорхой зааварлажээ. Эхлээд тэрээр буруутай этгээдтэй хувьчлан уулзаж, энэ асуудлаа ярих ёстой. Хэрэв буруутан буруугаа хүлээвэл, түүнтэй эвлэрч болно. Харамсалтай бид үүнийг хийдэггүй. Харин асуудлыг хаа хамаагүй хүмүүст ярьж хов жив болгодог. Түүнээс болоод асуудал хээрийн түймэр шиг улам газар авч, хэрүүл маргаан ч нэмэгддэг. Нэгдүгээр алхам бол **“явж түүнтэй ганцаарчлан уулзан зэмлэх”** гэдгийг бүгдээрээ мартахгүй байцгаая!

[18:16] Хэрэв буруутай хүн зэмлэлийг сонсохгүй бол түүн дээр **нэг юм уу хоёр ах дүүгээ дагуулан очих хэрэгтэй**. Ингэхдээ буруугаасаа гэмшин, дахин шинээр эхлэхийг нь хүссэн сэтгэлтэй байх ёстой. Арай олуулаа очих нь тухайн хүний байдал илүү ноцтой болж буйг илтгэдэг. Тэгээд **хоёр ба гурван гэрчийн амаар хэрэг нь бүрэн нотлогдох болно** (Дэд хууль 19:15) хэмээн бичвэрт шаардсаны дагуу хоёр ба гурван хүний үг хангалттай гэрчлэл болно. Алив хүний эсрэг буруутгал хоёроос гурван гэрчтэй байх хэрэгтэй гэсэн энгийн дүрмийг дагаагүйгээс болоод чуулганы дотор үүсдэг асуудал зовлонгийн хор уршгийг тооцож хэмжих арга үгүй. Үүн дээр энэ ертөнцийн шүүх ер нь христитгэгчдийн чуулган, цуглаануудаас илүү шударгаар үйлддэг.

[18:17] Буруутай этгээд хоёр ба гурван хүний үгийг ч гэсэн **сонсохоос татгалзаж байвал** тухайн асуудлыг нутгийн **чуулганы** өмнө авчрах хэрэгтэй. Хэргийг шүүн тунгаах үүрэгтэй этгээд нь иргэний шүүх биш нутгийн чуулган болохыг анхааралдаа аваарай. Христитгэгч хүн итгэгч ах дүүгийнхээ эсрэг хууль шүүхэд хандаж болохгүй (1Коринт 6:1-8).

Буруутай этгээд чуулганы өмнө хүртэл буруугаа хүлээхээс татгалзах аваас түүнийг **харь үндэстэн болоод татвар хураагч мэт** үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, түүнтэй харьцахдаа түүнийг чуулганы хүрээний гаднах хүмүүсийн адил үзэх хэрэгтэй гэсэн үг. Тэр жинхэнэ итгэгч

байж болно. Гэхдээ жинхэнэ итгэгч мэт амьдрахгүй байгаа учраас түүнд тийнхүү хандах хэрэгтэй. Хэдийгээр тэр даян дэлхийн чуулганы дотор байсаар байгаа боловч орон нутгийн чуулганы хувь завшааныг хүртэх эрхээ алдах болно. Энэ сахилгажуулалт бол маш хүнд арга хэмжээ юм. Энэ нь түр зуур тухайн хүний махбодыг сүйрүүлэхийн тулд Сатаны хүчинд тушааж буй хэрэг бөгөөд ингэснээр түүний сүнс Эзэн Есүсийн өдөр аврагдаж болох юм (1Коринт 5:5). Ийм арга хэмжээ авч буйн зорилго бол тэр хүнд бурууг нь мэдрүүлж, нүглийг нь хүлээн зөвшөөрүүлэхэд оршино. Энэ зорилго биелэх хүртэл итгэгчид түүнтэй гаднын хүнтэй хэрхэн харьцдаг шигээ ердийн харьцаж болно. Гэхдээ нүглийг нь буруутгаж буйгаа болон итгэгч ахан дүүгийн ёсоор нөхөрлөж чадахгүй гэдгээ хандлагаараа харуулж байх хэрэгтэй. Хэрэв тэр хүн бурханлаг гэмшилд хүрсэн нь баттай болбол чуулган нэн даруй түүнийг буцааж хүлээн авах хэрэгтэй.

**[18:18]** Энэ эшлэл өмнөх үгстэй холбоотой. Хэрэв чуулган залбиралтайгаар Үгэнд дуулгавартай хандаж, сахилгажууллын арга хэмжээг тэр хүнд холбовол тэр нь **тэнгэрт** хүндлэгдэх болно. Сахилгажуулагдсан хүн гэмшиж, нүглээ хүлээн зөвшөөрөх үед чуулган түүнийг итгэгчдийн нөхөрлөлд эргээд хүлээн авбал, энэхүү тайлах үйлдлийг Бурхан батлах болно (Иохан 20:23-ыг үз).

**[18:19]** Тэгвэл нэг асуулт урган гарна. “Дээр дурдсан холбох, тайлах үйлдлийг хийхийн тулд чуулган хэр том байх хэрэгтэй вэ?” Хариулт: Тийм асуудлыг залбирал дотор Бурхан дээр авчрахад **хоёр** хүн байхад л хангалттай. Тэднийг Бурхан сонссон гэдэгт бат итгэж болно. Ер нь энэ эшлэлийг залбиралд хариулах амлалт хэмээн иш татдаг боловч хам сэдвийг нь харвал чуулганы сахилгажуулалтай холбоотой залбирлын тухай дурдсан байна. Үүнийг хамтдаа залбирах ердийн залбирлын тухай хэмээн үзсэн тохиолдолд залбирлын талаар өгүүлсэн Библийн бусад бүх сургаалтай хамт харах хэрэгтэй. Тухайлбал:

1. Бидний залбирал Бурханы илчлэгдсэн хүсэлд нийцэж байх хэрэгтэй (1Иохан 5:14, 15).
2. Бидний залбирал итгэлтэй байх хэрэгтэй (Иаков 1:6-8).
3. Бидний залбирал цэвэр мөс чанартай байх хэрэгтэй (Еврей 10:22а).

**[18:20]** Хорьдугаар эшлэлийг хам сэдвийнх нь гэрэлд харж тайлбарлах нь зүйтэй. Энд Шинэ гэрээний үеийн чуулганы хамгийн цомхон хэлбэрийг өгүүлээгүй. Бас жирийн залбирлын цугларлыг ч хэлээгүй. Харин ямар нэг нүглээс болж түнжингүй болсон хоёр итгэгчийг эвлэрүүлэхийн төлөө чуулган цуглаж буй тухай ярьж байна. Үүнийг Христийг төв болгосон итгэгчдийн алив цуглаантай холбон тайлбарлаж болох ч хам сэдвийг нь баримтлан авч үзэх нь илүү зөв болно.

“Түүний нэрээр” цуглах гэдэг нь Эзэн Есүс гэж хэн болохыг таньж мэдсэн, Үгэнд нь дуулгавартай хүмүүс эрх мэдлээр нь цуглахыг хэлнэ. Түүний нэрээр цуглаж болох цор ганц нь гэж өөрсдийгөө нэрлэж чадах ямар ч бүлэг байхгүй. Хэрэв тийм байсан бол Эзэн Есүсийн газар дэлхий дээрх бие маш жижиг, хязгаарлагдмал хүрээтэй байх байсан. Түүнийг Эзэн ба Аврагч хэмээн хүлээн зөвшөөрсөн **хоёр ба гурван хүн цугласан** газарт Есүс өөрөө хамт байх болно.

#### **Г. Хязгааргүйгээр уучлах тухай (18:21-35)**

[18:21, 22] Тэр үед Петр “Өөрсдийн маань эсрэг нүгэл үйлдсэн **ах дүүгээ** бид хэдэн удаа **уучлах** хэрэгтэй вэ?” гэж асуув. Тэрээр **долоон удаа** уучлахыг дэндүү их нигүүлсэл үзүүлж байгаа хэрэг гэж бодож байжээ. Харин Эзэн Есүс хариуд нь “**Долоон удаа** биш, **харин дал дахин долоон удаа**” гэв. Эзэн Есүс шууд утгаар нь 490 гэсэн хязгаар тогтоогоогүй. Харин “хязгааргүй” гэдгийг ийнхүү зүйрлэлийн аргаар хэлжээ.

“Тэгвэл дээр дурдаад байсан сахилгажууллын арга хэмжээ яах болж байна? Буруутай хүнтэй эхлээд ганцаарчлан уулзаад, болохгүй бол нэг юм уу хоёр хүнтэй очиж уулзаад, болохгүй бол чуулганд хэргийг мэдүүлэх шаардлага тэгээд байгаа юм уу? Зүгээр л уучлаад асуудлыг дуусгачхаж болохгүй юм уу?” гэсэн асуулт гарч болох юм.

Юу гэвэл, уучлалын үйлчлэлд дараах шат байдгийг ойлгох хэрэгтэй. Үүнд:

1. Хэрэв ах дүү минь надад бурууг үйлдэх юм уу миний эсрэг нүгэл үйлдвэл би түүнийг тэр даруй зүрх сэтгэлдээ уучлах хэрэгтэй (Ефес 4:32). Энэ нь намайг хорсол ба үл уучлалын сүнснээс чөлөөлж, асуудлыг буруутай этгээдийн мөрөн дээр орхиход тусалдаг.
2. Би түүнийг уучиллаа ч уучлагдсаныг нь тэр даруй хэлэх хэрэггүй. Буруутай хүнийг гэмшээгүй байхад уучилсан тухайгаа мэдэгдвэл шударга бус хэрэг болно. Тиймээс би эхлээд түүн дээр очиж уулзаад, түүнийг нүглээ гэмшээсэй хэмээн хүсэж найдсан хайрын сэтгэлээр зэмлэх хэрэгтэй (Лук 17:3).
3. Хэрэв тэр хүн буруугаа хүлээн уучлалт гуйвал уучилсан гэдгээ хэлэх хэрэгтэй (Лук 17:4).

**[18:23]** Уучлалыг үнэгүй авсан мөртлөө бусдыг уучлахгүй бол ямар их хор уршигтайг харуулахын тулд Эзэн Есүс **тэнгэрийн хаанчлалын** сургаалт зүйрлэлийг ярьж байна.

**[18:24-27]** Бүртгэл дээрээ байгаа найдваргүй зээлүүдээ цэгцлэхийг **хүссэн нэгэн хаан** байж гэнэ. **Тооцоо хийж эхлэх үед арван мянган талантын өртэй** зарцыг түүн дээр авчрав. Гэвч тэр зарц өрөө төлөх ямар ч төлбөрийн чадваргүй байсан тул эзэн нь түүнийг гэр бүлийнх нь

хамтаар боол болгон худалдаж, өрийг нь төлүүлэх тушаал буулгажээ. Айж сандарсан зарц эзнээсээ хугацаа өгөхийг гуйж, боломж олговол **бүгдийг** төлөхөө амлав.

Өрөнд орсон ихэнх хүмүүс боломж, хугацаа л (26-р эшлэл) байвал хийж чадна гэсэн өөдрөг үзэлтэй байдаг. Галилын нийт ашиг орлого л гэхэд ердөө 300 талант байсан атал энэ хүн дангаараа 10,000 талантын өртэй байсан. Тэгэхээр энэ хүний өр дэндүү их байжээ. Эзэн Есүс ийм өндөр дүн хэлснээрээ сонсогч нарынхаа гайхширлыг төрүүлж, анхаарлыг татан, Бурханы өмнө ямар их өртэйг нь харуулахыг зорьсон. Мартин Лутер: “Бид бүгдээрээ Бурханы өмнө гуйлгачид мөн. Өрөө төлөх ямар ч найдвар бидэнд байхгүй” гэж хэлдэг байв (Бичвэрийн Холбооноос гаргадаг Өдөр Бүрийн Сургамж ном).

Эзэн нь зарцынхаа маш ихээр харамсан халагласан хандлагыг үзээд 10,000 талант өрийг нь бүрэн уучилжээ. Энэ бол шударга ёс биш нигүүлсэл юм.

**[18:28-30]** Түүнтэй хамт ажилладаг өөр нэг зарц түүнд **зуун денарын** (хэдхэн зуун доллар) өртэй байв. Гэтэл уучлагдсан зарц нөхрөө уучлахын оронд **багалзуурдаад** бүх өрөө төлөхийг шаардаж нэхэв. Хөөрхий өртөн хамт ажилладаг нөхрөөсөө өрийг нь төлөх жаахан хугацаа өгөхийг гуйсан ч тус болсонгүй. Ингээд **өрөө төлөх хүртлээ шоронд** хаягдав. Одоо

өртэй хүн шоронд орчихсон болохоор мөнгө олох боломж нь хаагдаж, шоронгоос гарах ямар ч найдваргүй болов.

**[18:31-34]** Энэ увайгүй хандлагыг үзсэн бусад **зарц нар** энэ тухай **эзэндээ** хэлцгээв. Өөрийнх нь асар их өрийг уучлаад байхад өчүүхэн жаахан өрийг үл уучилсан тэр зарцад хаан асар ихээр хилэгнэж, хар санаат зарцыг буцааж авчруулаад өрөө төлөх хүртэл нь шоронд хорьжээ.

**[18:35]** Энэ сургаалт зүйрлэлийн утга тодорхой юм. Бурхан бол тэр Хаан мөн. Түүний бүх зарц нар түүнд нүгэл хэмээх өртэй билээ. Тэд үүнийгээ хэзээ ч төлж чадахгүй. Гэвч гайхамшигт нигүүлсэл ба агуу өршөөл энэрлээр Эзэн тэр бүх өрийг төлж, ямар ч болзолгүй бүрэн уучлалыг үзүүлсэн байна. Тэгвэл итгэгч хүн нэгэндээ бурууг үйлдлээ гэж бодъё. Харин буруутай итгэгч зэмлүүлээд буруугаа хүлээж, уучлал гуйв. Гэвч гомдсон итгэгч нь уучлахаас татгалзжээ. Хаан Эзэн хэдэн сая долларын өрийг нь хэлтрүүлээд байхад хэдхэн зуун долларын авлагаа тэр нэхсээр байв. Ийм хандлагыг Хаан Эзэн шийтгэхгүй гэж үү? Гарцаагүй шийтгэнэ. Ийм хүн энэ амьдралдаа Эзэний сахилгажууллыг хүртэж, Христийн шүүх сэнтийн өмнө шагналаа алдах болно.



**Д. Гэрлэлт, гэр бүл салалт, гэрлэхгүй байх шийдвэрийн тухай (19:1-12)**

[19:1, 2] Эзэн Есүс Галил дахь үйлчлэлээ дуусгаад зүүн тийш Иерусалимын зүг явав. Тэрээр ямар замаар явсныг бид мэдэхгүй ч Иорданы зүүнтэйд орших Переаг дайран өнгөрсөн нь тодорхой харагддаг. Матай энэ нутгийн тухайд **Иорданы тэртээх Иудейн нутаг** хэмээн бүдэг бадаг өгүүлжээ. Переад хийсэн үйлчлэл нь 19:1-ээс эхлээд 20:16 юм уу 20:28 хүртэл гарна. Эзэн Есүс Иорданыг хэзээ гаталж, Иудейд очсон нь тодорхой дурдагдаагүй байна.

[19:3] Энд гарч буй олон түмэн бол Эзэн Есүсээр эдгээлгэхээр дагаж байсан хүмүүс бололтой. Түүнийг олон хүн дагаж байсан учраас **фарисайчууд** байгаа газрыг нь хялбархан олсон болов уу. Тэд зальт үнэг мэт санаагаар Эзэн Есүсийг үгэнд нь унагахыг зорьж байв. Тэгээд Түүнээс гэр бүл **салж** болох ямар нэг хуулийн үндэслэл байгаа эсэхийг асуужээ. Эзэн Есүс ямар ч хариу өгсөн иудейчүүдийн аль нэг бүлэглэлийг уурлуулах байв. Тэдний нэг хэсэг нь салалтын талаар либерал буюу чөлөөт үзэлтэй бол, нөгөө хэсэг нь салж болохгүй гэсэн хатуу зарчим барьдаг байжээ.

[19:4-6] Бурхан анхнаасаа эр хүнийг нэг л эхнэртэй байхыг хүсэж байсан гэдгийг Эзэн Есүс тайлбарласан. **Эр, эм** хүмүүсийг бүтээсэн Бурхан, гэрлэлтийн харилцааг эцэг эхтэйгээ харилцах харилцаанаас дээгүүр байх ёстой хэмээн тушаажээ. Мөн гэрлэлт бол хоёр хүний

нэгдэл гэдгийг Бурхан айлдсан. Бурханы энэ тогтоолыг хүний гаргасан ямар ч хууль журам зөрчих ёсгүй.

**[19:7]** Эзэн Есүсийн үг Хуучин гэрээтэй гарцаагүй зөрчилдөж байна гэж фарисайчууд боджээ. **Мосегийн** хуульд **салалтыг** зөвшөөрөөгүй гэж үү? Эр хүн эхнэртээ салалтын бичиг үлдээгээд гэрээсээ явуулж болно гэж хуульд заасан шүү дээ (Дэд хууль 24:1-4).

**[19:8]** **Мосе** салалтыг **зөвшөөрсөн** гэдгийг Есүс хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ энэ нь хүн төрөлхтөнд зориулсан Бурханы дээдийн дээд хүсэл байгаагүй бөгөөд Израилийн урвамхай сэтгэлээс болж ийм хууль өгснийг Есүс хэлсэн: **“Та нарын зүрх сэтгэлийн хатуугаас болоод Мосе та нарт эхнэрүүдээсээ салахыг зөвшөөрсөн. Харин эхнээсээ ийм байгаагүй.”** Бурханы туйлын хүсэлд салалт гэж байгаагүй боловч хүслийнх нь эсрэг зүйлийг хүртэл хүлцэн өнгөрүүлэх үе Бурханд байдаг ажээ.

**[19:9]** Гэвч салалтыг зөвшөөрсөн урьдын зөөлөн хууль цаашид хэрэгжих ёсгүй гэдгийг Эзэн Есүс бүрэн дээд эрх мэдэлтэйгээр тунхаглав. Үүнээс хойш салж болох ганцхан л үндэслэл байж болно. Тэр нь **садар самуун** юм. Үүнээс өөр шалтгаанаар гэр бүлээсээ салж, өөр хүнтэй гэрлэсэн хүн **завхайрсанд** тооцогдоно.

Хэдийгээр шууд дурдагдаагүй боловч завхайрлын улмаас салсан хосуудын гэмгүй тал нь өөр хүнтэй гэрлэж болно гэж Эзэний маань үгэнд битүүхэн цухалзаж байна. Эс бөгөөс гэр

бүл салах нь ямар ч утга учиргүй болох бөгөөд зүгээр тусдаа амьдарч байгаагаас ялгарахгүй.

**Садар самуун** (грек: *порнеиа*) гэж ерөнхийдөө завхайрал гэсэн утгатай. Гэхдээ үүнийг гэрлэлтийн өмнө үйлдэгдэж, гэрлэсний дараа мэдэгдсэн садар самуун гэж үздэг Библийн олон эрдэмтэн бий (Дэд хууль 22:13-21-ийг үз). Зөвхөн иудейчүүдийн гэрлэх ёслолтой холбож үздэг эрдэмтэд ч бий. Тиймээс иудейчүүдэд зориулсан сайнмэдээ болох Матай номд л зөвхөн салж болох ийм үндэслэлийг дурдсан гэж тэд хэлдэг.

Гэр бүл салалтын тухай илүү дэлгэрэнгүйг 5:31, 32-ын тайлбараас үзнэ үү.

**[19:10] Шавь нар** нь салалтын талаарх Эзэний сургаалыг сонсмогцоо, салж болох ганцхан шалтгаан байгаа юм бол гэрлэж нүгэлд унаснаас бүр **гэрлэхгүй байх нь дээр** юм байна гэж туйлшрав. Гэхдээ тэглээ гээд ганц бие байхын нүгэлд унах эрсдэлээс тэд хамгаалагдахгүй шүү дээ.

**[19:11]** Тиймээс Аврагч Эзэн маань гэрлэхгүй байх шийдвэр нь амаргүй гэдгийг тэдэнд сануулсан. Тусгай нигүүлсэл хүртсэн хүмүүс л гэрлэхгүй явж чадна. **“Ингэж хэлэхийг бүх хүн хүлээн авч чадахгүй, харин өгөгдсөн хүмүүс л чадна”** гэдэг нь Эзэн Есүсийн үгийг бүгд ойлгохгүй гэсэн утгатай биш, харин дуудагдаагүй л бол хэн ч гэрлэхгүйгээр явж чадахгүй гэсэн утгатай юм.

[19:12] Гурван төрлийн **тайган** байдаг тухай Эзэн Есүс тайлбарласан. Зарим хүн нөхөн үржих чадваргүй, **тайган төрдөг**. Зарим нь хүний гараар тайган болдог. Дорнын ихэс дээдэс өөрсдийнх нь татвар эмст бараа болох эрчүүдийг мэс заслын аргаар хөнгөлж, тайган болгодог байв. Гэхдээ Есүс **тэнгэрийн хаанчлалын төлөө өөрийгөө тайган болгосон** хүмүүсийг энд онцлон авч үзэж байна. Тийм хүмүүс бие физиологийн хувьд ямар нэг асуудалгүй бөгөөд гэр бүл зохиох боломжтой байсан боловч Хаан болоод хаанчлалд өөрсдийгөө зориулж, Христийн үйл хэрэгт амь амьдралаа өргөн, өөр зүйлд сатаарахгүйн тулд сайн дураараа гэрлэлтээс таггалздаг байна. Паул энэ тухайд: “Гэрлээгүй хүн Эзэнд хэрхэн таалагдах вэ хэмээн Эзэний юманд санаа тавьдаг” гэсэн байдаг (1Коринт 7:32). Тэдний гэрлэхгүй байх шийдвэр нь бие физиологийн асуудлаас биш, харин сайн дурын хүслээс үүдэлтэй ажээ.

Бүх хүн ийм замаар явж чадахгүй. Харин Бурханы хүч чадлыг авсан хүмүүс л чадна: “Хүн бүрд өөрийнх нь бэлэг Бурханаас байдаг бөгөөд нэг нь ийм байхад нөгөө нь өөр байдаг” (1Коринт 7:7).

### **Е. Хүүхдүүдийн тухай (19:13-15)**

Салалтын тухай яриаг залгаад хүүхдүүдийн тухай гарч байгаа нь тун сонирхолтой (Марк 10:1-16-г бас үз). Гэр бүл салалтад хамгийн их зүдэрдэг нь хүүхдүүд билээ.

Эцэг эхчүүд Хоньчин-Багшаар ерөөлгөх гэж хүүхдүүдээ Есүс дээр авчрав. Харин шавь нар нь үүнийг үзээд, төвөгшөөж, уурлан эцэг эхчүүдийг зэмлэв. Гэтэл Есүс тэдний яриаг тасалдуулж, хүүхдүүдийг хэчнээн их нандигнадаг болохоо илэрхийлсэн: “Хүүхдүүдийг над уруу ирүүл. Тэднийг бүү хорь. Тэнгэрийн хаанчлал бол эдэн шиг хүмүүсийнх билээ.”

Энэ үгэнд хэд хэдэн чухал сургамж агуулагддаг. Юмыг маш сайн хүлээж авдаг, цагаан цайлган сэтгэлтэй хүүхдүүдэд Бурханы үгийг хүргэх ажлыг Эзэний зарц нар чухалчлан үзэх хэрэгтэй гэдэг нь нэг дэх сургамж юм. Хоёрт гэвэл, Эзэн Есүст итгэнэ гэсэн хүүхдүүдийг цааш түлхэх биш, харин урамшуулах хэрэгтэй. Тамд хаягдах насны доод хязгаарыг мэдэх хүн гэж үгүй. Хүүхэд чин сэтгэлээсээ аврагдахыг хүсэж байхад, түүнийг бага балчир байна гэх хэрэггүй. Бас нөгөө талд, хүүхдийг хүчилж, Эзэн Есүст итгэдэг хэмээн хүчээр хэлүүлж болохгүй. Сэтгэл хөдлөл нь мэдрэг эмзэг байх тусам тухайн хүүхдэд дарамт шахалтын аргаар сайнмэдээ хүргэх явдлаас сэрэмжилж, тэднийг хамгаалах хэрэгтэй. Аврагдахын тулд хүүхэд заавал том болох албагүй ч томчууд харин хүүхэд шиг болох шаардлагатай (Матай 18:3, 4; Марк 10:15).

Гуравт, “Хариуцлага үүрэх насанд хүрээгүй байхдаа нас барсан хүүхэд хаашаа явах вэ?” гэдэг асуултын хариуг Эзэн Есүсийн маань үг

тодорхой өгч байна. **“Тэнгэрийн хаанчлал бол эдэн шиг хүмүүсийнх билээ”** гэж Есүс хэлсэн. Тэгэхээр нялх балчир үрсээ алдсан эцэг эхчүүдэд энэ үг маш тодорхой баталгааг өгч байна.

Гэтэл хүүхдийг Христийн биеийн эрхтэн, хаанчлалыг өвлөгч болгоно гээд хүүхдэд баптисм хийхдээ энэ эшлэлийг ашиглах явдал байдаг. Хэрэв энэ эшлэлийг анхааралтай уншвал, эцэг эхчүүд хүүхдүүдээ баптисм хүртээгч дээр бус, Эзэн Есүс дээр авчирсан гэдгийг харж чадах биз ээ. Эзэн Есүс дээр ирсэн хүүхдүүд аль хэдийнээ хаанчлалын өв залгамжлагч болчихсон тухай энд хэлсэн байна. Түүнээс гадна, энд дусал усны тухай ч дурдаагүй байгааг анхаараарай.

### **Ё. Эд хөрөнгөний тухай: Баян залуу удирдагч (19:16-26)**

**[19:16]** Энэ үйл явдлаас бид дөнгөж саяхан өгүүлсэн зүйлийн нөгөө талыг харах боломжтой. Тэнгэрийн хаанчлал нь хүүхдүүдийнх гэдгийг хэлсний араас тийш орох нь томчуудад хэчнээн хэцүү гэдгийг дурдсан байна.

Нэгэн баян хүн Эзэн Есүсийн яриаг тасалдуулж, нэг зүйлийг чин сэтгэлээсээ сонирхон лавлав. Тэрээр Эзэн Есүсийг **“Сайн Багш”** хэмээн дуудаж, **мөнх амийг олохын тулд юу хийх ёстойг асуув.** Гэхдээ асуусан асуултыг нь харвал тэр хүн Эзэн Есүсийг таниагүйн дээр авралын замыг ойлгоогүй ажээ. Тэр хүн “Багш” гэж дуудсан нь Есүсийг агуу хүмүүсийн нэг гэж үзсэнийг харуулдаг. Тэрээр

Есүсийг бусад хүнтэй нэг түвшинд тавьжээ. Түүнээс гадна тэрээр **мөнх амийг** бэлэг гэдгийг эс ойлгож, цалин мэтээр ханджээ.

**[19:17]** Тэгэхэд бидний Эзэн **“Чи юунд намайг сайн хэмээн дуудна вэ? Сайн нь зөвхөн ганц бөгөөд тэр нь Бурхан юм”** хэмээн асууж тэр хүнийг туршин шалгав. Есүс энд өөрийгөө Бурхан болохыг үгүйсгэсэндээ бус, харин **“Та Бурхан болохоор л би таныг сайн гэж дуудлаа”** гэж хэлэх боломжийг тэр хүнд олгожээ.

Дараа нь Есүс аврагдах замын талаар тэр хүнийг туршин шалгахын тулд **“Хэрэв чи амьтай болохыг хүсэж байгаа бол тушаалуудыг сахь”** хэмээн хэлсэн. Аврагч Эзэн маань аврагдахын тулд хүн тушаалуудыг сахих хэрэгтэй гэдэг санаагаар үүнийг хэлээгүй юм. Харин тэр хүний зүрхэнд нүглээ ухаарах сэтгэлийг төрүүлэхийн тулд хуулийг ашигласан байна. Тэгсэн ч гэсэн өнөөх хүн тэнгэрийн хаанчлалд үйлсээр орж чадна гэсэн төөрөгдлөөсөө салсангүй. Тийм ч учраас ямар хуулиудыг сахих вэ гэж асуусан.

**[19:18-20]** Тэгэхээр нь Эзэн Есүс тухайн хүнд хамаатай таван тушаалыг иш татаад, оргил хууль болох **“Чи хөршөө өөрийн адил хайрла”** гэснийг дээр нь нэмж хэлсэн. Өнөөх эр хувиа хичээсэн байдалдаа сохорсон тул тэр бүх тушаалыг **сахисан** хэмээн бардамнан сайрхжээ.

**[19:21]** Хөршөө өөрийн адил хайрладаггүйг нь харуулахын тулд Эзэн Есүс түүнд **“Чи бүх эд**

**хөрөнгөө зарж мөнгө болгон ядууст өгөөд ирж намайг дага” гэжээ.**

Эд хөрөнгөө зарж, сайн үйлсийн төлөө хандивлавал аврагдана гэсэн санаагаар Эзэн Есүс энэ үгийг хэлээгүй юм. Аврагдах цорын ганцхан зам бий. Тэр нь Эзэн Есүст итгэх билээ.

Гэхдээ аврагдахын тулд хүн нүгэлтэй болохоо ойлгож, Бурханы ариун шаардлагуудад хүрэхгүй гэдгээ мэдэх хэрэгтэй. Энд гарч байгаа баян эр эд хөрөнгөө бусадтай хуваалцахыг хүсээгүй. Тэгэхээр тэрээр хөршөө өөрийн адил хайрладаггүй гэсэн үг. Тэр хүн Есүст хандан, “Эзэн минь, тийм шаардлага байдаг бол би нүгэлтэн юм байна. Хичээл зүтгэлээр би өөрийгөө аварч чадахгүйгээ ойлголоо. Нигүүлслээрээ та намайг авраач” гэх хэрэгтэй байв. Тэрээр Аврагч Эзэний үгийг дагасан бол авралын замыг заалгах байсан.

**[19:22]** Даанч тэр тэгсэнгүй. Харин **гунигтайгаар холдон явлаа.**

**[19:23, 24]** Есүс баян хүний хандлагыг үзээд **“Баян хүн тэнгэрийн хаанчлалд орох нь нэн бэрх аж”** гэв. Хүн эд баялгийг шүтээн болгох хандлагатай байдаг. Эд баялагтаа найдахгүй амьдарна гэдэг тэдэнд маш хэцүү ажээ. Тийм учраас Эзэн Есүс **“Баян хүн тэнгэрийн хаанчлалд орохоос тэмээ зүүний сүвэгчээр нэвтрэх нь илүү хялбар”** гэж мэдэгдсэн юм. Есүс энд ярианы хэтрүүлэл ашиглаж байна. Хэлж байгаа үгээ мартагдахааргүй нөлөөтэй болгохын тулд ийм аргыг ашигладаг.



Мэдээж хэрэг тэмээ зүүний сүвэгчээр нэвтрэх ямар ч боломжгүй. “Зүүний сүвэгч” гэж хотын хаалганд байх жижиг хаалгыг хэлдэг байсан гэх тайлбар бий. Тийм хаалгаар тэмээ мөлхөж, ихэд зүдрэн ордог байв. Гэхдээ үүнтэй ижил зүйл ярьсан Лукийн хэсэгт мэс заслын үед ашигладаг зүүг хэлдэг үгийг ашигласан. Хам сэдвийг нь харсан ч, Эзэн Есүс хэцүүгийн тухай биш, харин боломжгүй байдлыг ярьж байна. Хүний талаас бол баян хүнд аврагдах ямар ч боломж байхгүй.

**[19:25]** Үүнийг сонсоод **шавь нар нь ихэд гайхав**. Мосегийн хуулийг дагавал Бурхан ивээлээ хайрлана гэсэн бөгөөд уг хуулийн дор амьдарч асан иудейчүүд баян байхыг Бурханы ерөөл хэмээн үздэг байв. Хэрэв Бурханы ерөөлийг хүртсэн хүн аврагдаж чадахгүй юм бол тэгээд хэн чадах юм бэ?

**[19:26]** Эзэн хариуд нь **“Энэ нь хүмүүст боломжгүй, харин Бурханд бүх юм боломжтой”** гэж айлдав. Хүний талаас бол ямар ч хүнд аврагдах боломж байхгүй. Зөвхөн Бурхан л хүний сүнснийг аварч чадна. Гэхдээ өөрийн хүслээсээ татгалзаж, Христэд бууж өгөх нь ядуу хүнийг бодвол баян хүнд илүү хэцүү. Тийм ч учраас Христэд итгэсэн баячууд ядуусаас цөөн байдаг. Нүдэнд харагдах амьдралын баталгаагаа үл үзэгдэх Аврагчаар солино гэдэг тэдний хувьд бараг боломжгүй зүйл юм. Зөвхөн Бурхан л тийм өөрчлөлтийг хийж чадна.

Библи тайлбарлагчид болоод номлогчид христитгэгч хүнийг баян байж болно гэж ярихдаа энэ эшлэлийг ашигладаг. Мөнх амийг авахад эд баялаг саад болдог тухай ярьсан Эзэний үгийг ашиглаад газар дээр баялаг хураахыг зөвтгөж байгаа нь нэн хачирхалтай. Дутагдаж гачигдагсад, хэрэгцээ нь эс хангагдагсад газар сайгүй амьдарч, Христ хэзээ мөдгүй эргэж ирэхээр байхад, бас Эзэн маань газар дээр эд баялаг бүү хураа гэж тушаасан байхад христитгэгч хүн яаж эд баялгаас зуурсаар байж чадах юм бэ? Бид хөрөнгө мөнгө цуглууулж, баяжсанаараа хөршөө өөрийн адил хайрладаггүйн буруутан болно.

### **Ж. Өөрийгөө золиослон амьдарсан хүмүүст өгөгдөх шагналын тухай (19:27-30)**

[19:27] **Петр** Аврагч Эзэний сургаалын гол санааг ойлгожээ. Эзэн Есүс “Бүхнээ орхиод Намайг дага” гэж буйг ухаарсан тэрээр **“Бид бүх зүйлийг орхиод таныг дагасан. Тэгвэл бид юу хүртэх вэ?”** гэж асуув. Энд Петрийн махбодын чанар, хуучин хүн илрэн гарч байна. Ийм сэтгэлээс бид өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй. Тэрээр Эзэн Есүстэй тохиролцоо хийх гэж оролдож байна.

[19:28, 29] Тэгэхэд нь Эзэн Есүс, өөрийнх нь төлөө хийсэн бүхэн зохих шагналаа авна гэдгийг Петрт батлан хэлсэн. Тэр дундаа арван хоёр шавь нь мянган жилийн хаанчлалд эрх бүхий байр сууринд суух болно. **Дахин сэргэлт** гэдэг нь

ирээдүйд газар дэлхий дээр ноёрхох Христийн захиргааг хэлж байна. **“Хүний Хүү өөрийн сүр жавхлантаг сэнтийдээ залрах үед”** гэдэг үгээс үүнийг харж болно. Энэ бол хаанчлал биетээр газар дэлхий дээр орших үе юм. Тэр үед арван хоёр шавь **Израилийн арван хоёр овгийг шүүж, арван хоёр сэнтийд залрах болно.** Шинэ гэрээнд гарч буй шагналууд нь мянган жилийн хаанчлалд эзлэх байр суурьтай холбоотой байдаг (Лук 19:17, 19-ийг үз). Шагналыг Христийн шүүх суудлын өмнө гардуулан өгөх боловч Эзэн Есүсийг газар дэлхий дээр хаанчлахаар эргэн ирэх үед үзэгдэх болно.

Харин жирийн итгэгчдийн талаар Эзэн Есүс **“Миний нэрийн төлөө өөрийн гэр орноо, ах дүүсээ, эгч дүүсээ, эсвэл эцэг эхээ, хүүхдүүдээ, эсвэл эдлэн газраа орхисон хүн бүр зуу дахин ихийг хүртэх бөгөөд мөнх амийг хүртэнэ”** гэж айлджээ. Энэ амьдралдаа тэд цусан төрлийн холбоотой хүмүүсээсээ саллаа ч, дэлхий даяар байх итгэгчдийн нөхөрлөл тэднийг хүлээн авна. Тэд гэр бүлээ орхивол ганц айлыг орхино. Харин халуун дотноор угтан авах зуун зуун итгэгч айл тэдэнд бий. Эдлэн газар, эд хөрөнгөөсөө хагацавч, тооцох аргагүй үнэтэй сүнслэг баялаг тэдэнд өгөгдөнө.

Бүх итгэгчдийн ирээдүйн шагнал бол **мөнх амь** мөн. Гэхдээ бүхнээ орхиж, хамгаа золиослон байж мөнх амийг хүртэнэ гэсэн утга энд байхгүй. Мөнх амь бол бэлэг. Тиймээс түүнийг ямар нэг үйлс, гавьяа, зүтгэлээр олж авах боломжгүй. Энд

ярж байгаа зүйл бол шагнал. Бүхнээ орхисон хүмүүс тэнгэр дэх мөнх амийг хүртэхдээ бусдаас илүү давуу талыг олно гэсэн үг. Итгэгч бүгд амьтай боловч тэрхүү мөнх амьдралдаа бүгд адилхан байр сууринд заларч, ижил хувь завшааныг эдлэхгүй.

**[19:30]** Эцэст нь Эзэн Есүс тохиролцоо, наймаацах гэсэн сэтгэлийг сэрэмжлүүлж байна. Петрт хэлсэн үг бол “Миний төлөө хийсэн бүхэн чинь шагнагдана. Гэхдээ хувиа бодсон хандлагад хөглөгдөхөөс сэрэмжил, эс бөгөөс **эхэнд байгаа олон хүн сүүлчийнх болж, сүүлчийнх нь эхнийх болно**” гэсэн хэрэг. Үүнийг дараагийн бүлэгт өгүүлсэн сургаалт зүйрлэлд тодорхой харуулсан. “Эхэнд байгаа нь сүүлчийнх болж, сүүлчийнх нь эхнийх болно” гэсэн үг нь, дагалдагчийн замд гараанаас сайн гарлаа гээд хангалттай биш шүү гэдгийг сэрэмжлүүлсэн байж болох юм. Хэрхэн эхлэх нь биш, харин хэрхэн дуусгах нь л чухал билээ.

Энэ хэсгийг өндөрлөхийн өмнө анхаарч харах ёстой нэг зүйл бий. Юу гэвэл, “тэнгэрийн хаанчлал”, “Бурханы хаанчлал” гэх үгсийг 23, 24 дүгээр эшлэлд ашиглахдаа нэгээр нь нөгөөг нь орлуулжээ. Тиймээс энэ хоёр үг яг адилхан утгатай.

### **3. Усан үзмийн талбайд ажилласан хүмүүсийн шан хөлсний тухай сургаалт зүйрлэл (20:1-16)**

**[20:1, 2]** Энэхүү сургаалт зүйрлэл нь 19 дүгээр бүлгийн төгсгөлд өгүүлсэн шагналын

тухай ярианы үргэлжлэл юм. Жинхэнэ дагалдагч бүхэн шагнал авах боловч, шагнагдах эрэмбэ нь тухайн дагалдагчийн үйлчилсэн хандлагаар тодорхойлогдоно гэдгийг Эзэн Есүс үүгээр хэлэхийг зорьжээ.

**Нэгэн газрын эзэн усан үзмийн талбайдаа ажиллуулах хүмүүсийг хөлслөхөөр өглөө эрт гарч** буй үйл явдлаар уг сургаалт зүйрлэл эхэлдэг. Тэр хүмүүс **өдрийн нэг денарын** хөлсөөр ажиллахаар тохиролцов. Энэ нь тухай үедээ боломжийн цалин байв. Бүгдээрээ тэднийг өглөөний 6:00 цагт ажиллаж эхэлсэн гэж бодъё.

**[20:3, 4]** Газрын эзэн өглөөний 9:00 цагт дахин гадагш гарч зах дээр **ажилгүй зогсож буй** өөр хүмүүсийг олж хөлслөв. Энэ удаа тэд хөдөлмөрийн гэрээ байгуулсангүй. **Би та нарт шударгаар төлнө** гэсэн үгэнд найдаад тэд явж ажиллажээ.

**[20:5-7]** Газрын эзэн үд дунд болон өдрийн 3:00 цагт дахиад олон хүнийг олж, шударга хөлс өгнө гээд ажиллуулав. Оройны 5:00 цагт тэр дахиад ажилгүй байсан хүмүүсийг хөлслөв. Тэд залхуудаа ажилгүй суугаагүй юм. Ажиллах хүсэл байсан боловч ажил олоогүй болохоор орой болтол ажилгүй байжээ. Тиймээс газрын эзэн тэднийг **усан үзмийн тариалан уруу** явуулав. Ингэхдээ тэдэнд цалин хөлсний талаар юу ч ярьсангүй.

Хамгийн эхний хүмүүс тохиролцоо гэрээнд үндэслэн ажиллах болсон гэдгийг та эндээс

анзаарах хэрэгтэй. Бусад нь хөлс мөнгөний асуудлыг газрын эзэнд даатгажээ.

**[20:8]** Ингээд ажлын өдөр дуусахад газрын эзэн ажилчдад хөлсийг нь өгөхийг даамалдаа үүрэгдэв. Ингэхдээ сүүлд хөлслөгдсөн хүмүүсээс эхэлж хамгийн түрүүнд хөлслөгдсөн хүмүүсийн хөлсийг сүүлд нь өг гэв. (Тиймээс хамгийн түрүүнд ажилд орсон хүмүүс бусдынхаа авсан мөнгийг харсан байна.)

**[20:9-12]** Хүн бүхэн ижил цалин авч байв. Бүгд нэг денар авав. Өглөөний 6:00 цагт ажилд орсон хүмүүс их ажилласан болохоор илүү хөлс авна гэж бодсон ч тэгсэнгүй. Тэд ч гэсэн нэг денар авчээ. Тэд хамгийн урт цагаар **өдрийн халуунд** ажилласан байхад ийм хөлс өгсөнд нь газрын эзэнд дургүйцэн гомдоллоцгоов.

**[20:13, 14]** Газрын эзнээс тэдний нэгэнд өгсөн хариулт маш чухал сургамжийг бидэнд өгдөг. Эхлээд тэр **“Анд минь, би чамд ямар ч буруу юм хийгээгүй. Чи нэг денараар ажиллана гэж надтай тохирсон биш үү? Өөрийнхөө хөлсийг аваад замаараа явж үз. Харин би сүүлчийн энэ хүнд чамд өгсөнтэй адил хөлс өгөхийг хүсэж байна”** гэж хэлсэн. Эхэнд хөлслөгдсөн хүмүүс өдрийн нэг денараар ажиллахаар тохиролцсон бөгөөд уг хөлсөө авсан. Харин бусад нь өөрсдийгөө газрын эзний нигүүлсэлд даатгаад, тэрхүү нигүүлсэлээ хүртсэн. Нигүүлсэл бол шударга ёсноос сайхан билээ. Эзэн Есүстэй тохиролцож, юу авах талаар

наймаа хийснээс нигүүлсэлд нь шагналаа даатгавал илүү дээр.

**[20:15]** Газрын эзэн дараа нь **“Өөрийнхөө юмыг хүссэнээрээ зарах нь миний хувьд ёс бус юм гэж үү?”** гэсэн. Бурхан хамгийн дээд эрх мэдэл бөгөөд хүссэнээ хийх эрхтэй. Тэрээр таалсан зүйлээ үйлддэг. Гэхдээ түүний таалсан зүйлс нь үргэлж зөв, шударга, зохистой байдаг. Газрын эзэн цааш нь **“Эсвэл өгөөмөр зангаас минь болж нүдэнд чинь атаархал хурав уу?”** гэсэн. Энэ асуулт хүний мөн чанар дахь хувиа хичээсэн занг илчилж байна. Өглөөний 6:00 цагаас ажилласан хүмүүс авах ёстойгоо авсан боловч бага цаг ажиллаж ижил хөлс авсан хүмүүст атаархсан. Бидний дотор ч гэсэн үүнийг шударга бус гэх хүмүүс байгаа биз ээ. Тэгэхээр энэ нь тэнгэрийн хаанчлалд бид цоо шинэ бодол сэтгэлтэй байх ёстойг л харуулаад байгаа юм. Бид шунал хүслээ гэж, өрсөлдөх сэтгэлээ хаяж, Эзэн Есүс шиг бодолтой болох хэрэгтэй.

Тэр хүмүүст бүгдэд нь мөнгө хэрэгтэйг газрын эзэн мэдэж байсан. Тиймээс шуналынх нь дагуу биш, харин хэрэгцээнийх нь дагуу тэдэнд хөлс төлсөн. Авах ёстойгоосоо багыг авсан хүн нэг ч байгаагүй. Өөрсдийнх нь болоод гэр бүлийнх нь хэрэгцээг хангаж чадах хэмжээний мөнгийг газрын эзэн тэдэнд өгчээ. Жеймс Стюард энэ сургаалт зүйрлэлийг дүгнэн, “Ашиг харж, шагналынхаа талаар тохиролцоо хийдэг хүмүүс алдаж байгаа нь тэр. Тийм хүмүүс эцэст нь Бурханы хайр энэрлийг үзээд ямагт амаа

барьдаг”<sup>39</sup> гэжээ. Уг сургаалт зүйрлэлийг энэ талаас хараад судлах бүр Бурханы шударгыг ойлгохоос гадна түүний сайхан сэтгэлийг улам л таньж мэддэг. Өглөөний 6:00 цагт ажилд гарсан хүмүүс ийм гайхалтай эзэнд өдөржин үйлчилснийгээ урамшуулал цалин мэт үзэх хэрэгтэй байжээ.

**[20:16]** Есүс сургаалт зүйрлэлээ төгсгөхдөө **“Тиймээс сүүлчийнх нь эхнийх болж, эхнийх нь сүүлчийнх байх болно”** гэж айлдав (19:30-г үз). Шагнал гардуулах үе ирэхэд үүн шиг гайхал төрүүлэх зүйлс гарах болно. Өөрсдийгөө эхэнд байна гэж бодсон хүмүүс сүүлчийнх болно. Яагаад гэвэл тэд бардамнал болоод хувийн ашиг сонирхлын үүднээс үйлчилсэн учраас тэр юм. Харин хайр ба талархлаар үйлчилсэн хүмүүс өндрөөр үнэлэгдэнэ.

Гавьяа байгууллаа гэж бодсон үйлс нь

Гэм нүглийн улбаатай байсныг харуулна тэр

Гэтэл, санаанаас арчигдсан өчүүхэн үйлдэл нь

Гарцаагүй түүний төлөө байсныг харуулна тэр

-Анон

## **И. Эзэн Есүсийн үхэл ба амиллын тухай (20:17-19)**

Эзэн Есүс Переаг орхиж, **Иерусалим** өөд явахдаа Иерихогоор дайрсан нь (29 дүгээр эшлэлийг үз) тодорхой харагддаг. Тэрээр **арван хоёр шавиа дэргэдээ аваад** ариун хотод өөрийг нь юу хүлээж байгааг дахин ярив. Тэрээр **ахлах тахилчид, хуулийн багш нарт тушаагдах**



болно. Энэ үг Иудасын итгэл эвдсэн үйлдлийг хэлжээ. Иудейн удирдагчид Түүнийг **алахаар яллана**. Гэхдээ ялыг гүйцэлдүүлэх эрх мэдэлгүй учраас тэд түүнийг **харь үндэстнүүдэд** (ромчууд) **тушаана**. Харь үндэстнүүд түүнийг доромжилж, ташуурдаж, цовдолно. Гэсэн ч үхлийн хүч түүнийг тогтоон барьж дийлэхгүй бөгөөд Тэрээр **гурав дахь өдрөө амилах болно**.

#### **К. Хаанчлалд эзлэх байр суурийн тухай (20:20-28)**

Зовлон эдэлж, үхэхээ ярьсны дараа дагалдагчид зовлонгийнх нь тухай бодохын оронд өөрсдийнхөө сүр жавхлан, яруу алдар дээр төвлөрч байсан нь хүний нүгэлт мөн чанарыг бэлхнээ илтгэн харуулах мэт.

Христ зовлон эдлэх тухайгаа хамгийн анх ярихад Петр түүнд нь дургүйцсэн (16:22). Хоёр дахь удаагаа ярьсны дараахнаас шавь нар нь “Хэн хамгийн агуу вэ?” гэсэн асуултыг хөндсөн. Харин энд Тэр гурав дахь удаагаа ярьж байна. Гэтэл араас нь Иаков, Иохан нар хувийн ашиг сонирхол агуулсан хүсэлт тавьсан. Удахгүй зовлон ирнэ гэдгийг хэлсээр байхад Түүнийг ойлгох сэтгэл тэдэнд байсангүй. Харин ч сүр жавхлантад алдрын тухай үгийг л хүлээн авсан байв. Тиймдээ ч хаанчлалыг зөвхөн материаллаг талаас нь харж, буруу ойлгожээ (Бичвэрийн

Холбооноос гаргадаг Өдөр Бүрийн Сургамж ном).

**[20:20, 21]** Иаков, Иохан нарын эх Эзэн Есүс дээр ирээд хаанчлалаа байгуулахдаа хөвгүүдийг нь өөрийнхөө хоёр талд суулгаж өгөхийг гуйв. Хоёр хүү нь Есүстэй ойр байвал хаанчлалд тэр сэтгэл хангалуун байж чадна. Гэвч Бурханы хаанчлалд хүнийг хэрхэн өргөмжилдөг зарчмыг тэр ойлгоогүй ажээ.

Маркийн сайнмэдээнд болохоор энэ хүсэлтийг Иаков, Иохан нар өөрсдөө тавьсан гэж бичсэн (Марк 10:35). Гэхдээ Матайн тэмдэглэлтэй зөрчилдсөн зүйл энд үгүй. Тэд ээжийнхээ ятгалгаар хүсэлт тавьсан байж болно. Эсвэл ээжтэйгээ гурвуулаа Эзэн Есүс дээр ирсэн байх магадлалтай.

**[20:22]** Юу асууж буйгаа ойлгохгүй байгааг нь Эзэн Есүс тэдэнд шулуухан хэлсэн. Тэд загалмайгаар дамжихгүйгээр титэм авахыг хүсжээ. Тахилын ширээг алгасаад сэнтийд заларч, зовлон амсахгүйгээр сүр жавхлан хүртэхийг хүсжээ. Тиймээс Есүс тэднээс “**Миний уух аяганаас та нар ууж чадах уу?**” гэж асуув. Аяга гэж юу хэлснийг бид гайхах хэрэггүй. Юу болохыг нь тэр 18, 19 дүгээр эшлэлд тодорхой дурдсан. Тэр зовлон эдэлж, үхэх ёстой.

Иаков, Иохан нар эдлэх зовлонг нь хуваалцаж чадна гэсэн боловч мэдлэгээр бус,

сэтгэлийн хөдлөлөөр ийм итгэлтэй хариулсан болов уу.

**[20:23]** Аяганаас нь тэд гарцаагүй ууна гэдгийг Эзэн Есүс хэлсэн. Иаков итгэлийнхээ төлөө амиа алдсан. Харин Иохан Патм арал уруу цөлөгдсөн. Роберт Литл энэ тухай: “Иаков амиар гэрчлэгчийн үхлээр үхсэн бол Иохан амиар гэрчлэгчийн амьдралаар амьдарсан” гэсэн байдаг.

Хаанчлалын эдгээр хүндэт байр суурийг хэн нэгэнд өөрийн дураар олгохгүй бөгөөд эдгээр байр сууринд хэн суухыг тодорхой шалгуурт үндэслэн **Эцэг** шийднэ гэдгийг Есүс тайлбарлаж өгсөн. Иаков, Иохан нар Христтэй маш ойр дотно байсан учраас Түүний дэмжлэгээр энэ байр сууринд сууж чадна гэж эндүүрчээ. Гэвч хэнд илүү талтай вэ гэдгээр үүнийг шийдэхгүй ажээ. Бурханы төлөвлөгөө ёсоор бол Эзэн Есүсийн төлөө хэн их зовлон эдэлсэн нь Түүний баруун, зүүн талд суух болно. Тэгэхээр Бурханы хаанчлалын тэргүүн суурийг авах хүмүүс нэгдүгээр зууны итгэгчдээр хязгаарлагдахгүй гэсэн үг юм. Өнөөдөр амьдарч байгаа хүмүүсийн зарим нь тэднээс илүү зовлон амсаж, тэдний түрүүнд гарах боломжтой.

**[20:24]** Зебедеен хөвгүүд ийм зүйл хүссэнийг сонсоод бусад **арван** шавь нь **ах дүү хоёрт зэвүүцэв**. Тэд өөрсдөө хамгийн агуу нь байхыг хүссэн учраас ийнхүү уурлаж, Иаков, Иохан хоёр өрсөж хүсэлт тавьсанд нь дургүйцсэн бололтой.

[20:25-27] Тэдний энэ байдлаас улбаалж, Бурханы хаанчлалын агуу байдал юунд үндэслэдэг тухай гайхамшигт мэдэгдлийг Эзэн Есүс хэлсэн билээ. **Харь үндэстнүүд** бусдыг захирч, захиргаадаж байгаагаар агуу байдлыг хэмждэг бол Бурханы хаанчлалд агуу байдал нь үйлчлэлээр илэрдэг. Агуу болохыг хүссэн хүн **зарц** болох хэрэгтэй. **Тэргүүнд байхыг** хүссэн хүн **боол** болох хэрэгтэй.

[20:28] **Хүний Хүү** дорд үйлчлэлийн төгс жишээг бидэнд үзүүлсэн. Тэрээр **үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд, амиа олны төлөө золиос болгон өгөхөөр** энэ дэлхийд ирсэн билээ. Бурхан хүмүүн биеэр ирсэн учрыг “үйлчлэх, өгөх” гэсэн хоёрхон үгээр илэрхийлж болно. Өндөр дээд Эзэн малын тэвш ба загалмай уруу доош бууж, өөрийгөө тийм дорд болгосныг бодох үнэхээр гайхалтай. Хэр их дорд болсон бэ гэдгээс нь тэр хэр их агуу вэ гэдэг нь харагддаг. Энэ зарчим бидэнд ч гэсэн адил юм.

#### **Л. Хоёр сохор хүнийг эдгээсэн нь (20:29-34)**

[20:29, 30] Есүс Переагаас гарч, Иорданыг гатлаад **Иериход** иржээ. Тэгээд Иерихо хотоос гараад явж байтал **хоёр сохор** Түүн уруу хандан чангаар “**Давидын Хүү, Эзэн минь ээ, биднийгээ өршөөгөөч**” гэж хашхиралдав. Тэдний махбодын нүд сохор ч гэлээ сүнсний нүд нь маш хурц ажээ. Учир нь Есүс бол Мессиа гэдгийг тэд таньсан. “**Давидын Хүү**” гэдэг үгийг ашигласан байдлаас үүнийг харж болно. Хожим

Есүс ноёрхлоо тогтоохоор буцан ирэхийн өмнөхөн сохорсон Израилийн итгэгч үлдэгсэд Түүнийг Христ болохыг таньж, хүлээн авах болно. Энэ хоёр сохор хүн тэднийг бэлгэдэн төлөөлсөн байж болох юм (Исаиа 35:5; 42:7; Ром 11:25, 26; 2Коринт 3:16; Илчлэл 1:7).

**[20:31-34]** Тэнд цугласан олон түмэн тэр хоёр хүнийг болиулах гэж оролдсон боловч **тэд улам чангаар хашхирав.** Есүс тэднээс юу хүсэж байгааг нь асуухад тэд бидний залбирал шиг бүдэг бадаг ерөнхий юм ярилгүй, **“Эзэн, нүд маань нээгдэхийг бид хүсэж байна”** гэв. Тэд хүсэлтээ тодорхой хэлсэн учраас хариугаа ч тодорхой авсан. **Есүс тэднийг ихэд өрөвдөж, нүдэнд нь гар хүрэхэд тэр даруй тэд хараа орж, түүнийг дагалаа.**

Эзэн Есүс тэдэнд гар хүрч харааг нь эдгээсэн явдлыг Гаебелейн ажиглаад маш ашиг тустай дүгнэлт хийсэн байдаг:

Эзэн Есүс өвчтөнд гар хүрч эдгээх нь Матайн сайнмэдээнд ямар бэлгэдлийн утгатайг бид өмнө үзсэн. Эзэн Есүс хүнийг эдгээхдээ гар хүрэх нь Бурханы диспенсаци хөтөлбөрийн хувьд өөрөө газар дэлхий дээр биеэр байж, Израильд өршөөнгүй хандахыг заадаг. Харин алсаас, хүний итгэлээр дамжин хүрч, үгээрээ эдгээсэн тохиолдлууд нь өөрөө газар дэлхий дээр байхгүй үеийг заадаг. Тэр үед өөрт нь итгэлээр ойртох харь үндэстнүүдийг тэр эдгээнэ.<sup>40</sup>

Энэ үйл явдлыг тэмдэглэсэн Матайн тэмдэглэл нь Марк 10:46-52 ба Лук 18:35-43, 19:1-ийнхээс зөрүүтэй мэт харагддаг. Энд хоёр сохор хүн гарч байна. Харин Марк болон Лукийн тэмдэглэлд нэг сохор хүн гардаг. Марк, Лук нар хүмүүсийн сайн таньдаг Бартимай гэгч нэгийг нь л онцлон дурдсан бололтой. Харин Матайн сайнмэдээ нь голчлон иудейчүүдэд зориулагдсан болохоор тэнд байсан хоёр хүнийг хоёуланг нь дурдсан болов уу. Учир нь иудейчүүдийн үзлээр, дор хаяж хоёр хүн байвал тухайн гэрчлэл хүчин төгөлдөр болдог (2Коринт 13:1). Өөр нэг зөрүүтэй мэдээлэл гэвэл Матай, Маркийн сайнмэдээнд тэмдэглэснээр Есүс Иерихогоос гарч явах үед энэ үйл явдал тохиолджээ. Харин Лукийн сайнмэдээнд Есүс Иерихо уруу ойртож байхад ийм явдал болсон гэж тэмдэглэсэн байна. Үүнийг ойлгохын тулд хоёр Иерихо байсныг мэдэх хэрэгтэй. Хуучин Иерихо ба шинэ Иерихо. Есүс нэг Иерихогоос гарч, нөгөө Иерихо уруу нь орж явах үедээ энэ гайхамшгийг үйлдсэн болов уу.

## **ХИ. ӨӨРИЙГӨӨ ХААН БОЛОХЫГ ИЛЭРХИЙЛСЭН БОЛОВЧ АРД ТҮМЭН НЬ ХҮЛЭЭН АВСАНГҮЙ (21-23-р бүлэг)**

### **А. Иерусалим уруу ялгууснаар орсон нь (21:1-11)**

**[21:1-3]** Эзэн Есүс Иерихогоос гараад явж байх замдаа Бетан, **Бетфагийн** байрладаг **Чидун уулын** зүүнтээд ирэв. Тэндээс зам Чидун уулын

өмнө үзүүрт хүрч, цаашаагаа Иехошафатын хөндий уруу уруудаад, Кидрон горхийг гаталж, **Иерусалим** өөд өгсдөг.

Есүс **хоёр шавиа** Бетан уруу илгээхдээ уг тосгоноос **уяатай илжгийг дудрантайгаа байгааг олно** хэмээн урьдаас хэлж өгөв. Есүс тэдэнд “Уяаг нь **тайлаад** тэднийг **Над уруу авчир. Хүн юм хэлбэл ‘эд Эзэнд хэрэгтэй’ гэж хэлээрэй.** Эзэн нь цааргалахгүй” гэж зааварчлав. Илжигний эзэн Есүсийг мэддэг байсан бөгөөд тусална гэж өмнө нь хэлсэн байх магадлалтай. Аль эсвэл Эзэн Есүсийн бүхнийг мэдэгч хүч ба дээдийн дээд эрх мэдлийг энэ үйл явдал харуулж байна. Бүх зүйл Есүсийн хэлсний дагуу болжээ.

[21:4-5] Эзэн Есүс Иерусалим уруу очихдоо дудрантай илжиг унаж Зехариагийн зөгнөлийг биелүүлэв. Уг зөгнөлд:

**“Сионы охинд хэл.**

**Харагтун, Хаан чинь чам уруу очиж явна.**

**Илжиг ба илжигний төл дудран унаад**

**Эгэл даруухнаар очиж байна.”**

[21:6] **Шавь нар** илжиг ба дудран дээр хувцсаа тохонгуут Есүс дудран дээр мордон (Марк 11:7) Иерусалимын зүг явав. Энэ бол түүхэн мөч байлаа. Сер Роберт Андерсоны тооцоолсноор (Энэ тооцоог нь Ирж буй Жонон номоос нь үзэж болно) энэ үед Даниелийн эш үзүүллэгийн жаран ес дэх долоо хоног дууссан. Одоо Мессиа таслагдах ёстой (Даниел 9:26).

Эзэн Есүс илжиг, дудран унаад Иерусалим уруу очсон нь өөрийгөө Мессиа гэдгийг илэрхий

тунхагласан явдал юм. Ланж энэ талаар дараах тайлбарыг хийсэн байна:

Тухайн цаг үед ямар ч эргэлзээгүйгээр Мессиад хамаатуулан тайлбарлаж байсан эш үзүүллэгийг Есүс зориудаар биелүүлжээ. Өмнө нь Тэр өөрийнх нь хэн болохыг тунхаглах аюултай хэмээн үзэж байсан бол, одоо харин чимээгүй байж болохгүй гэж үзжээ. Есүс өөрийнхөө хэн болохыг бүдэг бадаг, тодорхойгүй тунхагласан гэж хэлэх боломж үүнээс хойш үлдсэнгүй. Иерусалим хот Мессиагийн үхэлд буруутгагдах үедээ Мессиа ойлгомжтой тэмдэг өгөөгүй хэмээн хэлж чадахгүй болжээ.<sup>41</sup>

[21:7, 8] Эзэн Есүс Иерусалим уруу илжиг унаад ойртох үед хүмүүс дээл хувцсаа тайлж, дал модноос мөчир огтлон зам дээр нь дэвсэж, баяр хөөр, магтаалын дуугаар угтан авав. Хүмүүс хэсэг хугацаанд ч болов Түүнийг Хаан хэмээн хүндэлжээ.

[21:9] Хурсан олон “Давидын Хүүд Хосанна! Эзэний нэрээр ирэгч нь ерөөлтэй е!” гэж хашхиралдаж байлаа. Дуулал 118:25, 26-аас иш татсан энэ үг яалт ч үгүй Мессиагийн ирэлттэй холбогддог. Хосанна гэдэг нь “одоо авраач” гэсэн утгатай. Хүмүүс тухайн үед “Биднийг Ромын дарлалаас авраач” гэсэн утгаар ийнхүү хашхирч байсан болов уу. Харин хожим нь энэ үг магтаалын уухай болж хувирсан. “Давидын Хүү”, “Эзэний нэрээр ирэгч нь



**ерөөлтэй еэ!”** гэж хэлснээс харахад хүмүүс Есүсийг тэр мөчид Мессиа гэж үзжээ. Есүс бол Иеховагийн эрх мэдлээр хүслийг нь гүйцэлдүүлэх гэж ирсэн Ерөөлт Нэгэн мөн.

Маркийн тэмдэглэлийг үзвэл, хурсан олны зарим нь “Бидний эцэг Давидын ирж буй хаанчлал ерөөлтэй еэ!” (Марк 11:10) хэмээн хашхирч байсан. Тэгэхээр хүмүүсийн дотор “Христ Давидын сэнтийд сууж Бурханы хаанчлалыг байгуулах гэж байна” гэсэн бодол байсан нь тодорхой. Бас тэд **“Хамгийн дээдэд Хосанна!”** хэмээж, Мессиаг магтах газрын магтаалд оролцуулахаар тэнгэрийг дуудаж, хамгийн дээд тэнгэрээс авралыг илгээгээч гэж Эзэн Есүст хашхирч байв.

Есүс Иерусалим уруу ормогцоо сүм уруу явсныг Марк 11:11 дээр тэмдэглэжээ. Гэхдээ сүмийн дотогш биш, сүмийн хашаа уруу орсон. Уг нь сүм бол Бурханы өргөө гэр. Гэтэл одоо өөрийнх нь гэр орон биш болжээ. Яагаад гэвэл тахилчид болоод ард түмэн Түүнд зүй ёсных нь байр суурийг өгөхөөс татгалзжээ. Аврагч Эзэн маань эргэн тойрныг гүйлгэн харсны дараа тэндээс гарч, арван хоёр шавьтайгаа хамт Бетан уруу явжээ. Энэ нь ням гарагийн орой байлаа.

**[21:10, 11]** Харин **Иерусалим хотынхон** тэр үеэр Түүний хэн болох талаар будилж орхицгоов. Асуусан нэгэнд нь **“Энэ чинь Галилын Назараас ирсэн эш үзүүлэгч Есүс байгаа юм”** гэдгээс өөр юм хэлсэнгүй. Тэгэхээр Есүсийг үнэхээр Мессиа гэж ухаарсан хүн тун цөөн

байжээ. Есүсийг хаан мэт угтсан энэ хувирамтгай хүмүүс долоо ч хүрэхгүй хоногийн дараа “Түүнийг цовдол! Түүнийг цовдол!” хэмээн хашхирч байсан билээ.

### **Б. Сүмийг цэвэрлэсэн нь (21:12, 13)**

**[21:12]** Есүс үйлчлэлээ эхэлж байхдаа сүмийн ойр орчимд наймаа арилжаа эрхэлж байгаа хүмүүсийг хөөн гаргасан удаатай (Иохан 2:13-16). Гэвч ашиг ихтэй энэ бизнес сүмийн гадна хашаанд дахин цэцэглэжээ. Тахилд өргөдөг мал амьтан, шувуудыг тэнд өндөр үнээр зардаг байв. Иудей хүмүүс мөнгө солигчдод өндөр үнэ төлж, гадаад мөнгөн тэмдэгтээ солиулж, сүмд төлөх ёстой хагас шекелийн татвараа төлж байлаа. Эзэн Есүс үйлчлэлээ дуусгахын өмнөхөн ариун юмсаар ашиг ологч хүмүүсийг дахин нэг удаа хөөж байна.

**[21:13]** Ариун юмсыг бузарлаж, Бурханы юмсаар ашиг хонжоо олж, сүмийг наймаа арилжааны газар болгосон явдлыг Эзэн Есүс буруушааж, эш үзүүлэгч Исаиа, Иеремиа нарын номоос иш татав. Бурхан өөрийнхөө сүмийг **залбирлын өргөө** байлгахыг хүссэн гэдгийг сануулж, Исаиа 56:7-г хэлэв. Гэтэл одоо сүм нь **дээрэмчдийн** үүр болжээ (Иеремиа 7:11).

Эзэн Есүс сүмийг ийнхүү цэвэрлэсэн нь Иерусалимд ирсний дараах анхны албан ёсны үйлдэл байв. Үүгээрээ тэр сүмийн эзэн гэдгээ харуулсан билээ.

Энэ үйл явдал өнөөгийн бидэнд хоёр сургамжийг өгдөг. Нэгт, сүм чуулганыг зах зээл, хоолны газар, мөнгө олох арга хэрэгсэл болгож буйг цэвэрлэн зайлуулахад Эзэн Есүсийн хүч чадал бидэнд хэрэгтэй. Хоёрт, Ариун Сүнсний сүм болсон бие махбодод маань Эзэн Есүсийн цэвэрлэх үйлчлэл байнга хэрэгтэй.

## **В. Тахилчид ба хуулийн багш нарын уур хорсол (21:14-17)**

**[21:14]** Дараа нь бидний Эзэн **сохор, доголон хүмүүсийг** сүмийн талбайд эдгээв. Тэрээр хаа явсан газартаа гачигдаж дутагдсан хүмүүсийг өөртөө татаж байсан бөгөөд хэрэгцээг нь хангахгүйгээр тэднийг гар хоосон буцааж байсангүй.

**[21:15, 16]** Гэвч хорсож занасан нүднүүд Түүнийг ажиглан харж байлаа. Тэр үед хэсэг хүүхдүүд Есүсийг магтан алдаршуулж, **“Давидын Хүү”** хэмээж буйг сонссон тэдгээр **ахлах тахилч ба хуулийн багш нар** ихэд хилэгнэцгээв.

Тиймээс тэд **“Та эдний юу хэлж буйг сонсож байна уу?”** гэцгээв. Өөрийг нь Мессиа гэж буй хүүхдүүдийг болиулах байх гэж тэд боджээ. Хэрэв Есүс Мессиа биш байсан бол биш гэдгээ хэлэх хамгийн зөв цаг энэ байлаа. Гэвч Есүс тийм юм ярьсангүй. Харин ч хүүхдүүдийн зөв гэдгийг хэлсэн. Тэрээр Септуагинт орчуулгаас Дуулал 8:2-ыг иш татав: **“Нялх, хөхүүл хүүхдүүдийн амнаас магтаалыг Та**

**өөрийнхөө төлөө бэлдсэн.”** Эрдэм мэдлэгтэй тахилч, хуулийн багш нар түүнийг Тослогдсон Нэгэн гэж магтахгүй юм бол бяцхан хүүхдүүд Эзэнд мөргөх болно. Хүүхдүүд заримдаа наснаасаа хэтэрсэн сүнслэг хараатай байх бөгөөд тэдний итгэл ба хайрын үгс Эзэний нэрд ердийн биш алдрыг авчирдаг.

[21:17] Эзэн Есүс шашны удирдагчдад энэ үнэнийг бодуулж орхиод, дахин **Бетан** уруу явж, тэндээ шөнийг өнгөрөөв.

### **Г. Үр жимсгүй инжрийн мод (21:18-22)**

[21:18, 19] Эзэн Есүс маргааш **өглөө** нь Иерусалим уруу дахин явав. Явж байгаад **замын хажууд таарсан нэгэн инжрийн модон дээр очин өлссөн гэдсээ цатгахаар жимс хайсан боловч навчнаас өөр юу ч олсонгүй. Есүс тэр модонд “Чамд үр жимс хэзээ ч бүү ургаг” гэхэд инжрийн мод тэр даруй хувхайрчээ.**

Тухайн үед инжрийн модны жимслэх цаг хараахан болоогүй байсан гэж Маркийн сайнмэдээнд тайлбарласан (Марк 11:12-14). Тэгэхээр жимсгүй байгаагийнх нь төлөө модыг зэмлэж буй нь Аврагч Эзэнийг маань шалтгаангүй уурладаг гэсэн ойлголтыг төрүүлдэг. Мэдээж хэрэг бидний Эзэнд тийм зан чанар байхгүй. Тэгвэл энэ явдлыг хэрхэн тайлбарлах вэ?

Библийн газар нутгийн инжрийн модны жимс навчнаасаа түрүүлж гараад, навчтай болсон үедээ хүн идэхүйц боловсорсон байдаг.

Навч нь гарчихсан байхад ямар ч жимсгүй байна гэдэг нь цаашдаа тогтмол жимс гаргахгүйг харуулдаг.

Эзэн Есүсийн гайхамшгууд дотроос энэ удаагийнх ганцаараа өөр. Христ энэ удаа ерөөгөөгүй, харин хараасан. Амь өгөөгүй, харин устгасан. Тийм учраас хүмүүс энэ түүхийг барьж шүүмжлэл гаргаж ирдэг. Гэхдээ ийм шүүмжлэл нь Христийн хэн болохыг мартаад байдаг. Христ бол Бурхан, бүх орчлон ертөнцийн Эзэн билээ. Түүний зарим үйлдэл бидэнд ойлгомжгүй байж болно. Гэхдээ Түүний хийсэн бүхэн зөв гэсэн байр сууринаас бид хандах хэрэгтэй. Энд гарч байгаа инжрийн модны хувьд гэвэл, уг мод цаашид жимс гаргахгүй гэдгийг Эзэн мэдэж байсан. Тиймээс Эзэн маань тариалангийн талбайгаасаа үржилгүй модыг зайлуулж буй тариаланчтай адил ханджээ.

Инжрийн модыг хараасан явдал нь бэлгэдлийн утгатай үйлдэл юм. Энэ үйлдэлд нь Эзэнийг маань шүүмжилдэг хүмүүсийн дотор ч ингэж үздэг олон хүн бий. Түүнийг Иерусалимд ирэхэд нь дуу шуутай хүлээн авсан байдлыг Аврагч Эзэн маань үүгээр тайлбарлажээ. Инжрийн мод нь усан үзэм ба чидуны мод адил Израиль үндэстнийг төлөөлдөг. Есүс Израиль үндэстэн дээр ирэхэд навчтай байв. Навч нь амаараа хүлээн зөвшөөрч буй байдлыг нь илэрхийлсэн. Гэвч тэнд Бурханыг гэсэн үр жимс байсангүй. Эзэн Есүс Израиль үндэстнээс жимс идэхийг хүсэж байжээ.

Инжрийн модноос нэгэнт гарчихсан байх ёстой жимс нь гараагүй учраас цаашид ч жимс гарахгүй гэдэг нь тодорхой байсан шиг үл итгэгч израильчуудаас ч бас цаашид үр жимс гарахгүй. Тиймээс Есүс инжрийн модыг хараасан. МЭ 70 онд Израилийн дээр буусан шийтгэлийг үүгээр зөгнөсөн.

Үл итгэгч Израиль үүрд үр жимсгүй байна гэдгийг санах хэрэгтэй. Харин Израилийн үлдэгсэд шүүрэлтийн дараа Мессиа уруу эргэн ирэх болно. Их зовлонгийн үе ба мянган жилийн хаанчлалын үед тэд Түүний төлөө үр жимс гаргах болно.

Энэ хэсэгт гарч буй үйл явдлыг тайлбарлах эхний утга нь Израиль үндэстэнтэй холбоотой. Гэхдээ бас амаараа хүлээн зөвшөөрдөг атлаа амьдралдаа үр жимсгүй бүх цаг үеийн хүмүүст ч хамаатай үйл явдал мөн.

**[21:20-22]** Мод ийм хурдан хувхайрсныг үзээд **шавь нар** нь гайхацгаав. Тэгэхэд нь Эзэн Есүс тэдэнд “Итгэлтэй бол та нар үүнээс ч агуу гайхамшгуудыг хийж чадна” гэж хэлжээ. Жишээлбэл, тэд **ууланд** хандан “**Дээш өргөгдөж тэнгист хаягд**” гэж хэлсэн ч **биелэх болно**. “**Та нар итгэлтэйгээр залбиран гуйсан бүх зүйлээ хүлээн авах болно.**”

Дахин хэлэхэд, юу ч гуйсан өгнө гэж хэлсэн мэт энэ этгээд амлалтыг тайлбарлахдаа бид залбирлын талаарх Библийн бүх сургаалыг хамтад нь авч үзэх хэрэгтэй. Христитгэгч хүн хүссэн бүхнээ гуйж, түүнийхээ хариуг Бурханаас

хүлээх хэрэгтэй гэсэн утгаар энд хэлээгүй. Итгэгч хүн Библид дурдсан нөхцөл шаардлагуудын дагуу залбирах хэрэгтэй.

#### **Д. Есүст хэн эрх мэдэл өгсөн бэ? (21:23-27)**

**[21:23]** Есүсийг сүмийн гаднах хашаанд сургаал зааж байхад нь ахлах тахилчид ба ахлагчид сургаалыг нь тасалдуулаад, зааж номлох, гайхамшиг үйлдэх, сүмийг цэвэрлэх эрх мэдлээ хэнээс авсныг нь асуув. Есүс ямар ч хариу өгсөн түүнийг гарцаагүй мухардалд оруулна гэж тэд найдаж байв. Есүс өөрийгөө Бурханы Хүү учраас эрх мэдэлтэй гэвэл, тэд Түүнийг Бурханыг доромжилсон хэргээр буруутгана. Эрх мэдлээ Бурханаас авсан гэвэл тэд Түүнээс баталгаа шаардана. Хэрэв хэн нэг хүнээс авсан гэвэл тэд уг эрх мэдлийг нь хүчингүйд тооцно. Яагаад гэвэл өөрсдийгөө тэд итгэл сүсгийг хамгаалагч хүмүүс гэж үздэг байсан ба ард олны сүсэг бишрэлийн асуудлыг удирдан чиглүүлэгч нарыг албан ёсоор сурган бэлтгэж, эрх олгодог хүмүүс нь тэд байв. Гэтэл Есүс ямар нэг албан ёсны сургууль төгсөөгүйн дээр Израилийн удирдагчдаас зөвшөөрөл аваагүй ажээ. Ер нь Бурханы тосолгоогоор хүч чадлыг авсан хүмүүсээс шашны мэргэжилтнүүд энэ асуултыг хэзээнээсээ л асуусаар ирсэн билээ.

**[21:24, 25]** Эзэн Есүс тэдний асуултын өдөөс нэг санал тавив. **Иоханы баптисм нь тэнгэрээс эсвэл хүмүүсээс гэдгийн аль нь болохыг хэлж өгвөл өөрийн эрх мэдлийн талаар**

тайлбарлана гэж Тэр хэлэв. Иоханы **баптисм** гэж Иоханы үйлчлэлийг хэлж байна. Тэгэхээр Эзэн Есүс тэднээс “Иохан үйлчлэл хийх эрхийг хаанаас авсан бэ? Бурханаас авсан уу, эсвэл хүнээс үү? Иохан Израилийн удирдагчдаас ямар зөвшөөрөл авсан бэ?” гэж асууж байна. Асуултын хариу тодорхой байлаа. Иохан бол Бурханы илгээсэн хүн юм. Түүний хүч чадал нь хүний томилгооноос бус, Бурханы тосолгооноос иржээ.

Тахилчид ба ахлагчид ацан шалаанд орох нь тэр. Хэрэв Иоханыг Бурхан илгээсэн гэчихвэл дараа нь тэд хэлэх үггүй болно. Иохан хүмүүсийг Есүс уруу хандуулж, Түүнийг Мессиа гэдгийг тунхаглаж байсан. Иоханы эрх мэдлийг тэнгэрээс эхтэй гэвэл “Тэгвэл та нар яагаад гэмшиж, Иоханы тунхагласан Христэд **итгээгүй юм бэ?**” гэсэн асуултад хариулах хэрэгтэй болно.

[21:26] Нөгөө талд, Иоханыг Бурхан томилоогүй гэчихвэл ард олны санаа бодолтой зөрчилдөнө. Хүмүүсийн ихэнх нь **Иоханыг** Бурханаас илгээгдсэн **эш үзүүлэгч** гэж үздэг байжээ. Хэрэв тэд зөв хариулж, Иоханыг Бурхан илгээсэн гэж хэлсэн бол Есүсээс асуусан асуултынхаа хариуг авах байв. Есүс бол Иоханаар замаа бэлтгүүлсэн Мессиа гэдгийг тэд харж чадах байсан.

[21:27] Гэвч тэд үнэнтэй нүүр тулахыг хүсээгүй учраас үнэнээс нүүр буруулж, Иоханы эрх мэдлийн эх сурвалжийг хэлэхийг хүссэнгүй. Тиймээс Есүс “**Би ч гэсэн ямар эрх мэдлээр**



эдгээрийг үйлддэгээ та нарт хэлэхгүй” гэлээ. Мэдчихсэн мөртлөө хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байгаа зүйлийг нь хэлээд ч яах билээ?

#### **Е. Хоёр хүүгийн тухай сургаалт зүйрлэл (21:28-32)**

**[21:28-30]** Нүглээ гэмшиж, Бурханы Хүүд итгэхийг уриалан дуудсан Иоханы үгийг дагаагүй ахлах тахилчид ба ахлагчдыг зэмлэх үүднээс Эзэн Есүс сургаалт зүйрлэл хэлэв. **Хоёр хүүтэй нэгэн хүн** байж гэнэ ээ. Тэрээр **усан үзмийн тариалан дээр** ажиллаж өгөхийг хоёр хүүгээсээ гуйв. Нэг нь **“Үгүй”** гэсэн боловч дараа нь бодлоо өөрчлөөд явж ажиллажээ. Нөгөөх нь **“За”** гэсэн боловч явж ажилласангүй.

**[21:31, 32]** **Эцгийнхээ хүслийг аль хүү нь биелүүлсэн бэ гэж** асуухад шашны удирдагчид өөрсдийг нь буруутгаж буйг ойлгосон ч юмгүй **“Эхнийх нь”** гэж хариуллаа.

Эзэн Есүс уг сургаалт зүйрлэлийг тайлбарлаж байна. **Татвар хураагчид болоод янхнууд** эхний хүү шиг байсан. Тэд Иохан баптистын үгийг тэр даруй дагаагүй боловч эцэст нь тэдний олонх нь гэмшиж, Есүст итгэсэн. Харин шашны удирдагчид хоёр дахь хүү шиг байсан. Тэд Иоханы тунхаглалыг хүлээн зөвшөөрч байна гэсэн боловч нүглээ хүлээн зөвшөөрөөгүйгээс гадна Аврагчид итгээгүй. Тийм учраас нүгэлтнүүд Бурханы хаанчлалд орж, өөрсдөдөө сэтгэл ханасан шашны удирдагчид гадна үлдэв. Энэ байдал өнөөдөр ч гэсэн адил

байна. Бусдын нүдээр нүгэлтэн гэж тооцогддог хүмүүс нь гэгээнтний дүр зүүсэн хүмүүсийг бодвол сайнмэдээг хүлээн авахад бэлэн байдаг.

**“Иохан зөвт байдлын замаар та нар уруу ирсэн”** гэдэг нь гэмшил ба итгэлээр дамжин зөвт байдалд хүрэхийг Иохан тунхагласан гэсэн утгатай.

### **Ё. Хар санаат тариаланчдын тухай сургаалт зүйрлэл (21:33-46)**

[21:33-39] Эрх мэдлийнх нь талаар асуусан асуултад хариу болгож Эзэн Есүс бас нэг сургаалт зүйрлэл ярив. **Нэгэн газрын эзэн усан үзмийн мод тариалж, түүнийгээ тойруулан хашаа барьж, дарс шахагч суулгаж, цамхаг босгожээ. Тэгээд түүнийгээ тариаланчдад түрээслүүлээд өөрөө холын нутаг уруу яваад өгөв. Ургац хураах цаг болоход эзэн ургацаас өөрийнхөө хувийг авахаар боолуудаа усан үзмийн тариаланчид уруу илгээжээ. Гэтэл усан үзмийн тариаланчид боолуудыг нь бариад нэгийг нь зодож, нөгөөг нь алж, өөр нэгийг нь чулуугаар цохив. Эзэн урьд явуулснаас ч олон боолуудыг дахин илгээсэнд тариаланчид мөн адил ханджээ. Гурав дахь удаад нь тэр “Тэд миний хүүг хүндэлнэ” гэж бодоод хүүгээ илгээв. Тариаланчид хүүг өв залгамжлагч гэдгийг бүрэн мэдэж байсан хэдий ч өвийг нь булаан авахыг санаархсандаа түүнийг алав.**

**[20:40, 41]** Сургаалт зүйрлэлийг хэлж дуусаад Эзэн Есүс тахилч ба ахлагч нараас асуусан нь: “Тэгвэл усан үзмийн тариалангийн эзэн тэдгээр тариаланчдад хэрхэн хандах вэ?” Тэд Түүнд “Тэр эзэн тэдгээр муу хүмүүсийг муугаар төгсгөж, хугацаанд нь усан үзмийг тушааж өгөх өөр тариаланчдад усан үзмийн тариалангаа түрээслүүлнэ” гэж хариулав.

Энэ сургаалт зүйрлэлийг тайлбарлах огтхон ч хэцүү биш. Бурхан бол газрын эзэн, Израиль бол усан үзмийн тариалан юм (Дуулал 80:8; Исаиа 5:1-7; Иеремиа 2:21). Хашаа нь Мосегийн хууль. Энэ хууль Израилийг бусад харь үндэстнүүдээс тусгаарлаж, Эзэний төлөөх онцгой ард түмэн болгосон. Дарс шахагч нь үр жимстэй холбоотой. Израиль үндэстэн Бурханд зориулан үр жимс гаргах ёстой байсан. Цамхаг нь ард түмнээ гэсэн Иеховагийн сонор сэрэмжтэй халамж анхаарлыг харуулдаг. Түрээслэгч тариаланчид бол ахлах тахилчид ба хуулийн багш нар юм.

Бурхан усан үзмийн тариалангаас нөхөрлөл, ариун байдал, хайрын үр жимсийг хүсэн Израилийн ард түмэн уруу өөрийн боолууд болох эш үзүүлэгчдийг байнга илгээж байв. Гэтэл Израильчууд эш үзүүлэгчдийг хавчиж, заримыг алжээ. Эцэст нь Бурхан “Тэд Хүүг минь хүндэтгэнэ” (37 дугаар эшлэл) гээд Хүүгээ илгээв. Ахлах тахилчид ба хуулийн багш нар “Энэ өв залгамжлагч байна” гэж хэлжээ. Тэд Есүсийн хэн болохыг мэдэж байсан болохоор

алахыг хүсжээ. Есүс бол Бурханы Хүү гэдгийг тэд дотроо хүлээн зөвшөөрч байсан боловч олны өмнө үгүйсгэж байв. Тэгэхээр үнэндээ тэд асуултынхаа хариуг мэдэж байжээ. Есүс Хүү Бурхан учраас Түүнд эрх мэдэл байсан юм.

Сургаалт зүйрлэлд тэднийг “Энэ чинь өв залгамжлагч байна. Ирэгтүн, түүнийг алж, өвийг нь булаацгаая” (38 дугаар эшлэл) гэж хэлснээр дүрсэлсэн. Харин бодит амьдрал дээр тэд “Хэрэв бид Түүнийг ингээд орхивол бүх хүн Түүнд итгэнэ. Тэгвэл ромчууд ирж, эх орон, үндэстнийг маань устгана” гэж хоорондоо ярьсан. Тийм учраас тэд Түүнийг эсэргүүцэж, гадагш гарган, загалмайд цовдолжээ.

**[21:42]** Аврагч Эзэн маань газрын эзэн юу хийхийг асуухад өгсөн хариулт нь тэднийг өөрсдийг нь ялласан. Эзэн Есүс үүнийг 42, 43 дугаар эшлэлд харуулсан. Тэрээр Дуулал 118:22-оос иш татсан. Үүнд: **“Барилгачдын голсон чулуу булангийн тулгуур чулуу болжээ. Энэ нь Эзэнээс ирсэн бөгөөд бидний нүдэнд гайхалтай.”** Чулуу бол Христ. Барилгачид бол Израилийн удирдагчид. Чулуу өөрийгөө барилгачдад харуулсан боловч барилгачид барьж буй байшингийнхаа зураг төсөлд уг чулууг тооцож оруулсангүй. Харин ч ашиггүй хэмээн голж гадагш хаяжээ. Гэвч Бурхан Христийг үхлээс амилуулаад Түүнд дээдийн дээд байр суурийг өгөв. Тэрээр Бурханы барилгад хамгийн чухал чулуу болов. “Бурхан Түүнийг үлэмжийн дээдээр өргөмжилсөн бөгөөд

Түүнд аливаа нэрээс дээд нэрийг соёрхов.”  
(Филиппой 2:9)

**[21:43]** Тэгээд Есүс маш шулуухнаар, **“Бурханы хаанчлалыг та нараас авч, үр жимсийг нь ургуулах үндэстэнд өгөх болно”** гэж мэдэгдэв. Үнэхээр ч ийм зүйл болсон билээ. Израиль Бурханы сонгосон ард түмэн гэх статусаа түр хугацаанд алдаж, сохор харалган байх шийтгэл хүртэв. Мессиаг хүлээн аваагүй энэ үндэстний сэтгэлийг Бурхан хатууруулав. **“Үр жимсийг нь ургуулах үндэстэнд өгөгдөх Бурханы хаанчлал”** гэсэн эш үзүүллэгийг дараах байдлаар ойлгоно. Үүнд: (1) Итгэгч иудейчүүд болон харь үндэстнүүдээс бүрдсэн чуулган. Тэд бол “ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн” мөн (1Петр 2:9). (2) Христийн хоёр дахь ирэлтийн үеийн Израилийн итгэгч хэсэг. Золилтыг хүртсэн Израиль Бурханы төлөө үр жимс гаргах болно.

**[21:44]** **“Хэн энэ чулуун дээр унана, тэр хүн хэдэн хэсэг хэмхэрнэ. Энэ чулуу хэний дээр унана, чулуу тэр хүнийг нунтаг шороо мэт болгоно.”** Энэ эшлэлийн эхний хэсэгт уг чулуу газар дээр байна. Харин хоёр дахь хэсэгт нь дээрээс унаж байна. Энэ нь Христийн хоёр ирэлтийг хэлсэн бололтой. Христ эхний удаад ирэхэд иудейчүүдийн удирдагчид түүнд бүдрэн унаж, хэдэн хэсэг хэмхэрсэн. Христ хоёр дахь удаад ирэхэд Тэрээр шүүлт шийтгэлтэй хамт дээрээс буун ирж, өөрийн дайснуудыг тоос шороо мэт тараан цацна.

[21:45, 46] Христийн эрх мэдлийн тухай асуусан асуултын хариуд ийм сургаалт зүйрлэл хэлж, ингэхдээ өөрсдийнх нь талаар ярьж байгааг ахлах тахилчид болоод фарисайчууд ойлгожээ. Тиймээс тэд Есүсийг тэнд шууд барьж авахыг хүссэн боловч **олон түмнээс айж байлаа. Учир нь хүмүүс Түүнийг эш үзүүлэгч гэж үздэг байв.**

### **Ж. Хуримын найрын тухай сургаалт зүйрлэл (22:1-14)**

[22:1-6] Есүс ахлах тахилчид ба фарисайчуудын тухай яриагаа цааш үргэлжлүүлэн хуримын найрын тухай сургаалт зүйрлэлийг нэмж ярив. Уг сургаалт зүйрлэлд Тэрээр Израиль боломжоо алдаж, харь үндэстнүүд найрын ширээнд сууж байгааг дүрсэлсэн. Тэрээр **тэнгэрийн хаанчлалыг хүүгийнхээ хуримын найрыг хийсэн хаантай зүйрлэсэн.** Найрын урилга хоёр үе шаттай байв. Эхний удаагийн урилгыг хааны зарц нар биечлэн хүргэв. Гэвч хүмүүс очихоос татгалзжээ. Хоёр дахь удаагаа урихдаа найрын зоог бэлэн болсныг зарлалаа. Уригдсан хүмүүсийн зарим нь аж ахуй, ажил төрөлдөө хэт анхаараад урилгыг хүлээн авахаас татгалзаж, хүндлэлгүй зан гаргав. Харин зарим нь хүч хэрэглэн хааны зарц нарыг барьж аваад, **доромжлон гутааж, алав.**

[22:7-10] Хаан үүнд маш ихээр хилэгнэн уурлаж, тэдгээр **алуурчдыг хөнөөгөөд хотыг нь галдан шатаав.** Тэгээд бас эхний урилгын

жагсаалтыг хэрэгсэхгүй болгоод ирнэ гэсэн бүхэнд нийтэд нь ерөнхий урилга тараав. Энэ удаа **хуримын танхимд** хоосон суудал байсангүй.

**[22:11-13]** Гэхдээ **зочдын** дотор **хуримын хувцас өмсөөгүй нэгэн хүн** байлаа. Хуримын хувцасгүйгээр найрт орох боломжгүй гэдгийг нь хэлэхэд өнөөх хүн **дуугүй байв**. Тэгэхэд нь хаан тэр хүнийг шөнийн **харанхуйд хаях** тушаал буулгав. **Тэнд тэр уйлж, шүдээ хавирах болно**. Арван гуравдугаар эшлэлд гарч буй үйлчлэгч зарц нар (грек: *диаконос*) бол 3 дугаар эшлэлд гарч байгаа зарц боолуудаас (грек: *доулоус*) ялгаатай. Энэ сургаалт зүйрлэлд *диаконос* нь тэнгэрэлч нарыг, *доулоус* нь эш үзүүлэгчид болоод Бурханы элч нарыг хэлж байна.

**[22:14]** Эзэн маань сургаалт зүйрлэлээ дүгнээд **“Дуудагдсан нь олон боловч сонгогдсон нь цөөн”** хэмээн төгсгөв.

Сургаалт зүйрлэлийн утга юу гэвэл, хаан бол Бурхан, хүү бол Эзэн Есүс юм. Хуримын найр нь тэнгэрийн хаанчлалын баяр хөөрийг илэрхийлж байна. Энд чуулганыг Христийн сүйт бүсгүй хэмээн оруулж ирэх хэрэггүй. Тэгвэл хүмүүсийг будилахад хүргэж, сургаалт зүйрлэлийн утга санааг алдагдуулна. Энэ сургаалт зүйрлэлд чуулганы онцгой дуудлага ба хувь тавиланг ярих гээгүй. Харин Израиль боломжоо алдаж буйг ярьж байна.

Иохан баптист ба арван хоёр шавь израильчуудыг хуримын найрт найрсгаар урьсан

явдлыг эхний удаагийн урилга дүрсэлдэг. Гэтэл Израиль үндэстэн урилгыг хүлээн аваагүй. “Тэд ирэхийг хүссэнгүй” (3 дугаар эшлэл) гэсэн үг загалмайн цовдлолоор оргилдоо хүрсэн.

Урилгын хоёр дахь үе шат нь иудейчүүдэд сайнмэдээг тунхагласан явдлыг хэлж байна. Үйлс номд үүнийг тэмдэглэсэн. Гэтэл иудейчүүдийн зарим нь сайнмэдээг үл хүндэлсэн бол зарим нь уг мэдээг тунхаглагч хүмүүст хүч хэрэглэв. Элч нарын ихэнх нь итгэлийнхээ төлөө амиа өгсөн билээ.

Хаан Израильд шударга уураараа хилэгнэж, “цэргүүдээ” илгээн хотыг нь устгав. Цэргүүд гэдэг нь Титус болон түүний легионууд болох Ромын арми бөгөөд тэд МЭ 70 онд Иерусалим хотыг сөнөөж, хүн амынх нь ихэнхийг хөнөөжээ. Бурхан тэднийг ашиглаж, Израилийг шийтгэсэн гэдэг утгаараа тэд бол Бурханы цэргүүд юм. Ромчууд Бурханыг мэдээгүй ч Бурханы арми байсан билээ.

Тийнхүү Израиль боломжоо алдаж, Бурхан тэднийг үндэстнийх нь хувьд түр хойш тавив. Тэгээд сайнмэдээ харь үндэстнүүдийн бүх хүнд тунхаглагдаж эхлэв (Үйлс 13:45, 46; 28:28). Гэхдээ сайнмэдээг хүлээн авсан гэх хүмүүсийн жинхэнэ эсэхийг Бурхан шалгах болно. Хуримын хувцасгүйгээр найрт сууж байсан хүн бол хаанчлалд бэлэн хэмээн зөвхөн амаараа хүлээн зөвшөөрөгч юм. Гэвч ачир дээрээ Эзэн Есүс Христээр дамжин ирдэг Бурханы зөвт байдлыг тэр өмсөөгүй байдаг (2Коринт 5:21).



Үнэндээ хуримын хувцасгүй хүнд ямар ч шалтаг байгаагүй, цаашдаа ч байхгүй. Райригийн хэлсэнчлэн тухайн цаг үед хуримын хувцасгүй зочиндоо хувцас өгдөг ёс байжээ. Энэ сургаалт зүйрлэлд гарч буй хүн олгосон хувцсыг аваагүй гэдэг нь тодорхой байна. Христгүй хүн Бурханы хаанчлалд орох ямар эрхтэй вэ гэж асуугдах үедээ юу ч хэлж чадахгүй (Ром 3:19). Тиймээс тэр гаднах харанхуйд уйлж, шүдээ хавирах болно. Уйлах гэдэг нь тамын зовлонг хэлж байна. Харин шүдээ хавирах гэдгийг ер нь Бурханы эсрэг байнга тэрслэх, Бурханд үргэлж хорсохыг хэлсэн гэж үздэг. Хэрэв тийм бол тамын гал нь ариусган цэвэрлэх нөлөөтэй гэх үзэл буруу болох нь батлагдана.

Арван дөрөвдүгээр эшлэл зөвхөн хуримын хувцасгүй хүний тухай биш, уг сургаалт зүйрлэлд бүхэлд нь хамаатай. **Олон хүн дуудагдсан.** Өөрөөр хэлбэл, сайнмэдээний урилгыг олон хүн авсан. Гэвч **сонгогдсон нь цөөхөн.** Зарим нь урилгаас татгалзсан. Урилгыг нааштай хүлээн авсан хүмүүсийн дотор бас хуурамч хүмүүс байсан. Харин сайнмэдээг үнэнээр хүлээн авсан бүхэн сонгогдогсад мөн. Тухайн хүн Эзэн Есүс Христийг хүлээн авсан уу үгүй юу, түүнийг хэн гэж үзэж байна вэ гэдгээр л зөвхөн түүний сонгогдсон эсэхийг хэлж чадна. Женнингс энэ тухайд: “Хуримын найрт оролцооч хэмээн бүх хүнийг дуудсан билээ. Гэвч урьж байгаа Эзэн нь найрт тохирох хувцас өгнө

гэж зарим нь л итгэсэн бөгөөд үлдсэн нь үүнд найдахыг хүссэнгүй” гэжээ.

### **3. Цезарийнхыг Цезарт, Бурханыхыг Бурханд (22:15-22)**

Хорин хоёрдугаар бүлэгт иудейчүүдийн доторх гурван өөр бүлэглэлийн төлөөлөгч нар Бурханы Хүүг үгэнд нь унагах зорилгоор асуулт асууж буй тухай гардаг.

**[22:15, 16]** Эхлээд **фарисайчууд херодынхонтой** хамт ирсэн. Нэг нэгэндээ дайсагнадаг энэ хоёр бүлэглэл Аврагч Эзэнийг үзэн ядсан нийтлэг сэтгэлийнхээ улмаас түр ч болов хамтрав. Тэд Христийг мэхэнд унагаж, улс төрийн хувьд аюул дагуулах мэдэгдлийг амнаас нь унагахыг санаархжээ. Цезарьт захирагдах талаар иудейчүүд хоёр өөр байр суурьтай байсныг энэ мэхэндээ ашиглав. Иудейчүүдийн зарим нь харь үндэстний хаанд захирагдахыг хатуу эсэргүүцэж байсан бол херодынхон мэтийн зарим нэг нь үүнд харьцангуй уян хатан хандаж байв.

**[22:17]** Эхлээд тэд Эзэн Есүсийг үнэн журамтай, цэвэр ариун явдалтай, хэнээс ч айж эмээдэггүй хэмээн саймширхав. Тэгээд түүнийхээ араас бэлдэж ирсэн ярвигтай асуултаа тавьжээ. **“Бид Цезарьт татвар төлөх нь хуульд нийцэх үү?”**

Хэрэв Есүс “Үгүй” гэвэл херодынхоныг уурлуулаад зогсохгүй Ромын төр засгийг эсэргүүцсэн хэргээр буруутгагдана.

Фарисайчууд үүн дээр тун хурдан хөдөлж, Түүнийг хэрэгтэн болгох нь зайлшгүй. Хэрэв Есүс “Тийм” гэвэл иудейчүүдийн үндсэрхэг сэтгэлийг уландаа гишгэсэн хэрэг болно. Тэгвэл жирийн ард олны сэтгэл Түүний эсрэг болно. Хүмүүс Есүсийг Бурханы эш үзүүлэгч гэж үздэг байсан болохоор иудейчүүдийн удирдагчид Түүнд халдаж чадахгүй байсан нь үгүй болно.

**[22:18, 19]** Өөрийг нь занганд оруулахыг санаархаж буйг мэдээд Есүс тэднийг **хоёр нүүртнүүд** хэмээн нэрлэсэн. Тэгээд Тэрээр Ромын төрд татвар төлөхөд хэрэглэдэг **денар** хэмээх зоосыг үзүүлэхийг хүсэв. Уг зоосон дээр Цезарийнн дүрс, түүний нэр бичээстэй байлаа. Иудейчүүд энэ зоосыг үзэх тоолондоо харь үндэстний ноёрхол доор тэдэнд татвар төлж амьдардгаа санаж, бухимддаг байв. Тэд денарын зоосыг харахдаа нүглийнхээ улмаас Ромын боолчлол дор байгаагаа санах ёстой байсан. Хэрэв тэд Иеховад үнэнч байсан бол Цезарьт татвар төлөх тухай асуудал хэзээ ч гарахгүй байсан.

**[22:20, 21]** Есүс тэднээс “Энэ хэний дүрс, бичээс вэ?” гэж асуухад тэд “Цезарийнх” гэв. Тэгэхээр нь Эзэн Есүс “Тэгвэл Цезарийн юмыг Цезарьт, Бурханы юмыг Бурханд өг” гэлээ.

Асуусан асуулт нь эргээд өөрсдийг нь хүнд байдалд оруулав. Тэд Цезарьт татвар төлөх тухай асуудлаар Есүсийг занганд оруулахыг санасан. Харин Есүс Бурханд өгөх ёстойгоо өгдөггүйг нь илчлэв. Тэд Цезарьт өгөх ёстой юмыг өгч байсан

атлаа Бурханы шаардлагуудыг үл тоомсорложээ. Бурханы мөн чанар (Еврей 1:3), дүр төрхийг илэрхийлэгч Нэгэн өмнө нь зогсож байхад тэд Түүнд зохих байр суурийг нь өгсөнгүй.

Эзэн Есүсийн хариултаас харвал итгэгч хүний иргэний харьяалал хоёр газарт бий. Итгэгч хүн улс орныхоо төр засгийг дагаж, татвараа төлөх ёстой. Мөн удирдагчдынхаа талаар муу юм ярьж, тэднийг түлхэн унагах ажил хийж болохгүй. Түүний оронд төрийн эрх баригчдынхаа төлөө залбирах хэрэгтэй. Түүнээс гадна итгэгч хүн тэнгэрийн иргэн учраас Бурханыг дагах үүрэгтэй. Хэрэв энэ хоёр эрх мэдлийн дунд зөрчил гарвал итгэгч хүн Бурханыг нэн тэргүүнд тавих ёстой (Үйлс 5:29).

Бидний ихэнх нь 21 дүгээр эшлэлийг иш татахдаа Цезарийн тухай хэсэг дээр ихээхэн өргөлт өгөөд Бурханы тухай хэсгийг сулруулах гээд байдаг. Гэтэл Эзэн Есүс маань үүнээс л болж фарисайчуудыг зэмлэсэн юм шүү дээ.

**[22:22]** Фарисайчууд түүний хариултыг **сонсоод** хэлэх үггүй болсноо ойлгов. Тэд гайхахаас өөрийг хийж чадсангүй. Тэгээд тэндээс явжээ.

## **И. Садукайчууд ба амилалын тухай асуудал (22:23-33)**

Садукайчууд нь тухайн цаг үеийнхээ либерал буюу чөлөөт теологичид байсныг өмнө дурдсан. Тэд биеийн амилал, тэнгэрэлч, гайхамшгийг

үгүйсгэдэг байв. Үнэндээ үгүйсгэдэг зүйлс нь баталдгаасаа олон байлаа.

Тэдний зарим нь Есүс дээр **ирээд**, дахин амилал бол ямар ч утгагүй зүйл гэдгийг батлахын тулд өөрсдийн боловсруулсан нэгэн түүхийг ярив. Тэд Дэд хууль 25:5 дээр заасан гэрлэлтийн хуулийг санууллаа. Энэ хуулийн дагуу Израиль хүн **үр хүүхэдгүй** нас барвал **түүний** ах дүүсийн нэг нь бэлэвсэрч хоцорсон **эхнэртэй нь гэрлэж**, өрхийнх нь нэрийг Израилийн дотор авч үлдэн, гэр бүлийн доторх өвийг нь хадгалж хамгаалах ёстой.

**[22:25-28]** Тэдний өгүүлсэн түүх нөхрөө алдсан эмэгтэйн тухай байв. Тэр эмэгтэй бэлэвсэрч хоцроод хуульд заасны дагуу нөхрийнхөө дүүтэй гэрлэжээ. Гэтэл тэр нь ч бас нас барав. Тиймээс бас нэг дүүтэй нь гэрлэв. Ингэж явсаар долоо ах дүүтэй бүгдтэй нь гэр бүл болжээ. **Эцэст нь мөнөөх эмэгтэй ч үхэв.** Эндээс дараах асуулт гарч ирнэ. Есүс бол амилал мөн (Иохан 11:25). Харин тэд Түүнийг доош хийхийн тулд ийм асуулт бодож боловсруулжээ. Үүнд: **“Тэгвэл амилал дээр мөнөөх эмэгтэй тэр долоогийн хэнийх нь эхнэр болох вэ? Бүгд л түүнтэй гэрлэсэн шүү дээ.”**

**[22:29]** Дахин амилах тухай үзлээс учирзүйг нь ойлгох аргагүй маш олон ярвигтай асуултууд урган гардаг ба утга учиргүй зүйл учраас тийм зүйл байхгүй гэсэн санааг садукайчууд дэвшүүлжээ. Эзэн Есүс тэдэнд хариулахдаа, асуудлын гол нь дахин амилал гэдэг сургаалд бус,

тэдний бодол санаанд байгаа гэдгийг хэлж байна. Тэд **бичвэрүүдийг** болон **Бурханы хүчийг** мэдэхгүйгээс болж төөрөлджээ.

Нэгт, **бичвэрүүдэд** юу бичсэнийг тэд мэдэхгүй байв. Эхнэр, нөхрийн харилцаа мөнхийн улсад ч гэсэн үргэлжилнэ гэж Библид огт бичээгүй. Мөнхийн улсад эрэгтэй нь эрэгтэй хүн, эмэгтэй нь эмэгтэй хүн гэж танигдах боловч тэд гэрлэхгүй, хүүхэд гаргахгүй. Энэ утгаараа тэд тэнгэрэлч нартай адил болно.

Хоёрт, тэд **Бурханы хүчийг** мэдэхгүй байв. Бурхан хүнийг шороо тоосноос бүтээж чадсан юм бол нас барсан хүмүүсийн тоос болсон бие цогцсыг цуглуулаад алдрын биеийг бүтээж чадахгүй гэж үү?

[22:30-32] Тэгээд Эзэн Есүс бичвэрээс иш татаад дахин амилал нь зайлшгүй шаардлагатай зүйл болохыг хэлж байна. Гэтлэл 3:6 дээр Бурхан өөрийгөө **“Би бол Абрахам, Исаак, Иаковын Бурхан”** гэж хэлсэн. Харин Есүс энд **“Бурхан бол үхэгсдийнх бус, харин амьдын Бурхан”** гэдгийг тодруулж өгөв. Абрахам, Исаак, Иаков нартай Бурхан гэрээ байгуулсан. Гэтэл тэр гэрээ бүрэн биелэхээс өмнө тэр хүмүүс нас барсан. Тэгвэл цогцос нь булшинд үлдсэн энэ гурван хүний Бурхан байх боломж Бурханд байгаа гэж үү? Амласандаа заавал хүрдэг Бурхан аль эрт нас барсан хүмүүст амласнаа яаж биелүүлэх юм бэ? Үүнд ганц л хариу бий. Тэр бол биеийн амилал мөн.

[22:23] **Олон түмэн түүний сургаалд гайхаж байсан** нь мэдээж билээ. Өнөөдөр бид ч бас Түүний сургаалыг гайхан шагшдаг.

#### **К. Хамгийн агуу тушаал (22:34-40)**

[22:34-36] Өөрсдийг нь эсэргүүцдэг **садукайчуудыг** Есүс **дуугүй болгосныг фарисайчууд сонсоод** Түүнтэй ярилцахаар **цуглав**. Нэгэн **хуульч** тэднийг төлөөлөн ярьж, Есүсийг сорьж, хуулийн хамгийн **агуу тушаал аль болохыг асуув**.

**“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх бодлоороо Бурхан Эзэнээ хайрла”** гэдэг үг бол **хамгийн чухал тушаал** гэдгийг Эзэн Есүс үнэхээр оновчтой тодорхойлж өгөв. Маркийн сайнмэдээнд “бүх хүч чадлаараа” гэсэн үг нэмсэн байдаг (Марк 12:30). Тэгэхээр хүний нэн тэргүүний үүрэг бол Бурханыг байгаа бүхнээрээ хайрлах явдал юм. Зүрх гэдэг нь сэтгэл хөдлөлийг, сэтгэл гэдэг нь хүсэл шийдвэрийг, бодол гэдэг нь оюун ухааныг, хүч гэдэг нь бие махбодыг илэрхийлсэн болно.

[22:39, 40] Дараа нь Эзэн Есүс хүний хоёр дахь үүргийг тодорхойлж өгсөн. Тэр бол **хөршөө өөрийн адил хайрлах**. Барнес энэ тухайд: “Бурханыг болон хүнийг хайрлаж байвал христитгэлийг бүрэн ойлгосны шинж мөн. Мосе, эш үзүүлэгчид, Эзэн Есүс, элч нар бүгдээрээ үүнийг ярьж байсан билээ” гэж хэлжээ. **“Хөршөө өөрийн адил хайрлах”** гэдгийг бид нухацтай тунгаан бодох хэрэгтэй. Бид

өөрсдийгөө хэчнээн их хайрладгаа, өөрсдийнхөө сайн сайхан, тав тухад хэчнээн их анхаардгаа эргэцүүлж бодох хэрэгтэй. Тэгээд тэр хайраар бусдыг хайрлавал ямар байхыг төсөөлөөд үз. Бид бусдыг тэгж л хайрлах хэрэгтэй. Гэхдээ энэ хайр бидэнд төрөлхөөс байдаггүй, харин дээрээс ирдэг. Дахин төрөөд Христээр удирдуулсан хүн л бусдыг өөрийн адил хайрлаж чадна.

#### **Л. Давидын Хүү бол Давидын Эзэн (22:41-46)**

[22:41, 42] Хуульчийн асуултад Есүс хэрхэн хариулахыг үзээд **фарисайчууд** түүнээс эмээх болжээ. Эзэн Есүс тэдэнтэй уулзахдаа **“Та нар Христийн тухай юу гэж боддог вэ? Тэр хэний хүү вэ?”** гэж асуув.

Фарисайчуудын ихэнх нь Есүсийг Христ гэдэгт итгээгүй. Тэд Мессиа ирэхийг хүлээж байсан. Тиймээс Есүс “Та нар миний тухай юу гэж боддог вэ?” (Мэдээж хэрэг ийм утга бас агуулж байсан) гэж асуусангүй. Мессиа ирэх үедээ хэний Хүү байхыг тэр ерөнхий байдлаар асууж байна.

Мессиа **Давидын** удам байна гэж тэд зөв хариулсан.

[22:43, 44] Тэгэхээр нь Эзэн Есүс Дуулал 110:1-ээс иш татав. Тэнд Давид, **“Эзэн (Иехова) миний Эзэнд (Адонай) ‘Би чиний дайснуудыг хөл дор чинь тавих хүртэл миний баруун гарт залрагтун’ гэсэн”** гэж хэлжээ. Эхэнд дурдагдаж байгаа Эзэн бол Бурхан Эцэгийг, хоёр дахь Эзэн



бол Мессиаг зааж байна. Тэгэхээр Давид Мессиаг өөрийн Эзэн гэж үздэг байжээ.

[22:45] Эзэн Есүс эндээс дараах асуултыг гарган тавьсан. Үүнд: **“Хэрэв Давид түүнийг ‘Эзэн’ гэж дууддаг бол тэр яаж түүний хүү байх билээ?”** Хариулт нь гэвэл, Мессиа Давидын Эзэн ч мөн, бас Давидын Хүү ч мөн. Тэрээр Бурхан ч мөн, бас хүн ч мөн. Бурхан болохынхоо хувьд тэр Давидын Эзэн, хүнийхээ хувьд тэр Давидын Хүү юм.

Есүс Давидын удмын Мариагийн биеэс төрсөн учраас Давидын Хүү юм. Харин үг, үйлс, зан байдал нь Бурханы Хүү болохыг нь илчилж байсан. Фарисайчууд сургамж авсан бол Есүсийг Мессиа гэдгийг таньж чадах байсан.

[22:46] Гэвч тэд үнэнийг ойлгохыг хүссэнгүй. Есүсийн мэргэн ухааныг гүйцэхгүйгээ ойлгоод цаашид асуулт асуун занганд оруулах гэж хичээхээ больжээ. Үүнээс хойш арга барилаа өөрчилж хүчирхийллийг сонгов.

## **М. Үг үйлдэл хоёр нь зөрдөг байхаас сэрэмжлүүлэв (23:1-12)**

[23:1-4] Энэ бүлгийн эхний эшлэлүүдэд Аврагч Эзэн маань олон түмнийг болон **шавь нараа хуулийн багш нар болоод фарисайчуудаас** сэрэмжлүүлсэн. Энэ удирдагчид **Мосегийн суудалд** суужээ. Өөрөөр хэлбэл, тэд Мосегийн хуулийг номлодог байсан. Ерөнхийдөө тэд зөв юм зааж сургаж байсан ч амьдралын хэв маяг нь огт өөр байв. Нэг ёсондоо

үг үйлдэл хоёр нь тэнгэр газар шиг зөрүүтэй байжээ. Тийм учраас Эзэн Есүс **“Тэдний хэлсэн болгоныг та нар үйлд, сахь. Харин тэдний үйл хэргийн дагуу бүү үйлд. Учир нь тэд ярьдаг ч түүнийгээ үйлддэггүй”** гэсэн билээ.

Тэд хүмүүсийн дээр маш хүнд шаардлагууд тавьдаг (хуулийн үг үсгийг хэт туйлшран тайлбарлахыг хэлсэн бололтой) хэр нь дааж давшгүй тэрхүү ачаанаас нь өөрсдөө огтхон ч үүрэлцдэггүй байжээ.

**[23:5]** Тэд шашны ёслолуудыг үйлдэхдээ үнэн сэтгэлийн угаас бус, харин хүмүүст харагдах байдлыг чухалчилсан. Сахиус зүүсэн нь л гэхэд нэг жишээ юм. Бурхан өөрийн үгийг гартаа тэмдэг, хоёр нүднийхээ хооронд сахиус болгож байхыг израильчуудад тушаасан (Гэтлэл 13:9, 16; Дэд хууль 6:8; 11:18). Израильчууд өөрийнх нь үгийг бодон санан явж, түүгээр амь амьдралаа жолоодоосой гэсэндээ Бурханы хэлсэн энэ үгийг тэд хэт үгчлэн биелүүлж, сүнслэг утгыг нь үгүй болгожээ. Тэд бичвэрийн зарим хэсгийг бичсэн тэмдэг сахиусыг магнайдаа юм уу гартаа зүүдэг байв. Энэ нь хуулийг дагасандаа бус юм. Өргөн сахиус зүүчихвэл сүнслэг харагддаг учраас л тэд үүнийг хийдэг байжээ. Түүнээс гадна, хувцасныхаа өнцгүүддээ цацаг хийн түүн дээр цэнхэр уяа оруулж өмс хэмээн хууль иудейчүүдэд тушаасан (Тооллого 15:37-41; Дэд хууль 22:12). Иудейчүүд та нар Бурханы ард түмэн учраас бусад үндэстнээс ангид өөр байх ёстой шүү

хэмээн сануулах зорилгоор ийм цацаг хийхийг Бурхан тушаасан. Гэтэл фарисайчууд сүнслэг сургамжийг нь умартаж, урт цацгуудаараа өөрсдийгөө зөвт хүмүүс мэт харагдуулан, түүндээ сэтгэл ханацгаажээ.

**[23:6-8]** Фарисайчууд **найр наадмын** хоймор, **синагогуудын** хүндтэй суудал уруу зүтгэдэг нь өөрсдийгөө чухалчилдаг болохынх нь илрэл байв. Тэд **зах зээл дээр хүндлүүлэн мэндлүүлж**, биеэ тоосон байдлаа улам өөгшүүлэн, рабби (“хүндэт хүн минь” эсвэл “**багш**” гэсэн утгатай) гэж дуудуулахыг ихэд таатай хүлээн авдаг байсан.

**[23:9, 10]** Бурханд хамаатай хүндтэй нэрсийг өөрсөд дээрээ ашиглахгүй байхыг Эзэн Есүс шавь нартаа анхааруулжээ. Рабби гэдгийг тусгай хэргэм болгож, түүгээр бид дуудуулж болохгүй. Яагаад гэвэл **Христ** гэдэг ганцхан л **Багш** бий. Бид хэн нэгнийг **эцэг** гэж дуудаж болохгүй. Учир нь Бурхан бол бидний **Эцэг** билээ. Уестон үүнийг маш тодорхой гаргаж ирсэн:

Хүн Бурхантай харилцахад амин чухал хэрэгтэй зүйлсийг энд мэдэгджээ. Гурван зүйл итгэгч хүнийг бүрдүүлдэг. Үүнд: Итгэгч хүн гэж хэн бэ? Итгэгч хүн юунд итгэдэг вэ? Итгэгч хүн юу хийдэг вэ? Өөрөөр хэлбэл: Сургаал, ойлголт, хэрэгжүүлэлт. Хүний сүнслэг ахуйд гурван зүйл хэрэгтэй. Тэр нь амь, заавар, чиглүүлэг. Эзэн үүнийг Иоханы

сайнмэдээнд зургаан үгэнд багтаан “Би бол зам, үнэн, амь мөн” гэж хэлсэн. Бидний сүнсэнд амь өгч, тэрхүү амийг тэтгэж чадах хүн нэг ч байхгүй учраас хэнийг ч **Эцэг** гэж болохгүй. Алдаагүй хүн гэж нэг ч байхгүй. Тиймээс хэнийг ч багш болгох хэрэггүй. Бас хэнийг ч сүнслэг зааварлагч болгон хүлээн авах хэрэггүй. Бурхан ба Христтэй бусдаар дамжиж харилцах хэрэггүй. Харин та өөрөө бусдын адил ойр дотно харилцаатай болох боломжтой.<sup>42</sup>

Тэнгэрийн хаанчлалд бүх итгэгчид адилхан ахан дүүс бөгөөд нэгийг нөгөөгөөс нь илүү болгох цол хэргэм байж болохгүй гэсэн санааг Аврагч Эзэн маань хэлэхийг зорьжээ. Гэвч Христийн гэсэн хүрээлэлд сүржин нэршлүүд олноор үүсжээ. Тухайлбал, хүндлэлтэн (англи: Reverend), үнэн хүндлэлтэн (англи: Right Reverend), эцэг, бусдыг хөтлөн дагуулагч гэх мэт цол хэргэм бий. “Эмч/Доктор” гэдэг гэмгүй үг хүртэл латин хэлэндээ багш гэсэн утгатай. (Эзэн Есүсийн энэ анхааруулга сүнслэг харилцаанд зориулагдсан болохоос гэр бүл, ажил мэргэжил, сурган хүмүүжүүлэх харилцаанд хамаарахгүй. Жишээ нь хүүхэд аавыгаа “эцэг” гэж дуудаж болохгүй гэсэн үг биш. Эсвэл өвчтэй хүн анагаахын мэргэжилтэнг “эмч” гэж дуудаж болохгүй гэсэн үг биш). Сүнслэг харилцаанаас бусад харилцаанд “айж эмээвэл зохих хүнээс айж эмээж, хүндэтгэл хүлээх ёстой хүнийг

хүндэл” гэсэн зарчмыг баримталбал зохино (Ром 13:7).

**[23:11, 12]** Тэнгэрийн хаанчлалын зарчим газар дэлхийнхээс тэс өөр болохыг энд дахин дурдаж байна. Жинхэнэ агуу байдал хүмүүсийн бодож төсөөлдгөөс огт өөр, бүр эсрэг зүйл ажээ. Есүс **“Та нарын дундах хамгийн агуу нь зарц болог. Өөрийгөө өргөмжлөгч нь дорд болгогдож, өөрийгөө даруу байлгагч нь өргөмжлөгдөх болно”** гэж хэлсэн. Жинхэнэ агуу байдал үйлчлэхээр бөхийдөг. Өөрсдийгөө өргөмжилсөн фарисайчууд дорд болгогдоно. Өөрийгөө даруу байлгагч жинхэнэ дагалдагч хүн цаг нь ирэхээр өргөмжлөгдөх болно.

## **Н. Хуулийн багш нар болон фарисайчууд золгүй еэ! (23:13-36)**

Есүс өөрийнхөө цаг үед амьдарч байсан бардам сэтгэлтэй, шашинлаг, хоёр нүүртнүүдийг золгүй еэ хэмээн найман удаа халагласан байдаг. Есүс тэднийг хараагаагүй. Харин хувь тавиланг нь бодохдоо харуусан халагласан ажээ.

**[23:13]** Зөрүүд зан ба бусдад саат тотгор бологч хандлагад нь эхний халаглалыг хэлсэн. Тэд өөрсдөө Бурханы хаанчлалд **орохоос** татгалзсан. Тэгээд ч зогсохгүй тийш орох гэсэн хүнд саад тотгор болсон. Нигүүлслийн сайнмэдээний эсрэг зогсогчдын эгнээнд шашны удирдагчид хамгийн идэвхтэй байдаг нь нэн хачирхалтай. Тэд юунд ч гэсэн хүлээцтэй ханддаг атлаа авралын сайнмэдээг л хүлцэж

чаддаггүй. Төрөлх хүн Бурханы нигүүлслийг хүртэхийг хүсдэггүйн дээр тэр нигүүлслийг бусдад мэдүүлэх гэхэд саад тотгор болдог.

**[23:14] Бэлэвсэн эмэгтэйчүүдийн гэрийг цөлмөн,** үүнийгээ сунжирсан урт залбирлаар халхалдаг явдлыг нь буруутгаж хоёр дахь халаглалыг<sup>43</sup> хэлсэн. Орчин үед зарим нэг гаж урсгалынхан энэ аргыг ашигладаг. Тэд настай бэлэвсэн эмэгтэйчүүд, мэдлэггүй итгэгчдийг мэхэлж, хөрөнгийг нь “сүм чуулганыхаа” өмчлөлд шилжүүлж авдаг. Ийм залилан мэхлэгчид **илүү хүнд шийтгэл хүлээнэ.**

**[23:15] Ганц хүнийг ч сүсэгтнээ болгохын төлөө** асар их хичээл зүтгэл гаргаж, сүсэгтэн болмогц нь өөрсдөөсөө долоон дор болгодгийг зэмлэж, гурав дахь халаглалыг хэлсэн. Буруу сургаал заадаг өнөөгийн гаж урсгалуудын байдал энэ мөн. Тэд нэг хүнийг сүсэгтнээ болгохын тулд долоон зуун хаалга тогшиход бэлэн байдаг. Гэвч эцэст нь ёрын муу үр дүн гардаг. Энэ талаар хэн нэгэн нь дараах үгийг хэлжээ: “Хамгийн үнэнч сүсэгтэн болсон нь хамгийн гажууд болдог.”

**[23:16-22]** Дөрөв дэх халаглал нь заль мэхтэй мушгин гуйвуулалтыг нь буруушаасан. Тэд юмыг үндэслэлтэй бодож цэгнэхээс илэрхий татгалзаж, тангаргаа биелүүлэх үүрэг хариуцлагаас мултрах аргачлалыг боловсруулсан байна. Жишээлбэл, **сүмээр тангараглавал хамаагүй, харин сүмийн алтаар тангараглагч нь** амлалтаа биелүүлэх ёстой гэж

тэд сургаж байв. Бас тахилын ширээгээр андгайлагч нь үүрэг хүлээхгүй, харин дээрх өргөлөөр андгайлагч нь үүрэг хүлээнэ гэж номлож байсан. Үүгээрээ тэд алтыг Бурханаас (сүм бол Бурханы өргөө) дээгүүр тавьж, өргөлийг (ямар нэг хэлбэрийн үнэт зүйл) тахилын ширээнээс илүү үнэлсэн. Тэд материаллаг зүйлийг сүнсний зүйлээс илүү сонирхож байв. Тэд өгөхөөс (тахилын ширээ нь өргөх газар) илүү авахыг хүсэж байв.

Тэднийг **сохор газарчид** гэснээрээ учир шалтгааныг зориуд буруу тайлбарладгийг нь Есүс ил гарган харуулсан. Бурханд харьяалагддаг учраас л сүмийн алт нь онцгой үнэ цэнтэй болдог. Мөн өргөл нь тахилын ширээний улмаас үнэ цэнтэй болдог. Алтыг угийн үнэ цэнтэй зүйл гэж бодож байгаа хүмүүс сохор юм. Алтыг Бурханы алдрын төлөө ашиглавал үнэ цэнтэй болно. Махбодын учир шалтгаанаар өргөсөн өргөл үнэ цэнгүй юм. Эзэнд болон Эзэний нэрээр өргөсөн зүйлс л мөнхийн үнэ цэнтэй билээ.

Үнэн хэрэгтээ фарисайчууд юугаар ч тангарагласан түүнд нь Бурхан орж байсан тул тэд тангаргаа биелүүлэх ёстой байсан. Зальтай шалтгаан бодож оллоо ч амласнаа биелүүлэх үүргээсээ хүн мултарч чадахгүй. Ам гарч, андгай тангараг өгсөн бол заавал биелүүлэх учиртай. Үүргээсээ зайлсхийхийн тулд тусгай нэр томьёо гаргаж ирэх нь ашиггүй.

[23:23, 24] Тав дахь халаглал нь хий хоосон ёслол, зан үйлийн эсрэг байсан. **Хуулийн багш нар, фарисайчууд** тийм ч ач холбогдолгүй өвс ногооны аравны нэгийг хүртэл нарийн тооцон өргөж байв. Дуулгавартай дагахын тулд ийм жижиг зүйл дээр ч гэсэн анхаарал тавьж байгааг Есүс буруутгаагүй. Харин **шударга ёс, өршөөл, итгэлтэй байдлыг** огоорч, бусдад үнэхээр увайгүй ханддагийг нь Есүс буруутган зэмлэсэн юм. Есүс тэдний тухайд, **шумуулыг шүүгээд, тэмээг залгичихдаг** гэж дүрсэлсэн. Энэ хэтрүүлэл нь санаагаа илэрхийлэх нэг төрлийн ярианы арга юм. Аяганд шумуул орвол дарсыг уухдаа амаа жимийн бага багаар шимсээр уг шумуулыг шүүж үлдээдэг. Ийм өчүүхэн зүйлийг хүртэл шүүн тунгаадаг хэр нь Палестины хамгийн том бохир амьтан болох тэмээг анзааралгүй залгичихдаг нь нэн хачирхалтай. Фарисайчууд өчүүхэн жижиг зүйлсэд үнэхээр анхаарч байсан. Тэгсэн мөртлөө хоёр нүүр гаргах, шударга бус хандах, зэрлэг балмад аашлах, шунах зэрэг асар том нүглүүдэд сохор харалган болсон байв. Тэд юу нь чухал, юу нь чухал бишийг ялгах чадвараа гээжээ.

[23:25, 26] Зургаа дахь халаглал нь экстернализмын (гадаад байдлыг хэт чухалчлах үзэл) талаар байсан. Фарисайчууд бусдын өмнө сүсэгтэй, ёс суртахуунтай харагдахын тулд ихэд хичээл зүтгэлтэй байсан ч зүрх сэтгэлдээ **дээрэм тонуул, хувийн сонирхлоор**<sup>44</sup> дүүрэн байв. Тэд эхлээд аяга тавгийнхаа дотор талыг цэвэрлэх



хэрэгтэй байсан. Өөрөөр хэлбэл, гэмшил ба итгэлээр зүрх сэтгэлээ цэвэрлэх хэрэгтэй гэсэн үг. Тэгсэн цагт л биеэ авч яваа гаднах байдлыг Бурхан хүлээн зөвшөөрнө. Бидний дотор оршин буй жинхэнэ хүн нь гаднаа үзүүлж байгаа дүрээс ялгаатай байдаг. Хүмүүс юу гэж бодох бол гэдэгт хөтлөгдөн бид гаднах байдалдаа ач холбогдол өгдөг. Түүгээрээ бид биеэ авч явдаг. Харин Бурхан бидний дотор байгаа жинхэнэ хүнийг маань анхаардаг. Жинхэнээсээ бид хэн бэ гэдгийг Бурхан авч үздэг. Бурхан сэтгэлийн гүнд маань үнэн байхыг хүсдэг билээ (Дуулал 51:6).

**[23:27, 28]** Долоо дахь халаглал ч бас экстернализмын талаар байсан. Ялгаа нь гэвэл, зургаа дахь халаглалд хомхой сэтгэлийг нь шүүмжилсэн бол долоо дахь халаглалд **хоёр нүүрт зан ба хууль бус явдлыг** буруутгасан.

Иудей хүн булшинд санамсаргүй хүрч бузартаад ариун ёслолуудад орох эрхгүй болохоос сэргийлж булшнуудыг цагаанаар буддаг байжээ. **Цагаанаар будсан** булш нь гаднаасаа цэвэрхэн харагддаг ч дотроо ялзарч муудсан цогцсоор дүүрэн байдаг. Есүс хуулийн багш нар болон фарисайчуудыг ийм булштай адилтгасан. Хүмүүс шашны удирдагчидтай холбоотой байвал ариусна гэж боддог ч үнэн хэрэгтээ бузартаж байжээ. Яагаад гэвэл тэр хүмүүс хоёр нүүр ба ёс бус явдлаар дүүрэн байв.

**[23:29, 30]** Сүүлийн халаглалд нэр өгвөл “гаднаа хүндлэл, дотроо хөнөөл” гэж болох юм. **Хуулийн багш нар болон фарисайчууд** Хуучин

гэрээний эш үзүүлэгчдийг хүндэтгэж буй дүр эсгэн, булш бунхныг нь барьж босгон, хөшөө дурсгал дээр нь цэцэг тавьж, хүндлэлийн арга хэмжээн дээрээ **“Хэрэв бид эцэг өвгөдийнхөө үед амьдарч байсан бол эш үзүүлэгчдийн цусыг урсгахад тэдний хамсаатан болохгүй л байсан”** гэж хэлдэг байв.

[23:31] Есүс тэдэнд хандан **“Тэгснээрээ та нар өөрсдийгөө эш үзүүлэгчдийн амийг бүрэлгэсэн хүмүүсийн хөвгүүд гэдгээ гэрчилдэг”** гэж хэлсэн. Өмнөх эшлэлийг үзвэл, тэд эш үзүүлэгчдийг бүрэлгэсэн эцэг өвгөдөөсөө ялгаатай мэт харагдаж байна. Тэгэхээр тэд хэрхэн гэрчилсэн байх вэ? Нэгт, тэд эш үзүүлэгчдийн амийг бүрэлгэсэн хүмүүсийн мах цусны тасархай, үр удам, хөвгүүд гэдгээ хэлсэн үгэндээ хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ Есүс **хөвгүүд** гэдэг үгийг ашиглаж ижил мөн чанар бүхий хүмүүсийг илэрхийлсэн. Хуулийн багш нар, фарисайчууд эш үзүүлэгчдийн булшийг чимдэг ч өөрийг нь алахаар хуйвалдаж байгааг Есүс мэдэж байсан болохоор ингэж хэлжээ. Хоёрт гэвэл, тэд нас барсан эш үзүүлэгчдэд хүндэтгэл үзүүлсэн. Тэдний үйлдэл нь **“Бид зөвхөн нас барсан эш үзүүлэгчдэд дуртай”** гэж байгаатай адил юм. Энэ утгаараа ч гэсэн тэд эцэг өвгөдийнхөө хөвгүүд болохоо гэрчилжээ.

[23:32] Тэгээд дараа нь Эзэн Есүс **“Та нар өвөг эцгүүдийнхээ гэмийн хэмжээг дүүргэ”** гэсэн. Өвөг эцгүүд нь эш үзүүлэгчдийг хөнөөснөөрөө аллагын аяганы тодорхой хувийг

дүүргэсэн. Хуулийн багш нар, фарисайчууд Эзэн Есүсийг болон Түүний дагалдагчдыг хөнөөж уг аягыг удалгүй хальтал дүүргэх болно. Ингээд өвөг эцгүүдийнхээ өдүүлсэн хэргийг тэд дээд цэгт нь хүргэнэ.

**[23:33]** Энэ хэсэгт Бурханы Христ “**Могойнууд аа, хорт могойн удмууд аа! Та нар тамын шийтгэлээс яаж зугтаах вэ?**” гэсэн аянга мэт ширүүн үг хэлж байна. Хүний биеэр буусан агуу хайр ийм хатуу үг хэлж болох уу? Тийм ээ болно. Яагаад гэвэл жинхэнэ хайр нь бас зөвт бөгөөд ариун байх ёстой. Есүсийг хорхойд хоргүй, ямар ч сэтгэл хөдлөлгүй мөртлөө хайрлах чадвартай гэж үздэг олонхын ойлголт нь Библийн дагуу биш юм. Хайр хатуу чанга байж болно. Түүнээс гадна үргэлж шударга байх ёстой.

Буруутгаж зэмлэсэн энэ үгсийг согтуу архичдад, ёс бус хүмүүст биш, харин шашны удирдагчдад хандаж хэлснийг санах нь чухал. Эвангелийн зарим итгэгч Христийн загалмайн дайснуудтай нэгдэн нийлж буй энэ цөвүүн цагт Эзэн Есүсийн жишээг харах хэрэгтэй. Бас “Та гэм буруутнуудад туслан Эзэнийг үзэн ядагчдыг хайрлана гэж үү?” (2 Шастир 19:2) гэж Иехошафатад хэлсэн Иехүгийн үгийг санах хэрэгтэй.

**[23:34, 35]** Есүс зөвхөн өөрийнхөө үхлийг урьдчилан хараагүй. Өөрийнх нь илгээх эш үзүүлэгчид, мэргэд, хуулийн багш нар, элч нарыг тэдгээр хуулийн багш нар, фарисайчууд хөнөөнө гэдгийг Есүс тодорхой хэлсэн. Тэдний

зарим нь үхлийн аюулаас мултарлаа ч **синагогуудад** ташуурдуулж, **хотоос хотод** мөшгөгдөн, хавчигдах болно. Бурханы хүмүүсийн амийг хөнөөсөн бүх түүхийн хуралдсан буруутгалыг Израилийн шашны удирдагчид ийнхүү өөрсөд дээрээ овоолох болно. **Абелын цуснаас авхуулаад...Зехариагийн цус хүртэлх газар дээр урссан бүх зөвт хүний цус тэдэн дээр ирнэ.** Энэ Зехариа нь Хуучин гэрээний Зехариа номыг бичсэн Зехариа биш, харин 2Шастир 24:20, 21 дээр гардаг Зехариа юм. Хуучин гэрээний номуудын дарааллыг еврейчүүдийн эмхэтгэснээр үзвэл 2Шастир ном хамгийн сүүлд бий.

**[23:36]** Өнгөрсөн бүх үеийн буруу нь Христийн үгийг сонсож байсан **үеийнхэн дээр** (тухайн үеийн иудейчүүд) буухыг Эзэн Есүс хэлж байна. Өмнө нь урссан бүх гэмгүй цус, ямар ч нүгэлгүй Аврагчийн үхэлтэй нэгдэн нийлж оргилдоо хүрнэ. Өөрсдийн Мессиаг шалтгаангүйгээр үзэн ядаж, гэмт хэрэгтэн цаазалдаг загалмай дээр хадсан тэрхүү үндэстэн дээр шийтгэлийн ширүүн урсгал асгарах болно.

## **О. Есүс Иерусалимын төлөө харуусан гунигласан нь (23:37-39)**

**[23:37]** Эзэн Есүсийн халагласан үгсийг агуулж, нулимсаар нь төгссөн энэ бүлэг үнэхээр чухал хэсэг юм. Бараг хамгийн чухал нь ч байж мэднэ. Эзэн Есүс фарисайчуудыг хурцаар зэмлэснийхээ дараа, боломжоо алдсан

Иерусалим хотын төлөө ихэд харуусан гунигласан. **“Иерусалим аа, Иерусалим аа”** гэж энэ нэрийг давтан давтан хэлснээс харахад сэтгэлд нь үгээр илэрхийлэх аргагүй гуниг зовлон байсан бололтой. Иерусалим хот **эш үзүүлэгчдийг** хөнөөж, Бурханы элч нарыг чулуудсан. Гэсэн ч Эзэн түүнд хайртай бөгөөд **тахиа дэгдээхэйнүүдээ бөөгнүүлдэг шиг**, хүүхдүүдийг нь хамгаалж хайрласандаа цуглуулахыг олонтоо хүссэн. **Харин** Иерусалим хүсээгүй.

**[23:38]** Эзэн Есүс харуусал гашуудлынхаа төгсгөлд **“Харагтун, гэр чинь та нарт хоосон үлдэж байна”** гэж хэлсэн. Энд дурдагдсан гэр (англиар house: гэр, байшин, өргөө) бол юуны түрүүнд Бурханы сүм юм. Гэхдээ бас Иерусалим хот ба Израиль үндэстнийг ч хамруулан хэлсэн байж болно. Есүсийн үхэл ба хоёр дахь ирэлтийн хооронд тодорхой хугацаа байх болно. Тэр үед үл итгэгч Израиль Есүсийг олж харахгүй (Амилсных нь дараа түүнийг зөвхөн итгэгчид харсан).

**[23:39]** Израилийн итгэгч хэсэг нь Есүсийг өөрсдийн Мессиа-Хаан гэж хүлээн авах үе буюу Христийн хоёр дахь ирэлт уруу 39 дүгээр эшлэл зааж байна. Хожим тэд Христийг хүлээн авна гэдэг нь **“Эзэний нэрээр ирэгч нь ерөөлтэй еэ!”** гэсэн үгнээс харагдаж байна.

Христийг хөнөөсөн хүмүүсийн хувьд, тэдэнд хоёр дахь боломж байгаа гэсэн зүйл энд огт алга. Эзэн Есүс энд Иерусалимын тухай ярьж байсан.

Тэгэхээр Иерусалимын оршин суугчид болоод ерөнхийдөө Израилийн тухай ярьж байсан гэсэн үг. Хожим Иерусалимын оршин суугчид өөрсдийн жадалсан нэгнийг харж, ганц хүүгийнхээ араас гашуудах мэт түүний төлөө гашуудах үедээ (Зехариа 12:10) Христийг хараж болно. Өнөөг хүртэл иудейчүүдийн түүхэнд ганц хүүгийнхээ төлөө уйлдаг шиг тийм их гашуудал болоогүй байна.

### **ХШ. ЧИДУН УУЛАН ДЭЭР АЙЛДСАН ХААНЫ СУРГААЛ (24, 25-р бүлэг)**

Хорин дөрөв, хорин тавдугаар бүлэгт тэмдэглэсэн сургаалыг Чидун уулын сургаал гэж нэрлэдэг. Учир нь энэ чухал мэдэгдлүүдийг Эзэн Есүс Чидун уулан дээр хэлжээ. Энэ сургаалууд нь тэр чигтээ эш үзүүллэг бөгөөд их зовлонгийн үе болон Эзэний хоёр дахь ирэлтийн тухай зөгнөсөн. Ер нь үндсэндээ Израиль үндэстний тухай юм. Үйл явдал Палестинд өрнөнө. “Иудейд байгсад уул уруу зугтааг” (24:16) гэж хэлснээс үүнийг харж болно. Үйл явдлын гол эзэд нь иудейчүүд байна. Тухайлбал “Та нарын зугталт... амралтын өдөр таарахгүйн тулд залбир” (24:20) гэж хэлсэн нь үүнийг илтгэдэг. Сонгогдогсод (24:22) гэж чуулган биш, харин Бурханы сонгосон иудейчүүд болохыг ойлгох хэрэгтэй. Энэ хоёр бүлэгт гарч байгаа эш үзүүллэг, сургаалт зүйрлэлүүдийг бид чуулгантай холбох гээд байдаг боловч үнэндээ чуулганы тухай юу ч дурдаагүй болно.

## **А. Эзэн Есүс сүмийн сүйрлийг зөгнөсөн нь (24:1, 2)**

Чидун уулын сургаал “**Есүс сүмээс гарч явлаа**” гэх нэн чухал үгээр эхэлж байна. Эзэн Есүсийн энэ үйлдэл “Тэр чинь та нарт хоосон үлдэж байна” (23:38) гэсэн үгтэй нь холбоотой харагддаг. Энэ нь бидэнд Бурханы цог жавхлан сүмээс холдож байгааг дүрсэлсэн Езекиелийн дүрслэлийг сануулдаг (Езекиел 9:3; 10:4; 11:23).

Шавь нар нь сүмийн барилгын архитектурын сайханд Эзэн Есүсийн анхаарлыг хандуулж, гайхан шагшуулахыг хүсжээ. Тэд мөнхийг бус, зуурдынхыг харж, бодит дүрд нь бус, сүүдэрт нь ач холбогдол өгч байлаа. Тэгэхэд Эзэн Есүс сүмийн барилгын **нэг ч чулуу нөгөө дээрээ үлдэхгүй бүгд нурахыг** урьдаас зөгнөн хэлэв. Титус сүмийг үлдээх гэж хичээсэн боловч цэргүүд нь гал тавьж Христийн хэлсэн үгийг биелүүлжээ. Цэргүүдийн тавьсан гал сүмийн алтыг хайлуулахад хайлсан алт сүмийн чулуунуудын завсраар орсон байна. Цэргүүд алтыг авахын тулд сүмийн чулуунуудыг нэг нэгээр нь зайлуулж, Эзэн Есүсийн хэлснийг үг бүрчлэн биелүүлжээ. Израильд өгсөн энэ шийтгэл МЭ 70 онд тохиосон бөгөөд тэр үед Титусын захиргаан дор ромчууд Иерусалим хотыг үнсэн товрог болгосон билээ.

## **Б. Их зовлонгийн үеийн эхний хагас (24:3-14)**

**[24:3]** Есүсийг Чидун ууланд сууж байхад шавь нар нь түүн уруу хэдүүлхнээ ирж, гурван асуулт тавив. Үүнд:

1. **Эдгээр зүйл чинь хэзээ болох юм бэ?** Өөрөөр хэлбэл, сүм хэзээ сүйрэх вэ?
2. **Таныг заларч ирэхэд ямар шинж тэмдэг байх вэ?** Өөрөөр хэлбэл, таныг эргэн ирж, газар дэлхий дээр хаанчлалыг байгуулахын өмнө ер бусын онцгой үйл явдал юу тохиолдох вэ?
3. **Үеийн төгсгөлд ямар шинж тэмдэг байх вэ?** Өөрөөр хэлбэл, таны цог жавхланта ноёрхлын өмнөх үеийн төгсгөлийг юугаар таних вэ? (Хоёр ба гурав дахь асуултууд үндсэндээ ижил утгатай байна.)

Есүсийн шавь болсон энэ иудейчүүд газар дэлхий дээрх Мессиагийн цог жавхланта үеийг л бодож байсан гэдгийг бид мартаж болохгүй. Христ чуулганы төлөө ирэх талаар тэд бодоогүй. Учир нь Христийн ирэлтийн энэ үе шатын талаар мэдэх юм тэдэнд бараг байгаагүй. Христ хүч ба алдар дотор ирж, дайснуудаа устгаж, энэ ертөнцөд ноёрхох үеийг тэд бодож байсан.

Түүнээс гадна, тэд энэ дэлхийн төгсгөлийн тухай яриагүй гэдгийг мэдэх нь чухал. Харин **үеийн** (грек: *αιон*) төгсгөлийн тухай ярьж байсан. Эзэн Есүс эхний асуултад шууд хариулаагүй. Харин МЭ70 онд болох



Иерусалимын бүслэлтийг (Лук 21:20-24-ийг үз) хожмын өдөр болох ижил төстэй өөр нэгэн бүслэлттэй холбон ярьжээ. Ер нь Библийн эш үзүүллэгийг судалж байхад ийм зүйл байнга таарна. Эзэн эш үзүүлэхдээ, зөгнөлийг нь хагас хугас биелүүлэх ойрын ирээдүйн үйл явдлыг хүүрнэж байснаа үл анзаарагдах байдлаар шилжиж, зөгнөлийг нь бүрэн биелүүлэх эцсийн өдрийн үйл явдлуудтай түүнийгээ холбодог.

Хоёр ба гурав дахь асуултын хариултыг 24 дүгээр бүлгийн 4-44 дүгээр эшлэлд өгсөн. Эдгээр эшлэлд долоон жилийн зовлон гамшгийн үеийг дүрсэлсэн. Энэ үе нь Христийн сүр жавхланта хоёр дахь ирэлтийн өмнө тохионо.

Энэ долоон жилийн эхний гурван жил хагасыг 4-14 дүгээр эшлэлд дүрсэлсэн. Дараагийн гурван жил хагасыг их зовлонгийн үе, Иаковын зовлон гамшгийн үе (Иеремиа 30:7) гэж нэрлэдэг бөгөөд өмнө нь хэзээ ч тохиолдож байгаагүй маш их зовлон гамшиг энэ үед газар дэлхий дээр бий болно.

Их зовлонгийн үеийн эхний хагаст тохиолдоно гэж энд өгүүлсэн үйл явдлууд нь хүн төрөлхтний түүхэнд ер нь үе үе тохиолдож байсан зүйлс юм. Гэхдээ энд гарч байгаа үйл явдлууд нь бусад үеийнхээс илүү онцгой, эрчимжсэн байдалтай байх болно. Чуулганы дотор багтсан итгэгчдэд зовлон ирнэ гэдгийг Эзэн Есүс сануулсан (Иохан16:33). Гэхдээ тэр бүхэн нь одоо өгүүлж байгаа их зовлонгоос огт өөр зүйл юм. Их зовлон бол Бурханы Хүүгээс

татгалзсан ертөнц дээр бууж буй Бурханы уур хилэн билээ.

Бурханы уур хилэнгийн өдөр (1Тесалоник 1:10; 5:9; 2Тесалоник 2:1-12; Илчлэл 3:10) ирж, их зовлонгийн үе тохиохоос өмнө чуулган дээш авагдаж, энэ ертөнцөөс явна (1Тесалоник 4:13-18).

**[24:4, 5]** Их зовлонгийн үеийн эхний хагаст хуурамч мессиянууд олноор гарч ирж, олон хүнийг хуурч мэхэлнэ. Өнөөдөр олон олон гаж урсгалууд гарч ирж байгаа нь үүний нэг дохио байж болох ч энэ эш үзүүлэгийн биелэл нь биш. Тэдгээр нь өөрсдийгөө **Христ** гэж нэрлэсэн иудей хүмүүс байна.

**[24:6, 7]** **Дайн болоод дайны сураг чимээ сонсогдоно. Үндэстэн үндэстнийхээ эсрэг, хаанчлал хаанчлалынхаа эсрэг босно.** Өнөөгийн бид энэ эш үзүүлэгийн биеллийг харж байна хэмээн эндүүрдэг. Өнөөдөр болж буй дайн дажин бол энэ зөгнөлийн биелэл биш. Өнөөгийн дайн дажныг их зовлонгийн үеийнхтэй харьцуулбал хажууд нь юу ч биш санагдана. Юуны түрүүнд чуулганы шүүрэлт тохиох ёстой (Иохан 14:1-6; Коринт 15:51-57). Чуулган дээш шүүрэгдэхээс нааш энд өгүүлсэн эш үзүүлэгүүдийн нэг нь ч биелэхгүй. Чуулган газар дэлхийгээс явсны дараа Бурханы эш үзүүлэгийн цаг ажиллаж эхлэх бөгөөд энд дурдсан үйл явдлууд тэр даруй биелж эхэлнэ. **Дэлхийн энд тэнд өлсгөлөн, газар хөдлөлт болно.** Дэлхийн удирдагчид хүн амын үсрэнгүй

өсөлтөөс улбаатай хоол хүнсний хомсдолд одооноос санаа зовж байна. Гэхдээ энд өгүүлж буй өлсгөлөн дайн дажнаас болж бий болно.

Өнөөдөр газар хөдлөлтүүд эрс нэмэгджээ. Их зовлонгийн үед бүр ч их нэмэгдэнэ. Гэхдээ өнөөдөр болж байгаа газар хөдлөлтүүд нь Аврагч Эзэний маань хэлсэн үгийн биелэл биш юм.

**[24:8]** Энэ үеийг 8 дугаар эшлэлд **төрөх өвдөлтийн эхэн** гэжээ. Өөрөөр хэлбэл, Израилийн Мессиа-Хааны захиргаан дор буй болох шинэ эрин үеийг авчрах төрөлтийн өвдөлт юм.

**[24:9, 10]** Итгэмжтэй итгэгчид их зовлонгийн үед маш хүнд сорилтыг даван туулна. Үндэстнүүд Христэд үнэнч хүмүүсийн эсрэг хорсол зэвүүцлийн аян өрнүүлнэ. Христийн шавь нар шашны болоод иргэний шүүхээр шүүгдэнэ (Марк 13:9). Итгэлээсээ урваагүйгээс болоод олон хүн амиа алдана. Ийм сорилт шалгуурыг христитгэгч хүмүүс олонтоо амсаж байсан боловч энд өгүүлж байгаа нь их зовлонгийн үед тусгай үйлчлэл хийх 144,000 иудей итгэгчид хамаатай гэж харагддаг.

Зовлон эдэлж, амиа алдахаас айсандаа олон хүн урвана. Гэр бүлийнхэн нь өөрийнхнийхөө эсрэг мэдээлэл өгч, харгис хэрцгий хавчигч нарын гарт тушаана.

**[24:11]** Олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж, олныг төөрөлдүүлнэ. Үүнийг 5 дугаар эшлэлийн хуурамч мессиянуудтай андуурч

болохгүй. **Хуурамч эш үзүүлэгчид** гэдэг нь өөрсдийгөө Бурханы үгийг дамжуулагч гэж зарлах хүмүүс юм. Тэднийг хоёр аргаар таньж болно. Нэгт, тэдний эш үзүүлэлэг байнга биелдэггүй. Хоёрт, тэдний сургаал хүмүүсийг үнэн Бурханаас холдуулдаг. Хуурамч эш үзүүлэгчид гарч ирнэ гэдгээс үзэхэд их зовлонгийн үед иудейчүүд үйл явдлын гол эзэн байна гэдгийн бас нэг баталгаа юм. **Хуурамч эш үзүүлэгчид** Израиль үндэстэнтэй холбоотой байдаг. Чуулганд бол хуурамч багш нар аюул авчирдаг (2Петр 2:1).

[24:12] Гэмт муу үйл газар авч, хүний сайхан сэтгэл хомсдох болно. Бусдыг хайрладаггүй хүйтэн сэтгэлээс улбаатай үйлс хаа сайгүй байна.

[24:13] **“Харин эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах болно.”** Тэр цаг үед хүний сүнс тэвчээрээр аврагдана гэсэн утгаар энд хэлээгүй нь мэдээж. Аврал бол Бурханы нигүүлслийн бэлэг бөгөөд Христ золиос болон үхэж, дахин амилсан гэдэгт итгэснээр энэ авралыг үнэгүй авдаг гэж Библид маш тодорхой хэлсэн. Бас тэвчсэн бүгд бие махбодын хохирол амсахгүй гэсэн утгаар ч энд хэлээгүй нь тодорхой. Яагаад гэвэл олон итгэгчид амиа алдана гэдгийг 9 дүгээр эшлэлд хэлсэн. Ерөнхийдөө энэ эшлэл нь, их зовлонгийн үед итгэлээсээ урвахгүйгээр тууштай байсан хүн Христийн хоёр дахь ирэлтээр тэр бүх зовлонгоосоо ангижирна гэсэн утгатай. Итгэлээ үгүйсгэхийг амиа аварч үлдэх, эсвэл аюулгүй байх зам гэж бодож болохгүй.

Христ ирэхдээ итгэл нь үнэн хүмүүсийг л аварна. Харин авралд хүргэх жинхэнэ итгэлд тэвчих чанар гарцаагүй байдаг.

**[24:14]** Энэ үед **хаанчлалын сайнмэдээ бүх үндэстэнд гэрчлэл болж дэлхий даяар тунхаглагдана. Хаанчлалын сайнмэдээ** гэж юу болохыг өмнө нь 4:23 дугаар эшлэлийг тайлбарлахдаа дурдсан. Дахин хэлэхэд, **хаанчлалын сайнмэдээ** бол Христ ирээд газар дэлхий дээр **хаанчлалаа** байгуулна гэдгийг тунхагладаг сайнмэдээ юм. Их зовлонгийн үед түүнийг итгэлээр хүлээн авсан хүн мянган жилийн хаанчлалынх нь ивээл ерөөлийг эдлэх болно.

Арван дөрөвдүгээр эшлэлийг ер нь буруу тайлбарладаг. Юу гэхээр, сайнмэдээг сонсоогүй үндэстэн ястан дэлхий дээр олон байгаа учраас Христ чуулганыхаа төлөө хэзээ ч хамаагүй ирэх боломжгүй гэдэг. Гэхдээ энэ эшлэлд, Христ ариун хүмүүстэйгээ хамт ирэх тухай ярьж байгааг ойлгох хэрэгтэй. Христ ариун хүмүүсээ авахаар ирэх үйл явдал үүнээс тусдаа. Мөн энд Бурханы нигүүлслийн сайнмэдээг биш, харин хаанчлалын сайнмэдээг ярьж байгааг мэдэх нь чухал (4:23-ын тайлбарыг үз).

Энэ бүлгийн 3-14 дүгээр эшлэлд гарч буй үйл явдлууд Илчлэл 6:1-11-тэй холбоотой байна. Цагаан морьтон бол хуурамч мессиа. Улаан морьтон бол дайн дажин. Хар морьтон бол өлсгөлөн. Зэгэл ногоон морьтон бол өвчин тахал ба үхэл. Тахилын ширээний доор байсан

сүнснүүд бол итгэлээсээ болж амиа алдсан ариун хүмүүс юм. Илчлэл 6:12-17 дээр дүрсэлсэн үйл явдлууд Матай 24:19-31-тай холбоотой байна.

## **В. Их зовлонгийн үе (24:15-28)**

**[24:15]** Энэ эшлэл дээр ирэхэд их зовлонгийн эхний хагас дууссан байдаг. Бид 15 дугаар эшлэлийг Даниелын 9:27-той харьцуулан үзээд үүнийг мэдэх болсон. Дал дахь долоо хоногийн дунд буюу гурван жил хагасын төгсгөлд ариун газарт (энэ бол Иерусалим хотын сүм) хуурамч шүтээн тавина гэдгийг Даниел зөгнөсөн. Энэ жигшүүрт шүтээнд мөргөхийг бүх хүнд тушаах болно. Энэ тушаалыг дагаагүй хүн үхлийн ял амсана (Илчлэл 13:15).

**“Иймд эш үзүүлэгч Даниелын хэлсэн хоосролын бузар юм ариун газар байхыг харвал (уншигч нь ойлгог)...”** Иерусалимын сүмд шүтээн тавигдсанаар их зовлонгийн үе эхэлнэ. Бурханы үгийг мэддэг хүмүүст энэ нь тэмдэг болно. Зөгнөлийг **уншсан** хүн үүнийг **ойлгоосой** гэж Эзэн хүсэж буйг та анзаараарай.

**[24:16]** **Иудейд байгсад нь уул уруу зугтаах хэрэгтэй.** Иерусалимын ойр орчимд байвал тэрхүү шүтээнд мөргөөгүй хүмүүс амархан баригдана.

**[24:17-19]** Тэр үед маш хурдан хөдлөх хэрэгтэй. **Дээвэр дээр** сууж таарвал гэр уруугаа орж, юм хумаа авах гэсний хэрэггүй. Эд хөрөнгөө ардаа орхиод шууд зугтсан нь дээр. Эд юмаа цуглуулахад зарцуулсан цаг нь амьд үлдэх

үү эсвэл үхэх үү гэдгийг шийдэж мэднэ. **Талбайд** ажиллаж байсан хүн хувцсаа авах гэж орхисон газар уруугаа буцах хэрэггүй. Тэр үе **жирэмсэн** эмэгтэй, **хөхүүл** эхчүүдэд илүү хүнд тусна. Хурдан зугтах тэдэнд амаргүй байна.

[24:20] Энэ хүнд үе **өвөл** тохиохгүй байхын төлөө итгэгчид **залбирах** хэрэгтэй. Өвөл таарвал зугтаж явахад хүндрэлтэй, илүү осолтой болно. Бас **амралтын өдөр** тохиохгүй байхын төлөө залбирах хэрэгтэй. Хуулийн дагуу амралтын өдрөөр тийм хол явж болохгүй (Гэтлэл 16:26). Тиймээс амралтын өдөр таарчихвал итгэгчид аюултай бүсээс холдож чадахгүй болно.

[24:21] “Учир нь ертөнцийн эхнээс энэ үеийг хүртэл болоогүй, мөн дахиж хэзээ ч болохгүй агуу их гай гамшиг болно.” Их зовлонгийн үе нь хүн төрөлхтний түүхэнд гарсан бүхий л хавчлага зовлон, үй олноор хөнөөх явдал, арчин зайлуулах үйлдэл, хоморголон устгал, үндэс угсаагаар нь хүйс тэмтэрсэн тохиолдлуудаас ялгаатай гэдгийг энэ үг харуулж байна. Энэ эш үзүүллэг хэзээ нэгэн цагт ямар нэг хавчлагаар биелэгдсэн байх боломжгүй. Яагаад гэвэл энэ их гай гамшигийн төгсгөлд Христийн хоёр дахь ирэлт болох ёстой.

[24:22] Их зовлонгийн үед зовлон, гай гамшиг дэндүү аймшигтай хүнд байх учраас **тэр өдрүүдийг богиносгоогүйсэн бол** хэн ч амьд үлдэхгүй байв. Гэхдээ их зовлон тохиох гурван жил хагасын хугацаа богиносно гэсэн утгаар байх боломжгүй. Магадгүй өдрийн гэрэлтэй

цагийг Бурхан ер бусын аргаар богиносгоно гэсэн утгатай болов уу. Учир нь дайн тулаан, аллага хядлагын ихэнх нь өдрийн гэгээнээр болдог. **Сонгогдогсдын төлөө** (Есүсийг хүлээн авсан хүмүүс) Эзэн эрт харанхуй болгож өгнө. Тийнхүү энэ нь завсарлага болно.

[24:23-26] Хорин гурав, хорин дөрөвдүгээр эшлэлд Эзэн Есүс **хуурамч** мессиагууд болон **хуурамч эш үзүүлэгчдээс** дахин сэрэмжлүүлж байна. Их зовлонгийн үеийн гай гамшгийн цагт Мессиаг нэг нууц газарт байгаа гэх мэдээ тархах болно. Христийг үнэн сэтгэлээсээ, хайрын үүднээс эрмэлзэн хайдаг хүмүүсийг занганд оруулахын тулд ийм мэдээ тараах магадлалтай. Иймэрхүү үгэнд бүү итгэ гэж Эзэн Есүс бүх шавь нартаа анхааруулж байна. Бүр гайхамшиг үйлдэж байсан ч итгэх хэрэггүй. Тэр нь заавал Бурханаас байх албагүй. Сатан ч гэсэн гайхамшиг үйлдэж чадна. Хуульгүй хүн гарч ирээд Сатаны хүчээр олон гайхамшиг үйлдэх болно (2Тесалоник 2:9, 10).

[24:27] Христ гэнэтхэн сүр жавхлантайгаар ирнэ. Түүний ирэхийг дэлхий даяар бүх харна. Тиймээс Христийн ирэлтийг мэдэхгүй өнгөрөх ямар ч боломжгүй. Христийн ирэлт нь **аянгын** гялбаа шиг нүд ирмэхийн зуурт болж, бүгдэд тодорхой харагдана.

[24:28] Бузар муу нүгэл хилэнц, ялзрал завхрал Түүний уур хилэн, шүүлт шийтгэлээс зугтаж чадахгүй. **“Хүүр байгаа газар тас шувууд цуглардаг.”** Хүүр гэдэг нь Бурхан ба



түүний Христийг эсэргүүцэгч урвасан иудаизм, хуурамч христийнхэн, дэлхийн бүх тогтолцоог илэрхийлж байна. Тас шувууд гэдэг Бурханы шүүлт шийтгэлийг дүрсэлж байна. Энэхүү шүүлт шийтгэл нь Мессиагийн ирэлтээр хэрэгжих болно.

### **Г. Христийн хоёр дахь ирэлт (24:29-31)**

**[24:29]** Их зовлонгийн төгсгөлд тэнгэрт аймшигтай үзэгдлүүд бий болно. **Нар харанхуйлна.** Нарнаас ирсэн гэрлийг тусгаж ойлгодог **сар гэрэлтэхгүй** болно. Тэнгэрт оддын байршил алдагдаж, гараг эрхэс тойрог замаасаа гарна. Сансар огторгуйд ийм аймшигтай юм болж байхад цаг агаар, жил улирал, ертөнцийн зүй тогтол нөлөөнөөс нь ангид байх ямар ч боломжгүй.

Тэнгэрийн эрхэс газар дэлхийг донсолгож, хамаг юмыг нь хөмрөх үед юу болох бол гэдгийг Великовский дүрслэн бичсэнийг үзвэл бид бага ч атугай төсөөлөлтэй болох болов уу.

Тэр үед маш хүчтэй газар хөдлөлт болно. Агаар ба ус инерцээр тасралтгүй хөдөлнө. Хуй салхи газрыг шүүрдэх мэт хамаг юмыг хуу хамж, далай тэнгис эргээсээ хальж, элс хайрга, далайн амьтдыг гарган хаяна. Агаарын температур нэмэгдэж, хад чулуу хайлж, галт уулс дэлбэрч, газрын ан цаваар халуун лав урсаж, үлэмж их нутгийг бүрхэнэ. Тал газар өргөгдөж, шинэ уул үүсгэж, зарим

уул байрнаасаа хөдөлж, зарим уул дарагдаж, газрын гадарга өөрчлөгдөнө. Нуур цөөрөмд ч хөдөлгөөн орж, гол мөрөн ч урсгалаа өөрчилнө. Зарим газар оршин суугчидтайгаа хамт далайд живнэ. Ой мод шатна. Хуй салхи, догшин тэнгис ургаа моддыг үндэс мөчиртэй нь хуу хамна. Далай тэнгисийн ус урсан одож цөл болно.<sup>45</sup>

[24:30] “Тэгээд Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илэрхийлэгдэнэ.” Энэ нь ямар тэмдэг байхыг бидэнд хэлсэнгүй. Христийг эхний удаа ирэхэд тэнгэрт нэгэн тэмдэг үзэгдэж, онцгой од гарсан. Магадгүй гайхамшигт нэгэн од гарч Христийн хоёр дахь ирэлтийг зарлан тунхаглаж болох юм. Зарим хүн **Хүний Хүүг** өөрийг нь тэр тэмдэг гэж үздэг. Энэ тэмдэг нь юу ч байсан харагдах үедээ бүгдэд ойлгомжтой байх нь дамжиггүй. **Газрын бүх овог гашуудан уйлна.** Тэд Түүнийг хүлээн аваагүй учраас ийнхүү уйлна. Гэхдээ юуны түрүүнд мөнөөх нутгийн<sup>46</sup> овгууд буюу Израилийн арван хоёр овог гашуудан уйлна. “...тэд өөрсдийн жадалсан намайг харна. Тэд ганц хүүгийнхээ төлөө гашуудаж буй нэгэн мэт түүний төлөө төлөө гашуудан, ууган хүүгийнхээ хойноос асгартал уйлдаг шиг түүний хойноос асгартал уйлна” (Зехариа 12:10).

Тэгээд “тэд **Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр сүр хүч болоод агуу цог жавхлантайгаар ирэхийг харна.**” Юутай гайхалтай мөч вэ!

Нулимуулж, цовдлуулж байсан тэрээр амь ба алдар жавхлангийн Эзэн болж ирнэ. Дөлгөөн, даруу Есүс Иеховагийн дүрээрээ үзэгдэнэ. Тахилын Хурга тэрээр ялгуусан Арслан болж бууна. Назарын дорд мужаан байсан тэрээр хаадын Хаан, эздийн Эзэн болж заларна. Тэр тэнгэрийн үүлсийг хөсөг тэргээ болгоно. Тэрээр ноёрхох эрх мэдэл, хүч чадал, суу жавхлан дотор ирнэ. Бүх бүтээл энэ л мөчийг мянга мянган жилийн турш ёолон хүлээсэн билээ.

**[24:31]** Тэрээр бууж ирээд **тэнгэрэлч нараа** дэлхий даяар **илгээж, сонгогдогсдыг** буюу итгэгч Израилийг Палестины нутагт **цуглуулах болно**. Дэлхийн өнцөг булан бүрээс тэд Мессиатайгаа уулзахаар цугларч, Түүний жавхлант хаанчлалд орох болно.

#### **Д. Инжрийн модны сургаалт зүйрлэл (24:32-35)**

**[24:32]** “Одоо **инжрийн модноос сургаалт зүйрлэлийг сурч ав.**” Бидний Эзэн дахиад л байгаль дэлхийн зүй тогтлоос сүнслэг сургамж өгч байна. Инжрийн модны мөчир ногоорч, **зөөлрөхөд зун ойртжээ гэдгийг мэддэг**. Инжрийн мод нь Израиль үндэстний бэлгэдэл (21:18-22) гэдгийг бид өмнө үзсэн. Олон зуун жилийн турш Израиль нь чив чимээгүй үхмэл мэт байв. Тэд төр засаг, газар нутаг, сүм, тахилчгүйгээр олон зууныг элээжээ. Дахин улс болох шинж тэмдэг ч байсангүй. Ард түмэн нь дэлхий даяар тарсан байв.

Гэтэл 1948 онд Израиль улс байгуулагдав. Тэд өөрсдийн гэсэн газар нутаг, засаг захиргаа, мөнгөн тэмдэгт, төрийн сүлдтэй болов. Израилийн сүнсний байдал одоо ч гэсэн үржил шимгүй, хүйтэн хөндий байна. Тэднээс Бурханд зориулсан ямар ч үр жимс алга. Гэвч улс үндэстнийх нь хувьд Израилийн мөчир ногоорч, **зөөлөрсөн** байна гэж хэлж болно.

**[24:33] “Тиймээс та нар энэ бүхнийг хараад түүний ойрхон байгааг, үүдэн дээр чинь ирснийг мэдэгтүн!”** Израиль улс байгуулагдсан нь их зовлонгийн үе эхлэхэд ойрхон байгааг төдийгүй Эзэн өөрөө ойрхон, **үүдэн дээр байгааг** илтгэн харуулдаг.

Христ хаанчлахаар ирэх нь ойрхон байгаа юм бол чуулганы шүүрэлт бүр ч илүү ойрхон байгаа гэсэн үг биш үү? Христ цог жавхлантайгаар ирэхийн өмнө болох ёстой үйл явдлуудын сүүдэр аль хэдийнээ үзэгдээд эхэлчихсэн юм бол Түүний ирэлтийн (грек: *парусиа*) эхний үе шат бидэнд хэчнээн ойр байгаа бол (1Тесалоник 4:13-18)?

**[24:34]** Эзэн Есүс инжрийн модны тухай ярьсныхаа араас **“Үнэнээр би та нарт хэлье. Энэ бүхнийг тохиолдохоос нааш энэ үеийнхэн үгүй болохгүй”** гэж нэмж хэлэв. **“Энэ үеийнхэн”** гэдэг нь Христийн үед амьдарч байсан хүмүүс байх боломжгүй. Тэр хүмүүс одоо бүгдээрээ нас барчихсан. Гэтэл 24 дүгээр бүлэгт өгүүлсэн үйл явдлууд биелээгүй л байна. Тэгвэл Эзэн Есүс **“энэ үеийнхэн”** гэж юуг хэлсэн бэ? Үндэслэлтэй

бөгөөд оновчтой байж болохоор өгсөн хоёр тайлбар бий.

(1) Ф.У.Грант тэргүүтэй зарим хүн “Эдгээр зүйлийн эхлэлийг үзэх яг тэр **үеийнхэн** эцсийг нь ч бас үзнэ”<sup>47</sup> гэсэн үзлийг баримталдаг. Өөрөөр хэлбэл, Израилийг улс болсныг үзсэн хүмүүс (эсвэл их зовлонгийн эхлэлийг үзсэн хүмүүс) Эзэн Есүсийг үүл хөлөглөн ирж, газар дэлхий дээр ноёрхлоо тогтоохыг ч бас үзнэ гэсэн үг.

(2) “**Үеийнхэн**” гэдэг үгийг үндэстэн гэж ойлгож болно. Грек эхийг нь ингэж орчуулах бүрэн боломжтой. Грек дээрээ энэ үг нь нэг айлын, эсвэл нийтлэг чанартай, эсвэл нэг гаралтай хүмүүсийг хэлдэг (Матай 12:45; 23:35,36). Хэрэв энэ үзэл үнэн бол, иудейчүүд сөнөж устахгүй байсаар байж, энэ бүлэгт дурдагдсан бүхнийг үзэх болно гэсэн утгаар Эзэн Есүс хэлжээ. Иудейчүүд үнэхээрийн хүнд олон зовлонг даван туулж, одоо ч оршсоор байгаа нь түүхийн гайхамшиг мөн.

Харин миний хувьд үүнийг бас нэг өөр талаас хардаг. Есүсийн амьдарч асан цаг үед “энэ үеийнхэн” гэж өөрийг нь Мессиа гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан хатуу сэтгэлт иудейчүүдийг Есүс хэлж байсан. Тэгэхээр Израиль нь улс үндэстнийхээ хувьд Христээс татгалзах байдлаа Христийн хоёр дахь ирэлтийг хүртэл хэвээр хадгална гэдгийг Эзэн Есүс энд хэлж байна гэж надад бодогддог. Тэгээд тэрслүү бүхнийг нухчин дарна. Харин түүнд

захирагдахаар шийдсэн хүмүүс аврагдаж, мянган жилийн хаанчлалд орно.

**[24:35]** Эзэн Есүсийн үгс гарцаагүй биелнэ. Үүний баталгаа болгож тэрээр **“Тэнгэр газар үгүй боловч миний үгс огтхон ч үгүй болохгүй”** гэж хэлжээ. Энд хэлсэн, өнгөрөн одох тэнгэр бол Бурханы оршдог тэнгэр бус (2Коринт 12:2-4), харин од эрхэс, агаар мандал оршдог тэнгэр буюу бидний дээр оршдог хөх огторгуй юм. Тэнгэр газрын алга болохыг 2Петр 3:10-13 дээр дүрслэн өгүүлж, Илчлэл 20:11 дээр дурдаад өнгөрсөн байна.

#### **Е. Тэр өдөр, цагийг хэн ч мэдэхгүй (24:36-44)**

**[24:36]** Христийн хоёр дахь ирэлтийн тодорхой өдөр, цагийг хэн ч мэдэхгүй. Тэнгэрийн элч ч мэдэхгүй<sup>48</sup>. Харин Эцэг л мэднэ. Тиймээс Христийн ирэлтийн өдөр, цагийг тогтоох гэсний хэрэггүй. Бас тэр өдөр, цагийг мэднэ гэсэн хүмүүст ч итгэх хэрэггүй. Тэнгэрэлч нар мэдэхгүй байгаа нь ердийн хэрэг юм. Тэд бол тодорхой түвшний л мэдлэгтэй хязгаарлагдмал бүтээл билээ.

Христийн ирэлтийн өмнө амьдарч байх хүмүүс өдөр, цагийг нь мэдэхгүй ч эш үзүүллэгийг мэддэг хүмүүс жилийг нь мэдэж байх боломжтой. Тухайлбал, сүмд шүтээн тавьснаас хойш ойролцоогоор гурван жил хагасын дараа Христ ирнэ гэдгийг тэд мэдэж байна (Даниел 9:27; мөн Даниел 7:25; 12:7, 11; Илчлэл 11:2, 3; 12:14; 13:5-ыг тус тус үзнэ үү).

**[24:37-39]** Гэхдээ тэр үед **Ноагийн өдрүүдтэй адил** ихэнх хүмүүс юу ч бодолгүй амьдарч байна. Усан галавын өмнөх үеийнхэн маш хорон муу байсан боловч энэ шинж чанарыг энд онцолсонгүй. Ноагийн үеийн хүмүүс **идэж, ууж, гэрлэж, нөхөрт гарцгааж байсан.** Нэг ёсондоо тэд мөнх амьдрах юм шиг өдөр тутмын амьдралаа хэвийн үргэлжлүүлээд явж байсан. Үер ирж байгаа гэдгийг сануулсан боловч үерийн хамгаалалттай мэт юу ч бодож санахгүй амьдарч байв. Харин үер буухад тэд ямар ч бэлтгэлгүй, цорын ганц аюулгүй газрын гадна зогсож байлаа. Христийг ирэх үед ч гэсэн ийм байх болно. Аюулгүй хөвөгч авдар болох Христийн дотор байгаа хүмүүс л зөвхөн аврагдана.

**[24:40, 41]** **Хоёр хүн талбайд байхад нэгийг нь** шүүлт шийтгэл уруу авч яваад нөгөөг нь мянган жилийн хаанчлалд оруулахаар үлдээнэ. **Хоёр эмэгтэй тээрэмдэж байхад,** тэднийг салгана. Нэг нь шүүлт шийтгэлийн үерт урсаж, нөгөө нь Христийн хаанчлалын ерөөлийг хүртэхээр үлдэнэ. (Христийн ирэлтийн эхний үе шатанд Христ бүх итгэгчдийг тэнгэр уруу дээш авахад үл итгэгчид бүгдээрээ шүүлт шийтгэл амсахаар үлдэж хоцрох шүүрэлтийн үетэй энэхүү 40, 41 дүгээр эшлэлийг холбож, аврагдаагүй хүмүүст сэрэмжлүүлэг болгодог хүмүүс бий. Яах вэ ингэж ашиглаж болох л юм. Гэхдээ хам сэдвийг нь харвал Христ ноёрхлоо

тогтоохоор ирэх үетэй холбон тайлбарлах ёстой гэдэг нь тодорхой байна.)

**[24:42-44]** Тэрхүү өдөр, цагийг мэдэх хүн үгүй учраас бид анхаарал сэрэмжтэй, **сонор сэргэг** байх хэрэгтэй. Гэрт нь хулгай орохыг мэдэж байгаа хүн хулгайч ирэх тодорхой цагийг мэдэхгүй байсан ч юмаа алдахгүйн тулд сонор сэрэмжтэй байна. Ихэнх хүний бодоогүй цагт Хүний Хүү ирнэ. Тиймээс бид түүний ирэхийг хоног тоолон хүлээх хэрэгтэй.

**Ё. Зарим нь ухаантай, зарим нь хорон муу зарц нарын тухай сургаалт зүйрлэл (24:45-51)**

**[24:45-47]** Зарц хүн Эзэнийхээ эргэн ирэлтэд хэрхэн хандаж байгаагаас түүний үнэн мөнийг таньж болно гэсэн утгатай сургаалт зүйрлэлийг Эзэн Есүс энэ бүлгийн төгсгөлд өгүүлжээ. Зарц нар бүгдээрээ гэрийнхнийг цагт нь хооллож байх үүрэгтэй байлаа. Гэвч Христийн зарц гэсэн бүхэн жинхэнэ зарц байсангүй.

**Ухаалаг зарц** гэдэг нь Христийг ирэхэд Бурханы хүмүүсийг анхаарч халамжлах үүргээ биелүүлж байсан хүн юм. Тийм хүн хүндлэл хүртэж, тэнгэрийн хаанчлалд өндөр байр суурийг олно. Эзэн нь түүнийг **хамаг эзэмшил хөрөнгөө түүнд даатгана.**

**[24:48-51]** Хорон муу зарц гэдэг нь итгэгч нэртэй ч Эзэнээ ирнэ хэмээн боддоггүй хүн юм. Эзэнээ ирнэ гэж боддоггүй болохоор амьдралын хэв маяг нь ч муу байдаг. Тэрээр бусад зарц **нараа зодож, архичидтай идэж ууж эхэлдэг.**



Тэрээр Бурханы хаанчлалд бэлэн биш гэсэн үг. Хаан эргэн ирээд түүнийг шийтгэж, **хоёр нүүртнүүдтэй хамт нэг газар байрлуулна**. Тэд **тэнд уйлж, шүдээ хавирна**.

Есүс Мессиа-Хаан дүрээрээ газар дэлхий дээр биеэр ирэх ирэлтийг энэ сургаалт зүйрлэл ярьж байна. Гэхдээ зарчмыг нь шүүрэлтийн үед ч бас холбож болно. Христитгэгч гэсэн мөртлөө Бурханы хүмүүсийг үзэн ядаж, Христийн эргэн ирэлтийг эс хүлээгч бурхангүй хүмүүстэй нөхөрлөдөг олон хүн бий. Тэдний хувьд Христийн ирэлт нь ивээл ерөөл бус, шүүлт шийтгэл билээ.

### **Ж. Арван охины тухай сургаалт зүйрлэл (25:1-13)**

[25:1-5] “Мөн” гэсэн эхний үг энэ сургаалт зүйрлэлийг өмнөх 24 дүгээр бүлэгтэй холбож байна. Тэгэхээр Хааны биеэр ирэх үеийг болон түүний өмнөх үеийг ярьж байгаа гэсэн үг юм. Энд Есүс **шинэ хүргэнийг угтахаар дэнлүүгээ аваад гарсан арван охинтой тэнгэрийн хаанчлалыг зүйрлэсэн**. Тэдний тав нь ухаалаг бөгөөд дэнлүүндээ тос авсан байлаа. Харин нөгөө тав нь тэгсэнгүй. Ингээд хүргэнийг хүлээж байхдаа тэд унтаж эхлэв.

**Ухаалаг** таван охин нь их зовлонгийн үеийн жинхэнэ дагалдагч нарыг хэлсэн. Христитгэгч хэмээн амаараа хүлээн зөвшөөрч буйг дэнлүүгээр илэрхийлсэн. Харин тос бол Ариун Сүнсний бэлгэдэл юм. Мунхаг тав нь ч бас

дэнлүү барьснаас харахад тэд Мессиаг найдан хүлээж байгаа хэмээн амаараа мэдэгддэг байжээ. Гэвч үнэн байдал дээрээ дахин төрөөгүй байв. Тиймээс тэдэнд Ариун Сүнс байгаагүй. **Хүргэн** бол Христ Хаан юм. Хүргэн ирэхгүй удсан гэдэг нь Христийн хоёр ирэлтийн хоорондох үеийг бэлгэдсэн. Тэд арвуулаа **унтаж эхэлсэн** гэдэг нь гадна талаасаа ялгарах юм тэдэнд байгаагүй гэдгийг харуулж байна.

**[25:6]** Шөнө дөлөөр **хүргэний** ирж яваг зарлав. Түүний ирэхийг зарлаж олон тэмдгүүд бий болно гэдгийг бид өмнөх бүлэгт үзсэн.

**[25:7-9]** **Нөгөө охид бүгдээрээ босож дэнлүүгээ бэлдэв.** Тэд бүгдээрээ Эзэний өмнө бэлэн зогсохыг хүсэж байлаа. Гэвч мунхаг тав нь тосгүй байсан учраас нөгөө таваас тос гуйв. Тэгэхэд ухаалаг тав нь тосноосоо өгөхөөс татгалзаж, явж худалдаж авахыг зөвлөжээ. Ухаалаг тав нь харамч мэт санагдаж болох юм. Гэхдээ Ариун Сүнсийг дамжуулж болдоггүй болохоор ингэж хэлэхээс өөр арга байгаагүй. Мэдээж хэрэг Ариун Сүнсийг зардаггүй боловч Библид авралыг үнэгүйгээр, мөнгөгүйгээр худалдан ав гэж уран зохиолын дүрслэлээр хэлсэн нь бий.

**[25:10-12]** **Тэднийг явсан хойгуур хүргэн ирэв.** Шинэ гэрээний сири болон латин Вулгат орчуулгад хүргэнийг сүйт бүсгүйтэйгээ хамт ирсэн гэсэн байдаг. Энэ нь Библийн эш үзүүллэгтэй төгс нийцдэг. Эзэн Есүс сүйт бүсгүй болох чуулгантайгаа хамт хуримаасаа эргэн ирэх

болно (1Тесалоник 3:13). (Хурим нь шүүрэлтийн дараа тэнгэрт [Ефес 5:27] болно.) Их зовлонгийн үеийн итгэмжит ариун үлдэгсэд Түүнтэй хамт хуримын найрт оролцоно. Хуримын найр гэдэг нь Христийн хаанчлалын баяр хөөр, ивээл ерөөлийг хэлжээ. Ухаалаг охид **хүргэний хамт найрт оров. Тэгээд хаалгаа хаажээ.** Үүнээс хойш хаанчлалд ороход оройтжээ. Бусад таван охин ирээд дотогш орох гэхэд хүргэн тэднийг танихгүй гэдгээ хэлэв. Өөрөөр хэлбэл, тэд ерөөсөө дахин төрөөгүй байжээ.

[25:13] Эзэн Есүс энэ сургаалт зүйрлэлээр дамжуулж **соргог байхыг** сургамжилж байна. Учир нь түүний ирэх **өдөр, цагийг** хэн ч мэдэхгүй. Итгэгч бид Эзэнийгээ хэзээ ч ирж магадгүй гэсэн сэтгэлээр амьдрах хэрэгтэй. Бидний дэнлүү тосоор дүүрэн байна уу?

### 3. Талантын тухай сургаалт зүйрлэл (25:14-30)

[25:14-18] Эзэнийг ирэхэд жинхэнэ болон хуурамч зарц нар байх болно гэдгийг энэ сургаалт зүйрлэлд ч гэсэн өгүүлж байна. **Холын аянд гарахдаа зарц нараа дуудаад чадварынх нь дагуу** тус бүрд нь тодорхой хэмжээний мөнгө өгч буй **нэгэн хүн** байж гэнэ. Тэрээр эхний зарцдаа **тав**, удаах дахь зарцдаа **хоёр**, сүүлийн зарцдаа **нэг талант өгчээ.** Тэд энэ мөнгийг ашиглаад эзэндээ ашиг орлого олж өгөх ёстой байв. Эзэнээ явсны дараа таван таланттай хүн өөрт оногдсон хөрөнгөөрөө арилжаа хийгээд **нэмж таван талант олжээ.** Хоёр таланттай хүн

ч гэсэн авсан мөнгөө нэг нугалсан байв. **Харин нэг талант авсан зарц явж нүх ухаад мөнгөө булжээ.**

Энэ сургаалт зүйрлэлийн эзэн бол Христ, холын аян бол хоёр ирэлтийн хоорондох үе юм. Гурван зарц нь их зовлонгийн үед амьдрах Израильчууд юм. Тэд эзнийгээ эзгүй хойгуур ашиг сонирхлыг нь төлөөлөх ёстой байв. Тэдэнд чадварынх нь дагуу үүрэг хариуцлага оноожээ.

**[25:19-23] Удаан хугацааны дараа эзэн ирж зарц нартайгаа тооцоо хийж гэнэ.** Энэ нь хоёр дахь ирэлтийг хэлж байна. Эзэн нь эхний хоёр зарцад хоёуланд нь **“Сайн байна, итгэмжит сайн зарц минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тулд чамд ихийг хариуцуулъя. Эзнийхээ баяр баясгаланд ор”** гэж хэлсэн. Эзэн зарц нарынхаа үйлчлэлийг шалгахдаа хэр ихийг олсноор нь бус, хэр их хичээл зүтгэл гаргаснаар нь үнэлэх болно. Тэр хоёр зарц хоёулаа бүх чадвараа ашиглаж, зуун хувь ашиг олсон билээ. Тэд жинхэнэ итгэгчдийг төлөөлдөг. Тэд Мессиагийн хаанчлалын ерөөл жаргалыг хүртэх болно.

**[25:24, 25]** Гэтэл гурав дахь зарцад юу ч байсангүй. Тэрээр эзнээ муу хэлж, шалтаг тоочив. Тэр зарц эзнийгээ **үр суулгаагүй газраас хадгаж, юу ч цацаагүй газраас түүдэг хатуу сэтгэлтэй,** юм ойлгодоггүй хүн хэмээн буруутгав. Айдаст хүлэгдсэнээсээ болоод юу ч хийгээгүй, авсан ганц **талантаа** газарт булсан хэмээн тэр өөрийгөө өмөөрөв. Энэ зарц ямар ч эргэлзээгүй

үл итгэгч байсан юм. Жинхэнэ зарц хүн эзнийхээ талаар ийм юм бодохгүй.

**[25:26, 27] Эзэн нь түүнийг муу залхуу хэмээн зэмлэв. Эзнийхээ талаар тийм бодолтой байсан юм бол тэр зарц мөнгийг нь мөнгө хүүлэгчид хадгалуулж хүү авах ёстой байлаа. Үнэндээ эзэн нь 26 дугаар эшлэлд өөрийг нь буруутгасан үгийг хүлээн зөвшөөрөөгүй. Тийм учраас зарцдаа тэр “Хэрэв чи намайг тэгж боддог бол талантаараа арилжаа наймаа хийх шалтгаан бүр ч их байсан. Чиний шалтаг өөрийг чинь л буруутгаж байна” гэж хэлжээ.**

**[25:28, 29] Энэ зарц ганц талантаараа нэмж нэг талант олсон бол өмнөх хоёртойгоо адил үнэлэгдэх байв. Гэвч тэгсэнгүй. Тэрээр амьдралаа тайлагнахад газарт ухсан нүх л үзүүлэв. Тиймээс түүний нэг талантыг авч арван таланттай хүнд өглөө. Энэ бол сүнслэг ертөнцийн хувиршгүй зарчим юм. “Хэнд байна, түүнд нэмж өгөгдөнө. Түүнд элбэг дэлбэг байх болно. Харин хэнд эс байна, байгаа нь хүртэл түүнээс авагдана.”** Бурханы алдрын төлөө явах хүсэлтэй хүнд Бурхан ашиглах зүйлсийг өгдөг. Цааш явах тусам Бурханы төлөө явах боломж улам бүр нэмэгддэг. Харин Бурханы өгсөн зүйлсийг ашиглахгүй бол түүнийгээ алдах болно. Залхуурлын шан бол байгаагаа алдах.

Хэрэв бид өөрсдийн өмч хөрөнгийг Эзэний төлөө ашиглаж чадахгүй бол чадах нэгэнд нь өгөх ёстой. Энэ санааг **мөнгө хүүлэгчээр** дүрсэлсэн. Энэ тохиолдолд мөнгө хүүлэгч гэж

илгээлтийн эзэд, Библийн нийгэмлэг, христитгэлт хэвлэлийн газар, сайнмэдээний радио хөтөлбөр зэргийг ойлгох хэрэгтэй. Бидний амьдарч байгаа шиг дэлхий ертөнцөд мөнгийг зүгээр л хадгалаад байж болохгүй. Пиерсон энэ талаар дараах үгийг хэлсэн:

Хаанчлалын төлөө хэнээс ч хамаарахгүйгээр зоригтой үйлчлэх зүрх зориггүй итгэгч хүн өөрийн эд хөрөнгө, өгөгдсөн боломжоороо энэ ажилд оролцож болно. Эзэн Есүс болон чуулганы төлөө өөрийгөө идэвхийлэн зориулж буй хүмүүст тэр бүхнээ өгвөл оруулсан энэ хувь нэмрээс нь ашиг гарна. Тэр хүнд мөнгө, эд хөрөнгө, янз бүрийн боломж бололцоо байвч итгэл, хараа, эрч хүч, мэргэн ухаан дутаж байж болно. Харин Эзэний “**мөнгө хүүлэгч**” нар түүний мөнгө, эд хөрөнгө, боломж бололцоог Эзэний төлөө хэрхэн ашиглахыг түүнд харуулж чадна...Биеийн нэг эрхтний сул талд туслахын тулд өөр нэг эрхтний давуу талыг ашиглаж, хамтын ажиллагааг ханган, өчүүхэн доройгоо барьж босгохын тулд чуулган оршдог билээ.<sup>49</sup>

**[25:30]** Өнөөх зохисгүй зарцыг хаанчлалын гадна хөөж гаргасан. Тэрээр хорон муу хүмүүсийн адил мөнх зовлонгийн аймшигт хувь тавиланг хүртжээ. Тэрээр талантаараа хөрөнгө оруулалт хийгээгүйнхээ төлөө шийтгэл амсаагүй юм. Харин түүнээс сайн үйлс гараагүй нь авралд

хүрэх жинхэнэ итгэл түүнд байгаагүйг харуулсан.

## **И. Хаан үндэстнүүдийг шүүсэн нь (25:31-46)**

[25:31] Энэ хэсэгт үндэстнүүдийг шүүх шүүлтийн тухай гарна. Гэхдээ энэ нь Христийн шүүх суудал ба их цагаан сэнтийн шүүлтээс ялгаатай.

Христийн шүүх суудлын өмнө зөвхөн итгэгчид амьдралаа шалгуулна. Энэ нь шүүрэлтийн дараа болно. Тэр үед Христ итгэгчдийн амьдралыг дүгнэж, тохирсон шагнал өгнө. (Ром 14:10; 1Коринт 3:11-15; 2Коринт 5:9, 10). Их цагаан сэнтийн шүүлт нь мянган жилийн хаанчлалын дараа, мөнх цаг үе эхлэхэд болно. Нүглийн уучлалыг аваагүй хүмүүс тэнд шүүгдэж, галт нуурт хаягдана (Илчлэл 20:11-15).

Үндэстнүүдийг эсвэл иудей бус хүмүүсийг (грек үг нь аль алийг нь хэлдэг) шүүх шүүлт нь Христ газар дэлхий дээр ноёрхлоо тогтоохоор ирэх үед болно. Үүнийг 31 дүгээр эшлэлээс тодорхой харж болно. Үүнд: **“Хүний Хүү алдраа дуурьсган бүх тэнгэрэлч нарынхаа хамт ирж, өөрийн сүр жавхлант сэнтийд залрах болно”** гэжээ. Хэрэв Иоел 3:2 дээр үүний тухай өгүүлсэн бол энэ шүүлт Иерусалимын гадна талд, Иехошафатын хөдийд болох ажээ. Их зовлонгийн үеэр Христийн ахан дүүс болсон иудей хүмүүст хэрхэн хандсаных нь дагуу үндэстнүүдийг шүүх болно (Иоел 3:1, 2, 12-14; Матай 25:31-46).

[25:32] Энд **хонь, ямаа**, Христийн ахан дүүс гэсэн гурван төрлийн хүн байгааг анхаарах хэрэгтэй. Эхний хоёр нь бол их зовлонгийн үед амьдарч байсан харь үндэстнүүд юм. Харин гурав дахь нь Христийн ахан дүүс болох итгэгч иудейчүүд юм. Энэ иудейчүүд их зовлонгийн үед, уул овоо шиг хавчлага зовлонгийн дунд ч гэсэн Христийн нэрийг үгүйсгэхээс татгалзжээ.

[25:33-40] Хаан Есүс **хонио өөрийн баруун талд, ямааг зүүн талд байлгана**. Тэгээд **ертөнцийн сууриас** өөрсдөд нь зориулан **бэлтгэсэн цог жавхлант хаанчлалд** хонинуудыг урина. Тэд Эзэн Есүсийг **өлсөж байхад** хооллож, **цангаж байхад уух юм өгч, харь хүн байтал** хүлээн авч, ноорхой хувцастай байхад **хувцаслаж, өвчтэй байхад эргэж**, шоронд байхад түүн дээр очиж байсан учраас энэ сайхан ерөөлийг хүртэж байгаа ажээ. **Зөвт** хонинууд нь Хаан Есүст тийм сайхан сэтгэл гаргаж байгаагүйгээ хэлнэ. Учир нь тэд Эзэн Есүстэй хэзээ ч уулзаж байгаагүй юм. Тэгэхэд Есүс тэдэнд **“Ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол өөрт нь хийсэн хэрэг”** гэдгийг тайлбарлана. Эзэн Есүсийн шавь нарт хийсэн бүхэн Түүнд өөрт нь хийж өгснөөр тооцогдоно.

[25:41-45] Дараа нь **зөвт бус ямаануудад** хандан **“Диовал болон түүний тэнгэрэлч нарт бэлтгэсэн мөнх галд орж, надаас зайл”** гэж хэлнэ. Яагаад гэвэл тэд Иаковын зовлон гамшгийн үед Эзэн Есүсийг тоож үзээгүй юм.



Гэвч тэд Түүнтэй уулзаж байгаагүйгээ хэлж өөрсдийгөө өмөөрөхөд, дагалдагч нарыг нь эс хайхарсан бол Өөрийг нь эс хайхарсантай адил гэдгийг Эзэн Есүс сануулна.

**[25:46]** Тийнхүү ямаанууд **мөнх шийтгэлд**, хонинууд **мөнх аминд орно**. Эндээс хоёр асуулт урган гардаг. Нэгт, Бурхан үндэстнүүдийг бүхлээр нь аварч, эсвэл бүхлээр нь шийтгэдэг гэсэн санаа энэ хэсэгт байгаа мэт харагддаг. Хоёрт, хонинууд сайн үйлсээр аврагдаж, ямаанууд сайныг үйлдээгүйнхээ төлөө яллагдаж байна гэсэн ойлголтыг энэ хэсэг төрүүлдэг. Нэг дэх асуудлын хувьд гэвэл, Бурхан үндэстнүүдтэй хандахдаа ер нь багцаар нь авч үздэгийг санах хэрэгтэй. Нүглээсээ болж үндэстнээрээ шийтгүүлж байгаа тухай Хуучин гэрээний олон газар бий (Исаиа 10:12-19; 47:5-15; Езекиел 25:6, 7; Амос 1:3, 6, 9, 11, 13; 2:1, 4, 6; Обадиа 10; Зехариа 14:1-5). Гэхдээ тухайн үндэстний тухайн цаг үед авсан шийтгэл үргэлжилсээр байдаг гэж бодох нь утгагүй юм. Түүнээс гадна, тухайн улс үндэстэн дээр буусан шийтгэл хувь хүн бүрд нь хамаатай гэсэн үг биш. Бурхан шударга ёсыг улс үндэстэн дээр ч тэр, хүн тус бүр дээр ч тэр, аль аль түвшинд нь хэрэгжүүлдэг.

Энд “үндэстнүүд” гэж орчуулсан *этинэ* гэдэг грек үгийг “иудей бус хүмүүс буюу харь үндэстэн” гэж орчуулж болно. Тийм учраас иудей бус хувь хүмүүс дээр явуулж байгаа шүүлтийг энд өгүүлсэн гэж үзэх хэрэгтэй.

Хоёр дахь асуултын хувьд гэвэл, үйлсээр аврагдана гэж заахын тулд энэ хэсгийг ашиглаж болохгүй. Хүн үйлсээр биш, итгэлээр аврагддаг (Ефес 2:8, 9) гэдэг нь Библийн маш тодорхой сургаал мөн. Жинхэнэ итгэл сайн үйлсийг төрүүлдэг гэдэг нь ч Библийн чухал сургаал юм. Хэрэв итгэгч хүнээс ямар ч сайн үйл гарахгүй бол ерөөсөө аврагдаагүй гэдгийг харуулдаг. Тийм учраас тэдгээр харь хүмүүс иудей үлдэгсдэд сайхан сэтгэл үзүүлснээр аврагдаагүй гэдгийг ойлгох нь чухал. Тэдний үзүүлсэн сайхан сэтгэл Эзэн Есүсийг хайрласных нь илэрхийлэл ажээ.

Түүнээс гадна, зайлшгүй дурдах хэрэгтэй гурван зүйл энд бий. Нэгт гэвэл, Бурханы хаанчлал нь ертөнцийн сууриас өмнө зөвт хүмүүст бэлтгэгдсэн (34-р эшлэл) бол там нь диавол болон түүний тэнгэрэлч нарт зориулагдсан байжээ (41-р эшлэл). Бурхан хүнийг ерөөхийг хүсдэг. Тамыг анхнаасаа хүн төрөлхтөнд зориулаагүй. Гэхдээ хүмүүс зориудаар амиас татгалзвал тэдэнд үхэл оногдохоос өөр зам үгүй.

Хоёрт гэвэл, Эзэн Есүс мөнх гал (41-р эшлэл), мөнх шийтгэл (46-р эшлэл), мөнх амийн (46-р эшлэл) тухай ярьсан. Мөнх амийг ярьсан тэр ам мөнх шийтгэлийг ч бас ярьсан юм. Энэ гурвыг тодотгосон “мөнх” гэдэг үг нь грек дээрээ яг ижил байна. Тиймээс нэгийг нь мөнх гэж үзэх мөртлөө нөгөөг нь мөнх биш гэж яривал ямар ч утгагүй хэрэг болно. Хэрэв мөнх гэж орчуулсан

үгийг мөнх гэсэн утгаар ойлгохгүй л юм бол мөнх гэсэн утга илэрхийлэх өөр үг грек хэлэнд байхгүй. Энэ үг Бурханы мөнх чанарыг илэрхийлэхэд хэрэглэгдсэн учраас гарцаагүй мөнх гэсэн утгатай гэдгийг бид мэднэ (1Тимот 1:17).

Эцэст нь, Христ өөрийн хүмүүстэйгээ нэг гэдгийг иудей бус хүмүүсийг шүүх шүүлт бидэнд сануулж байна. Христийн хүмүүст учирсан зүйл Христэд учирсантай адил юм. Хэрэв бид Эзэн Есүст сайхан сэтгэл гаргахыг хүсвэл түүнийг хайрладаг хүмүүст сайхан сэтгэл гаргах хэрэгтэй.

#### **XIV. МЕССИА ХААНЫ ЗОВЛОН БА ҮХЭЛ (26, 27-р бүлэг)**

##### **A. Есүсийг алах хуйвалдаан (26:1-5)**

[26:1, 2] Матайн сайнмэдээнд Эзэн Есүс дөрөв дэх удаагаа буюу эцсийн удаа Өөрийнхөө үхлийг шавь нартаа урьдчилан хэлж (Матай 16:21, 17:23, 20:18) байна. Алгасал баярын үе Өөрийнх нь үхэх үйл явдалтай давхацна гэдгийг тэр мэдэгдэв. **“Хоёр хоногийн дараа алгасал баяр болохыг та нар мэднэ. Хүний Хүү цовдлуулахаар тушаагдана.”** Тэр жил алгасал баяр жинхэнэ утга учраа олжээ. Алгасал баярын хурга эцэст нь нэг юм ирэв. Одоо тэр удахгүй нядлагдах гэж байна.

[26:3-5] Есүс үхэх тухайгаа хэлж байх зуур **ахлах тахилчид, хуулийн багш нар, ард олны**

**ахлагчид тэргүүн тахилч Каиафын ордонд цугларч** төлөвлөгөө боловсруулж байв. Тэд Есүсийг хүмүүст анзаарагдахгүйгээр барьж аваад алах бодолтой байв. Гэхдээ үүнийгээ **баярын үеэр** хийвэл хуумгай хэрэг болно гэж үзжээ. Есүсийн амийг хөнөөсний төлөө ард олон үймээн самуун дэгдээж болзошгүй байлаа. Израилийн удирдагчид Мессиагаа алах гэж хуйвалдаж буй нь юутай харамсалтай! Уг нь тэд л хамгийн түрүүнд түүнийг таньж, хаан ширээнд нь залах ёстой байсан. Гэтэл тэд дайснуудынх нь тэргүүн эгнээнд явж байв.

#### **Б. Есүсийг Бетанд тосолсон нь (26:6-13)**

[26:6, 7] Тахилчдын хорт явуулга, шавь нарын итгэл алдрал, Иудасын урвалт гээд олон хүнд зүйл өмнө нь хүлээж байгаа энэ үед үнэхээрийн урамтай үйл явдал болж байна. **Есүсийг Бетанд уяман өвчтэй Симоны гэрт байхад их үнэтэй тос бүхий гөлтгөнө сав барьсан эмэгтэй орж ирээд толгой дээр нь тосоо цуглав.** Тэр эмэгтэйн Эзэн Есүсийг гэсэн сэтгэлийг асгасан тосных үнэ өртгөөс харж болно. Эзэн Есүсийн төлөө өргөхөд хэт үнэтэйдэх зүйл гэж юу ч байхгүйг тэр хийсэн үйлдлээрээ өнөөдөр ч ярьсаар байна.

[26:8, 9] **Шавь нар**, тэр дундаа Иудас (Иохан 12:4, 5) энэ үйлдлийг хий дэмий **үрэлгэн** байдал гэж үзэж байв. **Тосыг мөнгө** болгоод **ядууст өгсөн** бол дээр байх байсан гэж тэд боджээ.

[26:10-12] Есүс тэдний өрөөсгөл бодлыг залруулж өгөв. Тэр эмэгтэйн үйлдэл маш их золиостойгоос гадна үнэхээрийн үзэмж төгс байлаа. Түүгээр ч зогсохгүй үнэхээр цагаа олжээ. Ядуу хүмүүст хэзээ ч тусалж болно. Харин Аврагч Эзэнийг оршуулгад зориулж тослох боломж дэлхийн түүхэнд ганц л тохионо. Тэр цаг нь ирэхэд нэг л эмэгтэй үүнийг нь алдалгүй барьж авах сүнслэг хараатай байжээ. Өөрийнхөө үхлийн тухай ярьж байсан үгэнд нь итгэсэн тэрээр одоо л биш бол дахиж ийм боломж гарахгүй гэдгийг ойлгожээ. Үнэхээр ч түүний зөв байв. Оршуулгынх нь дараа Эзэн Есүсийн биеийг тослохоор төлөвлөж байсан эмэгтэйчүүд дахин амиллаас болоод чадаагүй билээ (Марк 16:1-6).

[26:13] Хайраас гарсан эгэл энгийн үйлсийг нь Эзэн Есүс мартагдуулаагүй юм. **“Үнэнээр би та нарт хэлье. Энэхүү сайнмэдээ бүх дэлхийн хаа ч тунхаглагдсан энэ эмэгтэйд дурсаж, үйлс нь яригдах болно.”** Үнэн мөргөлийн алив үйлдэл нь тэнгэрийн гудамжнуудыг анхилуун үнэрээр дүүргэж, хэзээ ч мартагдахгүйгээр Эзэний дурсамжид үлдэх болно.

### **В. Иудас урвасан нь (26:14-16)**

[26:14, 15] Эзэн Есүстэй хамт амьдарч, хамт аялж, Эзэн Есүсийн гайхамшгуудыг нүдээр харж, юутай ч зүйрлэшгүй сургаалыг нь сонсож, нүгэлгүй амьдралынх нь гэрч болсон арван хоёр дагалдагчийнх нь нэг Иудас Бурханы Хүүгээс

урвав. “Миний итгэдэг, талхнаас минь идэж байсан дотно найз минь” (Дуулал 41:9) гэж нэрлэсэн хүн нь өөдөөс нь өсгийгөө өргөв.

**Искарриотын Иудас ахлах тахилчид уруу очиж,** Багшийгаа **гучин мөнгөн зоосоор** зарахаар тохиролцов. Гучин мөнгөн зоос нь одоогийнхоор бол ердөө арван таван доллартой л тэнцэнэ. Тахилчид түүнд мөнгийг нь даруй газар дээр нь тоолоод өгөв.

Симоны гэрт Есүсийг тосолсон эмэгтэй ба Иудас хоёрыг харьцуулан харах нэн сонирхолтой. Тэр эмэгтэй Аврагч Эзэнийг дэндүү үнэ цэнтэйд тооцсон бол Иудас харин хэдхэн зоосоор үнэлжээ.

**[26:16]** Есүсээс зөвхөн хайр энэрлийг хүртэж байсан тэр хүн одоо түүнийг худалдаж байна.

**Г. Эзэн Есүсийн тэмдэглэсэн хамгийн сүүлчийн алгасал баяр (26:17-25)**

**[26:17]** Исгээгүй талхны баярын эхний өдөр байлаа. Энэ баяраар иудейчүүд исгэгч хөрөнгө гэртээ огт байлгадаггүй байв. Эзэн Есүс алгасал баярын зоог бэлдүүлэхээр шавь нараа Иерусалим уруу илгээж байхдаа энэ баярын утга учрыг бодож байсан биз ээ. Баярын зоог нь хүртэл онцгой утга агуулдаг.

**[26:18-20]** Хотод ороод нэг хүнтэй уулзаад гэрт нь баярын зоог бэлдэхийг Есүс шавь нартаа зааварчлав. Тэрээр уг хүний нэрийг хэлсэнгүй. Ийм бүдэг бадаг мэдээлэл өгч зааварчилсан нь өөрийг нь хөнөөхөөр санаархагчдад ажиг сэжиг

авхуулахгүй гэснийх бололтой. Ямартай ч, Есүс хүн бүрийг нарийн мэддэг болохыг эндээс харж болно. Хэн өөртэй нь хамтран ажиллах хүсэлтэй болохыг Есүс андахгүй мэднэ. Эзэний үгийг анхааралтай үзнэ үү: **“Багш ‘Миний цаг ойрхон байна. Би танайд шавь нартайгаа хамт алгасал баярыг тэмдэглэн’ гэсэн.”** Үхэл нь өөдөөс нь ирж явахад Тэрээр маш тайван байлаа. Ингээд төгс нигүүлслээр зоог бэлэн болов. Эзэн Есүсийн тэмдэглэсэн сүүлчийн алгасал баярт зориулж гэрээ хэрэглүүлсэн, нэр нь үл мэдэгдэх тэр хүн юутай хувьтай хүн бэ!

[26:21-24] Тэд зоогоо бариад сууж байтал арван хоёрынх нь нэг өөрөөс нь урвана хэмээн цочирдом мэдээ дуулгав. Шавь нар гуниглаж, сэтгэлдээ тавгүйтэж, өөрсдөдөө эргэлзэх сэтгэлээр дүүрч, нэг нэгээрээ **“Би биш биз дээ?”** хэмээн асууцгаав. Иудасаас бусад нь бүгд ингэж асуухад Есүс тэдэнд “Миний хамт тавагт гараа дүрэгч нь надаас урвах болно” гээд талх авч шөлөнд дүрээд Иудаст өгөв (Иохан 13:26). Энэ нь хайр ба нөхөрлөлийг бэлгэдсэн үйлдэл байлаа. Тэгээд бас өөрт нь тохиолдох зүйлсийг болиулах аргагүй тодорхой хүчин зүйлс байдгийг сануулав. Гэхдээ тэглээ гээд урвасан хүн үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөхгүй. **Тэр хүн төрөөгүй байсан бол илүү дээр байжээ.** Иудас өөрийн санаачилгаар, зориуд Аврагч Эзэнийг худалдсан болохоор үүнийхээ хариуцлагыг гарцаагүй үүрнэ.

[26:25] Эцэст нь Иудас **“Би биш биз дээ?”** хэмээн ичгүүргүйгээр асуухад Есүс **“Тийм”** гэж хариулав.

#### **Д. Хамгийн анхны Эзэний зоог (26:26-29)**

Иохан 13:30-ыг үзвэл Иудас талхнаас авмагцаа гарч явжээ. Тэгэхэд шөнө болсон байлаа. Тийм учраас Эзэний зоогийг барьж байхад Иудасыг байгаагүй гэж дүгнэж болохоор байна (Гэхдээ үүнийг хүлээн зөвшөөрдөггүй олон хүн бий).

[26:26] Эзэн Есүс шавь нартайгаа хамт алгасал баярыг хамгийн сүүлийн удаа тэмдэглэснийхээ дараа Эзэний зоогийг барив. Тэд алгасал баярын зоог барьж байсан учраас Эзэний зоогийн үндсэн зүйлс болох талх, дарс тэр үед ширээн дээр байж байлаа. Есүс энэ хоёр зүйлд цоо шинэ утга учир оруулав. Эхлээд тэрээр **талх аваад ерөөсний дараа хуваан шавь нартаа өгөөд “Май, ид. Энэ бол миний бие” гэлээ.** Есүс биеэ загалмай дээр хараахан өргөөгүй байсан болохоор энд дүрслэлийн аргаар ярьж, Өөрийнхөө биеийг талхаар бэлгэдсэн гэдэг нь тодорхой юм.

[26:27, 28] **Аяганы хувьд ч адил.** Аяга бол ямар нэг зүйлийг дотроо агуулдаг зүйл. Эзэн Есүсийн барьж байсан аяганд усан үзмийн дарс байв. Дарс нь **шинэ гэрээний цусыг** бэлгэдсэн. Ямар ч болзолгүйгээр нигүүлслийг хүртээдэг **шинэ гэрээ** нь Эзэн Есүсийн үнэт нандин **цусаар** баталгаажна. Тэрээр нүглүүдийг уучлахын тулд



олны төлөө цусаа урсгана. Түүний цус бүх хүнийг уучлахад хангалттай. Гэвч энэ цус **олны төлөө** урссан. Өөрөөр хэлбэл, зөвхөн итгэсэн хүмүүсийн нүгэл уучлагдах болно гэсэн үг юм.

**[26:29]** Дараа нь Аврагч маань шавь нартаа хандан “Энэ дэлхийг хаанчлахаар эргэн ирэх **хүртэл энэ усан үзмийн дарсыг та нартай хамт дахин уухгүй**” гэж сануулав. Тэр үед энэ дарс цоо шинэ утга учиртай болж, **Эцэгийн хаанчлалын** баяр хөөр, ивээл ерөөлийг илтгэнэ.

Заримдаа хүмүүс, Эзэний зоогийн талх нь исгэсэн байсан уу, исгээгүй байсан уу, дарс нь исэж хатуурсан байсан уу, зөөлөн ундаа байсан уу гэж асуудаг. Эзэн Есүс исгээгүй талх, хатуу дарс ашигласан гэж үзэх нь зөв. Тухайн үеийн дарс бүгдээрээ исгэлэн хатуу байсан. Исгэх хөрөнгө нь нүглийг бэлгэддэг, тиймээс талх нь исгээгүй байсан юм бол дарс нь ч бас исээгүй байсан байх ёстой гэж зарим хүн маргадаг. Үнэнийг хэлэхэд Эзэнийг Өөрийг нь умартаад талх, дарсанд л ач холбогдол өгвөл буруу болно. Талх өөрөө бол юу ч биш, харин талхны хэлж байгаа сүнслэг утга чухал гэдгийг Паул онцолсон байдаг. “Та нар исгэгдээгүй юм шиг шинэ зуурсан гурил байхын тулд хуучин хөрөнгийг бүрмөсөн цэвэрлэ. Учир нь бидний алгасал баярын хурга болох Христ тахил болсон юм. Иймд бид хуучин хөрөнгөөр бус, хорсол ба бузар муугийн хөрөнгөөр ч бус, харин чин сэтгэлийн ба үнэний исгээгүй талхаар баярыг тэмдэглэе” (1Коринт 5:7, 8). Асуудлын гол нь

талханд байгаа хөрөнгө бус, харин бидний амьдралд байгаа хөрөнгө юм.

### **Е. Өөртөө итгэлтэй шавь нар (26:30-35)**

**[26:30]** Эзэний зоогийн араас тэд магтуу дуулав. Дуулал 113-118 (“Их Халлел” гэж нэрлэдэг)-ын аль нэгээс дуулсан болов уу. Тэгээд тэд Иерусалимаас гарч, Кидрон горхийг гатлаад, Чидун уулын баруун талаар өгсөж, тэнд байдаг Гетсемани цэцэрлэгт хүрэв.

**[26:31]** Дэлхий дээр үйлчилсэн хугацаандаа Эзэн Есүс Өөрийнх нь өмнө хүлээж байгаа зүйлийг шавь нартаа олон удаа сануулж байсан. Харин энэ удаа тэр тэдэнд “Та нар бүгд энэ шөнө надаас нүүр буруулна” гэж хэлэв. Тэд аюулт шуурга дэгдэхийг хараад айдаст автана. Тэгээд өөрсдийгөө аврахын тулд Эзэнээ хаях болно. “Хоньчныг цохь, хоньд нь тарж бутарна” (13:7) гэсэн Зехариагийн эш үзүүллэг ийнхүү биелэх болно.

**[26:32]** Гэхдээ Тэрээр шавь нартаа хоосон найдвар үлдээсэнгүй. Түүнээс нүүр буруулсандаа тэд ичих боловч, Эзэн Есүс тэднийг огтхон ч хаяхгүй. Тэрээр үхлээс амилсныхаа дараа тэдэнтэй Галилд уулзана гэдгээ хэлэв. Юутай гайхалтай, юутай үнэнч хувиршгүй Анд вэ!

**[26:33, 34]** Петр Эзэн Есүсийн яриан дундуур орж, “Бүгд бүдэрлээ ч, би хэзээ ч бүдрэхгүй” гэж хэлэв. Есүс “хэзээ ч” гэсэн үгийг нь “энэ шөнө, гурван удаа” хэмээн залруулж өглөө.

**Тахиа донгодохоос өмнө, бодлогогүй шавь Петр Эзэнийгээ гурван удаа үгүйсгэх болно.**

**[26:35]** Тэгж хэлсэн ч гэсэн Петр үнэнч гэдгээ нотлохын тулд **“Үхэх байсан ч Таныг үгүйсгэхгүй”** хэмээн шийдэмгий хэлэв. Петрийн араас **шавь нар бүгдээрээ тэгж хэлцгээв.** Тэд энэ үгийг үнэн сэтгэлээсээ хэлсэн юм. Тэд үнэхээр л тэгнэ гэж бодож байсан. Гэвч зүрх сэтгэлд нь юу байдгийг тэд мэдэхгүй байсан болохоор ийм том ам гарцгаажээ.

**Ё. Гетсемани цэцэрлэгт Эзэн Есүс шаналан зовсон нь (26:36-46)**

Гетсемани цэцэрлэгийн түүхийг тайлбарлах нь ариун газар дээгүүр алхахтай адил гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ түүхэнд тайлбар хийх гэж буй хүнд үлэмжийн хүндлэл, эмээлт, бишрэл төрөх учиртай. “Энэ үйл явдлын тэнгэрлэг мөн чанар нь эмээн хүндлэх сэтгэлийг өөрийн эрхгүй төрүүлнэ. Үүнийг мэдэхгүй хүн энэ түүхийг тайлбарлавал үнэндээ байдлыг дордуулахаас хэтрэхгүй” хэмээн бичсэн Гая Кингтэй би санал нийлдэг.

**[26:36-38]** Есүс шавь нартайгаа хамт **Гетсемани** цэцэрлэгт очоод арван нэгэн шавийнхаа наймыг зайдуу үлдээгээд **Петр болон Зебедеен хоёр хүүг** аваад цэцэрлэгийн гүн уруу оров. Эндээс, Аврагч Эзэний сэтгэлийн зовлонг ойлгох чадвар дагалдагч бүрд ондоо байдаг хэмээн ойлгож болох уу?

**Тэр зовж, шаналж эхлэв.** Тэрээр сэтгэлдээ үхтлээ зовж байгаагаа Петр, Иаков, Иохан нарт ний нуугүй хэлэв. Хүмүүн бидний төлөө нүглийн тахил болох гэж буйгаа мэдэж байсан Түүний нүгэлгүй ариун сүнсний шаналлыг үгээр илэрхийлэх аргагүй биз ээ. Бидний төлөө нүгэл болох нь ямар ч нүгэлгүй Нэгэний хувьд ямар болохыг нүгэлт бид хэзээ ч ойлгохгүй (2Коринт 5:21).

**[26:39]** Есүс авч явсан гурван шавиа үлдээж, **жаахан цааш явсан** нь гайхах зүйл биш юм. Учир нь Түүний зовлонг хэн ч хуваалцаж чадахгүй. Хэн ч “**Эцэг минь, хэрэв Би үүнийг уухаас нааш энэ нь өнгөрөхгүй юм бол Таны хүсэл биелэг**” гэсэн залбирлыг нь залбирч чадахгүй.

Энэ залбирлыг үзээд бид Есүс загалмайгаас халширч, замаасаа буцахыг хүсэж байсан хэмээн дүгнэж болохгүй. Иохан 12:27, 28 дээр тэмдэглэсэн үгийг нь үзвэл, “Одоо сэтгэл минь шаналж байна. Би юу хэлэх вэ? ‘Аав аа, энэ цагаас намайг авраач’ гэх үү? Гэвч би энэ зорилгын төлөө л энэ цагт ирсэн. Аав аа, нэрээ алдаршуулаач” гэсэн байна. Болбол энэ аягыг өнгөрүүлж өгөөч гэсэн залбирал нь тэгэхээр загалмай уруу явахаас аварч өгөөч гэсэн гуйлт биш ажээ. Тэр энэ л зорилгын төлөө энэ дэлхийд ирсэн шүү дээ!

Энэ залбирал үнэндээ мэдэгдэл байсан юм. Тэрээр хариу хүлээсэндээ бус, бидэнд нэгийг ойлгуулах гэсэндээ ийн хэлжээ. Есүсийн

хэлснийг өөр үгэнд хөрвүүлбэл, “Аав аа, муу нүгэлтнүүдийг аврахын тулд загалмай уруу явахаас өөр зам байгаа бол түүнийг одоо илчлээч. Гэхдээ таны хүслээс өөр юуг ч би хийхгүй гэдгээ би танд хэлье” хэмээж болох юм.

Тэгвэл энэ залбирал ямар хариу авсан бэ? Ямар ч хариу аваагүй. Тэнгэрээс ямар ч чимээ гараагүй. Тэгэхээр ял буруутай нүгэлтнүүдийг зөвтгөж аврахын тулд нүгэлгүй Аврагч Христ биднийг төлөөлөн үхэхээс өөр зам байхгүй гэдгийг бид эндээс ойлгож чадна.

**[26:40, 41]** Есүс шавь нар дээрээ буцаад иртэл тэд унтаж байв. Тэдний **сүнс хүсэж** байсан ч **махбод нь сул дорой** байв. Бид өөрсдөө хэрхэн залбирдгаа харвал тэднийг шүүмжилж зүрхлэхгүй. Бид залбирахаасаа унтахыг илүү сайн хийдэг. Сонор соргог байх ёстой оюун бодол маань хаа сайгүй тэнэж явдаг. Эзэн Есүст Петрт хандан **“Та нар Надтай хамт ганцхан цаг ч сэргэж байж чадахгүй юу? Соригдохгүйн тулд сэргэг бай, залбир”** гэсэн үгээ бидэнд хэчнээн ч олон хэлдэг билээ дээ.

**[26:42]** Тэр дахин хоёр дахь удаагаа явж залбиран, Эцэгийн хүсэлд захирагдах болно гэдгээ хэлэв. Тэрээр зовлон ба үхлийн аяганаас шавхруу ч үлдээхгүй уух болно.

Есүс ганцаараа залбирахаас өөр аргагүй байсан. Тэрээр шавь нартаа хэрхэн залбирахыг зааж, тэдний нүдэн дээр залбирч байсан ч хэзээ ч тэдэнтэй хамт залбирч байгаагүй юм. Түүний мөн чанар хийгээд хийх ёстой ажлын онцлогоос

болоод Тэр залбирлын амьдралаа хэнтэй ч хуваалцаагүй билээ.

[26:43-45] Тэр шавь нар дээр хоёр дахиа эргэж ирэхэд шавь нь бас л унтаж байв. Гурав дахь удаад мөн л адил. Есүс залбирсан, шавь нар унтаж байсан. Харин гурав дахь удаагаа залбирч ирснийхээ дараа Тэр шавь нартаа **“Та нар одоо хүртэл унтаж амарсаар байна уу? Харагтун, цаг ойртчихлоо. Хүний Хүү нүгэлтнүүдийн гарт орж байна”** гэв.

[26:46] Эзэн Есүсийн залбиралтай хамт сонор соргог байх боломж өнгөрөн одлоо. Нөхрөө худалдсан хүний алхаа ч ойрхон иржээ. Есүс тэдэнд **“Бос, явцгаав”** гэв. Тэндээс холдох гэж биш, харин дайсантайгаа нүүр тулахаар тэр явав.

Гетсемани цэцэрлэгээс гарахын өмнө түр зогсоод энэ цэцэрлэгт Эзэн Есүсийн хэлсэн үгсийг сонсож, шаналлыг нь тунгаан бодоод, бүх зүрхээрээ Түүнд талархацгаая.

### **Ж. Иудас Есүсийг Гетсемани цэцэрлэгт барьж өгсөн нь (26:47-56)**

Бүтээлүүдийнх нь нэг нь ямар ч нүгэлгүй Аврагч Бурханаасаа урван барьж өгч байгаа энэ явдал түүхийн хамгийн хирдхийм хэрэг мөн. Хүмүүний нүгэлт чанарыг мэдэхгүй бол, яагаад ч өмөөрөх аргагүй Иудасын урвалтын суурь шалтгааныг тайлбарлаж чадахгүй байхсан.

[26:47] Есүс арван нэгэн шавьтайгаа **ярьж байх зуур Иудас илд шийдэмтэй бөөн хүмүүсийг дагуулан хүрч ирэв.** Зэвсэг агсахыг

Иудас санаачлаагүй нь мэдээж. Аврагч Эзэн маань бусадтай сөргөөцөлдөж, өөдөөс нь тэмцэлдэж байхыг Иудас огтхон ч харж байгаагүй юм. Ахлах тахилчид ба ахлагчид Есүст ямар ч зугтах боломж өгөхгүйгээр барьж авахаар хатуу шийдсэнийг энэхүү зэвсэглэсэн хүмүүсээс харж болох байх.

**[26:48]** Есүсийг барихаар ирсэн хүмүүст Есүсийг шавь нараас нь ялгаж өгөхийн тулд Иудас үнсэлтээр дохио өгөх байлаа. Хайрыг илэрхийлдэг бүх дэлхийн бэлгэдлийг энд хамгийн адгийн хэлбэрээр ашиглажээ.

**[26:49]** Иудас Эзэн Есүст ойртон очоод, “Амар байна уу, Рабби?” гээд **Түүнийг** нэлээн хэд **үнсэв**. Энэ хэсэг грек дээрээ үнсэх гэдэг хоёр өөр үгийг ашигласан. Эхлээд 48 дугаар хэсэгт болохоор үнсэх гэдэг жирийн үг байдаг. Харин 49 дүгээр эшлэлд, олон удаа үнсэх, үнсэж байгаагаа харуулах гэсэн утга илэрхийлсэн үг ашигласан.

**[26:50]** **Есүс** тайван уужуу хандлагаар, бурууг нь мэдрүүлэн, “**Анд минь, чи яах гэж ирэв?**” гэж асуулаа. Энэ асуулт Иудасын сэтгэлд хүчтэй хүрсэн нь маргаангүй боловч үйл явдал яах ийхийн зуургүй болж өнгөрөв. Иудастай хамт ирсэн хүмүүс Эзэн Есүсийг тэр даруй бүчин аваад баривчилжээ.

**[26:51]** Тэгэхэд шавь нарын нэг нь **илдээ сугалаад тэргүүн тахилчийн зарцын чихийг тас цавчжээ**. Энэ шавь бол Петр гэдгийг Иохан 18:10 дээр тэмдэглэсэн байна. Петр чихийг нь л

огтолсон болохоос үнэндээ амийг нь хөнөөх гэж санасан нь тодорхой. Ийн харгис авирлах нь Бурханы хүсэл хэмээн ташаа дүгнэсэн шиг, хүн алья гэсэн бодол нь ч хөөрхийлөлтэй арга хэмжээ байлаа.

[26:52] Харин энд Эзэн Есүсийн сайхан сэтгэлийн яруу алдар туяаран гийж байна. Эхлээд тэр Петрийг зэмлээд, **“Илдээ хуйнд нь хий. Илд агсагч бүхэн нь илдээр хөнөөгдөнө”** гэв. Христийн хаанчлалд ялалтыг махбодын аргаар олж авдаггүй. Сүнслэг тулаанд цэрэг арми ашиглавал гамшиг авчирсантай адил. Хаанчлалын дайснууд илд мэсээ хэрэглэж л байг. Эцэстээ тэд нухчин дарагдах нь үнэн. Харин Христийн цэргүүд бид залбирал, Бурханы үг, Сүнсээр дүүрэн амьдралын хүчийг ашиглацгаая.

Тэгээд дараа нь Есүс шархадсан хүнийг эдгээж өгсөн. Үүнийг бид эмч Лукийн сайнмэдээнээс мэдэж болно (Лук 22:51). Петрт чихээ тастуулж, Эзэн Есүсээр эдгээлгэсэн хүнийг нэрийг Малх гэдэг байв (Иохан 18:10). Энэ нь гайхамшигт нигүүлслийн дүр зураг биш гэж үү? Тэрээр өөрт нь хорсогчдыг хайрлаж, амийг нь хөнөөхөөр ирсэн хүмүүст энэрэл хайр харуулжээ.

[26:53, 54] Есүс тэр хүмүүсийг эсэргүүцэхийг хүссэн бол Петрийн барьсан нэг муу жижиг илдээр хязгаарлагдахгүй шүү дээ! Хүсэх л юм бол Тэр **арван хоёр легионоос** (36-72 мянган цэрэг) **олон тэнгэрэлчийг** дуудаж чадна. Тэгэхийн бол Бурханы төлөвлөгөөнд саад болохоос хэтрэхгүй. Христ анд нөхрөөсөө



урвалтыг амсаж, зовлон эдэлж, цовдлогдож, үхлээс амилахыг зөгнөсөн **бичвэрүүд биелэх ёстой.**

[26:55] Тэгээд Есүс, өөрийг нь барихаар илд мэс агсан ирж байгаа нь хачирхалтай байгааг барих гэж ирсэн хүмүүст хэлэв. Есүс хүчирхийлэл үйлдэж байхыг тэд хараагүй. Эсвэл юмыг нууцаар хийж байсан удаагүй. Харин ч тэрээр **өдөр бүр сүмд ирж сургаал заадаг** төлөв даруу Багш байсан. Тэр үед нь хялбархан барьж болох л байсан. Гэвч тэд тэгээгүй. Тэгтэл одоо юунд **илд, шийдэмтэй** ирнэ вэ? Хүний талаас бодсон ч гэсэн тэдний энэ үйлдэл ямар ч утгагүй зүйл байв.

[26:56] Гэсэн ч хүний хорон муу нь Бурханы төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс хэтрэхгүй гэдгийг Аврагч Эзэн маань мэдэж байв. **“Энэ бүхэн нь эш үзүүлэгчдийн бичвэрүүд биелэгдэхийн тулд болов.”** Багш нь аврагдах ямар ч найдваргүй болсныг ойлгосон **шавь нар бүгдээрээ Түүнийг орхин,** айн балмагдаж **зугтав.** Тэдний айн хулчийсныг зөвтгөх шалтгаан үгүй юм бол биднийхийг зөвтгөх шалтгаан бүр ч олдохгүй. Тэдний дотор Ариун Сүнс хараахан оршин суугаагүй байсан бол бидний дотор Ариун Сүнс нэгэнт оршин сууж байна.

### **3. Есүс Каиафын өмнө (26:57-68)**

[26:57] Эзэн Есүс хоёр газар шүүгдсэн байна. Нэг нь Иудейн удирдагчдын өмнө шүүгдсэн

шашны шүүх. Нөгөө нь Ромын эрх баригчдын өмнө шүүгдсэн иргэний шүүх. Дөрвөн сайнмэдээнд тэмдэглэснийг нэгтгэн үзвэл энэ хоёр шүүлт тус бүрдээ гурван үе шаттай байжээ. Иудейчүүдийн явуулсан шүүлтийн талаар тэмдэглэсэн Иоханы тэмдэглэлээс харахад, Есүсийг эхлээд Каиафын хадам эцэг Аннасын өмнө авчирчээ. Харин Матайн сайнмэдээ нь энэ шүүлтийн хоёр дахь үе шатнаас эхлэн тэмдэглэсэн байна. Энэ үед Есүсийг **тэргүүн тахилч Каиафын** гэрт авчрав. Тэнд иудейчүүдийн зөвлөл **цугласан байлаа**. Ердийн үед бол өөрийгөө өмгөөлөхөд нь бэлдүүлэх үүднээс буруутгагдаж байгаа хүнд тодорхой хугацаа өгдөг. Гэвч шашны удирдагчид Есүсийг аль болох түргэхэн шиг цаазлахыг хүсэн, огт хорилгүйгээр, хууль бус аргаар шүүлт явуулж (Исаиа 53:8), Түүнийг яллажээ.

Иудейчүүдийн зөвлөлийг бүрдүүлдэг фарисайчууд, садукайчууд, **хуулийн багш нар, ахлагчид** тэр шөнө өөрсдийн дагаж мөрдөх ёстой хууль дүрмээ хэрхэн уландаа гишгэдэг болохоо тодорхой харуулав. Тэд шөнө дөлөөр болон иудейчүүдийн аль нэг баяраар цуглах ёсгүй, хуурамч гэрч бий болгохын тулд хахууль өгөх ёсгүй, цаазлах тогтоолыг шөнө өнгөртөл гүйцэтгэж болохгүй байсан. Түүнээс гадна, сүмийн дотор байсан зөвлөлийн хурлын танхимд гаргаагүй шийдвэр нь хүчин төгөлдөрт тооцогддоггүй байсан. Иудейн удирдагчид Есүсээс салж ангижрахыг туйлаас их хүсэж

байсан учир хууль дүрмээ зөрчихийг ч юман чинээ бодсонгүй.

**[26:58]** Энэ шүүх хуралд Каиаф тэргүүн шүүгчээр ажиллаж, зөвлөл болохоор шүүх бүрэлдэхүүн ба яллагчийн үүргийг давхар гүйцэтгэж (уг нь энэ хоёр үүргийг нэг этгээд гүйцэтгэдэггүй), Есүс яллагдагч болж, **Петр** харин аюулгүй алс зайнаас хөндлөнгийн ажиглагчаар оролцов. **Петр юу болохыг** ажиглан **харж**, харуулуудтай **хамт сууж байв**.

**[26:59-61]** Иудейчүүдийн удирдагчид **Есүсийн эсрэг худал гэрч** олох гэж нэлээн зүдрэв. Хэрэв тэд шүүх үйл ажиллагааг журам ёсоор нь явуулж, Есүсийн гэмгүй гэдгийг нотлох нотолгоо хайсан бол илүү амжилттай болох байв. Харин эцэст нь хоёр хуурамч гэрч гарч ирээд “Энэ сүмийг устга. Би үүнийг гурван өдрийн дотор босгоно” (Иохан 2:19-21) гэсэн үгийг нь буруу ойлгосноороо найруулан ярив. Тэр хоёр гэрч, Есүсийг “Иерусалим хотын **сүмийг устгаад гурав хоногийн дотор дахин барьж чадна**” гэж хэлсэн хэмээн гүтгэв. Үнэн хэрэгтээ Есүс Өөрийнхөө үхэл ба амиллыг зөгнөн хэлсэн ажээ. Харин иудейчүүд энэ үгийг нь ашиглан түүнийг буруутгаж, Түүнийг алах шалтаг гаргаж ирэв.

**[26:62-63]** Өөрийг нь ийнхүү буруутгаж байхад Эзэн Есүс юу ч ярьсангүй. Тэрээр “хяргагчийн өмнө эс дуугарах хонь шиг амаа нээсэнгүй” (Исаиа 53:7). Тэргүүн тахилч Есүсийн дуугүй байдалд уурлаж, юм хэлүүлэх

гэж Түүнийг хүчлэв. Тэгсэн ч гэсэн Аврагч Эзэн маань юм хэлсэнгүй. Тэгэхээр нь тэргүүн тахилч түүнд, **“Чамайг амьд Бурханаар тангараглуулъя. Чи Бурханы Хүү, Христ мөн үү? Бидэнд хэлээч”** гэлээ. Тэргүүн тахилч тангараглуулсан цагт гэрчлэх ёстой гэдгийг Мосегийн хууль иудей хүнээс шаарддаг (Леви 5:1).

[26:64] Хуулийг дуулгавартай дагадаг иудей хүнийхээ хувьд Есүс тэргүүн тахилчид хариулан, **“Та ч өөрөө хэллээ”** гэв. Тэгээд Өөрийгөө Мессиа ба Бурхан гэдгийг бүр тодорхой мэдэгдэж, **“Харин Би танд хэлье. Та нар үүнээс хойш Хүчит Нэгэний баруун талд залрах Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр залран ирэхийг харах болно”** гэж айлдав. Есүс юу гэж хэлж байна вэ гэвэл: “Таны хэлсэн шиг, Би бол Бурханы Хүү, Христ мөн. Миний цог жавхлан одоохондоо хүний биеэр халхлагдсан байна. Хожим Би өөр дүрээр ирэх болно. Та одоо Миний дорд байх үеийг минь харж байна. Гэхдээ иудейчүүд та нар Намайг Бурхантай эн тэнцүү байр сууринд, Түүний баруун гар талд залраад, тэнгэрийн үүлс хөлөглөн, сүр жавхлантай ирэхийг харах болно.”

Энэхүү 64 дүгээр эшлэлийн эхэнд нь “та” гэж Каиафыг хэлж байна. Дараа нь “та нар” гэж иудейчүүдийг хэлсэн. Христ сүр жавхлантайгаар үзэгдэх үеийн Израильчуудыг тэднээр төлөөлүүлсэн. Есүс үнэхээр Бурханы Хүү мөн болохыг тэд тодорхой харах болно.

“Есүс өөрийгөө ‘Бурханы Хүү’ гэж нэрлэж байгаагүй хэмээн маргадаг хүмүүс бий. Гэтэл тэргүүн тахилч Есүсийг тангараглуулаад асуухад мөн гэдгээ энд (64-р эшлэлд) тодорхой хэлсэн байна шүү дээ”<sup>51</sup> гэж Ленски бичсэн байдаг.

[26:65-67] Каиаф Есүсийн хэлсэн үгийг маш сайн ойлгожээ. Есүс Мессиагийн тухай хэлсэн Даниелын зөгнөлийг иш татсан юм. Үүнд: “Би шөнийн үзэгдлийг харсаар байв. Харагтун, Хүний Хүү шиг Нэгэн тэнгэрийн үүлсийг хөлөглөн ирж, эртний Нэгэн дээр очоод Түүнд бараалхав” (Даниел 7:13). Есүс өөрийгөө Бурхантай эн тэнцүү хэмжээнд тавьсныг тэргүүн тахилч ойлгожээ (Иохан 5:18-ыг үз). Түүний үйлдлээс үүнийг харж болно. Бурханыг доромжилсонд хилэгнэж буйгаа илэрхийлж, тэрээр тахилчийн хувцсаа **ураад** Есүсийг буруутай гэж үзэж буйгаа зөвлөлд хэлэв. Тэгээд тэдний шийдвэрийг асуухад зөвлөл **“Тэр үхэх ёстой”** гэгцгээлээ.

[26:68] Шүүх бүрэлдэхүүн Есүсийг цохиж, алгадаж, нулимаад **“Христийнхээ** хүчийг ашиглан хэн цохисныг хэлээч” хэмээн доромжилсноор шүүх ажиллагааны хоёр дахь үе шат өндөрлөв. Үнэндээ үүнийг шүүх ажиллагаа гэж хэлэхийн ямар ч аргагүй юм.

## **И. Петр Есүсийг үгүйсгээд гашуунаар уйлсан нь (26:69-75)**

[26:69-72] Петрийн амьдралын хамгийн хар үе энд тохионо. Түүнийг **гадаа хашаан дотор сууж байтал** залуухан эмэгтэй дэргэд нь ирээд, Есүстэй хамт байсан хэмээн буруутгав. Петр түүний үгийг тэр даруй эрс үгүйсгэн, **“Чиний юу ярьж байгааг би ойлгохгүй байна”** гэв. Тэгээд дахиад хүний хараанд өртөхгүйн тулд **хашааны хаалга хавьд** ирээд зогсож байтал **өөр** нэг эмэгтэй **“Энэ хүн Назарын Есүстэй хамт байсан”** хэмээн олны дунд хэлэв. Тэгэхэд Петр тангараг тавин байж, **“Энэ хүнийг танихгүй”** гэв. **“Энэ хүн”** гэдэг нь түүний Эзэн байлаа.

[26:73, 74] Удалгүй тэнд зогсож байсан хүмүүс ирээд **“Чи тэдний нэг гарцаагүй мөн. Ярианаас чинь л илт байна”** гэлээ. Зүгээр нэг үгүйсгэх нь хангалтгүй байсан болохоор Петр энэ удаа хараал зүхэл хэлж, тангараглаад **“Би энэ хүнийг танихгүй”** гэлээ. Яг тэр үед **тахиа донгодов.**

[26:75] Энэ танил чимээ үүрийн аниргүйг цочоохдоо Петрийн сэтгэлийг зүсэх нь тэр. Өөртөө итгэл алдарсан тэрээр Эзэний хэлснийг санаад гадагшаа **гарч яван гашуунаар уйлав.**

Петрийн үгүйсгэсэн тоо ба цагийн тал дээр сайнмэдээний номууд хоорондоо зөрчилдөж байгаа мэт харагддаг. Матай, Лук, Иоханы сайнмэдээн дээр Есүсийг “Азарган тахиа донгодохоос өмнө чи намайг гурван удаа үгүйсгэнэ” гэж хэлснээр тэмдэглэсэн (Матай

26:34, Лук 22:34, Иохан 13:38). Харин Маркийн сайнмэдээнд, “Азарган тахиа хоёр удаа донгодохоос өмнө чи намайг гурван удаа үгүйсгэнэ” гэсэн байна (Марк 14:30).

Магадгүй нэгээс олон тахиа донгодсон байж болно. Нэг нь шөнөөр, нөгөө нь үүрээр. Аль эсвэл, сайнмэдээнд Петрийн зургаан өөр үгүйсгэлийг тэмдэглэсэн байх магадлалтай. Үүнд: (1) залуу эмэгтэйн өмнө (Матай 26:69, 70; Марк 14:66-68); (2) өөр нэг залуу эмэгтэйн өмнө (Матай 26:71, 72; Марк 14:69,70); (3) ойролцоо зогсож байсан хүмүүсийн өмнө (Матай 26:73, 74; Марк 14:70,71); (4) нэг эрэгтэй хүний өмнө (Лук 22:58); (5) өөр нэг эрэгтэй хүний өмнө (Лук 22:59, 60); (6) тэргүүн тахилчийн зарцын өмнө (Иохан 18:26, 27). Бид сүүлийн энэ хүнийг бусдаасаа өөр хүн гэж үздэг. Яагаад гэвэл тэрээр “Түүнтэй хамт цэцэрлэгт байхыг чинь би хараагүй бил үү?” гэж хэлсэн. Бусад хүнийг тэгж хэлсэн тухай тэмдэглээгүй.

#### **К. Өглөө зөвлөлийн өмнө шүүгдсэн нь (27:1, 2)**

Шашны шүүх ажиллагааны гурав дахь үе шат **өглөө эрт** зөвлөлийн өмнө болов. Яллагдагч буруугүй нь тогтоогдоогүй л бол эхэлсэн өдрөө хаагддаг хэрэг нэг ч байдаггүй. Шийдвэрийг шөнө өнгөрсний дараа гаргах ёстой байсан. Тэгвэл “тодорхой хугацаа өнгөрч, өршөөл үзүүлэх сэтгэл төрж магадгүй” гэж үздэг. Гэвч энэ удаа бол шашны удирдагчид өчүүхэн төдий ч өршөөх сэтгэл төрөхийг хүсээгүй нь тодорхой

байна. Гэхдээ ер нь шөнөөр шүүх ажиллагаа хийдэггүй учраас өөрсдийн шийдвэрийг хууль ёсны болгохын тулд тэд өглөө эрт дахин нэг хурал явуулав.

Иудейчүүд Ромын захиргаан доор байсан учраас цаазын ял гүйцэтгэх эрхгүй байлаа. Тиймээс тэд Есүсийг Ромын **захирагч Понти Пилатад** хүргэхээр яарав. Тэд ромчуудыг маш их үзэн яддаг ч Есүсийг түүнээс илүү үзэн яддаг байсан болохоор Ромын эрх мэдлийг ашиглаж түүнийг хөнөөлгөхөөс цааргалсангүй. Есүсийг эсэргүүцсэн эсэргүүцэл эвлэршгүй дайснуудыг нэгтгэжээ.

#### **Л. Иудас хийсэн үйлдэлдээ харамсаж, амиа хорлов (27:3-10)**

[27:3, 4] **Иудас гэмгүй цуснаас урвасан нүглээ ойлгож, авсан мөнгөө ахлах тахилчид болоод ахлагчдад буцааж өгөв.** Хуйвалдааны мастерууд болсон энэ хүмүүс хэдхэн цагийн өмнө Иудастай дуртайяа хамтран ажиллаж байсан бол одоо түүнээс нүүр буруулж, цаашид түүнтэй орооцолдохыг хүссэнгүй. Итгэл эвдэгчийн авдаг шан энэ билээ. **Иудас харууссан.** Гэхдээ энэ нь авралд хүргэдэг бурханлаг гэмшил байгаагүй юм. Иудас хийсэн хэргийнхээ үр дүнг хараад харамссан ч гэлээ Есүс Христийг Эзэн ба Аврагч гэж хүлээн зөвшөөрөөгүй байна.

[27:5] Цөхөрч найдвар тасарсан Иудас **мөнгөн зооснуудыг ариун газарт** (зөвхөн тахилчид орох эрхтэй газар) **чулууудаад, явж**



амиа хорлов. Иудас өөрийгөө модноос дүүжилсэнд олс нь тасарсан юм уу мөчир нь хугарснаас болоод унахдаа хэвлийгээ ярж, гэдэс дотроо цувуулсан байна. Үүнийг Үйлс 1:18-аас үзэж болно.

**[27:6] Ахлах тахилчид тэр мөнгийг сүмийн эрдэнэсийн сан хөмрөгт хийхгүй хэмээн “сүнслэг” дүр эсгэцгээв.** Тэр мөнгө бол Мессиаг барьж авахад төлсөн, **цусны үнэ** учраас тэд ийн шийджээ. Хүний амийг хөнөөчхөөд тэд юман чинээ бодсонгүй. Аяга тавгийнхаа гадна талыг цэвэрлэдэг ч дотроо заль мэх, худал хуурмаг, аллагаар дүүрэн гэсэн Эзэний маань үг үнэн ажээ.

**[27:7-10]** Тэгээд тэд тэр мөнгөөр ваарчны талбайг худалдан авч, харийн хүмүүсийг оршуулдаг газар болгов. Газар нутгийг нь олон олон харийнхан эзэлж, гудамжнуудад нь цус асгаруулахыг тэд тухайн үедээ яахин мэдэх билээ. Тэр цагаас хойш уг талбай нь нүгэлт Израиль үндэстэнд зориулагдсан **цуст талбай** болов.

Ахлах тахилчид өөрсдөө ч мэдэлгүй Зехариагийн эш үзүүлэгийг биелүүлжээ. Оршуулгын мөнгөөр ваарчнаас юм худалдаж авна (Зехариа 11:12, 13) гэж Зехариа эш үзүүлсэн байна. Зехариагийн энэ хэсэг хоёр өөр уншлагатай нь нэн сонин. Нэг уншлага нь “ваарчин” гэсэн байхад, нөгөөд нь “ваарчин” гэдгийн оронд “сан хөмрөг” гэсэн үг бий (RSV орчуулгыг үз).

Ахлах тахилчид цусны үнэд төлсөн мөнгийг сүмийн сан хөмрөгт хийх нь зүй бус гэж үзээд энэ мөнгийг ваарчинд өгч, оронд талбайг нь худалдан авснаараа нөгөө уншлагынх нь эш үзүүллэгийг биелүүлсэн байна. (Бичвэрийн Холбооноос гаргадаг Өдөр Бүрийн Сургамж ном).

Матай энэ эш үзүүллэгийг Иеремиад хамаатуулсан. Гэхдээ энэ эш үзүүллэгийг яалт ч үгүй Зехариагийн номоос иш татсан байна. Эрт цагт эш үзүүлэгчдийн бичвэрийг агуулсан хуйлмалуудын хамгийн эхэнд Иеремиа ном ордог байсан бололтой. Эртний зарим гар бичмэл ба Талмудын уламжлалаас үүнийг харж болно. Тийм учраас эш үзүүллэгийн бичвэрүүдийг нийтэд нь толгой номынх нь нэрээр Иеремиа гэж нэрлэдэг байсан байж болно. Энэ зарчим Лук 24:44 дээр тодорхой харагддаг. Энд еврей каноны гурав дахь хэсгийг нийтэд нь Дуулал номоор нэрлэжээ.

### **М. Есүс эхний удаа Пилатын өмнө (27:11-14)**

Иудейчүүд Есүсийг шашны шалтгаанаас болж үзэн ядсан бөгөөд түүндээ үндэслэж буруутган ялласан. Гэхдээ шашны шалтгаанаар оноосон ялыг Ромын шүүх авч хэлэлцэхгүй гэдгийг тэд мэдэж байлаа. Тийм учраас Есүсийг Пилатын өмнө аваачихдаа тэд яллаж болох улс төрийн гурван шалтгаан дурджээ (Лук 23:2). Үүнд: (1) Ромын эзэнт гүрэнд аюул учруулж

мэдэх бослого өдөөсөн; (2) Хүмүүсийг улсад татвар бүү төл гэсэн. Тийм учраас Ромын эзэнт гүрний хөгжилд саад учруулсан; (3) Өөрийгөө хаан гэж зарлаж, Ромын эзэн хааны эрх мэдэл, байр сууринд заналхийлсэн.

Пилат Есүсийг гурав дахь шалтгаанаар нь байцаасныг Матайн сайнмэдээнээс бид уншдаг. “**Та иудейчүүдийн Хаан мөн юм уу?**” гэж асуухад нь мөн гэж Есүс хариулав. Үүнээс болж иудейн удирдагчид Есүсийг харааж зүхэн, гүтгэн доромжиллоо. Яллагдагч чимээгүй байсанд Пилат **ихэд гайхжээ**. Есүс өөрийнх нь эсрэг буруутгалуудад хариулж, өөрийгөө аврах гэж огтхон ч хичээсэнгүй. Ингэж их дайрч давшлуулчхаад чив чимээгүй байсан хүнийг захирагч Пилат өмнө нь огт харж байгаагүй биз ээ.

## **Н. Есүс, Бараб хоёрын алийг сонгох вэ? (27:15-26)**

[27:15-18] Ромын эрх баригчид алгасал баяраар нэг иудей **хоригдлыг суллаж**, иудейчүүдийн уур бухимдлыг намжаадаг уламжлал тогтсон байв. Энэ удаа **Бараб** гэдэг хүн суллагдахаар нэр цоходсон байлаа. Бараб нь бослого гаргаж, хүн алсан хэргээр буруутгагджээ (Марк 15:7). Ромын эсрэг бослого тэмцэл гаргаснаараа тэр иудейчүүдийнхээ дунд танигдсан байв. **Есүс, Бараб** хоёрын аль нэгийг сонго гэхэд ард олон Барабыг сонгов. Захирагч Пилат үүнд гайхсангүй. Учир нь Есүст хорссон

ахлах тахилчид ард олны санаа бодолд нөлөөлсөн гэдгийг тэр мэдэж байсан юм.

**[27:19]** Яг тэр үед Пилатын **эхнэрээс** элч ирж, шүүх ажиллагааг тасалдуулав. Есүсийн асуудалд гар дүрэхгүй байхыг нөхөртөө тэр сануулсан байлаа. Учир нь тэр эмэгтэй **урьд шөнө** нь **Түүнээс болж ихэд** зовуурьтай зүүд зүүдэлжээ.

**[27:20-23]** **Барабыг чөлөөлж, Есүсийг хөнөөлгөхөөр ахлах тахилчид болоод ахлагчид** хүмүүсийг өдөөн турхирчээ. Тийм учраас, хэнийг нь суллуулмаар байна гэж Пилатыг дахин асуухад тэд алуурчныг сулла хэмээн хашхирцаав. Шийдмэг бус байдлынхаа торонд орооцолдсон Пилат тэднээс “Тэгвэл Христ гэгдэх Есүсийг би яасан дээр вэ?” гэж асуухад тэд нэгэн дуугаар цовдлохыг шаардав. Захирагч Пилат үүнийг ердөө ч ойлгосонгүй. Түүнийг яагаад цовдолно гэж? Тэр ямар буруу юм хийсэн юм бэ? Гэвч улангассан олныг намжаахаасаа нэгэнт оройгжээ. Үймж шуугьсан хүмүүс хэрээс хэтрэв. **“Түүнийг цовдол”** гэсэн дуу хадаж байлаа.

**[27:24]** Хэрэв ямар нэг арга хэмжээ авахгүй л бол хүмүүсийг зогсоон барих аргагүй болж, үймээн самуун дэгдэх гэж буйг Пилат ойлгов. Тиймээс тэр шаагьсан олны нүдэн дээр **гараа угааж**, Есүсийн гэмгүй **цусанд** ямар ч буруугүй гэдгээ тунхаглав. Гэхдээ шударга ёсыг уландаа гишгэсэн Пилатын буруу усаар угаагдах зүйл биш л дээ.

[27:25] Хурсан олон дэндүү сэтгэлийн хөөрөлтэй байсан учраас гэмгүй хүний цусны бурууг үүрэх тухайгаа бодох сөхөөгүй байсан болохоор, **“Түүний цус бидний болон бидний үр хүүхдүүдийн дээр байг”** гэгцгээв. Тэр цагаас хойш Израилийн ард түмэн гологдсон Мессиагийн цусны бурууг үүрч, түүхийнхээ турш хавчин гадуурхал, хоморголон устгал, хорих лагерь, хорт хийтэй өрөө гээд түмэн янзын зовлон амсаж иржээ. Тэднийг дахиад нэг аймшиг зовлон хүлээж байна. Тэр бол Иаковын зовлонгийн гамшиг гэж нэрлэгдсэн долоон жилийн үе юм. Энэ үеийг Матай 24 дүгээр бүлэг ба Илчлэл 6-19 дүгээр бүлэгт тодорхой дүрсэлсэн байна. Тэд Есүсийг Мессиа Хаан хэмээн хүлээн зөвшөөрөх хүртэл энэ хараалаас ангижрахгүй.

[27:26] Пилат Барабыг ард олонд суллан өгөв. Одоо ч гэсэн энэ сүнс дэлхийг ноёлж байна. Хүн төрөлхтөн алуурчныг хаан мэт өргөмжилж, зөвт Хааныг үгүйсгэж байна. Тэгээд заншил ёсоор Есүсийг ташуурджээ. Үзүүрт нь хурц төмөр хэлтэрхий тогтоосон урт суран ташуур байв. Ийм эдээр нуруун дундуур ороолгоход махыг өм татаж, асар их цус алдуулдаг. Одоо ингээд шийрэгнүүр захирагчийн хийх ажил үлдсэнгүй. Тэрээр Есүсийг цовдлох ажлыг цэргүүддээ даатгаад явав.

## **О. Цэргүүд Есүсийг доромжилсон нь (27:27-31)**

**[27:27, 28]** Тэгэхэд захирагч Пилатын цэргүүд Есүсийг ордон уруу нь авчирч, Ромын бүтэн нэг ангийг цуглуулж, Түүнийг тойруулав. Тухайн үед нэг ангид хэдэн зуун цэрэг байсан бололтой. Үүний дараа төсөөлөхөд ч бэрх үйл явдал болсон. Хэрцгий балмад цэргүүд Эзэн Есүсийг доромжлов. Орчлон ертөнцийн Бүтээгч ба Тэтгэгчийг Өөрийнх нүгэлт бүтээлүүд үгээр илэрхийлшгүй муухайгаар гутаажээ. Тэд Түүнийг нүцгэлэн хааны хувцастай адил **час улаан нөмрөг нөмөргөв**. Энэ нөмрөгөөс бид нэгийг ойлгож болно. Час улаан өнгө нь нүглийг илэрхийлдэг (Исаиа1:18) учраас Есүс миний нүглийг өмссөн хэмээн эндээс би бодох дуртай. Одоо би Бурханы зөвт байдлын хувцсыг өмсөх боломжтой болсон (2Коринт 5:21).

**[27:29, 30]** Тэр цэргүүд үүргэнээр титэм сүлжээд толгойд нь хүчээр углав. Энэ балмад үйлдлээс ч гэсэн авах сургамж бидэнд бий. Бидэнд алдрын титэм зүүлгэхийн тулд Есүс Өөрөө өргөст титэм зүүсэн билээ. Тэд Түүнийг нүгэлт Хаан мэт доромжилсон. Харин бид Түүнийг нүгэлтнүүдийн Аврагч хэмээн хүндэлж, Түүнд мөргөх болно.

Тэд бас Түүнд хулс атгуулав. Тэд үүгээр эрх мэдлийн таягийг дооглон тохуурхав. Тэр хулсыг атгаж байсан гар ертөнцийн захиргааг атгах гар гэдгийг тэд мэдэхгүй байлаа. Хадаас шаалгасан

Есүсийн гар одоо орчлон ертөнцийг захирах таягийг атгаж байна.

Тэд түүний өмнө мэхийж, иудейчүүдийн Хаан хэмээн дооглон мэндчилж байв. Тэд хорвоогийн цорын ганц төгс Хүний нүүр уруу **нулимж** байгаагаа ч мэдсэнгүй. Тэгээд тэд **хулсыг нь авч, түүгээр толгой уруу нь цохив.**

Есүс энэ бүхнийг зүгээр л тэвчин өнгөрөөв. Тэр юу ч хэлсэнгүй. “Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Түүнийг санагтун. Тэрээр Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн билээ” (Еврей 12:3).

**[27:31]** Эцэст нь тэд **Өөрийнх нь хувцсыг** буцааж өмсүүлээд цовдлохоор авч явав.

### **Ө. Хааныг цовдолсон нь (27:32-44)**

**[27:32]** Бидний Эзэн замынхаа тал хүртэл загалмайгаа үүрчээ (Иохан19:17). Замын талд ирээд цэргүүд **Курений** (хойд Африкийнх) **Симон** гэдэг хүнийг албадаж, **Есүсийн загалмайг үүрүүлэв.** Зарим хүн түүнийг иудей хүн байсан гэж үздэг бол, зарим нь харин хар арьстан байсан гэж үздэг. Гэхдээ тэр хүний угсаа гарлаас илүү чухал зүйл бол Эзэний загалмайг үүрэх гайхамшигтай хувь завшаан түүнд оногджээ.

**[27:33]** **Голгота** гэдэг нь арамей хэлээр “гавал” гэсэн утгатай. Калвари (Calvary) гэж *кранион* гэдэг грек үгийн латин орчуулгын англи галиг юм. Тэр газар гавал шиг хэлбэртэй байсан, эсвэл тэнд цаазын ял гүйцэтгэдэг байсан

болохоор ийн нэрлэжээ. Өнөөдөр энэ газрын байршил тодорхойгүй байна.

[27:34] Есүсийн гар хөлийг хадахаасаа өмнө цэргүүд Түүнд цөстэй хольсон дарс уулгах гэв. Өвчин намдаах зорилгоор үүнийг гэмт хэрэгтнүүдэд өгдөг байв. Гэвч Есүс үүнийг уусангүй. Тэрээр хүн төрөлхтний нүглийн бүх ачааг үүрэх ёстой байсан учраас өвдөлтөө намдаах хэрэг байсангүй.

[27:35] Матай загалмайн хэргийг ямар ч сэтгэл хөдлөл оруулалгүй, энгийнээр дүрсэлжээ. Ямар нэг чимэг хачир нэмж, хэрэгтэй хэрэггүй юм нуршилгүй, “Тэд Түүнийг цовдлов” гэж болсон явдлыг тодорхой бичжээ. Гэсэн ч энэ үгсийн гүнийг мөнх цаг ч шавхаж барахгүй.

Дараа нь цэргүүд **хувцсыг нь хувааж аваад**, зүйдэлгүй дээлийг нь хэн авахаа үзэж **шодоцгоов**. Дуулал 22:18 дээр эш үзүүлсний дагуу ийм явдал болжээ. Түүнд байсан эд хөрөнгө гэвэл ердөө энэ хэдэн хувцас байлаа. Дэнни энэ тухайд: “Энэ ертөнцөд амьдарсан цорын ганц төгс хүн амьдрах хугацаандаа ямар ч эд хөрөнгөгүй байсан бөгөөд өмсөж явсан хувцаснаасаа өөр юу ч үлдээгээгүй билээ” гэж хэлжээ.

[27:36] Тэр цэргүүд бол өчүүхэн хүмүүсийн ертөнцийн төлөөл билээ. Түүхийн алтан агшныг тэд огтхон ч мэдэлгүй хажуугаар нь өнгөрчээ. Хэрэв тэд мэдсэн бол тэндээ Түүнийг зүгээр хараад суухгүй байх байсан. Харин Түүний өмнө өвдөг сөхөрч, Түүнд мөргөх байсан.



**[27:37]** Христийн толгой дээр “ЭНЭ БОЛ ИУДЕЙЧҮҮДИЙН ХААН ЕСҮС” гэсэн бичиг хадав. Дөрвөн сайнмэдээнд энэ үг бага зэрэг зөрүүтэй байдаг.<sup>52</sup> Маркийн сайнмэдээнд “Иудейчүүдийн Хаан” (15:26), Лукийн сайнмэдээнд “Энэ бол Иудейчүүдийн Хаан” (23:38), Иоханы сайнмэдээнд “Назарын Есүс, Иудейчүүдийн Хаан” (19:19) гэсэн байдаг. Бичгэн дээр үгийг ахлах тахилчид дургүйцэж, Тэр Өөрийгөө иудейчүүдийн Хаан гэж хэлсэн болохоос, үнэн хэрэг дээрээ иудейчүүдийн Хаан биш гэж байв. Гэхдээ Пилат тэдний захирагч байсан болохоор өөрийн хүссэнээр хийв. Ийнхүү энэ үнэнийг еврей, латин, грек хэлээр бичээд бүгдэд харагдах газар өлгөлөө (Иохан 19:19-22).

**[27:38]** Нүгэлгүй Бурханы Хүү хоёр дээрэмчний дунд цовдлогдов. Үүнийг болохоос өмнө долоон зуун жилийн тэртээ Исаиа зөгнөж, Христ нүгэлтнүүдтэй хамт тоологдоно гэж хэлсэн билээ (Исаиа 53:12). Эхлээд хоёр дээрэмчин хоёулаа Түүнийг харааж доромжилж байв (44-р эшлэл). Харин эцсийн мөчид тэдний нэг нь гэмшиж, аврагдаж, хэдхэн мөчийн дараа Христтэй хамт диваажинд очжээ (Лук 23:42, 43).

**[27:39, 40]** Загалмай нь нэг талаас Бурханы хайрыг илчилдэг. Харин нөгөө талаас хүний нүгэл хэчнээн гүн болохыг харуулдаг. Хоньчин хоньдынхоо төлөө үхэж байхад хажуугаар нь өнгөрөгсөд Түүнийг тохуурхан “Сүмийг нурааж, гурав хоногийн дотор барьдаг хүн чи өөрийгөө авраач. Хэрэв чи Бурханы Хүү мөн

**юм бол загалмайнаасаа буугаач”** гэгцгээж байлаа. “Харвал итгэнэ” гэдэг рационалист үл итгэлийн үг энд цухалзаж байна. “Загалмайнаасаа буугаач!” Өөрөөр хэлбэл, “Загалмайн саадыг зайлуулбал бид итгэнэ” гэдэг либерализм ч гэсэн харагдаж байна. “Загалмайнаасаа буувал итгэнэ гэж тэд хэлсэн. Харин Тэр загалмайдаа үлдсэн болохоор бид итгэдэг” гэж Виллиям Бүүт хэлсэн байдаг.

**[27:41-44] Ахлах тахилчид, хуулийн багш нар, ахлагчид** доромж тохууны хоорт хоолой нийлүүлж, **“Тэр бусдыг аварсан боловч Өөрийгөө аварч чадахгүй”** хэмээн цангинуулав. Тэд Эзэнийг маань гутаан доромжлохын тулд ингэж хэлсэн бол бид харин тэр үгийг нь магтаалын дуундаа авч ашигласан юм:

Өрөвдмөөр зовсон нүгэлтнүүдэд  
Өршөөл энэрэл үзүүлэхийн тулд  
Өөр зам үгүй тул үхлээс  
Өөрийгөө Тэр аврах гэсэнгүй,  
Христ Бурханы Хүү цусаа урсгах ёстой байжээ  
Харин булай гэмтнүүд нүглээс чөлөөлөгдөх  
хувьтай болжээ

*-Алберт Мидлэйн*

Эзэний амьдралд ийм байсан юм бол, биднийх ч бас адил байх болно. Өөрийгөө аврахыг эрмэлзэх зуураа бусдыг аврах боломжгүй билээ.

Өөрийгөө Аврагч гэснийг нь, **Израилийн Хаан** гэснийг нь, **Бурханы Хүү** гэснийг нь шашны удирдагчид доог тохуу болгов. **Дээрэмчид** хүртэл хараал зүхлээрээ тэдэнтэй нийлэв. Шашны удирдагчид өөрсдийн Бурханаа басамжлахдаа гэмт хэрэгтнүүдтэй хамтарч байна.

## **II. Гурван цагийн турш харанхуй болов (27:45-50)**

[27:45] Хүмүүсийн гараас амссан зовлон шаналал, басамжлал доромжлол одоо амсах зүйлийнх нь дэргэд дэндүү өчүүхэн зүйл байлаа. **Зургаадугаар цагаас** (үд дунд) **есдүгээр цаг (15:00) хүртэл** Палестины **бүх нутгийг** төдийгүй Есүсийн ариун сэтгэлийг **харанхуй нөмрөн авлаа**. Энэ гурван цагийн хугацаанд нүглийн маань үгээр илэрхийлшгүй аймшигт хараалыг Тэр үүрчээ. Энэ гурван цагийн хугацаанд бүх нүглүүдийн маань эсрэг хилэгнэсэн Бурханы уур хилэнг, бидний амсах ёстой байсан тамын шийтгэлийг Тэр үүрчээ. Бид үүнийг ойлгож чадахгүй. Нүглийн эсрэг шаардсан Бурхан шударга шаардлагуудыг бүгдийг нь хангах нь Түүний хувьд ямар байсныг бид яасан ч ойлгож чадахгүй. Тэр гурван цагийн хугацаанд Тэрээр үнийг төлж, өрийг шийдэж, хүний авралд шаардлагатай ажлыг гүйцээсэн гэдгийг л бид мэднэ.

[27:46] Өдрийн 15:00 цагийн **орчимд Есүс чанга дуугаар “Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?” гэж хашхирлаа**. Энэ

асуултын хариулт Дуулал 22:3 дээр бий. Үүнд: “Израилийн магтаал дунд сэнтийд Залрагч аа, Та ариун билээ.” Бурхан ариун учраас нүглийг харж чаддаггүй. Тиймээс Бурхан нүглийг шийтгэдэг. Эзэн Есүс Өөрөө ямар ч нүгэлгүй байсан боловч бидний нүглүүдийн буруутгалыг Өөр дээрээ авчээ. Шүүгч Бурхан доош өнгийгөөд нүгэлгүй Золиосны дээр буй нүглүүдийг маань харсан байна. Тиймээс Тэр Хүүгээсээ Өөрийн хайрыг авчээ. Бурхан Өөрөөс нь нүүр буруулсанд Есүсийн зүрх тэсгэлгүй хашхирсан байна. Хатагтай Браунин үүнийг “Иммануелын өнчин сэтгэлийн хашхираан” хэмээн үнэхээр сайхан хэлсэн байна:

Хайртай ганц Хүүгээсээ  
Холдож Бурхан салжээ!  
Хаягдан Тэр орхигджээ!  
Адамын нүглүүд одоо харин  
Арчигдан зайлж, авагджээ!  
Эцэг, Хүүгийн дундаас ховхорчээ!  
Иммануелын өнчирсөн сэтгэл хашхирчээ!  
Орчлон хорвоог доргион чичрээжээ!  
“Бурхан минь, Би хаягдлаа” гээд  
Ганц л удаа чангаар орилжээ!

*-Елизабет Баррет Браунин*

[27:47, 48] Есүсийг “Ели, Ели...” гэж хашхирахад тэнд зогсож байсан хүмүүсийн зарим нь “Тэр Елиаг дуудаж байна” гэв. Тэд үнэхээр андуурч сонссон уу, аль эсвэл зүгээр л дооглон тохуурхаж ингэж хэлсэн үү гэдэг нь

тодорхойгүй. Тэгтэл нэг нь урт **хулс** авч, Түүндээ **цагаан цуутай хөвөн** тогтоогоод уруулд нь хүргэв. Дуулал 69:21-ээс үзвэл, энэ нь өрөвдсөндөө хийсэн үйлдэл биш, харин зовлонг нь нэмэгдүүлэх зорилготой байсан бололтой.

**[27:49]** Елиа ирвэл зөвт хүмүүст тусална гэж Иудейн уламжлалд үздэг байв. Тэд энэ бодлоороо, “**Елиа** ирж, Есүст туслах **эсэхийг харцгаая**” гэв. Гэвч Елиа ирэх цаг биш (Малахи 4:5), харин Есүсийн үхэх цаг байлаа.

**[27:50]** **Есүс дахин чангаар хашхираад Өөрийн сүнсээ гаргажээ.** Тэр **чангаар** хашхирсан. Тэрээр сул дорой биш, хүч чадалтай үхсэнийг эндээс харж болно. **Тэр сүнсээ гаргасан** гэдэг нь Түүний үхлийг бусад хүнийхээс ялгаатайг харуулж байна. Бид үхэх ёстой учраас үхдэг бол, Тэр үхэхийг сонгосон учраас үхжээ. “Би амиа өгнө. Тэгээд буцааж авна. Хэн ч амийг минь Надаас авахгүй. Харин Би Өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах ч эрх мэдэл бий” гэж Эзэн Есүс хэлсэн биш үү (Иохан 10:17, 18)?

Хорвоо ертөнцийн Бүтээгч Бурхан  
Хүн болж, хүний хараалыг үүрэв  
Тогтоож өгсөн хуулийнхаа шаардлагыг  
Тултал нь Өөрөө төгс биелүүлэв  
Өвс ногоо, бут сөөгийг ургуулсан Тэр  
Өргөст ургамал толгойдоо зүүв  
Газрын гүнд эрдэс төмөрлөг нуусан Тэр  
Гартаа хадаас, биедээ төмөр зоолгов

Моддыг ургуулж, ойг бүтээсэн Тэр  
Модонд хадуулж, биеэ өлгүүлэв  
Тэлүүлж Тэр загалмай дээр үхэв  
Толгод дээр тэр нь дурайж байв  
Дэлхий дээгүүр дэлгэсэн тэнгэр нь  
Дээр нь харанхуйлж, барайж байв  
Зарлигдан тушааж сансарт тогтоосон нар нь  
Царайгаа нууж, гэрлээ эс үзүүлэв  
Үнэт цусыг нь урегасан жад  
Бурханы хилэнгийн гал байв  
Цогцсыг нь тавьсан чулуун булш  
Гарынх нь урласан хад байв  
Өдгөө Түүний заларсан сэнтий нь  
Өнө мөнхөөс л Түүнийх байсан  
Өргөст бус, алдрын титэм Тэр зүүнэ  
Өвдөг бүхэн Түүнд сөхөрнө  
*-Ф.У.Питт*

## **Р. Сүмийн хөшиг цуу урагдав (27:51-54)**

**[27:51]** Есүсийг үхэх яг тэр мөчид **сүмийн** гол хоёр танхимыг заагладаг жин ихтэй нэхсэн **хөшиг** үл үзэгдэх нэгэн гараар **дээрээсээ доош хүртэл цуу урагдав**. Энэ хөшиг нь Бурханы оршдог Ариунаас ариун газрыг тусгаарладаг бөгөөд тэргүүн тахилчаас өөр хэн ч тийшээ орж болдоггүй байв. Энэ онцгой ариун газарт нэг хүн жилд нэг л удаа орох эрхтэй байв. Гэтэл одоо энэ тусгаарлал үгүй болов.

Энэ хөшиг нь Есүсийн биеийг төлөөлж байсныг Еврей номоос бид мэдэж авсан. Хөшиг

урагдсан нь Христийн бие үхэлд тушаагдсаныг харуулсан. Есүсийн үхлээр дамжуулан бид “Ариунаас ариун газарт орох итгэл зоригтой болсон билээ. Ийшээ бид Есүсийн цусаар болон бидэнд нээж өгсөн шинэ, амьд замаар нь орж чадна. Тэрхүү зам нь Есүсийн махан бие болох хөшгөөр дамждаг” (Еврей 10:19, 20). Эдүгээ хамгийн дорд итгэгч хүн ч гэсэн хүссэн цагтаа залбирал ба магтаалаар дамжуулж Бурханы оршихуй уруу орж чадна. Гэхдээ энэ сайхан эрхийг маш өндөр үнээр худалдан авсныг бүү мартаарай. Тэр бол Есүсийн цус билээ.

Бурханы Хүүгийн үхэл байгаль дэлхийд ч гэсэн нөлөө үзүүлэв. Бүтээл нь Бүтээгчтэйгээ салшгүй холбоотой байна. Тэгэхэд **газар хөдлөн хад чулуу хагаран олон булш нээгдэв.**

[27:52, 53] Гэхдээ онгойсон энэ булшнуудаас үхэгсэд амилж, Иерусалим уруу **орж, олон хүнд харагдсан** үйл явдал **Есүсийн амиллын дараа** л болсон гэдгийг харах нь чухал. Амилсан энэ ариун хүмүүс дахиад үхсэн үү эсвэл Эзэн Есүстэй хамт тэнгэр уруу явсан уу гэдгийг Библид дурдаагүй байна.

[27:54] Тэнд байсан Ромын зуутын дарга болон түүний хүмүүс байгалийн энэ сонин хачин үзэгдлүүдийг үзээд Есүсийг **Бурханы Хүү** (грек дээрээ Бурханы Хүү гэдгийн урд тухайлах ялгац байхгүй боловч үгийн дараалал нь үүнийг тухайлалтай болгодог<sup>54</sup>) мөн байжээ хэмээн хүлээн зөвшөөрөв. **Зуутын дарга** үүнийг ямар утгаар хэлсэн бэ? Есүс Христийг Эзэн ба Аврагч

хэмээн хүлээн зөвшөөрсөндөө ингэж хэлсэн үү, аль эсвэл ердийн хүнээс илүү нэгэн гэж бодсондоо хэлсэн үү? Үүнийг бид баттай мэдэхгүй. Ямартай ч, болж байгаа бүхэн нь Есүстэй хамт цовдлогдсон хүмүүсийн үхэлтэй бус, харин Есүстэй холбоотой байгааг тэр ямар нэг байдлаар ойлгож, түүнд айн эмээх сэтгэл төрсөн болохыг харуулж байна.

### **С. Итгэмжит эмэгтэйчүүд (27:55, 56)**

Галилаас Иерусалим хүртэлх бүх замынх нь турш Эзэн Есүсийг дагаж, Түүнд итгэмжтэй үйлчилж байсан эмэгтэйчүүдийн талаар энд онцгойлон дурдаж байна. **Магдалын Мариа болон Иаков, Иосеф хоёрын эх Мариа, Зебедеен эхнэр Саломе нар тэнд байв.** Эзэнийг гэсэн хатан зоригт сэтгэл нь энд туяаран гэрэлтэж байна. Эзэний эрэгтэй шавь нар амиа бодон зугтаах үед ч гэсэн энэ эмэгтэйчүүд Христтэй хамт үлджээ.

### **Т. Эзэн Есүсийг Иосефын булшинд оршуулав (27:57-61)**

**[27:57, 58] Ариматын Иосеф гэгч нэгэн баян хүн өөрөө зөвлөлийн гишүүн байсан ч Есүсийг Пилатад хүргэх шийдвэртэй нь санал нийлэхгүй байв (Лук 23:51).** Тэрээр Есүсийн **шавь** болохоо энэ мөчийг хүртэл нууж байсан бол одоо харин ямар ч аюул заналыг үл тоов. Тэр зориг гарган **Пилатад бараалхаж**, Эзэнийгээ оршуулах зөвшөөрөл хүсэв. Зөвлөлийн нэг



гишүүн хэнээс ч ичиж зовохгүйгээр цовдлогдсон хүний төлөө санаа тавьсан явдалд Пилат ямар их гайхаж, иудейчүүд ямар их урам хугарсныг төсөөлөх гээд үзээрэй. Иосеф Есүсийн биеийг оршуулахдаа эдийн засгийн хувьд, нийгмийн хувьд, шашны хувьд өөрийгөө ч гэсэн оршуулсан юм. Энэ үйлдлээрээ тэр Эзэн Есүсийг алсан хүмүүсээс өөрийгөө үүрд тусгаарласан билээ.

[27:59, 60] Пилат түүнд зөвшөөрөл олгов. Эзэнээ гэсэн хайрын сэтгэлээр **Иосеф** цогцсыг нь **цэвэр маалинган даавуунд ороож**, даавууны хооронд халуун ногоо цацав. Тэгээд **хад ухаж хийсэн өөрийнхөө шинэ булшинд** Эзэний биеийг **тавилаа**. Булшны амыг тээрмийн чулуу мэт хэлбэртэй том **чулуугаар** даруулав. Булшны ам нь чулуунд таарсан ховилтой байлаа.

Олон зууны тэртээ Исаиа “Түүний булш нүгэлт хүмүүстэй хамт байх байсан боловч, үхэлдээ Тэр баян хүнтэй хамт байсан” (53:9) гэж зөгнөжээ. Дайснууд нь Түүний биеийг Хинномын хөндийд хаяж, хог шатаадаг галаар чандарлах юм уу үнэгэнд идүүлнэ гэж бодож байсан нь дамжиггүй. Гэвч Бурхан төлөвлөгөөнд нь саад болж, Өөрийнхийгөө биелүүлж, Иосефыг ашиглан Түүнийг баян хүний булшинд оршуулжээ.

## У. Булшийг манасан нь (27:62-66)

[27:62-64] Алгасал баярын маргаашийг **бэлтгэлийн өдөр** гэдэг. Энэ өдөр Есүс загалмайд

цовдлогджээ. **Дараа өдөр нь ахлах тахилчид болоод фарисайчууд** тайван байж чадсангүй. Есүс Өөрийгөө үхлээс амилна гэж хэлж байсныг тэд санаад Пилат дээр очиж, булшийг манах тусгай хамгаалалт гаргаж өгөхийг гуйв. Үхлээс дахин амилна гэсэн үгэн дээр нь дөрөөлж, **шавь нар** нь цогцсыг нь хулгайлж болзошгүй тул сэрэмжилж ийм харуул гаргажээ. Хэрэв ийм юм болбол **“сүүлчийн мэхлэлт нь эхнийхээсээ ч дор болно”** хэмээн тэд айж байлаа. Өөрөөр хэлбэл, Түүний амилсан тухай мэдээ нь Өөрийгөө Мессиа ба Бурханы Хүү гэсэн тунхаглалаас ч муу үр дагавартай гэж тэд үзэж байв.

[27:65, 66] Пилат тэдэнд **“Та нарт харуул байна. Замаараа яв. Хэрхэн хамгаалахаа та нар өөрсдөө мэдэж байгаа биз ээ”** гэв. Пилатын үг нь нэг бол “Та нарт Ромын харуулууд байгаа шүү дээ” гэсэн утгатай, аль эсвэл “Та нарын хүсэлтийг ёсоор болгож, харуул олгож байна” гэсэн утгатай. **“Хэрхэн хамгаалахаа та нар өөрсдөө мэдэж байгаа биз ээ”** гэсэн үг нь ёжилсон утгатай байж ч мэдэх юм. Тэд чадах чинээгээрээ хичээсэн. Чулууг лацдаж, харуул тавьж, хамаг л арга чаргаа хэрэглэсэн боловч ямар ч тус нэмэр болсонгүй. Унгер энэ тухайд дараах үгийг хэлсэн:

Түүний дайснууд хамаг л урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, чулууг лацдаж, харуул байршуулсан боловч Бурханы

төлөвлөгөөг тасалдуулж чадаагүй юм. Харин ч бүр Хааны амиллыг батлах хөдөлшгүй нотолгоог бий болгов.<sup>54</sup>

## XV. МЕССИА ХААНЫ ЯЛАЛТ (28-р бүлэг)

### A. Хоосон булш, амилсан Эзэн (28:1-10)

[28:1-4] Ням гарагийн өглөө үүр цайхаас өмнө хоёр Мариа булшийг үзэхээр ирэв. Тэднийг ирэхэд маш хүчтэй газар хөдлөлт болсон байлаа. Нэгэн тэнгэрэлч тэнгэрээс буун ирж чулууг булшны амнаас зайлуулаад дээр нь суужээ. Ромын харуулууд цав цагаан хувцастай гэрэл цацарсан энэ зүйлээс айж газарт унацгаасан байв.

[28:5, 6] Тэнгэрэлч эмэгтэйчүүдэд хандан “**Бүү ай. Та нарын хайж байгаа нэгэн амласан ёсоороо үхлээс амилсан. Ирэгтүн. Түүний хэвтэж байсан газрыг үзэгтүн**” гэв. Тэнгэрэлч Эзэнийг гаргахын тулд биш, харин эмэгтэйчүүдэд Эзэн амилсныг харуулахын тулд чулууг зайлуулжээ.

[28:7-10] Тэгээд тэрхүү тэнгэрэлч эмэгтэйчүүдийг Түүний шавь нар уруу илгээж, энэ баярт мэдээг дуулгахыг даалгав. Эзэн дахин амилсан бөгөөд тэдэнтэй Галилд уулзах болно. Тэр эмэгтэйчүүд шавь нарт үзсэн сонссоноо хэлэхээр явж байх замд Есүс үзэгдэж, “Баярлагтун!”<sup>55</sup> гэх ганц үгээр мэндчилэв. Тэд Түүний хөлд унаж, Түүнд мөргөлөө. Шавь

нартайгаа Галилд уулзах болно гэдэг мэдээг шавь нарт нь дуулгахыг Есүс өөрийн биеэр тэдэнд даалгав.

### **Б. Худал хэлүүлэх гэж цэргүүдэд хахууль өгөв (28:11-15)**

[28:11] Хэвийн байдалдаа орсны дараа цэргүүдийн зарим нь гэмт хүн шиг гэлбэлзэн ахлах тахилчид дээр очиж, болсон явдлыг ярив. Тэд хүссэндээ хүрч чадсангүй. Булш хоосорчээ.

[28:12, 13] Шашны удирдагчид яаж тэвдэж сандарсныг төсөөлөхөд тийм ч хэцүү биш. Тэд тэр даруй ахлагчдыг дуудан хуралдаж, төлөвлөгөө боловсруулав. Тэд аргаа барахдаа цэргүүдэд хахууль өгч, “Шөнө унтаж байх хойгуур маань шавь нар нь хүрч ирээд Есүсийн цогцсыг хулгайлчихсан” гэж хүмүүст яриулав.

Энэ тайлбар бүр ч их асуултыг гаргаж ирэв. Цэргүүд харуулын байран дээрээ яагаад унтсан бэ? Шавь нар нь тэднийг сэрээхгүйгээр тэр хүнд чулууг яаж зайлуулсан бэ? Цэргүүд хэрхэн нэг зэрэг унтаж таарсан бэ? Хэрэв тэд унтаж байсан юм бол цогцсыг Есүсийн шавь нар хулгайлсан гэдгийг яаж мэдсэн бэ? Хэрэв тэдний ярьж байгаа нь үнэн бол үнэнийг ярихын тулд заавал хахууль авдаг нь ямар учиртай юм бэ? Хэрэв шавь нар биеийг нь хулгайлсан юм бол цогцсыг ороосон маалинган даавууг тайлан авч нямбайлан эвхэж тавих цаг зав гаргах хэрэг юу байсан юм бэ? (Лук 24:12; Иохан 20:6, 7).

**[28:14]** Үнэндээ тэр цэргүүд өөрсдийгөө ялд унагах зүйлийг ярихаар хахууль авчээ. Ромын хуулийн дагуу үүрэг гүйцэтгэж байхдаа унтсан цэрэгт үхэх ял оноодог байв. Тийм учраас тэдний яриа **захирагчийн чихэнд** хүрвэл тэднийг хэргээс мулталж өгнө гэдгээ иудейн удирдагчид амлаж байна.

Үнэн өөрөө өөрийгөө баталдаг. Харин худал хуурмагийг батлахын тулд дахиж тоо томшгүй худал зүйл ярих хэрэгтэй болдог.

**[28:15]** Гэхдээ энэ үлгэр **энэ өдрийг хүртэл иудейчүүдийн дунд** болон харь үндэстнүүдийн дотор **өргөн тархжээ**. Үүнээс өөр үлгэрүүд ч бас бий. Вилбур Смит ийм хоёр үлгэрийн талаар өгүүлсэн байдаг:

1. Эмэгтэйчүүд булшаа андуурсан гэх үлгэр бий. Гэхдээ түр азнаад бодоод үз. Баасан гарагийн үдээс хойшоос Ням гарагийн өглөө хүртэлх ахархан хугацаанд хамгийн хайртай хүнийхээ булшийг мартаж, будилдаг хүн гэж ер нь байх уу? Түүнээс гадна, уг булш нь Ариматын Иосефын булш, түүний хувийн цэцэрлэг байсан. Тиймээс тэнд өөр ямар ч булш байгаагүй. Эмэгтэйчүүд булшаа андуурсан гэж бодъё. Нүдэндээ нулимстай эмэгтэйчүүд ойр хавиа анзааралгүй буруу булшинд очсон байг. Тэр эмэгтэйчүүдийн хувьд тийм зүйл байж болох байх. Гэтэл хурц хараатай Симон Петр, Иохан гэгч хоёр загасчин огт уйлаагүй байсан бөгөөд булшинд очоод

хоосон байгааг нь харжээ. Тэднийг ч бас буруу булшинд очсон гэх үү? Түүгээр ч зогсохгүй, эмэгтэйчүүд булшинд очоод, хоосон байгааг нь үзэх үед тэнд тэнгэрэлч байсан. Тэнгэрэлч тэдэнд: “Тэр энд байхгүй. Тэр амилсан. Түүний хэвтэж байсан газрыг ирж үзэгтүн” гэж хэлсэн. Таны бодлоор тэнгэрэлч ч гэсэн буруу булшинд очсон гэж үү? Тэр ч болоогүй. Энэ онолуудыг толгой сайтай хүмүүс боловсруулсан гэдгийг бүү мартаарай. Үнэндээ энэ бол ямар ч утга учиргүй онол мөн.

2. Есүс арай үхээгүй байсан гэх үлгэр бас бий. Есүсийг булшинд тавих үед Тэр арай үхээгүй, ухаан алдсан байсан бөгөөд булшинд байхдаа ухаан орж, булшнаасаа гарсан гэж зарим хүн ярьдаг. Гэхдээ булшны аман дээр байсан үхэр чулуу, Ромын төрийн лацыг тэд огт тооцдоггүй. Булшны амны ховилд сууж, амыг дарсан тэр хүнд чулууг дотор талаас өнхрүүлж чадах хүн гэж байхгүй. Тэр дундаа, олон цагийн тамлал амссан, биеийн байдал дорой хүн бүр ч чадахгүй. Үнэндээ Эзэн Есүсийн амилал бол түүхийн хөдөлшгүй нотолгоотой үнэн бодит түүх юм. Зовлон эдэлж, үхсэнийхээ дараа Тэр амьд байгаагаа хөдөлшгүй олон нотолгоогоор шавь нартаа харуулсан юм.

Тэр Өөрийнхөндөө үзэгдсэн дараах тохиолдлуудыг та эргэцүүлж бодож үзээрэй.

- (1) Магдалын Мариад үзэгдсэн (Марк 16:9-11).
- (2) Эмэгтэйчүүдэд үзэгдсэн (Матай 28:8-10).
- (3) Петрт үзэгдсэн (Лук 24:34).
- (4) Еммау уруу явж байсан хоёр шавьдаа үзэгдсэн (Лук 24:13-32).
- (5) Томасыг байхгүй үед шавь нартаа үзэгдсэн (Иохан 20:19-25).
- (6) Томасыг байхад шавь нартаа үзэгдсэн (Иохан 20:26-31).
- (7) Галил нуурын дэргэд долоон шавьдаа үзэгдсэн (Иохан 21-р бүлэг).
- (8) Нэг зэрэг 500 итгэгчид үзэгдсэн (1Коринт 15:7).
- (9) Чидун ууланд шавь нартаа үзэгдсэн (Үйлс 1:3-12).

Христэд итгэх итгэлийн маань хөдөлшгүй, ганхашгүй хадан суурь бол Эзэн Есүс Христийн түүхэн баримттай амилал мөн. Та бид энэ суурин дээр бат зогсоод, энэ итгэлийн төлөө тэмцэж чадна. Учир нь няцаах аргагүй үнэн бидний талд байна. Хүмүүс үүнийг үгүйсгэж болох ч, худал гэдгийг нь баталж чадахгүй.<sup>56</sup>

### **В. Агуу захирамж (28:16-20)**

[28:16, 17] Эзэн Есүс үхлээс амилаад **Галилын** нэгэн уулан дээр шавь нартаа үзэгдэв. Үүнийг Марк 16:15-18, 1Коринт 15:6 дээр бас тэмдэглэжээ. Юутай гайхалтай уулзалт вэ!

Түүний зовлон үүрд өнгөрөн оджээ. Эзэн Есүс үхлээс амилж, одоо үүрд амьд учраас, тэд ч гэсэн үүрд амьдрах болно. Тэрээр шавь нарынхаа өмнө алдрын биетэйгээ зогсож байв. Тэд амьд бөгөөд хайрын Эзэнд мөргөв. Гэхдээ заримынх нь бодолд эргэлзээ байсаар байлаа.

**[28:18]** Тэгэхэд Эзэн Есүс тэдэнд, **“Тэнгэр, газар дээрх бүх эрх мэдэл надад өгөгдсөн”** гэж хэлэв. Бүх эрх мэдэл угаасаа хэзээд Түүнийх байсан нь мэдээж. Харин Тэрээр энд шинэ бүтээлийн Тэргүүн болсон эрх мэдлийн тухай ярьж байна. Тэрээр үхээд, эргэн амилсныхаа дараа, Бурханы Өөрт нь өгсөн бүхэнд мөнх амь өгөх эрхтэй болсон юм. Тэрээр хэзээд бүх бүтээлийн ууганы хувиар хүч чадал, эрх мэдлийг атгаж байсан. Гэхдээ одоо бол авралын ажлыг дуусгасан учраас үхлээс анх төрөгчийн хувиар эрх мэдэлтэй болсон юм. “Энэ нь Тэр Өөрөө бүх юмсын тэргүүн болохын тулд юм” (Колоссай 1:15, 18).

**[28:19, 20]** Тэрээр шинэ бүтээлийн Тэргүүний байр сууринаас агуу захирамжийг өгч байна. Энэ захирамж нь хаанчлалын одоогийн үе шатанд амьдарч байгаа бүх итгэгчдэд хамаатай. Хаанчлалын одоогийн үе шат нь Хааны үгүйсгэгдсэн үеэс эхэлж, хоёр дахь ирэлтээр нь дуусгавар болох үе юм.

Агуу захирамжид гурван тушаал агуулагдаж байна. Үүнийг бидэнд тавьсан санал гэж бүү андуураарай. Үүнд:



**1. “Явж, бүх үндэстнийг дагалдагч болго.”**

Гэхдээ бүх дэлхийг аврах тухай энд яриагүй юм. Сайнмэдээг тунхаглах үед үндэстэн бүрээс, бүх овгоос, бүх ард түмнээс, бүх хэлтнээс Аврагч Эзэний шавь ба дагалдагчид төрөхийг энд хэлж байна.

**2. “Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ.”** Христийн элч нар баптисмыг заах үүрэгтэй бөгөөд тушаал болгон даган ёстой. Баптисм нь итгэгч хүнийг гурвал бүхий ганц Бурханд итгэдэг болохыг нийтэд харуулдаг. Итгэгч хүний хувьд Бурхан бол Эцэг, Есүс Христ бол Эзэн, Ариун Сүнс бол өөрийнх нь дотор оршигч, өөрийг нь хүчжүүлэгч, өөрт нь зааж сургагч Нэгэн юм. Арван есдүгээр эшлэлд **нэр** гэдэг үг ганц тоон дээр байна. Нэг **нэртэй**, ганц мөн чанартай боловч гурван бодгаль буй. Тэр нь **Эцэг, Хүү, Ариун Сүнс**.

**3. “Та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа.”** Хүмүүсийг сайнмэдээнд итгүүлээд л зогсож болохгүй гэдгийг агуу захирамж хэлж байна. Тэднийг зөнд нь орхиж болохгүй. Харин Шинэ гэрээнд буй Христийн тушаалуудыг сахин биелүүлэхийг зааж өгөх хэрэгтэй. Дагалдагч байхын үндсэн зорилго нь Эзэнтэйгээ адил болох. Энэ зорилгод хүрэхийн тулд тэдэнд системтэйгээр зааж, Бурханы үгэнд захирагдахыг сургах хэрэгтэй.

Аврагч Эзэн маань төгсгөлд нь **үеийн төгсгөл хүртэл** дагалдагчидтайгаа хамт байхаа амлаж байна. Христийн дагалдагчид ямар ч

тусламжгүй ганцаараа явдаггүй. Бүх үйлчлэл, бүх замынх нь турш Бурханы Хүү тэдэнтэй хамт байна. Үүнийг мартаж болохгүй.

Агуу захирамжтай холбоотой “бүх” гэсэн дөрвөн зүйлийг анхааралдаа авна уу: **Бүх эрх мэдэл; бүх үндэстэн; тушаасан бүхэн; үргэлж (бүх цагт).**

Ингээд Матайн сайнмэдээ нь алдарт Эзэний маань агуу захирамж ба амлалтаар төгсөж байна. Хорин зууны тэртээ хэлэгдсэн энэ үг одоо ч хүчин төгөлдөр, ач холбогдолтой, үнэ цэнтэй хэвээр. Учир нь даалгавар дуусаагүй байна.

Эзэний айлдсан сүүлийн энэ тушаалыг биелүүлэхийн төлөө бид юу хийж байна вэ?

## ЗҮҮЛТ ТАЙЛБАР

<sup>1</sup>(1:1) Jehovah (Иехова) гэдэг нь Яавээ/Иехова гэдэг еврей нэрийн англижсан галиг юм. Энэ нэрийг Библид ЭЗЭН гэж орчуулдаг уламжлалтай. Еврейгээр Иешуа гэдэг нэр англиар Jesus гэж галиглагдсан нь үүнтэй ижил тохиолдол юм.

<sup>2</sup>(4:2, 3) Мэдэгдэл бүхий өгүүлбэрт *эи* (грекээр: хэрэв) орвол нэгдүгээр зэргийн болзол заадаг. Өөрөөр хэлбэл баталсан өгүүлбэр болдог. “Хэрэв чи Бурханы Хүү юм бол” гэдгийг арай өөрөөр “Чи Бурханы Хүү мөнөөс хойш”, “Чи Бурханы Хүү мөн юм чинь” гэж орчуулж болно.

<sup>3</sup>(Сэдэв хэлэлцүүлэг) “Диспенсаци” гэдэг нь хэрэг эрхлэлт, хөтөлбөр төлөвлөгөө, удирдан зохион байгуулалт юм. Түүхийн тодорхой нэгэн цаг үед Бурхан хүн төрөлхтөнтэй харилцахдаа авч хэрэгжүүлж буй арга замыг “диспенсанци” гэж нэрлэдэг. Энэ үг нь “тодорхой хугацаа”, “цаг үе” гэсэн утгатай биш. Харин аливаа нэг цаг үед хэрэгжүүлж буй Бурханы хөтөлбөр юм. Реганы хөтөлбөр (администраци) гэж ярихдаа бид үүнтэй ижил санаа илэрхийлдэг. Реганы хөтөлбөр гэвэл ерөнхийлөгч Реган албан үүргээ хашиж байх хугацаандаа баримтлах бодлого төлөвлөгөө гэсэн утгаар ойлгодог.

<sup>4</sup>(5:13) Алберт Барнес, Шинэ гэрээний тайлбар, Матай, Марк, хуудас 47.

<sup>5</sup>(5:22) Сонгомол текстэд (NKJV орчуулгын хөлийн тайлбарт “NU” гэж тэмдэглэсэн текст)

“шалтгаангүйгээр” гэх үг байхгүй. Энэ үг байхгүй тохиолдолд зөв шударга эгдүүцлийг ч гэсэн буруутгаж буй мэт ойлгогдох магадлалтай.  
<sup>6</sup>(5:44-47) Сонгомол текстэд (NU) татвар хураагчид гэх үгийн оронд харь үндэстнүүд гэж бий.

<sup>7</sup>(5:44-47) Мажорити текстэд ах дүү гэх үгийн оронд нөхөд гэж бий.

<sup>8</sup>(6:13) Энэхүү доксологийг сүмийн ёслолд ашиглах зорилгоор 1Коринт 29:11-ээс авсан гэж зарим эрдэмтэд үздэг. Гэхдээ энэ бол зүгээр таамаг юм. Уг залбирлын уламжлалт протестант хувилбарыг (KJV) өмгөөлөх үндэслэлүүд бий.

<sup>9</sup>(7:13, 14) Сонгомол болон мажорити текстийн үгс маш хүчтэй сэтгэл хөдлөл шингэсэн байдаг: “Амь уруу хөтөлдөг хаалга нь юутай хавчиг, зам нь хэчнээн хэцүү вэ! Түүнийг олдог нь ч цөөхөн.” Хамгийн хуучны гар бичмэлүүд (ерөнхийдөө NU) болон зонхилох гар бичмэлүүд (M) нь уламжлалт текстээс (TR) зөрдөг ч зөв гэдэг нь тодорхой байдаг. Яг энэ тохиолдолд KJ орчуулгын баримталсан уламжлалт текстийн нотолгоо маш сул.

<sup>10</sup>(7:28, 29) Жэмисон, Фаузет, Браун, *Шинэ гэрээний шүүн тодруулсан тайлбар*, 50 дугаар боть.

<sup>11</sup>(8:2) Библид уяман өвчний хэд хэд хэлбэрийг дурдсан. Гэхдээ тэдгээр нь Хансены өвчин гэж нэрлэдэг уяман өвчинтэй адилгүй. Жишээ нь гэхэд, Леви номд дурдсан уяман өвчин нь байшин, хувцсанд ч хүртэл халдварладаг байсан.

- <sup>12</sup>(8:16, 17) Арно К. Гаебелейн, *Матайн сайнмэдээ*, хуудас 193.
- <sup>13</sup>(8:28) NU текстэд гадарчууд гэж бичсэн. Хот ба бүс нутгийн нэрс давхцах тохиолдол гардаг.
- <sup>14</sup>(9:16) Арно К. Гаебелейн, *Матайн сайнмэдээ*, хуудас 193.
- <sup>15</sup>(9:17) У. Л. Петтингил, *Матай номын эгэл судлал*, хуудас 111, 112.
- <sup>16</sup>(10:8) Ихэнх гар бичмэлд “үхсэнийг босгох” гэсэн үг энд байдаггүй.
- <sup>17</sup>(10:21) Ж.К.Макавлэй, *Үхэлд ч хүртэл дуулгавартай: Иоханы сайнмэдээнээс чимээгүй цагийн судлал хийх нь*, II:59.
- <sup>18</sup>(10:41) Артур Т. Пиерсон, “Итгэгчийн төлөө хийсэн Христийн ажил”, *Кесвикийн үйлчлэл, эхний цуврал*, хуудас 114.
- <sup>19</sup>(11:27) Альва Ж. Маклайн, *Бурханы хаанчлал хэчнээн агуу вэ!*, хуудас 311.
- <sup>20</sup>(11:30) Ж.Х.Жоветт, *Өдөр бүрийн талх* номд иш татагдсан үг.
- <sup>21</sup>(12:8) Е.В.Рожерс, *Есүс бол Христ*, хуудас 65, 66.
- <sup>22</sup>(12:19) Альва Ж. Маклайн, *Бурханы хаанчлал хэчнээн агуу вэ!*, хуудас 283.
- <sup>23</sup>(12:21) Клейст ба Лилли, *эх грекээс тайлсан Шинэ гэрээ өргөн тайлбарын хамт*, хуудас 45.
- <sup>24</sup>(12:27) Элла Э. Похлэ, *Скофилдийн асуултын хайрцаг*, хуудас 97.
- <sup>25</sup>(12:34, 35) Сонгомол болон мажорити текстийн аль алинд “өөрийн зүрхний” гэж байхгүй. Гэхдээ энэ үг байлаа ч утга алдагдахгүй.

- <sup>26</sup>(13:13) Х. Честер Вүүдрин, Матайн сайнмэдээний тайлбар (нийтлэгдээгүй), Еммау Библийн Сургууль, 1961.
- <sup>27</sup>(13:22) Г.Х.Ланг, *Бичвэр дэх сургаалт зүйрлэлүүдийн сургамж*, хуудас 68.
- <sup>28</sup>(13:24-26) Меррилл Ф. Унгер, *Унгерын Библийн толь бичиг*, хуудас 1145.
- <sup>29</sup>(13:33) Ж.Х.Брукс, *Би очиж байна*, хуудас 65.
- <sup>30</sup>(13:49, 50) Арно К. Гаебелейн, *Матайн сайнмэдээ*, хуудас 302.
- <sup>31</sup>(14:4, 5) Эх сурвалж тодорхойгүй.
- <sup>32</sup>(16:2, 3) Мэдээж хэрэг цаг агаарыг ийнхүү шинжих нь Израильд тохиромжтой боловч Хойд Америк болон Их Британид таарахгүй.
- <sup>33</sup>(16:7-10) Таван мянган хүнээс үлдсэн талх, загасыг хийсэн арван хоёр *кофиной* нь 4,000 хүнээс үлдсэн талх, загасыг хийсэн долоон *спуридэсээс* багыг багтаасан байж болно.
- <sup>34</sup>(16:17, 18) Г.Кампбелл Морган, *Матайн бичсэн сайнмэдээ*, хуудас 211.
- <sup>35</sup>(16:19) Чарльз Райри, *Райри Судлал Библи, Хаан Жэймсийн Шинэчилсэн Орчуулга*, хуудас 1506.
- <sup>36</sup>(16:20) Жэймс С. Стюард, *Есүс Христийн амьдрал ба сургаал*, хуудас 106.
- <sup>37</sup>(16:26) Доналд Грей Барнхаус, *Үгсийг оновчтой өгүүлэх нь*, хуудас 53.
- <sup>38</sup>(18:11) Энэ эшлэл NU текстэд ороогүй боловч мажорити (М) буюу зонхилох гар бичмэлд агуулагдаж байна.

<sup>39</sup>(20:15) Жэймс С. Стюард, *Христийн доторх хүн*, хуудас 252.

<sup>40</sup>(20:31-34) Арно К. Гаебелейн, *Матайн сайнмэдээ*, хуудас 420.

<sup>41</sup>(21:6) Ж.П.Ланж, *Ариун Бичвэрүүдийн Тайлбар*, 25 боть, хуудасны дугаар тодорхойгүй.

<sup>42</sup>(23:9,10) Х.Г.Уестон, *Шинэ гэрээний Эхлэл ном болох Матайн сайнмэдээ*, хуудас 110.

<sup>43</sup>(23:14) Сонгомол текстэд (NU) хоёр дахь халаглал байхгүй.

<sup>44</sup>(23:25, 26) Мажорити текстэд хувийн сонирхол (*акрасиа*) гэх үгийн оронд шударга бус байдал (*адикиа*) гэж бий.

<sup>45</sup>(24:29) И.Великовский, *Орвонгоороо эргэсэн дэлхий*, хуудас 136.

<sup>46</sup>(24:30) Грек хэлний “*ge*” (англи хэлний “*geo*” гэдэг үгтэй харьцуул) “газар”, “нутаг”, “дэлхий” гэсэн утгатай.

<sup>47</sup>(24:34) Ф.У.Грант, “Матай”, *Тоогоор илэрхийлсэн Библи, Сайнмэдээний номууд*, хуудас 230.

<sup>48</sup>(24:36) NU текстэд “Хүү ч” гэсэн илүү үг бий.

<sup>49</sup>(25:28, 29) *Мөнгөний тухай Эзэний маань сургаалууд*, хуудас 3,4.

<sup>50</sup>(26:64) Англи хэлний *you* бол ганц (чи, та) болон олон тоог (та нар) аль алийг нь илэрхийлдэг. Харин грек болон монгол хэлэнд үүнийг ялгадаг. Энэ эшлэлийн эхний *you* нь грекээр “*су*” (чи, та). Энэ нь ганц тооны төлөөний үг. Онцлогийг гаргаж ирэхийн тулд үүнийг ашигласан. Харин хоёр дахь *you* нь

грекээр “хумин” (га нар) буюу олон тооны, гуравдугаар биеийн төлөөний үг. Үгийн хувиллаас нь үзвэл энэ уоч нь *опсэстэ* (харрах болно) гэсэн үгтэй холбоотой байна.

<sup>51</sup>(26:64) Р.Ч.Х. Ленски, *Элч Матайн бичсэн сайнмэдээний тайлбар*, хуудас 1064.

<sup>52</sup>(27:37) Иш татсан хэсгүүдийг бүгдийг нийлүүлбэл, “Энэ бол иудейчүүдийн Хаан, Назарын Есүс” гэсэн үг болж байна. Нэг бол Матай, Марк, Лук, Иохан нар бүгдээрээ тухайн үгийг бүтэн бичсэн боловч өөр өөр хэлээс иш татсан болохоор ялгаатай болсон байх боломжтой.

<sup>53</sup>(27:54) Грек хэлэнд өгүүлэхүүний үүрэгтэй нэр үг тухайлалтай бол үйл үгийн өмнө орохоороо ихэнх тохиолдолд ялгацгүй байна (Колвелийн дүрэм).

<sup>54</sup>(27:65, 66) Меррилл Ф. Унгер, *Унгерын Библийн гарын авлага*, хуудас 491.

<sup>55</sup>(28:9) Грекчүүд “Баярлагтун!” гэж мэндэлдэг байсан. Тиймээс үхлээс амилсан өглөө Эзэн Есүс мэндлэхдээ хэлсэн “Амар байна уу?” гэснийг NKJV “Баярлагтун!” гэж үгчлэн орчуулсан нь зөв юм.

<sup>56</sup>(28:15) Вилбур Смит, Библи Судлалд, Мүүдийгийн сар тутмын дугаар, 1969 оны 4-р сар.



## НОМЗҮЙ

Барнхаус, Доналд Грей.

*Үгсийг оновчтой өгүүлэх нь.* Веатон:  
Тиндал Хаус хэвлэлийн газар, 1969 он.

Гаебелейн, А. К.

*Матайн сайнмэдээ.* Нью Йорк: Лойзеюкс  
Брос., 1910 он.

Келли, Уиллиам.

*Матайн сайнмэдээгээр хийсэн лекцүүд.*  
Нью Йорк: Лойзеюкс Брос., 1911 он.

Ленски, Р.Ч.Х.

*Элч Матайн бичсэн сайнмэдээний  
тайлбар.* Менниполис: Августбургийн  
хэвлэх газар, 1933 он.

Макавлэй, Ж.К.

*Хааныгаа үзэгтүн!* Чикаго. Мүүдий  
Библийн Институт, 1982 он.

Морган, Г.Кампбелл.

*Матайн бичсэн сайнмэдээ.* Нью Йорк:  
Флемин Х. Ревелийн компани, 1929 он.

Петтингил, У. Л.

*Матай номын эгэл судлал.* Харрисбург.  
Фред Келкер, 1910 он.

Таскер, Р.В.Г.

*Элч Матайн бичсэн сайнмэдээ.* Гранд  
Рэпидс: Уиллиам Б. Эрдмансын  
хэвлэлийн компани, 1961 он.

Томас, В.Х.Гриффит.

*Матай номын тойм судлал.* Гранд Рэпидс:  
Уиллиам Б. Эрдмансын хэвлэлийн  
компани, 1961 он.

Уестон, Х.Г.

*Шинэ гэрээний Эхлэл ном болох Матайн сайнмэдээ.* Филадельфия: Америкийн Баптист Хэвлэн Нийтлэгч Нарын Холбоо, огноо байхгүй.

***Улирлын чанартай гарсан болон хэвлэн нийтлэгдээгүй материал***

Смит, Вилбур.

Библи Судлалд, Мүүдийгийн сар тутмын дугаар, 1969 оны 4-р сар.

Вүүдрин, Х. Честер.

Матайн сайнмэдээний тайлбар, 1961 он, Иллинойс мужийн Оак Паркийн Еммау Библийн Сургууль (одоо Еммау Библийн Коллеж нэртэй болсон).